

Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүх

S E M I N A R Y



СУДЛАХ ОЮУТНЫ ГАРЫН АВЛАГА

Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүх судлах оюутны гарын авлага

**Сүмийн Боловсролын
Системээс бэлтгэн гаргав**

**Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэв
Солт Лейк хот, Юта**

© 2001 by Intellectual Reserve, Inc.
Бүх эрх хамгаалагдсан
АНУ-д хэвлэв

Англи эхийн зөвшөөрөл: 1/00
Орчуулгын зөвшөөрөл: 1/00
Doctrine and Covenants and Church History Study Student Guide-ын орчуулга
Mongolian

Агуулга

Энэ гарын авлагыг хэрхэн ашиглах вэ?	1
Судруудыг судлах нь	2
Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүхийг унших хуваарь	7
Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүхэнд тавтай морилогтун	8
Нью-Йорк ба Пеннсилвани дахь Сүм	11
Иосеф Смит-Түүх 1 Иосеф Смит өөрийн түүхийг өгүүлсэн нь	11
Сургаал ба Гэрээний удиртгал хуудас Уг номын тухай мэдэх нь	13
*Сургаал ба Гэрээ 1 Их Эзэний удиртгал үг-Сэрэмжлүүлгийн дуу хоолой	14
Сургаал ба Гэрээ 2 Моронайн айлчлал	16
Сургаал ба Гэрээ 3 Бошиглогч чухал сургамж авсан нь	17
Сургаал ба Гэрээ 4 Их Эзэнд үйлчлэхээр бэлтгэсэн нь	18
Сургаал ба Гэрээ 5 Мормоны Номын гэрчүүд амлагдсан нь	19
Сургаал ба Гэрээ 6 Сүнсний гэрчлэл	20
Сургаал ба Гэрээ 7 Илчлэгч Иоханы нууцлагдмал цэдэг	21
Сургаал ба Гэрээ 8–9 Илчлэлт хүлээн авч танин мэдэх нь	21
Сургаал ба Гэрээ 10 Бошиглогчийг устгах хуйвалдаан	23
Сургаал ба Гэрээ 11 “Хэрэв чи хүсэх аваас”	24
Сургаал ба Гэрээ 12 “Энэ ажилд тусалдаг хүмүүст”	25
Сургаал ба Гэрээ 13 Аароны санваарын сэргээлт	26
Сургаал ба Гэрээ 14–16 Ах дүү гурван Витмерт өгсөн зөвлөгөө	26
Сургаал ба Гэрээ 17 Онцгой гурван гэрчид зориулсан илчлэлт	27
Сургаал ба Гэрээ 18 Төлөөлөгчдийн ажил ба бодгалиудын үнэ цэнэ	28
Сургаал ба Гэрээ 19 Мартин Харрист өгсөн зарлиг	30
Сургаал ба Гэрээ 20 Сүмийн Үндсэн хууль	32
Сургаал ба Гэрээ 21 Бурхан минь, Бошиглогч илгээсэн Танд талархъя!	34
Сургаал ба Гэрээ 22 Баптисм хүртээхийн тулд эрх мэдэл шаардлагатай	35
Сургаал ба Гэрээ 23 “Зэмлэл дор орших нь үгүй”	35
Сургаал ба Гэрээ 24 Сүмийн удирдагчдын үүргүүд	35
Сургаал ба Гэрээ 25 Эмма Смит-сонгогдсон эмэгтэй	37
Сургаал ба Гэрээ 26 Нийтийн дэмжлэгийн хууль	38
Сургаал ба Гэрээ 27 Хожмын өдрүүд дэх ариун ёслол	39
Сургаал ба Гэрээ 28 Сүмд зориулсан илчлэлтүүдийг зөвхөн Бошиглогч хүлээн авдаг	40
Сургаал ба Гэрээ 29 Хожмын өдрүүд дэх “сонгогдогсод” өгөгдсөн амлалтууд	41
Сургаал ба Гэрээ 30 Давид Витмер, Петр Витмер, Жон Витмер-“Бүү ай”	42
Сургаал ба Гэрээ 31 Томас Б.Марш-Амлалт ба сэрэмжлүүлэг	43
Сургаал ба Гэрээ 32 Леменчүүдэд хийсэн номлол	44
Сургаал ба Гэрээ 33 Есүс Христийн Хоёр дахь Ирэлтэд бэлтгэх нь	45
Сургаал ба Гэрээ 34 Оорсон Пратт-“Дуу хоолойгоо өргөгтүн”	46
Сургаал ба Гэрээ 35 Сидней Ригдон-Өмнө нь ирэгч	47
Сургаал ба Гэрээ 36 Эдвард Партриж-“Их Эзэний агуу хүмүүсийн нэг”	48
Сургаал ба Гэрээ 37–38 Дайснуудаасаа зугтаж, Огайод цугларцгаа	49
Сургаал ба Гэрээ 39–40 Жеймс Ковилл -Өгөгдсөн ба мартагдсан амлалтууд	50
Огайо ба Миссури дэх Сүм	51
Сургаал ба Гэрээ 41 Жинхэнэ шавь гэж хэн бэ?	51
Сургаал ба Гэрээ 42 Их Эзэнээс Өөрийн Сүмд өгсөн хууль	52
Сургаал ба Гэрээ 43 Их Эзэн бидэнд хандан ярьдаг арга замууд	54
Сургаал ба Гэрээ 44 Чуулганы зорилго	55
Сургаал ба Гэрээ 45 Есүс Христийн Хоёр дахь ирэлт	55

*Тэмдэглэл: Сургаал ба Гэрээ 1 Огайо болон Миссурид байх үеүдэд хүлээн авагджээ.

Сургаал ба Гэрээ 46	
Сүнсний бэлгүүд	57
Сургаал ба Гэрээ 47	
Сүмийн түүхчийн дуудлага	59
Сургаал ба Гэрээ 48	
Көртландад газар худалдаж авсан нь	59
Сургаал ба Гэрээ 49	
Христийн Хоёр дахь Ирэлтэд Итгэгчдийн Нэгдсэн Нийгэмлэг (Шейкерүүд)-г зориулсан захиас	60
Сургаал ба Гэрээ 50	
Сүнсний ажлуудыг ойлгох нь	61
Сургаал ба Гэрээ 51	
Өргөлийн хуулийн тухай нэмэлт заавар	62
Сургаал ба Гэрээ 52	
Сион, Шинэ Иерусалим илчлэгдсэн нь	63
Сургаал ба Гэрээ 53	
Сидней Гилбертийн дуудлага	64
Сургаал ба Гэрээ 54	
Гэрээнүүд ба тэдгээрийн үр дагаврууд	65
Сургаал ба Гэрээ 55	
В.В.Фелпс ажилд дуудагдсан нь	65
Сургаал ба Гэрээ 56	
Даруу бус хүмүүст өгсөн зэмлэл	66
Сургаал ба Гэрээ 57	
Сионы төв газар илчлэгдсэн нь	67
Сургаал ба Гэрээ 58	
Сионы талаарх Их Эзэний хүсэл	69
Сургаал ба Гэрээ 59	
Сион болон түүний гадаснуудад өгсөн зарлигууд	71
Сургаал ба Гэрээ 60	
“Тэд цагаа дэмий үрэх ёсгүй”	72
Сургаал ба Гэрээ 61	
Усан дээрх аюул	73
Сургаал ба Гэрээ 62	
Таны гэрчлэл тэнгэрт цэдэглэгддэг	74
Сургаал ба Гэрээ 63	
Сионд бэлтгэх нь	75
Сургаал ба Гэрээ 64	
Бусдыг уучлах нь	77
Сургаал ба Гэрээ 65	
Газар дээрх Бурханы хаант улс Тэнгэрийн хаант улсын замыг бэлтгэдэг	79
Сургаал ба Гэрээ 66	
Вильям Э.МакЛелин-“Цэвэр ариун болой чи, гэвч бүгдээр биш”	80
Сургаал ба Гэрээ 67	
Судрын сорилт	81
Сургаал ба Гэрээ 68	
Судрууд, Бурханы хүч ба эцэг эхчүүд	82
Сургаал ба Гэрээ 69–70	
Бурханы илчлэлтүүд-Ариун ажил үүрэг	83
Сургаал ба Гэрээ 71	
“Таны эсрэг ямар ч зэвсэг амжилтанд хүрэх нь үгүй”	84

Сургаал ба Гэрээ 72	
Бишопын ажил үүргүүдийн талаарх нэмэлт мэдээлэл	84
Сургаал ба Гэрээ 73	
Библийн Иосеф Смитийн орчуулгыг дуусгасан нь	86
Сургаал ба Гэрээ 74	
Бошиглогчийн асуулт	86
Сургаал ба Гэрээ 75	
Номлолын дуудлага	87
Сургаал ба Гэрээ 76	
Алдар суугийн өөр өөр зэрэглэлийн тухай үзэгдэл	88
Сургаал ба Гэрээ 77	
Иоханы илчлэлтийн талаарх асуултууд	91
Сургаал ба Гэрээ 78	
Бишопын агуулахыг бий болгох хэрэгцээ	92
Сургаал ба Гэрээ 79–80	
Номлолын дуудлага	93
Сургаал ба Гэрээ 81	
Ерөнхийлөгчийн Зөвлөлд өгсөн Их Эзэний зөвлөгөө	93
Сургаал ба Гэрээ 82	
Сионыг байгуулахтай холбоотой зааврууд	93
Сургаал ба Гэрээ 83	
Эмэгтэйчүүд, хүүхдүүдийн төлөө хүлээх хариуцлага	96
Сургаал ба Гэрээ 84	
Санваарын тухай илчлэлт	96
Сургаал ба Гэрээ 85	
Юмсыг өөрийнхөө эсвэл Их Эзэний аргаар хийх нь	99
Сургаал ба Гэрээ 86	
Улаан буудай хийгээд зэрлэг өвснүүдийн тухай сургаалт зүйрлэл	100
Сургаал ба Гэрээ 87	
Дайны тухай бошиглол	100
Сургаал ба Гэрээ 88	
Чидуны навч: Амар амгалангийн захиас	101
Сургаал ба Гэрээ 89	
Мэргэн Ухааны Үг	103
Сургаал ба Гэрээ 90	
Хаант улсын түлхүүрүүд	105
Сургаал ба Гэрээ 91	
Апокриф	107
Сургаал ба Гэрээ 92	
Цог золбоотой гишүүн бай	107
Сургаал ба Гэрээ 93	
Гэрэл ба үнэн	107
Сургаал ба Гэрээ 94	
Сүмийн барилгын хороонд зориулсан зааврууд	109
Сургаал ба Гэрээ 95	
Миний өргөөг барь!	110
Сургаал ба Гэрээ 96	
Көртланд дахь газрыг хуваасан нь	111


Сургаал ба Гэрээ 97	
Ариун сүмүүд ба Сион	112
Сургаал ба Гэрээ 98	
Мөрдлөг хавчлагад өгсөн хариу	113
Сургаал ба Гэрээ 99	
Жон Мурдокийн номлолын дуудлага	114
Сургаал ба Гэрээ 100	
Номлолын талаар Бошиглогч Иосеф Смит, Сидней Ригдон хоёрт өгсөн зөвлөгөө	115
Сургаал ба Гэрээ 101	
Миссурийн Жаксон гүнлэг дэх зовлон зүдгүүрүүдэд хариулсан нь	116
Сургаал ба Гэрээ 102	
Дээд Зөвлөлүүд ба Сүмийн сахилга бат	119
Сургаал ба Гэрээ 103	
Сион гэтэлгэгдэх үү?	119
Сургаал ба Гэрээ 104	
“Миний өөрийн аргаар”	120
Сургаал ба Гэрээ 105	
Сионы Хуаран	122
Сургаал ба Гэрээ 106	
“Шөнийн хулгайч мэт”	125
Сургаал ба Гэрээ 107	
Санваарын тухай илчлэлт	125
Сургаал ба Гэрээ 108	
“Ах нараа хүчирхэгжүүл”	127
Сургаал ба Гэрээ 109	
Көртландын Ариун сүмийг онцгойлон адисалсан нь	128
Сургаал ба Гэрээ 110	
Көртландын Ариун сүмд Их Эзэн хүрэлцэн ирж, түлхүүрүүдийг сэргээсэн нь	129
Сургаал ба Гэрээ 111	
Салем дахь эрдэнэс	130
Сургаал ба Гэрээ 112	
Арванхоёр Төлөөлөгчийн ажил	131
Сургаал ба Гэрээ 113	
Судруудын тухай асуултууд	132
Сургаал ба Гэрээ 114	
Давид В.Паттенд өгсөн илчлэлт	133
Сургаал ба Гэрээ 115	
Фар Вестийн Ариун сүм	133
Сургаал ба Гэрээ 116	
Адам-ондай-Аман	134
Сургаал ба Гэрээ 117	
“Нэрийн төдий бус харин ажил үйлсээрээ”	135
Сургаал ба Гэрээ 118	
Шинэ Төлөөлөгчид	136
Сургаал ба Гэрээ 119–120	
Аравны нэгийн хууль	138
Сургаал ба Гэрээ 121	
“Олон нь дуудагддаг боловч цөөхөн нь сонгогддог”	139
Сургаал ба Гэрээ 122	
“Хүмүүсийн чамд хийх зүйлээс бүү эмээ”	142
Сургаал ба Гэрээ 123	
Цэдэг хөтлөхийн ач холбогдол	142
Иллинойн Науву дахь Сүм	144
Сургаал ба Гэрээ 124	
Ариун барилгууд ба ариун дуудлагууд	144
Сургаал ба Гэрээ 125	
Зарахемла, Айова	146
Сургаал ба Гэрээ 126	
Бригам Янгд өгсөн илчлэлт	147
Сургаал ба Гэрээ 127–128	
Нас барагсдын өмнөөс хийх баптисмын ёслолын тухай зааврууд	148
Сургаал ба Гэрээ 129	
Гурван их түлхүүр	149
Сургаал ба Гэрээ 130	
Сургаалын үнэт эрдэнэс	150
Сургаал ба Гэрээ 131–132	
“Гэрлэлтийн шинэ бөгөөд үүрдийн гэрээ”	151
*Сургаал ба Гэрээ 133	
Аврагчийн Ирэлтэд замыг бэлтгэх нь	154
Сургаал ба Гэрээ 134	
Засаглалын талаарх итгэл бишрэл	156
Сургаал ба Гэрээ 135	
Үнэний төлөө өгүүтгэгдсэн нь	157
Сургаал ба Гэрээ 137	
Селестиел хаант улсын тухай үзэгдэл	159
Сүм Өрнөд рүү шилжсэн нь	161
Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх залгамжлал	
Сүмийн шинэ Ерөнхийлөгчийг сонгосон нь	162
Өрнөд рүү хийсэн аян (1845–1847)	
Эхэн үеийн анхдагчдаас бид юу сурч болох вэ?	163
Сургаал ба Гэрээ 136	
“Бүх хүмүүс . . . бүлгүүдэд зохион байгуулагдаг”	169
Ерөнхийлөгч Бригам Янг	
Бурханы хаант улсад зориулж хоргодох газар барих нь	169
Ерөнхийлөгч Бригам Янгийн өв	
Хожмын үеийн Мосе	177
Ерөнхийлөгч Жон Тейлор	
Эрх чөлөөний төлөө тэмцэгч	179
Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф	
Тунхаг Бичиг	184
Албан Тунхаг 1 болон “Гурван удаагийн хэлсэн үгнээс авсан хэсэг . . .”	
Олон эхнэр авах ёсыг Их Эзэн төгсгөл болгосон нь	189
Өргөжилтийн үе	190
Ерөнхийлөгч Лорензо Снөү	
Аравны нэгийн тухай илчлэлт	190

*Тэмдэглэл: Сургаал ба Гэрээ 133 Огайо болон Миссурид байх үеүдэд хүлээн авагджээ.

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит	
Сайн мэдээний сургаалын багш	193
Сургаал ба Гэрээ 138	
Нас барагсдын гэтэлгэлийн тухай үзэгдэл	198
Ерөнхийлөгч Хебер Ж.Грант	
Их Эзэнд үйлчлэхээр шийдсэн нь	199
Ерөнхийлөгч Жорж Альберт Смит	
Нэр төртэй үйлчлэгч?	203
Дэлхий дахины Сүм	207
Ерөнхийлөгч Давид О.МкКей	
“Гэр орон дахь бүтэлгүйтлийг ямар ч амжилт нөхөж чадахгүй”	207
Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит	
Сайн мэдээний шашны номлогч ба зохиолч	211
Ерөнхийлөгч Харольд Б.Лий	
Аварга Улаан Мод	214
Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл	
“Алхаагаа уртасга”	217
Албан Тунхаг 2	
Зохистой эрэгтэй хүн бүр санваарыг эзэмшиж болно	221
Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон	
Мормоны Номоор газар дэлхийг дүүргэсэн нь	222
Ерөнхийлөгч Ховард В.Хантер	
Христийнх шиг хайрыг эзэмшсэн хүн	226
Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли	
“Би өөдрөг үзэлтэй хүн. Ирээдүй сайн сайхан харагдаж байна гэж би боддог”	230
Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг	234
Амьд Христ:Төлөөлөгчдийн гэрчлэл	236
Итгэлийн Тунхаг	
Бид юунд итгэдэг вэ?	238
Сүмийн түүхэн дэх бидний байр	
Итгэлийн өв	241
Сургаал ба Гэрээн дэх Хүмүүс ба нэр томьёонууд	244

Энэ гарын авлагыг хэрхэн ашиглах вэ?

Судруудыг судлахад тань гарын авлагын хэсэг бүр танд удирдамж болно. Уншсан зүйлээ илүү сайн ойлгоход туслах хэсгүүдийг агуулдаг.



A Агуулга

Нээлттэй номын зурган дээр бичигдсэн гарчиг дор таны уншихаар товлосон судрын бүлгүүд эсвэл хэсгийн оршлууд байгаа. Эдгээр оршил хэсгүүд нь дараах мэдээллүүдийг агуулдаг:

- Түүхэн үндэс
- Тухайн судрын хэсэг нь өмнөх болон дараах хэсэг бүлэг буюу хэсгүүдтэй хэрхэн холбогдолтой болох талаарх тайлбар
- Уншихын өмнө эсвэл унших үедээ судрын хэсгийн захиас дээр анхаарал төвлөрүүлэхэд тань туслах асуулт болон санаанууд

Б Судруудыг судлах нь

“Судруудыг ойлгох нь” хэсэг нь судруудад агуулагдсан санаа болон үзэл баримтлалууд, хэцүү үг, огуулбэр болон тайлбарыг ойлгоход тань тусална. Сүмийн Ерөнхий эрх мэдэлтнүүдийн үгсийг тайлбарт олонтаа оруулсан байгаа.

В Судруудыг судлах нь

“Судруудыг судлах нь” хэсэг нь судруудад байдаг сайн мэдээний зарчмуудыг нээж олох, тунгаан бодох, амьдралд хэрэглэхэд туслах асуултууд болон үйл

ажиллагаануудыг агуулдаг. Гарын авлага дээр бичих зай байхгүй, иймд та эдгээр үйл ажиллагаануудыг тэмдэглэлийн дэвтэр эсвэл цаасан дээр хийх хэрэгтэй.

Судруудыг судлахад тань дараах алхмууд тусална:

- Залбирлаар эхэл.
- Судлах бүлэг буюу хэсгийн оршлыг уншиж, “Уншихын өмнө” хэсэг дэх судлах ур чадварыг үз (х. 00 [3–4]-ийг үз).
- Холбогдох “Судруудыг ойлгох нь” хэсгийг ашиглан товлосон бүлэг буюу хэсгийг унш. “Унших үед” хэсэг дэх судлах аргуудаас ашигла (х.00 4–5-ийг үз). Тэмдэглэл болон асуултуудыг тэмдэглэлийн дэвтэртээ бич. Бас өөрийн чинь хувьд нэн чухал бодол санаа, сэтгэгдлийн тухай бич.
- Өөрийн суралцаж буй бүлэг болон хэсгийн “Судруудыг судлах нь” хэсэг дэх үйл ажиллагаануудыг хий. Аль үйл ажиллагааг хийхээ сонго. Хэрэв та илүү ихийг мэдэхийг хүсвэл, бүх үйл ажиллагааг хий.

Гэрээр судлах семинарын хөтөлбөр

Хэрэв та гэрээр судлах семинарын хөтөлбөрт хамрагддаг бол хуудас 7 дээрх унших хуваарь нь семинарын долоо хоногт юу унших ёстойг харуулах болно. Семинар бол шашны боловсролын өдөр тутмын хөтөлбөр. Судруудыг залбиралтайгаар унших нь таны өдөр тутмын зуршил байх ёстой. Өдөр бүр семинарын ангид хамрагдах боломжгүй ч гэсэн даалгаврууд дээр өдөр бүр ажиллах хэрэгтэйг сана. Хэрэв таны семинарт хамрагдах хугацаа гучин зургаан долоо хоногос илүү эсвэл дутуу бол долоо хоногт ямар бүлэг болон хэсгүүдийг унших, ямар даалгавар хийж дуусгахыг багш чинь хэлж өгөх болно. Бие даан судруудыг уншиж, энэхүү судлах гарын авлагыг ашиглахад өдөр бүр 30–40 минут зарцуул.

Тухайн долоо хоногт суралцсан судруудын тухай өөрсдийн санаа бодол, суралцах удирдамж дахь үйл ажиллагаануудыг хийж гүйцэтгэсэн тэмдэглэлээ долоо хоног бүр багшдаа өгч байх ёстой. Багш тэдгээрийг уншиж, тэдэнд хариулан, таны тэмдэглэлийг буцааж өгнө. Та хоёр тэмдэглэлийн дэвтэр гаргаж долоо хоног бүр ээлжлэн ашиглах эсвэл салдаг хуудастай үдэгч хавтас ашиглаж болно. Багш хуудсыг эргүүлж өгөхөд, үдэгч хавтасандаа хуудсыг буцааж хий.

Өдөр тутмын семинарын хөтөлбөр

Хэрэв та өдөр бүр семинарт явдаг бол уг судлах удирдамжийг багшийн заавраар ашиглах болно.

Судруудыг судлах нь

Судруудыг уншиж, судлан ойлгоход тань туслахын тулд энэхүү гарын авлагыг бэлтгэсэн болно. Таны суралцах цагийн ихэнх нь судруудыг уншиж, тунгаан бодоход зориулагдах учраас, таны цагийг илүү үр ашигтай болгоход туслахын тулд энэ хэсгийг оруулсан болно.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан Ахлагч Ховард В.Хантер судар судлах талаар Сүмийн гишүүдэд үнэтэй зөвлөгөө өгснийг дор хураангуйлав. Түүний санаануудыг хуудсан дээр бичиж, суралцах үед харагдахаар газарт байрлуулж болно.

- Судруудыг ойлгохын тулд анхааралтай унш.
- Өдөр бүр судал.
- Өдөр бүр суралцах тогтмол цагийг товло.
- Анхаарал сарниулан, саад болохооргүй газарт суралц.
- Тодорхой тооны бүлэг болон хуудсыг уншихын оронд тодорхой хугацаагаар суралц.
- Суралцах төлөвлөгөө гарга.

(In Conference Report, 1979 оны 10-р сар, х. 91-93; *Ensign*, 1979 оны 11-р сар, х. 64-65-ыг үз.)

Хожмын Үеийн Гэгээнтний судруудын хэвлэл дэх судлах тусламжуудыг ашиглан судлах сайн ур чадвартай болсон үед та судраас судлахад илүү ашиг тусыг олох болно.

Хожмын Үеийн Гэгээнтний судруудын хэвлэл дэх судлах тусламжууд

Харьцуулах эшлэлүүд

Харьцуулах эшлэл нь таны судалж буй сэдвээр нэмэлт мэдээлэл, гүн ойлголт руу чиглүүлэх судрын эшлэл юм.

34 Эдгээр “үгс нь хүмүүсийнх буюу хүнийх биш, харин минийх бөлгөө; иймийн тул, тэдгээр нь хүнийх биш, харин минийх гэдгийг та нар гэрчлэх ёстой;

35 Учир нь тэдгээрийг та нарт ярьсан нь миний “дуу хоолой болой; учир нь миний Сүнсээр та нарт тэдгээр нь өгөгдсөн авай, мөн миний хүчээр та нар тэдгээрийг бие биендээ уншиж өгч болох

6 Марк 16:15-16.
29а 3 Ниф. 11:21-28;
С ба Г 20:72-74.
31а С ба Г 107:23-35.
32а С ба Г 20:27.
6 2 Петр 1:21;
С ба Г 68:3-4.
6 Моро. 3:1-4;

С ба Г 20:60; 107:58.
су Томилох,
Томилонт.
34а/су Судрууд.
35а С ба Г 1:38.
су Дуу хоолой.

Жишээ нь:
Сургаал ба Гэрээ 18:34-35-ыг уншиж, зүүвэр тайлбар 35а-г анхааран үз. Зүүвэр тайлбарт эш татагдсан судрыг олж уншснаар, Их Эзэний дуу хоолой хэрхэн сонсогддог талаар ямар нэмэлт ойлголтуудыг олж авч болох вэ?

Судруудын Удирдамж

Судруудын Удирдамж (СУ) нь Сүмийн бүх дөрвөн жишиг бүтээл дэх судрын эшлэлүүдтэй цагаан толгойн дэс дарааллаар хийсэн хэдэн зуун сэдвийн жагсаалтыг агуулдаг. Судруудын Удирдамжид Библийн олон нэр, сэдвүүдийн тодорхойлолт, тайлбарууд байдаг. Зүүвэр тайлбаруудад эш татагдаагүй нэмэлт эшлэлүүдийг үзэхийн тулд Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувдын индексийг үзэж болно.

39 Мөнхүү улиран тохиох дор, надаас “эмээдэг тэрээр Их Эзэний агуу “өдөр ирэхийг, бүр “Хүний Хүүгийн ирэлтийн “тэмдгүүдийг “хүсэн хүдээсээр байх болно.

40 Мөн тэмдгүүд болон гайхамшгуудыг тэд үзэх болно, учир нь дээр тэнгэрт, мөн доор дэлхийд тэдгээр нь үзүүлэгдэх болно.

6 С ба Г 63:33.
35а Марк 24:6.
37а Марк 13:28;
Лук 21:29-31.
39а С ба Г 10:55-56.
су Айх, эмээх—
Бурханаас эмээх;
Дуулгавартай байх,
Дуулгавартай,
Дуулгавартай

дагах.
6 су Есүс Христийн
Хоёр дахь Ирэлт.
6 су Хүний Хүү.
2 су Паг хугацааны
тэмдгүүд.
8 2 Петр 3:10-13;
С ба Г 35:15-16;
Моце 7:62.

болон “хүндэтгэл” сэдвийг анхааран үз. Их Эзэнд хүндэтгэл үзүүлэх хэрэгтэйг тод томруунаар харуулсан судрын эшлэлийг ол. Эмээх гэдэг үгийн хоёр өөр утгын тайлбарыг олохын тулд Судруудын Удирдамжаас (240-р хуудсыг) хар.

12 Гэхдээ энэхүү, Их Эзэний өдөр, чи нүглүүдээ ахан дүүстээ, мөн Их Эзэний өмнө “хүлээж, өөрийнхөө” өргөлүүд хийгээд өөрийнхөө ариун ёслолуудыг Бүхний Дээдэд өргөх ёстой гэдгийг санагтун.

13 Мөн чиний “мацаг барилт төгс байж болохын тулд, эсвээс, өөр үгээр, “баяр хөөр чинь дүүрэн байж болохын тулд энэ өдөр/чи хоол хүнсээ гагцхүү чин сэтгэлээсээ бэлтгэхээс өөр юу ч хийх ёсгүй.

Зөв шударга ёс.
6 су Харууссан зүрх.
6 су Золиослол.
9а Иаков 1:27.
6 су Хүндэтгэлийн өдөр.
10а су Шүтэн бишрэх.
12а су Хүлээн зөвшөөрөх, Хүлээн зөвшөөрөлт.
6 ө.х. Бурхан болон бусад хүний төлөөх үйлчлэлд

цаг зав, авьяасаа мөн, тусламж өгөх. су Золиослол.
13а су Мацаг барих. Мацаг барилт.
6 су Баяр баясгалан.
15а су Талархалтай, Талархах, Талархал өргөх.
6 Ег. 25:2; С ба Г 64:34.
6 Сур. үгс 17:22.
2 С ба Г 88:69.

Жишээ нь:
Сургаал ба Гэрээ 45:39-ийг унш. Ингэхдээ та “надаас эмээдэг тэрээр” гэсэн нийлэмж үгэн дэх эмээдэг гэдэг үгийн тухайд гайхаж болно. Их Эзэн Өөрөөсөө айдаг байхыг биднээс хүсдэг хэрэг үү? Судруудын Удирдамж дахь зүүвэр тайлбар

Сургаал ба Гэрээ 59:12 дахь өргөллүүд гэдэг үгийн утгыг ойлгоход зүүвэр тайлбар та нарт хэрхэн тусалдаг вэ? Хүндэтгэлийн өдөр та ямар төрлийн өргөллүүд өргөж болох вэ? Хоол ундгүй явахаас гадна мацаг барилт нь өөр ямар утгатай вэ?

Библийн Иосеф Смитийн орчуулга

Библийг судалж, Библийн илүү бүрэн, зөв орчуулгатай болох талаар илчлэлт эрэлхийлэхийг Бошиглогч Иосеф Смитэд Их Эзэн зарлиг болгожээ (С ба Г 45:60-ыг үз). Үүний үр дүнд буруу орчуулагдсан, тодорхой бус буюу бүрэн биш (Итгэлийн Тунхаг 1:8-ыг үз) байж болох Библийн хэсгүүдэд олон чухал үнэнийг Бошиглогч Иосеф Смит сэргээж, олон чухал өөрчлөлт оруулсан билээ. Сүнслэг мэдрэмжээр бичигдсэн энэхүү хувилбарыг “Иосеф Смитийн Орчуулга” гэдэг. Эл орчуулгыг “ИСО” гэж товчилдог. Иосеф Смитийн Орчуулгын зарим өөрчлөлт Судруудын Удирдамж дахь “Библийн Иосеф Смитийн Орчуулгаас Авсан Түүврүүд” нь 246-р хуудаснаас эхлэн байдаг.

Библийн газрын зураг ба гэрэл зургууд

Судруудын Удирдамжид байдаг газрын зураг болон гэрэл зургууд нь судруудад дурьдагддаг газар нутгуудыг олоход тусалдаг.

Сүмийн түүхийн он дараалал, газрын зургууд хийгээд гэрэл зургууд

1999 онд Сүм гурамсан сударт шинэ газрын зургууд, гэрэл зургуудыг нэмжээ. Эдгээр зургууд Хожмын Үеийн Гэгээнтний Хаан Жеймсийн хэвлэлийн Библийн холбогдох зургуудтай адил юм. Энэ хэсэгт Сүмийн түүхийн үйл явдлуудын он дараалал байдаг. Энэ хэсгийг үзэж, Бошиглогч Иосеф Смит Мормоны Номын орчуулгыг хэдэн оны хэдэн сард дуусгасныг мэд. Газрын зураг 2-ыг үзэж, Эцэг Иосеф Смитийн дүнзэн байшинг ол. Ямар чухал үйл явдал энд болсон бэ? (тэмдэглэл 1-ийг үз).

Бүлгийн тойм, хэсгийн тойм ба шүлгийн товч утга

Бүлгийн болон хэсгийн тойм, шүлгийн товч утга нь унших зүйлээ ойлгоход тань туслах суурь мэдээллийг өгөх буюу тайлбарладаг. Жишээ нь: Сургаал ба Гэрээ 89-ийн хэсгийн тоймыг уншсанаар та ямар ашигтай мэдээллийг олж авах вэ?

Хожмын Үеийн Гэгээнтний судруудын хэвлэл дэх судлах тусламжуудтай байх нь бүх зүйл нэг дор байдаг эшлэлийн цоморлиг болох бяцхан номтой байхтай адил юм!

Судлах ур чадвар

Бид “Христийн үгс дээр найрлах” (2 Нифай 32:3) ёстой гэж Нифай хэлсэн бөгөөд “[судруудыг] хичээнгүйлэн судлахыг” (3 Нифай 23:1) Есүс нифайчуудад зарлиг болгожээ. Ийнхүү хичээнгүйлэн судлах нь судруудыг зүгээр хурдан гүйлгэн уншихаас илүү чухал юм. Дараах санаанууд болон ур чадвар нь судалж байгаа үед илүү ихийг сурахад тань туслах болно. Эдгээр нь: Уншихын өмнө, унших үед, уншсаны дараа гэсэн гурван төрөлд хуваагддаг.

Уншихын өмнө

Залбирал



Судрууд сүнслэг мэдрэмжээр бичигдсэн юм. Иймээс Ариун Сүнсний нөхөрлөл бидэнд байгаа үед судрууд хамгийн сайн ойлгогддог. “ЭЗЭНий хуулийг сурч, хэрэгжүүлэхэд зүрхээ зориулсан” (Езра 7:10) санваартан Езрагийн тухай бид Хуучин Гэрээнээс мэддэг билээ. Унших бүрдээ залби-

рах замаар судруудыг уншихад зүрх сэтгэлээ бэлтгэгтүн.

Суурь мэдээллийг олж ав



Судруудын түүхэн үндсийг ойлгох нь унших үедээ илүү их гүн ойлголт олж авахад тань туслах болно. Судруудын Удирдамж нь ном бүрийн агуулга болон гол сэдвүүдийн товч тойм, түүхэн суурь мэдээллээр хангасан байдаг. Сургаал ба Гэрээн дэх хэсгийн тоймуудад илчлэлтүүдийн түүхэн

үндсийн товч тайлбар байдаг. Гурамсан судрын ар тал дахь индекс нь ашигтай мэдээллийг агуулдаг. Хэрэв боломжтой бол та судалж байгаа судрынхаа түүхэн үндсийн тухай Сүмээс нийтэлсэн бусад ном, гарын авлагуудаас лавлаж болно.

Асуултууд асуу

“Энэ шүлгүүдийг хэн бичсэн юм бол?” “Хэнд зориулж бичсэн юм бол?” “Энэ сургаал яагаад судруудад орсон юм бол?” “Өнөөдөр би уншихдаа юу мэдэж, юу сурах вэ?” “Энэ судруудаас юуг мэдэж авахыг Их Эзэн надаас хүсэх бол?” гэх мэт асуултуудыг уншихаасаа өмнө өөрөөсөө асуух нь ашигтай. Судруудыг уншихдаа, асуултуудынхаа хариуг эрж хай. Судруудын Удирдамж дахь судлах тусламжуудыг ашиглаж болохоос гадна Сүмийн гарын авлага, бусад ном хэвлэлүүдээс хариуг хайж болно гэдгийг сана.

Хэсгийн тойм болон шүлгийн товч утгыг унш



Хэсгийн тоймууд нь Сургаал ба Гэрээний хэсэг тус бүрийн агуулгыг товч, хэрэгцээтэй түүхэн суурь мэдээллээр хангадаг. Шүлгийн товч утга нь тухайн хэсэг дэх гол санаануудын энгийн товч тойм юм. Хэсгийн тойм, шүлгийн товч утгыг тухайн хэсгийг судлахаасаа өмнө унших нь зөвхөн судлах сайн зуршил болох төдийгүй, асуултууд асуух, унших үедээ хариуг эрэхэд өөрсдийгөө бэлтгэхэд тань туслах болно.

Унших үед

Зогсолт хийхээс бүү ай

Ихэнх шижир алт газрын гадаргуу дээр байдаггүй-шижир алтыг газар дороос ухаж гаргадаг. Хэрэв та удаан тогтож, түр зогсолт хийн, холбогдох зарим үйл ажиллагаануудаас хийж, судлах аваас таны судраас судлах явдлыг улам үнэ цэнэтэй болгоно.

Ойлгохгүй үгсийн утгыг толь бичгээс хар



Толь бичиг ашиглаж бай. Өөрийнхөө мэддэг гэж боддог аль нэг үгийг толь бичгээс харах нь зарим үед танд нэмэлт ойлголт өгч болно. Энэ гарын авлагын “Судруудыг ойлгох нь” хэсгүүд нь олон хэцүү үг, хэллэгийн утгыг ойлгоход тань тусална.

Зарим үед Их Эзэн сүнслэг өдөөлтөөр Өөрийн бошиглогчдоор дамжуулан бичээсүүдэд тайлбар хийлгэж үгс, нийлэмж үгсийн утгыг мэдэхэд бидэнд тусалдгийг анхаар. Жишээ нь: Сургаал

ба Гэрээ 41:5-ыг уншиж, Түүний шавь байна гэдэг нь юу гэсэн үг болох талаар Их Эзэн юу гэж хэлснийг ол.

Судруудын Удирдамж дахь судлах тусламжуудыг ашигла

“Судруудын Удирдамж дахь Судлах тусламжууд” хуудас 00 (2–3) дээрх хэсгийг үз.

Судрыг өөртэйгөө адилтга

Шүлэгт өөрийнхөө нэрийг хэрэглэх нь судрын сургаалуудыг илүү хувийн шинжтэй болгоход тусалдаг. Жишээ нь: Та Сургаал ба Гэрээ 30:1–2-ыг уншихдаа “Давидын” оронд өөрийнхөө нэрийг хэрэглэвэл, ямар өөрчлөлт гарах вэ?

Үзүүлэнтэй болго



Юу болж байгааг санаандаа зураглан дүрсэл. Жишээ нь: Иосеф Смит-Түүх 1:27–47-г унших үед, тэнгэр элч унтлагын өрөөнд чинь гурвантаа хүрч ирэн чухал захиасыг чамд өгвөл, ямар мэдрэмж төрөхийг төсөөлөн бодохыг хичээ.

Заримдаа судрууд дүрслэн бодохыг бидэнд хэлдэг.

Алма 5:15–18-ыг уншиж, Алмагийн хэлснийг хий. Энэ шүлгүүдийг дүрслэн бодох үед ямар санагдсан тухайгаа бичих цаг гарга.

Холбоос үгсийг хай

Холбоос үгс нь *гэвч, учраас, улмаас, иймээс, гэсэн хэдий ч* гэх мэт. Та эдгээр үгсийг унших үедээ эдгээр нь хоёр буюу түүнээс дээш санааг ойлгоход тусалдгийг анхаар. Заримдаа эдгээр нь хоёр буюу түүнээс олон зүйлсийг адил төстэй болон ялгаатайг нь харуулдаг.

Жишээ нь: Хэрэв та Сургаал ба Гэрээ 84:54–55 дахь *улмаас* гэдэг үг юуг харуулж байгааг бодох юм бол Мормоны Номын ач холбогдлын тухай чухал үнэнийг мэдэж чадна.

54 Мөн “итгэлгүйн улмаас, мөн та нар өөрсдийнхөө хүлээн авсан зүйлүүдэд хөнгөмсгөөр хандсаны улмаас та нарын оюун өнгөрсөн үед харанхуйлагдсан байлаа —

55 Энэхүү “хоосон болон итгэлгүй байдал нь бүхэл сүмийг буруушаалт дор авчирсан буюу.

Улмаас, учраас гэдэг үгс нь Гэгээнтнүүдийн итгэл, Мормоны Номын төлөө талархах тэдний талархал, илчлэлт болон Их Эзэний адислалуудыг хүлээн авах чадварынх нь хоорондох шалтгаан-үр дагаврын холбоог харуулж байна.

Сургаал ба Гэрээ 45:30–32-ыг уншиж, *учир нь, харин* гэсэн үгс хожмын өдрүүд дэх ёс бус болон зөв шударга хүмүүсийн эсрэг тэсрэг байдлыг хэрхэн харуулж байгааг анхааран үз.

30 Мөн тэр үед харийнханы цаг гүйцэлдэх болно.

31 Мөн давшгүй их “цээрлүүлэлтийг үзэх хүртлээ, үхэхгүй хүмүүс тэр үед амьдарсаар байх болно; учир нь эзгүйрүүлэгч өвчин уг нутгийг бүрхэх болно.

32 Гэвч миний шавь нар ариун газруудад “амьдарсаар байх болно, мөн шилжин нүүлгэгдэх нь үгүй бөлгөө; харин ёс бусчуудын дундах хүмүүс дуу хоолойгоо өргөж тэгээд Бурханыг “зүхэн мөн үзэх болно.

Харин гэдэг үгийг онцгойлон анхаарах юм бол зөв шударга хүмүүс Хоёр дахь Ирэлтийн өмнөх устгалуудаас аврагдах болно гэдэг баттай итгэлийг бидэнд төрүүлж чадна.

Загваруудыг хай

Сургаал ба Гэрээ 52:14-т Сатаны заль мэхнээс бид зайлсхийж болох загварыг Тэрээр бидэнд өгөх болно хэмээн Их Эзэн тунхагласан юм. Дараа нь шүлэг 19-д Тэрээр энэ загварыг харуулжээ. Сайн болон муу ёрын сүнснүүдийг хэрхэн таних талаар шүлэг 14 ба 19-т байдаг Их Эзэний тусламжийг мэдсэнээр бид уг загваруудыг ойлгохын тулд эдгээр шүлгүүдийг уншиж, судлах ёстой.



Загварыг олох өөр нэг жишээ бол *хэрэв, мөн, тэгвэл* гэсэн үгсийг Тэрээр хэрхэн ашигласныг харах замаар шалтгаан-үр дагаврыг харуулсан Их Эзэний тайлбарыг эрж хайх явдал

мөн. Сургаал ба Гэрээ 5-д Мартин Харриет Их Эзэний онцгой бэлгийг хүлээн авахын тулд юу хийх ёстойг хэлжээ. Шүлэг 24-ийг уншиж, мөн загварыг ол. Тэрээр эрэлхийлж байсан адислалаа хүлээн авахын тулд түүнд юу гэж хэлснийг эрж ол.

Үг, нийлэмж үг буюу санааг давтах нь эрж хайвал зохих өөр нэг загвар юм. Жишээ нь: Сургаал ба Гэрээ 11; 12; 14-р хэсгийн эхний таван шүлгийн агуулгыг харьцуул. Эдгээр илчлэлт тус бүр нь Их Эзэний хаант улс дахь хөдөлмөрөө эхэлж байгаа Сүмийн гишүүдэд өгөгджээ. Их Эзэн Өөрийн үйлчлэгч бүхэнд үүнтэй адил захиас өгснийг анхааран үз.

Судрууд дахь жагсаалтуудыг хай



Их Эзэний болон Түүний бошиглогчдын заасныг тодорхой ойлгоход жагсаалтууд тусалдаг. Арван Зарлиг бол жагсаалт юм (Египетээс Гарсан нь 20-ийг үз). 3 Нифай 12:3–11 дэх Ерөөлүүд бол жагсаалт гэдгийг хялбархан харж болно. Бусад жагсаалтуудыг олоход бага

ээрэг чармайлт шаардагдаж болно. Жишээ нь: Хүүхдүүдээ заахад эцэг эхчүүдээс юу шаардагдах талаар Сургаал ба Гэрээ 68:25–31-д Их Эзэний хэлсэн зүйлсээс жагсаалт хий.

Асуултууд асуу

“Уншихын өмнө” хэсэгт зааварчилсны дагуу асуултуудыг үргэлжлүүлэн асуу. Та унших явцдаа уншихын өмнө асуусан асуултуудаа давтан асуух буюу цоо шинэ асуултуудыг асууж болно. Асуултуудад хариулт эрэх нь өөрсдийн судраас суралцахад улам баг бөх ойлголтыг олж авах хамгийн чухал арга замуудын нэг юм. Асуух ёстой чухал асуултуудын нэг нь “Яагаад үүнийг сударт оруулах сүнслэг өдөөлтийг бичигч хүнд Их Эзэн өгсөн бэ?” гэсэн асуулт юм. Бичигч зарим үед ямар нэг зүйлийг “мөн бид тийн харав” гэжчилэн илт тодорхой, гол учрыг хэлж үлдээсэн байдгийг эрж ол.

Судрууд дахь асуултуудад хариул

Их Эзэн олон удаа асуулт асууж, дараа нь уг асуултад хариулсан байдаг. Тэрээр Сүмийн зарим ахлагчдаас: “Та юунд томилогдсон юм бэ?” (С ба Г 50:13) гэж асуужээ. Тэгээд Тэрээр хариулахдаа, “Үнэнийг заахаар урагш илгээгдсэн бүр Тайтгаруулагч болох Сүнсээр миний сайн мэдээг номлохоор буюу” (ш. 14) гэжээ.

Бусад тохиолдолд асуултууд асуусан боловч хариулт нь өгөгдөөгүй-учир нь ерөнхийдөө хариулт нь тодорхой учраас (Жишээ нь: С ба Г 122:8-ыг үз). Гэвч зарим үед судрууд хариулдаггүй, учир нь асуулт нь бодохыг шаарддаг учраас тэр даруйд хариулах боломжгүй байж болно. Жишээ нь: Алма 5:14–33-ыг уншаад, өөрийгөө тэнд байгаагаар төсөөлж эдгээр шүлгүүд дэх асуултуудад хариул.

Загварууд ба билэгдлийн утгыг хай



Бошиглогчид захиасаа илүү их хүчтэйгээр дамжуулахын тулд билэгдлүүд болон дүрслэлүүдийг олонтаа ашигладаг. Жишээ нь: Сургаалт зүйрлэлүүд бол илүү гүнзгий утгатай захиасыг энгийн хэлбэрээр өгүүлэх арга юм. Сургаалт зүйрлэл дэх түүх нь заагдаж байгаа сургамжийг амархан тогтоогддог, илүү гүнзгий утгатай болгодог.

Дараах зөвлөмжүүд нь судрууд дахь билэгдлүүдийг ойлгоход тань тусална:

1. Судрууд дахь тайлбарыг хай. Жишээ нь: Матай 13 дахь улаан буудай ба зэрлэг өвснүүдийн тухай сургаалт зүйрлэлийн олонхийг Сургаал ба Гэрээ 86:1–7, 101:64–66-д тайлбарласан байдаг. Зарим үед тайлбарыг зүүвэр тайлбарууд дахь харьцуулах эшлэлийг ашигласнаар олж болно.
2. Билэгдлийн шинж чанаруудын тухай, уг билэгдэл өөрт чинь юуг зааж байгаа талаар бод. Жишээ нь: Сургаал ба Гэрээ 38:24–27-д Их Эзэн Өөрөө ямар вэ гэдгийг дуулгавартай хөвгүүдээ хайрладаг эцгийн хайрын тухай өгүүлэн, гэр бүлийн гишүүд бие биетэйгээ хайр, эв нэгдлээр харьцан нэгдмэл байхыг онцлон анхааруулжээ.
3. Билэгдэл нь Аврагчийн тухай ямар нэг зүйл зааж байгаа эсхийг анхаар. “Бүх зүйл [Түүний] тухай гэрчилдэг” (Моисе 6:63) хэмээн Их Эзэн Адамд хэлжээ. Жишээ нь: Сургаал ба Гэрээ 101:81–91-д, эмэгтэйн гуйлтуудад хариулж байгаа шүүгч, туслахыг хүссэн Гэгээнтнүүдийн гуйлтад хариулж байгаа Их Эзэнтэй хэрхэн адилхан байна вэ?

Бич



Судлах үедээ тэмдэглэлийн дэвтэр болон цаас ойр байлгаж өөрийн сурч мэдсэн онцлог ойлголтууд, эсвэл уншсан зүйлийнхээ талаарх мэдрэмж болон жагсаалтууд зэрэг эргэн санахыг хүссэн санаануудыг тэмдэглэ. Мөн дараа уншихдаа эдгээр бодол санаа, ойлголтуудыг эргэн санахад хялбар байлгахын тулд та судруудынхаа зах дээр тэдгээрийг бичиж болно.

Олонх хүмүүс чухал үгс, нийлэмж үгсийг судрууд дээрээ тэмдэглэх дуртай байдаг. Үүнийг хийх зөв эсвэл буруу арга гэж байдаггүй. (Та үүнийг хийх огт сонирхолгүй ч байж болно.) Зарим хүмүүс шүлгийн дугаарыг дугуйлж, шүлэгт чухал утга оруулж байгаа үгс, нийлэмж үгсийг будах буюу доогуур нь зурдаг. Судруудад тэмдэглэгээ хийх өөр нэг арга бол харьцуулах эшлэлийг өөр судрын зах дээр бичих явдал юм. Үүнийг ижил сэдвийн хэд хэдэн шүлгүүд дээр хийж та гинжин хэлхээт судруудтай болсноор онцгой сэдвийг гинжин хэлхээн дэх аль нэг судраас олж чадна. Судруудад тэмдэглээ хийх нь чухал шүлгүүдийг түргэн олоход олонтаа тусалж чадна.


Уншсаны дараа

Тунгаан бод



Тунгаан бодох гэдэг нь өөрийн мэддэг болон сурч мэдсэн зүйлсийнхээ талаар асуултууд асууж, эдгээрт үнэлэлт дүгнэлт өгч, гүнзгий эргэцүүлэн бодох явдал мөн. Судруудад үүнийг заримдаа “бясалгах” (Иошуа 1:8-ыг үз) гэж нэрлэдэг. Тунгаан бодсоны үр дүнд, ялангуяа судруудын талаар тунгаан бодсоноор чухал илчлэлтүүд ирсэн нилээд хэдэн сайхан жишээ судруудад байдаг (С ба Г 76:15–20; 138:1–11-ийг үз).

Судруудыг өөртэйгөө адилтга



Судруудыг өөртэйгөө адилтгах гэдэг нь тэдгээрийг өөрийн амьдралтай харьцуулна гэсэн үг. Үүнийг хийхийн тул “Миний сая уншсан судруудад сайн мэдээний ямар зарчмууд заагдаж байна вэ?” “Эдгээр зарчмууд миний амьдралд хэрхэн холбогдох вэ?” гэх мэт асуултуудыг өөрөөсөө асуух хэрэгтэй. Судруудыг өөртэйгөө адилтгахын ач холбогдол нь “та нарыг бүх үнэн рүү удирдах болно” (Иохан 16:13) хэмээн Их Эзэний амласан Ариун Сүнсний өдөөлтийг сонсох явдал мөн.

Хожмын өдрүүд дэх сургаалуудыг дүрсэлж, заахын тулд Библид заагддаг олон нөхцөл, зарчмуудыг Сургаал ба Гэрээ ашигласан байдаг. Жишээ нь: “Израилын хүүхдүүдийг Улаан Тэнгисийн дундуур хуурай газраар гаталган” (С ба Г 8:3) авчрахад Моисе илчлэлтийн сүнсийг ашигласан

юм. Узагийн адил “Бурханы авдрыг тогтвортой болгохоор” (С ба Г 85:8; мөн 2 Самуел 6:6–7-г үз) гараа сунгахгүй байхыг Сүмийн гишүүдэд анхааруулан болгоомжлуулсан байдаг. Түүнчлэн “Абрахамын ажлыг хийгтүн” (С ба Г 132:32) хэмээн Гэгээнтнүүдэд зарлиг болгожээ.


Дахин унш



Бид судрын хэсгийг анх удаа уншаад л бүх зүйлийг шууд ойлгодоггүй. Чухамдаа бол, судруудыг судалж, үнэн зөвөөр ойлгох нь насан туршийн хэрэг юм. Ихэвчлэн бид судруудыг хоёр, гурав дахин унш-

саны дараа загваруудыг харж, дүрслэлтэй болон, илүү гүнзгий ойлгодог. Дахин уншихдаа та шинэ сургаалуудыг хайх буюу өөр асуултуудыг асууж болно. Аль нэг түүхийг эсвэл нэг, хоёр шүлгийг өөрийн үгээр бичихийг хичээх нь уншсан зүйлээ ойлгосон эсэхийг мэдэхэд бас судруудыг илүү сайн ойлгоход тань тусалж болно.

Бич



Зарим хүмүүс уншсан зүйлийнхээ гол санааг мөн уншсан зүйл нь тэдэнд ямар санагдсан болон эдгээр нь амьдралд нь хэрхэн хэрэглэгддэг талаарх бодол санааныхаа тухай өгүүлэн, тэмдэглэл хөтөлдөг. Хэрэв та энэ гарын авлагыг гэрээр суралцах семинарт ашиглаж байгаа

бол кредит үнэлгээ хүлээн авахын тулд тэмдэглэлийн дэвтэр хөтлөх хэрэгтэй. Эл тэмдэглэлийн дэвтэр нь судрын тэмдэглэлтэй адилхан байх болно.

Бас уншсан зүйлийнхээ тухай бусадтай ярилцах нь сайн байдаг. Сурч мэдсэн зүйлийнхээ тухай өөрөө ярих эсвэл бусад хүмүүстэй ярилцах зорилгоор эдгээрийг эргэн санахын тулд тэмдэглэж авах нь уншсан зүйлээ ойлгож, илүү олон зүйлийг эргэн санахад тань тусална.

Хэрэгжүүл



Сурч мэдсэн зүйлсийнхээ дагуу амьдарснаар судруудаас олж авдаг мэдлэгийн бодит үнэ цэнэ нь ирдэг. Их Эзэнд нэн ойр дотно байж, бидэнд Түүний өгдөг амар амгаланг мэдрэх нь сайн мэдээгээр амьдардаг хүмүүст ирдэг адисла-луудын зөвхөн зарим хэсэг нь л юм. Түүнээс гадна сурч мэдсэн зүйлээрээ амьдардаг хүмүүст илүү их зүйл өгөгддөг бол, сурч мэдсэн зүйлээрээ амьдардаггүй хүмүүс өөрсдөдөө байгаа мэдлэгийг ч алдах болно хэмээн Их Эзэн хэлжээ (С ба Г 1:33-ыг үз).

“Судруудыг судлахад... цаг заваа зориулаг-тун; мөн тэгэхэд та нарт юу хийх ёстой нь мэдүүлэгдэх болно” (С ба Г 26:1).

Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүхийг унших хуваарь


Арван минут болон түүнээс дээш хугацаагаар унших өдрүүд

Н	Д	М	Л	П	Б	БЯ	1дэх долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	2 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	3 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	4 дэх долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	5 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	6 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	7 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	8 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	9 дэх долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	10 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	11 дэх долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	12 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	13 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	14 дэх долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	15 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	16 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	17 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	18 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	19 дэх долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	20 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	21 дэх долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	22 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	23 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	24 дэх долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	25 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	26 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	27 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	28 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	29 дэх долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	30 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	31 дэх долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	32 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	33 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	34 дэх долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	35 дахь долоо хоног
Н	Д	М	Л	П	Б	БЯ	36 дахь долоо хоног

Энэ долоо хоногт миний уншихаар төлөвлөсөн бүлгүүд

"Судруудыг судлах нь"
Иосеф Смит-Түүх 1
Тайлбар оршил Сургаал ба Гэрээ 1 2 3 4 5
Сургаал ба Гэрээ 6 7 8 9 10
Сургаал ба Гэрээ 11 12 13 14 15 16 17 18
Сургаал ба Гэрээ 19 20 21
Сургаал ба Гэрээ 22 23 24 25 26 27 28 29
Сургаал ба Гэрээ 30 31 32 33 34 35 36 37 38
Сургаал ба Гэрээ 39 40 41 42
Сургаал ба Гэрээ 43 44 45 46 47
Сургаал ба Гэрээ 48 49 50 51 52 53
Сургаал ба Гэрээ 54 55 56 57 58 59
Сургаал ба Гэрээ 60 61 62 63 64
Сургаал ба Гэрээ 65 66 67 68 69 70 71 72 73
Сургаал ба Гэрээ 74 75 76
Сургаал ба Гэрээ 77 78 79 80 81 82 83
Сургаал ба Гэрээ 84 85 86
Сургаал ба Гэрээ 87 88
Сургаал ба Гэрээ 89 90 91 92 93 94
Сургаал ба Гэрээ 95 96 97 98 99 100
Сургаал ба Гэрээ 101 102
Сургаал ба Гэрээ 103 104 105
Сургаал ба Гэрээ 106 107 108
Сургаал ба Гэрээ 109 110 111 112 113 114
Сургаал ба Гэрээ 115 116 117 118 119 120 121 122 123
Сургаал ба Гэрээ 124 125 126
Сургаал ба Гэрээ 127 128 129 130
Сургаал ба Гэрээ 131 132
Сургаал ба Гэрээ 133 134 135 137
Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх залгамжлал Өрнөд рүү хийсэн аян (1845–1847 он) Сургаал ба Гэрээ 136
Ерөнхийлөгч Бригам Янг Бригам Янгийн өв
Ерөнхийлөгч Жон Тейлор Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф
Албан Тунхаг 1 ба "Гурван удаагийн хэлсэн үгээс авсан хэсэг . . ." Ерөнхийлөгч Порензо Снөү
Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит Сургаал ба Гэрээ 138 Ерөнхийлөгч Хебер Ж.Грант
Ерөнхийлөгч Жорж Альберт Смит Ерөнхийлөгч Давид О.МкКей
Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит Ерөнхийлөгч Харольд Б.Лий
Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл Албан Тунхаг 2
Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон Ерөнхийлөгч Ховард В.Хантер Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли
Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг
Амьд Христ Итгэлийн Тунхаг Сүмийн Түүхэн дэх бидний байр

Сургаал ба Гэрээ гэж юу вэ?



Сургаал ба Гэрээ бол Мормоны Ном, Агуу Үнэт Сувд, Библийн хамт Сүмийн дөрвөн жишиг бүтээлийн нэг юм. Сүмийн гишүүд дагахаар гэрээнд орсон энэ дөрвөн ном бол бурханлиг сүнсний мэдрэмжээр судар гэж хүлээн зөвшөөрөгдсөн юм. Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн

Чуулгын Ерөнхийлөгч асан, Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит, Сургаал ба Гэрээ бусад судруудаас ямар ялгаатайг тайлбарлахдаа:

“Библи бол эрт дээр үеийн хүмүүст өгсөн сургаал, зарлигуудыг агуулсан түүх юм. Энэ нь бас Мормоны Номонд ч холбогдоно. Мормоны Ном бол Америк тивд эрт дээр үед оршин амьдарч байсан хүмүүсийн түүх, тэдэнд өгөгдсөн сургаал, зарлигууд юм.


“Харин энэхүү Сургаал ба Гэрээ нь өнөө үеийн хүмүүст зориулсан Бурханы үгийг агуулдаг. Энэ бол бидний ном юм. Энэ ном Хожмын Үеийн Гэгээнтнүүдийнх юм. Алтнаас ч илүү үнэтэй энэ номыг бид бүх дэлхийн баялгаас ч илүүгээр дээдлэн үнэлэх ёстой” гэж Бошиглогч [Иосеф Смит] хэлсэн билээ. “Харин бид ингэж үнэлдэг бил үү? Хэрэв бид энэ номыг үнэлж, ойлгон, агуулдаг зүйлийг нь мэдэх юм бол, үүнийг эд баялгаас илүүгээр эрхэмлэн үнэлэх болно. Энэ ном бидний хувьд газар дэлхийн бүх баялгаас ч илүү үнэ цэнэтэй юм” гэжээ (*Doctrines of Salvation*, эмхтгэсэн, Брус Р.МкКонки, 3 боть, [1954–1956], 3:199).



Тэр үед Тэргүүн Зөвлөлийн зөвлөх асан, Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли бичсэн нь: “Сургаал ба Гэрээ бол манай судруудын дунд хосгүй өвөрмөц юм. Энэ бол Сүмийн үндсэн хууль мөн. Сургаал ба Гэрээнд жинхэнэ эх болох олон төрлийн

бичээс, хэлсэн үг ордог боловч энэ нь үндсэндээ энэ эрин үеийн Бошиглогч [Иосеф Смит]-оор дамжуулан өгөгдсөн илчлэлтийн ном юм”.

“Бурханы хожмын үеийн агуу ажлыг сэргээхэд энэхүү илчлэлтүүд Түүний олон талт зорилгуудыг аянгын дуу лугаа адил нүргэлсэн тунхаглалаар нээсэн билээ:



“Анхаарагтун, Ай миний Сүмийн хүмүүс, хэмээн дээд тэнгэрт оршигч хийгээд мэлмий нь бүх хүмүүс дээр байх түүний дуу хоолой хэлэх ажгуу; тийм ээ, үнэнээр би хэлнэ: Холын хүмүүс та нар анхаарагтун; мөн тэнгис далайн арлууд дээрх та нар хамтдаа дуулагтун.

Учир нь үнэхээр Их Эзэний дуу хоолой бүх хүмүүнд хандсан болой, мөн зайлан зугтах хэн ч үгүй; мөн харах нь үгүй нүд гэж үгүй болой, мөн сонсох

нь үгүй чих гэж үгүй, бас нэвтрэх нь үгүй зүрх сэтгэл гэж үгүй бөлгөө.” (С ба Г 1:1–2.)

“Тэрхүү сүр жавхлантай нээгдэлтээр мөнхийн үнэний оргилуураас үүдэлтэй өргөн цар хүрээтэй, гайхалтай сургаал нээгдсэн юм. Зарим нь Их Эзэн Өөрийн бошиглогчид хэлж бичүүлсэн шууд илчлэлт юм. Зарим нь Ариун Сүнсээр нөлөөлөгдсөн үедээ Иосеф Смитийн бичсэн болон хэлсэн үгс юм. Бас янз бүрийн нөхцөлд тохиосон үйл явдлуудын тухай түүний өгүүлсэн хүүрнэл үгс орсон ажээ. Энэ бүгд нийлээд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн сургаал, практик үйл ажиллагааны үлэмж хэсгийг бүрдүүлдэг . . .

“Номын хамарсан асуудлуудын цар хүрээ гайхмаар өргөн юм. Уг асуудлуудад Сүмийн удирдлагын зарчмууд болон дүрэм журмууд багтдаг. Бие махбодын болоод сүнсний амлалтууд аль аль нь хосолсон эрүүл мэндийн хосгүй өвөрмөц, гайхалтай дүрмүүд үндэслэгдэн бий болжээ. Мөнхийн санваарын гэрээ өөр ямар ч сударт байхгүй тийм байдлаар дүрслэгдсэн билээ. Нар, сар, оддын сүр жавхлангийн тухай Паулын товч дурдатгал дээр тулгуурлан, алдар суугийн гурван зэрэглэлийн онцгой боломжууд болон адислалууд мөн хязгаарлалтууд болон болзлууд нь зарлагдсан юм. Наманчлалыг тод томруун, шаардан шавдуулсан хэлээр тунхагласан байдаг. Баптисмын зөв хэв маяг өгөгдсөн юм. Шашны номлогчдыг олон зууны турш толгойг нь өвтгөсөн Бурхан тэргүүтний мөн чанар хүн бүхэнд ойлгомжтой хэлээр дүрслэгджээ. Их Эзэний санхүүгийн хууль зарлагдаж, Сүмийн үйл ажиллагааны санхүүжилтийг хэрхэн олж авч, захиран зарцуулахыг тодорхойлсон юм. Бурханы хөвгүүд охидын бүх үеийнхнийг адислахын төлөө нас барагсдын өмнөөс хийх ажил илчлэгдсэн билээ.

“Бурханы мөнхийн зорилгуудыг Иосеф Смит бүх талаар ойлгодог байсан нь Сургаал ба Гэрээг уншихад нотлогддог” (“The Order and Will of God,” *Ensign*, 1989 оны 1-р сар, 2, 4).

Сургаал ба Гэрээ болон Сүмийн түүхийг судлах нь миний хувьд яагаад чухал вэ?

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлсэн нь:




“Сургаал ба Гэрээ бол Бошиглогч Иосеф Смит болон түүний залгамжлагчдаар дамжин үргэлжилж байгаа Сэргээлтийн ажил, Мормоны Ном хоёрыг хооронд нь холбогч холбоос юм.

“Бид ариун сүмийн ажил, мөнхийн гэр бүл, алдар суугийн зэрэглэлүүд, Сүмийн зохион байгуулалт, тэрчлэн Сэргээлтийн бусад олон агуу үнэний тухай Сургаал ба Гэрээнээс мэддэг.

“Эдгээр зарлигуудыг судлагтун, учир нь тэдгээр нь үнэн бөгөөд итгэмжлэгдсэн юм, мөн тэдгээрт буй бошиглолууд хийгээд амлалтууд бүгд биелэгдэх болно.

“Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, мөн би өөрийгөө зөвтгөх нь үгүй; мөн тэнгэр хийгээд газар үгүй болсон ч,


миний үг алга болох нь үгүй, харин миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил, бүгд биелэгдэх болно” (С ба Г 1:37–38) хэмээн Их Эзэн хэлжээ.



“Мормоны Ном хүмүүсийг Христэд авчирдаг. Сургаал ба Гэрээ хүмүүсийг Христийн хаант улс, бүр бүх дэлхий дээрх цорын ганц үнэн бөгөөд амьд сүм, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд авчирдаг (ш. 30). Би үүнийг мэднэ.

“Мормоны Ном бол манай шашны ‘суурийн чулуу’, Сургаал ба Гэрээ бол үргэлжилж байгаа хожмын үеийн илчлэлтийн хамт оройн чулуу нь юм. Суурийн чулуу, оройн чулуу хоёулан дээр нь Их Эзэн баталсан тамгаа дарсан юм” (In Conference Report, 1987 оны 4-р сар, 105; *Ensign*, 1987 оны 5-р сар, 83).

Та Сургаал ба Гэрээг энэ жил судалснаар Их Эзэн сайн мэдээний үнэнүүдийг хэрхэн “шат шатаар, дүрэм дүрмээр” (С ба Г 128:21) сэргээснийг мэдэх болно. Өнөө үеийн илчлэлтийн тухай таны гэрчлэл өсч, Бошиглогч Иосеф Смитэд талархах талархал тань гүнзгийрнэ. Сүмийн Түүхэн дэх чухал үйл явдлуудыг судалснаар золиослол, бие сэтгэл бүхнээ зориулах үед төрдөг сүнслэг мэдрэмжийн жишээнүүдийн тухай, Их Эзэнийг мэддэг байсан бөгөөд газар дэлхий дээрх Түүний хаант улс, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн өсөлт хөгжилтөд тусалж байсан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тухай унших болно. Судалж суралцах болон залбирлаар дамжуулан Есүс Христэд итгэх итгэл тань өсч, Түүний хаант улсыг байгуулахад үйлчлэх хүсэл тань бэхжих болно.



Нью-Йорк ба Пеннсилъвани дахь Сүм



“Баруун Нью-Йорк арван есдүгээр зууны эхэнд үндсэндээ аглаг буйд нутаг, онгон зэлүүд газрын модыг огтлон зурвас газар гарган хагалж, тариалалтын нүсэр хүнд ажлаас няцаж шантардаггүй хүмүүст боломж олгодог нутаг байлаа. 1816 онд Рочестераас холгүй Палмирагийн дэргэд ирсэн Иосеф Смит, Люси Мак Смит нарын гэр бүл, тэд-

ний найман хүүхэд чухам тийм хүмүүс байлаа” (Гордон Б. Хинкли, *Truth Restored: A Short History of the Church of Jesus Christ of Latter-day Saints* [1947], 1).

Хүүхдүүдийнх нь нэг Иосеф Смит үнэнийг эрж, улмаар Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христ хоёр түүн дээр хүрч ирсэн үйл явдал энэ нутагт болсон юм. Харанхуйн болон урвалтын он жилүүдийн дараа тэнгэрийг нээсэн энэхүү шийдвэрлэгч илчлэлт нь Мормоны Номыг алтан ялтсуудаас “Бурханы бэлэг болон хүчээр” (С ба Г 135:3) орчуулах, санваар, сайн мэдээний ёслолууд болон Есүс Христийн Сүмийг газар дэлхий дээр сэргээх сэргээлт рүү хөтөлсөн билээ. Сүм сэргээгдсэнээр, Сүмийн доторх болон гаднах мөрдлөг хавчлагыг эс хайхран, сайн мэдээг дэлхий даяар тунхаглахын тулд номлогчдыг гадаадад явуулсан юм.



Иосеф Смит-Түүх 1

Иосеф Смит өөрийн түүхийг өгүүлсэн нь

Иосеф Смит-Түүх нь “1838 онд тэрээр бэлтгэж мөн Иллинойн Наувуд 1842 оны гуравдугаар сарын 15-наас Times and Seasons-д цувралаар нийтлэгдсэн Иосеф Смитийн албан ёсны гэрчлэл хийгээд түүхээс авсан хэсгүүд” (“Агуу Үнэт Сувд” оршил хэсгээс) болно.

Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Жон Тейлор бичихдээ: “Их Эзэний Бошиглогч хийгээд Үзмэрч Иосеф Смит энэ дэлхийд хүмүүний авралын тулд, зөвхөн Есүс Христийг эс тооцвол үүн дээр амьдарч асан аль ч бусад хүнээс илүү ихийг хийсэн юм” гэжээ (С ба Г 135:3). Иосеф Смит-Түүхэнд агуулагдсан, Бошиглогчийн өөрийнх нь үгээр бичигдсэн товч түүх нь Сэргээлт хэрхэн эхэлснийг өгүүлдэг. Хэрэв та хичээнгүй мөн залбиралтайгаар Бошиглогч Иосефын амьдрал, түүгээр дамжин илчлэгдсэн сайн мэдээний зарчмууд болон Их Эзэн Есүс Христийн тухай түүний гэрчлэлээс судлах аваас таны амьдралыг өөрчлөгч туршилага болж чадна. Энэ гэрчлэл болон түүхийг уншихдаа, Иосеф Смит ямархуу залуу байсныг олж мэдэхийг хичээ. Сэргээлтийн Бошиглогч байх учиртайг нь харуулсан ямар шинж чанар залуу Иосефт байсан бэ?



Судруудыг ойлгох нь



Иосеф Смит-Түүх 1

Хүмүүсийн буруу ойлголтыг залруулах (ш. 1)—
Тархсан цуурхал, худал үгсийг залруулж, үнэнийг хэлэх
Хуурмаг дүгнэлт (ш. 9)—
Худал хуурмаг шалтгаан, заль мэх
Итгэл үнэмшил (ш. 9)—
Итгэл бишрэл

Шашны бүлэглэлүүдийн хүрээ (ш. 26)—Янз бүрийн Сүмүүд буюу шашнууд
Тунхаглал (ш. 29)—
Харилцаа, харилцах
Сүрэл (ш. 37)—Үр тариаг хураасны дараа үлддэг тарианы хатсан иш
Томилогдсон (ш. 68, 71)—
Гар тавилтаар томилогдсон

Иосеф Смит-Түүх 1:17—Анхны Үзэгдлийн ач холбогдол



Тухайн үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байсан, Ахлагч Жеймс И. Фауст бидний урьд нь мэддэггүй байсан харин Эцэг Хүү хоёр Бошиглогч Иосеф Смит дээр хүрч ирсний дараа бид юу мэддэг болсныг жагсаажээ:

“Анхны Үзэгдлээс юу мэдэгдсэн бэ?

“1. Бидний Эцэг Бурхан хүмүүн биеэр оршдог нь, мөн хүн Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн нь нотлогдсон юм.

“2. Есүс бол Эцэгээс ангид, тусдаа хүн мөн.

“3. Есүс Христ бол түүний Хүү гэдгийг Эцэг тунхагласан билээ.

“4. Библид зааснаар Есүс бол илчлэлтийг дамжуулагч байв.

“5. Мэргэн ухааны төлөө Бурханаас асуух Иаковын амлалт биелэгдсэн байлаа.

“6. Иосеф Смитийг устгахыг хичээж байсан үл үзэгдэх дэлхийн хүмүүсийн үнэн нүүр царай илчлэгдсэн юм.

“7. Есүс Христийн үндэслэн байгуулсан Сүмээс урвасан урвалт тохиов. Тэр бүлэглэлүүдийн алинд нь ч нэгдэхгүй байхыг Иосефт хэлжээ. Учир нь тэрхүү бүлэглэлүүд хүмүүний сургаалыг заадаг байлаа.

“8. Иосеф Смит Бурхан, Түүний Хүү Есүс Христ хоёрын гэрч болсон юм” (In Conference Report, 1984 оны 4-р сар, 92–93; *Ensign*, 1984 оны 5-р сар, 68).

Иосеф Смит-Түүх 1:19—“Сүсэг бишрэл тунхаглагч тэд бүгдээрээ ялзарсан байлаа”

Тэр үеийн шашны сүсэг бишрэл тунхаглагчдын (үйлчлэгч, багш нар) ямар нэг зүйл буруу байсныг Бошиглогч Иосеф Смитийн туршлага түүнд харуулсан ажээ (Иосеф Смит-Түүх 1:5–6, 8–10, 12, 21–23-ыг үз). Тэргүүн Зөвлөлийн зөвлөх асан, Ерөнхийлөгч Ж.Рюбен Кларк Бага тайлбарлахдаа:

“Бурханаас эмээдэггүй хүн байдаггүй, ерөөсөө ч байгаагүй, бас олон зууны туршид ч байгаагүй. . . гэж би хэлэх гээгүй байна, үнэнч, зөв шударга олон сая хүмүүс өөрсдийнхөө жишгүүдийн дагуу зуун зууны туршид амьдарсаар ирсэн шүү дээ. . .

“Тэвч, бүр Их Эзэн Иосефт хэлсэнчлэн тэдний бүтэц тогтолцоо нь алдаан дээр суурилагдсаныг хэлэх ёстой” гэжээ (*On the Way to Immortality and Eternal Life* [1949], 442–443).

Иосеф Смит-Түүх 1:66—“Хүүхдүүдээ сургуульд явуулдаг байсан хүмүүсийн нэг”

Нутгийн сургуулийн багш нар хичээл заасныхаа төлөө авдаг цалингийн нэг хэсэг болгон сурагчдынхаа гэр оронд хэсэг хугацаагаар байдаг заншил тэр үед энэ нутагт байжээ.

Иосеф Смит-Түүх 1:68–72—Бошиглогч Иосеф Смит, Оливер Каудери хоёр баптисм хүртсэнийхээ дараа яагаад бие биенээ томилсон юм бол?

“Санваар хүртээсний дараа, ус руу орж, бие биендээ баптисм хүртээхийг Иохан Баптист Иосеф, Оливер хоёрт зааварласныг Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит тайлбарлажээ. Үүний дараа тэд бие биен дээрээ гар тавьж, өмнө нь Иохан Баптист тэдэнд олгосон санваарыг дахин олгожээ.

Яагаад тэд үүнийг хийхээр тэдэнд зарлиг болгосонд хоёр шалтгаан байлаа. Нэгдүгээрт: Баптисмын өмнө санваарыг олгох нь, зохион байгуулагдсан Сүмийн журамд харшилж байв. Тиймээс санваарыг тогтсон журмын дагуу баптисм хүртсэний дараа бие биедээ олгохыг тэдэнд зарлиг болгосон аж. Хоёрдугаарт: Өөрсдийнх нь хийж чадахгүй зүйлийг тэдний өмнөөс тэнгэр элч хийсэн юм. Эл санваарын түлхүүрүүдийг эзэмшсэн нэг ч хүн мөнх бус байдалд амьдарч байсангүй. Тиймээс энэ хүчийг олгохын тулд Цаг хугацааны голчийн эрин үед Аароны санваарын түлхүүрүүдийг эзэмшсэн энэхүү элчийг илгээх шаардлагатай байжээ. Хөшигний цаана талийгаач болсон хүмүүс дэлхий дээр амьд байгаа хүмүүсийн төлөө ёслол гүйцэтгэж, хөдөлмөрлөх нь тэнгэрийн журамд харш юм. Энд бас мөнх бус хүн үйлдэж чадахгүй, тиймээс нас барсан боловч амилуулагдсан хүмүүс тэдний төлөө үйлдэх шаардлагатай байлаа. Өөрөөр хэлбэл Сүмд хэрэглэгддэг тогтсон журмыг Иохан баримтлах ёстой байв. Иймээс Иосеф Смит, Оливер Каудери хоёр эхлээд баптисм хүртэж, дараа нь тэдэнд Аароны санваарыг олгосон байна” (*Essentials in Church History*, 27 дахь хэвлэл [1950], 57–58).



Сасквиеханна гол

Судруудыг судлах нь

Иосеф Смит-Түүх 1-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас (А-Ё) дөрвийг хий.

А Залуу Иосеф Смитийн тухай мэдэх нь

Иосеф Смит-Түүх 1:1–20-ийг судалж, дараах даалгавруудыг тэмдэглэлийн дэвтэртээ хий:

1. Иосеф Смитийн эцэг эх, ах, эгч, дүү нарын нэрсийг бич.
2. Аль Сүм зөв бэ гэдгийг Иосеф яагаад бодож эхэлснийг тайлбарла.
3. Их Эзэнд хандан залбирахаар явахад нь Иосефт сүнслэгээр нөлөөлсөн судрыг үз. Та энэ судрыг өөрсдийнхөө Библид тэмдэглэхийг хүсч болно. Судрын утгыг өөрийнхөө үгээр тайлбарла.
4. Өөрийн чинь хувьд чухал учир холбогдолтой, Анхны Үзэгдлээс бидний мэдсэн гурван үнэнийг жагсааж, уг шүлгүүд яагаад өөрт чинь гүнзгий сэтгэгдэл төрүүлснийг тайлбарла (Хэрэгтэй бол энэ хэсгийн “Судруудыг ойлгох нь” хэсгийг тусламж болгон үз).

Б Судрын гарамгай мэдлэг-Иосеф Смит-Түүх 1:15–20

Иосеф Смит-Түүх 1:14–20 дахь Анхны Үзэгдлийн тухай Бошиглогч Иосеф Смитийн шастирыг тунгаан бодож, хэрэв Иосеф Смит 1820 оны хаврын тэр нэгэн өдөр удирдамж хүсч залбираагүй бол та ямар боломжууд, адислалууд болон баяр баяслыг алдаж болох байсныг эцэг эх буюу Сүмийн аль нэг удирдагчтай ярилц. Ярилцсан зүйлээ дүрсэлсэн нэг догол мөр бич.



В Баримтуудыг ол

Иосеф Смит-Түүх 1:27–54-ийг судалж, дараах асуултуудад хариул:

1. Шүлэг 27-д өгүүлснээр, Анхны Үзэгдлээс хойш хэр зэрэг удаан хугацаа өнгөрсөн бэ?
2. 1823 оны есдүгээр сарын 21-нд Их Эзэнд хандан залбирахаар явахдаа Иосеф Смит юу болно гэж хүсэн хүлээж байсан бэ? Энэ нь түүний итгэлийн тухай танд юуг өгүүлж байна?
3. Тэр шөнө түүн дээр хүрч ирсэн тэнгэр элчийн нэр хэн бэ?
4. Иосеф Смитийн нэрийн талаар тэр ямар бошиглол хийсэн бэ? Энэ нь хэрхэн биелэгдсэн бэ?
5. Ялтсуудыг нуусан газар хаана байгааг Иосеф Смит яаж мэдсэн бэ?
6. Тэр шөнө, бас маргааш нь тэнгэр элч түүн дээр хэдэн удаа хүрч ирсэн бэ? Тэр яагаад тийм олон удаа ирсэн гэж бодож байна?



Г Өөрийн асуулт, хариултыг бич

Иосеф Смит-Түүх 1:66–75 болон үйл явдлуудын тухай Оливер Каудерийн дүрслэлийг зүүвэр тайлбарын хамт нэгтгэн дүгнэ. Эдгээр шүлгүүдээс хариулж болох сорилын таван асуулт бичиж, асуулт бүрийн дараа хариултыг тавь.

Д Гэрчлэлээ тэмдэглэ

Иосеф Смит-Түүхийг уншсаны дараа, Бошиглогч Иосеф Смитийн тухай, мөн Есүс Христийн үйлчлэгчийн хувьд бидний төлөө түүний хийсэн бүхний талаарх бодол санаагаа дүрсэлсэн нэг эсвэл хоёр догол мөр бич.

Е Тэмдэглэл бич

Иосеф Смит-Түүх 1:27–54 дэх Моронайн айлчлалын тухай уншсаны дараа Моронай 1:1–4, 10:1–6-г унш. Ялтсууд ил гаргагдаж, орчуулагдахыг 1,400 гаруй жил хүлээсний эцэст Иосеф Смит дээр хүрч ирсэн Моронай гэж өөрийгөө төсөөлөн бодоод, чамд ямар санагдах байсныг дүрсэлсэн тэмдэглэл бич.

Ё Нэг үйл явдлын тухай зураг зур


Иосеф Смит-Түүхэнд цэдэглэгдсэн өөр өөр үйл явдлуудыг бүгдийг нь нийлүүлэн бодоод, өөрт чинь гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн нэг үйл явдлыг дүрслэн зур. Уг үйл явдлын юу нь өөрт чинь гүнзгий сэтгэгдэл төрүүлснийг тайлбарла.



Сургаал ба Гэрээний эхний хуудсуудад удиртгал болон үндсэн суурь мэдээлэл байдаг. Эхний хуудас нь номын

нэр, агуулгын тухай товч тайлбар, хэвлэлийн тухай мэдээллийг агуулдаг. Тайлбар удиртгал нь эл ном ямар ном болох тухай мөн уг ном бидэнд хэрхэн ирснийг өгүүлнэ. Номонд бас эдгээр илчлэлтүүд үнэн болох тухай өнөө үеийн анхны Төлөөлөгчдийн гэрчлэл оржээ. Агуулгын он дараалал нь илчлэлтүүд хүлээн авагдсан дэс дарааллыг цаг хугацаа, газрын хамт харуулдаг. Та оршил хуудсуудыг уншихдаа, Сургаал ба Гэрээ бидэнд хэрхэн хүрч ирснийг, бас энэ номыг судлахыг Их Эзэн яагаад танаас хүсдэгийг эрж ол.

Судруудыг ойлгох нь



Тайлбар удиртгал

Цаг зуурын (догол мөр 1)— Бие махбодын, дэлхийн	Ач ивээл (догол мөр 13)— Бэлэг ба хүч
Бурханлиг тунхгууд (догол мөр 4)—Тэнгэрлэг зочид хүрч ирэх	Шашны номлолын (догол мөр 15)—Бурхан болон Түүний ажлын тухай үнэ- нүүдийн

Тайлбар удиртгал—Судраар удирдуулах нь хаагдаагүй!



Сургаал ба Гэрээний хөгжил нь Сүмийн хүлээн зөвшөөрөгдсөн судруудыг (“жишиг бүтээлүүд” эсвэл “судрын удирдлага” хэмээн олон-таа нэрлэгддэг) бүрэн гэж үзэх ёсгүйн нотолгоо юм. Хүмүүнд хандсан Бурханы бүх үгийг Библи агуулдаг бөгөөд илчлэлт ирэхээ зогссон гэж Христийн олон Сүм сургадаг.

Тэр үед Тэргүүн Зөвлөлийн зөвлөх асан, Ерөнхийлөгч Хью Б.Браун заахдаа: “Иосеф [Анхны Үзэгдлийг] харсан ойгоос гарч ирэхдээ наад тал нь дөрвөн тулгуур үнэнийг мэдсэн бөгөөд тэрээр эл үнэнүүдийг дэлхийд зарлан мэдэгдсэн юм. Нэгдүгээрт: Эцэг Хүү хоёр бол тусдаа, ялгаатай хувь хүмүүс юм. Хоёрдугаарт: Судрын удирдлага дуусаагүй. Гуравдугаарт: Хүн үнэхээр Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн. Дөрөвдүгээрт: Газар, тэнгэрийн хооронд харилцааны суваг нээгдсэн, иймээс илчлэлт үргэлжилж байна” гэжээ (In Conference Report, 1967 оны ес-аравдугаар сар, 120).



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Брус Р.МкКонки илчлэлтгүй байсан нь Библийг ойлгох дэлхийн ойлголтод ямар нөлөө үзүүлснийг тайлбарлахдаа: “Судрын удирдлага дууссан гэж хүмүүс үздэг нь тодорхой газарт; хүмүүс зөвхөн өнгөрсөн үеийн бошиглолын үгээр сүнслэг байдлын хувьд өөрсдийгөө тэжээн тэтгэхийг хичээдэг газарт;

амьд үгийг тэдэнд өгөх бошиглогчид, Төлөөлөгчидгүй газарт; хүмүүс шинэ илчлэлтүүд хүлээн авахаа больсон газарт тэд өнгөрсөн үеийн илчлэлтүүдийг тайлбарлаж, ойлгох чадваргүй болсон байдаг. Өнгөрсөн үеийн бошиглалуудыг зөвхөн дээд тэнгэрийн хүчээр хишиг хүртээгдсэн, эрт дээр үед үгийг

тэрлэсэн тэрхүү Ариун Сүнсээр оюун нь гэгээрсэн, амьд бошиглогчид л ойлгож чадна. Хүмүүс илчлэлтгүй бол зөвхөн өөрсдөд нь нээлттэй байгаа замаар л замнана. Тэд сүнслэг байдал дээр биш харин оюун билиг дээр шийдвэрээ гарган эртний үгийн утгыг хэлж өгдөг тайлбарлагч, бичээч нар, үйлчлэгч, шашны номлогчдод ханддаг” гэжээ (The Mortal Messiah: From Bethlehem to Calvary, 4 боть, [1979–1981], 1:275–276).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээний удиртгал хуудсуудыг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Хариултуудыг хай

Тайлбар удиртгал болон Агуулгын он дарааллыг судлахдаа дараах асуултуудад хариул:

1. Энэ илчлэлтүүд ямар шалтгаанаар өгөгдсөн бэ?
2. Аль онуудад далаас дээш илчлэлт хүлээн авагдсан бэ? Энэ онуудад яагаад ийм олон илчлэлт өгөгдсөн гэж та бодож байна?
3. Их Эзэн бүх илчлэлтийг Бошиглогч Иосеф Смитэд яагаад нэг дор өгөөгүй гэж та бодож байна?

Б Хэрэв амьд бошиглогчид байгаагүй бол...?

Удиртгал хуудсуудыг уншаад, орчин үеийн илчлэлтийг хүлээн авах амьд бошиглогчид байгаагүй бол юу тохиолдох байсныг тайлбарла.



Сургаал ба Гэрээ 1 Их Эзэний удиртгал үг-Сэрэмжлүүлгийн дуу хоолой

Номын удиртгал нь уг номыг бичсэн зохиогчийн зорилгыг тайлбарладаг. Сургаал ба Гэрээ 1 бол эдгээр хожмын өдрүүд дэх илчлэлтийнхээ номонд зориулсан Их Эзэний удиртгал үг юм. Өөрөөс нь илчлэлт хүлээн авах орчин үеийн бошиглогчдыг Их Эзэн дуудсаныг олон хүмүүс мэддэггүй. Тэр ч байтугай амьд бошиглогчдын хэлсэн үгст төдийлөн анхаарал тавьдаггүй Сүмийн гишүүд ч байдаг. Та энэ хэсгийг уншихдаа Их Эзэн хэнд хандан ярьж байгааг, Түүний сэрэмжлүүлэг юу болохыг, мөн Тэрээр яагаад үүнийг өгснийг анхааран үз. Эдгээр нь номын эхнээс эцсийг хүртэл давтагддаг гол сэдвүүд юм.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 1

Анхаарагтун (ш. 1)—
Сонсож, дагагтун

Алдсууд (ш. 3)—Нүглүүд,
ёс бус явдал

Лацдах (ш. 8–9)—Томилох,
тохоох, даалгах

Вавилон (ш. 16)—Дэлхийн
ёс бус явдлын бэлгэдэл

Ноёрхол (ш. 35)—
Нөлөөний хүрээ

Сургаал ба Гэрээ 1:6—“Зарлигуудын минь номны удиртгал”

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит заасан нь:



“Сургаал ба Гэрээний 1-р хэсэг бол анхны хүлээж авсан илчлэлт биш боловч, Их Эзэн үүнийг зарлигуудынхаа номны удиртгал болгон өгсөн учраас энд оруулжээ. Сургаал ба Гэрээ өвөрмөц сонин бөгөөд энэ ном бол Их Эзэний өөрийнх нь өгсөн удиртгал үгийг агуулах эрхэм дээд хүндлэлийг хүлээсэн цорын ганц ном гэдэгт итгэдэг бүх хүмүүсийн сонирхлыг татдаг. Гэвч тэрээр үүнийг өөрийнхөө ном хэмээн мэдэгдсэн нь тохиромжтой бөгөөд зүй ёсны юм. Номыг Иосеф Смит бичээгүй харин, Есүс Христ хэлж бичүүлсэн бөгөөд Сүмд болон Бурханд итгэдэг бүх ертөнцөд хандсан түүний өөрийнх нь болоод Эцэгийнх нь үгийг агуулдаг, нүглийн наманчлал болон түүний Сүм дэх гишүүнчлэл нь итгэх бүх хүмүүст хүртээмжтэй байж болно. Түүнчлэн Шинэ бөгөөд Үүрдийн гэрээ дахин нэгэнтээ үндэслэгдсэн билээ.



“Хэсэг 1 гэдэг энэхүү илчлэлт зарлигуудыг нийтлүүлэх тухай авч үзэж байсан үед 1831 оны арваннэгдүгээр сарын 1, 2-нд Хайрамд [Огайо] болсон гайхалтай чуулган дээр өгөгджээ. Энд Их Эзэн өөрийнхөө үгийг нийтлэх зөвшөөрөл өгсөн юм. Учир нь өөрийнх нь хүслийг нийтэд таниулахыг тэрээр хүсч байв. Сайн мэдээ сэргээгдэж, Бурханы

хаант улсад хүрэх замаа хүмүүн нэгэнт дахин олж болохын тулд итгэлгүй дэлхийд авралыг тунхаглахаар Сүмийн ахлагчдыг илгээв. Энэхүү удиртгал үг илчлэлтүүдийг бурханлиг баталгаагаар хангасан юм. Иймээс илчлэлтүүд ер бусын их хүчтэйгээр гарч ирсэн билээ. Иймээс илчлэлтүүдийг агуулсан зарлигуудыг биелүүлэх үүрэг хариуцлагыг нь илчлэлтүүдийг уншсан бүх хүмүүст, ялангуяа Сүмийн гишүүдэд хүчтэйгээр мэдрүүлэх ёстой” (*Church History and Modern Revelation*, 2 боть, [1953], 1:251–252).

Сургаал ба Гэрээ болон Зарлигуудын Номны тухай дэлгэрэнгүй мэдээллийг эл гарын авлагын “Сургаал ба Гэрээний Түүх”-ээс үз (х.00 [233]).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээний 1-р хэсгийг судлахдаа, үйл ажиллагаа Г болон өөр хоёр үйл ажиллагааг (А–В) хий.

А Шүлгийн товч агуулгатай танилц

Сургаал ба Гэрээний 1-р хэсгийн эхний шүлгийн өмнө хэвлэгдсэн шүлгийн товч агуулгыг анхааралтай унш. Шүлгийн товч агуулгаас өөрийнхөө мэдэхийг хүссэн хоёр сэдвийг тэмдэглэлийн дэвтэртээ бич. Сургаал ба Гэрээний 1-р хэсгийг уншсаны дараа энэ хоёр сэдвийн талаар юу мэдсэнээ товчхон бич.

Б Хэн, юу, хэзээ, яагаад гэдгийг мэд

1. Дараах асуултуудтай дөрвөн багана бүхий хүснэгтийг тэмдэглэлийн дэвтэртээ зур:

Их Эзэн хэнд хандан ярьж байна вэ?	Юу тохиолдох болно гэж Тэр хэлэв?	Уг үйл явдал хэзээ болно гэж Тэр хэлэв?	Энэ үйл явдал яагаад тохиолдоно гэж Тэр хэлэв?

2. Сургаал ба Гэрээ 1:1–16-г судлаад, дээрх асуултуудаас олсон хариултаараа хүснэгтийг бөглө.
3. Хэрэв чи энэ шүлгүүдийг ашиглан гэр бүлийн үдшийн хичээл заах боллоо гэвэл, хамгийн чухал ямар зүйлийг гэрийнхэндээ сануулан үлдээхийг хүсэх вэ?

В Сүйрлийг хэрхэн тэсч гарах вэ?

Сургаал ба Гэрээ 1:1–16-д Их Эзэн ёс бусчууд дээр ирэх сүйрлүүдийн тухай сэрэмжлүүлжээ. Эдгээр сүйрлүүдээс биднийг аврахын төлөө Тэрээр юу хийж байгааг шүлэг 17–30-д тайлбарласан байна. Их Эзэн биднийг нүглүүдээс аварч чадахын тулд юу хийх ёстойг ойлгоход шүлэг 31–39 тусална.

1. Дэлхийн оршин суугчид дээр ирэх сүйрлүүдийг мэдсэн Их Эзэн бидэнд туслахын тулд хэнийг дуудсан бэ? (шүлэг 17–18-ыг үз).
2. Тэд юу хийх ёстой байсан бэ? (шүлэг 19–23-ыг үз).
3. Дуудагдсан ажил үүргээ биелүүлэхэд нь тэдэнд туслахын тулд Их Эзэн юу хийсэн бэ? (шүлэг 24–30-ийг үз).

4. Ажил үүргээ биелүүлэхэд Их Эзэний үйлчлэгчид хэр зэрэг сайн ажилласан бэ?
5. Их Эзэний хийсэн зүйлийн ашиг тусыг хүртэхийн тулд бид юу хийх ёстой вэ? (шүлэг 31–39-ийг үз).
6. Та нар өөрсдийнхөө хийх ёстой зүйлийг хэр зэрэг сайн хийж байна вэ?

Г Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 1:37–38

Сургаал ба Гэрээг семинарт уншихаас төвөгшөөж: “Мормоны Номонд байдаг шиг ямар ч аятайхан түүх энд байдаггүй шүү дээ. Ийм байхад би яагаад эдгээр бүх илчлэлтийг унших хэрэгтэй юм бэ?” гэж хэлдэг нэг найз өөрт чинь байдаг гэж бод. Сургаал ба Гэрээний 1-р хэсгээс сурч мэдсэн зүйлээ ашиглан найздаа хариу бич. Өөрийнхөө амьдралаас, эсвэл шүлэг 37–38-д Их Эзэн бидэнд хандан хэлсэн зүйл үнэн гэдгийг харуулсан, үзсэн зүйлүүдээсээ жишээ тат.



1823 оны есдүгээр сарын 21-нд Иосеф Смит Их Эзэний өмнө өөрөө ямар байгаа талаараа бурхан-лиг илчлэлт хүсчээ (Иосеф Смит-Түүх 1:29-ийг үз). Залбирлынх нь хариуд тэдний дүнзэн байшингийн дээд давхрын унтлагын өрөөнд тэнгэр элч Моронай түүн дээр хүрч ирсэн аж. Моронай

залуу бошиглогчид шөнөжингөө заажээ.

Сургаал ба Гэрээний 2-р хэсэг нь Моронайн заасан бүх зүйлийн зөвхөн багахан хэсгийг агуулдаг (Иосеф Смит-Түүх 1:30–54-ийг үз. Моронайн бошиглолын биелэлт С ба Г 110-т байдаг, үүнийг тухайн хэсэгтэй хамт судлах болно). Энэ хэсгийг судлахдаа, уг илчлэлт Сургаал ба Гэрээнд яагаад орсон тухай бод.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 2

Их Эзэний өдөр (ш. 1)—
Есүс Христийн Хоёр дахь
Ирэлт

Сургаал ба Гэрээ 2:1—“Би та нарт санваарыг илчлэх болно”



“1829 онд Иосеф, Оливер хоёр Мелкизедек санваарт томилогдож, төлөөлөгчийн хүч, итгэмжлэл тэдэнд өгөгджээ. Тэгвэл Елиа санваарыг дараа нь тэдэнд илчилсэн нь ямар учиртай юм бол? Санваарын түлхүүрүүдийг, мөн энэ эрин үед харахан бүрэн ойлгогдоогүй

бөгөөд үйл ажиллагаанд бүрэн ороогүй байсан лацдалтын хүчнүүдийг илчлэхийн тулд Елиаг 1836 онд илгээсэн нь [С ба Г 110:13–16-г үз] энгийнээр нотлогддог. Елиасын өгсөн хүчнүүдээр дамжуулан патриархын жаягаар [Мелкизедек санваараар] зохион байгуулагдсан гэр бүлүүд үүгээр үүрд мөнхөд лацдан холбогдож чадах түлхүүрүүдийг Елиа сэргээсэн юм” (Жозеф Фиелдинг МкКонки, Роберт Л.Миллет, *Joseph Smith: The Choice Seer* [1996], 187).

Сургаал ба Гэрээ 2:1— Есүс Христийн Хоёр дахь Ирэлт хэрхэн “Агуу хийгээд аймшигтай” байх вэ?

Моронай дахин нотолсон Малахийн энэ бошиглолын талаар Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит заахдаа: “Энэ бошиглолын тунхагласан Их Эзэний агуу хийгээд аймшигт өдөр бол, бидний Их Эзэн тэнгэрийн үүлэн дунд агуу алдар суунд ирж, бурхангүйчүүдээс өс хонзон авах өдөр юм. Наманчилдаггүй бөгөөд нүглээр дүүрэн бүх хүмүүсийн хувьд энэ өдөр аймшигтай байх ч гэсэн, шударга хүмүүсийн хувьд энэ нь амар амгалангийн болон авралын өдөр байх болно. Гэвч, энэ өдөр ирэхийн өмнө Елиагийн эрх мэдлийн сэргээлтээр зарим хүчирхэг ажил гүйцэтгэгдэх ёстой, уг ажил дэлхийг устгалаас, эсвээс зүхлээр арчигдахаас аврахаар тийм их хүчтэй байх болно” гэжээ (*Doctrines of Salvation*, 2:112–113).

Сургаал ба Гэрээ 2:2—Эцгүүдэд өгөгдсөн амлалтууд” гэж юу вэ?

Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Жозеф Фиелдинг Смит: “Энэхүү хэллэг нь сайн мэдээний мэдлэггүйгээр, өргөмжлөлд хамаарах асуудлуудаар санваарын лацдах ёслолуудыг хүлээн авах боломжгүйгээр нас барсан хүмүүст өгөгдсөн амлалтуудыг тусгадаг. Эл амлалтуудын дагуу, хожмын өдрүүд дэх хүүхдүүд нас барагсдын өмнөөс эдгээр бүх ёслолуудыг гүйцэтгэх ёстой” (“The Promises Made to Fathers,” *Improvement Era*, 1922 оны 7-р сар, 829) гэж бичсэн байдаг.

Сургаал ба Гэрээ 2:3—Хэрэв Елиа ирээгүй бол дэлхий яагаад “бүрмөсөн устгагдах” байсан бэ?

“Яагаад дэлхий бүрмөсөн устгагдах байсан гэж? Хэрэв эцгүүд болон хүүхдүүдийн хоорондох гагнагч холбоос-нас барагсдын өмнөөс хийх ажил байхгүй бол биднийг бүгдийг нь хүлээн авахгүй байх байсан. Бурханы бүх ажил нурж, улмаар бүрмөсөн устгагдах байсан нь [С ба Г 128:15–18-ыг үз] энгийнээр нотлогддог. Ийм байдал, мэдээжийн хэрэг, бий болохгүй л дээ” (*Doctrines of Salvation*, 2:121–22) хэмээн Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит бичжээ.

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээний 2-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Шастируудыг харьцуул

Сургаал ба Гэрээ 2 бол Малахи 4:5–6-г дахин нотолсон тэнгэр элч Моронайн үгс юм. Энэ хоёр цэдгийг харьцуулснаар бид зарим чухал зүйлийг ойлгож чадна.

1. Малахи 4:5-ыг Сургаал ба Гэрээ 2:1-тэй харьцуул. Елиагийн хийх зүйл Малахид байхгүй гэж Моронай яагаад хэлсэн бэ? Энэ нь юу гэсэн үг вэ?
2. Малахи 4:6-г Сургаал ба Гэрээ 2:2-той харьцуул. Эцэг хүүхдүүдийн зүрх сэтгэлийг эргүүлэхийн тулд Елиа юу хийх хэрэгтэй байсан бэ?
3. Малахи 4:6-г Сургаал ба Гэрээ 2:3-тай харьцуул. “Зүхэл” гэж юу вэ? Энэ нь юу гэсэн утгатай вэ?
4. Елиагийн ирэлт Таны амьдралд гаргасан буюу гаргах өөрчлөлтийг тайлбарласан хоёр эсвэл гурван өгүүллэр бич.

Сургаал ба Гэрээ 3

Бошиглогч чухал сургамж авсан нь

Алтан ялтсуудаас Бошиглогч Иосеф Смитийн орчуулсан гар бичмэлийн эхний 116 хуудсыг Мартин Харрис алга болгожээ. Сургаал ба Гэрээ 3, Сургаал ба Гэрээ 10 бол дээрх хуудсуудыг алдсаны улмаас Бошиглогч Иосефын хүлээн авсан илчлэлтүүд юм. Хэсэг 3-т Иосеф Смит ямар буруу зүйл хийснийг хэлж, бошиглогчийнх нь дуудлагатай холбоотой чухал үнэнүүдийг Их Эзэн түүнд заажээ. Энэ илчлэлтийг хүлээн авах үед Бошиглогчид ямар санагдсан байж болохыг төсөөлөн бод.




Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 3

Бичээч (хэсгийн тойм)—
Хүний хэлж өгсөн зүйлийг
бичдэг хүн

Юу ч биш (ш. 1, 4, 7, 13)—
Үл ойшоох, эс тоомсорлох
Цаг зуурын (ш. 4)—
Махбодын, дэлхийн

Сургаал ба Гэрээ 3:12—Мартин Харрисыг Их Эзэн яагаад “ёс бус хүн” гэсэн бэ?



Бошиглогч Иосеф Смитийн хийж байсан Мормоны Номны орчуулгыг Мартин Харрис тэмдэглэж байхдаа, Мартин мэхлэгдэж байгаа хэмээн илт бодож байсан эхнэртээ, бас бусад хүмүүст орчуулсан хуудсуудыг үзүүлэх зөвшөөрлийг Их Эзэнээс гуйж өгөөч гэж Иосефоос шалсаар байсан аж. Юу болсныг Бошиглогч

Иосеф тайлбарлаж: “Би асуулаа, хариу нь гэвэл тэр үүнийг авч явах ёсгүй гэлээ. Гэвч тэрээр энэ хариунд сэтгэл ханасангүй, намайг дахин асууж өгөөч гэж шалсаар байв. Ингээд би асуулаа, хариу нь өмнөхийн адил байв. Тэрээр зорчилдож маргаагүй ч гэсэн, намайг дахин нэг удаа асууж өгөөч гэж нойтон хамуу шиг салахгүй байлаа. Ингэж олон удаа гуйсных нь дараа би Их Эзэнээс дахин асуухад, хуудсуудыг тодорхой болзолтойгоор авч явах баталгаа өгсөн тохиолдолд тэрээр хуудсуудыг зөвхөн өөрийн ах Призервед Харрис, эхнэр, аав, ээж хоёр, эхнэрийнхээ эгч хатагтай Кобб нарт үзүүлэхийг зөвшөөрөв. Сүүлчийн энэ хариуны дагуу тэрээр миний өмнө гэрээгээр чанд үүрэг хүлээж, энд дурдсанаас өөр хүмүүст үзүүлэхгүй байхыг би түүнээс шаардав. Тэр ч бас ийм үүрэг хүлээсэн. Миний шаардсаны дагуу тэрээр үүрэг хүлээж, хуудсуудыг аваад явлаа. Гэсэн ч, тэрээр өөртөө хүлээсэн хатуу хязгаарлалтуудыг эс хайхран, надтай хийсэн чанд гэрээгээ зөрчиж, хуудсуудыг бусад хүмүүст үзүүлснээс, тэд заль мэх хэрэглэн, хуудсуудыг түүнээс салган авсан байлаа. Ингээд хуудсууд өнөөдрийг хүртэл олдоогүй байна” гэжээ (*History of the Church*, 1:21).

Мартин Харрисын тухай дэлгэрэнгүй мэдээллийг “Сургаал ба Гэрээн дэх Хүмүүс ба нэр томъёонууд” (х. 244)-аас үз.

Сургаал ба Гэрээ 3:14—Бошиглогч Иосеф Смит ямар “онцгой боломжуудыг” түр хугацаагаар алдсан бэ?

Гар бичмэлийн 116 хуудас алдагдсаны дараа Моронай Иосеф Смит дээр хүрч ирэн ялтсууд болон Урим, Тумминыг авч явсан ч гэсэн, хэрэв тэрээр Их Эзэний зөвлөгөөг дагаагүйнхээ төлөө наманчлах юм бол, орчуулгыг үргэлжлүүлэхийг түүнд зөвшөөрөх болно гэж Иосефт амлажээ (*Church History in the Fulness of Times* [Religion 341–343 student manual, 2 дахь хэвлэл, 2000], х. 48–49).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээний 3-р хэсгийг судлахдаа (А-В) дэх үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Сургамжийг хай

116 хуудас алдагдсаны улмаас Бошиглогч Иосеф Смит санаагаар ихэд унасан аж. Сургаал ба Гэрээ 3:1–8-ыг нэгтгэн дүгнэж, Их Эзэний илчилсэн эдгээр шүлгүүд уг туршлагаас юу сурахыг Бошиглогчоос хүссэн тухай бич. Энэ шүлгүүдийн үгс, нийлэмж үгсээр хариултаа зөвтгө.

Б Сонголтууд ба үр дагаврууд

Мартин Харрис залуу бошиглогчид их тусалж байсан бөгөөд Иосеф Смит ч түүнд туслахыг хүсдэг байсан нь зүй ёсны юм. Тэмдэглэлийн дэвтрийнхээ нэг хуудсыг гурван багана болгон хувааж, Сургаал ба Гэрээ 3:1–15-ыг уншаад дараах жагсаалтуудыг хий:

1. Нэг дэх багананд: Мартин Харрисыг баярлуулах гэснээр Бошиглогч Иосеф Смит ямар буруу зүйл хийснийг, мөн эдгээр сонголтуудын үр дагаврын талаар Их Эзэн юу гэж хэлснийг жагсаан бич.
2. Хоёр дахь багананд: Бошиглогч Иосеф юу хийх ёстой байсан тухай, эсвэл юу хийх ёстой талаар, хэрэв тэрээр дуулгавартай байх юм бол ямар адислалууд ирж болох талаар Их Эзэний хэлсэн зүйлүүдийг жагсаа.
3. Гурав дахь багананд: Өнөөдөр залуу хүмүүс Иосеф Смитийн алдаатай адил ямар сонголт хийдгийг жагсааж (ялангуяа шүлэг 4, 6–7-г үз), өнөө үед ийм сонголтуудын үр дагавар юу болохыг тайлбарла. Хэрэв бид шүлэг 8 дахь Их Эзэний зөвлөгөөг дагах юм бол бидний хувьд амьдрал хэрхэн илүү сайн болохыг тайлбарла.

В Их Эзэний зорилгуудыг ол

Сургаал ба Гэрээ 3:19–20-д Мормоны Номын ялтсууд яагаад хадгалагдаж ирснийг Их Эзэн өгүүлсэн байдаг. Эндээс олсон шалтгаануудыг жагсааж, уг илчлэлт өгөгдсөн 1828 оноос хойш энэхүү зорилгуудыг биелүүлэхэд юу тохиолдсоныг тайлбарла.



Их Эзэний амжилттай үйлчлэгч байхын тулд хүн ямар үүрэг хүлээдэг вэ? Энэ асуултанд Сургаал ба Гэрээ 4 хариулдгийг бүрэн цагийн номлогч бүр мэднэ. Уг хэсэг ердөө долоохон шүлэгтэй ч гэсэн: “Энэ хэсэг насан турш судлахад хангалттай зөвлөгөө, зааврыг агуулдаг. Үүнийг гарамгай эзэмшсэн хүн хараахан нэг ч байхгүй. Энэ нь Иосеф Смитэд өгөгдсөн хувийн илчлэлт биш ч гэсэн, Бурханд үйлчлэх үйлчлэлийг

баяртай хүлээн авахыг хүсдэг бүх хүмүүст ашиг тустай байх болно” гэж Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит хэлжээ (Church History and Modern Revelation, 1:35). Энэ илчлэлтийг уншихдаа, үйлчлэхээр дуудагдсан тухайгаа та хэрхэн ярьж болохыг эрж хай.



Мариний Б. Кампвелл



Номлолын ажлыг Их Эзэн ургац хураахтай зүйрлүүлжээ

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 4

Сургаал ба Гэрээ 4—Иосеф Смитийн аав

Эцэг Иосеф Смитийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг “Сургаал ба Гэрээн дэх Хүмүүс ба нэр томьёонууд” (х.244)-аас үз.

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээний 4-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Хариултуудыг ол

Сургаал ба Гэрээний 4-р хэсгээс сурч мэдсэн зүйлээсээ дараах асуултуудад тэмдэглэлийн дэвтэртээ хариул:

1. Их Эзэнд үйлчлэхээр дуудагдсан хүмүүсээс юу шаардагддаг вэ? (ш. 2-ыг үз).
2. Ийм байдлаар үйлчилдэг хүмүүст ямар адислал амлагддаг вэ? (шүлэг 2, 4-ийг үз).
3. Гайхалтай энэхүү ажил ургац хураахтай юугаараа адилхан бэ? (шүлэг 1, 4-ийг үз).
4. Үйлчлэхээр дуудагдсанаа хүн яаж мэддэг вэ? (ш. 3-ыг үз).
5. Үйлчлэх дуудлага авсан хүн ямар таван шаардлагыг хангах ёстой вэ? (ш. 5-ыг үз).
6. Жагсаасан дөрвөн чухал шинж чанарын хамт Их Эзэний үйлчлэгч юуг мартажгүй байх ёстой вэ? (ш. 5-ыг үз).
7. Та үйлчлэхийг хүсдэг боловч дээрх шаардлагууд танд байхгүй бол, юу хийж болох вэ? (ш. 7-г үз).

Б Амлалтыг шалга

1. Сургаал ба Гэрээний 4-р хэсэгт дурдсан шаардлагуудаас та амьдралдаа бүрэн дүүрэн байлгахыг хүсдэг нэг шаардлагыг сонго. Үүнийг хуудас цаасан дээр бичиж,

байнга харагдах газарт тавь. Сургаал ба Гэрээ 4:7-д дурдсаны дагуу, энэ шинж чанарыг хөгжүүлэхэд өөртөө туслахыг Тэнгэрлэг Эцэгээс өдөр бүр гуйж бай. Уг шинж чанарыг хөгжүүлэхэд гарч байгаа өсөлт дэвшлийн тухай наад тал нь долоо хоногийн хугацаанд хувийнхаа тэмдгэлд нэг догол мөр бич.

2. Долоо хоногийн эцэст туршлагаа тэмдгэлэлийн дэвтэртээ товчхон бич.

Сургаал ба Гэрээ 5 Мормоны Номын гэрчүүд амлагдсан нь

Мормоны Номын орчуулгын 116 хуудсыг алдагдахад хүргэсэн дуулгаваргүй байдлынхаа төлөө Мартин Харрис наманчилсан хэдий ч (Сургаал ба Гэрээний 3-р хэсгийг үз), Бошиглогч Иосеф Смитэд ялтсууд үнэхээр байсны биет нотолгоог хүссэн хэвээр байлаа. Дэлхий дэх олон хүмүүсийн итгэдэг зүйлд сөргүүлэн Их Эзэн Өөрийн үйлчлэгчдийн заадаг үнэнүүдийг дэмжихийн тулд нотолгоогоор үргэлж хангадаг билээ. Энэ нотолгоог тусгайлан дуудагдсан гэрчүүд олонтаа хангадаг. “Хоёр буюу гурван гэрчийн амаар үг бүр батлагдах болно” (2 Коринт 13:1) гэдгийг Их Эзэн амлажээ. Ялтсуудыг гурван гэрчид “Бурханы хүчээр” (2 Нифай 27:12) үзүүлэх болно гэсэн бошиглолыг Мормоны Ном агуулдаг. Сургаал ба Гэрээ 5-р хэсэгт, хэрэв Мартин Харрис тодорхой болзлуудыг хангах юм бол түүний хүсэлт зөвшөөрөгдөж, тэрээр гэрчүүдийн нэг байж болох нь түүнд амлагдсан ажээ. Сургаал ба Гэрээ 17-р хэсэг бол эдгээр тусгай гэрчүүд болсон гурван хүнд өгөгдсөн ичлэлт юм. Та эдгээр хэсгүүдийг уншихдаа, ялтсуудыг хүн болгонд үзүүлэхийг Бошиглогч Иосеф Смитэд Их Эзэн яагаад зөвшөөрөөгүйг эрж хай.



Давид Витмер

Мартин Харрис

Оливер Каудери

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 5

Томилогдсон (шүлэг 6, 17)—Эрх мэдэл олгогдсон, ажил үүрэгт томилогдсон

Хадгалж ирсэн (ш. 9)—
Нууц байлгаж ирсэн

Эзгүйрүүлэгч аймшигт
цээрлүүлэлт (ш. 19)—
Устгагч тахал

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээний 5-р хэсгийг судлахдаа (А-В) дэх үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Үүнийг найздаа тайлбарла

Алтан ялтсууд музейд байгаа юу? гэж асуусан гишүүн бус найзтайгаа чи Мормоны Номын тухай ярилцаж байна гэж төсөөлөн бод. Иосеф Смит орчуулгыг дуусгасны дараа тэнгэр элч Моронай яагаад ялтсуудыг буцааж авсныг тайлбарлахын тулд Сургаал ба Гэрээ 5:1–9-ийг ашигла.

Б Тодорхойлолт бич

Сургаал ба Гэрээ 5:10–16 нь Мормоны Ном үнэнийг гэрчилсэн гурван гэрчийн тухай өгүүлдэг.

1. Шүлгүүдийг судлаад, яагаад эдгээр хүмүүс гэрчээр дуудагдсаныг Хүүхдийн Хэсгийн ямар ч хүүхэд ойлгож чадахаар гэрч гэдэг үгийн энгийн тодорхойлолтыг бич.
2. Сургаал ба Гэрээ 5:25 болон Мормоны Номын өмнөх “Гурван Гэрчийн Гэрчлэл”-ийг нэгтгэн дүгнэ. Эдгээр хүмүүс ялтсуудыг харж, Мормоны Ном үнэнийг гэрчилснийг мэдэх нь өөрийн чинь хувьд ямар учир холбогдолтойг тайлбарла.

В Хэрэв... тэгсэн бол юу болох байсан бол...

Сургаал ба Гэрээ 5:16–24-т хэрэв хүмүүс тодорхой зүйлүүдийг хийх буюу хийхгүй тохиолдолд юу болох тухай Их Эзэн нэлээд хэдэн амлалт өгчээ.

1. Өөрийнх нь үгсэд итгэдэг хүмүүст Их Эзэн ямар амлалт өгсөн бэ? (ш. 16-г үз).
2. Хэрэв хүмүүс зүрх сэтгэлээ хатууруулж, наманчлахгүй бол юу тохиолдох болно гэж Тэр хэлсэн бэ? (шүлэг 18–20-ийг үз).
3. Их Эзэн юу хийхийг Иосеф Смитэд зарлиг болгосон бэ? Хэрэв тэр дуулгавартай дагавал юу тохиолдох байсан бэ? (шүлэг 21–22-ыг үз).
4. Их Эзэн юу хийхийг Мартин Харрис зарлиг болгосон бэ? Хэрэв тэр дуулгавартай дагавал юу тохиолдох байсан бэ? (ш. 24-ийг үз).

Сургаал ба Гэрээ 6

Сүнсний гэрчлэл

Бидний залбирлуудад Бурхан хэрхэн хариулдаг вэ? Сургаал ба Гэрээ 6-д, түүний залбирлууд хэрхэн хариулагдсаныг Оливер Каудерид хэлжээ. Оливерт Их Эзэний хэлсэн зүйлүүдийг ойлгох нь залбирлуудынхаа хариуг танихад чинь тусалж чадна. Бошиглогч Иосеф Смитийн талаар залбирахад Оливерт мэдрэгдсэн амар амгалангийн тэрхүү мэдрэмжийг мэдрэх нь гайхалтай сайхан юм.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 6

Хадуур (шүлэг 3–4)—Тариа хураахад зориулсан хурц иртэй махир хутга шиг багаж

• **Үе, үеийнхэн** (шүлэг 8–9)—Энэ цаг үе буюу аль нэг эрин зууны хүмүүс

Сургаал ба Гэрээ 6—Оливер Каудери гэж хэн байсан бэ?

Оливер Каудерийн тухай мэдээллийг, “Сургаал ба Гэрээн дэх Хүмүүс ба нэр томъёонууд” (х.244)-аас үз.



Сургаал ба Гэрээ 6:2—Үгийн хүч

Их Эзэн Өөрийнхөө үгийн хүчийг дүрслэхийн тулд сэтгэлд хоногши зарим дүрслэлийг ашигласан байдаг. Бурханы үг хүчтэй гэдэг санаа нь ойлгоход хялбар юм. Учир нь түүний үгээр тэнгэрийн бүх зүйл хүмүүний зүрх сэтгэлд нэвтрэн ордог билээ. “Хоёр талдаа иртэй илднээс илүү хурц, үе мөч болон чөмгийг хоёуланг нь хэдэн хэсэг болгон салгах” гэсэн нийлэмж үг, Бурханы үг хүмүүний зүрх сэтгэлд хэрхэн зүсэх мэт нэвтрэн ордгийг тодорхой дүрсэлжээ (мөн 1 Нифай 16:1–2-ыг үз).

Сургаал ба Гэрээ 6:6—“Сионы ашиг сонирхол”

Сургаал ба Гэрээнд Сион гэдэг үг нэлээд хэдэн өөр байдлаар хэрэглэгдсэн байдаг (“Сургаал ба Гэрээн дэх Хүмүүс ба нэр томъёонууд” х.244)-ыг үз. Гэвч тухай бүр энэ үг түүнтэй хамт зөв шударга ёсоор амьдрах хүмүүсийг төлөвшүүлэх Их Эзэний хүч чармайлтуудтай холбоотой байдаг. “Сионы ашиг сонирхлыг авчирч, төлөвшүүлэхийг эрэлхийлэх нь” сайн мэдээг дэлгэрүүлэх болон Гэгээнтнүүдийн зөв шударга зан чанарыг төгөлдөржүүлэхийг хөхүүлэн дэмжих явдал мөн.

Сургаал ба Гэрээ 6:10–11—Оливер Каудерид ямар бэлэг өгөгдсөн бэ?

Оливер Каудерид Их Эзэний өгсөн бэлэг бол илчлэлтийн сүнс байлаа (С ба Г 8:3–4-ийг үз). “Хэрэг болсон үед энэ нь түүнд хамгаалалт болох байв. Мөн энэ нь түүнийг дайснуудынх нь гараас чөлөөлж, устгагчаас хамгаалах байв” хэмээн Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит заажээ (*Church History and Modern Revelation*, 1:52).

Сургаал ба Гэрээ 6:14–24—Оливер Каудери ямар гэрчлэл хүлээн авсан бэ?

“Бид энэ илчлэлтийг хүлээн авсны дараа Оливер Каудери аавын маань байранд суухаар явснаас хойш, бас ялтсуудыг миний бие олж авсан тухай манай гэрийнхэн түүнтэй ярилцсанаас хойш, нэг шөнө тэрээр орондоо орсны дараа, эдгээр зүйлүүд үнэхээр тийм байсан уу гэдгийг мэдэхийн тулд Их Эзэнд хандан залбирсан ажээ. Ийнхүү эдгээр зүйлүүд үнэнийг Их Эзэн түүнд харуулсан ч, тэрээр уг нөхцөл байдлыг бүхэлд нь нууцалж, хэнд ч яриагүй аж. Иймээс эл илчлэлт өгөгдсөний дараа, уг ажил үнэнийг тэр мэдэж байв, учир нь Бурхан тэр хоёроос өөр нэг ч амьд хүн уг илчлэлтэд дурдсан зүйлийн тухай мэдээгүй юм” гэж Бошиглогч Иосеф Смит бичжээ (*History of the Church* 1:35).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээний 6-р хэсгийг судлахдаа (А-В) дэх үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Харьцуул

Сургаал ба Гэрээний 6-р хэсэгт чухал үнэнүүдийг заахын тулд Их Эзэн дүрслэл болон бэлгэдлүүдийг ашиглажээ. Дараах нийлэмж үгсийг тэмдэглэлийн дэвтэртээ хуулж аваад, шүлэг 1–5-аас сурч мэдсэн зүйлүүдээрээ өгүүлбэрүүдийг төгсгө:

1. Сайн мэдээний захиас илдтэй адил юм. Учир нь . . .
2. Номлол фермийн ажилтай адил юм. Учир нь . . .
3. Залбирал бол хаалга тогшихтой адил юм. Учир нь . . .

Б Яаж баян, аз жаргалтай болох вэ?

1. Сургаал ба Гэрээ 6:7, 13-ыг 1 Нифай 11:21–23-аас Нифайн сурч мэдсэн зүйлтэй харьцуул. Баян, бас аз жаргалтай болох талаар сурч мэдсэн зүйлээ тайлбарла.
2. Баян бөгөөд аз жаргалтай байх талаар дээрх судруудын заадаг зүйл, биднийг баян, аз жаргалтай болгоно гэж дэлхийн боддог зүйлээс ямар ялгаатай вэ?
3. Их Эзэн бидэнд санал болгодог баяр баясгаланг дэлхийн баялгууд яагаад авчирч чадахгүй гэж та боддог вэ?

4. Аврал, мөнх амьдралын бэлэг таны хувьд ямар үнэ цэнэтэйг нэг эсвэл хоёр өгүүлбэрээр тайлбарла.

В Илчлэлт хэрхэн ирдгийг ойлгох нь

1. Сургаал ба Гэрээ 6:14–24-ийг уншаад, Иосеф Смит үнэхээр Бурханаар дуудагдсаныг Оливер Каудери яаж мэдсэнийг тайлбарла.
2. Өөрт чинь гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн хоёр шүлгийг Сургаал ба Гэрээ 6:14–24-өөс сонгож, амьдралдаа илчлэлт хүлээн авахын тулд дээрх шүлгүүдийг хэрхэн хэрэглэхийг дүрсэл.



1829 оны дөрөвдүгээр сарын турш Бошиглогч Иосеф Смит Мормоны Номын ялтсуудын орчуулгыг түүний бичээчээр ажиллаж байсан Оливер Каудерийн хамт үргэлжлүүлжээ. Эл илчлэлтийг өдөөсөн нөхцөл байдлыг Бошиглогч дүрслэхдээ: “Шинэ Гэрээнд дурдагддаг Төлөөлөгч Иоханы [Иохан 21:20—23-

ыг үз] шастирын талаар бидний хооронд үүссэн санал зөрөлдөөний ялгаа нь тэрээр наснаас хальсан уу, эсвэл амьд хэвээр байгаа юу гэдэгт байлаа. Үүнийг Урим, Туммимаар шийдвэрлэхийг бид харилцан тохиролцсон юм” гэжээ (History of the Church, 1:35–36).

Сургаал ба Гэрээний 7-р хэсгийг уншихдаа, Төлөөлөгч Иохан, Петр нар юуг хамгийн ихээр хүсч байсныг эрж ол. Иохан өмнө нь хийсэн зүйлээсээ илүү их юу хийхийг хүсч байсан бэ? Хэрэв Аврагч танаас юуг хамгийн их хүсч байгааг асуувал, та юу гэж хэлэх вэ?

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 7

Илгэ (хэсгийн тойм)—Юм бичихэд зориулан бэлтгэсэн хонь, ямааны элдсэн арьс

Тохинуулах (6–7-р шүлэг)—Үйлчлэх, туслах
Түлхүүрүүд (ш. 7)—Эрх мэдэл

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээний 7-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Нэг өгүүлбэрээр хариул

Сургаал ба Гэрээний 7-р хэсгийн тойм нь Иосеф Смит Оливер Каудери хоёр Их Эзэнээс юу хүссэн тухай өгүүлдэг (мөн энэ гарын авлагын С ба Г 7-р хэсгийн оршлыг үз). 7-р хэсгийг уншаад, дараах асуулт бүрд оногдох хариултыг нэг өгүүлбэрээр бич:

1. Иоханы болон Петрийн хүсч байсан зүйлсийн хооронд ямар ялгаа байсан бэ?
2. Сайн мэдээг хуваалцахын ач холбогдлын талаар та энэ хэсгээс юу мэдэж авав?
3. Зөв шударга хүслийн тухай та юу мэдэж авав?



Ариун Сүнсээр дамжуулан хувиараа илчлэлт хүлээн авах агуу адислал нь итгэл бишрэлтэй хүмүүст боломжтой юм. Сургаал ба Гэрээний 6-р хэсэгт илчлэлтийн бэлэг, ялангуяа эртний цэдгүүдийг орчуулах хүч Оливер Каудерид амлагджээ. Гэвч, илчлэлт хүлээн авах нь зүгээр л нэг хүсэхээс илүү их хүч чармайлт шаарддагийг Оливер мэдсэн ажээ. Далын гишүүн асан Ахлагч С.Дилвөрт Янг: “Үнэний тухай гэрчлэлийг хэлснээр танд ирдэг Сүнсийг хэрхэн тайлбарлахыг мэдэхээс илүү агуу, илүү сэтгэл догдлом, илүү баяр хөөртэй адал явдал та нарын хэнд нь ч тохиолдохгүй гэдгийг би гэрчилж чадна. . . Зүрх сэтгэлд маань Сүнс шивнэдэг арга замыг бид мэддэг байх ёстой. Бид үүнийг сонсож, үүнийг ойлгож, Сүнс хэзээ бидэнд байгааг мэдэж сурах ёстой, энэ нь заримдаа урт удаан хугацаа шаарддаг” хэмээн сургажээ (In Conference Report, 1959 оны 4-р сар, 59). Сургаал ба Гэрээний 8–9-р хэсгийг уншихдаа, орчуулах хүчтэй байхын тулд тэрээр юу хийх ёстой талаар Оливер Каудерид хэлсэн зүйлүүдийг, бас яагаад тэрээр орчуулгыг үргэлжлүүлэх боломжгүй болсныг анхааран үз. Түүнчлэн хувиараа илчлэлт хүлээн авах таны хүч чармайлтуудын талаар энэхүү илчлэлтүүд юу зааж байгааг анхааран үз.

Судруудыг ойлгох нь



Моисе илчлэлтийн сүнсээр Улаан Тэнгисийг хага яржээ

Сургаал ба Гэрээ 9

Шаардлагатай (ш. 3, 10–11)—Зохимжтой, хүсүүштэй

Дүйнгэ (ш. 9)—Будилсан, эргэлзэж тээнэгэлзсэн

Сургаал ба Гэрээ 8:6–8—“Аароны бэлэг”

“Оливер Каудерид өгөгдсөн өөр нэг бэлэг байсан нь Аароны бэлэг юм. Гартаа төмөр бариул барьж, Мосегийн төлөөний хүн болон өмнө нь явж байсан Аароны нэгэн адил, Оливер Каудери ийнхүү Иосеф Смитийн өмнө явах ёстой байлаа. Хэрэв тэр итгэлээр, мэргэн ухаанаар гуйх юм бол энэ бэлгийн хүчээр Их Эзэнээс юуг ч хүслээ гэсэн хүссэн зүйл нь зөвшөөрөгдөх байв. Энэ эрин үеийн түлхүүрүүдийг Иосеф Смитийн хамт эзэмших агуу алдар хүндэтгэлээр Оливер адислагдаж, Аароны нэгэн адил, олон тохиолдолд түүний төлөөний хүн болсон юм. Энэ эрин үед олон нийтийн өмнө анх удаа лекц уншсан хүн бол Оливер байлаа” хэмээн Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит хэлжээ (*Church History and Modern Revelation*, 1:52).

Сургаал ба Гэрээ 9:7–9—Сүнс үргэлж цээжин дотор шатахад хүргэдэг үү?



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Даллин Х.Өүкс тайлбарласан нь:

“Сүнсээр заалгах нь идэвхгүй зүйл биш. Бид асуудлуудыг оюун ухаандаа сайтар тунгаан бодох хүртэл Их Эзэний харилцаа ирэхгүй байх нь олонтаа тохиолддог. Их Эзэний

харилцаа ирэхэд л бид баталгаа хүлээн авдаг билээ.

“1829 оны дөрөвдүгээр сард Пеннсилванийн Хармонид хүлээн авагдсан өөр нэг илчлэлтэд Их Эзэн энэ үйл явцыг Оливер Каудерид тайлбарлажээ. Оливер яагаад Мормоны Номыг орчуулах боломжгүй байсныг Их Эзэн дүрслэхдээ:

“Болгоогтун, чи ойлгосонгүй; чи надаас асуухаас өөрөөр санаа тавиагүй байхад чинь, би үүнийг чамд өгөх юм шигээр чи бодсон байна.

“Гэвч болгоогтун би чамд хэлнэ, чи үүнийг оюундаа тунгаан бодох ёстой; дараа нь энэ нь зөв үү гэдгийг чи надаас асуух ёстой, мөн энэ нь зөв аваас, цээжин биеийг чинь чиний дотор шатахаар болгоно би; тиймийн тул, энэ нь зөв юм байна гэдгийг чи мэдрэх болно” гэжээ (С ба Г 9:7–8; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

“Энэ бол Сургаал ба Гэрээн дэх хамгийн чухал мөртлөө буруу ойлгогддог сургаалуудын нэг байж мэднэ. Сүнсний заалтууд мэдрэмжээр ирэх нь олонтаа байдаг. Энэ баримт нэн чухал ч гэсэн, энэ нь юу гэсэн утгатайг зарим хүмүүс буруу ойлгодог. Тэд цээжин дотроо ‘шатаж байгааг’ хэзээ ч мэдрээгүй учраас Ариун Сүнснээс гэрчлэл огт хүлээж аваагүй гэж ярьсан хүмүүстэй би тааралдсан.

“Цээжин дотор шатах’ гэдэг нь юу гэсэн үг вэ? Шаталтаар үүсдэг калорийн халуун шиг тийм халууныг мэдрэх хэрэгтэй гэсэн үг үү? Хэрэв тийм бол миний цээжин дотор хэзээ ч шатаж байгаагүй. Судар дахь ‘шатаж байгаа’ гэсэн үг нь тайтгарал, амар амгалангийн мэдрэмж гэсэн утгатай нь мэдээж юм. Энэ бол олон хүний хүлээн авдаг гэрчлэл. Энэ бол илчлэлт ажилладаг арга зам мөн.

“Намуухан, зөөлөн дуу хоолой нь, үнэхээр, ‘намуухан,’ ‘зөөлөн’ л байдаг (“Teaching and Learning by the Spirit,” *Ensign*, 1997 оны 3-р сар, 13).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээний 8–9-р хэсгийг судлахдаа, үйл ажиллагаа А, үйл ажиллагаа Б буюу В-г хий.

А Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 8:2–3



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Боид К.Пакер: “Төлөөлөгчийн хувьд би эдүгээ нэг л эх сурвалжаас үүдэлтэй сүнсний нөлөөг мөн ийм арга замаар сонсдог, үүнийг би хөвгүүн байхдаа сонсдог байсан. Одоо дохио нь бүр илүү тод байдаг” хэмээн хэлсэн байна (In

Conference Report, 1979 оны 10-р сар, 30; *Ensign*, 1979 оны 11-р сар, 21).

1. Сургаал ба Гэрээ 8:1–3-ыг судалж, Ариун Сүнс бидний оюун ухаанд хандан ярихад юу тохиолддогийг тайлбарла (Инос 1:10-ыг үз).
2. Ариун Сүнс хүний зүрх сэтгэлд хандан ярихад ямар мэдрэмж төрдөг вэ? (1Нифай 17:45-ыг үз).
3. Сүнслэг мэдрэмжийн дуу хоолой Ахлагч Пакерт яагаад илүү тод сонсогдсоныг тайлбарлаж болох юуг та Сургаал ба Гэрээ 8:1-ээс мэдсэн бэ?

Б Сургаалыг дүгнэ

1. Сургаал ба Гэрээ 6:23-т өгүүлснээр, Их Эзэн Оливер Каудеритай хэрхэн ярьсан бэ?
2. Илчлэлт хэрхэн ирдэг тухай Сургаал ба Гэрээ 8:2–3-т Их Эзэн өөр юу заасан бэ?

- Орчуулж байх үедээ хариултууд авах талаар Оливер Каудери Сургаал ба Гэрээ 9:7–9-өөс юу мэдсэн бэ?
- Илчлэлтийн үйл явцын талаар эдгээр хэсгүүдээс сурч мэдсэн зүйлээ дүгнэсэн нэг догол мөр бич.

В Болсон явдлын талаар сургамж бич

- Сургаал ба Гэрээний 8-р хэсэгт Их Эзэн Оливерт юу амласныг, мөн Сургаал ба Гэрээ 9-д, цаашид орчуулахыг яагаад түүнд зөвшөөрөөгүй талаар Их Эзэний хэлсэн зүйлүүдийг нэгтгэн дүгнэ.
- Энэ илчлэлтээс бидний авч болох сургамжийн тухай дүгнэсэн нэг өгүүлбэр бич.
- Их Эзэнээс сүнсний нөлөө хүсдэг хүн дүгнэлтийг тань хэрхэн хэрэглэж болох вэ?



Сургаал ба Гэрээний 3-р хэсэгт, ялтсуудаас Бошиглогч Иосеф Смитийн орчуулсан 116 хуудсыг Мартин Харрис хэрхэн алдсан тухай та уншидаг. Сургаал ба Гэрээний 10-р хэсэгт гар бичмэлийн 116 хуудас хэрхсэн тухай мөн эдгээр хуудсыг Сатан ямар зорилгоор ашиглах гэж байгааг Их Эзэн илчилжээ. Илүү чухал нь гэвэл, алдагдсан хуудсыг Их Эзэн юугаар нөхсөнийг та илрүүлэх болно. Энэ хэсгийг судлахдаа, энд дэлхий дээрх үйл явдлуудын өрнөлийг хянах Түүний хүчний тухай, тодруулбал Их Эзэний ажлыг устгах Сатаны хүч чармайлтуудын тухай Их Эзэн юу заасныг эрж ол.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 10

Алдас (шүлэг 20, 29)—Нүгэл
Өөртэйгөө зөрчилдөх (ш. 31)—Текстийн бичмэл хэсэг нь өөрийн чинь өмнөх бичсэнтэй тохирохгүй байх
Үе, үеийнхэн (шүлэг 33, 53)—Тухайн эрин үеийн хүмүүс
Шившиглэх (ш. 42)—Ичээх, ичгүүртэй болгох
Гуйвуулах (ш. 63)—Утгыг мушгин гуйвуулах

Сургаал ба Гэрээ 10:6—Бошиглогч Иосеф Смитийг ямар арга замаар хөнөөхийг Мартин Харрис эрэлхийлсэн бэ?

Мартин Харрис Бошиглогч Иосеф Смитийг хөнөөх бодолгүй байсан боловч, Мормоны Номын гар бичмэлийн 116 хуудас алдагдсаны үр дүнд бий болсон нөхцөл байдал нь бид “Бурханы зөвлөгөөг үл ойлшоовол” (С ба Г 3:13; С ба Г 3:12-ын “Судруудыг ойлгох нь” хэсэг, х. 17-г үз) юу тохиол-

дож болохыг харуулсан юм. Мартин Харрис яахыг Их Эзэн урьдаас мэдэж, үүнд бэлтгээгүй бол Сатан болон түүний үйлчлэгчид худал хуурмаг зүйлээрээ Бошиглогч Иосефыг хөнөөхөд амжилт олж болох байв (С ба Г 10:10–33-ыг үз). “Бурханы зөвлөгөөг үл ойлшоон”, гар бичмэлийг авч явахыг дахин дахин шалж, гар бичмэлийг сонор соргог хамгаалах үүргээ зөрчсөнөөр Мартин хэдийгээр санаатай биш боловч Сатаны зорилгод үр ашигтайгаар үйлчилсэн юм.

Сургаал ба Гэрээ 10:30–45—Их Эзэн төгсгөлийг эхлэлээс нь мэддэг



Гар бичмэлийн 116 хуудас алдагдсанаар дамжуулан Бошиглогч Иосеф Смит болон Мормоны Номыг Сатан устгахаас урьдчилан сэргийлсэн арга замыг Их Эзэн хоёр мянга гаруй жилийн өмнөөс бэлтгэсэн ажээ. Алдагдаж болох гар бичмэлийн цаг үеийг хамарсан ялтсуудын хоёр дахь хувийг хийхийг Тэрээр бошиглогч Нифайд зааварласан юм. Энэ хоёр цэдгийн гол ялгаа нь, алдагдсан хэсэгт түүх давамгайлсан бол, нөгөөх хувьд нь бошиглол болон ариун бичээсүүд давамгайлсан ажээ (1 Нифай 9:3–6; Мормоны Үгс 1:1–7-г үз).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээний 10-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А, мөн өөр хоёр үйл ажиллагааг хий.

А Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 10:5

Сатан гэдэг үг “дайсан,” “эсэргүүцэгч” гэсэн утгатай бөгөөд шударга ёсыг эсэргүүцэгч чөтгөрийн үүргийг дүрсэлдэг. Сатан болон түүний үйлчлэгчид нүгэл үйлдүүлэхээр биднийг уруу татдаг, энэ нь олиггүй муу муухай зүйл, аз жаргалгүй амьдрал руу хөтөлдөг билээ. Гэвч уруу таталтуудыг даван туулахад бидэнд туслах илүү агуу хүч Их Эзэнд бий.

- Алма 34:17–27, 3 Нифай 20:1-ийг унш. “Сатаныг байлдан дагуулахын [даван туулах]” (С ба Г 10:5) тулд бид юу хийх ёстой вэ? “Үргэлж залбир” гэдэг нь юу гэсэн утгатай гэж та боддог вэ?
- Сургаал ба Гэрээ 10:5-ыг 2 Нифай 32:8–9-тэй харьцуул. Хэн залбирахгүй байхыг бидэнд сургадаг вэ?

Б Сатаны “зальт төлөвлөгөөг” Их Эзэний мэргэн ухаантай харьцуул

1. Тэмдэглэлийн дэвтрийнхээ нэг хуудсыг хоёр багана болгон хуваа. Эхний баганыг “Сатаны зальт төлөвлөгөө,” хоёр дахийг “Их Эзэний мэргэн ухаан” гэж гарчигла.
2. Сургаал ба Гэрээ 10:6–29-ийг уншаад, Мартин Харрисаас хулгайлсан 116 хуудсаар Сатан юу хийхээр төлөвлөж байсан тухай Их Эзэний хэлсэн зүйлийг нэг дэх багананд дүрсэл.
3. Шүлэг 30–45-ыг уншаад, Сатаныг амжилт олохоос сэргийлэхийн тулд Их Эзэн юу хийснийг хоёр дахь багананд дүрсэл.
4. 1 Нифай 9:3–6, Мормоны Үгс 1:1–7-г унш. 116 хуудас алдагдсанаар бий болсон асуудлыг шийдвэрлэхийн тулд Их Эзэн хэр зэрэг урт удаан хугацаагаар бэлтгэснийг тайлбарла.

В Сатаны аргуудаас болгоомжил

Сургаал ба Гэрээ 10:20–29 нь биднийг мэхлэхийн тулд Сатаны хэрэглэдэг зарим аргуудыг тайлбарладаг.

1. Шүлэг 20–24-ийг нэгтгэн дүгнэж, Сатан хүмүүсийг үнэний эсрэг хэрхэн турхирдаг болон яагаад ингэдгийг тайлбарла.
2. Шүлэг 25–29-ийг судалж, Бошиглогч болон Мормоны Номыг устгахыг хичээх нь сайн хэрэг гэдгийг Иосеф Смитийн дайснуудад итгүүлэхийн тулд Сатан тэдэнд юу хэлснийг дүрсэл.
3. Өнөө үед мөн ингэхийг хэсэг бүлэг болон хувь хүмүүс хэрхэн оролдож болох вэ?

Г Хүүхдийн Хэсгийн хичээл бэлтгэ

1. Сургаал ба Гэрээний 3, 10-р хэсгүүд дэх 116 хуудас алдагдсан тухай шастирыг Хүүхдийн Хэсгийн 7 настай хүүхдүүдэд яаж заахаа бич.
2. Бошиглогч Иосеф Смитэд тохиолдсон явдлаас бидний авч болох хоёр сургамжийн тухай ярьж, уг сургамж өнөөдөр бидний амьдралд хэрхэн холбогдохыг харуул.



Хайрум Смит бол Бошиглогч Иосеф Смитийн ах юм (Иосеф Смит-Түүх 1:4-ийг үз). 1829 оны тавдугаар сард тэрээр Иосеф, түүний эхнэр Эмма, Оливер Каудери нарыг Мормоны Номын орчуулган дээр ажиллаж байхад тэдэнтэй уулзахаар Нью-Йоркийн Палмирагаас Пеннсилвангийн Хармонид иржээ. Хайрум Бошиглогч дүүдээ “чин сэтгэлийн хүсэлтээ” илэрхийлсний үр дүнд Сургаал ба Гэрээ 11 дэх илчлэлт ирсэн ажээ (History of the Church, 1:45-ыг үз).

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Нийл А.Максвелл:



“Сүнслэг байдлын хувьд чухал зүйлүүд болдог газарт зөв шударга хүсэл бодол байдаг” гэж заажээ (In Conference Report, 1996 оны 10-р сар, 27; Ensign, 1996 оны 11-р сар, 21). Сургаал ба Гэрээний 11-р хэсгийг уншихдаа, хүсэл, хүсэх гэдэг үгийг мөн бидний хүслийн ач холбогдлын талаар Их Эзэн юу гэж хэлснийг эрж ол. Илчлэлт дэх зөвлөгөөний ихээхэн хэсэг нь “сайн сайхан хүсэлтэй тэд бүгдэд” (ш. 27)-түүний дотор танд хамаатайг бас анхааран үз!

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 11

Нэгдэн нийлэгтүн (ш. 19)—Ойр бай

Дуугүй бай (ш. 22)—
Номлохоо бүү эхэл

Сургаал ба Гэрээ 11—Хайрум Смит

Хайрум Смитийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг “Сургаал ба Гэрээ дэх Хүмүүс ба нэр томьёонууд” (х.00 [231])-аас үз.

Сургаал ба Гэрээ 11:6—“Сионы ашиг сонирхлыг төлөвшүүл”

Энэ өгүүлбэрийг ойлгоход туслалцаа авахын тулд Сургаал ба Гэрээ 6:6 (х.00 [20])-гийн “Судруудыг ойлгох нь” хэсэг мөн “Сургаал ба Гэрээ дэх Хүмүүс ба нэр томьёонууд (х.00 [233]) дахь Сион гэдэг үгийг үз.

Сургаал ба Гэрээ 11:9—“Энэ үеийнхэнд наманчлалаас өөр юу ч бүү ярь”

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит заасан нь: “Наманчлалаас өөр юуг ч бүү тунхагла хэмээн Их Эзэн үйлчлэгчдэдээ уриалахдаа, баптисмыг бүү тунхагла, Их

Эзэний зарлигуудыг дуулгавартай дагахад хүмүүсийг бүү уриал гэсэн хэрэг биш, харин тэдний хэлдэг, хийдэг бүх зүйл хүмүүсийг наманчлалд авчрах сүнсэнд байхыг тэрээр хүсчээ” (*Church History and Modern Revelation*, 1:57). Өөрөөр хэлбэл, Их Эзэний хаант улсад үйлчлэхээр дуудагддаг бүх хүмүүсийн гол анхаарал өөрсдийгөө сайжруулахад нь хүмүүст туслах, тэдний амьдралыг Есүс Христийн сургаалуудад нийцүүлэн өөрчлөхөд төвлөрөх ёстой.

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээний 11-р хэсгийг судлахдаа (А-Г) дэх үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Амлагдсан адислалуудыг олж авах нь

1. Тэмдэглэлийн дэвтрийнхээ нэг хуудсыг хоёр багана болгон хуваа. Нэг баганыг “Амлагдсан адислалууд,” нөгөөхийг нь “Адислалуудыг олж авахад тавигдах шаардлагууд” гэж гарчигла.
2. Сургаал ба Гэрээний 11-р хэсгийг уншаад, Хайрум Смитэд (тэрчлэн “сайн сайхан хүсэлтэй тэд бүгдэд”) Их Эзэний санал болгосон адислалуудыг нэг дэх багананд жагсаа. Адислал бүрийн хамт, холбогдох шүлгийг тэмдэглэ.
3. Хоёр дахь багананд энэ адислалыг хүлээн авахын тулд Хайрум Смит (эсвэл та) юу хийх ёстой гэж Их Эзэний хэлсэн зүйлүүдийг бич. Уг адислалын талаарх шүлгүүд хаана байдгийг та өмнө нь эсвэл дараа нь унших хэрэгтэй байж болно.
4. Номлогчид эсвэл эцэг эхийн аль алинд нь онцгой сонирхолтой байж болно гэж бодсон адислалууд болон шаардлагуудаас хоёрыг сонго. Яагаад эдгээрийг сонгосноо тус бүрд нь тайлбарла.

Б Хүслийн ач холбогдол

1. Хүсэл, хүслүүд, хүсдэг гэсэн үгсийг агуулсан шүлгүүдийг Сургаал ба Гэрээний 11-р хэсгээс олж жагсаан бич. (Та эдгээр шүлгүүдийг судрууддаа тэмдэглэж болно.)
2. Мөн 1 Нифай 11:1; Алма 29:4; 41:3–6; Абрахам 1:2-ыг унш. Сайн мэдээний төлөвлөгөөн дэх бидний хүслийн ач холбогдлыг тайлбарласан нэг догол мөр бич.
3. Хийх ёстой ямар нэг сайн зүйл байсан ч гэсэн (өдөр бүр судрууд унших эсвэл олон удаа залбирах гэхчлэн) хүн үүнийг хийхийг хүсээгүй бол тэр юу хийж болох вэ?

В Сүнсний тухай мэдэх нь

1. Сургаал ба Гэрээ 11:12–14-өөс Бурханы Сүнсний тухай та юу мэдэв?
2. Дээрх шүлгүүдэд дүрслэгдсэн арга замуудын нэгээр (эсвэл олноор нь) та Сүнсийг мэдэрсэн үеийнхээ тухай бичнэ үү.

Г Энэ нь юу гэсэн утгатай вэ?

1. Хайрум Смитийг хий хэмээн Сургаал ба Гэрээ 11:21-д Их Эзэний хэлсэн зүйлүүдийг өөрийнхөө үгээр дүрсэл.
2. Хайрум Смит (эсвэл та) үгийг олж авахын тулд юу хийх ёстой гэж боддогоо дүрслэн “миний үгийг олж ав” гэсэн нь ямар утгатайг тайлбарла.

Сургаал ба Гэрээ 12

“Энэ ажилд тусалдаг” хүмүүст



Бүр Сүм зохион байгуулагдахаас өмнө эцэг Жозеф Найт Их Эзэний ажилд туслахыг хүсч байв (“Сургаал ба Гэрээн дэх Хүмүүс ба нэр томьёонууд” х.00 [232] дахь эцэг Жозеф Найтын тухай мэдээллийг үз). Тэрээр Сүм

зохион байгуулагдсаны дараахан түүнд нэгдсэн аж. Бошиглогч Иосеф Смит түүнд хүндэтгэл үзүүлж хэлэхдээ: “Өөрсдийнх нь дундаас хэн нэг нь үлдсэн үед Сионы хөвгүүд түүний тухай, энэ хүн Израилд итгэл бишрэлтэй нэгэн байсан юм хэмээн хэлэх болно. Тиймээс нэр нь хэзээ ч мартагдахгүй” гэжээ (*History of the Church*, 5:124–125).

Сургаал ба Гэрээний 12-р хэсгийг уншихдаа, уг ажилд илүү бүрэн дүүрэн туслахад эцэг Жозеф Найт хэрхэн тэнцэж болох талаар Их Эзэн юу гэж хэлснийг анхааран үз. Найт ахынх шиг “сайн сайхан хүсэлтэй тэд бүгдэд” (ш.7) Тэрээр хандан ярилаа гэж Их Эзэн хэлснийг бас анхааран үз.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 12:1–6-г ойлгохын тулд, энэ шүлгүүдтэй бараг адилхан Сургаал ба Гэрээ 6:1–6, 11:1–6-гийн “Судруудыг ойлгох нь” хэсгээс нэмэлт тусламжийг үз.

Сургаал ба Гэрээ 12

Биеэ барих (ш. 8)—Өөртөө хяналт тавих

Сургаал ба Гэрээ 12:8—“Хайраар дүүрэн”



“Хайр бол Бурханы гол шинж чанаруудын нэг бөгөөд Бурханы хөвгүүд байхаар эрмэлзэн тэмүүлдэг хүмүүс хайрыг харуулах ёстой. Бурханы хайраар дүүрэн хүн, зөвхөн гэр бүлийнхээ адислалд сэтгэл хангалуун байдаггүй,

харин бүх дэлхий даяар, бүх хүн төрөлхтнийг адислахад санаа тавьдаг” гэж Бошиглогч Иосеф Смит сургажээ (*History of the Church*, 4:227).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээний 12-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Жишээ гарга

Сургаал ба Гэрээ 12:8-д Их Эзэний өгүүлсэн шинж чанаруудаас аль нэг нь түүнд байдаг гэж өөрийнхөө боддог судрын нэг хүн эсвэл Сүмийн нэг удирдагчийн тухай бич. Уг шинж чанарыг тухайн хүн хэрхэн харуулсныг, бас Их Эзэний ажлыг илүү сайн хийхэд энэ нь түүнд хэрхэн тусалсныг тайлбарла.



Иосеф Смит-Түүх 1:68–74-өөс та Аароны санваарын сэргээлтийн тухай уншидаг. Сургаал ба Гэрээ 13 нь Иосеф Смит-Түүх 1:69-тэй адил юм. Иохан Баптистын үгсийг та энэ удаа уншихдаа сургаалын ач холбогдлын талаас нь шалгаж үз.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 13

Мессиа (ш. 1)—Есүс Христ	Умбуулалт (ш. 1)—Усанд
Тохинуулал (ш. 1)—	бүрэн дүрэх
Үйлчлэл	Ангижрал (нүглүүдийн)
	(ш. 1)—Уучлал, өршөөл

Сургаал ба Гэрээ 13:1—Санваарын түлхүүрүүд

Аароны санваарын түлхүүрүүдийг эзэмших гэдэг нь Аароны санваарыг хүлээн авсан хүн бүр уг санваарын түлхүүрүүдийг бас хүлээн авч, ашиглаж болдог гэсэн үг биш юм. “Петр, Иаков, Иохан нарын удирдлагаар ажиллаж” (хэсгийн тойм) байгаагаа Иохан Баптист хэлсэнчлэн Аароны санваарыг дээд буюу Мелкизедек санваар удирддаг.

“Сайн мэдээний эцсийн энэ эрин үед Их Эзэн бидэнд олгосон санваар болон энэхүү түлхүүрүүдийн тухай” Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит өгүүлж, тайлбарлахдаа:

“Түлхүүрүүд бол Ерөнхийлөгчийн Зөвлөлийн эрх юм; эдгээр нь Их Эзэний бүх ажил хэргийг дэлхий дээр

удирдаж, чиглүүлэх хүч ба эрх мэдэл мөн. Бусад бүх хүмүүс санваараар үйлчилж болох тийм арга маягаар удирдаж, хяналт тавих хүч эл түлхүүрүүдийг эзэмшдэг хүмүүст байдаг. Бид бүгд санваарыг эзэмшиж болно, ингэхдээ түлхүүрүүдийг эзэмшдэг хүмүүс бидэнд эрх мэдэл олгож, чиглэл өгсөн үед л бид санваарыг ашиглаж болно.

“Энэ санваар [Мелкизедек] болон түлхүүрүүдийг Иосеф Смит, Оливер Каудери хоёрт Петр, Иаков, Иохан, түүнчлэн Мосе, Елиа болон эрт дээр үеийн бусад бошиглогчид олгосон юм. Арванхоёрын Зөвлөлийн гишүүний хувьд онцгойлон адислагдсан энэ хоёрт тус бүрд нь түлхүүрүүдийг олгожээ. Гэвч түлхүүрүүд нь Ерөнхийлөгчийн Зөвлөлийн эрх учраас дэлхий дээрх Бурханы ахлах Төлөөлөгч болох Сүмийн Ерөнхийлөгч л зөвхөн түлхүүрүүдийг бүрнээр нь ашиглаж чадна” гэжээ (In Conference Report, 1972 оны 4-р сар, 98–99; *Ensign*, 1972 оны 7-р сар, 87).

Сургаал ба Гэрээ 13:1—Левийн хөвгүүд

Мосе хэдийгээр Мелкизедек санваартай байсан ч, Мосегийн хуулийг Аароны санваараар гүйцэтгэж байжээ (С ба Г 84:23–27-г үз). Зөвхөн Левийн овгийн эрэгтэйчүүдэд (леви-чүүд гэдэг байв) Аароны санваарыг олгодог байлаа. “Левийн хөвгүүд” гэдэг хэллэгийг тэр үед бүх санваар эзэмшигчдийг заахад хэрэглэдэг байжээ. Мосе, Аарон хоёр энэ овгийнх байв. Хуучин Гэрээний үед Мосегийн хуулийн өргөлүүдийг гүйцэтгэх нь левичүүдийн үүрэг байсан аж (Судруудын Удирдамж, “Леви,” х.118–119-ийг үз). Өнөө үед “Левийн хөвгүүд” гэдэг хэллэгийг Сүмд итгэл бишрэлтэйгээр санваарыг хүлээн авч, “Мосегийн болон Аароны хөвгүүд” (С ба Г 84:33–34-ийг үз) болсон бүх хүмүүсийг заахад хэрэглэдэг.

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээний 13-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Санваарын үйлчлэл

Аароны санваарын түлхүүрүүд болон хүч нь хүмүүсийн амьдралыг адисалж, Христэд ирэхэд нь тэдэнд тусалсан арга замуудыг харсан тухай нь нэг бишоптой, эсвэл Аароны санваар эзэмшигч хэн нэгэнтэй ярилц. Сурч мэдсэн зүйлээ тэмдэглэлийн дэвтэртээ бич.




Оливер Каудери Мормоны Номыг орчуулахад нь Бошиглогч Иосеф Смитэд туслан Пеннсилвангийн Хармонид байхдаа, Нью-Йоркийн Фейеттед байсан найз Давид Витмертаа захидал бичсэн ажээ. Захидалд тэрээр уг ажлын тухай гэрчлэлээ хуваалцсан байна.

Давид Витмер сонирхож, ямар ч үед туслахаа санал болгосон харуу бичжээ.

1829 оны тавдугаар сарын сүүлчээр, Мормоны Номыг орчуулахад мөрдлөг хавчлага саад бэрхшээл учруулж байлаа. Бошиглогч Иосеф Смит, Оливер Каудери хоёр Давид Витмерт бичиж, орчуулгыг дуусгахын тулд тэрээр гэр бүлийнхээ хамт тэднийд байх боломжийн талаар асуусан аж. Аав Петр Витмер нь зөвшөөрсөнд тэрээр мухлаг тэрэг хөллөж, Хармонид (217 километр орчим) хүрч ирэн, Иосеф Смит, эхнэр Эмма, Оливер Каудери нарыг авч, Фейетте рүү буцжээ. Үүнээс хойш удалгүй, Бурхан тэднээр юу хийлгэхийг хүсч байгааг мэдэхийг хүссэн хүү Петр Жон, Давид Витмер нарын хүсэлтээр Сургаал ба Гэрээ 14–16 дахь илчлэлтүүдийг Бошиглогч Иосеф Смит хүлээн авчээ (Витмерүүдийн тухай мэдээллийг бас “Сургаал ба Гэрээн дэх Хүмүүс ба нэр томъёонууд” х.244-аас үз).

Их Эзэн чамаар юу хийлгэхийг хүсдэгийг чи хэзээ нэгэн цагт сонирхож үзсэн үү? Энэ гурван хэсгийг уншихдаа, эл асуултын талаар бодож, дээрх гурван хүнд Их Эзэний өгсөн зөвлөгөө танд бас хамаатайг анхаар.



Давид Витмер



Жон Витмер

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 14:1–7-г ойлгохдоо үүнтэй адил Сургаал ба Гэрээ 11:1–7, 12:1–6-гийн “Судруудыг ойлгох нь” хэсгүүдээс нэмэлт туслалцаа ав.

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээний 14–16-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 14:7

1. Тэмдэглэлийн дэвтрийн хуудасны хэмжээтэй цаасан дээр Сургаал ба Гэрээ 14:7 дахь санаануудыг дүрсэлсэн үзүүлэн хий.
2. Сударт аврал гэдэг нэр томъёо өргөмжлөлд хамгийн олонтаа холбоотой байдаг. Үүнийг санаж, Сургаал ба Гэрээ 14:7-г 2 Нифай 31:20-той харьцуул. Сургаал ба Гэрээ 14:7-д биднийг хийх ёстой гэж Их Эзэний хэлсэн зүйлүүдийг хэрхэн биелүүлж болох талаар 2 Нифай 31:20 юу гэж хэлсэн байна вэ?

Б Таны хамгийн үнэ цэнэтэй зүйл



“Эцсийн эцэст, хамгийн агуу, хамгийн чухал үүрэг бол Сайн мэдээг номлох юм” (History of the Church, 2:478).

1. “Чамд хамгийн үнэ цэнэтэй байж болох тэр зүйл” гэж Их Эзэн юуг Жон Витмер, хүү Петр Витмер нарт хэлсэн бэ? (С ба Г 15:6; 16:6-г үз).
2. Яагаад энэ нь тэдний хийж чадах ямар нэг зүйлээс илүү их үнэ цэнэтэй байсан талаарх доод тал нь хоёр шалтгааныг бич.

Сургаал ба Гэрээ 17 Онцгой гурван гэрчид зориулсан илчлэлт



Сургаал ба Гэрээний 17-р хэсгийн тоймд, хожмын өдрүүдэд уг номыг гарч ирэхэд гурван хүн тусгай гэрч байх болно гэсэн бошиглол гардаг Мормоны Номын гурван эшлэл байдаг. Энэ хэсэг бол тэрхүү гэрчүүд байхаар дүрслэгдсэн сайх гурван хүнд өгөгдсөн илчлэлт юм. Уг илчлэлтэд, тийнхүү тусгай гэрчлэлтэй байхад өөрсдийгөө бэлтгэхийн тулд юу хийх ёстойг тэдэнд хэлжээ. Та уншихдаа Давид Витмер, Мартин Харрис, Оливер Каудери нарт өгсөн Их Эзэний зөвлөгөө нь Мормоны Ном болон бусад сүнсэлэг үнэнүүд үнэн гэдэг гэрчлэлтэй болох эсвэл энэхүү гэрчлэлээ бэхжүүлэхийг эрмэлзэж байгаа үед тантай хэрхэн холбогдож болох талаар бодож үз.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 17

Шидэт зүг чиг заагч (ш. 1) : Ач ивээл (ш.8)—Бурханаас
1)—Лиахона (1 Нифай 16:10, ирдэг хүч чадал, хүч
28–29; Алма 37:38–42-ыг үз) :

Сургаал ба Гэрээ 17—Энэ гурван хүн амлагдсан гэрчлэлийг хэзээ, яаж хүлээж авсан бэ?



Энэ гурван хүний эрмэлзэн хүсч байсан гэрчлэл 17-р хэсэг дэх гэрчлэл өгөгдсөний дараа удалгүй иржээ. Бошиглогч Иосеф Смит, Давид Витмер, Оливер Каудери, Мартин Харрис нар Витмерийнхний гэрийн ойролцоох ой руу очив. Тэнд дөрвөн хүн чин сэтгэлийн залбирлаар дамжуулан амлагдсан гэрчлэлийг эрэлхийлсэн боловч юу ч болсонгүй. Эцэст нь Мартин

Харрис өөрийгөө зохисгүй гэдэгт итгэснээ хэлж, хүлцэл өчив. Тэр ганцаараа уучлал гуйхаар тэндээс холдоход, үлдсэн гурван хүн гайхалтай үзэгдэл хүлээн авч, үзсэн зүйлийг нь гэрчилсэн Бурханы дуу хоолойг сонсчээ. Бошиглогч Иосеф тэгээд Мартин Харрисыг олохоор явав. Бошиглогч түүнтэй залбиралд нэгдэхэд, хэсэгхэн хугацааны дараа, бусад нь өмнө нь хүлээн авсан нөгөөх үзэгдлийг Мартин Харрис хүлээн авчээ. Мормоны Номын өмнөх “Гурван Гэрчийн Гэрчлэл” бол энэхүү болсон үйл явдлыг өгүүлсэн тэдний хүүрнэл юм. Мормоны Номон дахь гэрчлэлийн төлөө энэ гэрчүүд хариуцлага хүлээсний нэгэн адил энэ үеийн хүмүүс энэ гэрчүүдийн гэрчлэлийн төлөө хариуцлага хүлээх болно (2 Нифай 33:11–15; Ифер 12:38–39-ийг үз).



Энэхүү ариун туршлагаас хойш хэдхэн хоногийн дараа, Мормоны Номын ялтсуудыг өөр найман хүнд үзүүлэхийг Бошиглогч Иосефт зөвшөөрчээ. Хэдийгээр тэд үзэгдэл харж, Бурханы дуу хоолойг сонсоогүй ч гэсэн, ялтсуудыг барьж үзсэн аж. Тэдний гэрчлэл бас Мормоны Номын өмнө байдаг.

Сургаал ба Гэрээ 17:1—“Цээжний хуяг нь” юу байсан бэ?

Ялтсуудын хамт Иосефын хүлээж авсан цээжний хуягийг үзэх боломж Бошиглогчийн ээж Люси Мак Смитэд олдсон ажээ (Иосеф Смит-Түүх 1:35-ыг үз). Тэр энэ тухай өөрийнхөө бичсэн хүүгийнхээ намтарт дараах байдлаар дүрсэлжээ:

“Цээжний хуягийг нимгэхэн, бүр хэмжээ хэлбэрийг ямар ч төвөггүйгээр мэдэрч чадахаар тийм нимгэн шаа даавуун алчууранд ороосон байлаа.

“Цээжний хуяг нь нэг талдаа хүнхэр нөгөө талдаа гүдгэр, хүүзүүн талаас доош, өндрөөрөө ердийн нуруутай хүний гэдэсний төв хэсэг хүрсэн урт байлаа. Хуяг нь цээжинд бүслэх зориулалттай мөн шаа даавуугаар хийсэн дөрвөн бүчтэй, хоёрыг нь мөр давуулан арагш нь уядаг, нөгөө хоёрыг нь ташаан толгойноос уяж бэхэлдэг ажээ. Уяаны өргөн нь миний хоёр хурууны хэмжээтэй (уяаг би хэмжиж үзсэн), уяж бэхлэхэд тохиромжтой, үзүүртээ нүхтэй байсан” (*History of Joseph Smith*, хянан тохиолдуулсан Престон Нибли [1958], 111).

Сургаал ба Гэрээ 17:6—Мормоны Номын тухай Их Эзэний гэрчлэл

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Брус Р.МкКонки:



“Хүмүүнд өгсөн хамгийн хүндтэй андгай тангаргуудын нэг нь Иосеф Смит болон Мормоны Номонд холбогдох Их Эзэний дараах үгсэд байдаг. ‘Тэрээр [Иосеф Смитийг хэлж байна] уг номыг, бүр түүнд миний зарлиг болгосон тэрхүү хэсгийг орчуулсан юм, ‘мөн чиний Их Эзэн мөн чиний Бурхан амьдын адил, энэ нь үнэн бөлгөө’ (С ба Г 17:6) гэж Их Эзэн хэлжээ.

“Энэ бол Мормоны Номын тухай Бурханы гэрчлэл юм. Эл гэрчлэлд Бурхан Мормоны Ном үнэнийг нотлохдоо, хэрэв энэ ном үнэн бус аваас Бурхан Бурхан байхаа болино гэсэн утгыг илэрхийлжээ. Бас хүмүүст болон бурхдад мэдэгдсэн үүнээс илүү албан ёсны буюу илүү хүчирхэг ямар ч үг хэллэг байхгүй эсвэл байж ч чадахгүй” хэмээн сургажээ (In Conference Report, 1982 оны 4-р сар, 50; *Ensign*, 1982 оны 5-р сар, 33).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээний 17-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Тэдний гэрчлэл мөн та нарынх

1. Тэмдэглэлийн дэвтэртээ дараах схемийг хий:

Гурван Гэрч	Би
Хүссэн гэрчлэлээ хүлээж авахын тулд тэд юу хийх хэрэгтэй байсан бэ? (С ба Г 17:12-ыг үз).	Мормоны Ном болон бусад сүнслэг үнэнүүдийн тухай гэрчлэлээ бэхжүүлэхийн тулд би юу хийх ёстой вэ?
Тусгай гэрчлэл хүлээж авсны дараа тэд юу хийх ёстой гэж Их Эзэн хэлсэн бэ? (шүлэг 3, 5–6-г үз).	Намайг гэрчлэл хүлээж авсны дараа Их Эзэн надаас юу хүсэн хүлээх вэ?

Тэдэнд уг гэрчлэлийг өгсөн шалтгааныхаа тухай Их Эзэн юу гэж хэлсэн бэ? (шүлэг 4, 8–9-ийг үз).	Түүний сайн мэдээ болон Сүмийн тухай гэрчлэлтэй байхыг Их Эзэн яагаад надаас хүсдэг вэ?
Тэдний гэрчлэлийн ач холбогдлыг үнэлэн, Их Эзэн тэдэнд ямар амлалтууд өгсөн бэ? (шүлэг 7–9-ийг үз)	Гурван Гэрчид өгсөн Их Эзэний амлалтууд сайн мэдээний тухай миний гэрчлэлд хэрхэн холбогдох вэ?

2. Сургаал ба Гэрээний 17-р хэсгээс сурч мэдсэн зүйлээрээ Гурван Гэрчийн тухай асуултуудад хариул.
3. Дээрх судруудыг өөртэйгөө холбогдуулан бусад асуултанд хариул. Асуултуудад хариулахад чинь туслах бусад судруудыг олохын тулд та Судруудын Удирдамжийг бас ашиглаж болно.

Сургаал ба Гэрээ 18

Төлөөлөгчдийн ажил ба бодгалиудын үнэ цэнэ



Сургаал ба Гэрээ 18-р хэсэгт үздэг лэгдсэн илчлэлт Петр, Иаков, Иохан нар Мелкизедек санваарыг Иосеф Смит Оливер Каудери хоёрт олгосонтой ойролцоо үед өгөгджээ. Энэ нь Их Эзэн Есүс Христийн дээрх гурван Төлөөлөгч Иосеф Смит, Оливер Каудери хоёрыг

Төлөөлөгчид байхаар, мөн Түүний нэрийн тусгай гэрчүүд болж, үйлчлэлийн түлхүүрүүдийг авч явахын тулд томилсонтой холбоотой байлаа (С ба Г 27:12–13-ыг үз). Анхны Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга дараагийн зургаан жилд дуудагдаагүй ч гэсэн, Их Эзэн 18-р хэсэгт Төлөөлөгчдийн талаар мөн манай эрин үе дэх Арванхоёрын Чуулгын гишүүдийн талаар зарим зөвлөгөө өгчээ. Та энэ илчлэлтийг уншихдаа, өөрсдийнхөө уншсан сургаал, зарчим бүрийг, мөн Төлөөлөгчдийн үүрэг болон Мелкизедек санваарын тухай ерөнхийд нь авч үз.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 18

Бүү тэмц (ш.20)—Бүү марга, бүү эсэргүүц

Хариуцлага (ш.42)—Хүмүүс ажил хэрэг, үйл ажиллагаагаа өөрсдөө хариуцах

Сургаал ба Гэрээ 18:20—“Чөтгөрийн сүм”

“Чөтгөрийн сүм” гэж аль нэг тусгай Сүмийг хэлдэггүй, харин Есүс Христийн Сүмийн болоод Бурханы хүүхдүүдийн авралын эсрэг тэмцдэг аливаа хүн, бүлэг, байгууллага болон философи юм. Үнэн болон нинжин сэтгэл нь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гадна байж болох нь мэдээжийн хэрэг, гэвч зөвхөн Сэргээгдсэн Сүмд байдаг сайн мэдээний бүрэн байдал нь бидний Тэнгэрлэг Эцэг хүүхдүүдийнхээ төлөө хүсдэг авралын хувьд зайлшгүй шаардлагатай юм. Сургаал ба Гэрээ 18:20-ийн тухай Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит, “Энэ бол зөв шударга ёс болон үнэнийг эсэргүүцэн тэмцдэг хилэнц бүхний эсрэг тэмцэхэд зориулан бидэнд өгсөн заавар гэж бид ойлгох ёстой” (Church History and Modern Revelation, 1:83) гэжээ.

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 18-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А, В-г эсвэл В-г хий.

А Судрын гарамгай мэдлэг—Сургаал ба Гэрээ 18:10, 15–16

Бизнесийн ертөнцөд ямар нэг юмны үнэ нь уг зүйлийн оронд төлөхийг хүсч байгаа үнээр тодорхойлогддог. Ямар нэг зүйлийн үнэ нь төчнөөн мөнгө байна гэж хүн хэлж болно, гэвч өөр нэг хүн тухайн юмны үнэнд мөн ийм хэмжээний мөнгө төлөхөд бэлэн байгаа үед энэ үнэ зөв байдаг.

1. Сургаал ба Гэрээ 18:10–13-ыг судлаад бидний амь, амьдралын төлөө ямар үнэ төлөгдсөнийг, бас энэ үнийг хэн төлснийг тайлбарла.



2. Наманчилдаг хүмүүсийн талаарх Их Эзэний санаа бодлыг ямар үг дүрсэлж байна вэ? Энэ үг Түүний тухай танд юу өгүүлж байна вэ?

3. Сургаал ба Гэрээ 18:14-т, хүмүүст “наманчлалыг тунхаглахыг” Иосеф Смит, Оливер Каудери, Давид Витмер нарт (мөн бидэнд) зарлиг болгожээ. Наманчлахыг хүссэн хүмүүст туслахын тулд та шүлэг 10–13-аас сурч мэдсэн зүйлээсээ тэдэнд юу хэлж болох вэ?

4. Алма 34:14–17-г унш. Наманчлахын өөр нэг чухал учир шалтгаан юу вэ?

5. Алма 37:9-ийг унш. Энэ зүйлүүд үнэн гэдгийг хүмүүс өөрсдөө мэдэх нэг арга зам юу вэ?

Б Түлхүүр үгсийг хай

Сургаал ба Гэрээ 18:9-д Оливер Каудери, Давид Витмер нартай Их Эзэн “зарлигийн замаар” ярьжээ.

1. Шүлэг 9–21-ийг судлаад, юу хийхийг дээрх гурван хүнд зарлиг болгосныг тэмдэглэлийн дэвтэртээ бич. Зарлиг бүрийг тогтооход туслах дараах түлхүүр үгсийг эрж ол: *Бүх хүмүүн, санагтун, наманчлалыг тунхаглах, асуух, хүсэх, тэмцэх, авчрах, ярих.*

2. Дээрх зарлигуудаас гурвыг сонгож, уг зарлигууд тантай хэрхэн холбогдохыг дүрсэл.

В Христийн дуу хоолойг та хэзээ нэгэн цагт сонссон уу?

Хэрэв Их Эзэний дуу хоолойг анхааран сонсож, дуулгавартай дагахгүй бол бид аврагдаж чадахгүй хэмээн судрууд гэрчилдэг (Алма 5:38–39; С ба Г 1:14-ийг үз).


1. Сургаал ба Гэрээ 18:34–36-г судлаад та Их Эзэний дуу хоолойг хэрхэн өдөр бүр “сонсож” болохыг тайлбарла.

2. Шүлэг 24–25-д дүрсэлснээр эцсийн өдөр та ямар нэрээр дуудагдахыг мэдэхэд энэ нь хэрхэн тусалж чадах вэ?



Мормоны Номыг 5,000 хувь хэвлэхийг Палмирагийн хэвлэгч Эгберт Б. Грандинаар зөвшөөрүүлэхийн тулд

Мартин Харрис хэвлэлийн зардлыг төлөх баталгаа өгчээ. Хэвлэгчийн шаардсан 3000 доллараас илүү үнэтэй өмчийг Мартин эзэмшиж байсан учраас тэрээр ийнхүү баталгаа өгч чадсан ажээ. Гэвч хэвлэх ажил дуусахын өмнө “нэлээд олон хүмүүс цуглаан зохион байгуулж, эл номыг хэвлэгдэн гарсан үед нь худалдаж авахгүй байх тогтоол гаргав. Грандиныг бухимдаж эхлэхэд, хэвлэлийн зардлыг төлөх болно гэдгийг түүнд дахин итгүүлэхээр Бошиглогч Иосеф Смит Палмирад эргэж ирсэн аж. Хэрэв Мормоны Ном зарагдахгүй бол фермээ алдаж болзошгүй гэж айсан Мартин Харрис Бошиглогчид хандаж, удирдамж хүсэв. Хувийнхаа өмчид ‘харамч шунаг’ байх ёсгүйг, харин Мормоны Номын хэвлэлийн зардлыг төлөх зорилгоор ‘үүнийг харамгүй хуваалцахыг’ (С ба Г 19:26-г үз) Мартинд илчлэлтээр зарлиг болгожээ. Ноён Грандинд төлбөрийг хийхийн тулд Мартин Харрисын фермийн зуун тавин нэгэн акр газрыг 1831 оны дөрөвдүгээр сард дуудлага худалдаагаар зарсан аж. Энэхүү золиослол Мормоны Номыг хэвлэгдэх боломжтой болгосон юм” (Church History in the Fulness of Times, 65).



Сургаал ба Гэрээ 19-р хэсгийг уншихдаа, энэ илчлэлт Мартин Харрист хэрхэн нөлөөлсөн байж болохыг, мөн түүний хувийн асуудлууд илүү том төлөвлөгөөтэй хэрхэн нийцсэнийг бод. Өнөө үед Их Эзэн танаас хүсэн хүлээдэг хамгийн том золиослол юу вэ? Энэ илчлэлтийг унших үедээ та үүнийг дотроо бодож, Мартин Харрист Их Эзэний заасан зарчмууд одоо болон ирээдүйд танаас Түүний хүсэн хүлээх зүйлүүдэд хэрхэн холбогдохыг авч үз.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 19

Альфа ба Омега (ш. 1)— Грек цагаан толгойн эхний болон сүүлчийн үсэг (Түүний бүх талыг хамарсан мөн чанарыг дүрсэлсэн Есүс Христийн нэг нэр)
Арчин хаях (ш. 15)— Шийтгэх

Шунах (ш.25–26)— Харамлах, сувдаг сэтгэл гаргах
Хуваалцах (ш.26, 34)—Өгөх
Шашны сургаал (ш.31)— Шашны өөр өөр итгэл бишрэл
Ухуул (ш.37)—Заа, урам- шуулан дэмж

Сургаал ба Гэрээ 19:4, 16–17—Наманчлах уу, эсвэл зовох уу?

Алма 42:16, Сургаал ба Гэрээ 19:16–17-гийн талаар, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Даллин Х.Өүкс хэлсэн нь:

“Шийтгэлийг бүхэлд нь Аврагч үүрсэн учраас наманчилдаг хүн ерөөсөө зовох учиргүйг дээрх судрууд заадаг гэсэн үг үү? Энэ нь Аврагчийн бусад сургаалтай нийцэхгүй учраас ийм утгатай байж таарахгүй.

“Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, наманчилдаг хүн, уг нүглийн төлөө ‘бүр’ Аврагчийн зовон шаналсан шиг тийм байдлаар зовж шаналахгүй гэсэн утгатай юм. Наманчилдаг нүгэл үйлдэгчид ямар нэг хэмжээгээр зовлон үзэх болно, гэвч наманчлалынх нь улмаас, мөн Цагаатгалын улмаас, нүглийн төлөө Аврагчийн зовж шаналсан шиг тийм мөнхийн тарчлалын, ‘хүчтэй өвдөлтийг’ тэд биеэр амсахгүй” (*Sins, Crimes, and Atonement* [пашны боловсролынхонд хандаж хэлсэн үг, 1992 оны 2-р сарын 7], 5).

Сургаал ба Гэрээ 19:6–12—Эцэс төгсгөлгүй, мөнхийн шийтгэл

“Эцэс төгсгөлгүй шийтгэл”, “мөнхийн шийтгэл” гэдэг нэр томъёонууд нь урт удаан хугацааны шийтгэл гэхээс илүүтэй шийтгэлийн төрөл болохыг Их Эзэн илчилсэн юм. Эцэс төгсгөлгүй шийтгэл, мөнхийн шийтгэл бол “Бурханы шийтгэл” юм (С ба Г 19:11–12).

“Хүн зарлигуудыг анхаарахгүй удахын хэрээр, аврал түүнд байхгүй болно.

“... Есүс Христийн гүйцэтгэсэн бүх хүмүүний төлөөх аврал нь чөтгөрийг ялахын төлөө байсан юм. ... Христийг дуулгавартай дагах хүртлээ бүх хүмүүс зовлон эдэлнэ” (*Teachings of the Prophet Joseph Smith*, түүвэрлэсэн, Жозеф Фиелдинг Смит [1976], 357) гэж Бошиглогч Иосеф Смит сургасан юм. Тийнхүү Христийг дуулгавартай дагахаас үүрд татгалзсан Мөхлийн хүүгээс бусад бүх хүмүүсийн хувьд шийтгэл эцсийн бүлэгт төгсгөл болно (С ба Г 76:33–44-ийг үз).

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Жеймс И.Талмейж, “тамаас чөлөөлөгдөх нь тэнгэрт орлоо гэсэн үг биш” гэжээ (*The Vitality of Mormonism* [1919], 256). Эцэг төгсгөлгүй буюу мөнхийн шийтгэл-Бурханы шийтгэл, үүнийг хүлээн авсан хүмүүсийн хувьд төгсгөл ирэхэд тэд алдар суугийн хаант улсуудад байраа хүлээн авна. Та Сургаал ба Гэрээ 76-р хэсгийг судлахдаа энэхүү шүүлтүүдийн тухай илүү ихийг мэдэх болно.

Сургаал ба Гэрээ 19:15–19—Есүс Христийн шаналал



Сургаал ба Гэрээ 19:15–19 дэх бүх хүн төрөлхтний төлөөх Түүний зовлон шаналлын тухай Аврагчийн гэрчлэл нь зовлон шаналлыг хувь хүний төвшинд ойлгоход бидэнд тусалдаг. Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Жозеф Фиелдинг Смит хэлэхдээ: “Түүнийг гар, хөлөөр нь загалмайд хадаж орхисноос хойш

амьсгал хураах хүртлээ [Аврагч] асар их зовж шаналсан хэмээн бид бодож заншсан гэж би боддог. Цовдлолтоос үүдсэн өвдөлт хэчнээн хүчтэй байлаа ч гэсэн, энэ бол бие махбодоор амссан түүний хамгийн их зовлон шаналал биш, харин, үүний учрыг би зарим талаар ойлгож чадаагүй ч гэсэн, тэрхүү зовлон шаналал нь тэрээр бүх дэлхийн нүглийг нуруун дээрээ үүрсэн [Гетсеманид] тэр үед байсан гэдгийг би итгэлээр хүлээн зөвшөөрдөг, үүнийг та итгэлээр хүлээн зөвшөөрөх ёстой. Өөрийнхөө нүглийг үүрнэ гэдэг нь миний хувьд их хэцүү юм. . . . Гэтэл Тэрээр бүх дэлхийн нүглийг үүрэх ёстой байсан шүү дээ” гэжээ (In Conference Report, 1947 оны 10-р сар, 147–148).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 19-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А “Надаас сур”

Бид амар амгалан байж болохын тулд Өөрөөсөө сурахад Аврагч биднийг урьсан билээ (С ба Г 19:23; Матай 11:29-ийг үз). Сургаал ба Гэрээ 19-р хэсгээс Есүс Христийн тухай мэдсэн зүйлээ тэмдэглэлийн дэвтэртээ бич. Түүнийг дүрсэлсэн үг, өгүүлбэрүүдийг эрж олон Түүний хэлсэн, хийсэн зүйлүүдийг, бас яагаад гэдгийг ажигла. Мөн бидэнд заадаг, бидэнтэй харьцдаг Түүний арга замын талаар юу мэдсэнээ авч үз.

Б Судрын гарамгай мэдлэг—Сургаал ба Гэрээ 19:16–19

1. Чухал гэж өөрийнхөө бодсон гурван үгийг Сургаал ба Гэрээ 19:16–19-өөс сонгож, үг тус бүрийг яагаад сонгосноо тайлбарла.
2. Есүс юуг тэвчсэн, мөн яагаад үүнийг тэвчсэнийг Сургаал ба Гэрээ 19:16–19, 1Нифай 19:9; 2 Нифай 9:21–22; Мозая 3:7–9; 3 Нифай 27:14–15-аас сурч мэдсэн зүйлээрээ тайлбарла.
3. Сургаал ба Гэрээ 19:16–19 болон энэ үйл ажиллагааны бусад судруудыг судлах үед төрсөн санаануудаас заримыг нь тэмдэглэлийн дэвтэртээ бич.

В Зарлигууд болон тайтгарлыг ол

Мартин Харрис удирдамж авахаар Иосеф Смит рүү очиход, Бошиглогч түүнд зориулсан энэ илчлэлтийг хүлээн авчээ (энэ гарын авлагын С ба Г 19-р хэсгийн оршлыг үз).

1. Тэмдэглэлийн дэвтэртээ хоёр багана хий. Нэгийг нь “Зарлигууд,” нөгөөг нь “Тайтгарал” гэж гарчигла.
2. Сургаал ба Гэрээ 19-р хэсгийг нэгтгэн дүгнэж, тайтгарлын тухай зарлигууд болон үгсийг ол. Тэдгээрийг холбогдох багануудад жагсаан бич.
3. Тайтгарлын тухай өөрт чинь гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн нэг зарлиг, нэг хэллэгийг сонгож, эдгээр нь яагаад өөрт чинь гүнзгий сэтгэгдэл төрүүлснийг хэл.

Сургаал ба Гэрээ 20

Сүмийн Үндсэн хууль

1820 онд Эцэг Хүү хоёр Бошиглогч Йосеф Смит дээр хүрч ирэхэд, аль ч Сүмд нэгдэхгүй байхыг түүнд хэлж, “Сайн мэдээний бүрэн байдлыг ирээдүйд нэгэн цагт [түүнд] мэдүүлэх болно гэсэн амлалтыг” (History of the Church, 4:536) өгчээ. Тэрээр Мормоны Номыг олж аван орчуулж, Аароны болон Мелкизедек санвааруудын эрх мэдэл, түлхүүрүүдийг хүлээн авахад, түүнчлэн хожмын өдрүүд дэх Бурханы хаант улсад хамаарах бусад зааврууд өгөгдсөн үед Сайн мэдээний бүрэн байдал таниулагдаж эхэлсэн юм.

Сургаал ба Гэрээ 20 нь анх “Христийн Сүмийн Тунхагууд ба Гэрээнүүд” гэж нэрлэгдэн, Сүмийг зохион байгуулах болон удирдах гарын авлага болон хэрэглэгдэж байв. Энэ хэсгийг 22-р хэсгийн хамт Сүмийн цуглаанууд дээр бүтнээр нь олонтаа уншиж өгдөг байсан аж. Энэ хэсгийг заримдаа “Сүмийн Үндсэн хууль” гэдэг.



Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 20

Үзүүлэгдсэн (ш.5)—
Таниулагдсан, таниулсан, мэдүүлсэн
Ангижрал (шүлэг 5, 37)—
Уучлал
Хоосон зүйлүүд (ш.5)—
Мунхаг зүйлүүд
Хүсэл тачаангуй (ш. 20)—
Ихэвчлэн бие махбодын сэрэл, таашаал
Голч (ш.26)—Дээд цэг

Харууссан зүрх (ш. 37)—
Өнгөрсөн нүглийнхээ (хэн үүнийг үлдсэн нь хамаагүй) төлөө бүрэн харамсдаг даруухан зүрх сэтгэл
Гэмшсэн сэтгэл (ш. 37)—
Бурханыг дуулгавартай дагах хүсэл
Алдас (ш. 54)—Нүгэл, ёс бус, бусармаг явдал


Сургаал ба Гэрээ 20:1—Яагаад дөрөвдүгээр сарын зургаанд?



1830 оны дөрөвдүгээр сарын 6-ныг Их Эзэн Өөрийн Сүмийг албан ёсоор зохион байгуулах өдөр болгон өгчээ. Ерөнхийлөгч Харольд Б.Лий энэ өдрийн ач холбогдлын тухай: “1973 оны дөрөвдүгээр сарын 6 бол зөвхөн Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг энэ эрин үед зохион байгуулсны ойн өдөр төдийгүй, бас Аврагч, бидний Их Эзэн, Есүс Христийн төрсөн өдрийг тэмдэглэж байгаа учраас энэ өдөр онцгой чухал тэмдэглэлт өдөр юм” гэжээ (In Conference Report, 1973 оны 4-р сар, 4; Ensign, 1973 оны 7-р сар, 2).

Сургаал ба Гэрээ 20:9—Мормоны Ном “Сайн мэдээний бүрэн байдлыг” агуулдаг

Мормоны Ном сайн мэдээний бүрэн байдлыг агуулдаг гэж Их Эзэн хэлсэн нь: “Энэ ном өмнө нь илчлэгдсэн бүх сургаамж, сургаалыг агуулдаг гэсэн үг биш. Харин, бид өөрсдийнхөө авралд шаардлагатай сургаалуудын бүрэн байдлыг Мормоны Номоос олно гэсэн үг юм. Түүнчлэн аврал, өргөмжлөлийн арга замуудыг бүр хүүхдүүд ч гэсэн ойлгохоор сургаалуудыг тийм тодорхой, энгийн байдлаар заадаг” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлжээ (In Conference Report, 1986 оны 10-р сар, 4; Ensign, 1986 оны 11-р сар, 6).



Тэд судруудыг болон судруудын үнэнийг гэрчилдэг хүмүүсийг хэрхэн хүлээж авснаараа дэлхий шүүгдэх болно (С ба Г 20:8–15-ыг үз).

Сургаал ба Гэрээ 20:27–28—Эцэг, Хүү, Ариун Сүнс гурав бол “нэг Бурхан”

Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христ, Ариун Сүнс гурав бол тусдаа гурван хүн юм. Тэд бол нэг Бурхан гэж судрууд сургадаг нь Бурхан тэргүүтний гишүүдийн эв нэгдлийг харуулдаг. Зорилго болон сургаалын хувьд тэд эв нэгдэлтэй учраас бие биенийхээ өмнөөс ярьж, бие биенийхээ тухай гэрчилж чадна.

Сургаал ба Гэрээ 20:38–60—Энд дурдаагүй Сүмийн албан тушаалуудын тухайд?

“Сүмийг зохион байгуулахад удирдлагад нь” (Church History and Modern Revelation, 1:95) шаардлагатай байсан зүйлийг л зөвхөн Их Эзэн Сургаал ба Гэрээ 20-р хэсэгт илчилснийг Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит заажээ. Сүм өсөн хөгжих үед нэмэгдсэн бусад албан тушаалууд мөн дээрх илчлэлтэд дурдсан албан тушаалуудын тухай илүү ихийг бид хожмын илчлэлтүүдээс мэддэг билээ. Сүмийн гишүүнчлэлийн өсөн нэмэгдсээр байгаа хэрэгцээг хангахын тулд Их Эзэн Сүмдээ ажил үүрэг, албан тушаалуудыг нэмж бий болгон, улам боловсронгуй болгосоор байна, энэ нь цаашид үргэлжлэх болно (Итгэлийн Тунхаг 1:9-ийг үз).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 20-р хэсгийг судлахдаа (А–Е) дэх үйл ажиллагаануудаас гурвыг хий.

А Мормоны Номын ач холбогдол

“Сүмийн Үндсэн хууль”-Сургаал ба Гэрээ 20-р хэсэгт Мормоны Номын ач холбогдлын тухай өгүүлсэн нь тохиолдлын зүйл бус. Бошиглогч Иосеф Смит: “Мормоны Ном болон илчлэлтүүдийг авчихвал, манай шашинд юу үлдэх вэ? Бидэнд юу ч үлдэхгүй” гэжээ (Teachings of the Prophet Joseph Smith, 71).

1. Сургаал ба Гэрээ 20:8–16-гаас Мормоны Номын тухай юу мэдсэнээ жагсаан бич.
2. Шүлэг 17–36-гаас Мормоны Ном байгаа учраас “бидний мэддэг” сургаалуудыг жагсаан бич. Энэ сургаалуудаас нэгийг нь сонгож, уг сургаал өөрт чинь яагаад чухал болохыг тайлбарла.

Б Үнэн сургаалын ач холбогдол

“Үнэн сургаал нь ойлгогддог, санаа бодол, зан төлвийг өөрчилдөг” (In Conference Report, 1986 оны 10-р сар, 20; Ensign, 1986 оны 11-р сар, 17) гэж Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Байд К.Пакер сургажээ. Сургаал ба Гэрээ 20:17–36 нь сэргээгдсэн Сүмийн тулгуур сургаалуудыг жагсаан бичсэн юм. Энэ сургаалуудаас хоёрыг сонгож, хэрэв хүмүүс сургаалуудыг ойлгох юм бол, сургаал бүр нь тэдний амьдралыг дээшлүүлэхэд яагаад хүчтэй нөлөө үзүүлж болохыг тайлбарла.

В Баптисмын өмнөх ярилцлага

1. Сургаал ба Гэрээ 20:37 дээр үндэслэн баптисм хүртэхийг хүсч буй хэн нэгнээс асууж болох асуултуудыг жагсаан бич. Сүм болон судруудын талаар шинэ хөрвөгчид ихэвчлэн туршлага дутмаг байдгийг сана. Иймээс уг хүн ярьж байгаа зүйлийг чинь ойлгохоор бодож асуултуудыг бич.
2. Мозая 18:8–10, Моронай 6:1–6-г уншиж, тохиромжтой байж болох бусад асуултуудыг нэм.

Г Схем хий

1. Сургаал ба Гэрээ 20:38–60 нь Сүм дэх янз бүрийн албан тушаал, дуудлагуудын үүргийг тодорхойлдог. Дараахтай адил схемийг тэмдэглэлийн дэвтэртээ хийж, эдгээр шүлгүүдээс олж авсан мэдээллээр үүнийг бөглө.

Албан тушаал уу? дуудлага уу?	Үүрэг ба хариуцлага

2. Схемдээ жагсаан бичсан зүйлүүдээс та юу ойлгов?

Д Асуулт хариулт бич

Сургаал ба Гэрээ 20:61–84 нь Сүмийн гишүүдийн үүрэг ба хариуцлагын тухай заадаг.

1. Эдгээр шүлгүүдэд зааж байгаа чухал зарчмуудын тухай 7–10 асуулт хариулт бич. Асуулт бүрийн дараа хариултыг, мөн уг шүлэг болон хариулт нь хаана байгааг бич.
2. (Сонголтоор хий) Асуултынхаа хариултгүй нэг хувийг гэр бүлийнхээ аль нэг гишүүн эсвэл ангийнхаа нэг оюутанд өг. Буруу хариулсан асуултуудыг тайлбарлах чадвартай бай.

Е Хүүхдүүдэд заа

Тойргийнхоо буюу салбарынхаа Хүүхдийн Хэсэгт ариун ёслолын тухай богинохон хичээл зааж өгөхийг чамаас хүсчээ гэж бод. Сургаал ба Гэрээ 20:77, 79 дэх ариун ёслолын залбирлуудыг илүү сайн ойлгоход нь тэдэнд туслахын тулд юу заахаа бич. Бас тэд ариун ёслолыг хэрхэн илүү утга учиртай туршлага болгож болох тухай бич. Хэрэв тохиромжтой бол ариун ёслолын талаарх утга учиртай туршлагаа гэрчлэлийнхээ нэг хэсэг болгон хуваалц. Эцэг эх, багшдаа үзүүлж, зөвлөгөөг нь авсны дараа, та энэ хичээлийг Хүүхдийн Хэсэгт сайн дураараа заахыг хүсч болно.

Сургаал ба Гэрээ 21

Бурхан минь, Бошиглогч илгээсэн Танд талархъя!

Сүмийг зохион байгуулах ёстой өдрийн талаар хүлээн авсан илчлэлийг Бошиглогч Иосеф Смит дуулгавартай дагаснаар (С ба Г 20-р хэсгийн тойм болон шүлэг 1-ийг үз), сонирхсон бүх хүмүүс 1830 оны дөрөвдүгээр сарын 6-нд Витмерийн гэрт цуглажээ. Тухайн үеийн төр засгийн хуулиар шашны шинэ нийгэмлэг зохион байгуулахад наад тал нь гурван хүн, гэхдээ есөөс илүүгүй хүн оролцсон байх шаардлагатай байлаа. Тэнд бусад олон хүмүүс байсан ч гэсэн, оролцсон зургаан хүн нь хүү Иосеф Смит, Оливер Каудери, Хайрум Смит, Самуел Смит, хүү Петр Витмер, Давид Витмер нар байжээ.



Цуглаан дээр юу болсон тухай товч тойм Сургаал ба Гэрээ 21-р хэсгийн тоймд байдаг. Цуглааны үеэр Бошиглогч Сургаал ба Гэрээ 21 дэх илчлэлийг хүлээн авчээ.

Нийтэд дэлгэрсэн Сүмийн нэгэн дуулалд: “Бурхан минь, Бошиглогч илгээсэн Танд талархъя” (Сүмийн дуулал болон хүүхдийн

дуу, х. 19) хэмээн бид дуулдаг. Бид яагаад талархдаг юм бэ? 21-р хэсэг нь талархах учиртай хэдэн онцгой чухал шалтгааныг чухал зөвлөмжийн хамт бидэнд өгдөг.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 21

Үзмэрч (ш. 1)—Өнгөрсөн, : дэг хүн (Мозая 8:13–17;
одоо, ирээдүйн юмсыг мэд- : Мосе 6:35–36-г үз)

Сургаал ба Гэрээ 21:5–6—Бошиглогчийг дагаснаас ирдэг адислалууд

Ерөнхийлөгч Харольд Б.Лий хэлсэн нь:

“Их Эзэний ирэлтийн үүд хаалга болох эцсийн энэ эрин үед энэ Сүм болон дэлхийгээр дамжин Их Эзэнийг хүлээн очиход зарим чанга хатуу газар байдаг. Их Эзэнийг хүлээн авахад бэлэн болоход хүмүүсийг бэлтгэхийн тулд сайн мэдээ сэргээгдсэн юм. Сатаны хүч нэмэгдэх болно. Үүний нотолгоог бид юм бүхэн дээр харж байна. . .

“Эдүгээ энэ Сүмийн гишүүд бидний цорын ганц аюулгүй байдал бол Сүм зохион байгуулагдсан өдөр Сүмд хандан Их Эзэний хэлсэн зүйлүүдийг ширхэгчлэн биелүүлэх явдал мөн. Бошиглогчдоо Их Эзэний өгдөг үгс болон зарлигуудыг бид анхаарлынхаа төвд байлгаж сурах ёстой. . . . Сүмийн эрх мэдэлтнээс ирэх зүйлс танд таалагдахгүй байж болно. Энэ нь таны улс төр, нийгмийн үзэл бодолтой нийцэхгүй байж болно. Энэ нь таны нийгмийн амьдралын зарим талд саад болж мэднэ. . .



“. . . Их Эзэн Өөрийн Сүмийг удирдуулахаар тавьсан хүмүүсийг бид дагах уу, үгүй юү гэдгээс та бидний аюулгүй байдал хамаарна. Энэ Сүмийг ямар хүнээр удирдуулахаа Гэрээр мэддэг, иймээс тэр хүн алдаа гаргахгүй байх болно. . . .

“Сүмийн Ерөнхийлөгчийг дуулгавартай дагацгаа” (In Conference

Report, 1970 оны 10-р сар, 152–153).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 21-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А, эсвэл Б-г хий.

А Бошиглогчийн үүргийг дүрсэл

Бошиглогч Иосеф Смитийн тухай нэг өгүүллийг та хамтран сонинд тавих гэж байна гэж төсөөлөн бод. Сүм дэх Иосеф Смитийн үүргийг дүрслэхийг эрхлэгч тань хүсчээ. Сургаал ба Гэрээ 21:1-ийн тоймуудад дурдсан Их Эзэний таван нэрийг ашиглан нэр тус бүр нь юу гэсэн утгатайг, тэрчлэн Бошиглогч үүргээ биелүүлж байсан арга замуудыг дүрсэл. Энэ нэр томъёонуудын заримыг нь тодорхойлоход тусалцаа авахын тулд та Судруудын Удирдамжийг ашиглах хэрэгтэй болж мэднэ. Эл нэрүүд өнөөдөр амьд бошиглогчид хамаарна.

Б Яагаад Бошиглогчийг дагах ёстой вэ?

Сургаал ба Гэрээ 21:4–9-т Их Эзэн Сүмд өгсөн зөвлөгөөнөөс дараах асуултуудад хариул:

1. Бошиглогчийн ямар үгсийг хүлээн авахыг бидэнд зарлиг болгосон бэ? (шүлэг 4–5-ыг үз).
2. Та амьд бошиглогчийн үгсийг олж авч болох наад тал нь гурван газрыг жагсаан бич.
3. Бошиглогчийг дагахын тулд заримдаа яагаад “тэвчээр, итгэл” (ш. 5) шаардлагатай гэж та боддог вэ?
4. Чи өөрөө, эсвэл өөрийн чинь таньдаг хэн нэгэн Бошиглогчийн сургаалуудыг уншсанаас эсвэл тэдгээрийг дагаснаас шүлэг 6-д өгүүлсэн адислалуудын нэгийг хүлээн авсан тухай жишээ гарга.

Сургаал ба Гэрээ 22

Баптисм хүртээхийн тулд
эрх мэдэл шаардлагатай



Бурхан биднийг хүлээн авахын тулд ердөө л баптисмын ёслолыг гүйцэтгэх шаардлагатай гэдэгт зарим хүмүүс итгэдэг. Гэтэл “Бурханаас дуудагдсан, Есүс Христээс эрх мэдэл авсан хүн” (С ба Г 20:73) баптисмыг гүйцэтгэхийг Их Эзэн шаарддаг. Та Сургаал ба Гэрээ 22-р хэсгийг уншихдаа, юуны учир Их Эзэн санваарын энэхүү эрх мэдлийг Өөрөө олгосон хүмүүсийн гүйцэтгэсэн баптисмуудыг л хүлээн авах ёстойг эрж ол.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 21

Сургаал ба Гэрээ 22:2—“Мосегийн Хууль” ба “Үхмэл ажлууд”

Мосегийн Хууль нь бошиглогч Мосегоор дамжуулан Израилын хүүхдүүдэд илчилсэн ёслолуудын систем юм (Судруудын Удирдамж, “Мосегийн хууль,” х.133-ыг үз). Энэхүү “хуучин гэрээ” (С ба Г 22:1) Есүс Христийн Цагаатгалаар дуусгавар болжээ (3 Нифай 15:3-9-ийг үз).

Зохих ёсоор гүйцэтгэсэн баптисм нь Бурхан, хувь хүн хоёрын хооронд “шинэ бөгөөд үүрдийн гэрээг” (С ба Г 22:1; мөн С ба Г 20:37-г үз) байгуулдаг. Эрх мэдэлгүйгээр гүйцэтгэсэн баптисм бол “үхмэл ажил” юм. Учир нь ийм баптисмаар гэрээ хийгддэггүй.

Судруудыг судлах нь




Сургаал ба Гэрээ 22-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Сургаалыг тайлбарла

Сүмийн гишүүн болохыг сонирхдог боловч, өөр Сүмд өмнө нь баптисм хүртсэн учраас яагаад дахин баптисм хүртэх шаардлагатайг ойлгохгүй байгаа нэг найз өөрт чинь байдаг гэж бод. Сургаал ба Гэрээ 22-р хэсгээс (мөн С ба Г 20:37, 72-74-ийг үз) сурч мэдсэн зүйлээ ашиглан, сэргээгдсэн санваарын эрх мэдэлтэй хүн баптисм хүртээхийг яагаад Их Эзэн шаарддагийг ойлгоход нь найздаа туслахын тулд юу хэлж болохыг бич.

Сургаал ба Гэрээ 23

“Зэмлэл дор орших нь үгүй”



Оливер Каудери



Хайрум Смит



Самуел Смит



Эцэг Иосеф Смит



Эцэг Жозеф Найт

Сүмийн түүхийн энэхүү эхэн үед, юу хийх ёстой талаараа хувийн илчлэлт хүлээн авах гэж таван ах Бошиглогч Иосеф Смит руу очжээ. Тэдний хүн нэг бүрд өгөгдсөн зөвлөгөөнд адил төстэй зүйлүүд байдаг ч, нэлээд хэдэн чухал ялгаа байгааг анхааралтай ажигла.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 23

Зэмлэл (ш.1, 3-5)—Гэм
бурууг нь хэлэх

Ухуулга (ш.3)—Номлох,
урамшуулан дэмжих
Илэрхийлэх (ш.6)—Илчлэх

Сургаал ба Гэрээ 23:1—“Оливер, . . . бардамналаас болгоомжил”

Сургаал ба Гэрээ 23:1-д Оливер Каудерид Их Эзэний өгсөн зөвлөгөөг уншаад, Тэргүүн Зөвлөлийн зөвлөх, Ерөнхийлөгч Жеймс И.Фауст хэлсэн нь:

“Оливер оюун билгийн болон сүнсний гайхалтай адисла-луудтай байлаа. Гэвч цаг хугацаа өнгөрөх тусам тэрээр Их Эзэний сэрэмжлүүлгийг умартаж, бардамнал зүрх сэтгэлд нь нэвтэрсэн байлаа. Бригам Янг хожим нь эл бардамна-лын тухай хэлсэн нь:

“Энэ хаант улсад нэгэн цагт харьяалагддаг байсан, бас хаант улсад тэд л нэгдэн нийлээгүй бол хаант улс өсч хөг-жиж чадахгүй байсан гэж үнэхээр боддог байсан хүмүүстэй

би уулзсан. Өөртөө итгэх итгэл болон . . . ерөнхий чадварын хувьд ер бусын авьяаслаг нэг хүн байлаа. Би одоо тэр хүний тухай бодож байна. Хэрэв тэр хүн хаант улсыг орхих юм бол хаант улс цаашид өсч хөгжиж чадахгүй гэж Бошиглогч Иосефт олон удаа хэлсэн гэдэг. Би Оливер Каудерийн тухай ярьж байна л даа. Тэрээр хаант улсыг орхисон ч, хаант улс үргэлж өсч дэвжин, дайсны эсэргүүцэл бүрийг ялж, өөртөө нэгдэн нийлсэн бүх хүмүүсийг аюулгүйгээр авч явсан юм” (in *Journal of Discourses*, 11:252)” (In Conference Report, 1996 оны 4-р сар, 4; *Ensign*, 1996 оны 5-р сар, 5–6).

Оливер Каудери Сүмийг орхисноос хойш арван жилийн дараа эргэж ирэн, дахин баптисм хүртсэн боловч, хэрэв итгэлтэй хэвээр байсан бол түүнд байж болохоор байсан адислалуудаа нэгэнт алдсан байв (“Сургаал ба Гэрээн дэх Хүмүүс ба нэр томъёнууд,” х. 244)-ыг үз.

Сургаал ба Гэрээ 23:6—“Загалмайгаа үүр” гэсэн нь юу гэсэн үг вэ?

“Загалмайгаа үүрэх хүний хувьд, бүхий л бурханлиг бус явдлыг, түүнчлэн дэлхийн тачаангуй сэтгэлийг өөртөө үгүйсгэж, тэгээд миний зарлигуудыг сахиж ёстой” гэж Их Эзэн хэлжээ (ИСО, Матай 16:26).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 23-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Заавруудыг харьцуул

Сургаал ба Гэрээ 23-р хэсгийг нэгтгэн дүгнэж, дараах асуултуудад хариул:

1. Бардамналын эсрэг хэнийг сэрэмжлүүлсэн бэ?
2. Оливер Каудерийн зүрх сэтгэл Хайрум Смитийнхээ ямар ялгаатай байсан бэ?
3. Уг илчлэлтэд дурдсан таван хүнээс ганцхан эцэг Жозеф Найт л баптисм хүртээгүй байв. Бусдад хэлээгүй юуг Их Эзэн түүнд хэлсэн бэ? Жозеф Найтад хэлээгүй юуг Их Эзэн бусдад нь хэлсэн бэ?
4. “Хөдөлмөрлөгчийн шагнал” (ш. 7) гэж юу вэ? (С ба Г 4:2–4-ийг үз).



Сургаал ба Гэрээ 24 Сүмийн удирдагчдын үүргүүд

1830 оны долдугаар сард Сүмийн салбар ердөө гуравхан байсан нь: Манчестер, Фейетте, Колесвиллийн салбар юм. Дайснууд нь хуурамч хэрэг тулгасны учир Бошиглогч Иосеф Смит Колесвиллд баривчлагдав. Тэрээр гэм буруугүй байсан ч, Сүмийн удирдагчдад саад бэрхшээл учруулахын тулд мөрдлөг хавчлага

үргэлжилсээр байв. С ба Г 24-р хэсгийг уншихдаа Сүмийн гишүүдийн төлөө Иосеф Смит, Оливер Каудери хоёр юу хийх ёстой байсан талаар, мөн удирдагчдынхаа төлөө Сүмийн гишүүд юу хийх ёстой байсан талаар Их Эзэний хэлсэн зүйлүүдийг эрж ол.



Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 24

Бүрэн дуу мэт (ш. 12)— Арчигдах (ш. 16)—
Зоригтой, тодорхой Шийтгэгдэх

Сургаал ба Гэрээ 24:3, 9—“Албан тушаалаа эрхэмлэн биелүүл”

“Дуудлагаа эрхэмлэн биелүүлэх гэж юу гэсэн үг вэ? Энэ бол дуудлагын ач холбогдлыг өндөрт өргөж, дуудлагаа бүх хүмүүсийн нүдэнд хүндэтгэлтэй, сайшаалтай болгож бэхжүүлэн, тэнгэрийн гэрлээр бусад хүмүүсийг гийгүүлэх явдал мөн. Хүн дуудлагыг хэрхэн эрхэмлэн биелүүлдэг вэ? Энгийнээр өгүүлбэл, дуудлагад хамаарах үйлчлэлийг гүйцэтгэснээр Ахлагч хүн Ахлагчийн үүргүүд юу болохыг сурч мэдсэнээр, улмаар үүргүүдээ биелүүлснээр өөрийнхөө томилогдсон Ахлагчийн дуудлагыг эрхэмлэн биелүүлдэг. Ахлагчийн хувьд ийм байдаг бол, дикон, багш, санваартан, санваарын албан тушаал хашдаг хүн бүрийн хувьд мөн адил юм” гэж Тэргүүн Зөвлөлийн зөвлөх, Ерөнхийлөгч Томас С.Монсон хэлжээ (In Conference Report, 1986 оны 4-р сар, 49; *Ensign*, 1986 оны 5-р сар, 38–39).

Сургаал ба Гэрээ 24:15—“Хөлийнхөө тоосыг гүвэх нь”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Жеймс И.Талмейж сургахдаа: “Өөр хэн нэгний эсрэг гэрчлэл болгон хөлийнхөө тоосыг гүвэх ёслолыг иудейчүүд нөхөрлөлийг тасалж, үүнээс үүдэн гарч болох үр дагавруудын хариуцлагыг хүлээхгүйн бэлгэдэл болгон ойлгодог байжээ. “Хөлийнхөө тоосыг гүвэх” нь Их Эзэнээс Төлөөлөгчдөдөө өгсөн заавруудаар буруутгалын

ёслол ба гэрчлэл болсон ажээ. Энэ эрин үед зохих эрх мэдлээр толилуулагдсан үнэнийг санаатайгаар эсвэл хор уршигтайгаар эсэргүүцдэг хүмүүсийн эсрэг гэрчлэхийн тулд эрх мэдэл олгогдсон Өөрийн үйлчлэгчдийг Их Эзэн ийм байдлаар удирдан чиглүүлдэг (С ба Г 24:15; 60:15; 75:20; 84:92; 99:4-ийг үз). Буруутгалын энэ бэлгэдлээр Их Эзэний өмнө гэрчлэх хариуцлагыг гагцхүү ер бусын онцгой нөхцөлд, Их Эзэний Сүнс удирдан чиглүүлсний дагуу хэрэглэдэг” гэжээ (Jesus the Christ [1962], 320).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 24-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-г хий.

А Бошиглогчийн үүргүүд

1. Тэмдэглэлийн дэвтэртээ хоёр багана хий. Нэгийг нь “Бошиглогч”, нөгөөг нь “Гишүүд” гэж гарчигла. Сургаал ба Гэрээ 24:5–9-өөс сурч мэдсэн зүйлээсээ бошиглогчийн болон гишүүдийн үүргүүдийг холбогдох багануудад жагсаан бич.
2. “Бошиглогч” гэсэн жагсаалтын төгсгөлд эдгээр үүргүүдээ биелүүлэхийн тулд бошиглогч өнөө үед юу хийдгийг тайлбарла. “Гишүүд” гэсэн жагсаалтын дор та үүргээ биелүүлэхийн тулд юу хийдгээ тайлбарла.

Б Их Эзэний зөвлөгөөг нэгтгэн дүгнэ

Сургаал ба Гэрээ 24-р хэсэг дэх Их Эзэний зөвлөгөөг нэгтгэн дүгнэ:

1. Иосеф Смитэд өгсөн зөвлөгөө (шүлэг 1–9-ийг үз).
2. Оливер Каудерид өгсөн зөвлөгөө (шүлэг 10–12-ыг үз).
3. Гайхамшгуудын талаарх зөвлөгөө (шүлэг 13–14-ийг үз).

Сургаал ба Гэрээ 25 Эмма Смит-сонгогдсон эмэгтэй



Лиз Лемон Свиндл

Сургаал ба Гэрээ 25-р хэсэг дэх илчлэлтийг хүлээн авсан үед Бошиглогч Иосеф Смит Эмматай гэрлээд гурван жил болж байв. 1827–1830 оны энэ гурван жил олон хурц үйл явдал, сорилтоор дүүрэн байлаа. Гэвч Эмма Смит нөхрийнхөө дэргэд байж, нөхрөө итгэлтэйгээр

дэмжиж байв. Арван хоёр жилийн дараа 1842 оны гуравдугаар сарын 17-нд Эмма Смит Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчөөр дуудагдахад

энэхүү илчлэлтийн нэг хэсэг биелэгджээ (History of the Church, 4:552–553-ыг үз).

Эмэгтэйчүүдийн ерөнхий цуглаан дээр Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли: “Миний мэдэхээр энэ бол гагцхүү эмэгтэй хүнд тусгайлан өгөгдсөн илчлэлт бөгөөд төгсгөлд нь Их Эзэн, “Энэ бол бүгдэд хандсан миний дуу хоолой болой” (С ба Г 25:16) гэж хэлсэн байдаг. Тиймээс энэ тохиолдолд Их Эзэний өгсөн зөвлөгөө та бүгдэд хамаатай юм” гэжээ (In Conference Report, 1984 оны 10-р сар, 109; Ensign, 1984 оны 11-р сар, 90).

Сүм зохион байгуулагдсанаас гурван сарын дараа “намайг баярлуулах . . . ариун дууллаудын түүвэр хийлгэхээр” (С ба Г 25:11) Их Эзэн Эмма Смитийг дууджээ. Түүний эмхтгэсэн дууллын ном 1835 онд хэвлэгдсэн аж. Тэр цагаас хойш Хожмын үеийн сүмийн дууллын ном болсоор ирсэн эл ном Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн бичсэн нэлээд дууллыг агуулдаг. Зарим дууллыг нь бусад Сүмүүд ашигладаг байна.



Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 25

Сургаал ба Гэрээ 25:7-Эмма “томилогдсон” гэдэг нь юу гэсэн үг вэ?

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит тайлбарлахдаа: “‘Томилох’ гэдэг нэр томъёог Сүмийн эхэн үед томилолт, онцгойлон адислалт хоёуланд нь үгийн утгаар нь холбогдуулан хэрэглэдэг байжээ. Санваар эзэмшсэн эрэгтэйчүүдийг, салбаруудыг тэргүүлж, тусгай ажил гүйцэтгүүлэхээр ‘томилогдсон’ хэмээн ярьдаг байж. Эгч нарыг бас зарим тусгай ажил үүрэгт дуудагдахад нь тэднийг ‘томилогдсон’ гэж хэлдэг байж. Томилох, онцгойлон адислахын хоорондох ялгааг бид хожмын жилүүдэд бий болгосон юм. Эрэгтэйчүүд санваарын албан тушаалуудад томилгодож, гадас, тойрог, салбар, номлол, хавсралт байгууллагуудыг тэргүүлэхээр онцгойлон адислагддаг. Эгч нар хавсралт байгууллагуудын ерөнхийлөгчөөр, эсвэл номлолуудад гэх мэт, онцгойлон адислагдахаас биш, томилогддоггүй. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, Эмма Смит судрыг тайлбарлахаар ‘томилогдсон’ гэдэг нь түүнд санваар олгосон гэсэн үг биш, харин тэрээр Сүмийн Нийгмийн Халамжийн Бүлэгт хэрэгжүүлэх энэ дуудлагад онцгойлон адислагдсан гэсэн үг юм” гэжээ (Church History and Modern Revelation, 1:126).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 25-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Зарлигууд ба амлалтууд

1. Тэмдэглэлийн дэвтэртээ хоёр багана хий. Нэгийг нь “Зарлигууд болон дуудлагууд,” нөгөөг нь “Адислалууд болон амлалтууд” гэж гарчигла. Сургаал ба Гэрээ 25-р хэсгийг судалж, Эмма Смитэд Их Эзэний хэлсэн зүйлүүдийг холбогдох багануудад жагсаан бич.
2. Мөн тантай холбогдож болох зарлигуудаас ба адислалуудаас нэгийг сонгож, уг зарлигийг та хэрхэн сахидгаа, мөн эл адислалд та яагаад дуртай байдгаа дүрсэл.

Б Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 25:12

Сургаал ба Гэрээ 25:12-ыг уншиж, дараах асуултуудад хариул:

1. “Зүрх сэтгэлийн дуун” гэж Их Эзэн юуг хэлсэн гэж та боддог вэ?
2. Зөв шударга хөгжим хэрхэн залбиралтай адилхан байдаг вэ?
3. Их Эзэн ямар төрлийн хөгжимд “баясдаггүй” вэ? Та юу гэж бодож байна?
4. Дараах үгсийг уншиж, зохистой хөгжмөөр өөрийгөө хүрээлүүлэхийн тулд хувийн амьдралдаа юу хийж болох тухай бич:

“Тэнгэрлэг Эцэгтээ ойр байхад чинь хөгжим чамд тусалж чадна. Хөгжмийг хүмүүжүүлэх, гэгээрүүлэх, сүнслэг мэдэрэмжтэй байх, эв нэгдлийг хангахад ашиглаж болно. Гэвч хөгжмийг бас ёс бус зорилгоор ашиглаж болно. Хөгжим нь хурд, айзам, эрч хүч, утга уянгын байдлаараа Сүнсний мэдэрэмжийг бууруулж чадна. Зохисгүй хөгжмөөр оюун ухаанаа дүүргэж болохгүй. Хөгжим хүний амьдралд чухал, хүчтэй нөлөө үзүүлж чадна. Хөгжим сонсох зуршлаа хэрсүү ухаанаар, залбиралтайгаар авч үздэг байх ёстой. Хөгжим сонсох зуршилдаа хяналт тавих хүсэлтэй байж, сүнслэг байдлын хувьд хор хохирол учруулж болох хөгжмөөс зайлсхийх ёстой. Сайн мэдээний зарчмуудад харшилдаг санааг агуулсан хөгжмийг бүү сонс. Сатаны үзэл санаа эсвэл хилэнцэт бусад зуршил, ёс суртахуунгүй явдлыг хөхүүлэн дэмжсэн, хар ярианы буюу бүдүүлэг, олиггүй муухай хэллэгтэй, эсвэл Сүнсийг холдуулан зайлуулах хөгжмийг бүү сонс. Сонсох хөгжмөө сонгоход, бас дууны чанга сулын хувьд дотроо бодолтой, буурь суурьтай бай” (Залуучуудын Бат Бөх Байдлын төлөө [товхимол, 1990], 13–14).

Сургаал ба Гэрээ 26

Нийтийн дэмжлэгийн хууль



Та тойрог буюу салбартаа хэн нэгнийг дуудлагад дэмжин батлахын тулд гараа өргөх нь ямар учиртайг бодож үзсэн үү? Дэмжин батлах нь санал өгөхтэй адил биз дээ? Энэ бол ямар нэг зүйл хийхээр амлаж байгаа хэрэг гэвэл та гайхах уу?

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 26

Сургаал ба Гэрээ 26:2—“Нийтийн дэмжлэг” гэж юу гэсэн үг вэ?

Их Эзэнээс ирсэн эхэн үеийн нэг илчлэлтэд, “Албан ёсоор зохион байгуулагдсан уг Сүмийн салбар байгаа үед, сүмийн саналгүйгээр нэг ч хүн энэ сүмийн ямар ч албан тушаалд томилогдох ёсгүй” (С ба Г 20:65) гэжээ. Бүх ёслол болон дуудлагуудыг Сүмийн гишүүдээр дэмжүүлэн батлуулах зарчмыг нийтийн дэмжлэгийн хууль гэдэг (С ба Г 26:2-ыг үз). Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Марк Э.Петерсен нийтийн дэмжлэгийн тухай өгүүлж, тайлбарлахдаа: “Нийтийн дэмжлэг нь зүсэн зүйлийн сүсэгтнүүд, есөн шидийн хуурамч багш нар, зүсээ хувиргасан удирдагчдад шургалах нүх олгодоггүй, удирдан чиглүүлэгч, ил тод, ганцхан дуу хоолой Сүмд байдагт Их Эзэний хүмүүсийг хандуулдаг, энэ дуу хоолой бол илчлэлтээр зохих журмын дагуу сонгогдож, Сүмийн ерөнхий чуулган дээр хүмүүсийн саналаар хүлээн зөвшөөрөгддөг бошиглогч, үзмэрч, илчлэгчийн дуу хоолой юм” гэжээ (In Conference Report, 1974 оны 4-р сар, 82; *Ensign*, 1974 оны 5-р сар, 56).



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Жеффри Р.Холланд, тэрхүү дэмжин батлах санал Сүмийн удирдагчдад хэчнээн чухал болох талаар хэлэхдээ: “Тэд хувь хүний хувьд ямар нэг хязгаарлалттай байлаа ч гэсэн, удирдагчдад дэмжин баталдагт нь би та бүгдэд онцгой талархалтай байдаг. Та өнөө өглөө нийтийн

дэмжлэгээр, сайн дураараа албан тушаал хүсч байсан эсвэл тухайн зорилгод тэнцэх нэг хүнийг биш, харин уг ажлын түлхүүрүүдийг эзэмшин, хариуцлагыг үүрэх, хаант улсын тэргүүлэх ажилтнуудыг дэмжин баталлаа, чухамдаа бол, ‘дээш нь өргөлөө.’ Тэгээд хамгийн сүүлчийн нэр, шинээр томилогдогсдын хамгийн өчүүхэн нь болох Жеффри Холландын нэр гарахад, та бүгд гараа дуртайяа өргөлөө. Ингэснээрээ та бүгд: ‘Та биднийг түш. Эндээс өөр газарт, таныг огтоос хараагүй, таныг хэн бэ гэдгийг бараг мэдэхгүй шахам Омаход, Онтариод, Осакад та биднийг түш. Харин та бол бидний “ах нарын” нэг, ингэхлээр та

бол бидний хувьд харь хүн болон гадны хүн биш, харин нутгийн хүн, Бурханы гэр бүлийнх юм. Манай гэр бүлүүд таны төлөө залбирч байх болно, мөн та бидний зүрх сэтгэлд үргэлж байх болно. Бидний хүч чадал таны хүч чадал болно. Бидний итгэл таны итгэлийг төлөвшүүлэх болно. Таны ажил бидний ажил байна' хэмээн нулимс нь цийлэгнэн, шөнө дүлээр шалан дээгүүр алхалж байгаа Холланд ахад хэлж байгаа хэрэг." (In Conference Report, 1994 оны 10-р сар, 41–42; Ensign, 1994 оны 11-р сар, 32).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 26-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Адислал ба үүрэг хариуцлага

Сургаал ба Гэрээ 26-р хэсгийг уншаад, нийтийн дэмжлэгийн хууль танд хэрхэн адислал болдгийг тайлбарла. Бас гараа өргөж, дэмжин батлах санал өгснөөр та ямар үүрэг хариуцлага хүлээдгийг тайлбарла.



Ариун ёслолд эрт дээр үед бас сэргээгдсэн Сүмийн эхэн үед дарс хэрэглэдэг байсны оронд бид яагаад үс хэрэглэдэг вэ? Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн үед ариун ёслолын тусгай цуглаан болохыг та мэдсэн үү? Хэн тэнд байх вэ? Сургаал ба Гэрээ 27-р хэсгийг уншихдаа эдгээр асуултаудад хариултыг хай.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 27

Хүчтэй ундаа (ш. 3)— Алкогол (архи) агуулсан ундаанууд

Хормойгоо шуух (ш. 15)— Энэ хэллэгийн үгчилсэн утга нь хурдан гүйхийн тулд дээлийнхээ (эсвэл нөмрөгийнхөө) хормойг бүсэндээ хавчуулах. Хормойгоо шуух гэсэн нь бэлтгэлтэй байхын бэлгэдэл юм.



Сургаал ба Гэрээ 27:5—Моронай “түлхүүрүүдийг” нь эзэмшдэг “Ефраимын савааны цэдэг” юу вэ?



Их Эзэн бошиглогч Езекиелд хоёр номын тухай ярьсан байдаг. Нэг нь “Иудагийн саваа” хэмээн Түүний нэрлэсэн “Иуда болон түүний хамтрагчид болох Израилын хөвгүүдийн төлөө” (Езекиел 37:16, 19) цэдэг байв. Нөгөөх нь Ефраимын саваа болох Иосеф ба түүний хамтрагчид болох Израилын

хамаг гэрийн төлөө” (ш. 16) цэдэг байв. Иудейчүүд бол Иуда болон Иудагийн хаант улсын бусад овгуудын үр удам юм (Судруудын Удирдамж, “Иудейчүүд,” х. 113-ыг үз). Эдний цэдэг бас Библид байдаг. Лихай болон түүний гэр бүл бол Египетэд худалдагдсан Иосефын үр удам байсан бөгөөд түүний үр удмынхан болон тэдэнтэй нэгдсэн хүмүүсийн цэдэг бол Мормоны Ном юм. Мормоны Номын хүмүүсийн сүүлчийн бошиглогч, цэдэг хөтлөгч Моронай ялтсуудыг Кумора гүвээнд нуужээ (Иосеф Смит-Түүх 1:33–34-ийг үз).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 27-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Юу чухал вэ?

1. Сургаал ба Гэрээ 27:1–4-ийг судалж, ариун ёслолоос хүртэхэд юу чухал, юу чухал биш болохыг жагсаан бич.
2. Долоо хоног бүр ариун ёслолоос зохих ёсоор хүртэхийн тулд та ямар бэлтгэл хийх хэрэгтэй вэ?

Б Жагсаалт хий

Сургаал ба Гэрээ 27:5–14 нь Есүс Христийн Хоёр дахь ирэлтийн өмнөхөн болох ариун ёслолын агуу цуглааныг дүрсэлдэг.

1. Сургаал ба Гэрээ 27:5–14-ийг судалж, дээрх цуглаанд оролцох бүх хүмүүсийг жагсаан бич. Шүлэг 11-д өгүүлсэн Михаил гэж хэн бэ?
2. Бусад олон хүмүүс, түүний дотор хэрэв итгэлтэй байх юм бол чи бас тэнд байж болохыг ямар шүлэг харуулдаг вэ?



Адам-ондай-Аманы хөндий

3. Мөн Сургаал ба Гэрээ 116:1-ийг уншиж, энэ цуглаан хаана болохыг бич.
4. Дараах судруудыг уншиж, эдгээрийг Сургаал ба Гэрээ 27:5–14; Даниел 7:9–14; Матай 26:29; Сургаал ба Гэрээ 107:53–57; 116:1-тэй харьцуулах эшлэлүүд болгон бич.

В Хуяг дуулгаа шалга

Сургаал ба Гэрээ 27:15–18-ыг нэгтгэн дүгнэж, дараах даалгаврыг хий:

1. Аль нэг зарлигт (Мэргэн Ухааны Үг буюу залбирал гэхчлэн) дуулгавартай байх нь хамгаалалтын хувцастай хэрхэн адилхан болох тухай хоёр жишээг тэмдэглэлийн дэвтэртээ бич.
2. Дээрх шүлгүүдэд өгүүлсэн хамгаалалтын хувцастай байх нь шүлэг 5–14-т дүрслэгдсэн ариун ёслолын агуу цуглаанд оролцохуйц зохистой байхад танд хэрхэн туслах вэ?
3. Шүлэг 15–18-ыг дүрсэлсэн нэг зураг зурж, өрөөндөө өлгөж болно. Хуяг дуулгын бүх хэсгүүдийг нэрлэхэд анхаар.



Сургаал ба Гэрээ 28

Сүмд зориулсан илчлэлтүүдийг зөвхөн Бошиглогч хүлээн авдаг



Сүмийн эхэн үед Сүмийг бүхэлд нь удирдах илчлэлтүүдийг хүлээн авах зөвхөн ганцхан хүнийг Их Эзэн дууддагийг гишүүд ойлгодоггүй байв. Бид бүгд өөрсдөдөө өгсөн хувийн илчлэлтүүдийг ажил үүргүүдээ зориулан хүлээн авч болно, зөвхөн Бошиглогч, Сүмийн Ерөнхийлөгч ИХ Эзэнийг төлөөлөн дэлхий дахинд хандан ярьдаг билээ.

Оливер Каудери Хайрам Пейж бол Оливер Каудерийн бас Витмерийнхний хүргэн ах байв.

Тэрээр хүү Петр Кристиан, Жон, Жакоб, Давид Витмер нарын эгч Катрин Витмертэй, харин Оливер Каудери бас тэдний эгч нарын нэг, Элизабет Анн Витмертэй гэрлэсэн ажээ. Хайрам Пейж бол Мормоны Номын Найман Гэрчийн нэг байв. Нэг чулуугаар дамжуулан өөрөө Бурханаас илчлэлтүүд хүлээн авдаг гэдэгт тэр итгэсэн байлаа. Сургаал ба Гэрээ 28-р хэсгийг уншихдаа, энэ илчлэлт хэнд, яагаад өгөгдсөнийг ажигла. Бошиглогч Иосеф Смитийн дуудлага, Оливер Каудерийн дуудлагын хоорондох ялгааг тайлбарла.

Америкийн уугуул индианчуудад номлогч болохоор дуудагдсан Оливер Каудерийн дуудлага Сургаал ба Гэрээ 28-р хэсэгт байдаг. Мөн Сион “леменчүүдийн ойролцоох хил дээр байх болно” (ш. 9) гэдэг нь мэдэгджээ.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 28

Леменчүүдийн ойролцоох : (Гурамсан судрынхаа ар тал хил (ш. 9)—Нэгдсэн Улс дахь газрын зураг 5–6-г үз)
болон Индианчуудын нутгийн хоорондох зааг газар : **Нийтийн дэмжлэг** (ш. 13)—Хамтаараа санал өгөн батлах

Сургаал ба Гэрээ 28:1–3—Сүмд зориулсан илчлэлт хүлээн авах эрх хэнд байдаг вэ?

“Сэрэмжлүүлгийн Дуу Хоолой” хэмээн нэрлэгдсэн 1913 оны тунхаглалд тэр үеийн Тэргүүн Зөвлөл-Жозеф Ф.Смит, Антон Х.Лунд, Чарльз В.Пенрөүз нар тайлбарлахдаа:

“Хайрам Пейжийн үеэс хойш (С ба Г хэсэг 28), янз бүрийн үед төөрөлдүүлэгч сүнснүүдээс Сүмийн гишүүдэд илэрхийлэлтүүд ирдэг байлаа. Зөрчлийн улмаас Тэргүүн Залилан Мэхлэгчийн идэш хялбархан болдог байсан эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдэд тэдгээр илэрхийлэлт зарим үед ирдэг байлаа. Сүмийн дүрэм журам, ёслолуудыг чанд сахидаг гэдгээрээ бардамнадаг хүмүүс, Бурханлиг эх сурвалжаас, тэр ч байтугай тэдгээр хүмүүсээс ирж байгаа мэт дуураймал мэдрэмж төрүүлдэг хуурамч сүнснүүдээр зарим үед зайцуулагдан, тийм хүмүүсийг ‘үнэхээр сонгогдогсод’ хэмээн бодож, мөн чанарын ялгааг нь танихад хэцүү байдаг. Сатан өөрийгөө гадаад төрхөөрөө ‘гэрлийн тэнгэр элч’ болгон өөрчилдөг.

“Үзэгдэл, зүүд, хэл яриа, бошиглол, сэтгэгдэл болон аливаа ердийн бус бэлэг, эсвэл сүнсний нөлөө нь, хүлээн авагдсан Сүмийн илчлэлтүүдэд үл нийцэх, Сүмийн хууль ёсны эрх мэдэлтнүүдийн шийдвэрүүдэд харшлах ямар нэг зүйлийг дамжуулахад, энэ нь гадаад байдлаараа хэчнээн ч үнэмшилтэй юм шиг байх нь хамаагүй, Бурханаас биш гэдгийг Хожмын Үеийн Гэгээнтнүүд мэдэж болно. Сүмийн удирдамжууд удирдлагаар дамжин илчлэлтээр ирэх болно гэдгийг гишүүд бас ойлгох ёстой. Итгэлтэй бүх гишүүд өөрсдийнхөө төлөө, гэр орныхоо төлөө, өөрсдийг нь удирдахаар томилогдсон хүмүүсийн төлөө Ариун Сүнсний мэдрэмжийг хүлээн авах эрхтэй юм. Сүмийн удирдлагаар дамжин Бурханаас ирдэгтэй харшлах юуг ч гэсэн, эрх мэдлээс үүдэлтэй биш, итгэж болохгүй зүйл гэж үзэн, хүлээн авахгүй байх ёстой” гэжээ (*Improvement Era*, 1913 оны 9-р сар, 1148).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 28-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Сүмд зориулсан илчлэлтийг хэн хүлээж авдаг вэ?

Сургаал ба Гэрээ 28-р хэсгийн тойм, шүлэг 1–7, 11–13-ыг унш. Тэгээд дараах асуултуудад хариул:

1. Бошиглогч Иосеф Смитийн “чин сэтгэлээсээ асуусан” асуудал юуны тухай байсан бэ?
2. Их Эзэн түүнд ямар хариу өгсөн бэ? (шүлэг 1–7-г үз).
3. Сүмд зориулсан илчлэлтүүдийг өнөөдөр хэрхэн хүлээн авдаг вэ? (шүлэг 11–13; мөн С ба Г 26:2-ыг үз).
4. Сүмд зориулсан илчлэлтийг өнөө үед хэн хүлээж авдаг вэ?



Эцсийн өдрүүдийн тухай бошиглолудаас илүү ихээр бидний анхаарлыг татдаг цөөн хэдхэн сэдэв байдаг. Бид эцсийн өдрүүдэд аж төрж байна (С ба Г 1:4-ийг үз). Эцсийн өдрүүдэд амьдарч байгаагаа мэддэг учраас манай өнөө үеийн талаар Их Эзэний илчилсэн зүйлүүдийг бид онцгой сонирхох ёстой. Сургаал ба Гэрээ 29-р хэсгийг уншихдаа, Хоёр дахь Ирэлтийн өмнө, тэр үед, мөн дараа нь юу тохиох талаар Их Эзэний хэлсэн зүйлүүдийг, мөн тэдгээр үйл явдлуудад бэлтгэхийн тулд та юу хийж болохыг эрж хай.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 29

Цагаатгасан (ш. 1)—Үнийг төлсөн, төлөөсийг нь өгсөн
Тогтоол (шүлэг 8, 12)—Тушаал, зарлиг, хууль
Цаг зуурын (ш. 35)—Дэлхийн
Сүнсний үхэл (ш. 41)—Бурханы оршихуйгаас таслагдах
Гэтэлгэл, гэтэлгэгдсэн (шүлэг 42, 44, 46)—Аврал, боолчлолоос чөлөөлөгдөх

Сургаал ба Гэрээ 29:7—Сонгогдогсод гэж хэн бэ?

“Сонгогдогсод гэж тодорхой ажилд сонгогдсон [шилэгдсэн] хүмүүсийг хэлнэ” гэж Бошиглогч Иосеф Смит заажээ (*History of the Church*, 4:552).

“Ерөнхий утгаараа, сонгогдогсод нь Их Эзэнийг хайрладаг, түүний Сүнсний чиглүүлэлд ойр амьдрахын тулд хүч чадлынхаа хэрээр бүх зүйлийг зүрх сэтгэлийнхээ бүрэн зорилгоор хийдэг, Сүмийн болон Сүмийн бус хүмүүс юм.

“Ерөнхийлөгч Жорж К.Каннон [Тэргүүн Зөвлөлийн зөвлөх асан], ‘Бүх хүн төрөлхтөн аврагдахын тулд сонгогдсон юм. Хэрэв биеэ авч яваа байдал нь ийм болгохгүй л бол, хүн хогийн ургамал биш’ (*Gospel Truth*, 1:140.). Сүмийн гишүүн биш сонгогдогсод бол Эзэн Хоньчны дуу хоолойг анхааран сонсож, тэрхүү дуу хоолойг дуулгавартай дагадаг, улмаар Сүмд хүлээн авагддаг ‘хонинууд’ (Мозая 26:21–28) юм. Ийм хүмүүс бол сонгогдогсод бөгөөд тэднийг цуглуулахыг номлогчдод зөвлөдөг” гэжээ (С ба Г 29:7). (Хоит В. Бага Бревстер, *Doctrine and Covenants Encyclopedia* [1988], 148).



Сургаал ба Гэрээ 29:35–39—Сонгох эрх гэж юу вэ? Сонгох эрх яагаад тийм их ариун нандин байдаг вэ?

Сонгох эрх бол сонголт хийж, уг сонголтынхоо дагуу үйлдэх эрх чөлөө бөгөөд энэхүү эрх чөлөө бидний Тэнгэрлэг Эцэгийн хувьд хэчнээн чухал, хэчнээн ариун нандин болохыг Сургаал ба Гэрээ 29:35–39 харуулдаг. Сонгох эрхээ зөрчихийн оронд, чөтгөрөөр удирдуулан, бослого гаргах боломжийг Тэрээр Хүүхдүүдийнхээ гуравны нэгд олгосон юм. Сонгох эрхийг маань хадгалахын тулд мөнх бус байдал дахь бидний сорилт зохион байгуулагдсан билээ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Брус Р.МкКонки, сонгох эрх оршин тогтноход юу шаардлагатайг тайлбарлахдаа: “Сонгох эрх оршин тогтноход дөрвөн том зарчим үйлчилж байх ёстой: 1. Хуулиуд байх ёстой, Бурханы хүчээр томилогддог хуулиуд, сахих эсвэл сахихгүй

байж болох хуулиуд байх; 2. Эсрэг тэсрэг байх ёстой, сайн ба муу, ариун журам ба мөс жудаггүй явдал, зөв ба буруу гэхчлэн эсрэг тэсрэг зүйлүүд оршиж байх-энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, нэг хүч нэг тийш татаж байхад нөгөөх нь нөгөө тийш нь чангааж байх эсрэг тэсрэг тал байх ёстой; 3. Сонгох эрхийг эдэлдэг хүмүүс сайн ба мууг ялган мэддэг байх ёстой, энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, эсрэг тэсрэгийн ялгааг тэд мэддэг байх ёстой; 4. Сонголтын чөлөөт хүч ноёрхож байх ёстой” гэжээ (*Mormon Doctrine*, 2 дахь хэвлэл, [1966], 26).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 29-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

A Сургаалыг нэгтгэн дүгнэ

Дараа асуултуудаас дөрвийг сонгож, Сургаал ба Гэрээ 29-р хэсгээс сурч мэдсэн зүйлүүдээрээ асуултуудад хариул:

1. Их Эзэн ямар хүмүүсийг цуглуулах вэ? Тэд хэрхэн цуглуулах вэ? (шүлэг 1–8-ыг үз).
2. Хоёр дахь Ирэлтээр юу тохиох вэ? (шүлэг 9–13-ыг үз).
3. Хоёр дахь Ирэлтийн өмнө юу тохиох вэ? (шүлэг 14–21-ийг үз).
4. Мянган жилийн эцэст юу тохиох вэ? (шүлэг 22–30-ыг үз).
5. Сатан болон сонгох эрхийн тухай энэ шүлгүүд юу заадаг вэ? (шүлэг 35–40-ийг үз).
6. Уналт болон гэтэлгэлийн тухай энэ шүлгүүд юу заадаг вэ? (шүлэг 40–50-ийг үз).



Сургаал ба Гэрээ 30 Давид Витмер, Петр Витмер, Жон Витмер-Бүү ай”

Номлолд үйлчилж, харийн хүмүүст сайн мэдээг номлох нь ямар байх болно гэж та боддог вэ? Магадгүй танд сүмийнх биш хэн нэгэнтэй сайн мэдээг хуваалцсан туршилага аль хэдийнээ байж болох юм. Ямар үед та сэтгэл зовсон эсвэл бага зэрэг айсан байдалтай байсан бэ? Сургаал ба Гэрээ 30-р хэсэгт ах дүү Витмерүүд сайн мэдээг номлохоор дуудагджээ. Айдсын тухай тэдний хүн нэг бүрд Их Эзэн юу гэж хэлснийг эрж ол.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 29

Сургаал ба Гэрээ 30:1–2—“Миний зарлиглаагүй тэднээр ятгагдсан нь”

Давид Витмер болон түүний бусад гэр бүлийн үлдсэн гишүүд Хайрам Пейжийн хүлээн авсан хуурамч илчлэлтүүдээр мэхлэгдсэн ажээ (С ба Г 28-ыг үз).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 30-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

A Энэ нь тантай хэрхэн холбогдож болох вэ?

Сургаал ба Гэрээ 30-р хэсэг нь Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Давид Витмер (25 настай), Бага Петр Витмер (21 настай), Жон Витмер (28 настай) нарт Их Эзэний өгсөн зөвлөгөөг агуулдаг. Энэ хэсгийг нэгтгэн дүгнэж, дараах асуултуудад хариул:

1. Витмерүүд юунаас эмээж байна гэж Их Эзэн хэлсэн бэ?
2. Их Эзэн танд хандан ярьж байгаа гэж бодоод, шүлэг 1–2-ыг унш. Та эдгээр алдаануудыг гаргахгүй байхад итгэлтэй байхын тулд юу хийхийг хүсэх вэ?



Сургаал ба Гэрээ 31 Томас Б.Марш-Амлалт ба сэрэмжлүүлэг

Сургаал ба Гэрээ 31-р хэсэг нь 30-р хэсэг (С ба Г 30-ийн оршлыг үз)-тэй ойролцоо үед хүлээн авагджээ. Томас Б.Марш өгсөн Их Эзэний зөвлөгөө нь Тэрээр Өөрийн хүүхдүүдийг хэр зэрэг сайн мэддэгийг харуулдаг. Томас Марш өгсөн амлалт болон сэрэмжлүүлгүүдийг уншихдаа, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга зохион байгуулагдахад тэрээр уг чуулгын анхных нь Ерөнхийлөгч болсныг сана. Хожим нь тэрээр Бошиглогч Иосеф Смитийг дэмжихэд алдаж, эхнэрийнхээ алдааг залруулж чадаагүйд хүргэсэн асуудлын улмаас уурлан, улмаар Сүмийг орхисон ажээ.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 31

Боодлуудыг үүрэх (ш. 5)—
Боосон тариаг үүрэх (ном-
лолын ажилд амжилт олох)

Сургаал ба Гэрээ 31:4–5—“Шатаагдахад аль хэдийн бэлэн байгаа цагаан талбай”



Марший Б. Кампвелл

Их Эзэн номлолын ажлын тухай ярихдаа, ургац хураалтын бэлгэдлийг олонтаа ашигласан байдаг (Иохан 4:35–36; С ба Г 4:4-ийг үз). Улаан буудай мэт үр тариа боловсорч гүйцэн түрүү нь цагаан болбол, тариаг хураахад бэлэн болсон байдаг. Ургац хураахад бэлэн болоход тариан түрүүг хадуураар хадаж,

боодол болгон боодог байжээ. Тариаг хадсаны дараа, түрүү гэж нэрлэгддэг ишийг талбайгаас зайлуулахын тулд шатаадаг байв.

Энэ бүгдийг номлогчдын хийдэг ажилтай зүйрлүүлсэн байдаг. Сайн мэдээг сонсох хүсэлтэй бөгөөд Аврагчийн Хоёр дахь Ирэлтээр дэлхийг цэвэршүүлэн шатаах бэлтгэлд дуулгавартай хүмүүст номлогчид сайн мэдээг тунхагладаг билээ.

Сургаал ба Гэрээ 31:9—13-Зөвлөгөөг дагаагүйн төлөөс буюу Бурхан хүүхдүүдээ хэр зэрэг сайн мэддэг вэ?

Томас Б.Марш Сэргээлтгийн эхэн үеийн хамгийн чадварлаг удирдагчдын нэг байв. Тэрээр нэлээд хэдэн номлолд үйлчилж, 1835 онд Арванхоёрын Чуулга анх зохион байгуулагдахад Төлөөлөгчөөр дуудагдаж, тус чуулгын анхны ерөнхийлөгч нь болжээ. Гэвч дараа нь тулга тойрсон асуудлаас болж, “тэвчээртэй бай,” “бүү доромжил,” “гэрийнхнээ номхон дөлгөөн байдалд авч яв,” “үргэлж залбир,” “эцсийг хүртэл итгэлтэй бай” (шүлэг 9, 12–13) гэсэн Их Эзэний зөвлөгөөг дагаагүй нь түүнийг урвалт руу хөтөлсөн юм. Ерөнхийлөгч Маршийг Миссурын Фар Вестэд амьдарч байхад болсон явдлыг, 1839 онд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүнээр дуудагдсан, Ахлагч Жорж А.Смит дүрсэлсэн нь:

“Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Ерөнхийлөгч байсан Томас Б.Маршийн эхнэр, Харрис эгч [Жорж Харрисын эхнэр] хоёр ахиухан бяслаг хийхийн тулд бие биендээ ээлжлэн сүү өгөхөөр тохиролцсон аж. Ингэхдээ тэд сүүний цөцгийг [сүүний хамгийн өтгөн тослог хэсэг] авч үлдэхгүй, сүүтэй нь хамт өгөхөөр тохиролцжээ. Та бүхэн хоёр эмэгтэй бяслаг хийхийн тулд бие биендээ сүү сэлбэж өгөх тухай, тулга тойрсон өчүүхэн жижиг асуудал шиг санагдаж болох юм.

“Хатагтай Харрис тохиролцоондоо үнэнч байж, сүүг цөцгийтэй нь хамт хатагтай Маршид аваачиж өгсөн бол, харин хатагтай Марш, арай ахиухан сайхан бяслаг хийхийн тулд бүх сүүнийхээ цөцгийг авч үлдээд, шингэн сүүг хатагтай Харрист өгдөг байжээ.

“Эцэст нь, хатагтай Марш цөцгийг өөртөө авч үлдсэн нууц задарч, улмаар энэ хэргийг Багш нар шийдвэрлэх болж.

Тэд уг асуудлыг шалгахад хатагтай Марш цөцгийг авч үлдэн, хатагтай Харрисыг хохироосон нь нотлогдов.



“Багш нар энэ хэргийг бишопт мэдүүлж, ингээд Сүмийн байнгын шүүх хуралдав. Цөцгийг өөртөө авч үлдсэн нь буруу, ингэснээр хатагтай Марш гэрээгээ зөрчсөн байна гэж тэд шийдвэрлэсэн учир бишоп өөрт нь, бас эхнэрт нь шударгаар хандсангүй гэж Ерөнхийлөгч Марш үзжээ.

“Марш тэр даруйд Дээд Зөвлөлд давж заалдсанд, Дээд Зөвлөл уг асуудлыг их тэвчээртэйгээр шалган судалсан аж. Харин Дээд Зөвлөл буурь суурьтай байгууллага байсныг би та нарт батлан хэлье. Арванхоёр Төлөөлөгчийн Ерөнхийлөгч, Израил дахь агуу хүн байсан Марш эхнэрийнхээ нэр төрийг хамгаалахад хамаг анхаарлаа хандуулж, халуун чулуу долоохоос ч буцаагүй боловч, Дээд Зөвлөл эцэст нь бишопын шийдвэрийг хэвээр баталсан ажээ.

“Үүнд гомдсон Марш Сүмийн Тэргүүн Зөвлөлд давж заалдахад, Иосеф зөвлөхүүдтэй хамтран хуралдаж, энэ хэргийг хэлэлцээд, Дээд Зөвлөлийн шийдвэрийг хэвээр нь батлав.

“Тулга тойрсон энэхүү өчүүхэн хэрэг ихээхэн хэл ам, хэрүүл шуугин дэгдээх нь тэр. Ингээд Томас Б.Марш тамд очсон ч хамаагүй, эхнэрийнхээ нэр төрийг хамгаалах болно гэдгээ мэдэгдсэн гэдэг.

“Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Ерөнхийлөгч байсан хүн бүхнээс илүү шударга байх ёстой атал, гэр бүлийнхээ гишүүний үйлдсэн буруу зүйлийг албан тушаалаараа түрий барин дахин дахин өмгөөлж байсан нь дараагийн удаа юунд хүргэж болох вэ? Тэрээр шүүгчийн өмнө очиж, ‘Мормончууд’ Миссури мужид дайсанаж байгаа мэтээр бичгээр мэдүүлэг өгсөн юм.

“Эл мэдүүлэг 15,000 орчим Гэгээнтнийг орон гэр, унасан газар, угаасан уснаас нь хөөлгөж, мянга мянган хүн хэргийн уршгаар бий болсон гай зовлонгоос болж үхэж үрэгдсэн, сүйрүүлэгч захирамжийг Миссурийн засгийн газраас гаргуулсан юм” (in *Journal of Discourses*, 3:283–284).

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли энэ түүхийг ерөнхий чуулган дээр давтаж, тайлбарлахдаа: “Тулга тойрсон энэхүү өчүүхэн хэрүүл маргааныг шийдвэрлэх ёстой байсан хүн,

үүнийг бүр дэвэргэн, Сүмийн ажилтнуудад, тэр тусмаа Ерөнхийлөгчийн Зөвлөлд төвөг удсанаараа, үнэхээр яалт ч үгүй тамын хаалгаар орсон юм. Тэр Сүм дэх албан тушаалаа алдсан. Тэр сайн мэдээний тухай гэрчлэлээ алдсан. Арван есөн жилийн турш тэр ядуу зүдүү байдалд, сэтгэл санааны хүнд дарамт, түмэн зовлон эдэлж, өвчин эмгэгт нэрвэгдэн, ганцаардан амьдарч, цагаасаа өмнө өтөлж хөгширсөн юм. Эцэст нь, тэрээр Аврагчийн нэгэн сургаалт зүйрлэл дэх үрэлгэн хүү лүгээ адил (Лук 15:11–32-ыг үз), мунхаг юм хийснээ ухаарч, хүнд бэрхийг туулан энэ хөндийд хүрч ирэн, өөрийгөө уучлахыг, бас Сүмд дахин баптисм хүртэх зөвшөөрлийг Бригам Янгаас гуйсан билээ. Тэрээр Арван Хоёрын Зөвлөлийн анхны Ерөнхийлөгч, Көртландын үед, түүнчлэн Фар Вестийн эхэн үед хайр, хүндэтгэл хүлээсэн, эрхэм хүндэт нэгэн байсан билээ. Харин одоо тэрээр ердөө диконоор томилогдож, Их Эзэний өргөөний хаалгач байхыг л хүсч байв” гэжээ (In Conference Report, 1984 оны 4-р сар, 111; *Ensign*, 1984 оны 5-р сар, 83).

Марш ах Сүмд эргэж ирсний дараа, урвалтынхаа тухай ярихдаа:

“Миний урвалт хэрхэн эхэлснийг мэдэхийг би олонтаа хүсдэг байлаа, ингээд би Их Эзэний Сүнснийг зүрх сэтгэлээсээ алдсан байжээ гэсэн дүгнэлтэд хүрсэн.

“Дараачийн асуулт бол, “Чи хэзээ, хэрхэн энэ Сүнснийг алдсан бэ?” гэсэн асуулт байлаа. Би Бошиглогчид өшөө хорсол өвөрлөж, үүний улмаас үзэл бодол маань өөрчлөгдөж, зөв юм болгоныг хараар будаж, сайныг биш, харин муут эрж хайхад хамаг цаг зав, ухаан бодлоо зориулдаг байжээ. Ингээд л Чөтгөр намайг дөртэй бух шиг хөтөлж эхлэхэд, уур уцаар, агаа жөтөө, хорсол хилэн гэгч дэлхийн санаа бодол бүр ч гаарсаар байлаа. Үүнийг би дотроо мэдэрдэг байсан. Уур уцаар, хорсол хилэнг би мэдэрдэг байсан. Ийнхүү Их Эзэний Сүнс надаас холдон зайлж, судруудад өгүүлдгээр, би харалган болж, Иосеф ахын нүдэн дэх дүнзийг харж байна гэж боддог байлаа, гэвч миний нүдэнд үртэс биш, харин дүнз орсон хэрэг” гэжээ (in *Journal of Discourses*, 5:206–207).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 31-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Хэлэх үг бэлтгэ

Сургаал ба Гэрээ 31-р хэсгээс сурч мэдсэн зүйлүүдээсээ Их Эзэний зөвлөгөөг дагах тухай ариун ёслолын цуглаан дээр хэлж болох үг бич.

Б Гэр бүлийн үдшийн хичээл заа

Сургаал ба Гэрээ 31-р хэсгээс сурч мэдсэн зүйлүүдээсээ, мөн 31-р хэсэг болон Томас Б.Маршийн амьдралаас бид ямар сургамж авч болох тухай гэр бүлийн үдшийн хичээл заа.



Сургаал ба Гэрээ 32 Леменчүүдэд хийсэн номлол

Сургаал ба Гэрээнд леменчүүд рүү номлогчдыг илгээх тухай Оливер Каудерийг дуудсан Их Эзэний дуудлагад анх удаа дурдсан байдаг (С ба Г 28:8-ыг үз). Мөн тэр сар буюу 1830 оны есдүгээр сард, Бага Петр Витмер Оливертэй хамт явахаар дуудагджээ (С ба Г 30:5-ыг үз). Дараагийн сард нь Парли П.Пратт, Зиба Петрсон хоёр тэдэнтэй хамт явахаар дуудагдав. Сургаал ба Гэрээ 32-р хэсгийг судлахдаа, энэ номлогчдод Их Эзэн юу амласныг эрж ол.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 32

Сургаал ба Гэрээ 32:1—Парли П.Пратт гэж хэн байсан бэ?



Парли П.Пратт энэ илчлэлт хүлээн авагдахаас ердөө ганцхан сарын өмнө 1830 онд Нью-Йоркод Сүмийн гишүүн болжээ. Тэрээр Сүмд үйлчлэх олон ажил үүргийг гүйцэтгэж байв (С ба Г 32-ын тойм, 1–2; 49:1–3; 50:37; 52:26; 97:3–5; 103-ын хэсгийн тойм, 30, 37; 124:127–29-ийг үз). Тэрээр 1835 онд зохион байгуулагдсан Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын анхны гишүүдийн нэг байв.

Парли Пратт Сүмээс нийтлүүлсэн олон номлол болон сүмийн дуулуудыг бичсэн бөгөөд Солт Лейкийн Хөндийд хүрч ирсэн анхдагч нарын нэг байлаа. Тэрээр Арканзаст номлолд үйлчилж байхдаа хөлсний алуурчинд алагдсан билээ.

Сургаал ба Гэрээ 32:2–3—Леменчүүдэд хийсэн номлолд юу тохиолдсон бэ?

1830–1831 оны өвлийн туршид бараг 1,500 бээр (2,400 орчим километр) аялсан номлогчдын жижигхэн бүлэг замын ихэнхийг явганаар туулжээ. Нью-Йорк, Огайо дахь Америкийн уугуул индиан овгууд, Миссурийн цаадах индианчуудын нутагт тэд сайн мэдээг танилцуулсан байна. Тэр үед Миссури Нэгдсэн Улсын баруун хязгаар; Миссурийн баруун хэсэг Индианы нутаг байлаа. Гэвч тэд хамгийн их амжилтыг Огайогийн Көртланд орчмын нутагт олжээ. Шинэ Гэрээг Христийн шүтлэгтнүүдэд буцаан авчрахыг сүвэгчилж байсан бүлэг хүмүүстэй тэд тэнд тааралдсан аж. Ердөө гуравхан долоо хоногт номлогчид 127 хүнд баптисм хүртээж, Сүмийн

гишүүнчлэлийг бараг хоёр дахин нэмэгдүүлэв (*Church History in the Fulness of Times*, х.79–88-ыг үз).



Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 32-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А “Надаас суралцах” нь

“Номхон дөлгөөн болон зүрх сэтгэлдээ даруу” (С ба Г 32:1) байх ба сүнслэг зүйлсийг сурч мэдэх бидний чадварын хоорондох уялдааны талаар юу ойлгосноо дүрсэл (мөн С ба Г 136:32–33-ыг үз).

Б “Би өөрөө тэдэнтэй хамт явж, мөн тэдний дунд байх болно”

Их Эзэн чамд, эсвэл өөрийн чинь таньдаг хэн нэгний төлөө юу хийсэн тухай, Сургаал ба Гэрээ 32:3-т Тэрээр номлогч-дод юу амласан тухай бич.

Сургаал ба Гэрээ 33

Есүс Христийн Хоёр дахь Ирэлтэд бэлтгэх нь


Сайн мэдээний сэргээлтийн анхдагч зорилго бол Бурханы хүүхдүүдийг урвалт, дэлхийн шинж чанараас гарган авчирч, Есүс Христийн Хоёр дахь Ирэлтэд тэднийг бэлтгэх явдал мөн (С ба Г 1:12–17-г үз). Сургаал ба Гэрээ 33-р хэсэгт Их Эзэн энэхүү захиасыг дэлхийд хүргэхийн тулд номлолын үйлчлэлд хоёр хүнийг дууджээ. Энэ хэсгийг судлахдаа, бэлтгэхийн тулд бид юу хийх ёстойг, мөн дэлхийг сэргэмжлүүлэхэд тусалдаг хүмүүст амлагдсан адислалуудыг эрж ол.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 33

Санваараар мэргэших (ш. 4)—Сайшаал магтаал, хувийн ашиг сонирхлын үүднээс номлох (2 Нифай 26:29-ийг үз)

Боодлуудыг үүрэх (ш. 9)—Тарианы боодлуудыг үүрэх (номлолын ажилд амжилт гаргах)



Леменчүүд рүү очсон номлогчдын аялал

Сургаал ба Гэрээ 33:17—“Дэнлүүгээ бэлтгэж асаа”



Сургаал ба Гэрээ 33:17-д өгүүлсэн дэнлүү, тос, Хүргэн Хүү нь арван онгон охины тухай Аврагчийн сургаалт зүйрлэлд холбогдоно (Матай 25:1-13-ыг үз). Энэ сургаалт зүйрлэлд, Аврагчийн (Хүргэн Хүү) ирэлтэд бэлтгэлгүй байгаа (дэнлүү нь тосгүй байгаа) хүмүүс Түүний дэргэдээс таслагдах болно гэдгийг Их Эзэн заажээ.

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 33-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-г хий.

А Нэг шүлгийг зургаар дүрсэл

Их Эзэн энэ илчлэлтэд олон үгийг зураглан дүрсэлсэн байна. Сургаал ба Гэрээ 33:3, 6-9, 13, 17 дахь дүрслэлүүдээс нэгийг сонгож, Их Эзэний заасан зүйлийг дүрсэлсэн нэг зураг зур. Тухайн шүлгийн өгүүлснийг зүгээр л шууд дүрслэн зурах хэрэггүй, харин утгыг нь гарга. Юуг, яагаад зурснаа дүрслэн, зургандаа тайлбар хий.

Б Илчлэлтийг хэрэгжүүл

1. Сургаал ба Гэрээ 33:3, 7-д дэлхийн тухай тодорхойлолтоороо Их Эзэн юуг хэлсэн гэж боддогоо тайлбарла.
2. Энэ тодорхойлолт, шүлэг 2, 4-т Их Эзэний дүрсэлсэн дэлхийн тодорхойлолтоос ямар ялгаатай байна вэ?

Сургаал ба Гэрээ 34

Оорсон Пратт—“Дуу хоолойгоо өргөгтүн”



Оорсон Пратт хожмын өдрүүдийн агуу Төлөөлөгчдийн нэг болсон юм. Сургаал ба Гэрээ 34-т Их Эзэний тухай мөн өөрийнх нь тухай түүнд юу хэлснийг ажигла.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 34

Гажууд хийгээд зөрүүд (ш. 6)—Тэрслүү, муйхар, гаж буруу

Бүү татгалз (ш. 10)—Бүү ухар, бүү няц



Шофар хэмээн нэрлэгддэг эртний еврейн бүрээг хуцын эврээр хийдэг байжээ

Сургаал ба Гэрээ 34:1—Оорсон Пратт

Оорсон Пратт ах Парли П.Праттаасаа сайн мэдээний захиасыг сонссоны дараа, 1830 оны есдүгээр сарын 19-нд, арван ес дэх төрсөн өдрөөрөө баптисм хүртжээ. 1835 онд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга зохион байгуулагдахад ах дүү хоёр хоёулаа Төлөөлөгчөөр дуудагдсан байна. Оорсон Пратт ахынхаа адил Сүмийн олон номлолд үйлчилсэн аж (С ба Г 34-р хэсгийн тойм, 1-10; 52:26; 75:14; 103:40; 124:127-29; 136:13-ыг үз). Тэрээр бас шашин, шинжлэх ухааны сэдвүүдээр олон ном бичсэн бөгөөд Солт Лейкийн Хондийд ирсэн анхдагч нарын нэг байв. Тэрбээр 1881 онд нас барах хүртлээ дөчин таван жил гаруй Төлөөлөгч байжээ.

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 34-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Хоёр шүлгийг харьцуул

Иохан 3:16, Сургаал ба Гэрээ 34:3-ыг уншиж, харьцуул. Эцэг Хүү хоёрын тухай эдгээр шүлгүүдээс юу сурч мэдсэн нээ дүрсэлсэн нэг догол мөр бич.

Б Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн тухай бид юу мэддэг вэ?



1. Марк 13:32-37-г уншиж, Хоёр дахь Ирэлт хэзээ, хэрхэн тохиох талаар Есүсийн хэлсэн зүйлийг бич.
2. Сургаал ба Гэрээ 34:6-12-ыг судалж, Хоёр дахь Ирэлтийн тухай эндээс бид ямар нэмэлт ойлголт авдгийг тайлбарла. Удахгүй, өмнө, хурдан гэдэг үгсийг ажиглаж, тайлбарлахад анхаар.

Сургаал ба Гэрээ 35 Сидней Ригдон-Өмнө нь ирэгч

Их Эзэн хүүхдүүдээ нэгбүрчлэн таньдагийг Иосеф Смит, Сидней Ригдон хоёрт өгөгдсөн илчлэлт-Сургаал ба Гэрээ 35-р хэсэгт харуулдаг. Сидней Ригдоны өнгөрсөн, ирээдүйн тухай Их Эзэн түүнд юу гэж хэлснийг ажигла. Илчлэлтийг судлахдаа Их Эзэн Өөрийн хаант улсад үйлчлэхэд таныг хэрхэн бэлтгэсэн тухай бод.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 35

Мунхаглал болон жигшүүрт хэргүүд (ш. 7)—Тэнгэллэл, ёс бус явдал

Бамбай (ш. 14)—Хамгаалалт (бамбай бол ихэвчлэн гар дээр бэхэлдэг жижигхэн дутуй хуяг)

Тэдний бүсийг бүслэх (ш. 14)—Бэлтгэгдэхэд нь хүмүүст туслах

Будлиулах (ш. 25)—Хүмүүсийг ялган таних аргагүйгээр бусад хүмүүстэй нийлүүлэх

Сургаал ба Гэрээ 35:2—“Бурханы хөвгүүд болох” гэдэг нь юу гэсэн үг вэ?

Бид бүгдээрээ Тэнгэрлэг Эцэгийнхээ сүнсэн хүүхдүүд билээ (Үйлс 17:29; Еврей 12:9-ийг үз). Гэвч, Түүнтэй дахин хамт амьдрахын тулд, бид бүгдээрээ Есүс Христийн Цагаатгалаар дамжин Сүнсээр дахин төрөх ёстой (Мозая 5:7–8-ыг үз).

Сургаал ба Гэрээ 35:3—“Миний үйлчлэгч Сидней”



Сидней Ригдон Огайогийн Кертландад тохинуулагч байв. Тэрээр Мормоны Номыг залбирч уншсаны дараа 1830 онд Сүмд нэгдсэн аж. 1833–1844 онуудад тэрээр Бошиглогч Иосеф Смитийн нарийн бичгийн дарга бөгөөд Тэргүүн Зөвлөлийн зөвлөхөөр үйлчилж байв (С ба Г 35-р хэсгийн тойм, 3–6; 58:50, 57–58; 71:1; 76-р хэсгийн тойм, 11–15; 90:6, 21; 93:44, 51; 102:3; 124:126-г үз). Иосеф Смитийг нас барсны дараа Сидней Ригдон Сүмийн хяналтыг Арванхоёр

Төлөөлөгчөөс өөртөө авахыг оролдож, үүний улмаас 1844 оны есдүгээр сард Сүмээс хөөгдсөн байна.

Сургаал ба Гэрээ 35:11—“Вавилоны эзгүйрэл”

Вавилон бол бүх үндэстнүүдийн дунд нүгэл хилэнц, муу муухай бүхнийг бий болгодог дэлхийн ёс бус байдлын бэлгэдэл юм. Ийм бүх ёс бус бусармаг явдал Есүс Христийн Хоёр дахь Ирэлтээр цэвэршин арилна.

Сургаал ба Гэрээ 35:13—“Үндэстнүүдийг шигших” гэж юу гэсэн үг вэ?

Иосеф Смитийн үед, шигших гэдэг нь үр тариаг хальснаас нь салгахыг хэлдэг байж. Хуучин Гэрээний үед үр тариаг хатуу газар дээр тарааж, шараар (үхрээр) дээгүүр нь гишгүүлэх эсвэл (Дэд Хууль 25:4-ийг) саваагаар цохидог байсан аж (Рут 2:17-г үз). Номлогчид Бурханы үгэн “савааг” (1 Нифай 11:25-ыг үз) ашиглан, зөв шударга хүмүүсийг ёс бусчуудаас хэрхэн салган тусгаарлагдгийг дүрслэхийн тулд Их Эзэн энэ дүрслэлийг Сургаал ба Гэрээ 35:13-т ашигласан байдаг.



Сургаал ба Гэрээ 35:20–21—Библийн Иосеф Смитийн Орчуулга (ИСО)

Библийн олон чухал хэсэг алга болсон эсвэл өөрчлөгдсөн байлаа (1 Нифай 13:24–29-ийг үз), иймээс Библид олон залруулга хийхийг Их Эзэн Бошиглогч Иосеф Смитэд зарлиг болгожээ (С ба Г 35:20; 41:7; 45:60–61; 73:3–4; 93:53-ыг үз). Сургаал ба Гэрээ 35-р хэсэгт, Бошиглогчийн хэлж өгсөн өөрчлөлтүүдийг бичихийг Сидней Ригдонд Их Эзэн зарлиг болгосон байдаг (ш. 20-ийг үз). Энэ хувилбарыг Иосеф Смитийн Орчуулга (ИСО) гэдэг. Өөрчлөлтүүдийн зарим нь таны Судруудын Удирдамжид газрын зургуудын өмнө байгаа. Иосеф Смитийг Библийн орчуулга дээр ажиллаж байхад, олон хэсгийг тайлбарласан илчлэлтүүдийг Их Эзэн түүнд өгчээ (С ба Г 76; 77; 86; 91; 93; 113; 132; мөн Мосе; Иосеф Смит-Матай; “Библийн Иосеф Смитийн Орчуулга,” энэ гарын авлагын х.00 [3]-ыг үз).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 35-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Сургаалыг тайлбарла

- Сургаал ба Гэрээ 35:2-г нэг гэдэг үгийг гарч ирэх бүрд нь тэмдэглэ.
- Энэ шүлэгт нэг гэдэг үг ямар утгатай байгааг, Тэнгэрлэг Эцэг, Түүний Хүү Есүс Христ болон бидний хоорондох харилцааны тухай энэ үг юу зааж байгааг тайлбарла (мөн Иохан 17-г үз).

Б “Илүү агуу ажлыг” тогтоо

Сургаал ба Гэрээ 35:3–6-д Сидней Ригдонд өгсөн Их Эзэний зөвлөгөөг нэгтгэн дүгнэ. Сидней Ригдон ямар ажлыг өмнө нь хийж байснаасаа “илүү сайн” хийхээр хэрхэн дуудагдсаныг тайлбарла (С ба Г 35:3-ын “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз).

В Судар бидэнд хэрхэн тусалдгийг тайлбарла

Сургаал ба Гэрээ 35:20-д судрууд “миний өөрийн сонгосон тэдний авралын төлөө” өгөгдсөн юм хэмээн Их Эзэн тайлбарлажээ. Бидний авралд судрууд ямар үүрэг гүйцэтгэдгийг

Тэрээр шүлэг 21-д өгүүлжээ. Дараах харьцуулах эшлэлүүд болон өөрийнхөө бодол санааг ашиглан судрууд бидэнд хэрхэн тусалдгийг тайлбарла:

1. Их Эзэний дуу хоолойг сонсоход (мөн С ба Г 18:34–36-г үз).
2. Түүнийг харахад (мөн Матай 5:8-ыг үз).
3. Хоёр дахь Ирэлтэд бэлтгэхэд (мөн Иосеф Смит-Матай 1:37-г үз).
4. Цэвэршихэд (мөн Моронай 7:48-ыг үз).



Таныг хэн болохыг Их Эзэн үнэхээр мэддэгт итгэдэг үү? Тийм ээ, Тэр мэддэг, бас энэ илчлэлт бол Тэрээр хүүхдүүдээ хэр зэрэг сайн мэддэгийн өөр нэг жишээ юм. Сургаал ба Гэрээ 36-р хэсгийг судлахдаа өөрийгөө Эдвард Партрижийн оронд тавиад төсөөлөн бод. Их Эзэн өөрт чинь юу гэж хэлэх байсан гэж чи бодож байна?

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 36

Сүсгийн загвар (хэсгийн тойм)—Бурханд хоёргүй сэтгэлээр хандахын үлгэр жишээ

Зөрүүд энэ үеийнхэн (ш.6)—Эсэргүүцдэг, эсвэл удирдахад хэцүү хүмүүс

Сургаал ба Гэрээ 36:1—Эдвард Партриж

Леменчүүд рүү илгээсэн номлогчид Миссури рүү явах замдаа Огайогийн Кортландад зогсох үед 1830 оны аравдугаар сарын орчим Эдвард Партриж сэргээгдсэн сайн мэдээг анх сонсчээ (С ба Г 28:8; 32:2–3-ыг үз). Гэвч тэр дараа нь нэлээд хэдэн сар өнгөртөл Сүмд нэгдээгүй аж. Бошиглогчийн ээж Люси Мак Смит баптисм хүртэх Эдвард Партрижийн шийдвэрийн тухай дараах зүйлийг бичжээ: “Мөн оны [1830] арванхоёрдугаар сард Иосеф гэртээ нэг цуглаан хийхээр товлосон байлаа. Түүнийг номлож байхад Сидней Ригдон, Эдвард Партриж хоёр орж ирээд, цугларгасдын дунд суув. Иосеф үгээ дуусгаад, үг хэлэх хүсэлтэй бүгдэд үг хэлэх боломж олгов. Тэгтэл ноён Партриж босч, Манчестерт байхдаа номлож байсан сургаалын талаар зарим нэг мэдээлэл, ойлголттой болсон ч, биднийг олоогүй учраас бидний зан араншингийн талаар



хөршүүдээс маань лавласан тухайгаа ярилаа. Иосеф Мормоны Номын талаар тэднийг хууран мэхлэх хүртлээ бид ёстой л хорхойд хоргүй, мөрөөрөө хүмүүс байсан гэнэ. Тэрбээр бас манай фермийн хажуугаар өнгөрөхдөө, ферм маш эмх цэгцтэй, нөр хичээнгүй хөдөлмөр шингэснийг нь харжээ. Бас итгэл бишрэлийнхээ төлөө бидний золиосолсон зүйлийг харж, бидний үнэн байдал манай шашны бусад зүйлийн талаар эргэлзээ төрүүлээгүйг сонсоод, тэрээр бидний гэрчлэлд итгэсэн ажээ. ‘Хэрэв’ Иосеф ах надад баптисм хүртээх юм бол, би баптисм хүртэхэд бэлэн байна” (*History of Joseph Smith*, 191–192) гэж билээ. 1830 оны арванхоёрдугаар сарын 11-нд Иосеф Смит түүнд баптисм хүртээжээ.

Эдвард Партриж хожим нь Сүмийн анхны бишоп болж (С ба Г 35 тойм; 36 тойм, 1–7; 41:9–11; 42:10; 50:39; 51:1–4, 18; 52:24; 57:7; 58:14–16, 24–25, 61–62; 60:10; 64:17; 124:19-ийг үз), Миссурид олон мөрдлөг хавчлагад өртсөн аж. Сүмийн итгэлтэй гишүүн тэрээр 1840 онд, Иллинойн Наувуд дөчин долоотойдоо нас баржээ.

Сургаал ба Гэрээ 36:2—“Бибээр чиний дээр мутраа тавих болно”

Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Харольд Б.Лий Сургаал ба Гэрээ 36:2-ын талаар хэлэхдээ: “Адислагдах хэн нэгний толгой дээр эрх мэдэл олгогдсон үйлчлэгчдийнх нь нэг гар тавих үед уг адислалыг гүйцэтгэхэд Их Эзэн өөрөө тэдэнтэй хамт бас гараа тавихтай агаар нэгэн юм гэж Тэрээр энд хэлсэн байдаг. Иймээс эрх мэдлийн түлхүүрүүдийг Тэрээр итгэмжлэн даатгасан үйлчлэгчдээрээ дамжуулан өөрийн хүчийг хүмүүний дунд хэрхэн харуулдгийг бид хардаг” гэжээ (*Be Secure in the Gospel of Jesus Christ*, Brigham Young University Speeches of the Year [1958 оны 2-р сарын 11], 6).

Сургаал ба Гэрээ 36:6—“Махан биеэр бузарлагдсан өмсгөлийг хүртэл жигшин, гал дотроос урагш гарч ирэгтүн”

Хуучин Гэрээний үед өвчин даамжрахыг зогсоохын тулд өвчилсөн хүмүүс бузартсан бүх хувцсыг шатааж, цэвэрших үйл явцыг биеэр туулахыг Их Эзэн зарлиг болгодог байжээ (Левит 13:47–59-ийг үз). Сургаал ба Гэрээ 36:6-д Их Эзэн өвчнөөс илааршихыг нүглээс цэвэршихтэй харьцуулжээ (мөн Иуда 1:23; Алма 5:57-г үз).

Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан Ахлагч Спенсер В.Кимбалл, нүгэл рүү хөтөлдөг нөхцөлүүдийг өөрчлөх хэрэгцээг тайлбарлахдаа: “Хүн нүглийг зөвхөн орхисноор илүү сайн нөхцөлийг хүсч чадахгүй. Тэрээр илүү сайн нөхцөлийг бий болгох ёстой. Тэрээр толбо болсон өмсгөлүүдийг үзэн ядаж, нүглийг жигшдэг болсон байх хэрэгтэй. Тэр нүглийг зөвхөн орхисон байх төдийгүй, бас нүглийн эргэн тойрон дахь нөхцөлүүдийг өөрчилсөн нь тодорхой байх ёстой. Нүгэл бий болдог газрууд, нөхцөл байдлуудаас зайлсхийдэг байх ёстой, учир нь эдгээр нь нүглийг дахин өдөөхөд ямагт бэлэн байдаг. Хамтран нүгэл үйлдсэн хүмүүсээс бүрмөсөн холдох ёстой. Нүгэл үйлдэхэд оролцсон хүмүүсийг тэр үзэн ядаж болохгүй, гэвч тэднээс болон нүгэлтэй холбоотой бүх зүйлээс зайлсхийх ёстой” гэжээ (*The Miracle of Forgiveness* [1969], 171–172).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 36-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Тэмдэглэл бич

Хэрэв та Эдвард Партриж байсан бол, мөн Сургаал ба Гэрээ 36-р хэсэгт Гэрээр юу хийснээ Их Эзэн танд ярьсан бол, өөрт чинь ямар санагдах байсныг дүрсэлсэн тэмдэглэлийг дэвтэртээ бич.

Б Сурч мэдсэн зүйлээ тайлбарла


Сургаал ба Гэрээ 36:2-ыг уншсаны дараа, санваар хүлээн авах талаар юу сурч мэдсэнээ тайлбарла.



Леменчүүдэд сайн мэдээг хүргэхээр Миссури рүү явах замдаа Огайогийн Көртландад зогссон номлогчдын амжилт Сүмийн гишүүнчлэлийг эрс нэмэгдүүлсэн билээ (С ба Г 32:1–3-ыг үз). Ердөө гуравхан долоо хоногт тэд 127 хүнд баптисм хүртээснээр, найман сартай Сүмийн гишүүнчлэлийг бараг хоёр дахин нэмэгдүүлжээ. Көртландад уур амьсгал нөхөрсөг байсан бол, Нью-Йоркод мөрдлөг хавчлага улам гаарсаар байлаа. Сургаал ба Гэрээ 37–38-р хэсгийг уншихдаа, уг асуудлыг шийдвэрлэхэд туслахын тулд Сүмд өгсөн Их Эзэний зарлигууд болон заавруудыг эрж ол.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 37



Сургаал ба Гэрээ 38

Серафим (ш. 1)—Тэнгэр элч

Сургаал ба Гэрээ 38:12—“Дэлхийг хадаж, хогийн ургамлуудыг цуглуул”



Энэ шүлэг улаан буудай ба зэрлэг өвсний тухай Аврагчийн сургаалт зүйрлэлд холбогдоно (Матай 13:24–30, 36–43-ыг үз; мөн С ба Г 86:1–7-г үз).

Сургаал ба Гэрээ 38:30—“Хэрэв та бэлтгэгдсэн байх аваас эмээх нь үгүй”

“Зааж сургахад бэлтгэгдсэн байхын тулд хүн судруудыг судлан, тунгаан бодож, суралцаж, итгэлээ төлөвшүүлэх ёстой. ‘Хэрэв та бэлтгэгдсэн байх аваас эмээх нь үгүй’ хэмээн Их Эзэн хэлсэн бөгөөд бага балчраасаа эхлэн өсч насанд хүрсэн бүх жилүүдэд хавсралт байгууллага, семинар, институт, гэр бүлийн үдэш, ариун ёслолын цуглаан, түүнчлэн өөр бусад газруудад заадаг хичээлүүд нь айдсыг арилгах бэлтгэлийг залуу хүн бүрд авчирдаг гэдэгт бид найддаг” хэмээн хэмээн Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл сургажээ (“Advice to a Young Man: Now Is the Time to Prepare,” *New Era*, 1973 оны зургадугаар сарын 9).

Сургаал ба Гэрээ 38:32—“Би та нарт өөрийн хуулийг өгөх болно”

Бошиглогч Иосеф Огайогийн Көртландад Сургаал ба Гэрээ 42-р хэсгийг хүлээн авснаар энэ амлалт гүйцэлдсэн юм.

Сургаал ба Гэрээ 38:32—“Тэнгэрийн хүчээр хишиг хүртэх болно”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Брус Р.МкКонки сургасан нь: “Энэ эрин үед, бүр 1831 оны нэгдүгээр сард ахлагчид Ариун Сүнсний бэлэг хүлээн авсны дараа, итгэлтнүүдэд зориулан хадгалж байсан хишигийг (С ба Г [38:32]; 43:16), ‘хүмүүний үрсийн дунд мэдэгдээгүй тэрхүү адислалыг’ (С ба Г 39:15) Их Эзэн хүртээснээ тэдэнд илчилж эхэлсэн юм. 1833 оны зургадугаар сард Тэрээр: ‘Миний сонгосон тэдэнд тэнгэрийн хүчээр хишиг хүртээхээр миний төлөвлөж буй байрыг та нар барих ёстой хэмээх зарлигийг би та нарт өгч байна. Учир нь энэ бол та нарт өгсөн Эцэгийн амлалт юм. Тиймийн тул үлдэхийг, бүр Иерусалим дахь миний Төлөөлөгчдийн адилаар би та нарт зарлиг болгож байна’ гэжээ (С ба Г 95:8–9; 105:11–12, 18, 33).” (*Doctrinal New Testament commentary*, боть 3 [1966–1973], 1:859).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 37–38-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Эдгээр илчлэлтүүдийг өөрийнхөө амьдралтай харьцуул

1. Нью-Йоркийн бүс дэх дайснуудынх нь улмаас Их Эзэн юу хийхийг Сүмд хэлсэн бэ?

2. Өнөө үед Сүмийн гишүүд янз бүрийн дайсантай тулгарч болох ч дайснаас хэрхэн зайлсхийх талаар Их Эзэн зөвлөгөө өгсөөр байдаг. Учирдаг аюулаас зайлсхийхэд бидэнд туслахын тулд өнөө үед Их Эзэний өгсөн зарим зөвлөгөөг жагсаан бич.

Б Найздаа зөвлөгөө өг

Буруу шийдвэр гаргаснаас бэрхшээл, харуусалтай тулгарсан нэг найз өөрт чинь байж гэж бод. Сургаал ба Гэрээ 38:1–12-оос уншсан зүйлээ ашиглан, тэрээр дэлхийг сонсох биш, яагаад Их Эзэнийг болон Түүний зөвлөгөөг дагах ёстой талаар дээрх шүлгүүдээс өөрийнхөө олж чадах аль болох олон шалтгааныг өгүүлсэн зөвлөгөөг найздаа бич.

В Сионы шинж чанарууд ба нөхцөл

Гэгээнтнүүд итгэлтэй байсан нөхцөлд тэдний байгуулж чадах Сион буюу “амлалтын нутгийн” тухай Сургаал ба Гэрээ 38:18–42-т Их Эзэн Бошиглогч Иосефт заажээ.

1. Тэмдэглэлийн дэвтэртээ хоёр багана хий. Нэг дэх багананд, амлалтын нутаг юутай адилхан байх талаар дээрх шүлгүүд юу зааж байгааг бич. Хоёр дахь багананд, амлалтын нутгийн хувьд зохистой байхын тулд Гэгээнтнүүд юу хийх хэрэгтэйг бич.
2. Энэ газар одоогийн бидний амьдарч байгаа газраас ямар ялгаатай байхыг, мөн амлагдсан нутагт амьдрахад юунд нь та хамгийн дуртай байхыг тайлбарласан нэг догол мөр бич.



Өөртөө нэгэнт бий болсон заншил буюу зуршлыг өөрчлөх нь яагаад их хэцүү гэж та боддог вэ? Уг заншил буюу зуршлыг санах нь өөрчлөлтийг амар хялбар болгодог уу, эсвэл улам хэцүү болгодог уу? Яг ийм нөхцөл байдал Жеймс Ковиллд тулгарсан ажээ. Тэрээр илчлэлт хүсч Бошиглогч Иосеф Смит дээр ирэх үедээ өнгөрсөн дөчин жилийн турш баптист тохинуулагч байв. Сургаал ба Гэрээ 39-р хэсэгт Их Эзэн түүнд өгсөн амлалтууд болон сэрэмжлүүлгүүдийг ажигла. Дараа нь Сургаал ба Гэрээ 40-р хэсэгт тэр ямар сонголт хийснийг, мөн ямар үр дагаварт хүрснийг ажигла.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 39

Голч (ш. 3)—Дунд эсвэл дээд цэг

Хозанна (ш. 19)—“Одоо авраач, бид залбирч байна” гэсэн утгатай еврей үг

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 39–40-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А, Б эсвэл В-г хий.

А Зүрх сэтгэлийн эмгэнэлт өөрчлөлт



Тэмдэглэлийн дэвтэртээ хоёр зүрх зураад, нэгийг нь, “одоо байгаа нь,” нөгөөг нь “өмнө байсан нь” гэж гарчигла.

1. Сургаал ба Гэрээ 39-р хэсгийн тойм болон шүлэг 7–13-ыг унш. Жеймс Ковиллын зүрх сэтгэлийн өөрчлөлтийн талаар Их Эзэний хэлсэн зүйлийг мөн үүний улмаас тэрээр юу хийхээр дуудагдсаныг нэг дэх зүрхэн дотор бич.
2. Сургаал ба Гэрээ 40-р хэсгийн тойм болон шүлэг 1–3-ыг унш. Жеймсийн зүрх сэтгэл хэрхэн, юуны улмаас өөрчлөгдсөнийг хоёр дахь зүрхэн дотор бич. Эл өөрчлөлтийн улмаас түүнд юу тохиолдох болно гэж Их Эзэн хэлснийг бас тайлбарла.
3. Жеймс Ковиллд тохиолдсон зүйлийг Марк 4:3–9, 14–20-д Их Эзэний өгүүлсэн сургаалт зүйрлэлтэй харьцуул. Тэнд дүрслэгдсэн хөрснүүдийн аль нь Жеймс Ковиллын зүрхтэй хамгийн адилхан байна вэ?

Б Зарлал бич

Сургаал ба Гэрээ 39:10–24 нь номлогчдын зарим чухал үүрэг хариуцлагуудыг дүрсэлдэг. “Ямар нэг юм авах тухай” зарлал сонинд хэрхэн гардгийг бодож үз. Эдгээр шүлгүүд дэх мэдээллийг ашиглан, номлогч ямар байх ёстой, юу хийх ёстойг бич. Зарлалаа: “Бүрэн цагийн номлогчид ажилд авна” гэж эхэл.

В Түүх бич

Жеймс Ковилл яагаад Их Эзэний чиглүүллийг дагаагүй тухай өгүүлсэн бэ? Сургаал ба Гэрээ 40:1–3-ыг унш. Тэгээд Жеймс Ковилл шиг сул дорой боловч, Их Эзэнийг дуулгавартай дагаснаар сул дорой байдлаа даван туулж, номлолд үйлчлэх боломжтой болсон өнөө үеийн нэг хүний тухай товч зохиомол түүх бич.

Огайо болон Миссури дэх Сүм

“Мормоны үзэл санаа, үйл ажиллагаа Огайо, Миссурид үлэмж хэмжээгээр төвлөрч байсан жилүүд бол [Сүмийн] түүхэн дэх хамгийн чухал мөртлөө хамгийн эмгэнэлтэй он жилүүд байлаа. Энэ үед Сүмийн удирдлагын үндсэн зохион байгуулалтыг үндэслэн бий болгосон юм. Олон тулгуур, өвөрмөц сургаалуудыг Иосеф Смит зарлан тунхаглав. Уг ажил анх удаа гадаад дэлгэрэв; мөн энэ өрнөл хөгжилтэй зэрэгцэн, олон хүний амь насыг авч одон, бүх Гэгээнтнүүд ноцтойгоор хохирсон, харгис мөрдлөг хавчлагд Сүм өртсөн билээ.

“Түүхэн чухал ач холбогдолтой үйл явдлууд дээрх хоёр газарт нэгэн зэрэг өрнөж байсан үед, унаа тээврийн хүндрэлээс болж хоёр бүлгийн хоорондын харилцаа хязгаарлагдмал байсан ч, Сүмийн ажилтнууд шаардлага гарсан үед нэг газраас нөгөө рүү нь очдог байлаа” (Hinckley, Truth Restored, 41).



1831 оны нэг, хоёрдугаар сард Бошиглогч Иосеф Смит гэр бүлийнхээ хамт Огайод шилжиж иржээ. Тэднийг тэнд ирсэн үед тус бүс нутаг дахь Сүмийн гишүүнчлэл бараг гурван зууд хүрээд байлаа. Шинэ хөрвөгчдөөс олон нь “Шавь нар” гэгддэг байсан шашны нийгэмлэгээс ирсэн байв. Тэдний хувьд сайн мэдээ цоо шинэ зүйл байсан учраас, “зарим хачирхалтай үзэл санаа, хуурмаг сүнснүүд” (С ба Г 41-р хэсгийн тойм) хэмээн Бошиглогчийн нэрлэсэн зүйл тэдэнтэй хамт ирсэн ажээ. Хэдэн сарын турш, тэр ч байтугай Сүмд нэгдсэн нийхээ дараа ч эдгээр хөрвөгчид “нийтийн өмч хөрөнгө” буюу бүх өмч хөрөнгийг нийтээрээ эзэмших ёстой гэсэн дүрмийг мөрдсөөр байв. Гэвч энэ систем хэрхэн үйлчлэх тухайд тэдний дунд зөрчилдөөн гардаг байлаа. “Шавь нар бүх зүйлийг нийтээрээ эзэмшидэг байсан бөгөөд тэд материаллаг зүйлүүдийг маш түргэн үрэн таран хийнэ, учир нь аль нэг ахад байдаг зүйл, ах нарын хэнийх нь ч юм байж болно гэж сударт заадаг гэж тэд үздэг байв, иймээс тэд бие биенийхээ хувцас хунар, бусад эд юмсыг зөвшөөрөлгүйгээр авч хэрэглэдэг байсан нь будлиан, дургүйцэлд хүргэдэг байв. Учир нь тэд судрыг ойлгодоггүй байв” хэмээн Жон Витмер энэ тухай бичжээ (“Church History,” Journal of History, 1908 оны 1-р сар, 50-иас эш татжээ).

Эхэн үеийн эдгээр хөрвөгчдийн зарим нь итгэлтнүүдэд Сүнс нөлөөлдөг арга замын талаар төөрөлдсөн байв. Огайогийн анхны нэг хөрвөгч Жон Коррилл илчлэлт хүлээн авдаг хэмээн мэдэгдсэн зарим хүмүүсийн зан авирт сэтгэл санаа нь үймэрч: “Тэд биеэ хачирхалтайгаар авч явдаг, заримдаа индианчуудын ааш авирыг дуурайж, зарим үед талбай руу гүйж очин, хожуул дээр гарч, цугларагсдаар хүрээлүүлсэн юм шиг номлож гардаг-бүгд л үзэгдэлд бүрэн шингэж ууссан мэт, орчин тойрондоо юу болж байгааг мэдэхгүй, ухаан алдсан юм шиг болдог” гэжээ (Church History in the Fulness of Times, 92-оос эш татжээ).



Эдвард Партриж

Есүс Христийн шавь байхыг хүсдэг хүнээс чухам юу шаардагддаг вэ? Сургаал ба Гэрээ 41-р хэсгийг судлахдаа, хэн өөрийнх нь шавь, мөн хэн өөрийнх нь шавь биш болох талаар Их Эзэний хэлсэн зүйлийг ажигла. Эдвард Партрижийн талаар Их Эзэний хэлсэн зүйлээс үзэхэд, тэр жинхэнэ шавь байх шаардлагыг хангасан гэж та бодож байна уу? Та энэ шаардлагыг хангадаг уу?

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 41

Шавь (ш. 5)—
Дуулгавартай, итгэл биш-
рэлтэй дагагч

Заль мэх (ш. 11)—Шударга
бус явдал, хууран мэхлэх

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 41-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Та яагаад шавь байхыг хүсэх ёстой вэ?

Яг Бошиглогч Иосеф Смитийн үеийнх шиг, Есүс Христийн үнэн шавь гэж хэн бэ гэдэг талаар өнөөдөр дэлхийд олон өөр үзэл бодол байдаг.

- Сургаал ба Гэрээ 41:1–6-г уншаад, шавь гэж хэн бэ гэдэг талаар Есүсийн хэлснийг хураангуйлан дүгнэ (мөн С ба Г 6:32; 41:5; 52:40-ийг үз).
- Эдгээр шүлгүүдээс сурч мэдсэн зүйлээс харахад, яагаад та шавь гэж нэрлэгдэхийг хүсэх учиртай вэ?

Б Өнөө үед бипопыг (салбарын ерөнхийлөгч) хэрхэн дууддаг вэ?

Эдвард Партриж Сүмийн анхны бишпоор дуудагджээ (С ба Г 41:9–12-ыг үз). Тэр үеэс хойш мянга мянган итгэлтэй эрчүүд бишпоор үйлчлэх дуудлага хүлээн авсан юм. Одоогийнхоо

бишоп болон салбарын ерөнхийлөгч, эсвэл өнгөрсөн үед салбарын ерөнхийлөгч болон бишоп байсан хүмүүстэй ярилцлага хийж, дараах нийлэмж үгс, өгүүлбэрүүд ямар утгатайг түүнээс асуу: “Би дуудагдсан,” “Сүмийн дуу хоолой,” “бишопоор томилогдсон,” “түүний зүрх сэтгэл цэвэр ариун.” Түүний хариултыг тэмдэглэлийн дэвтэртээ бич.



Сургаал ба Гэрээ 42

Их Эзэнээс Өөрийн Сүмд өгсөн хууль

Огайо руу шилжин нүүхийг Их Эзэн Сүмийн гишүүдэд зарлиг болгож, тэнд Тэрээр Өөрийн хуулийг тэдэнд өгөх болно гэжээ (С ба Г 38:32-ыг үз). Энэ амлалтыг биелүүлэхийн тулд Сургаал ба Гэрээ 42 –р хэсэг өгөгджээ. Энэ илчлэлтийн нэг хэсэг нь өмч хөрөнгийн өргөлийн хуулийг танилцуулдаг. Энэ хуулийн тухай та юу мэдэх вэ? Энэ хуулийг өнөөдөр хэрэглэдэг үү? Энэ хэсгийг судлахдаа, хэрэв хүн бүр энэ илчлэлтэд өгөгдсөн зарлигуудаар амьдардагсан бол дэлхий хэчнээн их өөр байх байсан тухай бод. Чи өөрийгөө Есүс Христийн Хоёр дахь Ирэлтэд бэлтгэхийн тулд ямар зарлигуудыг илүү хичээнгүйгээр дагах ёстойг анхааралтай авч үз.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 42

Зөрчил (ш. 10)—
Зарлигуудыг дагахгүй байх
Даамал (ш. 32)—Эзнийхээ
эд юмсыг хариуцах үүрэг
хүлээсэн, итгэмжлэгдсэн
үйлчлэгч

Нууц хуйвалдаанууд (ш. 64)—Хилэнцэт мууг үйлдэхийн тулд ёс бус хүмүүс нууцаар тохиролшох
Завхайрал (ш. 74)—
Бэлгийн харилцааны нүгэл

Сургаал ба Гэрээ 42:12—“Сайн мэдээний бүрэн байдал” гэж юу вэ?



Мормоны Ном Сайн мэдээний бүрэн байдлыг агуулдаг гэж Их Эзэн хэлсэн нь юу гэсэн үг болохыг Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит тайлбарлахдаа: “Энэ тухайд, гэрлэлтийн үүрд мөнхийн байдал болон нас барагсдын өмнөөс хийх баптисмд хамаарах юу ч Мормоны Номонд цэдэглэгдээгүй байна хэмээн зарим хүмүүс боддог.

Анхааралтай унших юм бол, энэ ном бүх зарчмуудыг бүрнээр нь агуулдаг гэж Их Эзэн өгүүлээгүй ч гэсэн, бүрэн байдал нь Түүний Сүмийг үндэслэн байгуулах болон

Түүний Сайн мэдээнд зайлшгүй шаардлагатайг заасан байдаг. . . . Нас барагсдын өмнөөс хийх баптисм бол шинэ сургаал биш, харин нас барагсдын өмнөөс хийх баптисмын зарчмыг л хэрэглэх явдал гэдгийг мартахагүй байцгаая. Мөнхийн гэрээнүүдэд чухал ач холбогдол өгдөг учраас эдгээрийн тухай бүх судруудад заагддаг шүү дээ. Сүм зохион байгуулагдах тулгуур зарчмууд болон хүмүүс наманчлах шаардлагатай тухай бүх зүйл Мормоны Номонд маш тодорхой байдаг. Түүнээс гадна эдгээр судруудад хэрэглэгддэг ‘бүрэн байдал’ гэдэг үг ‘элбэг дэлбэг,’ эсвэл тавигдсан зорилгуудын хувьд хангалттай гэсэн утгатай юм. Хүмүүнийг Бурханы оршихуйд өргөмжлөлд буцаан авчрахад шаардлагатай бүх түлхүүр, эрх мэдэл болон зарчмуудыг бидэнд илчиллээ ч гэсэн, хүмүүс эдгээрийг дуулгавартай дагалала ч гэсэн, бидний итгэл, дуулгавартай байдал дутмагийн улмаас хараахан илчлээгүй байгаа, илчлэгдэх учиртай үнэний олон зарчим бас л байгаа шүү дээ” гэжээ. (3 Нифай 26:8–9-ийг үз.)

Сургаал ба Гэрээ 42:18—Аллага, уучлагдашгүй нүгэл

“Хоёр дахь хамгийн ноцтой нүгэл бол аллага үйлдэх-гэмгүй хүний цусыг санаатайгаар урсгах явдал мөн. Эл нүглийн талаар Их Эзэн хэлэхдээ: ‘Чи хүн алах ёсгүй. мөн хүн алсан хүнд энэ дэлхийд ч, мөн ирэх дэлхийд ч өршөөл үгүй болой’ (С ба Г 42:18) гэжээ. Тийнхүү аллагын төлөө Есүс Христ төлөөс хийж чадахгүй (эсвэл ‘цагаатгах’ буюу ‘уучлах’ боломжгүй) бөгөөд энэ бол хуулиар шийтгүүлэх ёстой уучлагдашгүй нүгэл юм. Гэвч энэ нүгэл нь, нүгэл үйлдэгч эцэстээ өөрийнхөө амиар бүрэн төлөөс хийснээр, уучлалын байдлыг олж, уучлагдах нүгэл болдог. Энэ нүгэл уучлагдашгүй байдгийн нэг шалтгаан нь, уучлал наманчлал дээр үндэслэдэг атал аллага үйлдэгч нь нүглээ бүрэн наманчлах боломжгүй байдаг, учир нь бүрэлгэсэн амийг тэрээр нөхөн төлөх боломжгүй юм” гэжээ (Даниел Х.Людлоу, *A Companion to Your Study of Book of Mormon* [1976], 222).

Сургаал ба Гэрээ 42:30–39—Өргөлийн хууль

Ямар нэг юмыг “өргөл болгох” гэдэг нь түүнийг аль нэг тодорхой зүйлд зориулах гэсэн утгатай юм. Бүх юмс Их Эзэнийх бөгөөд бидэнд Түүний өгсөн юм болгон нь дэлхий дээр Түүний хаант улсыг байгуулахад туслахын төлөө ашиглагдах ёстойг өргөлийн хууль заадаг (С ба Г 104:11–18-ыг үз). Сүмийн эхэн үед энэ хуулиар амьдрахаар сонгосон гишүүд мөнгө, өмч хөрөнгөө бишопт өргөл болгон өгч, оронд нь хариуцах ажил үүрэг (мөнгө, өмч хөрөнгө болон хариуцах үүрэгт ажлууд) хүлээн авдаг байв. Бишопоос хүлээн авсан зүйлүүд хүмүүсийн өөрсдийнх нь өмч болдог байсан аж. Гишүүд хүлээн авсан зүйлсээ өөрсдийн хэрэгцээг хангахад ашигладаг байлаа. Тэд юуг ч үйлдвэрлэн бүтээлээ гэсэн, хэрэгцээнээсээ илүү гарсныг нь ядуучууд, гачигдалтай хүмүүст туслахын тулд бишопт эргүүлж өгдөг байв (С ба Г 42:30–39; 51:2–9-ийг үз). Аминч үзлийг даван туулж, селестиел хаант улсад амьдрахад өөрсдийгөө бэлтгэхэд нь гишүүдэд туслахын тулд өргөлийн хууль өгөгджээ (Моисе 7:16–19-ийг үз).

Сүмийн зарим гишүүд “Нэгдсэн Журам” хэмээн нэрлэгддэг байсан хамтын нийгэмлэгт амьдрахыг хэсэг хугацаанд оролдсон боловч энэ хуулиар бүрэн амьдарч чадаагүй юм (С ба Г 105:1–5, 9–13-ыг үз). Өнөөдөр аравны нэг, мацгийн өргөл, Сүмийн халамжийн хөтөлбөр, Сүмийн дуудлага, гэрийн болон айлчлагч багшийн ажил нь өргөлийн хуулиар амьдрахад бэлтгэхэд бидэнд тусалдаг (С ба Г 119-р хэсгийн тоймыг үз). “Өргөл бол хүн цаг зав, авьяас билиг, эд

хөрөнгөө сүнслэг болон материаллаг байдлын талаар гачигдалтай хүмүүсийг халамжлах, Их Эзэний хаант улсыг байгуулахад зориулах явдал мөн. Халамжийн Үйлчлэлээр гишүүд үйлдвэрлэлийн төслүүдэд ажиллан, Дезерет Индастрид (хандивласан эд зүйлсийг хямд үнээр худалддаг, Сүмийн эзэмшлийн дэлгүүрүүд) эд юмс хандивлаж, мэргэжлийн авьяас чадвараа хуваалцан, мацгийн өгөөмөр өргөл өгч, тойргийн болон чуулгын үйлчлэлийн төслүүдэд оролцдог. Тэд цаг заваа гэрийн болон айлчлагч багшийн заалтад зориулдаг. Бид бие сэтгэл бүхнээ зориулснаар бие сэтгэлээ өргөл болгож байгаа хэрэг” гэж Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл сургажээ (In Conference Report, 1977 оны 10-р сар, 124; *Ensign*, 1977 оны 11-р сар, 78).

Сургаал ба Гэрээ 42:46—Үхэл хэрхэн “тааламжтай” байх вэ?

“Үхэл хагацлын нөгөө талд гэр бүлээрээ дахин уулзаж учрахын агуу баяр хөөр байдгийг бид санах ёстой. Ийнхүү хүмүүс хагацаж, тусгаарлагдсанаар тэд эргэн уулзаж, гэртээ харьж байгаа явдал мөн. Бид энэ үед ‘нас нөгчсөн тэднийг алдсаныхаа төлөө’ уйлдаг, учир нь Их Эзэн бидэнд ийн зарлиг болгосон юм (С ба Г 42:45-ыг үз). Гэвч Их Эзэний ивээлд нас барсан хүмүүс ‘үхлийг үл амсана, учир нь энэ нь тэдэнд тааламжтай байх болно’ (С ба Г 42:46) хэмээн өгүүлдэг Тайтгаруулагчаар дамжуулан бид бас агуу тайтгарлыг хүлээж авдаг” гэж Ерөнхийлөгч Езра Тафт Бенсон сургажээ (*The Teachings of Ezra Taft Benson* [1988], 33).



Үхэл харамсал гунигтай ч гэсэн, зөв шударга хүмүүсийн хувьд аймаар юм биш.



“Чи эхнэрээ бүх зүрх сэтгэлээрээ хайрлаж, өөр хэнтэй ч биш, зөвхөн түүнтэй нэгдэн нийлэх ёстой” (С ба Г 42:22).



Мацгийн өгөөмөр хандиваар дамжуулан бид гачигдалтай хүмүүст өгч чадна.



Өвчтэй хүмүүсийг адислахад Сүмийн ахлагч нарыг уриалдаг.

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 42-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа Б буюу В, эсвэл үйл ажиллагаа А буюу Г-г хий.

А Илчлэлт хүлээж авах загвар

Хэрэв Түүний Сүмийн ахлагч нар тодорхой зүйлүүдийг хийх юм бол, тэд эрж хайж байсан илчлэлтүүдээ хүлээж авах болно гэдгийг Их Эзэн Сургаал ба Гэрээ 42:1–3-т амлажээ (энэ бол 42-р хэсэг юм).

1. Шүлэг 1–3-ыг судалж, энэ илчлэлтийг тэд хүлээж авахад Их Эзэн ямар шаардлагууд тавьсныг жагсаан бич.
2. Гэр дотроо Их Эзэнээс илчлэлт хүлээж авахад эдгээр шаардлагууд танд хэрхэн тусалж болох вэ?

Б Нэг чухал санааг сонго

Сургаал ба Гэрээ 42 Гэгээнтнүүдэд зориулсан олон төрлийн заавар агуулдаг. Дараах зургаан бүлэг шүлэг тус бүрийг нэгтгэн дүгнэ. Нэг зааврыг сонгож, өнөөдөр уг заавар гишүүдэд хэчнээн чухал болохыг тайлбарла:

1. Шүлэг 11–17
2. Шүлэг 18–29
3. Шүлэг 30–39
4. Шүлэг 40–52
5. Шүлэг 61–69
6. Шүлэг 74–93

В Сион юутай адилхан байна гэж та боддог вэ?

Их Эзэн Сургаал ба Гэрээ 42:9, 16–55-д Шинэ Иерусалимд амьдрах Өөрийнх нь хүмүүсийн амьдрал ямархуу байхыг тайлбарлажээ. Дээрх шүлгүүдийг уншаад, дараах үйл ажиллагаануудаас нэгийг хий:

1. Хэрэв та ийм нийгэмд амьдрах юм бол амьдрал хэрхэн өөр байна гэж боддогоо дүрсэл. Энэ тухай наад тал нь долоон жишээг харуулж, жишээ бүрийн талаарх шүлгийн дугаарыг жагсаан бич.
2. Та Шинэ Иерусалимд амьдарч байгаа бол амьдралын чинь нэг өдөр ямар байхыг дүрсэлсэн өдрийн тэмдэглэлтэй адилхан нэг түүх бич. Танай гэр орон, нийгэм хамт олон, сургуулийн тань амьдрал ямар байхыг уг түүхэнд өгүүлж, ашигласан жишээ бүрийнхээ талаарх шүлгийн дугаарыг тавь.

Г Схемийг бөглө

Их Эзэн Сургаал ба Гэрээ 42:61–68-д асуух гэдэг үгийг гурвантаа хэрэглэжээ. Доорхтой адил схемийг тэмдэглэлийн дэвтэртээ зурж, бөглөхийн тулд дээрх шүлгүүдийг судал.

Сургаал ба Гэрээ 42	Юу асуух вэ?	Үүнийг мэдэх нь яагаад чухал вэ?
Шүлэг 61		
Шүлэг 62		
Шүлэг 68		

Сургаал ба Гэрээ 43

Их Эзэн бидэнд хандан
ярьдаг арга замууд

Бошиглогч Иосеф Смит Сургаал ба Гэрээ 43-р хэсэг дэх илчлэлтийг хүлээн авах үед Сүм байгуулагдаад бүтэн жил ч болоогүй байлаа. Илчлэлт хүлээн авдаг үйл явц, журмыг олон гишүүн ойлгодоггүй байв. Илчлэлтийн тухай Их Эзэн өмнө нь заасан (С ба Г 21; 28; 42-ыг үз) боловч, тэдгээр илчлэлтүүд хараахан хэвлэгдээгүй, мөн өргөн хэмжээгээр хүртээмжтэй болоогүй байв. Үүний улмаас, төөрөгдөл, тэр ч байтугай залилан мэхлэхэд хүргэдэг байсан алдаа завхрал үе үе гардаг байж. Жишээ нь: Энэ илчлэлт өгөгдөхийн өмнөхөн Огайогийн Кертландад нэг эмэгтэй өөрийгөө бошиглогч хэмээн мэдэгдэж, Сүмийн олон хүнийг өөрийнхөө сургаал, бошиглолдууд гэгчид итгүүлэн дагуулах гэж оролдсон аж.

Сургаал ба Гэрээ 43-р хэсгийг уншихдаа, Сүмд илчлэлт хэрхэн өгөгддөг талаар, мөн гишүүн бүрийн үүргийн талаар Их Эзэн юу гэж хэлснийг эрж ол. Их Эзэн бошиглогчдоор дамжуулан ярихаас гадна дэлхийд хандан ярьдаг арга замуудын тухай юу гэж хэлснийг, мөн Тэрээр Өөрийнхөө захиасыг сонсохыг биднээс яагаад хүсдэг шалтгаануудыг бас ажигла.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 43

Бодлого (хэсгийн тойм)—
Удирдлага

Хаалганд орох (ш. 7)—
Баптисм хүртэж, Их Эзэний
бусад зарлигуудыг дагах

Өөрсдөлөө үүрэг хүлээх
(ш. 9)—Гэрээнд орох

Хишиг хүртээгдэх (ш.
16)—Адислагдах, бэлэг
хүлээн авах

Нойрсож буй үндэстнүүд
(ш. 18)—Нас барсан олон
хүмүүс

Бүсээ бүсэл (ш. 19)—
Өөрсдийгөө бэлтгэ

Миний зэвүүцлийн хилэн
(ш. 26)—Миний уур

Мянган (жил) (ш. 30)—
Христ дэлхий дээр хаанч-
лах мянган жилийн хугацаа

Өөрчлөгдсөн байх (ш. 32)—
Нас бараад амилуулагдах

Чанд байдал (ш. 34)—
Ариун зүйлүүд

Сургаал ба Гэрээ 43:2–5—Сүмд бүхэлд нь зориулагдсан илчлэлтийг зөвхөн Сүмийн Ерөнхийлөгч хүлээж авдаг

Сүм дэх илчлэлтүүдийн зарчмын талаар Тэргүүн Зөвлөлийн зөвлөх асан, Ерөнхийлөгч Жеймс И.Фауст тайлбарлахдаа:

“Сүмд зориулсан байнгын илчлэлт, удирдлага нь Сүмийн Ерөнхийлөгчөөр дамжиж ирдэг бөгөөд тэрээр Гэгээнтнүүдийг хэзээ ч буруу удирдахгүй.

“... Сүмийн хувь гишүүд өөрсдийн дуудлага, хариуцдаг үүрэгт ажлынхаа талаар, бас гэр бүлийнхээ талаар илчлэлт хүлээн авч болно. Тэд эрх мэдлээр өөрсдөөсөө дээгүүр хүмүүст зориулсан сүнсний удирдамж хүлээн авч чадахгүй.

“... Тогтсон журам болон санваарын сувгаас гадуур Сүмд зориулсан илчлэлтийг Бурханаас шууд хүлээн авдаг хэмээн мэдэгддэг хүмүүс буруу удирдагддаг. Энэ нь бас тэднийг дагадаг хэнд ч болов холбогдоно” гэжээ (In Conference Report, 1996 оны 4-р сар, 6; Ensign, 1996 оны 5-р сар, 7).



Өөрийн Сүмийг удирдуулахаар Бурханы дуудсан хүмүүсээр дамжин Сүмд зориулагдсан илчлэлт ирдэг.

Сургаал ба Гэрээ 43:31—Мянган Жилийн үед Сатан хүлэгдэх болно

Тэргүүн Зөвлөлийн зөвлөх асан, Ерөнхийлөгч Жорж К.Каннон: “Сатан хүлэгдэх тухай бид ярьдаг. Сатан Бурханы хүчээр хүлэгдэх болно. Гэвч тэрээр бас түүний үгийг хүмүүс сонсохгүй байхаар, түүгээр удирдуулахгүй байх явдлаар, Бурханы хүмүүсийн шийдвэр төгс байдлаар хүлэгдэх болно” гэж сургажээ (Gospel Truth: Discourses and Writings of President George Q. Cannon, эмхтгэсэн Жеррелд Л.Ньюквист, боть 2, [1957–1974], 1:86).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 43-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Чи юу гэж хэлэх вэ?

Мормоны Номыг уншаад, үнэн гэдэгт нь итгэсэн гэж хэлсэн нэг хүнтэй чи танилцжээ гэж бод. Сүнсний зарим өвөрмөц туршлагауд түүнд бас байдаг. Мөн Сүм нийтээрээ мэдвэл зохих чухал илчлэлтүүдийг тэр хүлээж авсан гэж ярьжээ. Иймэрхүү нөхцөлд хууртагдахаас чамайг сэрэмжилж чадах наад тал нь гурван зарчмыг Сургаал ба Гэрээ 43:1–7-гоос тэмдэглэлийн дэвтэртээ бичиж ав. Тэр хүнд чи юу гэж хэлэх вэ?

Б Сүмийн цуглаануудыг хэрхэн үр ашигтай болгох вэ

1. Сүмийн цуглаан болон хичээлүүдэд бид “хамтдаа цуглахад” ямар байх ёстойг Их Эзэн Сургаал ба Гэрээ 43:8–10-т заажээ. Бид юу хийх ёстой гэж Тэр хэлснийг жагсаан бич.
2. Ариун ёслолын цуглааны зорилгын талаар Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл сургахдаа: “Хэрэв та дуулж, залбиран ариун ёслолоос зохистойгоор хүртэх юм бол, дараагийн

цагийн турш, тэр ч байтугай үг хэлэгч ядмагхан байлаа ч гэсэн, шүтэн биширч, бясалган сууж чадна. Та хувийн тус нэмрээрээ цуглааныг үнэ цэнэтэй болгох нь үүрэг хариуцлага тань юм” (*The Teachings of Spencer W. Kimball*, хянан тохиолдуулсан Эдвард Л.Кимбалл [1982], 514–515). Ерөнхийлөгч Кимбаллын зөвлөгөөг анхааралдаа авч, Сүмийн цуглаануудад оролцоход танд юу тохиолддогийг Их Эзэн Сургаал ба Гэрээ 43:8–10-г дүрсэлсэн зүйлүүдээс байнга хийж болох гурван зүйлийг дүрсэл.

В Үг хэлэх олон арга зам

1. Сургаал ба Гэрээ 43:17–25-ыг судалж, дэлхийн хүмүүст хандаж Их Эзэний ярьдаг арга замуудыг жагсаан бич. Хэлэх, дуудах, дуу хоолой гэдэг үгс хоорондоо ялгаатай эдгээр арга замуудыг олоход танд туслах болно.
2. Яагаад Их Эзэн хүмүүст хандан ярих ийм олон арга замыг ашигладаг гэж та боддог вэ? Өөрийнхөө туршлагаас, түүнчлэн бусдын туршлагаас, өөр ямар арга замуудыг чи энэ жагсаалт дээр нэмж чадах вэ?

Г Зарим үнэт зүйлсийг жагсаан бич

“Эдгээр зүйлүүдийг зүрх сэтгэлдээ нөөцлөх” (С ба Г 43:34) тухай Их Эзэний зөвлөгөөний талаар бодож, өөрийнхөө тогтоохыг хүсдэг гурван сургаалыг Сургаал ба Гэрээ 43-р хэсгээс жагсаан бич. Эдгээр сургаал бүрийг яагаад сонгосноо тайлбарла. Сургаалуудыг гэр бүлийн нэг гишүүн эсвэл найзтайгаа хуваалц.

Сургаал ба Гэрээ 44

Чуулганы зорилго



Чи өөрийгөө Сүм дээр байна гэж, мөн хоёр долоо хоногийн дараа гадасны чуулган болно гэж зарлалаа гэж бод. Нэг найз чинь чам руу бөхийж, “Би Сүм дээр тогтмол болдог гадасны чуулганы цуглаануудыг таслах ёстой дургүй. Ингэхэд яагаад бид гадасны цуглаан хийдэг юм бэ?” гэж асуужээ. Чи ямар тайлбар өгөх вэ? Сургаал ба Гэрээ 44-р хэсэгт, чуулганд хамтдаа цуглаж байхыг Их Эзэн Сүмд зарлиг болгосон байдаг. Үүний шалтгаан бас Түүний амласан адислалууд өнөөдөр ч гэсэн манай

тойрог, салбар, гадас, дүүрэг, номлолын болон ерөнхий чуулгануудын хувьд үнэн зөв хэвээр байна.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 44

Сургаал ба Гэрээ 44:2–5—Чуулганы адислалууд

Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч асан, Ховард В.Хантер хэлэхдээ: “Чуулганы үе бол, мэдлэг ба гэрчлэл өсөн нэмэгдэж, Бурхан амьдардаг бөгөөд итгэл бишрэлтэй хүмүүсийг адислах нь батаждаг сүнсний сэргэлтийн цаг мөн. Энэ нь Есүс Христ бол амьд Бурханы Хүү мөн гэдэг ойлголт, түүнд үйлчлэх, зарлигуудыг нь сахихад шийдвэр төгс байдаг хүмүүсийн зүрх сэтгэлд шатаж байдаг цаг үе юм. Чуулган бол амьдралаа авч явахад сүнслэгээр нөлөөлөгдсөн чиглүүлгийг бидэнд өгдөг цаг үе-илүү сайн нөхөр, эхнэрүүд, эцэг эхчүүд, илүү дуулгавартай хөвгүүд охид, бүр сайн найз нар болон хөршүүд байхад сэтгэл догдлом, шийдэмгий байдлыг харуулдаг цаг мөн” гэжээ (In Conference Report, 1981 оны 10-р сар, 15; *Ensign*, 1981 оны 11-р сар, 12).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 44-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Чуулганы хүч

1. Сургаал ба Гэрээ 44:1–5-д өгүүлснээр, хэрэв чуулганд хамтдаа цуглах тухай түүний зарлигийг ахлагч нар итгэлтэйгээр дагасан тохиолдолд, Их Эзэн тэдэнд ямар амлалт өгсөн бэ? Өнөөдөр манай чуулгануудад энэ амлалтууд хэрхэн биелэгдэж болох вэ?
2. Тойрог, гадасны чуулган, ерөнхий чуулган дээр хэлсэн эсвэл хийсэн зүйлийн улмаас та адислагдсан, эсвэл сүнслэг байдлын хувьд өссөн үеийнхээ тухай бичнэ үү. Эсвэл тойрог, гадасны чуулган болон ерөнхий чуулганы үед өгөгдсөн зарим чухал захиасын талаар товч илтгэл бич.

Сургаал ба Гэрээ 45

Есүс Христийн Хоёр дахь ирэлт

Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн тухай бодох үед танд ямар санагддаг вэ? Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит: “Бид тэр үеийг хүсэн хүлээж байна. Бид тэр цагт найдаж, тэр үеийн төлөө залбирдаг. Христийг ирэхэд зөв шударга хүмүүс баясах болно. Учир нь тэр үед дэлхийд амар амгалан, хүмүүст зөв шударга ёс ирнэ” гэжээ (Doctrines of Salvation, 3:14).

Хоёр дахь Ирэлтийн тухай их зүйлийг Сургаал ба Гэрээ 45-р хэсэг илчилдэг. Сүмийн талаар олон худал хуурмаг зүйл яригдаж, бичигдэж, гишүүдийг мөрдөн хавчиж байсан үед энэ илчлэлт Гэгээнтнүүдэд баяр баяслыг авчирсан юм хэмээн Бошиглогч Иосеф Смит хэлжээ (С ба Г 45-р хэсгийн тоймыг үз). Илчлэлтийг уншихдаа үүний захиасууд мөрдлөг хавчлагын үед баяр баяслыг хэрхэн авчирч болохыг авч үз. Хүнд сорилтын үед эсвэл таны тухай, шашны тань тухай бусад хүмүүс цуурхал тарааж байгаа үед уг илчлэлт танд баяр баяслыг хэрхэн авчирч болох вэ?



Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 45

Гэтэлгэл (шүлэг 17, 46)—
Чөлөөлөлт

Сэргээлт (ш. 17)—Хуучин
байдлаар нь сэргээх, цуг-
луулах

Алдас газар авах болно (ш.
27)—Нүгэл маш ихсэх болно

Цээрлүүлэлт (ш. 31)—
Үлэмж устгал буюу гай
зовлон

Энэ газар (ш. 43)—
Иерусалим (Есүс анх удаа

энэ номлолыг өгөхөд
Түүний байсан газар)

Энэ уул (ш. 48)—
Иерусалим руу харсан
Чидуны Уул

Элэглэгч (ш. 50)—Ариун
зүйлүүдийг жигшин
зэвүүцдэг хүн

**Бурханыг мэддэггүй
үндэстнүүд** (ш. 54)—
Христийн сайн мэдээг сон-
соогүй хүмүүс

Сургаал ба Гэрээ 45:22-23—“Дэлхийн төгсгөл”

Иосеф Смит-Матай 1:4-т өгүүлснээр, “дэлхийн төгсгөл” нь ёс бусчуудын устгалыг хэлж байгаа болно.

Сургаал ба Гэрээ 45:23-26—Энэ бошиглолд түүхийн ямар үеүдийг өгүүлсэн байна вэ?

Есүсийн эртний шавь нарын асуусан хоёр асуултыг бид мэддэг байх юм бол Сургаал ба Гэрээ 45:16-59-д Есүс Христийн заасан зүйлүүд илүү тодорхой ойлгогддог. Нэгдүгээрт: Иерусалимын ариун сүм хэзээ устгагдах цагийн тухай тэд мэдэхийг хүссэн юм. Хоёрдугаарт: Есүсийн Хоёр дахь Ирэлтийн тухай, ёс бусчууд хэзээ устгагдахыг, мөн Христ Хаадын Хаан болж, хэзээ хаанчлахыг мэдэхийг тэд хүссэн ажээ (Матай 24:3; Иосеф Смит-Матай 1:4-ийг үз). Энэ хоёр

үйл явдал нэгэн цаг үед тохиох болно гэж Түүний шавь нар боддог байж, харин энэ хоёр үйл явдал өөр өөр цаг үед тохиох болно гэж Есүс сургажээ. Сургаал ба Гэрээ 45:18-21-д ариун сүм устгагдах тухай Аврагч ерөнхийд нь заажээ. Шүлэг 22-24-т энэ хоёр асуултын хоорондын холбоог Тэрээр тайлбарласан байдаг. Шүлэг 25-53-т эцсийн өдрүүд болон Хоёр дахь Ирэлтийн тухай бошиглалууд байдаг, харин шүлэг 54-59 нь Мянган жилийн тухай, өөрөөр хэлбэл, Христ дэлхий дээр хаанчлах мянган жилийн үеийн тухай юм.

Сургаал ба Гэрээ 45:25-31—“Харийнханы цаг”

Ерөнхийлөгч Езра Тафт Бенсон сургасан нь:

“Бидний амьдарч байгаа цаг үеийг ‘Харийнханы цаг’ хэмээн Их Эзэн нэрлэжээ. Харь үндэстнүүд гэдэг нь Христийн шүтлэгтэй үндэстнүүд-бидний гарал үүсэл тэднээс эхтэй-Хойд, Өмнөд Америк, Европын үндэстнүүд юм. ‘Харийнханы цаг нь’ сайн мэдээ дэлхийд сэргээгдсэн үеэс (1830) сайн мэдээг Харийнхан эсэргүүцсэний дараа, сайн мэдээг иудейчүүдэд дахин номлох цагийг хүртэл үргэлжлэх цаг хугацаа юм. Их Эзэн үүнийг хэрхэн тайлбарласныг авч үзье:

“Мөн Харийнханы цаг ирэхэд, харанхуйд суугч тэдний дунд гэрэл гийх болно, мөн энэ нь миний сайн мэдээний бүрэн байдал байх болно;

“Гэвч тэд үүнийг хүлээн авах нь үгүй. Учир нь тэд гэрлийг хүртэх нь үгүй, мөн хүмүүний дүрмүүдийн улмаас тэд зүрх сэтгэлээ надаас буруулдаг.

“Мөн тэр үед Харийнханы цаг гүйцэлдэнэ.” (С ба Г 45:28-30; налуу бичлэг нэмэгдсэн.)

“Харийнханы цаг гүйцэлдэх нь хэрхэн ойртож байгааг бид доорх тэмдгүүдээр мэдэж болно:

“Тэр өдөр дайнууд болон дайнуудын цуурхал сонсогдох болно, мөн бүх дэлхий үймээн самуунд байж болно, хүмүүний зүрх сэтгэл мохох болно, дэлхийн төгсгөлийг хүртэл Христ ирэлтээ хойшлуулна хэмээн тэд хэлнэ.

“Мөн хүмүүний хайр хөрч, алдас газар авна.” (С ба Г 45:26-27.)

“Хаант улсын энэ сайн мэдээ дахин бүх дэлхийд, бүх үндэстнүүдэд гэрчлэл болон номлогдох болно, тэгээд төгсгөл, эсвээс ёс бусчуудын устгал ирнэ” (ИСО, Матай 24:32-ыг үз).

“Энэ тэмдгүүд гүйцэлдэж байгааг өнөөдөр бид гэрчлэхгүй гэж үү? Улс үндэстнүүд манай номлогчдыг эх орондоо нэвтрэхийг зөвшөөрч байгаагаар сайн мэдээ бүх дэлхийд хүрч байна. Сүм өсч, цэцэглэн хөгжиж байна. Бүх хүмүүний аюултай дайсан Сатан огтхон ч саарахгүй байгаа хилэгнэлээр, бас цаг нь дуусах ойртож байгаад сэтгэл түгшин- бидний дээдэлдэг бүхнийг устгахыг оролдож байна” (“Prepare Yourself for the Great Day of the Lord,” *New Era*, 1982 оны 5-р сар, 47).

Сургаал ба Гэрээ 45:32—“Ариун газрууд”



Хэрэв шавь нар нь ариун газруудад байх юм бол, тэд эцсийн өдрүүдийн бүх аймшигт шүүлүүдийг амсахгүй байх болно хэмээн Аврагч хэлжээ. Эл ариун газрууд нь юу вэ? “Ариун эрэгтэйчүүд, ариун эмэгтэйчүүд ариун газруудад байдаг, мөн энэхүү ариун газрууд бол манай ариун

сүм, манай шүтээний байрууд, бидний гэр орон, түүнчлэн Сионы гадаснууд юм” гэж Ерөнхийлөгч Езра Тафт Бенсон сургажээ (Come unto Christ [1983], 115).

Гэгээнтнүүдийн цугларалтын тухай, Сион үндэслэн байгуулагдах тухай Түүний заасан Сургаал ба Гэрээ 45:64–71-д эдгээр ариун газруудын талаар Их Эзэн илүү их зүйлийг илчилжээ.

Сургаал ба Гэрээ 45:60–61—Иосеф Смит Шинэ Гэрээг орчуулсан уу?

Сургаал ба Гэрээ 45:60–61 Хаан Жеймсийн Библийн Иосеф Смитийн Орчуулгын тухай өгүүлдэг. (Дэлгэрэнгүй мэдээллийг Сургаал ба Гэрээ 35:20–21-ийн (х. 47 “Судруудыг ойлгох нь” хэсэг; Судруудын Удирдамж, “Иосеф Смитийн Орчуулга,” х.105-аас үз).

Сургаал ба Гэрээ 45:68—Сион гэж юу вэ?

Сионы тухай мэдээллийг “Сургаал ба Гэрээ дэх Хүмүүс ба нэр томьёонууд” (х 244-аас үз).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 45-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас гурвыг хий.

А Та яагаад сонсох ёстой вэ?

1. Их Эзэнийг сонсоход биднийг урьдаг (мөн сонсох урилга болох “анхаарагтун,” “сонсогтун,” “чихээ хандуулагтун” гэсэн үгс, өгүүлбэрүүдийг эрж ол) үгс, өгүүлбэрүүдийг Сургаал ба Гэрээ 45:1–15-аас эрж олон тэмдэглэ. Түүнийг сонсоход биднийг эхчнээн удаа урьсан байна вэ?
2. Түүнийг сонсох сайн учир шалтгааныг бидэнд өгдөг юуг эдгээр шүлгүүд Есүс Христийн тухай заасныг жагсаан бич.
3. Жагсаан бичсэн жагсаалтаасаа нэг шалтгааныг сонгож, яагаад эл шалтгаан чамд чухал болохыг тайлбарла.
4. Их Эзэнийг сонсох нь хэдийд хамгийн хэцүү байдаг гэж чи боддог вэ? Амьдралдаа Түүнийг илүү сайн сонсоход жагсаалт чинь чамд хэрхэн туслах вэ?

Б Мэдээллийг зохион байгуулж, амьдралдаа хэрэгжүүл

1. Сургаал ба Гэрээ 45:16–59-д Аврагчийн өгүүлсэн гол цаг үе тус бүрд зориулсан баганатай дараах схемийг тэмдэглэлийн дэвтэртээ зур. Багана тус бүрд тухайн цаг үед юу тохиох болно хэмээн Түүний хэлсэн зүйлүүдийг бич.

Сургаал ба Гэрээ 45-д бошиглосон үйл явдлууд

Есүсийн Төлөөлөгчдийн үе	Харийнханы цаг үе	Хоёр дахь Ирэлтийн цаг үе	Мянган Жилийн үе

2. Их Эзэн энэ мэдээллийг яагаад бидэнд өгсөн гэж та боддог вэ?
3. Энэ илчлэлт таны амьдралд чухал ач холбогдолтой байж болох наад тал нь хоёр өөр арга замыг тайлбарла.

В Захиаст дүн шинжилгээ хий

Хэлсэн зүйлийнх нь улмаас шавь нар нь тэвдэн сандарсан гэж Есүс хэлжээ (С ба Г 45:34-ийг үз).

1. Сургаал ба Гэрээ 45:26–34-ийг нэгтгэн дүгнэж, шавь нарыг нь тэвдэн сандрахад хүргэсэн байж болох юуг Есүс хэлснийг жагсаан бич.
2. Шүлэг 35–44-ийг нэгтгэн дүгнэ. Бошиглосон үйл явдлуудыг нь үл харгалзан, “тэвдэн сандрахгүй байх” (ш. 35) тайвшруулсан ямар шалтгаануудыг Есүс шавь нартаа хэлсэн бэ?

Г “Агуу зүйлүүд та нарыг хүлээж байна”

Танай бишоп эсвэл салбарын ерөнхийлөгч эцсийн өдрүүд болон Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн тухай үг хэлэхийг өөрөөс чинь хүсчээ гэж бод. Эцсийн өдрүүдийн сөрөг талуудад олон хүмүүс анхаарал төвлөрүүлдгийг тэр хэлээд, зөв шударга хүмүүсийн хүсэн хүлээж болох эерэг үйл явдлуудыг онцгойлон анхаарахыг чамаас хүсчээ. Аврагчийг ирэхэд баяр баяслаар угтахад бэлтгэхийн тулд бид юу хийж чадах талаар онцгойлон анхаарахыг тэр бас чамаас хүссэн аж. Хэлэх үгэндээ оруулахыг хүссэн санаануудыг Сургаал ба Гэрээ 45-р хэсгээс жагсаан бич. Эдгээр санаа тус бүрийг агуулдаг шүлгүүдийг тэмдэглэ.



Д Ёс бус байдлаас хамгаалах хамгаалалт

1. Сургаал ба Гэрээ 45:32-г өгүүлснээр, Их Эзэний шавь нар эцсийн өдрүүдийн ёс бус бусармаг явдлуудаас хэрхэн зайлсхийж чадах вэ?
2. Шүлэг 62–71-д Их Эзэн өөр ямар мэдээллийг өгсөн бэ?
3. Сургаал ба Гэрээ 115:5–6-д Их Эзэний хэлсэн зүйлүүдээс өөр юуг та энд нэмж болох вэ?
4. Сүм таны хувьд “амар амгалан,” “аюулгүй байдлын,” эсвэл “хоргодох” газар байх арга замуудын тухай бичнэ үү.



Сэргээгдсэн Сүмд эхний жилүүдэд сэтгэл нь догдолсон, шийдвэр төгс гишүүд олон байсан боловч, Их Эзэний арга замуудын талаар туршлагагүй хүмүүс бас байсныг та өмнө нь мэдсэн билээ. Их Эзэн Өөрийнхөө Сүмд ажил хэрэг хэрхэн явагддаг байхыг хүсч байсан талаар эдгээр гишүүдэд удирдамж хэрэгтэй байлаа. Цуглаануудыг хэрхэн хөтлөн явуулах, итгэлтнүүдэд амлагдсан Ариун Сүнсний янз бүрийн бэлгүүдийг хэрхэн ойлгох тухай асуултууд болон эргэлзээ тээнэгэлзээнд хариулт болж, Сургаал ба Гэрээ 46-р хэсэг хүлээн авагдсан ажээ. Эдгээр бэлгүүд өгөгддөг арга зам, янз бүрийн бэлгүүдийн жишээ, мөн эдгээр бэлгүүдийг хэрхэн ашиглах тухай зааврууд энэ илчлэлтэд байдаг.



Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 46

Дахин засрах (ш. 4)—
Наманчлах

хичээсэн шалтгаанаар
ямар нэг зүйлийг хийх

Шуналт хүслээрээ үрчи-
хэж болох (ш. 9)—Амиа

Сургаал ба Гэрээ 46:11—Хүн бүрд ямар нэг бэлэг өгөгддөг

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Марвин Ж.Аштон хэлсэн нь:

“Амьдралын хамгийн нэгэн эмгэнэлт явдал нь, миний бодоход, хүн өөрийгөө ямар ч авьяас чадваргүй гэж үзэхэд бий болдог болов уу. Жигшил зэвүүцэл, урам хугаралт ирэхэд, бид өөрсдийнхөө үнэлэмжийг үлэмж бууруулж, цөхрөл гутралд хүрэхэд энэ нь бидний хувьд, бас Бурханы мэлмийд хар өдөр болдог. Бид өөрсдийгөө биений өндөр, оюун ухаан, хичээл сургуулийн дүн, эд хөрөнгө, эрх мэдэл, ажил алба, нийгмийн байдлаараа, эсвэл гадаад төрхөөрөө үнэлж дүгнээд, авьяас чадваргүй гэж үзэх нь зөвхөн шударга бус төдийгүй, бас үндэслэлгүй юм. . . .

“Бурхан хүн нэг бүрд нэг буюу түүнээс дээш тусгай авьяас чадварыг өгсөн байдаг. . . . Бурханаас өгсөн бэлгүүдийг танин мэдэж, түүн дээрээ өөрсдийгөө хөгжүүлэх нь бидний хүн нэг бүрийн үүрэг юм. Бид бүгдээрээ Бурханы дүр төрхөөр бүтээгдсэнийг, чухал биш хүмүүс гэж ерөөсөө байдаггүйг бид санах ёстой. Хүн бүхэн Бурханд бас нөхдөдөө үнэ цэнэтэй юм” (In Conference Report, 1987 оны 10-р сар, 23; *Ensign*, 1987 оны 11-р сар, 20).

Сургаал ба Гэрээ 46:11-29— Энэ Сүнсний бэлгүүдийн бүрэн жагсаалт мөн үү?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Брус Р.МкКонки, “Сүнсний бэлгүүд нь тоогоороо эцэс төгсгөлгүй, төрөл зүйлээрээ хязгааргүй юм. Илчлэгдсэн үгэнд жагсаан бичсэн авьяас билгүүд бол нигүүлсэнгүй Бурхан өөрийг нь хайрлаж, өөрт нь үйлчилдэг хүмүүст юулсан хязгааргүй бурханлиг ач ивээлийн энгийн жишээ юм” гэж тэмдэглэжээ (*A New Witness for the Articles of Faith* [1985], 371). Сургаал ба Гэрээ 46-р хэсгээс гадна, сүнсний бэлгүүдийн жагсаалт 1 Коринт 12, Моронай 10-т байдаг.

Төдийлөн яриад байдаггүй зарим бэлгүүдийн тухай Ахлагч Марвин Ж.Аштон: “Асуухын бэлэг; сонсохын бэлэг; намуухан, зөөлөн дуу хоолойг анхааран сонсож, ашиглах бэлэг; уйлж чаддаг байх бэлэг; зөрчилдөөнөөс зайлсхийх бэлэг; зөвшин тохиролцох бэлэг; хоосон давтахаас зайлсхийх бэлэг; зөв шударга зүйлийг эрж хайх бэлэг; бусдыг шүүхгүй байх бэлэг; Бурханаас удирдамж эрэлхийлэх бэлэг; шавь байх бэлэг; бусдыг халамжлах бэлэг; тунгаан бодох боломжтой байх бэлэг; залбирал хэлэх бэлэг; хүчтэй гэрчлэл хэлэх бэлэг; бас Ариун Сүнс хүлээн авах бэлэг” байдгийг жагсаан бичжээ (In Conference Report, 1987 оны 10-р сар, 23; *Ensign*, 1987 оны 11-р сар, 20).

Сургаал ба Гэрээ 46:15—“Үйлчлэлийн ялгаанууд”
“Үйлчлэлийн ялгаанууд” нь Сүм дэх санваартны удирдагчдын үйлчлэлд хамаарна.

Сургаал ба Гэрээ 46:16—“Үйл ажиллагааны олон янз байдал”

“Үйл ажиллагааны олон янз байдлыг” мэдэх нь сүнсний илэрхийллүүд Их Эзэнийх мөн эсэхийг ялган таних явдал мөн (мөн Иосеф Смит-Матай 1:22-ыг үз).

Сургаал ба Гэрээ 46:24-25—Хэлний бэлэг ба хэлийг хөрвүүлэх бэлэг

Номлогчид гадаад хэл сурч, сонирхогчид нь заагдаж байгаа сайн мэдээг ойлгож, гэрчлэлтэй болох номлолын ажлын явцад эдгээр бэлгүүд Сүм дээр олонтаа нотлогддог. Бошиглогч Иосеф Смит сургахдаа: “Өөр хэлээр ярьдаг хүмүүсийн дунд Пентекостын өдөр (Төлөөлөгчид Ариун Сүнсээр дүүрч, хэлүүдээр ярьсан үе) адил номлох зорилгоор хэл өгөгддөг ба Сүм дээр хэлийг заах шаардлага байдаггүй. Учир нь Ариун Сүнстэй ямар ч хүн Бурханы юмсын талаар төрөлх хэлээрээ ярьж байгаа лугаа адил өөр хэл дээр ярьж чадах бөгөөд итгэл нь тэмдгүүдээр бус, харин Бурханы үгийг сонссоноор ирдэг” гэжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, 148-149).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 46-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Их Эзэний хариуг ол

1. Сургаал ба Гэрээ 46-р хэсгийн тоймыг унш. Энэ илчлэлтэд Их Эзэн юуны талаар зөвлөгөө өгөхийг хүссэн бэ?
2. Шүлэг 1–8-д өгүүлснээр, эдгээр асуудлын талаарх Их Эзэний зөвлөгөө юу вэ?
3. 3 Нифай 18:28–32-т Их Эзэний заасан зүйлүүдээс бид өөр ямар мэдээлэл олж авч болох вэ?

Б Сүнсний бэлгүүдийг ойлгоход шинэ гишүүдэд туслах нь

Сургаал ба Гэрээ 46-р хэсэгт тайлбарласан Сүнсний бэлгүүдийг ойлгоход нь Сүмийн шинэ гишүүдэд хэрэгтэй гэж бодсон гурван санааг бич. Эдгээр санаа бүрийн дотроос нь олсон шүлгүүдийг тэмдэглэж, чи яагаад уг санааг сонгосноо товч тайлбарла.

В Бэлгүүдийг эрэлхийлэх нь

1. Сургаал ба Гэрээ 46:8–12-оос, Сүнсний бэлгүүдийн тухай юуг ойлгохыг Их Эзэн биднээс хүсдэгийг жагсаан бич.
2. Шүлэг 13–27-д дурдсан Сүнсний бэлгүүдийг, мөн “Судруудыг ойлгох нь” хэсгийн шүлэг 11–29-д Ахлагч Аштоны нэрлэсэн сүнсний бэлгүүдийг авч үз. Өөртөө байгаасай гэж хүсдэг хоёр бэлгийн тухай бич. Яагаад энэ бэлгүүдийг өөртөө байгаасай гэж хүсдэгийг тайлбарлахдаа-шүлэг 8–12-т Их Эзэний хэлсэн үгсийг сана.

Сургаал ба Гэрээ 47 Сүмийн түүхчийн дуудлага

Сүм зохион байгуулагдсан өдрөөс эхлэн, цэдэг, түүх хөтлөхийг Их Эзэн зарлигджээ (С ба Г 21:1-ийг үз). Хөтлөгдсөн ном болон цэдгүүдээр бид шүүгдэх болно гэдгийг судрууд заадаг (Илчлэлт 20:12; С ба Г 128:7-г үз). Үнэн зөв түүх нь Адамын үеэс хойш сайн мэдээг заах болон гэрчлэлийг төлөвшүүлэх чухал эх сурвалж байсаар ирсэн билээ (Мосе 6:5–6, 45–46; 1 Нифай 3:19–20; Мозая 1:2–5-ыг үз). Сургаал ба Гэрээ 47-р хэсгийг уншихдаа, Сүмийн түүхч байх Жон Витмерийн дуудлага чухал түүхүүдийг хөтлөхөд танд хэрхэн холбогдохыг бод.

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 47-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Юу бичихээ мэдэх нь

1. Сургаал ба Гэрээ 47-р хэсэгт өгүүлснээр, Түүхэнд юу бичихээ Жон Витмер хэрхэн мэдсэн бэ?
2. Хэн нэгэн хүн түүхийн цэдэг хөтөлснөөс та ямар замаар адислагдсан бэ?
3. Өөрийн чинь бичсэн цэдэг бусад хүмүүст ямар замаар адислал болж болох вэ?



“Насан туршид үргэлжлэх тэмдэглэл хөтөл, . . . ингэснээр тэнгэр элчүүд үүрд мөнхөд үүнээс иш татаж болно. Өнөөдөр эхэл, тэгээд тэмдэглэлдээ өдөр тутмын үйл ажиллагаагаа, хамгийн гүн гүнзгий бодол санаагаа, ололт амжилтаа бас бүтэлгүйтлээ, хэлхээ холбоо болон гарамгай амжилтаа, сэтгэгдэл ба гэрчлэлээ бич” хэмээн Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл зөвлөжээ (“Angels May Quote from It,” “New Era, 1975 оны 10-р сар, 5).

Сургаал ба Гэрээ 48

Көртландад газар худалдаж авсан нь

1830 оны арванхоёрдугаар сард өгөгдсөн илчлэлтэд хариулж, Сүмийн гишүүд Огайогийн Көртландын бүсэд цугларсаар байлаа (С ба Г 37; мөн С ба Г 38-р хэсгийг үз). Гэвч Көртланд бол Сионы газар биш байсныг удирдагчид мэдэж байв. Нөгөө талаар, Сион хаана байхыг тэд хараахан мэдээгүй байлаа. Көртландад гишүүд хэр зэрэг удаан байхаар төлөвлөх ёстой байв? Тэд Сион руу хөдлөхийн өмнө богинохон хугацаагаар тэнд байх уу? Эдгээр асуудлаарх Бошиглогч Йосеф Смитийн асуултуудад хариулт болж, Сургаал ба Гэрээ 48-р хэсэг хүлээн авагджээ. Энэ илчлэлт бол Их Эзэн материаллаг юмсын тухай асуудлуудаар зөвлөгөө өгдөг бөгөөд энэхүү материаллаг асуудлууд нь Сүнсний зүйлүүдэд олонтаа нөлөөлдгийг харуулдаг судрууд дахь олон жишээний нэг юм.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 48

Дорно зүгийн ахан дүүс
(ш. 2)— Нью-Йорк,

Пеннсилваниас Огайо руу
ирж байсан Сүмийн гишүүд

Сургаал ба Гэрээ 48:6—Цугларалт Тэргүүн Зөвлөлийн удирдлагаар явагдаж байв

Гэгээнтнүүдийн цугларалт буюу хожмын өдрүүдэд Сионыг байгуулах тухайд бид хууртагдах хэрэггүй юм. Ерөнхийлөгч Харольд Б.Лийгийн хэлсэнчлэн: “Цугларалтын ажлыг удирдах хариуцлагыг Их Эзэн Сүмийн удирдагчдын гарт итгэмжлэн даатгасан нь тодорхой юм. Ирээдүйд ийм цугларалт хаана, хэзээ болох тухай хүсэл тааллаа Тэрбээр тэдэнд илчлэх болно. . . [Сүмийн гишүүд] ийм заавар өгөгдөх хүртэл, Их Эзэн зохих эрх мэдэлтэнд илчлэх хүртэл сэтгэл санаагаар үймрэх ёсгүй” (Ye Are the Light of the World [1974], 167).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 48-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Хариултаудыг ол

Сургаал ба Гэрээ 48-р хэсгийн тойм, шүлэг 1–6-г уншиж, дараах асуултуудад хариул:

1. Гэгээнтнүүдийн эцсийн цугларах газар нь Огайогийн Кертланд биш гэдгийг харуулсан юуг Их Эзэн хэлсэн бэ?
2. Гэгээнтнүүдийг юу хий гэж Их Эзэн хэлсэн бэ?
3. Тэд мөнгөө юунд ашиглах хэрэгтэй байсан бэ?
4. Гэгээнтнүүд өөрсдийнхөө төлөө, эсвэл “тэдэнд сайн санагдсанаар” (ш. 3) юуг хийж болно хэмээн Их Эзэн хэлсэн бэ? (мөн С ба Г 58:26–29; 62:4–5-ыг үз).

Сургаал ба Гэрээ 49

Христийн Хоёр дахь Ирэлтэд
Итгэгчдийн Нэгдсэн Нийгэмлэг
(Шейкерүүд)-т зориулсан захиас

Хэрэв хэн нэгэн нь: “Чи юунд итгэдэг нь ерөөсөө падгүй хэрэг. Харин амьдрал чинь сайн байх нь л чухал” гэж хэлбэл, чи юу гэж хариулах вэ? Бидний итгэл амьдралын хэв маягт маань нөлөөлдөг үү? Хэрэв итгэл өөрчлөгдвөл, энэ нь зан төлөвт хэрхэн нөлөөлөх вэ? Мөнхийн үнэнийг ойлгох нь ямар байдлаар амьдралын хэв маягт чинь өөрчлөлт гаргасан бэ?

Христийн Хоёр дахь Ирэлтэд Итгэгчдийн Нэгдсэн Нийгэмлэг нь (Шейкерүүд) Огайогийн Кертландын ойролцоо байсан, олон гишүүнтэй, шашны бүлэг байсныг та Сургаал ба Гэрээ 49-р хэсгийн тоймоос уншиж

болно. Тэдний итгэлийн зарим нь сэргээгдсэн сайн мэдээний сургаалуудаас ямар ялгаатай байсныг хэсгийн тойм бас дүрсэлдэг. Сургаал ба Гэрээ 49-р хэсэгт Их Эзэний онцлон авч үзсэн сургаал бүрийг уншихдаа, энэхүү өвөрмөц үнэнийг мэдэх нь бидний амьдралын хэв маягт хэрхэн нөлөөлж болох тухай бод.



Шейкерийн эхэн үеийн нэгэн цуглаан

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 49

Ганц бие амьдрал (хэсгийн тойм)—Огт гэрлэхгүй, эсвэл бэлгийн харилцаанд ерөөсөө орохгүй байх

Өргөмжлөгдөх (шүлэг 10, 23)—Өндөр байр сууринд тавигдах
Тоо хэмжээгээр (ш. 17)—Тоогоороо бүрэн байх

Сургаал ба Гэрээ 49:8—“Ариун хүмүүс гэж хэн бэ”?

Сургаал ба Гэрээ 49:8-д өгүүлсэн “ариун хүмүүс” нь Есүс Христийн ирэлтийг хүртэл дэлхий дээр маханбодоор тусгай тохинуулал гүйцэтгэж байгаа энэ үеийнхэнд үл хамаарах Илчлэгч Иохан ба Гурван Нифай хүн болох хүмүүс юм” гэж Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит хэлжээ (Church History and Modern Revelation, 1:209).

Сургаал ба Гэрээ 49:24–25—Биелэгдэж байгааг нь бид харж чадах бошиглолууд

Хоёр дахь Ирэлт аль хэдийн болж өнгөрсөн гэдэгт Шейкерүүд итгэдэг байв. Хоёр дахь Ирэлтийн өмнө гүйцэлдэх учиртай хоёр бошиглолын тухай Сургаал ба Гэрээ 49:24–25-д өгүүлдэг. Эл илчлэлт өгөгдөх үед дээрх хоёр илчлэлтийн алиных нь ч биелэлтийн нотолгоо бага байлаа. Гэвч бидний үед Нэгдсэн Улсын баруун хэсэгт, толгод болон уулсын дунд Сион цэцэглэн хөгжиж, сая сая леменчүүд Сүмд ирж, дэвжин хөгжиж байгааг бид харж байна.

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 49-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Хуурамч сургаалыг залруул

1. Тэмдэглэлийн дэвтрийнхээ нэг хуудсыг хоёр багана болгон хуваа. Нэг багананд Сургаал ба Гэрээ 49-р хэсгийн тоймд тайлбарласан Шейкерийн итгэлүүдийг

жагсаан бич. Хоёр дахь багананд, эхний жагсаалтан дахь Шейкерийн итгэл бүрийг залруулах юуг Сургаал ба Гэрээ 49-р хэсэгт заасныг жагсаан бич.

2. Шейкерийн эдгээр итгэлийн нэгнийг нь тухайд уг буруу сургаалыг залруулсан судрыг Библиэс ол. Олсон сургаалаа хоёр дахь багананд бичсэн тайлбарынхаа дэргэд харьцуулах эшлэл болгон бич.
3. Энэ илчлэлтэд тайлбарлагдсан зөв сургаалуудыг ойлгох нь ямар учир холбогдолтой гэж та бодож байна? Өөрөөр хэлбэл, юунд итгэдэг нь чиний хувьд яагаад чухал байдаг вэ? Сургаал ба Гэрээ 49-р хэсэгт Их Эзэний тайлбарласан сургаалаас хариултандаа жишээ татаж, уг жишээ таны амьдралын хэв маягт одоо бас үүрд мөнхөд хэрхэн нөлөөлж болохыг тайлбарла.

Сургаал ба Гэрээ 50 Сүнсний ажлуудыг ойлгох нь

Сүнсний бэлгүүд нь хүний дотор бие махбодын хариу үйлдлүүдийг бий болгодог гэдэгт итгэх нь Сүм сэргээгдсэн үед Христийн зарим Сүмүүдийн дунд нийтлэг байжээ. Жишээ нь: Шашны цугларалтууд дээр Сүнсээр дүүргэгдсэн хүн үл ойлгогдох хэлээр чанга ярих, газар дээгүүр өнхрөх, татаж унах, ухаан алдсан үедээ ямар нэг “үзэгдэл” харах гэхчлэнгийн хачирхалтай зүйл тохиолддог хэмээн боддог байж. Сүмийн шинэ гишүүд сэргээгдсэн сайн мэдээний тухай гэрчлэлтэй болж байсан ч, зарим нэг хуучин зуршил, уламжлалаа үргэлж тэр даруйд орхиж чаддаггүй байв. Иймээс энэхүү хачирхалтай ааш авир шинээр сэргээгдсэн Сүмийн цуглаанууд дээр зарим үед харагддаг байсан аж.

Хожим нь Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын анхны гишүүдийн нэг болсон Парли П.Пратт, энэхүү хачирхалтай ааш авирт сэтгэл нь зовниж, Бошиглогч Иосеф Смитээс зөвлөгөө хүссэн аж. Их Эзэн хариуд нь Сургаал ба Гэрээ 50 дахь илчлэлтийг Бошиглогчид өгчээ.

Сатан Сүнснийг ихэд адилхан дуурайж, туршлагагүй буюу өсч боловсроогүй Гэгээнтнүүдийг хуурч мэхлэн, харалган болгохыг байнга хичээсээр байлаа. Сургаал ба Гэрээ 50-р хэсгийг уншихдаа, хууртагдахаас зайлсхийхэд тань туслах зөвлөгөөг эрж ол. Бас Сүнсний мэдрэмжийг болон адислалуудыг илүү бүрэн дүүрэн хүлээж авахын тулд Сүнс ажилладаг арга замын талаарх үнэнүүдийг эрж ол.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 50

Хоёр нүүртэн (шүлэг 6–8)—Зөв шударга хүний дүр эсгэдэг боловч хэрэг дээрээ тийм биш хүмүүс


Дайсан (ш. 7)—Сатан

Үүндээ баригдах (ш. 33)—

Хуурамч сүнсэнд дийлдэх

Сургаал ба Гэрээ 50:24—Төгөлдөржилт өөд гэрэлд осон хөгжих нь

“Заавар хүлээж авах чадвартай ой ухаан, оюун билэгт чиглэсэн тэнгэрийн гэрэлд анхааралтай, хичээнгүй ханддаг тэр хэмжээгээр авьяас чадвар нь өргөжин тэлдэг хүнийг Бурхан бүтээсэн гэж бид үздэг. Амьдралдаа тохиолдсон муу муухай бүхнийг даван туулсан, нүгэл үйлдэх хүсэл болгоноо орхисон хүн төгөлдөржилтөд илүү ойр дөхөж очдог. Энэ үед тэр хүний үзэл бодол илүү тод томруун,



баяр баясал нь илүү агуу болсон байна. Ингээд тэр хүн эрт дээр үеийнхний адилаар, Өөрийг нь Бүтээгчийн хүч, сүр жавхланг бишрэн шүтэх итгэлийнхээ тэрхүү цэгт хүрч ирэх бөгөөд Түүнтэй хамт амьдрахын тулд дээд тэнгэрт аваачигдана. Харин энэ бол хүн эгшин зуурын төдийд хэзээ ч хүрч ирээгүй дамжих буудал гэж бид үздэг билээ” гэж Бошиглогч Иосеф Смит хэлсэн байдаг (*History of the Church*, 2:8).

баяр баясал нь илүү агуу болсон байна. Ингээд тэр хүн эрт дээр үеийнхний адилаар, Өөрийг нь Бүтээгчийн хүч, сүр жавхланг бишрэн шүтэх итгэлийнхээ тэрхүү цэгт хүрч ирэх бөгөөд Түүнтэй хамт амьдрахын тулд дээд тэнгэрт аваачигдана. Харин энэ бол хүн эгшин зуурын төдийд хэзээ ч хүрч ирээгүй дамжих буудал гэж бид үздэг

Сургаал ба Гэрээ 50:30–34—Сүнснүүдийг ялган таних нь

Их Эзэн энэ илчлэлтэд зарим сүнслэг үйл явдал, үйл ажиллагаа, сургаал номлол эсвэл хэн нэгэн нь Бурханаас уу гэдгийг мэдэхийн тулд залбирч байхыг Сүмийн гишүүдэд зөвлөжээ. Хэрэв хүн үнэнч шударга, хоёргүй сэтгэлтэй байх юм бол, хариу нь Ариун Сүнсний хүчээр мэдэгдэнэ. Сургаал ба Гэрээ 6:22–24; 8:2–3; 9:7–9, мөн таны судалсан бусад судрууд нь Ариун Сүнсний батлагч нөлөөг танин мэдэхэд чинь тусална. Түүнээс гадна, ялган таних сүнсний бэлэг нь санваарын түлхүүрүүдийн хамт бишпоууд болон Сүмийн бусад удирдагчдад өгөгддөгийг Сургаал ба Гэрээ 46-р хэсэгт заадаг. Тэдний зөвлөгөө мэхлэгдэхээс зайлсхийхэд бидэнд тусалж чадна.

Тэргүүн Зөвлөлийн зөвлөх асан, Ерөнхийлөгч Жорж К.Каннон: “Их Эзэнтэй гэрээнд орсон хүмүүст Түүний амласан Сайн мэдээний бэлгүүдийн нэг нь сүнснийг ялган таних бэлэг-олон хүмүүсийн төдийлөн боддоггүй бэлэг, түүний төлөө ховорхон залбирдаг байж болох бэлэг юм. Энэхүү бэлэг үлэмж үнэ цэнэтэй бөгөөд Хожмын Үеийн Гэгээнтэн бүрд байвал зохих бэлэг юм. . . Энэ бэлэггүй нэг ч Хожмын Үеийн Гэгээнтэн байх ёсгүй, учир нь хуурч мэхлэх, буруу замаар удирдан дагуулахыг эрэлхийлдэг олон янзын сүнс дэлхийд байдаг” гэж мэдэгджээ (*Gospel Truth*, 1:198).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 50-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа Б, мөн өөр хоёр үйл ажиллагааг хий.

А Үр дагавруудыг тогтоо

Сургаал ба Гэрээ 50:1–9-ийг уншаад, дараах асуултуудад хариул:

1. Удирдагчдын зөвлөл зүрх сэтгэлийн агуу эв нэгдэлтэйгээр Их Эзэнд хандахад үр дүн нь ямар байдаг вэ?
2. Итгэлээр тэсвэр тэвчээртэй байхаас ирдэг адислал юу вэ?
3. Хоёр нүүр гаргахын үр дагаврууд юу вэ?

Б Багш нар болон оюутнуудын үүрэг

Сүнслэгээр суралцахын тулд сайн мэдээг номлодог хүмүүс, мөн номлолыг хүлээн авдаг хүмүүсийн аль аль нь үүрэг хариуцлага хүлээх ёстойг Их Эзэн Сургаал ба Гэрээ 50:10–22-т тайлбарлажээ.

1. Эдгээр шүлгүүдээс, сайн мэдээг заадаг хүмүүсийн үүрэг хариуцлагуудыг жагсаан бич.
2. Заалтыг хүлээн авдаг хүмүүсийн үүрэг хариуцлагуудыг жагсаан бич.
3. Хэрэв тэд аль аль нь үүрэг хариуцлагаа биелүүлэх юм бол, юу тохиолдоно гэж Их Эзэн хэлсэн бэ?
4. Эдгээр шүлгүүд дэх тайлбар нь хуурамч сургаалуудыг заадаг хүмүүсээр, эсвэл Их Эзэн зөвшөөрөөгүй арга замуудаар үйлдэхэд хууртагдахаас зайлсхийхэд тань хэрхэн тусалж болох вэ?
5. Их Эзэний энэ зөвлөгөөг та Сүм дээрх хичээллүүдийнхээ аль нэгэнд хэрхэн хэрэглэж болох вэ?



В Бэлгэдлийг тайлбарла

1. Сургаал ба Гэрээ 50:23–25 дахь Сүнслэг мэдлэгийг Бурхан юутай харьцуулсан бэ?
2. Яагаад энэ нь ийм аятайхан бэлгэдэл байдаг вэ? Бидний бие махбодын амьдралд энэ бэлгэдэл хэрхэн үйлчилдэг талаар нэг жишээ гаргаж, мөн эл бэлгэдэл нь бидний сүнсний амьдралтай хэрхэн адилхан болохтой харьцуул.

Г Их Эзэний тухай илүү ихийг мэд

1. Сургаал ба Гэрээ 50:40–46-д Түүний хэлсэн зүйлээс та Их Эзэний тухай юу мэдсэн бэ? (Энэ асуултанд хариулахдаа, илчлэлтийн зорилгыг сана.)

2. Өөрт чинь онцгой гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн эсвэл сэтгэлийг чинь ихэд догдлуулсан нэг өгүүлбэр буюу шүлгийг дээрх шүлгүүдээс сонго. Уг өгүүлбэр буюу шүлэг яагаад өөрт чинь гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн тухай бич.

Сургаал ба Гэрээ 51 Өргөлийн хуулийн тухай нэмэлт заавар



Нэгдсэн Улсын дорнод хэсгээс энд цугларч байсан Гэгээнтнүүдэд өөрсдийн газраа хуваалцахыг Их Эзэн Огайо дахь Сүмийн гишүүдэд Сургаал ба Гэрээ 48:2-т зарлиг болгожээ. Нью-Йоркийн Колесвиллаас нэгэн бүлэг Сургаал ба Гэрээ 51 дэх илчлэлтийн өмнөхөн хурч ирсэн аж. Огайогийн Томпсон-д (Көртландын ойролцоо) байсан Леман Копли (С ба Г 49-д танилцуулсан) өөрсдийн 283га-гаас арай илүү газраа Гэгээнтнүүдийн цугларалтад зориулж бэлэн болгосон байжээ. Өмнөх илчлэлтүүд (С ба Г 41–42) бишопыг Сүмийн гишүүдийн материаллаг хэрэгцээнд туслах үүрэг хариуцлагатай болгосон байв. Бишоп Эдвард Партриж албан тушаалаа хэрхэн ажиллах талаар, мөн Томпсонд суурьшихад нь Колесвиллын Гэгээнтнүүдэд хэрхэн туслах талаар Бошиглогч Иосеф Смитээс удирдамж хүссэн аж. Бишоп Партрижийн асуултуудыг Бошиглогч Их Эзэнд хүргэв. Хэсэг 51-д өргөлийн хуулийн талаарх Их Эзэний нэмэлт заавар байдаг. (Энэ хууль С ба Г 42:30–55-д илчлэгджээ.)

Сургаал ба Гэрээ 51-р хэсгийг судлахдаа, та өөрсдийнхөө нутаг дахь гачигдалтай хүмүүст туслахын тулд юу хийдэг тухайгаа бод. Энэ илчлэлт дэх зарчмууд юу хийх ёстойгоо илүү сайн ойлгоход тань хэрхэн тусалдаг вэ?

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 51

Хувь (шүлэг 3–5)—
Амьдрахад шаардлагатай
газар, бараа материал гэхч-
лэн эд зүйлс

Өөртөө ноогдох хэсгийг
(ш. 5)—Өмчлөх эрхийн

бичигт өөрийнх нь өмч
хэмээн хууль ёсоор бүрт-
гэгдсэн хэсгийг
Даамал (ш. 19)—Ямар нэг
ажлыг эрхлэн хариуцдаг хүн

Сургаал ба Гэрээ 51:5—“Тэрээр бэлгийг хадгалж чадахгүй”

Хүмүүс өргөлийн хуулиар амьдарч байгаа үед тэд бүх зүйлийг Сүмд өгөх буюу өргөдгийг Сургаал ба Гэрээ 51:3–5-д тайлбарладаг. Дараа нь бишоп эдгээр юмсыг хэрэгцээ болон хүслээр нь мөн “[тэдний] нөхцөл байдлынх нь дагуу” (ш. 3) хүмүүст өгдөг байв. Түүнээс гадна, бишопоос хүлээн авсан юуг ч гэсэн энэ хүмүүс эзэмшдэгийг нотолсон өмчлөх эрхийн бичгийг бишоп тэдэнд өгдөг байсан аж. Тухайн хүнээс Сүмд өгсөн зүйлийн тоо хэмжээ, өөрт нь хэрэгцээ-тэйгээс илүү байвал, илүү гарсан зүйлийг гачигдалтай хүмүүсийг халамжлахын тулд бишопын агуулахад хийнэ. Энэ бол шүлэг 5-д өгүүлсэн “бэлэг” юм. Хэрэв хүн Сүмээс гарах юм бол, өмчлөх эрхийн бичгээр түүнд олгосон зүйлийг тухайн хүн өөртөө үлдээж болно, харин агуулахад хийсэн зүйлийг буцааж олгодоггүйг энэ илчлэлт өгүүлдэг.



Бидний өдөг цаг хугацаа, ажил хөдөлмөр, мөнгө төгрөгний бэлэг нь ядуучууд, гачигдалтай хүмүүсийг халамжлахад туслах зорилготой бишопын агуулахыг дүүргэхэд тусалдаг.

Сургаал ба Гэрээ 51:10–11—Өргөл болгосон мөнгийг “өөр Сүмд” өгөх нь

“Өөр Сүм” гэдэг нь Сүмийн өөр салбарыг хэлж байгаа юм. Энд өгч буй зөвлөгөө нь “Колесвилл Салбарын эзэмшдэг өмчийг өөр ямар ч Салбар шаардаж болохгүй гэсэн утгатай” (Хайрум М.Смит, Жанн М.Сходал, *Doctrine and Covenants Commentary*, дахин хянасан хэвлэл, [1972], 299). Аль сүмд харьяалагддагийг эс харгалзан ядууст туслахад бишопуудыг урамшуулан дэмждэг.

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 51-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Энэ юу гэсэн үг вэ?

Сургаал ба Гэрээ 51:3-т өгүүлснээр өргөлийн хуулиар хүн бүр “адил тэгш” хувийг хүлээн авах болно гэсэн нь юу гэсэн үг вэ?

Б Өнөө үед өргөлийн хууль хэрхэн үйлчилдэг вэ?

1. Өнөөдөр Сүмд гачигдалтай хүмүүст бишоп хэрхэн анхаарал халамж тавьдгийг Сүмийн нэг удирдагчаас асуу. Мэдсэн зүйлээ тэмдэглэлийн дэвтэртээ бич.
2. Сургаал ба Гэрээ 51-р хэсэгт өгүүлсэнтэй адил арга замаар ядууст туслахын тулд та юу хийж чадахаа тайлбарла. Өнөө үеийн Сүмд “агуулах” гэж юу болох, та энэ агуулахад юу өгч чадахаа бас оруул.



Сургаал ба Гэрээ 52

Сион, Шинэ Иерусалим
илчлэгдсэн нь

Номлолын дуудлага хүлээж авах нь ирээдүйн номлогч, түүний гэр бүл, найз нөхдийн хувьд сэтгэл догдлом үйл явдал мөн. 1831 оны зургадугаар сарын 3–6-нд болсон Сүмийн чуулганы дараахан гуч гаруй хүнийг, түүний дотор Бошиглогч Иосеф Смитийг Миссури рүү явуулахаар Их Эзэн томилжээ. Тэд замдаа номлолоо хийн тус тусдаа аяласан аж. Тэднийг Миссурид хүрэхэд нь “өвийн [тэдний] нутаг” (С ба Г 52:5) илчлэгдэх болно гэсэн тусгай амлалт Их Эзэн өгснийг тэд уг нутаг Сионы хот байх газар буюу хожмын үеийн Шинэ Иерусалим гэж ойлгосон ажээ. Номлолын дуудлага хүлээн авахын сэтгэл догдлом баярыг чи төсөөлж чадах уу?



Өнөө үеийн номлогчдын нэгэн адил Сургаал ба Гэрээ 52-р хэсэгт дуудагдсан номлогчдод ажилдаа амжилт олоход нь тэдэнд туслах заавар, зөвлөгөө хэрэгтэй байлаа. Зөв шударгыг номлогчдын хувьд хүлээн авах ёстой “загварыг” (ш. 14) Их Эзэн тэдэнд өгсөн.

Их Эзэний зөвлөгөө нь биднийг Түүнд дуулавартай байхад туслахаас гадна Түүний жинхэнэ төлөөлөгч бус хүмүүст мэхлэгдэхээс зайлсхийхэд бас тусалдаг.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 52

Ариулан адислах (ш. 2)—Онцгойлон адислах, зориулах

Иаковын үлдэгдэл (ш. 2)—Израилын угсааны багахан хэсэг

Өв залгамжлагчид (ш. 2)—Газрыг өвлөн эзэмших хууль ёсны эрхтэй хүмүүс

Тарианы хог мэт шигших (ш. 12)—Үр тариаг хальснаас

нь салгах гэсэн утгатай нийлэмж үг, гэвч энэ тохиолдолд энэ нь “түүнийг эрхшээлдээ оруулах” эсвэл “түүний дээр хүч, эрх мэдэлтэй байх” гэсэн утгатай

Гэмшдэг (шүлэг 15–16)—Наманчилдаг бөгөөд даруу
Хиймэл шүтээн (ш. 39)—Ямар нэг зүйлийг Бурханаас илүүгээр үнэлэх

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 52-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-г хий.

А Загвар

Мэжлэгдэхээс зайлсхийх “загварыг” Их Эзэн Сургаал ба Гэрээ 52:14–19-д өгчээ.

1. Эдгээр шүлгүүдийг нэгтгэн дүгнэж, “[Түүгээр] хүлээн авагдах” буюу “Бурханых” хэмээн тооцогддог хүмүүсийн шинж чанаруудыг жагсаан бич.
2. Эдгээр шинж чанаруудыг эзэмшсэн хүнд ирэх адислуудыг жагсаан бич.

Б Номлогчдод зориулсан зөвлөгөө

Сургаал ба Гэрээ 52 дахь илчлэлтийг Их Эзэн номлолд дуудагдсан хүмүүст тусгайлан өгчээ. Их Эзэн тэдэнд хэлсэн зүйлүүдээс өнөөгийн номлогчид сурч болно гэж бодсон гурван зүйлийг бич.

Сургаал ба Гэрээ 53 Сидней Гилбертийн дуудлага

Тэнгэрлэг Эцэгийн хүүхэд нэг бүрд өвөрмөц авьяас билэг өгөгдсөн байдаг. Хүн авьяас билгээ хөгжүүлж, бусдад туслахын тулд эдгээрийг ашигласан үед хүн бүр хождог. Төлөөлөгч Паул төрөл бүрийн авьяас билгийг хүний биеийн өөр өөр эрхтнүүдтэй харьцуулсан байдаг (1 Коринт 12-ыг үз). Жишээ нь, хүн бүр толгой байх юм бол, гарын ажлыг хэн хийх юм бэ? Эсвэл, хүн бүр гар байх юм бол, бодож сэтгэх ажлыг хэн хийх юм бэ?

Чамд ямар авьяас билэг байдаг вэ? Нөхдөдөө туслах, Бурханы хаант улсыг байгуулахад чи авьяас билгээ хэрхэн ашиглаж болох вэ? Сургаал ба Гэрээ 53-р хэсэг бол Их Эзэн Хаант улсдаа ажиллах хүнийг авьяас билэгт нь тохируулан дууддагийн нэг жишээ мөн.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 53

Сургаал ба Гэрээ 53:4—“Энэ Сүмд төлөөний хүн байгтун”

Сидней Гилберт нь Огайогийн Кортланд дахь Ньюэл К.Витнейн дэлгүүрийнх нь түнш байлаа. Сургаал ба Гэрээ 53-р хэсэгт Их Эзэн түүнийг Сүмийн төлөөний ажилтнаар эсвэл Сүмийн өмнөөс бизнесийн үйл ажиллагаа явуулахаар дууджээ. “Сидней Гилберт бол чадварлаг бизнесмен байсан юм. . . Их Эзэн Гэгээнтнүүдээ шинэ нутагт, бүр Миссурид цуглуулж байсан үед, тэдний төлөө бизнес хийх Сидней Гилберт шиг хүмүүс хэрэгтэй байлаа. Бизнесийн авьяас билиг нь зөвхөн хүмүүст үйлчлэхэд зориулагдаж байгаа үед л сайн зүйл юм. Энэ тохиолдолд л бизнесийг сүнсний бэлэг гэж нэрлэх хэрэгтэй. Бизнесийн авьяас чадварыг аминч үзэл, сувдаг шунахай зорилгоор ашиглаж байвал, эл чадвар урхи занга, зүхэл болдог. Бизнесийн авьяас билэг Их Эзэний үйлчлэлд байгаа үед адислал байдаг. Төлөөний ажилтны хувьд тэрээр Сүмийг хөл дээр нь босгоход тусалж чадсан юм” (Смит ба Сходал, *Doctrine and Covenants Commentary*, 313).



Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 53-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Хаант улсыг байгуулахад туслахын тулд авьяас чадвараа ашигла

1. Их Эзэн Сидней Гилбертийг Сүмийн бизнесменээр дуудсан юм. Харин тэр энэ дуудлагад тэнцэхийн тулд юу хийх ёстой гэж Их Эзэн хэлсэн бэ?
2. Энэ зөвлөгөөг дагаснаар бизнесийнх нь арга барилд ямар өөрчлөлт гарсан гэж та бодож байна?
3. Өөрийнхөө авьяас чадварын талаар бодож үз. Их Эзэний хаант улсыг адислахын тулд та авьяасаа хэрхэн ашиглаж болох вэ?

Сургаал ба Гэрээ 54

Гэрээнүүд ба тэдгээрийн үр дагаварууд

Их Эзэний хүсэл тааллыг хэрэгжүүлэхийн төлөө бид хичээн чармайж байхад, бусад хүмүүсийн дуулгаваргүй, ёс бус байдал саад тотгор болж хүндрэл бэрхшээл учруулдаг. Үүний энгийн жишээ бол Сүмийн хичээлдээ сууж, сурч мэдэх эрмэлзэлтэй байж, Ариун Сүнсийг мэдрэхийг хүсэх үед анги дахь бусад хүмүүсийн биеэ авч яваа байдал, үйлдлүүд өөрийн чинь хүсэн хүлээсэн дээрх зүйлст саад бэрхшээл учруулна. Бусдын дуулгаваргүй үйлдлийн улмаас Их Эзэний зарлигуудыг сахихыг хичээдэг байсан хэсэг хүмүүст саад тотгор учирсан нөхцөл байдлыг Сургаал ба Гэрээ 54-р хэсэгт авч үзжээ.



Эл судлах гарын авлагын Сургаал ба Гэрээ 51-р хэсгийн ориилд та Огайогийн Томпсонд, Леман Коплийн ферм дээр суурьшсан Нью-Йоркийн Колесвиллын хэсэг Гэгээнтний тухай уншидаг. Копли ах Христийн Хоёр дахь Ирэлтэд Итгэгчдийн Нийгэмлэгт (Шейкерүүд; С ба Г 49-р хэсгийг үз) хийсэн номлолоос эргэж ирсний дараа, газраа өргөл болгосон өмнөх гэрээгээ зөрчиж, Колесвиллын Гэгээнтнүүдийг “өөрийнхөө” өмч дээр суурьшуулахаас татгалзжээ. Сүмийн итгэлтэй гишүүд-ялангуяа салбарын ерөнхийлөгч, Ньюэл Найт нөхцөл байдлынхаа талаар Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Их Эзэнээс удирдамж хүссэн аж. Хариуд нь Сургаал ба Гэрээ 54, 56 дахь илчлэлтүүд ирсэн юм.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 54

1 Шаргуу зогсох (ш.2)—Итгэлтэй байх, үйлчлэлээ үргэлжлүүлэх

Гэмшсэн (ш.3)—Нүглийн төлөө харамсаж, дуулгавартай дагах хүсэлтэй байх

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 54-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Энэ тухай бодож үз

Сургаал ба Гэрээ 54-р хэсгийн түүхийн үндэс суурийг нэгтгэн дүгнэ (энэхүү судлах гарын авлагын хэсгийн тойм болон оршлыг үз). Их Эзэн Өөрийгөө шүлэг 1-д хэрхэн танилцуулсныг ажигла.

1. Их Эзэн Өөрийгөө танилцуулах замаар Леман Копли болон Колесвиллын Гэгээнтнүүдэд ямар захиас илгээсэн гэж та бодож байна?
2. Энэ захиас таны үг хэл, бодол санаа, үйл ажиллагаанд өнөөдөр хэрхэн нөлөөлж болох вэ?

Б Гэрээний ач холбогдол

Сургаал ба Гэрээ 54-р хэсэгт гэрээнүүдийн тухай юу заадаг вэ? Хариултаа бичихдээ илчлэлтийн түүхэн үндэс суурийг анхаар.

Сургаал ба Гэрээ 55

В.В.Фелпс ажилд дуудагдсан нь

“Амьдралаа Бурхан руу эргүүлсэн эрэгтэй, эмэгтэйчүүд амьдралдаа өөрсдийнхөө хийж чадахаас хавьгүй ихийг Тэрээр хийж чадна гэдгийг илрүүлэн олох болно. Бурхан тэдний баяр баяслыг гүнзгийрүүлж, харааг нь тэлэн, ухааныг нь хурцалж, булчинг нь чангаруулан, сэтгэл санааг нь өндөрт өргөдөг билээ. Бас Тэрбээр тэдний адислалуудыг тэнгэрийн од лугаа адил олон болгож, боломжийг нь нэмэгдүүлэн, бодгалийг нь тайтгаруулж, найз нарыг нь өсгөн торниулж, амар амгаланг тэдэн дээр асган юүлэх болно” гэж Ерөнхийлөгч Езра Тафт Бенсон сургажээ (“Jesus Christ: Gifts and Expectations,” Ensign, 1988 оны 12-р сар, 4). Чи ямар ч авъяас чадвартай байлаа гэсэн, Их Эзэнд үйлчлэхэд тэдгээрийг Түүний тусламжтайгаар ашиглавал авъяас чадвар чинь улам сайжирна.

Сургаал ба Гэрээ 55 дахь илчлэлт Виллям В.Фелпст чиглэгджээ. Илчлэлтийг уншихдаа Их Эзэн юу хийхэд түүнийг урьсныг, мөн Тэрээр Фелпс ахын авъяас чадварыг хэрхэн ашиглах бодолтой байсныг ажигла.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 55

Сургаал ба Гэрээ 55:1—В.В.Фелпс гэж хэн байсан бэ?



В. В. Фелпс

Виллям Вайнес Фелпс бол Нью-Йоркийн, ажил нь бүтэмжтэй хэвлэгч, багш, улс төрч байлаа. Тэрээр “нэг Мормоны Ном худалдаж аваад Сүмийн тухай анх мэджээ. . . . Тэр ‘Мормоны Номыг Библиитэй харьцуулан уншиж, шөнөжингөө суусан гэдэг.’ Маргааш өглөө нь Виллям: ‘Би энэ сүмд элсэнэ, энэ сүм үнэн гэдэгт би итгэлээ’” гэж дуу алджээ (Сюзан Ийстон Блакк, *Who’s Who in the Doctrine and Covenants* [1997], 223).

Фелпс ах Мормоны Номын тухай дараах гэрчлэлийг хожим нь хэлжээ:

“Энэ бол сайн ном, эл номон доторх мэдлэгийн төлөө Бурханд талархах агуу талархалгүйгээр, *шударга* бус хүн үүнийг уншиж чадахгүй. . . .

“Би Мормоны Номын талаар гүнзгий тунгаан бодох үедээ, Бурханы үйлчлэгчид эл номоор тохиолгон авчрах алдар сууг угтан харах үедээ найдвараар, гэрлээр, баяр баяслаар, сэтгэл ханамжаар дүүрдэг билээ. Хэчнээн гайхалтай ном бэ! Ямар гаргуун үнэт эрдэнэ вэ!” (“Letter No. 10,” *Messenger and Advocate*, 1835 оны есдүгээр сар, 177).

В. В. Фелпс “Сүмийн хэвлэгчээр” (С ба Г 57:11) үйлчилж байв. 1833 онд Миссурид Зарлигуудын Номыг хэвлэж байх үед, гэрийнх нь хэвлэх цехийг танхайрагчид дайрч, устгажээ. Хожим нь тэрээр Сургаал ба Гэрээний 1835 оны хэвлэлийг гаргахад тусалсан аж. Тэрээр Сүмийн олон дууллыг бичжээ. Эдгээрийн нэг нь “Бурханы Сүнс” юм. Кортландын Ариун сүмийг онцгойлон адислахад энэ дууллыг дуулжээ. Тэр 1839 онд Сүмээс урваж, Бошиглогч Иосеф Смитийн заналт дайсан болсон гэдэг. Тэрээр наманчилж 1840 онд Сүмд дахин нэгдсэн аж. Тэрээр 1872 онд наятайдаа Ютад нас баржээ.

Сургаал ба Гэрээ 55:4—Залуу хүмүүст заах нь Их Эзэнийг баярлуулдаг

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли сургахдаа: “Чадах л хэрээрээ боловсролтой бол гэж би залуу хүмүүс та нарт хандан хэлэхийг хүсч байна. Оюуны чадвар, гарын ур дүйг шамдан сурч хөгжүүл. Боловсрол бол сайхан амьдрах боломжид нэвтрэх түлхүүр мөн. Сүнсний зүйлүүдийг судалж, сурах төдийгүй бас сүнсний бус зүйлүүдийг ч сурч мэдэх үүрэг хариуцлагыг энэ Сүмийн гишүүд та нарт Их Эзэн оногдуулсан билээ. Боловсролтой болох нь их золиослол шаарддаг ч гэсэн, насны залуу нарны эртэд чадах л хэрээрээ боловсрол олж ав. Үр хүүхдийнхээ амьдралыг та адислах болно. Энэ ажлын төлөөх өндөр хүндэтгэлийг хүлээх учраас та Сүмийг адисална” гэжээ (*Teachings of Gordon B. Hinckley* [1997], 172).


Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 55-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Юмс хэрхэн өрнөсөн бол?

1. Энэ судлах гарын авлагын Сургаал ба Гэрээ 55-р хэсгийн оршил дахь Ерөнхийлөгч Езра Тафт Бенсоны эшлэлийг нэгтгэн дүгнэ. Ерөнхийлөгч Бенсоны амласантай адил адислалуудыг хүлээж авахын тулд Сургаал ба Гэрээ 55:1 дэх ямар өгүүлбэрт анхаарал тавих нь Виллям В.Фелпст чухал байсан гэж та бодож байна?
2. Энэ илчлэлт дэх зөвлөгөөг Фелпс ах дагасан болов уу гэж та бодож болох юм. Сүмийн дууллын ном байвал, Виллям В.Фелпсийн (“Бурханы Сүнс,” Израилыг Гэтэлгэгч,” “Тэр хүнийг магт,” “Gently Raise the Sacred Strain,” “Мөнхийн Эцэг Бурхан минь” гэхчлэн) бичсэн олон дууллын нэрийг олж, уншиж болно. Тэр хэсэг хугацаанд Сүмээс холдсон ч гэсэн, дуулууд бичсэн нь Бурханы хаант улсыг байгуулахад авьяас чадвараа хэрхэн ашиглаж байсны жишээ юм. Фелпсийн нэг дууллыг уншихад өөрт чинь ямар сэтгэгдэл төрсөн эсвэл өнгөрсөн үед энэ дуулал өөрт чинь хэрхэн сүнслэг мэдрэмж төрүүлсэн тухай бич.



Сургаал ба Гэрээ 56 Даруу бус хүмүүст өгсөн зэмлэл

Сургаал ба Гэрээ 56-р хэсэгт Огайогийн Томпсон дахь маргаанд оролцсон хувь хүмүүст өгсөн зөвлөгөөний үргэлжлэл юм (С ба Г 51, 54-р хэсгийн тойм, судлах энэхүү гарын авлагын орилуудыг үз). Гэвч илчлэлт дэх Их Эзэний зөвлөгөөг олон нөхцөлд өнгөрсөн, одоо, ирээдүйд хэрэглэж болно. Зөвлөгөөг уншихдаа ямар хэрэг

явдал Өөрт нь таалагддаггүйг Их Эзэн хэлснийг, эдгээр хэрэг явдлуудын үр дагавруудын талаар, түүнчлэн ийм нүглүүдээс урьдчилан сэргийлэх болон наманчлах талаар биднийг юу хийж болно гэж Тэрээр сануулсныг эрж ол.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 56

Зөвүүцэл (ш.1, 16)—Зөв шударга уур

Ялзруулах (ш.4–6)—Бохир болгох, илжрүүлэх

Төлөөс (ш.16–9)—Шударга төлбөр, шагнал

Сургаал ба Гэрээ 56:2—Хүн хэрхэн “загалмайгаа үүрдэг” вэ?

ИСО, Матай 16:26-гаас бид: “Эдүгээ загалмайгаа үүрэх хүн, бүхий л бурханлиг бус явдлыг, түүнчлэн дэлхийн тачаангуй сэтгэлийг өөртөө үгүйсгэж, мөн миний зарлигуудыг сахих ёстой” гэдгийг мэддэг.

Сургаал ба Гэрээ 56:8—Бардамналыг наманчлах нь

“Бардамналыг даруу байдал, номхон дөлгөөн зан, хүлцэнгүй байдлаар засч залруулдаг. . . . Бардамналыг харууссан зүрх, гэмшсэн сэтгэлээр эдгээн илааршуулдаг (In Conference Report, 1989 оны 4-р сар, 6; *Ensign*, 1989 оны 5-р сар, 6) гэж Ерөнхийлөгч Езра Тафт Бенсон сургажээ. Ерөнхийлөгч Бенсон цааш нь хэлэхдээ бид доорх зүйлсийг хийснээр “өөрсдийгөө даруусгахаар сонгож” чадна гэжээ. Үүнд:

- “Бусад хүмүүсийг” “өөр шигээ” хүндлэн дээдэлснээр.
- Сүмийнхээ удирдагчдын зөвлөгөөг дагаснаар.
- “Биднийг гомдоосон хүмүүсийг уучилснаар.”
- “Амь бие хайргүй үйлчилснээр.”
- Номлолд үйлчилж, сайн мэдээг хуваалцсанаар.
- Ариун сүмд олон удаа орсноор.
- “Нүглээ хүлээж, орхин, Бурханаас төрснөөр.”
- “[Бурханыг] амьдралдаа нэгдүгээрт тавьснаар.”

Сургаал ба Гэрээ 56:8—Эзра Тайред өмнө нь ямар зарлиг өгөгдсөн бэ?

Эзра Тайрегийн өргөл болгосон өмчийн талаар Бошиглогч Иосеф Смит урьд нь түүнд зөвлөгөө өгсөн байв. Тэрээр газрынхаа нэг хэсгийг бусад өгөх бодлынхоо талаар хоёр дахь удаагаа зөвлөгөө авсан бололтой. Аминч үзэл нь номлолд үйлчлэх болон Сионы газрыг онцгойлон адислахад туслах боломжийг нь түүнд үгүй болгосон юм.

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 56-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Эсэргүүцэл: Үр дагавар ба зүхэл

1. Сургаал ба Гэрээ 56-р хэсэгт Сүмийн зарим гишүүдийн бардамнагч, эсэргүүцэгч үйл ажиллагааны тухай Их

Эзэн өгүүлжээ. Бардамнагч, эсэргүүцэгч хүмүүст юу тохиолдох талаар Тэр бас зөвлөгөө өгсөн байна. Бардамнал, эсэргүүцлээс урьдчилан сэргэмжлэх болон наманчлах талаар тэд юу хийх ёстой талаар Тэр бас тэдэнд зөвлөсөн юм. Доорхтой адил схемийг тэмдэглэлийн дэвтэртээ хий. Шүлэг 1–15-д Их Эзэний хэлсэн зүйлүүдээр схемийг бөглө. Жагсаан бичсэн зүйл бүрд холбогдох шүлгийг хаанаас авснаа тэмдэглэ.

Бардамнал, эсэргүүцлийн жишээнүүд	Бардамнал, эсэргүүцлийн үр дагаврууд	Бардамнал, эсэргүүцлээс урьдчилан сэргэмжлэх болон наманчлах шийдлүүд

2. Энэ үйл ажиллагаанаас сурч мэдсэн зүйлийнхээ улмаас өөрийнхөө хийх нэг юмны тухай бич. Чи яагаад үүнийг хийхээ тайлбарла.

Б Баян уу, эсвэл ядуу юу?

1. Сургаал ба Гэрээ 56:16-д өгүүлснээр, баячуудын ямар зан араншинг Их Эзэн зэмлэсэн бэ? Үүнээс ямар дагавар гарч болох вэ?
2. Шүлэг 17-д өгүүлснээр, ядуучуудын ямар зан араншинг Их Эзэн зэмлэсэн бэ? Их Эзэн итгэлтэй, даруу ядуучуудад шүлэг 18–20-д ямар амлалтууд өгсөн байна бэ?
3. Эдгээр шүлгүүдээс сурч мэдсэн зүйлүүд дээрээ үндэслэн дараах өгүүлбэрүүдийг төгсгө:
 - а. “Хэрэв . . . бол, би баян байхыг хүсэхгүй.”
 - б. “Хэрэв . . . бол, би ядуу байхад дургүйцэхгүй.”



Сургаал ба Гэрээ 57

Сионы төв газар илчлэгдсэн нь

“Сионыг байгуулах нь Бурханы хүмүүсийн үе үеийнхний сонирхлыг татсаар ирсэн учир шалтгаан юм. Сионыг байгуулах нь бошиглогчид, санваартнууд, хаадын сэтгэл зүрхийг эзэмдсээр ирсэн сэдэв яах аргагүй мөн. Тэд одоогийн бидний амьдарч байгаа үеийг оргилуун сэтгэлээр хүсэн хүлээсээр ирсэн юм. Тийнхүү тэд манай өнөө үеийг оргилуун сэтгэлээр, тэнгэрлэгээр, баяр баясалтайгаар хүсэн хүлээж, энэ үеийн тухай дуулж, бичин, бошиглож байсан юм” гэж Бошиглогч Иосеф Смит хэлжээ (History of the Church, 4:609–610).

Бошиглогч Иосеф Смит Мормоны Номыг орчуулж байхдаа, Америк тив хожмын үед Шинэ Иерусалим буюу Сионы хотын газар байх болно гэдгийг мэджээ (Ифер 13:5–8-ыг үз). Эцсийн өдрүүдэд Сионыг үндэслэн байгуулахыг эрж хайх хүмүүст Мормоны Ном бас агуу адислалуудыг амладаг (1 Нифай 13:37-г үз). Сүм зохион байгуулагдахын өмнө, энэ ажилд өөрсдөө хэрхэн тусалж болохыг мэдэх гэж Бошиглогч дээр ирдэг хувь хүмүүст, Сионы зорилгыг бий болгохыг эрмэлз хэмээн хэлдэг байв (С ба Г 6:6; 11:6; 12:6; 14:6-г үз).

Сүм зохион байгуулагдсаны дараа ч, Сион чухал асуудал хэвээр үлдсэн юм. Хайрам Пейж Сионы байршилн талаар илчлэлт хүлээн авсан мэтээр мэдэгдсэнээр, Сүмийн гишүүдийн дунд маргаан, будлиан үүсгэжээ (С ба Г 28-р хэсгийг үз). Гэвч Их Эзэн Пейж ахыг залруулж, Сионы хот “Леменчүүдийн ойролцоох хил дээр” (С ба Г 28:9) байх болно гэдгийг хэлжээ.



Бошиглогч Иосеф Смит сүнсээр нөлөөлөгдсөн Библийн орчуулга дээр ажиллаж байхдаа Сионы тухай бүр ихийг мэджээ. Үерийн өмнө Сионы хотыг үндэслэн байгуулсан бошиглогч Енохын тухай өгүүлсэн, эхлэлээс алга болсон судрын бүхэл хэсгийг

Их Эзэн түүнд илчилсэн байна (Мосе 6–7-г үз). Үүнээс хойш удалгүй, Сионыг үндэслэн байгуулахад Сүм түүгээр амьдрах хэрэгтэй сүнсэлэг болон сүнсэлэг бус хуулиудын тухай илчлэлт болсон “хуулийг” Их Эзэн Бошиглогчид илчилсэн юм (С ба Г 42-ыг үз). Энэ илчлэлтэд, Сионы байршилыг яг зааж илчлэх болно гэдгийг Их Эзэн Бошиглогчид амласан ажээ.

1831оны зургадугаар сард хэдэн хэсэг номлогчдыг Нэгдсэн Улс болон индианчуудын (эсвэл леменчүүд) нутгийн хоорондох зааг дээрх Миссури руу явуулахаар Их Эзэн дуудав. Тэднийг эргэж ирсний дараа Сионы байршилыг илчлэх болно гэж Их Эзэн амласан байна (С ба Г 52-р хэсгийг үз). Бошиглогч Иосеф Смиттэй хамт явсан хэсгийн зарим хүмүүс 1831 оны долдугаар сарын 17-нд иржээ. Түүнээс хойш удалгүй бусад номлогчид хүрч ирсэн аж. Бошиглогч уг газар болон нөхцөл байдлын тухай авч үзээд, Их Эзэнд хандсан түүний асуулт болон гуйлтуудын үр дүн болсон илчлэлт Сургаал ба Гэрээ 57-р хэсэгт байдаг.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 56

Сургаал ба Гэрээ 57:3–4—Төв газрыг худалдаж авсан нь



“Индепенденс хот Миссурийн хамгийн үзэсгэлэнт, саруул сайхан газруудын нэгэн хэсэгт байрладаг. . . . Энэ бол эртний хот. Энэ хот 1827 онд үндэслэгдсэн боловч, 1831 онд ердөө л нэг тосгон байв. Эдүгээ Индепенденс Канзас хотын зах болжээ” (Смит ба Сходал, *Doctrine and Covenants Commentary*, 331).

Сургаал ба Гэрээ 57:4—“Иудей хийгээд харийн хоорондох бүр хилийн зааг”

57-р хэсэг дэх илчлэлт өгөгдөх үед Миссури мужийн баруун хил нь, зохион байгуулагдсан Нэгдсэн Улсын хилийн хэсэг байжээ. Миссурийн баруунтаах газар бол Индианчуудын нутаг байв. Индианчууд (эсвэл леменчүүд) энд “иудейчүүд” хэмээн нэрлэгддэг байв. Учир нь тэд Израилын угсааны шууд удмынхан байлаа. “Харь, харийнхан” гэдэг нэр томъёо нь Миссурийн цагаан арьст суурьшигчдыг заадаг (С ба Г 19:27). Мормоны Номын жишгээр, Америк нь Харь үндэстэнд тооцогддог. (Гурамсан судрынхаа ар дахь газрын зураг 5–6-г үз.)

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 57-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Төвд юу байх ёстой вэ?

1. Сургаал ба Гэрээ 57-р хэсгийн тоймд Их Эзэнээс Бошиглогч Иосеф Смитийн асуусан гурван асуултыг бич.
2. Шүлэг 1–5-ыг нэгтгэн дүгнэж, аль асуултанд Бошиглогч хариу хүлээж авсныг тайлбарлаж, ямар хариу авсныг бич.
3. Бид уг хариултаас Сионыг байгуулж, төлөвшүүлэхэд өнөө үед шаардлагатай, чухал зүйлсийн талаар юуг мэдэж болох вэ?

Хэрхэн бизнес эрхлэх вэ?

Сионыг байгуулахын тулд анхаарах хэрэгтэй тодорхой хэдэн ертөнцийн (дэлхийн буюу материаллаг) асуудал байдаг. Иймээс, С ба Г 57 Сионы үндэс суурийг тавихад туслахаар хүмүүст өгөгдсөн янз бүрийн ертөнцийн ажил үүргүүдийг авч үзжээ. Энд өгсөн зөвлөгөө нь Их Эзэний мэлмийд хүлээн зөвшөөрөгдөхүйц бизнес эрхлэх хэнд ч гэсэн хамаатай байж болно. Сидней Гилберт (шүлэг 6, 8–10), Бишоп Эдвард Партриж (ш. 7), Виллям В.Фелпс (шүлэг 11–12), Оливер Каудери (ш. 13) нарт Их Эзэний өгсөн зөвлөгөөг унш. Бизнес хэрхэн эрхлэх тухай наад тал нь дөрвөн чухал зарчмыг энэ зөвлөгөөнөөс тэмдэглэлийн дэвтэртээ бичиж, өнөө үед бид эдгээр зарчмуудыг хэрхэн хэрэглэж болохыг тайлбарла.



Миссури бол хожмын үеийн Сион болон Шинэ Иерусалим байх болно гэдгийг Их Эзэн илчилсэн үед та тэнд Сүмийн гишүүн байсан бол өөр юуг Их Эзэнээс мэдэхийг хүсэх байсан бэ? Тэр үед Сүмийн гишүүд Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан зөвлөгөө хүсэх талаар ихэд санаа тавьдаг байв. Шинээр илчлэгдсэн Сионы газрын талаарх онцгой зөвлөгөөг агуулсан Сургаал ба Гэрээ 57, 58 дахь илчлэлтүүдийг Их Эзэн өгчээ.



© 1988 Глен С. Холминсон

“Сионы ашиг сонирхлыг” (С ба Г 6:6; 11:6; 12:6) өнөө үед бий болгоход туслахын тулд та юу хийж байна? Сургаал ба Гэрээ 58-р хэсгийг уншихдаа, Их Эзэний зөвлөгөөг та хэрхэн хэрэгжүүлэх талаар бод.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 58

Бурханы өвийн хот (ш. 13)—Бурханы сонгосон хүмүүсийн газар

Бурханы өвийн нутаг (ш. 17)—Бурханы сонгосон нутаг

Лазан (ш. 26)—Залхуу, хойрго

Өөрсдийнхөө төлөө сонгогчид (ш. 28)—
Сонголтууд хийх болон үйлдэх ёс суртахууны сонгох эрхтэй хүмүүс

Төлөөний хүн (шүлэг 49, 51, 55)—Бусдын өмнөөс ажиллах эрх мэдэл олгогдсон хүн

Сургаал ба Гэрээ 58:8–11—“Сайн зүйлүүдийн нэн сайн цэвэршүүлсэн тунгаамал дарсны найр”

Сургаал ба Гэрээ 58:8–11-д дурдсан найрын дүрслэл бол хамгийн сайхан хоол, ундааны бэлгэдэл юм. Эрт дээр үеийн бошиглогчид сайн мэдээ бүрэн байдлаараа байгаагүй үеийг өлсгөлөнтэй харьцуулдаг байжээ (Амос 8:11-ийг үз). Сайн мэдээний Сэргээлт нь Сүнсний бүх өлсгөлөнг цатгах найрыг авчирсан юм. Түүнээс гадна, Сэргээлтийн агуу зорилгуудын нэг нь “Хурганы гэрлэлтийн” (С ба Г 58:11) үеэр болох “Их Эзэний үдшийн зоогт,” өөрөөр хэлбэл, Есүс Христийн Хоёр дахь Ирэлтэд хүмүүсийг бэлтгэх явдал мөн.

Сургаал ба Гэрээ 58:26–29—“Бүх зүйлд би зарлиглах нь тохирохгүй бөлгөө. . . . Сайн зарчимд санаа сэтгэлээ бүрэн зориул”

Ахлагч Эзра Тафт Бенсон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байхдаа сургасан нь: “Заримдаа Их Эзэн Өөрийнх нь хүүхдүүд өөрсдөө бие даан ажиллахыг нь найдан хүлээхэд, тэд ингэж ажиллалгүй, илүү их шагналаа алдахад хүрэхэд Их Эзэн нэг бол уг асуудлыг ерөөсөө хайрлалгүй орхиж, үр дагавруудыг нь тэд биеэрээ үзэхээр болгодог, нэг бол асуудлыг бүр их нарийвчлалтайгаар нэг бүрчлэн хэлж өгдөг. Тэр хэдийчинээ нарийвчлалтайгаар нэг бүрчлэн хэлж өгнө, бидний шагнал ихэвчлэн төдийчинээ бага байдаг гэж би айдаг.” (In Conference Report, 1965 оны 4-р сар, 122).

Сургаал ба Гэрээ 58:26–29 дэх энэ зөвлөгөөг дагаснаас үр дүнг нь үзсэн жишээ Далын гишүүн, Ахлагч Вон Ж. Феатерстөүний хуваалцсан нэг туршлагад байдаг:



“Намайг арав юм уу арван нэг орчим настай байхад манай садан төрлүүдээс олон хүн айлчлан ирж билээ. 35 эсвэл 40 хүн байсан байх. Ээж тэднийг зоогт урьсан ажээ. Зоогийн дараа бүх хүмүүс өөр өрөөнд орж суув. Уул овоо мэт угаагаагүй таваг, халбага сэрээ энд тэндгүй овоолоостой байв. Хоолыг тэндээс өөр газарт зөөж өгөөгүй болохоор хоол хийхэд хэрэглэсэн угаагаагүй сав суулга тэр чигээрээ байж байлаа.

“Сүүлд нь бүгд яваад өгөхөөр, бүх цэвэрлэгээг ээж л хийх байхдаа гэж би тэр үед бодсоноо санадаг. Надад нэг санаа төрлөө. Тэгээд би цэвэрлэж гарлаа. Сав суулга угаагч

машин гараагүй байсан үе л дээ. Ээж маань үргэлж цэвэрхэн байдаг цэмцгэр хүн байсан тул сав суулгыг яаж зөв угааж, арчихыг бидэнд заадаг байв. Би уул шиг овоорсон ажлыг тэр даруй эхэллээ. Тэгээд гурван цаг орчмын дараа би сүүлчийн тавгийг хатааж дуусч байв. Үлдсэн бүх хоол хүнсийг зөөн хурааж, лангуу, тосгуур, шал бүгдийг нь цэвэрлэлээ. Гал тогооны өрөө ганц ч толбогүй, гял цал болсон байв.

“Орой аажуухан бүх зочдыг явсны дараа ээж цэвэрлэгээ хийхээр гал тогооны өрөөнд орж ирлээ. Тэр агшинд ээжийнхээ нүүрэнд илэрсэн баясгаланг би хэзээ ч мартаггүй. Би толгойноосоо хөлөө хүртэл норсон байв. Ээжийнхээ нүүрэнд илэрсэн тэрхүү баясгаланг хараад, хүч хөдөлмөрийнхөө үнэ цэнийг мэдэрсэн нь надад хэчнээн сайхан байсан гээч. Энэ сэтгэл хөдлөл, тайвшрал, бахархлын мэдрэмж байлаа. Ээжийн нүүрэнд тэрхүү баясгалан дахин дахин, бүр мянга дахин илэрч байхын төлөө би чармайх болно гэж тэр үед шийдэж билээ” (“We Love Those We Serve,” *New Era*, 1988 оны 3-р сар, 19).

Сургаал ба Гэрээ 58:43—Нүглээ хүлээж мөн орших болно



Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Спенсер В.Кимбалл сургасан нь: “Хүн сэтгэл санаагаа уудлан илчилж наманчлахгүй бол, аливаа шалтаг, зөвтгөлгүйгээр зохисгүй бодол санаа, сул талаа хүлээн зөвшөөрөхгүй бол, аливаа зөрчлөөсөө уучлагдана гэж хэзээ ч байхгүй. Хүн ноцтой нүгэл үйлдсэнээ хүлээн зөвшөөрөх ёстой. Учруулсан хохирол,

үүний ноцтой байдлыг өчүүхэн ч бууруулалгүйгээр, өөрөөр хэлбэл, уг хохирлын хүнд үр дагаврыг өчүүхэн ч зөөлрүүлэлгүйгээр өөрөө хүлээж, мөн энэ бол үнэхээр том хэрэг гэдгийг хүлээн зөвшөөрснөөр, тэр хүн наманчлалаа эхлэхэд бэлэн болсон байдаг.” (*Love versus Lust*, Brigham Young University Speeches of the Year [1965 оны 1-р сарын 5], 10).

Түүнээс гадна, бидний үйлдсэн нүгэл бусад хүмүүст хохирол учруулсан үед бид нүглээ хүлээж, хохирол учруулсан хүмүүсээс уучлал гуйх ёстой. Ариун явдлын хуулийг зөрчих, бие махбодын болон бэлгийн зүй бус харилцаа, манай Сүмийн гишүүнчлэлд нөлөөлж болох бусад нүглийг Сүмийн холбогдох эрх мэдэлтний өмнө хүлээх ёстой. Бишоп буюу салбарын ерөнхийлөгч тухайн хүний Сүм дэх байдлыг тодорхойлж, наманчлалын явцад нь түүнд тусалдаг. Сүмийн эрх мэдэлтний өмнө нүглээ хүлээх шаардлагын талаар асуулт байвал, энэ тухай бишоп буюу салбарын ерөнхийлөгчтэйгөө ярилц.

Сургаал ба Гэрээ 58:57—Нутгийг мөн ариун сүмийн газрыг Их Эзэнд ариулж мөн онцгойлон адислаг



Миссурийн нутагт байсан ариун сүмийн газрыг Сидней Ригдон нийтийн арга барилаар ариулан адисалж, Бошиглогч Иосеф Смит 1831 оны наймдугаар сарын 3-нд Ариун сүмийг онцгойлон адисалсан. Сидней Ригдон, Эдвард Партриж, В. В. Фелпс, Оливер Каудери, Мартин Харрис, Жозеф Көү нар оролцжээ.

“Онцгойлон адислах ажиллагаа хүндэтгэлтэй, сэтгэл догдлом байлаа” гэж Бошиглогч бичжээ (*History of the Church*, 1:199).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 58-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа Б, А эсвэл В-г хий.

А Ойроос хар

Миссурийг Сионы хот болон ариун сүмийн газар байх болно гэдгийг Их Эзэн илчилсэн тэр цаг үед тэнд байх нь маш их сэтгэл догдлом байсан биз ээ. Мэдээжийн хэрэг, Гэгээнтнүүдийн дараагийн зорилт нь Сионыг барихаар ажиллах явдал байлаа. Тэд уг зорилгын бүрэн биелэлтийг хараагүй юм. Мөн тэд өөрсдийн өдрүүдэд Сион бүрэн байгуулагдахыг харна гэж Их Эзэн тэдэнд хэлээгүй аж. Сургаал ба Гэрээ 58-р хэсгээс уншсан зүйлээ ашиглан, дараах асуултуудад хариул:

1. Сион хэзээ сүр жавхлантайяа сүндэрлэн босох вэ? (шүлэг 1–5, 44–46, 56-г үз).
2. Их Эзэн яагаад эхний бүлгийг Сион руу илгээсэн бэ? (шүлэг 6–13, 44–46-г үз).
3. Сион хэрхэн байгуулагдах вэ? (шүлэг 8–13, 44–46, 50–56-г үз).
4. Бошиглогч Иосеф энэ талаар залбирч, Сургаал ба Гэрээ 57-р хэсгийн тоймд цэдэглэгдсэн эхний хоёр асуултад хариулахад энэ илчлэлт хэрхэн тусалдаг вэ?

Б Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 58:26–27

Сургаал ба Гэрээ 58:26–27-р хэсгийн “Судруудыг ойлгох нь” хэсгийг уншсаны дараа, Их Эзэний энэ зөвлөгөөг хүмүүс хэрхэн биелүүлж байгааг өөрөө харсан тухай хоёр жишээ бич. Хэрэв чи ямар ч жишээг санаж чадахгүй байвал хүн энэ зөвлөгөөгөөр хэрхэн амьдарч болно гэж боддог тухайгаа бич.

В Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 58:42–43

Сургаал ба Гэрээ 58:42–43-т Их Эзэний заасан наманчлалын хоёр чухал зарчмыг бич.

Сургаал ба Гэрээ 59

Сион болон түүний гадаснуудад өгсөн зарлигууд

Зарим хүмүүс зарлигуудыг ачаа дарамт гэж үздэг байхад бусад нь яагаад тэдгээрийг адислалууд гэж үздэг юм бол? Бурханы зарлигуудын зорилго юу вэ? Зарлигууд байхгүй бол таны амьдрал хэр зэрэг өөр байхсан бол? Хэрэв нийгэм, хамт олон бүгдээрээ Бурханы зарлигуудыг сахидаг бол ямар байх бол? Тийм газарт амьдрахыг чи хүсэх үү? Таны одоогийн амьдардаг нийгэмээс ийм нийгэм ямар ялгаатай байх бол? Сургаал ба Гэрээ 59-р хэсгийг уншихдаа, энэ илчлэлтэн дэх хууль, зарлигуудад дуулгавартай байх нь Сионыг байгуулахад бидэнд хэрхэн тусалж болох талаар бод.

“Бурхан зарим хуулиудыг хүмүүний гэр бүлд өгсөн юм. Хэрэв эдгээр хуулиудыг хүмүүс сахих юм бол, [Түүний селестиел] амралтыг өвлөн авахад тэднийг бэлтгэхэд эдгээр хуулиуд хангалттай юм. Тийнхүү, Бурхан Өөрийн хуулиудыг бидэнд өгсний зорилго нь энэ юм гэж бид үздэг. Хэрэв тийм биш бол, юуны учир, эсвэл юуны төлөө эдгээр хуулиуд өгөгдсөн юм бэ? Хэрэв хүмүүний бүх гэр бүл зарлиггүй байх нь зарлигтай байснаас өөрцүгү юм бол, зарлигуудыг өгсний учир зорилго юу юм бэ?” гэж Бошиглогч Иосеф Смит сургажээ (Teachings of the Prophet Joseph Smith, 54).

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 59

Харууссан (ш. 8)—
Наманчилдаг, дуулгавартай

Бүхнээ зориул (ш. 10)—
Хайр, шийдвэр төгс байдлаа харуул

Сургаал ба Гэрээ 59:1–2—“Полли Найт нас эцэслэсэн нь

Бошиглогч Иосеф Смитийг Миссурид ирснээс хойш хоёр дахь ням гарагт Сургаал ба Гэрээ 59-р хэсгийг хүлээн авчээ. Энэ илчлэлтийг хүлээж авахын өмнө Полли Найтын оршуулгад Бошиглогч оролцсон аж. Шүлэг 1–2 нь энэ үйл явдалд үзүүлсэн шууд хүндэтгэл бололтой.

“Хүү Ньюэлийнх нь хэлснээр Полли Найтын эрүүл мэнд хэсэг хугацаанд улам муудсаар байсан аж. Көртландаас Миссури рүү хийсэн аяны үед тэр хүндээр өвчилсөн байв. Гэвч ээж маань цааш явахаа болихыг зөвшөөрсөнгүй. Ээжийн маань цорын ганц бөгөөд хамгийн агуу хүсэл бол Сионы нутагт хөл тавьж, тэнд ясаа тавих явдал байсан юм. Гэвч очих ёстой газартаа биднийг хүрэхээс өмнө ээж маань маш түргэн муудаж байсан болохоор, өөд болох юм бол авх хийхийн тулд би эрэг дээр гарч, мод худалдаж авлаа.

Харин Их Эзэн ээжийн минь зүрх сэтгэлийн хүслийг гүйцэлдүүлж, зорьсон газарт нь амьд мэнд хүргэсэн билээ” (in *History of the Church*, 1:199, зүүвэр тайлбар).

“7-ны өдөр би Ахмад Жозеф Найтын эхнэр Полли Найт эгчийн оршуулгад оролцлоо. Энэ бол энэ нутагт Сүмд тохиолдсон анхны нас баралт байв. Зохистой гишүүн амилуулалтыг хүртэл Есүсийн дотор нойрсдог хэмээн би хэлж чадна” (*History of the Church*, 1:199) гэж Иосеф Смит тэмдэглэжээ.

Сургаал ба Гэрээ 59:6—“Тэрчлэн энэ мэт ямар ч зүйлийг үйлдэх ёсгүй”

“Тэрчлэн энэ мэт ямар ч зүйлийг үйлдэж болохгүй” гэсэн өгүүлбэрийг хулгай, садар самуун, үр зулбуулах, түүнчлэн хүний амийг бүрэлгэхэд хамааруулан өөр өөр цаг үед Бошиглогчид хэрэглэсэн байдаг. Шударга бус явдлын бүх хэлбэр хулгайтай адил гэдгийг Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл заажээ (In *Conference Report*, 1976 оны 10-р сар, 7; *Ensign*, 1976 оны 11-р сар, 6-г үз). “Хүний биеийг илж таалах, завхайрал, ижил хүйстэнтэй бэлгийн харилцаанд орох, түүнчлэн ёс суртахуунгүй явдлын бусад аливаа хэлбэр нь садар самуунтай адил юм” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон сургасан байдаг (In *Conference Report*, 1984 оны дөрөвдүгээр сар, 8; *Ensign*, 1984 оны 5-р сар, 8-ыг үз). “Цус ойртолтын буюу хүчингийн бусармаг гэмт хэрэг, түүнчлэн эхийн амь насанд аюултай эсвэл ноцтой гажигтай үр хөврөл нь төрөлтийг даахгүйг эрх бүхий эмнэлгийн мэргэжилтнүүд нотолсноос бусад тохиолдолд үр зулбуулах нь хүн алахтай адил юм” гэж Ахлагч Бонд К.Пакер заажээ. (In *Conference Report*, 1990 оны 10-р сар, 108; *Ensign*, 1990 оны 11-р сар, 85)

Сургаал ба Гэрээ 59:8—“Харууссан зүрх мөн гэмшсэн сэтгэлтэйгээр”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Брус Р. МкКонки: “Харууссан зүрх, гэмшсэн сэтгэлтэй байх нь нүглийн төлөө гүнзгий харамсан, бүх талаар даруу төлөв, наманчлагч байж, чин сэтгэлээсээ, үнэн зорилготойгоор наманчлах явдал мөн” гэж тайлбарласан байдаг (*Mormon Doctrine*, 161).

Сургаал ба Гэрээ 59:15—“Их инээдтэйгээр бус”

Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Жозеф Фиелдинг Смит сургасан нь: “Тэгээнтнүүд инээдэм баясалтай байх хэрэгтэй гэдэгт би итгэдэг, гэвч энэ нь зохих ёсны хязгаартай байх ёстой. Биднийг дүнсгэр царайлан дуугүй явах, гэгээн дүр эсгэн, хоёр нүүр гаргадаг байхыг, бас ийм байлгахыг Их Эзэн боддог гэдэгт би итгэдэггүй. Биднийг аз жаргалтай, баяр хөөртэй байхыг тэр биднээс хүсэн хүлээдэг гэж би боддог. Харин орилж хашгирсан, эвгүй байдлаар, эрх зоргоороо биеэ авч явахыг дэлхийн зугаа цэнгэл, инээд баяслаа болгодог хоосон, мунхаг зүйлсийн хойноос хөөцөлдөхийг тэрээр биднээс хүсэн хүлээдэггүй гэж би боддог.” (In *Conference Report*, 1916 оны 10-р сар, 70).

Судруудыг судлах нь


Сургаал ба Гэрээ 59-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

Адислалуудыг жагсаан бичиж, дүрсэл

1. Сургаал ба Гэрээ 59:1–4, 23-т зөв шударга хүмүүст Их Эзэний амласан адислалуудыг жагсаан бич.
2. “Ажлууд нь тэднийг дагалдах болно” (ш. 2) гэсэн нь юу гэсэн утгатайг бод. Мөн Алма 41:3–6, 10, 13–15-ыг уншиж, дээрх үгс хэрхэн сайн мэдээ, эсвэл муу мэдээ байж болохыг тайлбарла.
3. “Цөөн бус зарлигууд нь” (ш. 4) бидэнд хэрхэн адислал болж чадах вэ?

Б Манай үеийн тухай хүснэгт хий

Дараахтай адил хүснэгтийг тэмдэглэлийн дэвтэртээ зур. “Чи ёстой,” “Чи ёсгүй” гэсэн өгүүлбэрүүдийг Сургаал ба Гэрээ 59:5–13-аас олж, эдгээр зарлигуудыг хүснэгтэн дээр жагсаан бич. Шүлэг 18–21-д Их Эзэний хэлсэн зүйлсийг хүснэгтэн дээр нэм. Эдгээр “хүснэгтүүдийг” өдөр бүр харагдах газарт тавьж болно.



В Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 59:9–10

Сургаал ба Гэрээ 58:26–27-д, бид юм болгоноор зарлигдуулаад байх хэрэггүй гэж Их Эзэн хэлсэн байдаг. Их Эзэн сургаал, зарчмуудыг заагаад эдгээр нь үнэнийг харуулахын тулд “санаа тавин” чармайхыг биднээс дараа нь хүсэн хүлээдэг. Сургаал ба Гэрээ 59:9–10 Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахихтай холбоотой үндсэн сургаал, зарчмуудыг тоймлон авч үзсэн байдаг ч, өнөөдөр бид юу хийх ёстой, юу хийх ёсгүйг тусгайлан заадаггүй.

1. Сургаал ба Гэрээ 59:9–10-аас Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь сахихад баримтлах ёстой чухал сургаал, зарчмуудыг жагсаан бич.
2. Жагсаалтан дээрээ шүлэг 11–16-д заасан зүйлүүдийг нэм.
3. Хүндэтгэлийн өдрийг ариунаар нь бүрэн сахихын тулд чи улам олон удаа хийж байх нэг зүйлийн тухай бас бүр цөөн хийж байх (эсвэл бүрмөсөн орхих) нэг зүйлийн тухай бич.



1831 оны зургадугаар сард Огайогийн Көртландаас Миссури рүү явахдаа “үгийг замдаа номлох” (С ба Г 52:9) олон номлогчийг Их Эзэн дууджээ. Сүмийн дараагийн чуулганыг Миссурид хийсэн байна (шүлэг 1–2-ыг үз).

“1831 оны наймдугаар сарын 8-ны өдөр, . . . ахлагч нар юу хийх ёстойгоо асуув. . . Тэдний зарим нь зэмлэл хүртэв. Учир нь тэд Огайгоос явах замдаа өгсөн зөвлөгөөг дагаагүйн улмаас Их Эзэн тэдэнд баярласангүй. Сайн мэдээг замын дагуу номлож, хүмүүсийн дунд гэрчлэлээ хэлэхийг тэдэнд зарлиг болгосон байлаа. Гэвч тэдний зарим нь хүнээс айсны улмаас эл зарлигийг эрхэмлэн биелүүлсэнгүй ажээ. Хүн бүр төрөлхөөсөө номлогч байдаггүй нь үнэн л дээ, гэвч энэ нь унасан энэ дэлхийд бидний биелүүлэх ёстой үүрэг байтал Сайн мэдээг тунхаглахын тулд дуу хоолойгоо өргөх хариуцлагаас хулчийдаг хүмүүс байдаг. Бүхий л ‘зүрх сэтгэл, хүчин чадал, оюун болон чадлаараа’ Их Эзэнд үйлчлэхээр ахлагч нар бүр эхлэлээс зарлигдуулсан юм. Учир нь талбай цагаан, хадахад бэлэн байлаа. Зарлигийг биелүүлээгүй хүмүүст шийтгэл оногдуулах хэрэгтэй байв. Тэд эцсийн өдөр гэм буруугүй байх боломжгүй байв. Сайн мэдээг номлох нь тэдний хувьд мөхөхгүй байхаас гадна бодгальдаа авралыг авчрах арга хэрэгсэл байлаа. Хүнээс айсан хүмүүс илгээгдсэн ахлагч нарын дотор олон байсан ч, хэрэв тэд Түүнд итгэх юм бол, ажил үйлст нь тэднийг дэмжихээр Их Эзэн амласан юм” гэж Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит бичжээ (Church History and Modern Revelation, 1:220).

Сургаал ба Гэрээ 60 дахь зааврын ихээхэн хэсэг нь Сүмийн эхэн үеийн ахлагчдад холбогдолтой байсны нэгэн адил өнөөдөр ч бидэнд бас хамаатай юм. Бид дэлхий дээрх үүрэг зорилгоо биелүүлэх хангалттай цаг хугацаа, авьяас чадвараар адислагдсан билээ. Бид цаг зав, авьяас чадвараа үр ашигтайгаар хэрэглэхийг анхаарах нь бидний сорилтын нэг хэсэг юм. Энэ илчлэлтийг судлахдаа, Их Эзэний үгс бас танд хэрхэн холбогдох тухай бод.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 60

Сургаал ба Гэрээ 60:8, 13–14—“Ёс бусчуудын цугларалтууд”

“Ёс бусчуудын цугларалт” (С ба Г 61:30, 32–33; 62:5; 68:1-ийг бас үз) гэдэг бол, хилэнцэт санаа бодлын улмаас бус харин Их Эзэний арга замуудыг үл тоомсорлодог учраас буруу зүйл хийдэг хүмүүс юм (С ба Г 123:12-ыг үз).

Сургаал ба Гэрээ 60:15—“Хөлийнхөө тоосыг гүвэгтүн”

Сургаал ба Гэрээ 24:15 (х. 00 [36])-ын “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз.

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 60-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас нэгийг хий.

А Бэлгэдэл бий болго

Зураг нь зарим үед замын хөдөлгөөний тэмдэг шиг, санаануудыг илэрхийлэхэд ашиглагддаг. Сургаал ба Гэрээ 60:2–4-ийн дараах санаануудыг авч үзэн, эдгээр санаа бүрийг илэрхийлэхэд хэрэглэж болох нэг бэлгэдлийг зур. Эдгээр шүлгүүдэд заагдсан Их Эзэний санааг уг бэлгэдэл хэрхэн илэрхийлж байгааг бэлгэдэл бүрийн дэргэд тайлбарла.

1. Амаа нээ (ш. 2)
2. Авьяас чадвараа бүү нуу (ш. 2)
3. Хүнээс бүү ай (ш. 2)
4. “Миний уур дүрэлзэж байна” (ш. 2)
5. Улам итгэлтэй бай (ш. 3)
6. “Бибээр өөрийн эрдэнэсийг сонгож авна” (ш. 4)



Б Сургаалыг тунгаан бод

Сургаал ба Гэрээ 60:1–4-д, бусад хүмүүс юу гэж хэлэх бол гэдгээс айсны учир сайн мэдээг хуваалцаагүй хүмүүст Их Эзэн уураа илэрхийлжээ. Шүлэг 3–4-д Их Эзэн Өөрийнхөө болон эцсийн өдрүүдийн талаар бид сайн мэдээг бусадтай хуваалцахад илүү их зоригийг өгөх юу хэлсэн бэ? (Ром 1:16–18-ыг бас авч үз.)

В Жишээ гарга

Сургаал ба Гэрээ 60:12–17-д, Миссурийн Жаксон дүүрэг дэх Сионд цуглахыг хүссэн хүмүүст хандаж Их Эзэн ярьжээ. Энэ шүлгүүдийг уншиж, Их Эзэний зөвлөгөө өнөө үед ч хамаарахыг харуулахын тулд дараах өгүүлбэрүүдийг гүйцээ:

1. Бид . . . үед уур хилэн, сөргөлдөөнөөс зайлсхийдэг.
2. Бид . . . цагаа дэмий үрдэг.
3. Бид . . . үед авьяас чадвараа булшилдаг.



© 1997 Аль Равиндс

“9-ний өдөр [1831 оны наймдугаар сарын] би арван ахлагчийн хамт Индепенденс нутгийн төлөө Көртландыг зорив. Бид далбаат завиар мөрнийг уруудан, эхний өдөр Форт Осейж хүртэл яваад, тэнд оройн хоолондоо гоц сайхан зэрлэг цацагт хяруулын мах идлээ. Миссури, Миссисипи мөрнүүд, энэ нутгийн бусад гол мөрнүүдийн усан дээр ихэд нийтлэг байдаг олон аюул мэдэгдсэн гурав дахь өдрийг хүртэл онц гойд үйл явдал болсонгүй. Ингээд бид Макилвейны тохойд мөрний эрэг дээр буудалласны дараа нэгэн устгагч өөрийн аймшигт их сүр хүчээрээ усны гадаргуу дээр давхиж яваа үзэгдлийг Фелкс ах гэгээн цагаан өдрөөр тодоос тод харав. Бусад нь чимээ шуугианыг сонссон боловч үзэгдлийг харсангүй” гэж Бошиглогч Иосеф Смит бичжээ (History of the Church, 1:202–203).

Маргааш өглөө нь наймдугаар сарын 12-нд Сургаал ба Гэрээ 61-р хэсэгт цэдэглэгдсэн илчлэлтийг Бошиглогч хүлээн авчээ. Энэ илчлэлтийг уншихдаа Их Эзэн тэднийг “их усан дээгүүр шаламгайлан” (ш. 3) хурдлахыг хүсээгүйн шалтгаануудаас наад тал нь хоёрыг эрж ол. Энэ илчлэлт өнөө үед номлолын ажилд хэрхэн холбогдох тухай бод.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 61

Альфа ба Омега (ш. 1)—
Грек цагаан толгойн эхний
болон сүүлчийн үсэг (Их
Эзэн бүх зүйлийн дээгүүр
хүчтэйг бэлгэджээ)

Сайн зүйлүүд (ш. 17)—
Элбэг дэлбэг, арвин их бай-
даг зүйлүүд
Суваг (шүлэг 23–24)—
Хүний гараар бүтсэн усан
зам (Огайогийн Суваг)

Сургаал ба Гэрээ 61:20–22—“Их Эзэн бибээр, өчигдөр та нарт ууртай байлаа”



“Усан дээгүүр явсан гурван өдрийн үеэр ах нарын дунд зарим санал зөрөлдөөн, атгаг санаа бий болж, улмаар тайлбар, эвлэрэл шаардлагатай болсон аж. Далбаат завиар их уст мөрнөөр аялах нь удааширч байв. Хэвлэх машин худалдаж авахаар томилогдсон хүмүүс-Сидней Гилберт, Виллям В.Фелпс хоёрт бас Бошиглогч, Сидней Ригдон, Оливер Каудери нарт Көртландад түргэн буцаж ирэхийн тулд далбаат завинаас илүү тохиромжтой тээврийн хэрэгсэл олохыг зарлиг болгосон байжээ. Макилвейны тохойд хоногдсон шөнийн ихэнхийг эдгээр асуудлуудад зориулсан аж. Ах нар эвлэрч, ажил үүрэг нь илүү яаралтай байсан хүмүүс маргааш өглөө нь хуурай газраар Сейнт Льюсийг зорьж, бүлгийн үлдсэн нь мөрнөөр цааш аянаа хөөжээ” (Б.Х.Робертс, *A Comprehensive History of the Church*, 1:262–263).

Сургаал ба Гэрээ 61:30–31—Их Эзэн Огайогийн Цинцинатийн оршин суугчдад яагаад уурласан бэ?

“Энэ илчлэлтийн үед Цинцинати нь ердөө л нэг тосгон байв. Гэвч эл тосгон Индепенденс мэтийн өрнө зүгийн бусад жижиг хотуудын адил, хууль зөрчсөний улмаас том хотуудаас албадуулан хөөгдсөн хүмүүсийн цугларах газар болж байлаа. Хилийн бүх хотуудад тэр үед ёс бус бусармаг явдал ихээхэн газар авсан байв. Цинцинати дахь номлолоо биелүүлсний дараа энэ хоёр ах Көртланд руу буцах аянаа үргэлжлүүлэв” гэж Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит тайлбарлажээ. (*Church History and Modern Revelation*, 1:225)

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 61-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Бурханы хүчийг ойлгох нь

1. Сургаал ба Гэрээ 61:1–5-ыг уншиж, дараах асуултуудад хариул:
 - а. Номлогчид усаар явснаараа ямар боломжуудыг алдсан бэ?

б. Усаар явахыг Их Эзэн яагаад номлогчдод зөвшөөрсөн бэ?

2. Шүлэг 6–16-г судалж, усан дээр тэдэнд аюулгүй байх болно гэж Их Эзэн яагаад хэлснийг тайлбарла. Чөтгөрийн хүчтэй харьцуулсан Бурханы хүчний тухай та эндээс юу мэдэж авав?

Б Хэрхэн “толбогүй” байх вэ?

Сургаал ба Гэрээ 61:33–39-ийг нэгтгэн дүгнэж, юуны учир номлолд үйлчлэх дуудлага хүлээж авдаг шалтгаануудыг жагсаан бич. Өөрт чинь гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн нэг шалтгааныг сонгож, уг шалтгаан яагаад Их Эзэнд үйлчлэх сайн учир шалтгаан байдгийг тайлбарла.

Сургаал ба Гэрээ 62

Таны гэрчлэл тэнгэрт цэдэглэгддэг



Бошиглогч Иосеф Смит, Сидней Ригдон, Оливер Каудери гурав Макилвейн тохойд буудалласан үедээ Сургаал ба Гэрээ 61-р хэсгийг хүлээн авсан аж. Тэд “хуурай газраар Көртланд руу яаралтай явахад чиглүүлэгдэж, бусад нь далбаат завиар аянаа цааш хөөхөөр зааварлагджээ.

“Ингэж хуваагдан явсны маргааш нь, наймдугаар сарын 13-нд Иосеф Индепенденс руу явж байх замдаа нэлээд хэдэн ахлагчтай уулзаж, баяр баяслаар блхсан нэг цуглаан зохион байгуулсан аж [тэр үед 62-р хэсэг дэх илчлэлт хүлээн авагджээ]. Үүний дараа ахлагчид хуваагдан Бошиглогч хоёр хамтрагчтайгаа аянаа үргэлжлүүлж, бусад нь Сионы газрыг зорив.

“Бошиглогч, Сидней, Оливер гурав 1831 оны наймдугаар сарын 27-нд Көртландад хүрч иржээ. Үйл явдлаар дүүрэн аяллынхаа үед тэд сүнсний нөлөөг их хэмжээгээр мэдэрч, Бурханы хүчний олон илэрхийллийг гэрчилсэн аж. Тэдний итгэл бэхжиж, Бүхнийг Чадагчийн зорилго тэдний ухаарлын мэлмийд улам бүр тод болж. Гэрлийг хүн төрөлхтний мэлмийгээс нуухын тулд Сатаны гаргадаг хүч чармайлын талаар тэд бас ихийг мэддэг болсон аж” (Жорж К.Каннон, *Life of Joseph Smith, the Prophet [1958]*, 123–124).



Сургаал ба Гэрээ 62-р хэсгийг судлахдаа, гэрчлэлээ бусадтай хуваалцах нь яагаад ийм агуу зүйл байдгийг эрж ол. Эдгээр гэрчлэлүүдийг хэн сонсдогийг бас гэрчлэлээ хуваалцах нь амьдралд тань үзүүлдэг нөлөөг мэдэх нь таныг гайхахад хүргэж болох юм.

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 62-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Саналаа хэл

Сургаал ба Гэрээ 62:3-т, бид сайн мэдээний тухай гэрчлэлээ хуваалцахын ач холбогдлын тухай Их Эзэн өгүүлжээ. Энэ шүлгийг өөрийнхөө үгээр тэмдэглэлийн дэвтэртээ дахин бичиж, биднийг гэрчлэлээ бусадтай хуваалцахад яагаад эдгээр зүйлүүд тохиолддог тухай санал бодлоо хэл.

Б “Энэ нь надад хамаагүй хэрэг”

Сургаал ба Гэрээний өмнөх хэсгүүдэд Их Эзэн, “энэ нь надад хамаагүй хэрэг” (С ба Г 60:5; 61:22; 62:5-ыг үз) гэдэг өгүүлбэрийг ашигласан байдаг. Сургаал ба Гэрээ 62:5–8-ыг уншиж, Их Эзэн энэ өгүүлбэрийг ямар утгаар хэлснийг, мөн Тэрээр биднийг тусгай заавраар хангаагүй үедээ биднээс юу хүсэн хүлээдэг гэж бодлогоо тайлбарла.

Сургаал ба Гэрээ 63

Сионд бэлтгэх нь

Сургаал ба Гэрээ 63-р хэсгийн тоймд Сионыг байгуулах Гэгээнтнүүдийн асар их сонирхлыг дурддаг. Энэ илчлэлтэд Сион хэрхэн байгуулагдах болон Сионд очиход хэн тэнцэх тухай олон зүйлийг Их Эзэн тайлбарлажээ. Энэ хэсгийг судлахдаа Сионд амьдрахын юу нь хамгийн сайхан байх тухай бод. Эхэн үеийн зарим Гэгээнтнүүдийн энэ талаар хийж байсан юуг Их Эзэн зэмлэсэн бэ?

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 63

Завхай хүн (ш. 17)—Ёс сур- : Унтаршгүй (ш. 34)—
тахуунгүй зуршилтай хүн : Төгсгөлгүй, дуусахгүй

Сургаал ба Гэрээ 63:20–21—“Өөрчлөлтийн Өдөр”



Есүс Өөрийн Төлөөлөгчид Петр, Иаков, Иохан нарыг Өөрчлөлтийн Уулан дээр авч гараад (Матай 17:1—3-ыг үз), Христийн Хоёр дахь Ирэлтийн дараа дэлхий ямар болохыг үзүүлжээ. Тэдний харсан бүх зүйлийн бүрэн шастирыг бид хараахан хүлээж аваагүй байгааг Сургаал ба Гэрээ 63:21-д харуулдаг. Арванхоёр

Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Брус Р.МкКонки тайлбарласан нь:

“Христийн Хоёр дахь Ирэлтийн үед Их Эзэний оршихуйгаас ирэх ёстой сэргээх цагийн тухай Петр өгүүлсэн байдаг (Үйлс 3:19–21-ийг үз). Түүний үгс Итгэлийн Тунхагийн аравдугаар зүйлд ‘дэлхий шинэчлэгдэж, диваажингийн алдар суугаа хүлээн авах болно’ гэж тэмдэглэсэнтэй агаар нэг юм. Энэ үйл явдал бол ‘хүний Хүү сүр жавхлант сэнтийдээ залрах үед’ (Матай 19:28.) тохиох ‘сэргээлт’ юм. Энэ бол бас . . . дэлхий хувиран өөрчлөгдөх ‘өөрчлөлтийн’ өдөр юм. (С ба Г 63:20–21.)

“Энэ дэлхий шинэ буюу диваажингийн байдлаар бүтээгдсэн байлаа. Дараа нь Адамын нүглийн улмаас одоогийнхоо телестиел байдалд унасан ажээ. Бидний Их Эзэний Хоёр дахь Ирэлтээр газар дэлхий шинэчлэгдэж, дахин үүсэн бий болж, сэргэн өөрчлөгдөж, хувиран дахин шинэ дэлхий, диваажингийн дэлхий болно. Энэ дэлхийн мянган жилийн байдал нь уналтын өмнө оршиж байсан байдал, үзэсгэлэн төгөлдөр, алдар суут анхныхаа төрхөнд эргэн орох болно.” (Mormon Doctrine, 795–796; налууу бичлэг анхны эхэд байгаа болно.)

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит сургасан нь: “Энэ бүхэн бидний амьдарч байгаа Цаг хугацааны бүрэн байдлын эрин үед тохиох ёстой. Цаг хугацааны бүрэн байдал гүйцэлдэхэд энэ дэлхий эхлэлд ямар байсан, дахин түүн шигээ болно. Далай умард зүгт гэдрэг туугдах болно. Арлууд эх газартай нийлж, газар хуваагдахаас өмнөх үеийнх шигээ болно. (С ба Г 133:22–24.)” (Church History and Modern Revelation, 1:231.)

“Өөрчлөлтийн энэхүү өдөр” “шинэ тэнгэр, шинэ газар бий болох үеийнхээс өөр юм. Мянган Жилийн дараа дэлхийн төгсгөл ирж, улмаар дэлхийн амилуулалт, дэлхийн алдар суу ирж, “зөв шударга хүмүүс буюу селестиел хаант улсад харьяалагдах хүмүүсийн гэр орон болж, зөвхөн тэд энд амьдрах болно” гэж Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит тайлбарлажээ (Doctrines of Salvation, 3:282.)

Сургаал ба Гэрээ 63:25–27—“Их Эзэн Бибээр, Цезарийн зүйлүүдийг Цезарьт нь огдог билээ”



Иудейчүүд Ромын Эзэн хаан Цезарьт татвар төлдөг нь хуульд нийцэх үү гэж ахлах тахилчид, хуулийн багш нар асууж, Есүсийг занганд оруулахыг хэрхэн оролдсон тухай бид Лук 20:19–26-д уншидаг. Хэрэв Тэрээр тийм ээ, нийцнэ гэж хэлэх юм бол, иудейчүүд өөрсдийг нь

түрэмгийлэн эзэлсэн ромчуудыг үзэн яддаг учраас Түүнийг эсэргүүцэх болно гэдгийг тахилчид, багш нар нар мэдэж байв. Хэрэв Есүс үгүй, нийцэхгүй гэж хэлбэл, тэд Түүнийг ромчуудад мэдэгдэхэд, Ромын захиргаанаас урван тэрсэлсэн гэж үзээд, ромчууд Түүнийг баривчлах байв. Цезарийн дүрстэй зоосыг Есүс тэдэнд үзүүлж, “Цезарийн зүйлүүдийг Цезарьт, Бурханы юмыг Бурханд өг (ш. 25) гэжээ.

Хэдийгээр дэлхий бүхэлдээ Их Эзэний ч гэсэн, Миссурид Сионы хотыг байгуулах газрыг Гэгээнтнүүд худалдаж авах ёстойг Бошиглогч Иосеф Смитийн үед Гэгээнтнүүдэд заахын тулд Их Эзэн энэ түүхийг ашиглажээ.

Сургаал ба Гэрээ 63:34—“Мөн гэгээнтнүүд тэрчлэн арай ядан зугатаах болно”

Бошиглогч Иосеф Смит Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн тухай ярьж, тайлбарлахдаа: “Ёс бусчууд гашуун зовлонгоо эдлэхэд Гэгээнтнүүд бүх шүүлтээс мултрах болно гэдэг нь хуурмаг санаа юм. Учир нь бүх маханбод зовох болно.

Бүр 'эв шударга хүмүүс ч арай ядан мултрах болно' Гэгээнтнүүдээс ч бас олон нь мултарна. Учир нь шударга хүмүүс итгэлээр амьдарна. Гэвч зөв шударга хүмүүсээс олон нь махан биеийн сул доройн шалтгаанаар өвчин, тахал зэргийн золиос болон унана. Тэглээ ч гэсэн тэд Бурханы хаант улсад аврагдана. Өвчин болон үхлийн золиос болдог учраас ийм хүмүүс зөрчил гаргадаг гэж хэлэх юм бол, энэ нь ариун биш зарчим болно, учир нь бүх маханбод үхлийн эрхшээлд байдаг. Иймд 'Та шүүгдэхгүйн тулд, бүү шүү' гэж Аврагч хэлсэн юм" гэжээ (*History of the Church*, 4:11).

Сургаал ба Гэрээ 63:50—"Хүмүүний нас" гэж юу вэ?

Бидний одоогийн мөнх бус байдалд хүний нас далан хоёр жил юм хэмээн нифайн шавь нарт Их Эзэний өгсөн амлалтад дурддаг (3 Нифай 28:1–3-ыг үз). Гэвч Мянган Жилийн үед ийм байхгүй.

"Тэр үеийн Бошиглогч Исаиа өгүүлэхдээ: 'Тэнд цөөхөн хоног амьдардаг нялхас ч, өөрийн өдрүүдийг гүйцээгээгүй хөгшид ч байхгүй болно: *зуу наслаад үхэх хүнийг залуу хүн гэж тооцох болно*' (Исаиа 65:20; налуу бичлэг нэмэгдсэн) гэжээ.

"Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит энэ нөхцлийг тайлбарлаж, хэлсэн нь: 'Дэлхий дээрх хүмүүс мөнх бус хэвээр байна, гэвч өвчин эмгэг, гай гамшиг, үхэл хагацлыг даван туулах хүч тэдэнд байхаар тийм өөрчлөлт тэдэн дээр ирнэ. Үхэл байх боловч газар дэлхийгээс арилна. Учир нь хүмүүс модны насыг хүртэл буюу нэг зуу насална ([С ба Г] 63:50–51-ийг үз), тэгээд хүмүүний насанд тэрээр нас нөгчих нь түүнд өгөгдсөн бөлгөө. Гэвч энэ үхэл нүд ирмэх зуур ирэх бөгөөд мөнх бус байдлаас гэнэт үхэшгүй байдалд орно. Булш байхгүй болж, зөв шударга хүмүүс алдар суут амилуулалтад дээш авагдана" гэжээ ([*Church History and Modern Revelation*,] 1:461; налуу бичлэг нэмэгдсэн) (Брювстер, *Doctrine and Covenants Encyclopedia*, 10).

Сургаал ба Гэрээ 63:61–64—"Миний нэрийг уруулдаа хэрхэн авахад бүх хүмүүн болгоомжлог"

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Жеймс И.Талмейж заахдаа:

"Бурханы нэрийг дэмий хоосон хэрэглэх гэдэг нь . . . энэ нэрийг байх ёстойгоор нь биш, харин хөнгөн хуумгай, хоосон, үр ашиггүйгээр хэрэглэх явдал мөн. . . .

"Товчхон хэлбэл:

"1. Бид бүдүүлэг үг хэллэгээр Бурханы нэрийг дэмий хоосонд аваачиж болно.

"2. Бид хуурамчаар тангарагласнаар, андгай тангараг, амлалтуудаа биелүүлэхгүй байснаар Бурханы нэрийг хоосонд аваачдаг.

"3. Бид энэ нэрээр эрх мэдэлгүйгээр ярихаар бүдүүн зүрх гаргасан үед бий болдог гутаан доромжлогч мэдрэмжээр Түүний нэрийг хоосонд аваачдаг.

"4. Бид Түүний нэрийг өөрсөд дээрээ авснаас хойш зарлигуудыг эсэргүүцэх ямар нэг зүйлийг санаатайгаар хийснээр Түүний нэрийг хоосонд аваачдаг" гэжээ (In Conference Report, 1931 оны 10-р сар, 50, 53).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 63-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас гурвыг хий.

А Сэрэмжлүүлгийн тэмдгүүд ба Сургаалт үг

Итгэхээсээ өмнө тэмдгүүд болон гайхамшгуудыг эрэлхийлдэг эсэргүүцэгчдэд зориулсан хүчирхэг үгсийг Их Эзэн хэлжээ.

1. Сургаал ба Гэрээ 63:1–12-ыг судалж, ёс бусчуудын хүлээн авах "тэмдгүүдийн" хэлбэрийг тайлбарла.
2. Шүлэг 5–12-оос сурч мэдсэн зүйлүүдээ ашиглан, Их Эзэний таашаадаггүй хүмүүст сэрэмжлүүлэх нэлээд хэдэн тэмдгийн талаар бичих зүйлүүдээ жагсаа.
3. Тэмдэг эрэгчдэд Их Эзэний өгсөн сэрэмжлүүлгийг илэрхийлсэн нэг зүйр үг эсвэл амархан тогтоогдох нэг хэллэгийг бич.

Б Үр дагавруудыг тогтоо

Бидний хийдэг юм бүхэн-бидний сайн үйлс, бидний нүглүүд өөрийн гэсэн үр дагавартай байдаг.

1. Тэмдэглэлийн дэвтэртээ дөрвөн багана хий. Багануудыг "Нүглүүд", "Нүглийн үр дагаврууд", "Нүглийн хувилбар", "Нүглийн хувилбарын үр дагаврууд" гэж гарчигла.
2. Сургаал ба Гэрээ 63:13–19-ийг уншиж, энд дурдсан нүглүүдийг эхний багананд жагсаан бич. Хоёр дахь багананд нүгэл тус бүрийн үр дагавруудыг жагсаан бич.
3. Шүлэг 20–21-ийг уншиж, нүглийн хувилбар болон үр дагавруудынх нь тухай мэдээллийг холбогдох багануудад бич.
4. Зарим хүмүүс дуулгавартай дагахын оронд яагаад нүгэл үйлддэг гэж та боддог вэ? Дуулгавартай байдал яагаад илүү сайн сонголт байдаг вэ?

В Мэдлэгийн түлхүүр

Сургаал ба Гэрээ 63:22–23, Алма 12:9–11-ийг унш. Бидэнд хандаж хэлсэн зүйлүүд хаант улсын "нууцуудыг" ойлгох түлхүүр байдаг тухай товчлон бич. Их Эзэн яагаад үүнийг шаарддаг гэж та боддог вэ?

Г Санаа чинь зовж байна уу, эсвэл тайтгарав уу?

Сургаал ба Гэрээ 63:32–37-д эцсийн өдрүүдийн тухай Их Эзэн юу гэж заасныг нэгтгэн дүгнэ.

1. Хоёр дахь Ирэлтийн талаар зарим хүмүүсийг санаа нь зовоход хүргэж болох нэг бошиглолыг сонгож, яагаад энэ нь хүмүүсийн санааг зовоож болохыг тайлбарла.
2. Зарим хүмүүсийг тайтгаруулж болох өөр нэг бошиглолыг сонгон, яагаад гэдгийг тайлбарла.
3. Эцсийн өдрүүдэд амьдрах тухайд юу гэж бодлогоо тунгаан бодож, Хоёр дахь Ирэлтийг айдсын оронд итгэлээр угтахад хэрхэн бэлтгэхээ дүрсэлсэн нэг догол мөр бич (шаардлагатай бол энэ хэсгийн "Судруудыг ойлгох нь" хэсгийг үз).

Д Мянган Жил юутай адилхан байх вэ?

Сургаал ба Гэрээ 63:47–54-ийг судлаад, Мянган Жилийн үед Сион дахь амьдрал ямар байхыг дүрсэлсэн тодорхойлолт бич. Өв, үхэл, хүний нас, нүд ирмэх зуур өөрчлөгдөх, тусгаарлалт зэрэг дараах гол чухал санаануудыг дүрслэлдээ оруулахыг анхаар (шаардлагатай бол энэ хэсгийн “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз).



Бидний мэддэг шиг тийм үхэл Мянган Жилд байхгүй болно.

Е Өнөө үеийн жишээ гарга

Их Эзэний нэрийг дэмий хоосон болгодог хүний тухай бид бодохдоо, ихэвчлэн бүдүүлэг үг ярианы тухай боддог. Энэ нүглийг үйлдэх өөр хэлбэрүүд байдгийг Сургаал ба Гэрээ 63:60–64-т тайлбарлажээ. Эдгээр шүлгүүдийг болон Сургаал ба Гэрээ 63:61–64-ийн “Судруудыг ойлгох нь” хэсгийг судлаад, Их Эзэний нэрийг хоосон хэрэглэхээс бид хэрхэн зайлсхийж болох тухай өнөө үеийн хэдэн жишээ бич.

Сургаал ба Гэрээ 64 Бусдыг уучлах нь

Сургаал ба Гэрээ 64-р хэсэг хүлээн авагдсан үед Бошиглогч Иосеф Смит гэр бүлийнхээ хамт Кортландаас зүүн өмнөд зүгт гуч орчим бээрт орших, Огайогийн Хайрам руу шилжихээр бэлтгэж байв. Бошиглогч Библийн орчуулгын ажлаа тайван үргэлжлүүлэх газартай байхын тулд саяхны хөрвөгчид Жон Жонсон, Алис Жонсон нар тэднийг өөрсөдтэйгөө хамт амьдрахыг урьсан ажээ.

Энэ илчлэлтийн эхний хэсэгт, бүх зарлигуудаас хамгийн хэцүү нь, бидэнд хохирол учруулсан эсвэл биднийг гомдоосон хүмүүсийг уучлах явдал мөн. Энэ бол бидний үүрэг гэдэгт зарим хүмүүс хэрхэн хандагийг энд авч үзжээ. Бусдыг уучлахаас татгалздаг хүмүүст Их Эзэний илчилсэн гайхалтай үнэнийг ажигла.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 64

Далим эрэх (шүлэг 6, 8)— Дугагдал олохыг хичээх, ул
Дугагдал олохыг хичээх, ул : Вавилон (ш. 24)—Дэлхийн
Дугагдал олохыг хичээх, ул : буюу дэлхийн шинж байд-
шагайх : лын бэлгэдэл

Сургаал ба Гэрээ 64—Огайогийн Хайрам руу шилжсэн нь

Бошиглогч Иосеф Смитийг гэр бүлийнхээ хамт Жон Жонсоных (“Эцэг Жонсон” хэмээн Сүмд нэрлэгддэг байсан) руу шилжин ирэхийг урьсан урилга бол, ажлаа үргэлжлүүлэх боломжтой “гэр орныг өөрсдөдөө эрж хайхыг” (С ба Г 63:65) Иосеф, Сидней Ригдон хоёрт зарлиг болгосон Их Эзэний зарлигийн хариу байлаа. Жонсоныхон Бошиглогч Иосефтой учирсан гайхалтай туршлагынхаа үр дүнд Сүмд нэгдсэн ажээ:



Огайогийн Хайрам дахь Жон Жонсоныхны гэр

“Бошиглогчийг Огайод ирсний дараахан, тавин гурван настай эцэг Жонсон эхнэр Элсагийнхаа хамт бас методист тохинуулагч Эзра Бүүт нар Мормоны пашныг сонирхохоор Кортландад хүрч иржээ. Шинэ пашны номнолын тухай ярилцаж байх үеэр Элса [Алис] үе мөч-

ний архаг өвчнөөсөө эдгэрсэн гэдэг. Түүхэн баримтанд энэхүү гайхалтай эдгэрэлтийн талаарх нарийн ширийн зүйлүүдийн талаар бичихдээ, тухайлбал ‘Ярилцлагын үеэр яриа төлөөлөгчдийн үед өгөгддөг байсан ер бусын бэлгүүдийн тухай сэдэвт шилжсэн ажээ. Хэн нэгэн: “Хатагтай Жонсон хатангиршсан тахир гартай байна. Эдүгээ Бурхан дэлхий дээр хэн нэгэнд түүнийг эдгээх ямар нэгэн хүчийг өгсөн болов уу?” гэж хэлэв. Хэдэн мөчийн дараа ярианы сэдэв өөрчлөгдөхөд, Смит босч өрөөн дундуур алхалж ирээд, хатагтай Жонсоны гараас барьж, ихэд хүндэтгэлтэйгээр, сэтгэл догдлом байдлаар: “Эмэгтэй, Их Эзэн Есүс Христийн нэрээр, эдгэр хэмээн би танд зарлиг болгож байна” гэж хэлчихээд даруй өрөөнөөс гарч явлаа.’ Элса тэр дорхноо эдгэрч, маргааш нь ‘хүндрэл буюу өвдөлтгүйгээр угаалгаа хийжээ’ хэмээн түүхэн цэдэгт тэмдэглэсэн байдаг [History of the Church, 1:215–216, зүүвэр тайлбарыг үз]. Энэ гайхалтай эдгэрэлт нь Жонсоны аав ээж хоёр тэр даруйд хөрвүүлэг хийж, Бошиглогчоор баптисм хүртэх замд шууд хөтөлжээ” (Блак, Who’s Who in the Doctrine and Covenants, 152).



“Их Эзэн, бибээр өршөөх түүнийгээ би өршөөх болно, харин бүх хүмүүнийг уучлах нь та нараас шаардагдана” (С ба Г 64:10).

Сургаал ба Гэрээ 64:7—“Үхэлд хүргэх” нүгэл үйлдэх гэж юу гэсэн үг вэ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Брус Р.МкКонки: “Тэрлээс бас сайн мэдээний үнэнээс эргэж няцдаг хүмүүс; өөрсдийгөө Сатанд тушаадаг хүмүүс; түүнд дэмжлэг туслалцаа үзүүлж, зорилгод нь дайчлагддаг хүмүүс; мөн ингэснээрээ түүний хүүхдүүд болдог хүмүүс ийм замаар үхэлд хүргэх нүгэл үйлддэг. Тэдний хувьд наманчлал гэж үгүй, уучлал гэж үгүй, авралын найдвар огтоос үгүй. Тэд бол Сатаны хүүхдүүд учраас мөхлийн хөвгүүд юм” гэж тайлбарлажээ (*Mormon Doctrine*, 737).

Сургаал ба Гэрээ 64:21—Фредерик Г.Виллямс




Фредерик Г.Виллямс 1830 оны аравдугаар сард, Огайогийн Көртландад сүмд нэгдсэн аж. Тэрээр баптисмынхаа дараа удалгүй номлолд итгэлтэйгээр үйлчилжээ. 1832 онд Их Эзэн Виллямс ахыг Тэргүүн Зөвлөлд Бошиглогч Иосеф Смитийн зөвлөхөөр дуудав. Бошиглогч түүнд итгэдэг байлаа. Тэр Сүмийн итгэлтэй удирдагчдын нэг байв. 1837 онд үнэний төлөө хоёргүй сэтгэлээр зүтгэхдээ гуйвж дайвж эхэлсэн аж. Тэрээр дуудлагаасаа чөлөөлөгдөж, Сүмийн гишүүнчлэлээ алдав. Тэр 1838 онд дахин баптисм хүртэж, 1842 онд нас барах хүртлээ итгэлтэй хэвээр байсан гэдэг (Блак, *Who's Who in the Doctrine and Covenants*, х. 346–348-ыг үз).

Сургаал ба Гэрээ 64:23—Энэ шүлгэн дэх “Аравны нэг” юуг зааж байна вэ?

Сургаал ба Гэрээ 64-р хэсэгдэх илчлэлтийг хүлээн авснаас хойш ойролцоогоор долоон жил болтол аравны нэгийн хууль өгөгдөөгүй байв (С ба Г 119-ийг үз). Шүлэг 23-т хэрэглэгдсэн “аравны нэг” гэдэг нэр томьёо бол “зөвхөн аравны

нэг хувь төдийгүй, Сүмийн санд оруулах сайн дурын бүх өргөл ба хандив” (С ба Г 119-ийн тойм) гэсэн утгатай ажээ.

Сургаал ба Гэрээ 64:21—Их Эзэн яагаад “Көртландын нутагт таван жилийн хугацаанд хүчирхэг түшицтэй үлдэхийг” хүссэн бэ?



Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит сургадаа: “Энэ газарт энэ эрин үеийн анхны ариун сүм баригдах ёстой байлаа. Энэ ариун сүмд Сэргээлтийн амин чухал түлхүүрүүд илчлэгдэх учиртай байв. Бүх хүмүүс тэр үед Миссури дэх Сион руу шилжин ирж, ариун сүмийн барилгад тэдний дайснууд саад учруулж магадгүй байв. . . . Эртний бошиглогчдын эзэмшиж байсан санваарын түлхүүрүүдийг сэргээх нь Сүмийн өсөлт дэвшилтэд нэн чухал байлаа. Өөрөө энд ирж болох бас хүчний эдгээр түлхүүрүүдийг эзэмшдэг элчүүдээ илгээж болох өөрийнх нь нэрэн дээр баригдах өргөө буюу ариун сүмийг Көртландад барихыг Их Эзэн хуульчилсан ажээ. Ариун сүмийг барихад цаг хугацаа шаардагдана. . . . Көртландад хүчирхэг түшицтэй байхыг Их Эзэн Гэгээнтнүүдэд уриалсан илчлэлтийг 1831оны есдүгээр сарын 11-нд өгсөн ажээ. 1836 оны гуравдугаар сард Их Эзэний өргөөг онцгойлон адисалж, дараагийн сард нь ариун түлхүүрүүдийг олгосон юм” гэсэн байна (*Church History and Modern Revelation*, 1:237).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 64-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 64:9–11

Бид бүгд нүгэл үйлддэг. Иймээс бид өршөөлийг эрэх хэрэгтэй. Сургаал ба Гэрээ 64:7–11-д Их Эзэн хэнийг өршөөх талаар зарим тодруулга хийсэн байдаг.

1. “Их Эзэн бибээр, . . . нүглүүдийг нь өршөөдөг билээ” гэсэн өгүүлбэрийг тэмдэглэлийн дэвтэртээ бич. Шүлэг 7–11-ээс хүлээх, асуух, үхэл, өршөөх, уучлах гэдэг үгсийг олж, Их Эзэний өгүүлсэн уучлагдах дөрвөн нөхцөлийг жагсаан бич.
2. Дөрөв дэх нөхцөл (шүлэг 8–10-ыг үз) маш хэцүү гэж зарим хүмүүс боддог. Та үүнийг яагаад зөвшөөрч байгаа, эсвэл яагаад зөвшөөрөхгүй байгаагаа тайлбарла.
3. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн Ахлагч Боид К. Пакер: “Уучлал бол сүнсний хүчтэй эм юм. Илааршуулагч гавар-өөрийг чинь гомдоосон хүмүүсийг уучлах нь эдгээлт юм” гэж хэлжээ (*In Conference Report*, 1987 оны аравдугаар сар, 20; *Ensign*, 1987 оны 11-р сар, 18). Ахлагч Пакерын үгсийг ашиглан, уучлахаас татгалзах нь яагаад “илүү их нүгэл” (С ба Г 64:9) болно гэж боддогоо тайлбарла.

Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 64:23

Сургаал ба Гэрээ 64:23-т, аравны нэгийг шударгаар төлөх нь Түүний Хоёр дахь Ирэлтийг дагалдах цэвэршүүлэлтэнд шатаагдахаас хамгаалах хамгаалалт мөн гэдгийг Их Эзэн харуулжээ.

1. Шүлэг 23-ыг шүлэг 24-тэй харьцуулж, аравны нэгийг шударгаар төлөх нь “бардам” бөгөөд “ёс бусыг үйлддэг” хүмүүсийн дунд байхаас хүнийг хэрхэн холдуулдгийг тайлбарла.
2. Аравны нэгийг бүрэн төлдөг хүн бусад зарлигуудыг бас сахидаг гэж чи яагаад боддог вэ?
3. Аравны нэгийг бүрэн төлөгчдийн зарим нийтлэг шинж чанарыг дүрслэхийг эцэг эхээсээ эсвэл санваартны аль нэг удирдагчаас хүс. Аравны нэгийг бүрэн төлөхийн үнэ цэнэ, ач холбогдлын талаар энэ яриа танд юуг өгүүлж байна вэ?



“Аравны нэгээ төлдөг тэрээр Миний ирэлтээр шатаагдах нь үгүй” (С ба Г 64:23).

В Зоригжуулан дэмжсэн захидал бич

Номлолд үйлчлэхээр төлөвлөж байгаа боловч, өөрийгөө амжилт олох найдваргүй гэж санаа нь зовж байгаа нэг найз өөрт чинь байдаг гэж бод. Сургаал ба Гэрээ 64:29–33-т Их Эзэний хэлсэн зүйлүүдийг ашиглан, найзыгаа зоригжуулан дэмжсэн захидал бич. Түүнийг зоригжуулах юуг Их Эзэн хэлснийг тайлбарла. Эдгээр шүлэгт өгүүлснээр тэр номлолдоо ямар “амжилт” олж чадахыг, бас яагаад амжилт гаргаж чадахыг тайлбарла.

Г Өгүүлбэр дэх түлхүүр үгсийг ашигла

Сургаал ба Гэрээ 64-р хэсэгт, Сион ямархуу байх талаар илүү их мэдээллийг Их Эзэн өгчээ. Шүлэг 37–43-ыг нэгтгэн дүгнэж, *шүүх, алдар суу, туг, дагжин чичрэх* гэдэг үгсийг ол. Дараа нь эдгээр үгс Сионыг хэрхэн дүрсэлснийг тайлбарласан өгүүлбэрт дээрх үгсийг ашигла.

Сургаал ба Гэрээ 65

Газар дээрх Бурханы Хаант улс Тэнгэрийн Хаант улсын замыг бэлтгэдэг



Бурханы хаант улс ирэхийн төлөө залбирахыг Их Эзэн иавь нартаа Шинэ Гэрээнд зааварласан байдаг (Матай

6:10-ыг үз). Бурханы хаант улс гэж юу вэ, энэ хаант улс хаана байдаг вэ? Бурханы хаант улс, тэнгэрийн хаант улс хоёр адилхан уу? Илчлэлтээр өөрт нь өгөгдсөн залбирал хэмээн Бошиглогч Иосеф Смитийн хэлсэн Сургаал ба Гэрээ 65-р хэсэгэдгээр асуултаудад хэдэн чухал хариулт өгдөг.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 65

Бурханы хаант улсын түлхүүрүүд (ш. 2)— Сүмийг тэргүүлэх санваарын эрх мэдэл

Итгэмжлэгдсэн (ш. 2)— Эрх мэдэл өгөгдсөн, томилогдсон

Дарагдах (ш.6)— Дийлэгдэх, ялагдах

Сургаал ба Гэрээ 65:2—“Гараар урагш өнхрүүлэгүй уулнаас таслагдсан чулуу” гэж юу вэ?

Урагш өнхөрч бүх дэлхийг дүүргэх чулууны тухай дүрслэл бол хожмын өдрүүдэд Бурханы хаант улс сэргээгдэх тухай Хуучин Гэрээний бошиглолоос үүдэлтэй юм (Даниел 2:28–45-ыг үз). Энэ сэргээлтийн тухай Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлсэн нь:

“Бид бол дэлхий дээрх хамгийн агуу хаант улс-хүмүүний мэргэн ухаанаар удирдуулдаггүй, харин Их Эзэн Есүс Христээр удирдуулдаг хаант улсын иргэд билээ. Энэ хаант улс байгаа нь бодитой юм. Эл хаант улсын хувь тавилан тодорхой. Энэ бол бошиглогч Даниелын өгүүлсэн хаант улс-гараар өнхрүүлэгүйгээр уулнаас тасарч, урагш өнхрөн, дэлхийг дүүргэх хаант улс юм. (Даниел 2:34–35-ыг үз.)

“Мөнх бус хүмүүн энэ хаант улсыг байгуулаагүй юм. Энэ хаант улс бурханлиг тэргүүнээсээ илчлэлтээр дамжин ирсэн. Эл хаант улс арван есдүгээр зууны үеэс эхэлснээсээ хойш уулнаас өнхрөн улам томорсоор байгаа цасан бөмбөг лүгээ адил урагш ахиж байна.” (“Pillars of Truth,” *Ensign*, 1984 оны 1-р сар, 4).



“Сайн мэдээ өвч дэлхийг дүүргэх хүртлээ гараар урагш өнхрүүлэгүй уулнаас таслагдсан чулуу лугаа адил, дэлхийн бүх хязгааруудад ураги тгүгэх болно” (С ба Г 65:2).

Сургаал ба Гэрээ 65:5–6—Бурханы хаант улс, Тэнгэрийн хаант улсын хоорондох ялгаа юу вэ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Жеймс И.Талмейж тайлбарлахдаа:

“Бурханы хаант улс” гэдэг хэллэг ‘Христийн Сүм’ гэдэг нэр томъёотой адил утгаар хэрэглэгддэг. Харин ‘Тэнгэрийн хаант улс’ гэдэг нэр томъёог Их Эзэн зарим үед ялгаатай утгаар хэрэглэдэг нь тодорхой болсон билээ. 1832 онд Тэрээр Өөрөө Сүмийн ахлагчдад хандаж үг хэлэхдээ, энэ үгэнд анхаарал хандуулахыг дараах үгсээр уриалжээ [С ба Г 65:1–6-г үз].

“Залбирал нь үгсийг зүгээр л давтаж урсгах биш, зүгээр л нэг хэлээд өнгөрөх биш, харин Тэнгэрийн хаант улсын ирэлтэд газар дэлхийг бэлтгэхийн тулд Бурханы хаант улс урагш ахин хөгжихийн төлөө залбирахыг энэ хүмүүст зөвлөдөг байсан, залбирал одоо ч ийм л байгаа. Таны хаанчлал ирэх болтугай, хүсэл чинь тэнгэрт шигээ газар дээр биелэгдэх болтугай” гэж Их Эзэний залбирал хүчинтэй хэвээр байг. Тэнгэрийн хаант улс ирэхийн төлөө, түүний ирэлтэд дэлхийг бэлтгэхэд хичээн зүтгэхийн төлөө бид залбирч байна. Дэлхий дээр аль хэдийн бий болсон Бурханы хаант улс . . . оршин байгаа засаг төрийн бүхий л хэлбэрийг түлхэн унагаахыг эрэлхийлдэггүй. Тэнгэрийн хаант улс ирж, Хаанаар тэргүүлүүлэн, дэлхийд үндэслэгдэн бий болохоос өмнө зөв зарчмуудыг заах болон шударга засаг төрийн зарчмуудын дагуу амьдрах хүмүүсийг төлөвшүүлэхээс бусад, дэлхийн засгийн газруудад хамаарах асуудлуудад хяналт тавихыг зорьдоггүй. Гэвч Тэрээр захирч, хаанчилна, учир нь ийнхүү хаанчлах нь Түүний эрх юм” гэжээ (In Conference Report, 1916 оны 4-р сар, 128–129).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 65-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Нийлэмж үгсийг шүлэгтэй тохируул

Сургаал ба Гэрээ 65-р хэсэг дэх нийлэмж үгийг утгыг нь хамгийн сайнаар илэрхийлж байгаа өгүүлбэр буюу нийлэмж үгтэй тохируул.

1. “Түүний замуудыг шулуун болго” (ш. 1)	а. Санваарын эрх мэдэл
2. “Бурханы хаант улсын түлхүүрүүд” (ш. 2)	б. Итгэлтнүүд Христийг угтахаар цугларах
3. “Уулнаас тасарсан . . . чулуу” (ш. 2)	в. Агуу гэрэл ба хүчийг үзүүлэх
4. “Хурганы үдшийн зоог” (ш. 3)	г. Хожмын өдрүүд дэх сэргээгдсэн Сүм
5. “Алдар суугийнхаа гялбаанд хувцаслагдан” (ш. 5)	д. Замыг бэлтгэ, юмсыг бэлэн болго

Б Залбирлыг дүгнэ

Сургаал ба Гэрээ 65:4–6-д Иосеф Смитийн залбирсан зүйлүүдийг нэгтгэн дүгнэж, эдгээр үйл явдлуудад туслахын тулд чи юу хийж чадахаа тайлбарла.



Виллям Э.МакЛелин сайн мэдээгээр хэрхэн илүү сайн амьдрахыг мэдэхэд өөрт нь туслах илчлэлтийг Бошиглогч Иосеф Смитээс хүсчээ. Сургаал ба Гэрээ 66-р хэсгийг судлахдаа, МакЛелин ах илчлэлтийн талаар юу гэж бодсон байж болохыг бод. Аль хэсгүүд нь тайтгаруулж, урам дэм өгч байна? Аль хэсгүүд нь сэтгэл түгшүүлмээр байна?

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 66

Алдсууд (ш. 1)—Нүгэл : Түүртэх (ш. 10)—Ачаалал : ихтэй, дарамттай байх

Сургаал ба Гэрээ 66—Виллям Э. МакЛелин

Виллям МакЛелин Харви Витлок, Давид Витмер хоёроос сэргээгдсэн сайн мэдээний захиасыг сонсох үедээ Иллинойн Парист амьдарч байжээ. Тэрээр 30–40 сурагчтай сургуулиа хааж, Миссурин Индепенденсий зорив. 1831 оны наймдугаар сарын 20-нд Хайрум Смит түүнд баптисм хүртээжээ. Тэрээр урвасны учир 1838 онд Сүмийн гишүүн байх эрхээ хасуулсан байна.


Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 66-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Жишээг ол

Виллям Э. МакЛелинд өгсөн урам хайрласан амлалтууд, залруулга болон сэрэмжлүүлгийг Сургаал ба Гэрээ 66-р хэсэгт агуулдаг.

1. Энэ илчлэлт дэх амлалтын нэг жишээ, залруулгын нэг жишээг тэмдэглэлийн дэвтэртээ бич. Жишээ, залруулгыг олсон шүлгийн дугааруудыг бич.
2. Эл илчлэлт өнөө үед бидний хүлээн авдаг патриархын адислалтай хэр зэрэг адилхан байна вэ?
3. Иаков 4:7, Ифер 12:27-г Сургаал ба Гэрээ 66:3-ын хамт унш. Эдгээр шүлгүүдээс сурч мэдсэн зүйлүүдээс чинь харвал, МакЛелин ах зөвлөгөө хүсэн Их Эзэнд хандахад, амьдралынх нь юу “үл таалагдсаныг” Их Эзэн яагаад түүнд хэлсэн бэ? (Иаков 4:7, Ифер 12:27-г харьцуулах эшлэлүүд болгон С ба Г 66:3-ын зах дээр бич; Иаков 4:7 С ба Г 66:3-ын зүүвэр тайлбарт байдгийг ажигла.)



Хэрэв бид Есүс Христэд ирэх юм бол наманчлахад Тэрээр бидэнд туслах болно (С ба Г 66:3-ыг үз).



Огайогийн Хайрамд болсон онцгой чуулганы үеэр, Их Эзэнээс хүлээн авсан илчлэлтүүдээ Бошиглогч Иосеф Смит ном болгон хэвлүүлэх зорилготой байв. Чуулганы үеэр Их Эзэний Өөрийнх нь нэрлэснээр “Зарлигуудын минь номын удиртгал”-ыг (С ба Г 1:6- одоогийн Сургаал ба Гэрээ 1-р хэсгийг илчилж, ном болгон хэвлэх зөвшөөрөл өгсөн ажээ. Энэ бол Түүний удиртгал үг, гэрчлэл болон илчлэлтүүд юм.

Оливер Каудери 1-р хэсэг дэх илчлэлтийг чуулганд цугларагсад уншиж өгсний дараа ах нараас хэд хэдэн хүн босч, уг илчлэлт үнэнийг гэрчлэн, номыг хэвлэхээр төлөвлөснийг дэмжиж байгаагаа илэрхийлэв. Цөөхөн хүн илчлэлтийн үг хэллэгийг сайжруулах санал гаргасан аж. Ийнхүү санаа тавьсны үр дүнд Иосеф одоогийн Сургаал ба Гэрээ 67-р хэсгийг хүлээн авсан юм. Илчлэлтүүдээс дутагдал олсон хүмүүсийг Их Эзэн буруушааж, Бошиглогчийн хүлээн авсан илчлэлтүүдийн хамгийн өчүүхэнтэй нь эн тэнцүү ямар нэг зүйлийг хийхээр оролдоод үз гэжээ (С ба Г 67:6–8-ыг үз).



Бошиглогч Иосеф Смитэд өгсөн Их Эзэний илчлэлтүүдийг бичихэд тэрээр өөрийгөө илүү сайн мэргэшсэн хэмээн сургуулийн багш Виллям Э.МакЛелин боддог байсан гэнэ. Тэр оролдоод үзсэн ч, огт чадахгүй байгаагаа өөрөө хүлээн зөвшөөрсөн аж. Илчлэлтүүд үнэхээр Бурханаас ирснийг тэр мэдсэн хэмээн хожим нь МакЛелин гэрчилжээ.

Бошиглогч Иосеф Смит бичсэн нь: “Өмнөх илчлэлт [С ба Г 67] хүлээн авагдсаны дараа, Виллям Э.МакЛелин [МакЛелин], өөрийнх нь үнэлэмжээр бол, хамгаас мэргэн ухаантай нэгэн, мэдрэмжээсээ илүү ихийг сурсан нэгэн, Их Эзэний зарлигуудын хамгийн өчүүхэнтэй нь адил зарлиг бичих гэж оролдсон боловч чадсангүй. Их Эзэний нэрээр бичнэ гэдэг өгүүлшгүй том хариуцлага байлаа.

Ахлагч нар болон тэнд байсан бүх хүмүүс Есүс Христийн хэлийг дуурайх гэсэн энэ хүний хоосон оролдлогыг гэрчилж, Сайн мэдээний бүрэн байдалд, тэрчлэн наймайг

зэмсэг болгож надаар дамжуулан Сүмд Их Эзэний өгсөн зарлигууд болон илчлэлтүүдийн үнэнд итгэх итгэлээ шинэчилсэн юм. Тийнхүү Ахлагч нар мэдсэн үнэнээ бүх дэлхийд гэрчлэх хүслээ илэрхийлж байлаа.”(History of the Church, 1:226).

Бидний ойлголт хязгаарлагдмал учраас, заримдаа бид удирдагчдаа эргэлзэхээр уруу татагдаж болох юм. Сургаал ба Гэрээ 67-р хэсгийг судлахдаа, Их Эзэний сонгосон удирдагчдад бид яагаад итгэх ёстой талаар Түүний заасан зүйлд тусгайлан анхаарал тавь.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 67

Түүний хэлээс илүү дээр илэрхийлэх (ш. 5)—
Илчлэлтийн сэдвийг илүү сайн үг хэллэгээр бичих

• Өөрсдийгөө ангид байлгах (ш. 10)—Зайлсхийх, холдох
• Зуурдын (ш. 10, 12)—
• Дэлхийн, сүнсний биш,
• мөнх бус

Сургаал ба Гэрээ 67:10–12—Бурханыг харах онцгой боломж

Иохан 1:18, 1 Иохан 4:12 дахь, “Бурханыг хэн ч хэзээ ч хараагүй” гэсэн үгс нь зарим төөрөгдлийг бий болгодог. Учир нь Мосе мэтийн бошиглогчид Бурханыг “нүүр нүүрээрээ” тулан харсныг (Египетээс Гарсан нь 33:11; мөн Исаиа 6:5; Иосеф Смит-Түүх 1:17-г үз) бид мэднэ. Сургаал ба Гэрээ 67:11-д, Бурханы оршихуйд байхын тулд мөнх бус хүн “Бурханы Сүнсээр амьдруулагдах ёстой” гэж Их Эзэн тодруулсан нь Түүний сүр жавхланг тэсвэрлэн даах боломжийг хүнд олгоно хэмээн утга нь өөрчлөгджээ. Мосе үүнийг “хувирсан” (Мосе 1:11) хүмүүн бие хэмээн дүрсэлсэн байдаг. (ИСО, Иохан 1:19; ИСО, 1 Иохан 4:12-ыг үз.)

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 67-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Эдгээр илчлэлтүүд чиний хувьд ямар учир холбогдолтой вэ?

Сургаал ба Гэрээ 1 –р хэсэг нь 67-р хэсгийн өмнөхөн хүлээн авагджээ. Энэ хоёр илчлэлт хоёул Их Эзэнээс Бошиглогч Иосеф Смитийн хүлээн авсан илчлэлтүүдийг ном болгон хэвлэхээр төлөвлөж байсныг авч үзжээ (судлах гарын авлагын С ба Г 67-р хэсгийн оршлыг үз).

1. Сургаал ба Гэрээ 1:17–24, 67:4–9-ийг нэгтгэн дүгнэж, Иосеф Смитийн хүлээж авсан илчлэлтүүдийн талаар Их Эзэний хэлснийг товчлон бич.
2. Илчлэлтүүд бичигддэг хэлбэрийг ойлгоход эдгээр судрууд бидэнд хэрхэн туслах вэ?
3. Энэ жил өөрсдийнхөө судалсан илчлэлтүүдийн талаарх бодол санаагаа илэрхийлсэн нэг догол мөр бич. Зүрх сэтгэлд чинь нэвтэрч, амьдралд чинь өөрчлөлт гаргасан наад тал нь нэг хэсгийн тухай өгүүл.

Б Үйл явцыг тоймлон дүрсэл

Их Эзэн бидэнд өгөхийг хүссэн адислалуудыг заримдаа бид хүлээн авч чаддаггүй. Учир нь бид эдгээр адислалуудад бэлэн байдаггүй. Сургаал ба Гэрээ 67:1–3, 10–14-т Их Эзэний хэлсэн зүйлүүдээс, амласан адислалуудыг нь хүлээж авахын тулд бид юу хийх ёстойг тоймлон дүрсэл.



Залбирахыг, мөн Их Эзэний өмнө шударгаар амьдрахыг эцэг эхчүүд хүүхдүүдээ заах ёстой.

“Судрын” тодорхойлолт юу вэ? Номлолын ажлын зорилго юу вэ? Номлогчдод ямар хүч байдаг вэ? Бишпоор хэн дуудагдаж болох вэ? Аароны шууд удмынхны хувьд яах ёстой вэ? Эцэг эхчүүдийн нэн тэргүүний үүрэг хариуцлага юу вэ? Гэгээнтнүүдийн дундах ямар асуудлуудад Түүний “хүсэл сайн биш” байсан гэж Их Эзэн хэлсэн бэ? Сургаал ба Гэрээ 68-р хэсгийг уншихдаа эдгээр асуултуудын хариуг анхааралтай хай.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 68

Сургаал ба Гэрээ 68:1—Оорсон Хайдад зориулсан бошиглол

“Энэ шүлэг дэх бошиглол нэг бүрчлэн биелэгджээ. Оорсон Хайд сайн мэдээг ‘хүмүүсээс хүмүүст, нутгаас нутагт’ тунхаглав. 1832 онд Самуел Х.Смит тэр хоёр Нью-Йорк, Массачусетс, Мэйн мужууд, мөн Рөүд арал дээгүүр хоёр мянган бээр газрыг явганаар туулжээ. Оорсон Хайд 1835 онд Төлөөлөгчөөр томилогдож, 1837 онд Англи руу номлолд явсан аж. 1840 онд түүнийг Иерусалим руу номлолд илгээсэн байна. Тэрээр Далайг гаталж, Англи, Германаар дамжин, Константинополь, Каир, Алесандрид очиж, эцэст нь Ариун Хотод хүрчээ. 1841 оны аравдугаар сарын 24-нд тэрээр Чидуны Уулан дээр гарч, иудейчүүдийн цугларалтын төлөө Палестиныг онцгойлон адисалсан залбирал хэлжээ” (Смит, Сходал нар, *Doctrine and Covenants Commentary*, 409).

Сургаал ба Гэрээ 68:4—Судар гэж юу вэ?

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит сургасан нь:

“Цугларсан хүмүүсийн өмнө ах нарын нэг нь боссон үед мөн Их Эзэний сүнсний нөлөө түүнд байгаа үед тэрээр Их Эзэн түүгээр хэлүүлэх гэснийг л ярьдаг. Эл цэдгүүдийн аль нэгэнд бичигдсэн ямар нэг зүйлийг чи олбол, энэ нь судар юм. Эдгээрийг бид Сүмийн жишиг бүтээлүүд гэж нэрлэдэг билээ. Сүнсээр нөлөөлөх эрх олгогдсон ах нарын удирдамжаас мэдээжийн хэрэг, бид хамааралтай байдаг.

“Тухайн үед Сүмд зориулсан илчлэлтийг өгөх хүн Сүмд ганцхан л байдаг, энэ бол Сүмийн Ерөнхийлөгч юм. Гэвч энэ нь, энэ Сүмийн бусад гишүүдэд Их Эзэний үгийн тухай ярихад саад болдог гэсэн үг биш. Харин 68-р хэсэгт, энэ илчлэлтэд өгөгдсөний дагуу, эдгээр илчлэлтүүдийн нэгэн адил, энэ номон дахь илчлэлт нь Сүмийн тэргүүлэх ажилтнаар дамжиж ирэх болно гэсэн үг юм. Гэвч ерөнхий чуулган, гадасны чуулган дээр бусад үйлчлэгчдийн ярьсан Их Эзэний үг, эсвэл Их Эзэн тэдний амаар хэлүүлсэн үг нь бусад эрин үеүдийн бошиглогчдын бичсэн зүйлүүд, хэлсэн үгстэй яг адил Их Эзэний үг байдаг” (*Doctrines of Salvation*, 1:186).



“Ариун Сүнсээр урагш хөдөлгөгдөх тэд юуг ч ярилаа гэсэн судар байх болно” (С ба Г 68:4).

Манай Сүмийн удирдагчдын хэлсэн үг Ариун Сүнсээр нөлөөлөгдсөнийг бид яаж мэдэх вэ? Тэргүүн Зөвлөлийн гишүүн асан, Ерөнхийлөгч Бага Ж.Рюбен Кларк хэлсэн нь:

“Би энэ асуултыг бодож үзсэн. Тэгээд миний дүгнэлтээр бол уг асуултын хариулт нь: Бид өөрсдөө ‘Ариун Сүнсээр нөлөөлөгдсөн’

үед л үг хэлэгчид ‘Ариун Сүнсээр нөлөөлөгдсөнийг’ хэлж чадна.

“Ийм замаар, үг хэлэгчид Сүнсээр нөлөөлөгдөн ярьж байгааг мэдрэх хариуцлага нь тэднээс бидэнд бүрэн шилжиж ирдэг.” (*When Are the Writings or Sermons of Church Leaders Entitled to the Claim of Scripture?* [шашны боловсролынхонд хандаж хэлсэн үг, 1954 оны 7-р сарын 7]).

Судруудыг судлах нь


Сургаал ба Гэрээ 68-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Их Эзэний тодорхойлолтыг хүүхдэд тайлбарла

Чи өөрийгөө Хүүхдийн Хэсэгт хичээл зааж байна гэж бод. Сургаал ба Гэрээ 68:4 дэх *судрын* тухай Их Эзэний тодорхойлолтыг ойлгоход нь арван настай хүүхдүүдэд туслахыг хүсч байна гэж төсөөл. Энэхүү чухал үзэл баримтлалыг ойлгоход нь хүүхдүүдэд туслахын тулд юу хэлэхээ бич. (Энэ хэсгийн “Судруудыг ойлгох нь” хэсэг дэх мэдээллийг хэрэгтэй бол ашигла-гэхдээ үүнийг өөрийнхөө үгээр тайлбарла.)

Б Жагсаалт хий

- Итгэлийн Тунхаг 1:4-ийг унш. Тэгээд Сургаал ба Гэрээ 68:25–28-д хүүхдүүдээ заахыг Их Эзэн эцэг эхчүүдэд зарлиг болгосон “Сайн мэдээний анхдагч зарчмууд болон ёслолуудыг” тэмдэглэлийн дэвтэртээ жагсаан бич.
- Сүмийн гишүүдэд зориулсан нэмэлт зарчмуудыг Сургаал ба Гэрээ 68:29–33 агуулдаг. Тэндээс олсон зүйлүүдээ жагсаан бичиж, дараа нь шүлэг 31-д дүрсэлсэн “ёс бусчууд” яагаад Их Эзэнд таалагдаагүйг тайлбарла.



Илчлэлтүүд болон Сүмийн бусад материалуудыг хэвлүүлэхийг Бошиглогч Иосеф Смит болон бусад ах нар тэдний үүрэгт ажил болгон өгчээ.

1831 оны арваннэгдүгээр сарын 1–2-нд болсон Сүмийн чуулганы үеэр, Зарлигуудын Номыг В.В.Фелпсийн үндэслэн байгуулсан хэвлэх цехэд хэвлүүлэхийн тулд илчлэлтийн түүврийг Миссури рүү илгээхээр шийджээ. Илчлэлтүүд болон өргөл болгосон Сүмийн санг Миссури рүү яаж тээвэрлэн хүргэхийг тодруулахын тулд Сургаал ба Гэрээ 69-р хэсэг дэх илчлэлтийг хүлээн авчээ. Энэ илчлэлтийг уншихдаа, Их Эзэн яагаад Оливер Каудерийг ганцаараа явахыг хүсээгүйг ажигла. Их

Эзэн түүнээс юу хүсэн хүлээж байсан талаар Жон Витмерийн хүлээн авсан өөр нэг ойлголтыг бас ажигла.

Өргөлийн хуулийн зарчмуудын дагуу, амь зуулгаа хангах болон хамт олонд үйлчлэх арга зам болгон гишүүдэд үүрэгт ажил оногдуулан өгдөг байжээ. Жишээ нь: Фермийн аж ахуй эрхлэх газар, бизнес эрхлэгчид зориулсан дэлгүүр, хэвлэгчид зориулсан хэвлэлийн цех гэх мэт нь хүмүүсийн үүрэгт ажилд ордог байв. Сургаал ба Гэрээ 70-р хэсэг бол Сүмийн зарим ах нар т хариуцуулсан үүрэгт ажлын тухай илчлэлт юм. Илчлэлтийг судлахдаа, оногдсон ажил үүрэгтээ улам итгэлтэй байхад чинь тусалж чадах юуг Их Эзэн хэлснийг эрж ол.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 70

Сургаал ба Гэрээ 70:5–8—“Тэд эдгээр зүйлүүдийг Сүмд ч мөн дэлхийд ч өгөх ёсгүй”

“Илчлэлтүүд болон зарлигуудыг хариуцах үүрэгт ажилд” (С ба Г 70:3) ах нарыг томилсон нь Сүмийн энэ номуудыг хэвлэж, тараах нь тэдний эрхэлсэн ажил болно гэсэн үг байв. Тэд өөрсдийгөө, гэр бүлээ тэжээн тэтгэхэд туслахын тулд, яг л фермер буюу дэлгүүр эзэмшигчийн нэгэн адилаар, “үүний ашиг тусыг [орлогыг]” (ш. 5) хэрэглэх ёстой байлаа. Сүмийн материалуудыг худалдсанаас орох орлогыг Сүмд шууд өгөх ёсгүй байв. Учир нь “сүнсний зүйлүүдийг гүйцэтгэхээр томилогдсон тэрбээр хөлс шангаа хүртэх нь зүй ёсны юм” (ш. 12). Тэдний хүлээж авсан, хэрэгцээнээс нь илүү гарсан орлогыг бишоптой хамтран тооцож тогтоогоод, ядуучуудыг халамжлахын тулд Их Эзэний агуулахад өгөх ёстой байв (ш. 7-г үз).

Сургаал ба Гэрээ 70:14—Материаллаг зүйлүүддээ та нар тэгш байх ёстой гэсэн нь юу гэсэн үг вэ?

“Сионд дээш очсон, эсвэл дээш очих тухай бясалган боддог бүх хүмүүс Сион баригдах ёстой өргөлийн хуулиар үүрэг хүлээдгийг бид энэ илчлэлтээс [С ба Г 70] бас өөр бусад илчлэлтүүдээс мэддэг. Материаллаг зүйлүүдэд тэгш байж, гэрээнд шунаг сэтгэлээр орохгүй байхыг тэдэнд зарлиг болгожээ. Адил тэгш байх гэдэг нь бүгд адил тоо хэмжээний хоол хүнстэй байх ёстой гэсэн үг биш, харин хүн бүр хэрэгцээнийхээ хэрээр авах ёстой гэсэн үг юм. Жишээ нь: Хүн ажлынхаа онцлогийн дагуу биш, харин гэр бүлийнхээ хүмүүсийн тоонд тохируулан авч болно” гэж Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит тайлбарлажээ (*Church History and Modern Revelation*, 1:268–269).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 69–70-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Судрууд ямар үнэ цэнэтэй вэ?

Илчлэлтүүдийг хэвлэх шийдвэр гаргасан Сүмийн чуулган дээр илчлэлтүүд нь Сүмийн хувьд бүх дэлхийн баялагуудтай тэнцэх үнэ цэнэтэйг тодорхойлохын тулд санал хураалт явуулахыг Их Эзэн Бошиглогч Иосеф Смитэд даалгажээ” (*History of the Church*, 1:235).

1. Сургаал ба Гэрээ 69–70-р хэсэгт заасан үнэнүүдээс Сүмд онцгой үнэ цэнэтэй гэж өөрийнхөө боддог нэг үнэнийг сонгож, тэмдэглэлийн дэвтэртээ бич.
2. Сургаал ба Гэрээнээс өөрийнхөө мэдсэн, өөрийн чинь хувьд онцгой учир холбогдолтой өөр нэг үнэнийг сонгон авч бичээд, яагаад гэдгийг тайлбарла.

Б Өргөлийн хууль хэрхэн үйлчилдэг вэ?

Сургаал ба Гэрээ 70-р хэсэгт өргөлийн хууль хэрхэн үйлчилдгийн жишээг харуулжээ.

1. Энэ илчлэлтэд дурдагдсан зургаан хүнийг жагсаан бичиж, тэдний үүрэгт ажлууд юу байсныг тайлбарла (шүлэг 1–5 болон С ба Г 70:5–8-ын “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз).
2. Үүрэгт ажлаасаа олсон орлогыг яах ёстой гэж Их Эзэн тэдэнд хэлсэн бэ? (шүлэг 6–12-ыг үз).

В Адил тэгш байх гэдэг нь юу гэсэн үг болохыг тайлбарла

Сургаал ба Гэрээ 70:14–18-ыг уншсаны дараа, “хүн бүр яг адилхан юмстай байх Сионд амьдрахсан гэж би хүсэхгүй гэж боддог. Өөр хүмүүсийн дуртай юманд би дургүй байвал яах вэ?” гэж хэлсэн нэг найз чамд байдаг гэж бод. Сургаал ба Гэрээ 51:3; 70:14–16; мөн энэ хэсгийн “Судруудыг ойлгох нь” хэсгээс сурч мэдсэн зүйлүүдээрээ найздаа хариу бич. Материаллаг зүйлүүдэд адил тэгш байх тухай буруу ойлголтыг залруулахад анхаар. Сионд амьдрахын давуу талуудыг өөрийнхөө ойлгосноор тайлбарласан нэг догол мөрийг захидалдаа оруул.

Сургаал ба Гэрээ 71

“Та нарын эсрэг ямар ч зэвсэг амжилтад хүрэх нь үгүй”



Сүмийн гишүүн бус хүмүүс Сүмийн талаар зөв мэдээлэл авдаг байх нь чухал юм. Буруу таашаа үзэл бодол, худал хуурмаг зүйлс их тархсан үед Сүм үнэн болох тухай хамгийн сайн зар сурталчилгаа бол сэрэгээдсэн сайн мэдээний үнэнүүдийг тайлбарласан гишүүдийн дуу хоолой юм. Сургаал ба Гэрээ 71-р хэс-

гийг судлахдаа, Бошиглогч Иосеф Смитийн үед сонинуудад тархсан буруу үзэл бодлын талаар юу хийхийг тэрээр Их Эзэнээс асуусныг ажигла.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 71

Мадлах (ш. 7)—Дуугүй болгох, яахаа мэдэхгүй болгох (хүнийг)

Сургаал ба Гэрээ 71:1–8—Бид “дайснуудаа хэзээ мадлах” ёстой вэ?

Нэгэн эдгээлтийг гэрчилсний дараа Сүмд нэгдсэн, методист тохинуулагч асан, Эзра Бүүт урваж, Сүмийн эсрэг есөн захидал бичсэн ажээ. Огайогийн Равенна дахь, *Ohio Star* (Огайогийн Од)-д нийтлэгдсэн захидлууд улайрсан шүүмжлэлээр дүүрэн байв. Шүүмжлэл нь “өнгө аяс, худал хуурмагаараа, Их Эзэний ажлыг түлхэн унагаах гэсэн хоосон санаархлаараа [Бүүт] сул дорой талаа, ёс бус бусармаг хийгээд мунхаа харуулсан юм. Дэлхий Бүүтийн шүүмжлэлийг хараад нүд нь бүлтгийж, чих нь дэлдийхээр үнэнхүү хачирхалтайгаар тэрбээр ичгүүрийнхээ хөшөөг өөртөө босголоо” хэмээн Бошиглогч Иосеф Смит бичжээ (*History of the Church*, 1:217). Бүүт бол урвасан анхны хүн биш юм. Гэвч тэр бол Мормоны материалуудын эсрэг гүтгэлэг бичиж, нийтлүүлсэн Сүмийн анхны гишүүн байлаа.

Эзра Бүүтийн эсэргүүцэл үлэмж ноцтой болсонтой холбогдуулан, сайн мэдээг хүч болон нотолгоогоор дэлхийд тунхаглахын тулд Их Эзэн Иосеф Смит, Сидней Ригдон хоёрыг 1831 оны арванхоёрдугаар сарын 1-нд орчуулгын ажлаас нь дууджээ. “Зарим үед ёс бус бусармаг хүмүүсийн дайралтыг хэрэгсэхгүй байх нь мэргэн ухаан байдаг. Бусад үед тэдний дайралтыг айж эмээлгүй, чадварлагаар сөрөн зогсож няцаах нь чухал” (Смит, Сходал нар, *Doctrine and Covenants Commentary*, 423).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 71-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Нарийн тодорхой зүйлүүдийг эрж ол

1. Сургаал ба Гэрээ 71-д Иосеф Смит, Сидней Ригдон хоёрт юу хийхийг зарлиг болгосон бэ? Яагаад? (шүлэг 1–8, хэсгийн тойм, “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз).
2. Юу хэлэхээ тэд яаж мэдсэн бэ? (ш. 1-ийг үз).
3. Иосеф Смитийн үеэс одоог хүртэл шүлэг 9–11-д Их Эзэний амласан ямар үнэнийг та нар Сүмийн түүхээс ажигласан бэ?

Сургаал ба Гэрээ 72

Бишопын ажил үүргүүдийн талаарх нэмэлт тэдээлэл



Их Эзэн Эдвард Партрижийг Сүмийн анхны бишопоор 1831оны хоёрдугаар сард дууджээ (С ба Г 41:9-ийг үз). Бишоп Партриж Сионы бишопоор үйлчилж байсан Миссурийн Индепенденс рүү Бошиглогч Иосеф Смитийг дагалдан явжээ. Их Эзэн дараа нь Ньюэл К.Витнейг Огайогийн Кертландад бишопоор үйлчлүүлэхээр дуудав (С ба Г 72:7–8-ыг үз). Тэр жилийн эцсээр, бишоп Партрижийн гэргий Лидия Огайогоос хүүхдүүдээ авчирч, Индепенденст байсан нөхөр рүүгээ очсон ажээ.

Өнөө үед Сүмд үйлчлэх бидний үүрэг хариуцлага нь өргөлийн хуулиар бидэнд өгөгдөж болох ажил үүрэг мөн чанартаа биш юм. Гэвч дээрх Гэгээнтнүүдэд үүрэгт ажлынх нь талаар Их Эзэний өгсөн зөвлөгөөнөөс итгэлтэй үйлчлэлийн тухай бид зарим чухал сургаамж авч болно. Сургаал ба Гэрээ 72-р хэсгийг судлахдаа, зохистой үйлчлэгч байхын тулд хүн юу хийх ёстой талаар Их Эзэний хэлсэн үгсийг эрж ол.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 72

Ариулан адислагдсан (ш. 12)—Онцгойлон адислагдсан, зориулагдсан

Тэрхүү зүйлээс (ш. 13)—Мөнгө буюу чадвараар

Хүн бүрийг хүлээн зөвшөөрч болохуйц гэж үзэх (ш. 17)—Хүмүүсийн зохистой байдлыг нотолсноор

Бичгийн асуудлууд (ш. 20)—Сүмийн хэвлэл нийтлэлийн ажил

Сургаал ба Гэрээ 72:1–8—Сүмийн эхэн үе дэх бишопын үүрэг



Сүмийн хоёр дахь бишоп Ньюэл К.Витней

Бишоп Эдвард Партриж Сүмийн анхны бишопоор дуудагдсан юм. Хожим нь бусад хүмүүс дуудагдахад тэрээр өнөө үеийнхээр бол Тэргүүлэх бишоптой адил албан тушаалд дуудагдсан аж. Ньюэл К.Витней тийнхүү Бишоп Партрижийн эрх мэдлийн харьяалалд оров. Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит тайлбарлахдаа: “Кертландын бишоп нь ажил үүргийн тайлангуудыг байнгын бүртгэл мэдээнүүдийг хадгалдаг Сионы бишопт ‘гардуулах’ ёстой байв. Ньюэл К.Витней ийм үүрэгтэй бишоп болж ажиллахаар дуудагдсан ажээ. Тэрээр Кертландад Их Эзэний агуулахыг ажиллуулж, жимсний цэцэрлэгийн тэр хэсэг дэх мөнгийг хүлээн авч, өөрт нь зарлиг болгосны дагуу ахлагчдын тайланг авах ёстой байв. Мөн хэрэгцээгээ хангахын тулд хүлээн авсан зүйлүүдийнхээ хөлсөнд хүмүүс хэчнэнийг төлөх ёстой байна, тэр хэмжээгээр тэд төлбөр хийх ёстой байв. Хүлээн авсан мөнгийг Сүмийн төлөө, ‘ядуучууд болон гачигдалтай хүмүүст’ зориулах ёстой байлаа. Хэрэв төлбөр хийх боломжгүй хүн байвал, тооцоог гаргаж, Сионы бишопт өгөхөд, Их Эзэн мэдэлд нь өгсөн зүйлүүдээс бишоп өрийг төлнө” гэжээ (Church History and Modern Revelation, 1:270).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 72-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Ажил үүргийн биелэлтийг хэрхэн тайлагнадгийг тайлбарла

Үүрэгт ажил гэдэг нэр томъёо зөвхөн өргөлийн хуулиар хүлээн авагддаг ажил үүрэгт хамаатай хэдий ч, хариуцлага хүлээх зарчим нь өнөөгийн бидний Сүмийн үүрэг хариуцлагад холбогдож болно. Сүмийн дараах ажил үүргүүдийн хувьд, хүн ажил үүргээ хэрхэн биелүүлсэн тухай тайлангаа хаана, хэзээ, хэнд өгөх ёстойг тайлбарла (С ба Г 72:2–5-ыг үз):

1. Миа Мейд ангийн ерөнхийлөгч
2. Аароны санваар дахь санваартан
3. Гэрийн багш
4. Аравны нэгийг төлөгч

Б Бишопын үүргүүд




Хэдийгээр одоо бид өргөлийн хуулиар амьдардаггүй ч гэсэн, өнөө үед бишопын ажил үүргээс нэлээд нь Сургаал ба Гэрээ 72:5–13-т дүрсэлсэн ажил үүргүүдтэй адил юм.

1. Эдгээр шүлгүүдийг бишоп буюу салбарын ерөнхийлөгчтэйгөө эсвэл зөвлөхүүдийнх нь нэгэнтэй ярилцаж, өнөө үед бишопт байдаг дээр дурдсантай адил төстэй үүргүүдийг тэмдэглэлийн дэвтэртээ жагсаан бич. Бишоп энэхүү үүргүүдээ гүйцэтгэхийн тулд юу хийдгийг тайлбарла.
2. Бишопын ажлыг хөнгөвчлөхөд туслахын тулд чи юу хийж болох вэ?

Сургаал ба Гэрээ 73

Библийн Иосеф Смитийн Орчуулга дууссан нь

1831 оны арванхоёрдугаар сарын ихэнх өдрүүдэд Иосеф Смит, Сидней Ригдон хоёр урвагчдын худал хуурмаг гүтгэлгийн улмаас бий болсон хохирлыг арилгахын тулд Огайогийн Кертланд хавийн нутагт номложээ (С ба Г 71-р хэсгийн тоймыг үз). Энэ дуудлага нь Библийг хянан тохиолдуулах сүнсээр нөлөөлөгдсөн Бошиглогчийн ажлыг түр зогсоохыг тэднээс шаардсан аж. Сургаал ба Гэрээ 73-р хэсэгт, орчуулгын ажилдаа дахин анхаарал төвлөрүүлэхийг Их Эзэн Иосеф Смитэд зааварласан юм. Сидней Ригдон бичээчээр үйлчлэх ёстой байв.



Библийн Хаан Жеймсийн хувилбарын Иосеф Смитийн орчуулгын нэг хуудас. Сүнсээр нөлөөлөгдсөн, Библийн хянан тохиолдуулалтын дуусахыг Бошиглогч Иосеф Смитэд зарлиг болгожээ.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 73

Хормойгоо шуу (ш. 6)—
Бэлтгэлтэй бай

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 73-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Библийн Иосеф Смитийн Орчуулгын ач холбогдол

Бошиглогч Иосеф Смитэд Их Эзэний өгсөн анхны ажил үүргүүдийн нэг нь Мормоны Номыг орчуулах байлаа. Орчуулгын үед Бошиглогч олон асуулт асууж, Их Эзэн хариулжээ. Эдгээр илчлэлтүүдээс олон нь Сургаал ба Гэрээний хэсгүүд болсон ажээ (жишээ нь, С ба Г 3; 5–6; 8–10-ыг үз).

1. Сургаал ба Гэрээ 73:3-т Бошиглогч, Сидней Ригдон хоёрыг ямар ажилд эргэж ор гэж Их Эзэн хэлсэн бэ?
2. Сургаал ба Гэрээ 76–77; 86; 91-ийн хэсгийн тоймуудыг унш. Эдгээр илчлэлтүүд Иосеф Смитийн Орчуулгын

талаар юу өгүүлдгийг тайлбарлаж, тэнд заагддаг зүйлийн тухай товч тайлбарла.

Сургаал ба Гэрээ 74

Бошиглогчийн асуулт

Сургаал ба Гэрээ 74-р хэсэг бол Библийн Иосеф Смитийн Орчуулга Сайн мэдээний бүрэн байдлын Сэргээлт болон сайн мэдээний чухал зарчмуудыг ойлгох бидний ойлголтод хэчнээн чухал хувь нэмэр оруулсны нэг жишээ юм. Бошиглогч Иосеф Смит Библийн үгсийг тунгаан бодох үед асуултууд олонтаа гарч ирдэг байсан аж. Тэрээр бичээч Сидней Ригдонгийн хамт тэдгээр асуултуудыг Их Эзэнд хүргэдэг байв. Энэ нь илчлэлтэд замыг нээж өгсөн юм. Энэ илчлэлтийг судлахдаа, эртний судрыг ойлгоход бидэнд туслах орчин үеийн илчлэлт байгаа нь хэчнээн чухал адислал болохыг тунгаан бод.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 74

Хөвч хөндөх хууль (ш. 2)— : лагатай байсан шашны нэг
Мосегийн хуулиар шаард- : зан үйл

Сургаал ба Гэрээ 74:1—Үл итгэгч нөхөр эсвэл эхнэрийг яах вэ

Төлөөлөгч Паулын үед Коринт дахь Сүмийн зарим гишүүд “нөхөр болон эхнэр нь хөрвүүлэгдэхэд тэрээр хөрвүүлэгдээгүй эхнэр болон нөхрөө цэвэр биш, эсвэл бохир гэж үздэг байсан нь илэрчээ. Огт тийм биш ээ! Уг чанартаа эхнэр эсвэл нөхрийн аль нэг нь хөрвүүлэгдэх нь тэр гэр бүлд ариусгагч нөлөө авчирдаг гэж Гэгээнтэн Паул хэлжээ [1 Коринт 7:12–14-ийг үз]” (Смит, Сходол нар, *Doctrine and Covenants Commentary*, 432).

Сургаал ба Гэрээ 74:1–7—“Мосегийн хууль тэдний дундаас үгүй болгогдох ёстой”

Гэрлээгүй Сүмийн гишүүд Сүмийнхээ гишүүд дотроос гэрлэдэг байх ёстой, ингэснээрээ эхнэр нөхөр хоёр нэг адил итгэл бишрэлийг хуваалцахгүй байгаа үед гардаг асуудлуудаас зайлсхийхэд Төлөөлөгч Паул санаа тавьдаг байв. Ялангуяа Мосегийн хуулийг цаашид мөрдөхөөс зайлсхийхийг тэр хүсдэг байжээ.

“Энд илэрхийлсэн гол санаа нь эхний болон сүүлчийн шүлэгт байдаг [С ба Г 74:1, 7]. Энэхүү санаа нь бага насны хүүхдүүд Есүс Христийн Цагаатгалаар ариусч, цэвэр ариун болдгийг нотолдог.

“Эл үзэл баримтлалаас хоёр дүгнэлт гарч байна. Энэ илчлэлтэд дэвшүүлсэн нэг дэх цогц санаа бол, бага насны

хүүхдүүд ариусахын тулд Мосегийн итгэлийг баримтлагчдын заадаг шиг хөвч хөндүүлэх хэрэггүй гэсэн санаа. Хоёрдахь нь гэвэл, бага насны хүүхдүүд Есүс Христийн Цагаатгалаар цэвэр ариун болдог гэсэн нь өмнөх санаатай адил тэнцүү ач холбогдолтой юм” (Смит, Сходал нар, *Doctrine and Covenants Commentary*, 432).

Сургаал ба Гэрээ 74:5—Өөрийн чинь итгэлийг хуваалцдаг хүнтэй гэрлэхийн ач холбогдол



Ахлагч Спенсер В.Кимбалл Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байхдаа бичсэн нь: “Бүтэмжтэй гэрлэлт зөв болзоноос эхэлдэг нь тодорхой юм. Хүн өөртэйгөө холбоотой байдаг, сургуульд хамт сурдаг, Сүмд хамт явдаг, нийгмийн арга хэмжээнд хамт оролцдог хүмүүсийн дотроос л хэн нэгэнтэй ерөнхийдөө гэрлэдэг. Тиймээс, энэ

сэрэмжлүүлэгт (Дэд Хууль 7:3–4; 2 Коринт 6:14-ийг үз) онцгой анхаарал тавьдаг. Гишүүн бус хүмүүстэй эсвэл болзоо талаар зохих мэдлэггүй буюу итгэлгүй гишүүдтэй тохиолдлоор бүү болзоо тавь. ‘Өө, би энэ хүнтэй гэрлэх бодолгүй байна. Энэ бол зүгээр л нэг “зугаацах” болзоо шүү дээ’ гэж аль нэг охин хэлж болно. Гэвч сайн мэдээг хэзээ ч хүлээн авахгүй хүнд тохиолдлоор хайр сэтгэлтэй болохгүй гэх газаргүй. Сүмийн гишүүдтэй гэрлэсний дараа баптисм хүртдэг цөөн тооны хүн байгаа нь үнэн. Зарим сайн эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд Сүмийн гишүүдтэй гэрлэснийхээ дараа Сүмд нэгдэж, хоёргүй сэтгэлтэй, идэвхтэй хэвээр үлддэг. Бид тэднээр бахархдаг, тэдэнд талархдаг. Тэд бол бидний дундах адислагдсан цөөнх хэсэг юм. Сүмд нэгдээгүй бусад нь эелдэг ялдам, дотроо бодолтой, дороо суурьтай, хамтач санаа бодолтой байж, Сүмийн загваруудын дагуу шүтэн биширч, үйлчлэх боломжийг гишүүн эхнэр болон нөхөртөө олгодог. Гэвч Сүмийн гишүүдтэй гэрлэгсдийн олонх нь Сүмд нэгддэггүй . . . ихэнхийнх нь хувьд үзэл бодлын зөрчил, урам хугаралт, цөхрөл, гэр бүл салалт тохиолддог (*The Miracle of Forgiveness*, 241–242)

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 74-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий

А Чухал санаануудыг товчлон тэмдэглэ

Сургаал ба Гэрээ 74-р хэсэг нь 1 Коринт 7:12–14-ийг тайлбарлахад тусалж, гурван гол асуултад хариулдаг. Дараах асуулт тус бүрийг тэмдэглэлийн дэвтэртээ бичиж, эдгээр асуулт бүрд энэ илчлэлтийн өгсөн хариуг товчлон бич (хэрэгтэй бол энэ хэсгийн “Судруудыг ойлгох нь” хэсгийг ашигла).

1. Хэрэв гэрлэсэн эхнэр нөхөр хоёрын зөвхөн нэг нь сайн мэдээнд хөрвөгдвөл, итгэгч биш эхнэр болон нөхрөө яах ёстой вэ?
2. Бид хэнтэй гэрлэх талаар Их Эзэн ямар зөвлөгөө өгсөн бэ?
3. Бага насны хүүхдүүдийн тухай Их Эзэн юу заасан бэ?



Сургаал ба Гэрээ 75 Номлолын дуудлага

Кертландаас тавин бээр зайтай Огайогийн Амхерстэд болсон чуулган дээр Сургаал ба Гэрээ 75-р хэсгийг хүлээн авчээ. Энэ чуулганы нэг чухал үйл явдал нь Иосеф Смитийг Дээд Санваартны Ерөнхийлөгчөөр дэмжин батлах байв. Энэ бол Сүмийн Тэргүүн Зөвлөлийн албыг зохион байгуулах анхны алхмуудын нэг байлаа. Эл илчлэлт “чуулганы дуу хоолойгоор, тэдний хэд хэдэн үүрэг даалгаврыг” (С ба Г 73:2) ахлагчдад мэдүүлэхээр хоёр долоо хоногийн өмнө амласан Их Эзэний амлалтын биелэлтийг бас агуулдаг. Тэр үед гэрлэсэн эрэгтэйчүүд номлолын дуудлага хүлээн авч, дуудлагадаа үйлчлэх үеэр эхнэр, гэр бүлээ ардаа орхидог байв. Энэ илчлэлт тэдгээр эрчүүд, ар гэрийнхэнд нь ямар практик зөвлөгөө өгсөн байна вэ? Эцэг эсвэл нөхөр нь номлолд явсан гэр бүлийн талаар Сүмийн үлдсэн гишүүд ямар үүрэг хүлээдэг байсан бэ?

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 75

Олон боодол үүрэгдэх (ш. 5)—Номлолын амжилтын бэлгэдлийн нэр томъёо



Их Эзэн номлолын ажлыг ургац хураах үед тарианы боодлуудыг цуглуулахтай харьцуулжээ.

Сургаал ба Гэрээ 75:18–20—“Хөлийнхөө тоосыг гүвэх” гэсэн нь юу гэсэн утгатай вэ?

Сургаал ба Гэрээ 24:15 (х.00 [36])-ын “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз.

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 75-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

© 1994 Жанат Р. Каннон, гэрэл зурагчин, И. Дейл Лебарон

А Амлалтуудыг тунгаан бод

1. Сургаал ба Гэрээ 75:5, 1–11, 13, 16-г нэгтгэн дүгнэж, Их Эзэн юу гэж зарлиг болгосныг, мөн номлолд явж байгаа хүмүүст ямар амлалт өгснийг жагсаан бич.
2. Амлалтуудаас нэгийг сонгож, уг амлалт яагаад өөрт чинь гүнзгий сэтгэгдэл төрүүлснийг тайлбарласан хоёр эсвэл гурван өгүүлбэр бич.
3. Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байсан Ахлагч Спенсер В.Кимбалл: “Номлол бол зүгээр нэг хайш яйш зүйл биш-энэ бол Сүм дэх аль нэг өөр хөтөлбөр ч биш. Аравны нэг, ариун ёслолын цуглаан, Мэргэн Ухааны Үг сонголт байдаг бол номлол энэ бүхнээс илүү чухал ямар нэг сонголт ч биш. Мэдээж хэрэг, чөлөөтэйгөөр сонгох эрх бидэнд байдаг. Харин Их Эзэн бидэнд сонголтнуудыг өгсөн билээ. Бид өөрсдөдөө ямар санагдсанаар үйлдэж болно. Бид номлолд явж болно эсвэл явахгүй байж болно. Гэвч хэвийн байдалтай залуу эрэгтэй бүр, аравны нэгийг төлдгийнхөө адилаар, цуглаануудад оролцдогийнхоо адилаар, Хүндэтгэлийн өдрийг сахидаг шигээ, бас амьдралаа толбогуй, цэвэр ариун авч явдаг шигээ, номлолд явах эрхэм үүрэгтэй юм” гэжээ (Circles of Exaltation [шашны боловсролынхонд хандаж хэлсэн үг, 1968 оны зургадугаар сарын 28], 3).

Залуу эрэгтэйчүүдийн адил номлолд үйлчлэх үүрэг залуу эмэгтэйчүүдэд байдаггүйг Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли зааж хэлэхдээ:

“Манай залуу эмэгтэйчүүд номлолд явах үүрэггүйг тэдэнд хэлэхэд Тэргүүн Зөвлөл, Арванхоёрын Зөвлөл нэгдмэл байна. Би хэлэх зүйлээ хэн нэгийг гомдоохгүйгээр хэлж чадна гэдэгт найдаж байна. Залуу эрэгтэйчүүдийнхтэй харьцуулахуйц тийм үүрэг өөрсдөд нь байдаггүй юм байна гэж залуу эмэгтэйчүүд бодох ёсгүй. Тэдний зарим нь номлолд явахыг нэн их хүсэх болно. Энэ тохиолдолд залуу эмэгтэйчүүд бишоптойгоо бас эцэг эхтэйгээ зөвлөлдөх ёстой. Хэрэв энэ санаа эргэлт буцалтгүй байх юм бол яахыг чинь бишоп мэдэх болно.

“Номлолын ажил бол юуны өмнө санваартны үүрэг мөн гэж өмнө нь хэлснээ би давтан хэлж байна. Ийм болохоор, манай залуу эрэгтэйчүүд гол ачааг үүрэх ёстой. Энэ бол тэдний ажил бас үүрэг нь юм” (In Conference Report, 1997 оны аравдугаар сар, 73; Ensign, 1997 оны 11-р сар, 52).

Сайн номлогч байхын тулд залуу эрэгтэйчүүд ямар бэлтгэл хийх ёстой вэ? Үйлчлэхэд бэлэн байхад нь залуу эрэгтэйчүүдэд туслахын тулд залуу эмэгтэйчүүд юу хийж болох вэ?

Сургаал ба Гэрээ 76 Алдар суугийн өөр өөр зэрэглэлийн тухай үзэгдэл

Бошиглогч Иосеф Смит, Сидней Ригдон хоёр сүнсээр нөлөөлөгдөн Библийн орчуулга (ИСО) дээр ажиллаж байх үеэр Сургаал ба Гэрээ 76-р хэсэг хүлээн авагджээ.

Уг илчлэлт хүлээн авагдахад хамт байлцсан Фило Диббл ах энэ талаар доорх зүйлийг бичжээ:


“Сургаал ба Гэрээ Номонд цэдэглэгдсэн уг илчлэлт Огайогийн [Хайрамд] ‘Эцэг Жонсоны’ гэрт хүлээн авагдсан бөгөөд тэр үед Иосеф, Сидней хоёр Сүнсэнд байж, тэнгэр нээгдэхийг харсан юм. Тэр өрөөнд өөр арванхоёр хүн байсан байх, тэдний дунд бүх хугацааны гуравны хоёрт нь би байсан-би тэрхүү алдар сууг харж, хүчийг мэдэрсэн боловч, үзэгдлийг хараагүй. . . .

“Иосеф нэг үдэш цонхоор гадагш харж, өрөөнд байсан бүх хүмүүсийн харж чадахгүй байсан зүйлийг харж, хоорондоо зайтайгаар хэлсэн нь: ‘Би юу харж байна гээч?’ Дараа нь тэрээр харсан зүйлээ, эсвээс харж байсан зүйлийнхээ тухай яриу. ‘Би бас үүнийг харж байна’ гэж Сидней сая дуугарлаа. Тэгээд Сидней, ‘Би юу харж байна гээч?’ гэж хэлээд харсан зүйлээ давтан хэлэхэд Иосеф, ‘Би бас үүнийг харж байна гэж хариулав’

“Ийм яриа богинохон завсарлагатайгаар үзэгдлийн төгсгөл хүртэл давтагдсан бөгөөд тэр үеийн туршид өөр нэг ч хүн ганц ч үг хэлсэнгүй. Иосеф, Сидней хоёроос хэн нь ч дуу чимээ гаргах буюу хөдөлсөнгүй, намайг тэнд байсан бүх үеийн туршид, миний бодоход цаг гаруй болсон болов уу, үзэгдлийн төгсгөлийг хүртэл тэд гар, хөлөө ч хөдөлгөөгүй шиг санагдана.

“Тэр бүх хугацааны туршид Иосеф тэрхүү гайхалтай сүр жавхлангийн дунд огт хөдөлгөөнгүй, тайван гэгч нь сууж байхад Сидней цонхигор царайлан үлбийж, гутал нь хавчсан юм шиг харагдаж байлаа. Үүнийг ажигласан Иосеф инээмсэглэн, ‘Сидней үзэгдлийн үед над шиг байсангүй’ гэв.” (“Recollections of the Prophet Joseph Smith,” The Juvenile Instructor, 1892 оны 5-р сарын 15, 303–304).

Сургаал ба Гэрээ 76-р хэсгийг судлахдаа, дээрх үзэгдлийг өдөөсөн юуг Иосеф, Сидней хоёр уншиж байсныг эрж ол. Үзэгдэл хэрхэн эхэлсэн бэ? Хаант улсуудын алдар сууг тэд ямар дарааллаар харсан бэ? Үзэгдлийн үед чи тэр өрөөнд байсан бол тэрхүү агуу үйл явдалд бага ч гэсэн оролцсон бол ямар байх байсныг төсөөлөн бод.



Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 76

Бясалгах (ш. 19)—Тунгаан бодох, эргэцүүлэн бодох

Мөхөл (ш. 26)—Сатаны нэг нэр, устгал, сүйрэл

Мөхлийн хөвгүүд (ш. 32)—Сатантай хамт үүрд мөнхөд зовох түүний дагалдагчид

Хилэгнэлийн савнууд (ш. 33)—Уур хилэнгээр дүүрсэн

Гэтэлгэгдэх (ш. 38)—Чөлөөлөгдөх, аврагдах

Огторгуй (шүлэг 70–71, 81, 109)—Тэнгэр

Эзэгнэл (шүлэг 91, 95, 111, 114, 119)—Эрх мэдэл, захиргаа

Садарлагчид (ш. 103)—Ёс суртахуунгүй хүмүүс

Сургаал ба Гэрээ 76—Илчлэлтийн бүтэц

Хүн төрөлхтөн байнга асууж ирсэн хамгийн чухал асуултуудын заримд нь Сургаал ба Гэрээ 76-р хэсэг хариулдаг. Илчлэлтийн агуулгыг дараах байдлаар ангилж болно:

- Итгэлтнүүдэд өгсөн амлалтууд (шүлэг 1–10-ыг үз)
- Энэ илчлэлт өөд хөтөлсөн нөхцөлүүд (шүлэг 11–18-ыг үз)
- Бурханы Хүүгийн алдар суу (шүлэг 19–24-ийг үз)
- Люсиферийн уналт (шүлэг 25–29-ийг үз)
- Мөхлийн хөвгүүдийн зовлон шаналал (шүлэг 30–38, 43–49-ийг үз)
- Селестиел алдар сууг өвлөх хүмүүс (шүлэг 50–70, 92–96-г үз)
- Террестриел алдар сууг өвлөх хүмүүс (шүлэг 71–80, 87, 91, 97-г үз)
- Телестиел алдар сууг өвлөх хүмүүс (шүлэг 81–90, 98–112-ыг үз)
- Энэ илчлэлтийг хүн хэрхэн ойлгож болох вэ? (шүлэг 114–119-ийг үз)

Сургаал ба Гэрээ 76:22–24—Гэрчүүдийн ач холбогдол

Бошиглогч Иосеф Смит бол энэ илчлэлтийг хүлээн авсан цорын ганц хүн байгаагүйг тэмдэглэх нь чухал юм. Ганцхан Сидней Ригдон үзэгдлийг бүхэлд нь нүдээр харсан гэрч байсан төдийгүй, өрөөнд байсан бусад хүмүүс үзэгдлийг хараагүй ч гэсэн, хүчийг мэдэрснээ бас гэрчилсэн ажээ. Их Эзэн Өөрийн хүмүүст шинэ сургаалыг хэдийд ч илчлэхдээ, нэгээс дээш гэрчийг илгээдэг билээ. Энэ бол “гэрчүүдийн бурханлиг хууль” гэгддэг зарчим болохыг Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит тайлбарласан байдаг:

“Гэрчлэлийг болон гэрчүүдийн томилолтыг судруудад тодорхой нотолсон хууль байдаг. Их Эзэнд байдаг энэ хууль хүмүүст шинэ хууль өгөхөд үргэлж дагалддаг.

“Бүх эрин зууны туршид энэ хууль бэхжиж тодорхой болж иржээ. Хэрэв бүх эрин зууны төгс цэдгүүд бидэнд байдаг бол Их Эзэн эрин үе бүрийг үндэслэн бий болгоход тэнд өөрийг нь гэрчлэх нэгээс дээш гэрч байсаар ирэх байсан. Паул Коринтчуудад бичихдээ: ‘Хоёр буюу гурван гэрчийн амаар үг бүр батлагдах болно’ гэжээ [2 Коринт 13:1]” (Doctrines of Salvation, 1:203).

Сургаал ба Гэрээ 76:29—Хүмүүний бодгалийн төлөөх тулалдаан

Энэ амьдралд бидний оролцдог- харанхуйн эсрэг гэрлийн дайн, муугийн эсрэг сайны дайн энд газар дэлхий дээр эхлээгүй юм. Бидэнд зориулж энэ дэлхийг бүтээхээс

өмнө “тэнгэрт дайн” (Илчлэлт 12:7) болсон аж. Сатан бут цохигдож, “дэлхий рүү доош хаягдахад, мөн түүний элчүүд түүнтэй хамт доош хаягдав” (ш. 9). Гэвч тэр дайн тэнд дуусаагүй юм. Учир нь энд дэлхий дээр “Бурханы зарлигуудыг сахидаг, түүнчлэн Есүс Христийн тухай гэрчлэл тэдэнд байдаг” (ш. 17) хүмүүсийг устгахыг эрэлхийлсээр байгаа билээ.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч М.Рассел Баллард хэлсэн нь:



“Хүмүүний бодгалийг хамгаалах тэмцэлд Сүмийн гишүүд шийдвэрлэгч үүрэгтэй юм. Есүс Христийн сайн мэдээний Сэргээлтийн алдар суут захиасыг дэлхийн хүмүүст хүргэхийн төлөө номлогчид тулалдааны талбарт үнэний илдээр тулалдаж байна. Эрсдэлгүй дайн гэж ерөөсөө байдаггүй. Их Эзэний Хоёр дахь ирэлтэд бид-

нийг ойртох үед хүмүүний бодгалийн төлөөх тулалдааны эрч хүч улам нэмэгдэж, эрсдэл улам ихсэх болно гэдэгт эцсийн өдрүүдийн бошиглолууд намайг хөтөлдөг.”

“Ирэх он жилүүдийн сорилтуудад өөрсдийгөө болон гэр бүлээ бэлтгэх нь айдсыг итгэлээр солихыг биднээс шаардах болно. Биднийг эсэргүүцэж, бидэнд заналхийлдэг дайснуудаас эмээх айдсыг бид даван туулах чадвартай байх ёстой. ‘Бүү ай, бяцхан сүрэг, сайныг үйлдэгтүн, дэлхий болон там та нарын эсрэг нэгдэг, учир нь хэрэв та нар миний хадан дээр баригдах аваас, тэд дийлэх нь үгүй’ гэж Их Эзэн хэлсэн юм” гэжээ (С ба Г 6:34) “(In Conference Report, 1989 оны 9, 10-р сар, 43; *Ensign*, 1989 оны 11-р сар, 34).

Сургаал ба Гэрээ 76:31–35—“Мөхлийн хөвгүүд” гэж хэн бэ?

Уучлагдашгүй нүгэл үйлдсэнээрээ мөхлийн хөвгүүд болдог хүмүүсийн тухай Бошиглогч Иосеф Смит хэлэхдээ: “Ариун Сүнсний эсрэг нүглээс бусад бүх нүгэл уучлагдах болно. Учир нь мөхлийн хөвгүүдээс бусад бүх хүмүүсийг Есүс аварна. Уучлагдашгүй нүглийг хүн хэрхэн үйлддэг вэ? Тэр хүн Ариун Сүнсийг хүлээн авч, тэнгэрийг өөртөө нээлгэн, Бурханыг мэдсэний дараа Түүний эсрэг нүгэл үйлддэг. Хүн Ариун Сүнсний эсрэг нүгэл үйлдсэний дараа, түүний хувьд наманчлал гэж байдаггүй. Тэрээр нарыг харж байгаа атлаа нар гийхгүй байна гэж хэлдэг. Тэнгэр түүнд нээгдсэн байхад тэрээр Есүс Христийг үгүйсгэдэг, авралын төлөвлөгөө болон үнэн нүднийх нь өмнө нээлттэй байхад үүнийг үгүйсгэдэг. Ингээд энэ үеэс эхлэн тэр хүн дайсан болдог” гэжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, 358).

Сургаал ба Гэрээ 76:37–38—Хоёр дахь үхэл гэж юу вэ?

Уучлагдашгүй нүгэл, Ариун Сүнсний эсрэг нүгэл бол “үхэлд хүргэх нүгэл юм. Учир нь энэ нь Сүнсний зайлуулдаггаараа хоёр дахь үхэл болдог-хоёр дахь үхлийг биеэр амссан хүмүүс Бурханы оршихуйгаас таслагдаж, үүрд мөнхийн туршид чөтгөр болон түүний элчүүдтэй хамт амьдрахаар илгээгддэг” гэж Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит сургажээ (*Doctrines of Salvation*, 1:49).

Сургаал ба Гэрээ 76:54—Ууган Хүүгийн Сүм гэж юу вэ?

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит хэлсэн нь: “Сүмд баптисм хүртсэн хүн бүр Их Эзэний зарлигуудыг сахих үүрэг хүлээдэг. Тэрээр гэрээнд ордог. Учир нь баптисм бол

‘шинэ бөгөөд үүрдийн гэрээ юм.’ (С ба Г 22:1.) Өөрөөс нь шаардагддаг бүх зүйлд тэрээр итгэлтэй байж, зохистой амьдралаар өөрийгөө нотлон харуулах юм бол бусад гэрээнүүдийг, мөн түүнийг өв залгамжлагч болгох бусад үүргүүдийг өөр дээрээ авдаг, ‘Ууган Хүүгийн Сүмийн’ гишүүн болох нь түүний хувьд онцгой боломж юм.’ Тэд бол Эцэг бүх зүйлүүдийг гарт нь өгсөн хүмүүс юм. Тэрээр Эцэгийн болон Түүний алдар суугийн бүрэн байдлыг хүлээн авна. Үүнээс илүү үнэ цэнэтэй зүйл гэж юу байх билээ? Хүч чармайлт гаргахгүйгээр энэхүү үнэт зүйлийг олж авч чадахгүй” гэжээ (In Conference Report, 1969 оны 4-р сар, 122–123).

Сургаал ба Гэрээ 76:84—“Эдгээр нь тамд доош хаягдсан тэд юм”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Брус Р.МкКонки там болон телестииел хүмүүсийн хоорондын уялдаа холбоог тайлбарласан нь:

“Амилуулалтынхаа эцсийн өдрийг хүлээж байгаа ёс бус сүнснүүдийн оршин суудаг сүнсний дэлхийн тэр хэсгийг там гэдэг. Үхэл, амилуулалтынхаа хооронд ёс бусчуудын сүнс гадаад харанхуй, шеолын баргар гуниглал, ёс бус сүнснүүдийн хүлээлгийн тамд хаягддаг. Тэнд тэд хараалын тарчлалыг амсдаг. Тэнд тэд мөнхийн гал дотор өс авалтад үйлээ эдэлж, уйлж, шүдээ хавирдаг. Тэнд Бурханы уур хилэнгийн зэвүүцлийн гал ёс бусчууд дээр юүлэгддэг. (Алма 40:11–14; С ба Г 76:103–106-г үз.) . . .

“Амилуулалтын дараа тамд зовон шаналсан хүмүүсийн дийлэнх олонх нь телестииел хаант улсад шилжин очих болно. Мөхлийн хөвгүүдийн хувьд зүхэгдсэн байдал нь чөтгөр болон түүний элчүүд эцэс төгсгөлгүй зовлон гасланд илгээгдэхээр солигдох болно. . . .

“Тамд хэн очих вэ? Судруудад энэ асуултад зөндөө хариулсан байдаг. Телестииел хаант улсад очих хүмүүс тамын гүнийг туулан хүрэх газар руугаа аян хийдэг билээ. Телестииел хуулинд дуулгавартай байсны үр дүнд, телестииел хуулиар амьдардаг бүх хүмүүс тамд очих болно” (Mormon Doctrine, 349–350).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 76-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-гаас гадна өөр гурван үйл ажиллагааг хий.

А Судрыг ойлгох нь

1. Сургаал ба Гэрээ 76-р хэсгийн “Судруудыг ойлгох нь” хэсгийг (“Илчлэлтийн бүтэц”) ашиглан тэнд жагсаан бичсэн төрлүүдийг тус бүрд нь авч үзсэн шүлгүүдийг судрууддаа тэмдэглэ. Судар дээр тэмдэглэл хийх илүү сайн арга гэж өөрийнхөө үзсэн нэг аргыг сонгож ав.
2. Тэмдэглэлийн дэвтэртээ гурван багана зурж, “Селестииел хаант улс,” Террестриел хаант улс,” “Телестииел хаант улс” гэж гарчигла. Сургаал ба Гэрээ 76:30–112-ыг нэгтгэн дүгнэж, эдгээр хаант улс тус бүрд очих хүмүүсийн зан чанаруудыг жагсаан бич.

Б Үзэгдлийг дүрсэл

Өөрт чинь гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн, Сургаал ба Гэрээ 76-р хэсгийн хоёр хэсгийг дүрсэлсэн зургийг тэмдэглэлийн дэвтэртээ зур. Зураг бүрийг товч дүрсэлж илчлэлтийн энэ хоёр хэсгийн юу нь өөрт чинь гүнзгий сэтгэгдэл төрүүлснийг ярь.



В Захидал бич

1. Сургаал ба Гэрээ 76:1–10-ыг судалж, “зөв шударга ёсонд болон үнэнд эцсээ хүртэл надад үйлчилдэг тэднийг хүндэтгэхийн” (ш. 5) тулд Бурхан юу хийхийг дүрсэлсэн өгүүлбэрүүдийг жагсаан бич.
2. Зөв шударга байна гэдэг нь хүч чармайлт гаргалаа ч гэсэн хэцүү байдаг гэж боддог нэг найз эсвэл гэр бүлийн нэг гишүүн чамд байдаг гэж бод. Жагсаалтаа ашиглан зөв шударга хүмүүст Бурханы амласан амлалтуудыг тайлбарласан захидал бич. Аль амлалтууд чиний хувьд илүү чухал учир холбогдолтойг хэлж, яагаад гэдгийг тайлбарла.

Г Судрын гарамгай мэдлэг—Сургаал ба Гэрээ 76:22–24

1. 76:20–24-т цэдэглэгдсэн гэрчлэлийг нэгтгэн дүгнэ. Аврагчийн тухай эдгээр шүлгүүд юу зааж байгааг жагсаан бич.
2. Аврагчийн тухай энэ үзэгдлийн дараа Бошиглогч Иосеф Смит, Сидней Ригдон хоёрт ямар бодол төрсөн байж болохыг тунгаан бод. Есүс Христийн тухай гэрчлэлээ мөн Түүний талаар юу мэддэгээ хувийнхаа тэмдэглэлд бич.

Д Сорил бич

Сургаал ба Гэрээ 76-р хэсгийн “Судруудыг ойлгох нь” (“Илчлэлтийн бүтэц”) хэсэг дэх төрөл зүйл бүрд зориулж, утга учиртай, наад тал нь нэг сорилын асуулт бич. Асуулт бүрийн дараа хариултыг өгч, асуултын хариуг мэдэх нь яагаад чухал гэж бодож байгаагаа тайлбарла.

Е Судруудын Удирдамжаа ашигла

1. Судруудын Удирдамжаасаа (х.122) Люцифер гэдэг үгийг харж, энэ үг ямар утгатайг тэмдэглэлийн дэвтэртээ тайлбарла.
2. Сургаал ба Гэрээ 76:25–29 дэх тодорхойлолт, мэдээллийг ашиглан мөнх бус байдлын өмнөх дэлхий дэх

Люсиферийн тухай, түүнд юу тохиолдсон тухай мэддэг зүйлээ бич.

3. Тэр яагаад “Бурханы гэгээнтнүүдтэй дайтахыг” онцгойлон хүсдэг байсан бэ? (Хэрэв тусламж хэрэгтэй бол, ш. 29; мөн С ба Г 76:29-ийн “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз).

Ё Селестиел хаант улсын шаардлага ба шагналууд

1. Селестиел алдар сууг хүсдэг хүмүүсээс юу шаардагддагийг Сургаал ба Гэрээ 76:50–53-аас жагсаан бич.
2. Бид яагаад “итгэлээр даван туулах” (ш. 53) шаардлагатай гэж чи бодож байна? Шаргуу ажил, шийдэмгий чанар, сэтгэлийн тэнхээ яагаад хангалтгүй байдаг вэ? (Мөн С ба Г 76:69; 2 Нифай 31:19–21; Моронай 6:4-ийг үз.)
3. Селестиел хаант улсад очих хүмүүсийн тухай Сургаал ба Гэрээ 76:50–70, 92–96-д заасан зүйлүүдээс өөрт чинь учир холбогдолтой наад тал нь хоёр адислалыг бичиж, чи яагаад эдгээр адислалуудыг хүсдэгээ тайлбарла.

Сургаал ба Гэрээ 77

Иоханы илчлэлтийн талаарх асуултууд



Төлөөлөгч Иохан долоон тамгаар тамгалсан ном харжээ.

“Илчлэлтийн ном бол Бурхан нэгэн цагт бичүүлсэн хамгийн тодорхой номуудын нэг мөн” гэж Бошиглогч Иосеф Смит нэгэнтээ мэдэгджээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, 290).

Сүмийн олон гишүүд Төлөөлөгч Иоханы номыг нэлээд хэцүү гэж үздэг, мөн энэ ном ямар утгатай талаар Христийн ертөнц олон зууны туршид маргалдсаар байгаа билээ. Илчлэлтийн номын утгыг нээн харуулж, Иосеф Смитийн тайлбарласан байдлаар үүнийг ойлгож эхлэхэд бидэнд туслах ойлголтын зарим түлхүүрүүд Сургаал ба Гэрээ 77-р хэсэгт байдаг. 77-р хэсэг дэх Их Эзэний хариултаудыг ойлгоход тусалцаа авахын тулд Илчлэлтийн Номыг бас үз.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 77

Зуурдын (ш. 2, 6)—Дэлхийн биет зүйлүүд болон дэлхийн амьдралд хамаарах

Елиа (ш. 9)—Бурханы нэг элчийн нэр

Сургаал ба Гэрээ 77:2–3—Иоханы харсан араатнуудын тухай бид юу мэддэг вэ?

Хэдийгээр бид мэдэхгүй ч гэсэн, Тэнгэрлиг Эцэгийн бүтээлүүдийн чухал хэсэг болсон амьдралын ер бусын хэлбэрүүдийг Иохан харсан ажээ. Тэдгээр бүтээлүүдийн тухай Бошиглогч Иосеф Смит хэлэхдээ: “Манай дэлхийтэй адилхан хэдэн мянган дэлхийгээс хэдэн мянган удаа аврагдсан хэдэн арван мянган хэлбэрийн амьтад-бидний огт төсөөлөхгүй хачирхалтай араатнууд, тэнгэрт л бүгдийг нь харж болох амьтдыг Иохан тэнд харсан гэж би боддог. Зөвхөн тэнгэрт л байдаг их нууцыг Иоханд үзүүлсэн хэрэг” гэжээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, 291). Өөр нэг удаа тэрээр: “Тэр дөрвөн араатан бол бүрэн хэмжээгээрээ бүтээгдсэн бөгөөд бусад дэлхийнүүдээс аврагдсан хамгийн сүр жавхлантай дөрвөн амьтан байжээ. Учир нь тэдгээр амьтад төгс, тэндэх тэнгэр элчүүд лүгээ адил байж. Тэдгээр амьтад хаанаас ирснийг бидэнд хэлээгүй, бас би мэдэх ч үгүй, гагцхүү тэдгээр нь Бурханыг магтан алдаршуулсан Иоханд харагдаж, сонсогдсон ажээ” гэж хэлжээ (*History of the Church*, 5:343–344). Энэ илчлэлт илүү нарийн төвөгтэй, бидний олонтаа бодлогоос илүү агуу ертөнц рүү бидний мэлмийг нээдэг нь тодорхой байна.

Сургаал ба Гэрээ 77:15—“Хоёр Гэрчийн” талаар бид юу мэддэг вэ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Брус Р.МкКонки: “Энэ хоёр гэрч бол Тэнгэрийн Их Эзэн ач ивээлийн энэхүү сүүлчийн эрин үед үүрдийн Сайн мэдээнийхээ бүрэн байдлыг түүгээр дамжуулан сэргээсэн, даруухан хүн, Иосеф Смитийн дагалдагчид байх ёстой. Тэд бол Арванхоёрын Зөвлөлийн эсвэл Сүмийн Тэргүүн Зөвлөлийн гишүүд байх нь эргэлзээгүй” гэж заажээ (*Doctrinal New Testament commentary*, 3:509).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 77-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Судруудын Удирдамжаа ашигла

Сургаал ба Гэрээ 77:1-ийн зүүвэр тайлбарт “Дэлхий, түүний хувь тавилан” гэсэн Судруудын Удирдамжийн эшлэл байдаг. Судруудын Удирдамжийнхаа энэ тайлбарыг Библи (х.00 [115])-дээ олж, уг сэдвийн талаар илүү ихийг мэдэхийн тулд, жагсаан бичсэн эшлэлүүдээс нэлээд хэдийг унш. Ирээдүйд манай гараг дээр юу болохыг илүү сайн ойлгоход чинь туслах, олсон санаануудаасаа гурвыг жагсаан бич.

Б Долоон тамгатай ном

1. “Ар дээрээ долоон тамгаар тамгалагдсан” номын тухай, мөн Илчлэлт 5:1-д Иоханы харсан тамгануудын тухай бид Сургаал ба Гэрээ 77:6–7-гоос юу мэдсэн бэ?
2. Энэ дэлхий дээр юу болохыг Бурхан эхлэлээс мэдэж байсныг мэдэх нь та нарын хувьд хэр зэрэг тайтгарал болох вэ?

В Нэр томьёог тайлбарла

1. Духан дээрээ тамгатай байсан итгэлтнүүдийн тухай Иосеф Смитийн асуултуудад хариулсан Их Эзэний хариулт Сургаал ба Гэрээ 77:9–11-д байдаг. Бас Илчлэлт

7:1-4, 14:1-ийг уншиж, уг “тамга” тэдгээр хүмүүсийн тухай юуг илчилдэг гэж бодож байгаагаа тайлбарла.

2. Тамга нь өнөө үеийн хүмүүст байдаг уу, эсвэл ирээдүйд тохиолдох зүйл гэж та нар бодож байна уу?



Сургаал ба Гэрээ 78

Бишопын агуулахыг бий болгох хэрэгцээ

Зарим хүмүүст хэрэгцээнээс нь маш их зүйл илүү байхад бусад нь зөвхөн амь зуулгаа арай ядан хангаж байгааг Тэнгэрлэг Эцэгийн бодол санаа гэж чи боддог уу? Сургаал ба Гэрээ 78-р хэсэгт Их Эзэн бүх хүүхдүүдээ ханган тэтгэх төлөвлөгөөгөө тайлбарлажээ. Дэлхийн адислаалуудаа Түүний төлөвлөсөн арга замаар зохицуулан эдэлдэг хүмүүст Их Эзэний өгсөн амлалтуудыг эрж ол.



Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 78

Аманы хүү (ш. 20)— хэлээр “Бурхан” гэсэн утгатай ажээ
Бурханы хүү (Аман гэдэг нь
Адамын ярьдаг байсан

Сургаал ба Гэрээ 78:3—“Миний хүмүүсийн ядууст зориулсан агуулах”

1831 оны хоёрдугаар сард Их Эзэн Сүмд Өөрийн нэг хуулийг өгч, “ядуусыг санаж өмч хөрөнгөө тэднийг дэмжихийн тулд өргөл болгохыг” (С ба Г 42:30) гишүүдэд зарлиг болгосон юм. Уг зарлигт өгүүлсэн нь: Ядуусыг дэмжин тэтгэхийн тулд өгөх зүйлс нь “миний Сүмийн бишоп болон зөвлөхүүдийнх нь өмнө тавигдах” (ш. 31) ёстой. Бишоп тулгамдсан хэрэгцээг шийдвэрлэсний дараа үлдсэн зүйлүүд нь “ядуус болон гачигдагсад өгөхийн тулд миний агуулахад хадгалагдаж” (ш. 34) байх ёстой. 1832 оны гуравдугаар сард амлагдсан агуулахыг үндэслэн байгуулах цаг иржээ.

Сургаал ба Гэрээ 78:5-7—Адил тэгш байх гэдэг нь юу гэсэн үг вэ?

“Адил тэгш байх гэдэг нь гүйцэтгэсэн хөдөлмөрийнхөө төлөө хүн бүр адилхан нөхөн төлбөр авна гэсэн хэрэг биш, харин хүн бүр хэрэгцээнийхээ хэрээр авах ёстой, ингэснээр адил тэгш байх нь хангагдах ёстой гэж Их Эзэн үздэг ажээ. Хүмүүсийн зүрх сэтгэлд аминч үзэл үгүй болсон үед энэхүү хүсүүштэй зүйл биелэгдэнэ. Гэвч атаа жотөө, аминч үзэл хүмүүсийн санаа сэтгэлээс арилаагүй цагт энэ нь бүтэшгүй зүйл юм. Бид адил тэгш байдлын талаарх Селестиел хуулийг сахих чадвартай байх нь маш чухал юм” хэмээн Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит сургажээ (*Church History and Modern Revelation*, 1:307).

“Илчлэлтүүд адил тэгш байдлын тухай өгүүлдэг учраас нэгдсэн журам нь онол, практикийн хувьд хамтын буюу коммунист шинжтэй гэж зарим хүмүүс үздэг нь буруу юм. Нэгдсэн журмын адил тэгш байдал бол өнөөдөр зарим хүмүүсийн хамгаалж байгаа шиг эдийн засаг, нийгмийн хувьд тэгшитгэх явдал биш юм. Их Эзэний дүрсэлсэн адил тэгш байдал бол [тухайн хүний] гэр бүлд тохирсон, ‘нөхцөл боломжийнх нь дагуу мөн хүсэл хийгээд хэрэгцээнийх нь дагуу’ (С ба Г 51:3) адил тэгш байдал юм” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлжээ (“A Vision and a Hope for the Youth of Zion,” in *1977 Devotional Speeches of the Year* [1978], 74).

Сургаал ба Гэрээ 78:11-12—“Сатаны тамлал” гэж юу вэ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Брус Р.МкКонки: “Сатаны тамлалд орох гэдэг нь түүний эрхшээлд орох гэсэн утгатай юм. Энэ бол санваар, зөв шударга ёс, бурханлиг чанарын хамгаалах бүх хүч тухайн хүнд байхгүй болж, тэрээр Сатаны гарт шилжин очно гэсэн үг юм. Ингэснээр тэр хүнийг ямар ч хориг саадгүйгээр тамлан, мөрдөн хавчих, үйлийг нь үзэн зовооход Сатан чөлөөтэй болдог. Хязгаарлалт байхгүй болоход Сатаны уруу таталт болон зүхлүүд энэ дэлхийд, бас ирэх дэлхийд аль алинд нь гал болон хүрээр авалцан шатаагч, дүрслэхийн аргагүй түмэн гай зовлон авчирна. Харагдсан хүмүүс тамд ийнхүү тарчлан зовно” гэж заажээ (*Mormon Doctrine*, 108).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 78-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас гурвыг хий.

А Ярилцлага явуул

1. Сургаал ба Гэрээ 42:30-34, 78:1-4-ийг нэгтгэн дүгнэ. Өргөлийн хуулийн дагуу агуулахыг хэрхэн ашигладаг байсныг дүрсэл.
2. Аравны нэгийн хуулийн дагуу бишопуудын агуулах өнөө үед хэрхэн ялгаатай ажиллагдийг тайлбарлахыг Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхийлөгчөөсөө эсвэл санваартны аль нэг удирдагчаас хүс. Мэдсэн зүйлээ товчхон бич.

Б Ялгааг төсөөлөн бод

1. Сургаал ба Гэрээ 78-р хэсгийг уншаад “дэлхийн зүйлүүдэд” (ш. 6; мөн С ба Г 78:5-7-гийн “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз) бид адил тэгш байх ёстой гэж Их Эзэн хэлсэн нь ямар утгатайг тайлбарла.

2. Хэрэв тийм байдлаар хүн бүр “тэгш” байсан бол танай орчин, сургууль, нийгэм хамт олны хувьд юу нь илүү сайн байхсан бол?

В Шалтгааныг хэл

Сургаал ба Гэрээ 78:14-т дэлхийн үлдсэн хэсгээс Сүм “тусгаар байдалтай байх” ёстой гэж Их Эзэн хэлжээ.

1. Тусгаар байдалтай байхад тусалж болох ямар заавруудыг Их Эзэн Сүмд өгсөн бэ?
2. Бие даах илүү чадвартай болоход бидэнд тусалж болох өөр юуг Сүм хийж, зааж байгааг та нар хардаг вэ?

Г Чи юу гэж хэлэх вэ?

Багш нарын чуулгын ерөнхийлөгч бөгөөд чуулгынх нь нэлээд хэдэн гишүүн үйл ажиллагаануудыг сонирхохгүй байгаа юм шиг санагдсан учраас урам нь хугарсан нэг найз чамд байдаг гэж бод. Чуулгынх нь гишүүд Сүмд ирдэг боловч тэр долоо хоногт болох Залуу Эрэгтэйчүүдийн үйл ажиллагаануудад оролцохыг хүсдэггүй ажээ. Юуг ойлго-вол зохиохыг Их Эзэн түүнээс хүснэ гэж чи бодож байна? Үүнийг ойлгоход нь найздаа туслахын тулд Сургаал ба Гэрээ 78:17–18-ыг ашигла.

Сургаал ба Гэрээ 79–80

Номлолын дуудлага

Бошиглогчийн гарын үсэг зурсан номлолын дуудлагыг хүлээн авах нь хэчнээн гайхалтай сайхан байдгийг бодоод үз. Сургаал ба Гэрээ 79–80-р хэсэгт номлолын дуудлагаа хүлээн авсан ах нарт ямар санагдсаныг төсөөлөн бод. Тэдгээр ах нар номлолын дуудлагаа хүлээж авч байсан үед өнөөдрийн номлогчдод учирдаггүй ямар сорилтууд тэдэнд тулгарсан байж болох вэ?



Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 79

Тайтгаруулагч (ш. 2)—
Ариун Сүнс

Тариан боодлуудаар
дахин титэм хүртээх (ш.
3)—Хөрвөгчдөөр түүнийг
адислах

Сургаал ба Гэрээ 80:4—Та нар мэддэггүй юмаа зааж чадахгүй

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Оорсон Пратт номлолын ажлын талаар дараах зүйлийг ажиглажээ: “Би номлогчдын хэд хэдэн бүлэгтэй гадаадад ажиллаж байсан . . . , бас тэднийг харамсан, гашуудаж байхыг харсан, тэднийг санаа бодлоо бие биедээ—Өө би хамаг цаг заваа шал тэнэг зүйлд үрж байсан атлаа мөнх амьдралын зарчмуудыг эрхэмлэн дээдэлж, судруудыг судлахад, Сүмийн сургаалуудыг яс махандаа шингэтэл гүнзгий ойлгон, удирдамж болгон бидэнд тэнгэрээс илчилдэг зарчмуудыг мэдэж авахад илүү их цаг хугацаа зарцуулж байсангүй! Гэтэл би дэлхийн оршин суугчдын өмнө зогсоход бэлтгэгдэж, манай зарчмуудын талаар тэднийг сэнхрүүлэх ёстой байсан шүү дээ” гэж хэлэхийг нь сонссон.” (in *Journal of Discourses*, 7:76).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 79–80-хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Номлолын ажлын адислалууд

1. Сургаал ба Гэрээ 79:1-д Их Эзэн сайн мэдээг Жаред Картерт хэрхэн дүрсэлсэн бэ?
2. Сайн мэдээний тухай ийм байдлаар мэдэрдэггүй хүмүүс байвал, тэд юу хийх ёстой гэж чи боддог вэ?
3. Картер ах итгэлтэйгээр үйлчилсэн тохиолдолд Их Эзэн түүнд ямар амлалтууд өгсөн бэ? Одоо үед та нар эдгээр амлалтуудыг хэрхэн авч чадах вэ?

Б Номлогчийн бэлтгэл

1. Сургаал ба Гэрээ 80-д, Стефен Бурнетт, Эден Смит нарт номлолдоо юу заахыг зарлиг болгосон бэ?
2. Номлогч бүр энэ зарлигийг Их Эзэний төлөвлөсөн арга замаар биелүүлэхийн өмнө юу хийх ёстой вэ?

Сургаал ба Гэрээ 81

Ерөнхийлөгчийн Зөвлөлд өгсөн Их Эзэний зөвлөгөө

Их Эзэн Сүмийнхээ бүрэн зохион байгуулалтыг Бошиглогчид бүгдийг нь нэг дор илчлээгүй юм. Сүм өсч хөгжихийн хэрээр зохион байгуулалт нь өргөжин тэлж

байлаа. Сургаал ба Гэрээ 81-р хэсэгт, хожим нь Тэргүүн Зөвлөл болсон, “Дээд Санваартны Ерөнхийлөгчийн Зөвлөлийн талаар Их Эзэн нэмэлт зөвлөгөөг Иосеф Смитэд өгчээ. Сүмийг удирдахад туслах юуг Их Эзэн Иосеф Смитэд өгснийг эрж ол. Их Эзэнээс энэ дуудлагыг хүлээн авсан үед Фредерик Г.Виллямст ямар санагдсан байж болохыг төсөөлөн бод. Энэ илчлэлт анх Жесси Гауст зориулагдсан ч, тэр итгэлтэй хэвээр үлдээгүйг бас ажигла (С ба Г 81-р хэсгийн тоймыг үз).



Фредерик Г. Виллямс Бошиглогч Иосеф Смитийн зөвлөхөөр дуудагджээ.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 81

Альфа ба Омега (ш. 7)— Грек цагаан толгойн эхний болон сүүлчийн үсэг, Есүс Христийн нэг нэр. Энэ нэр

Есүс бол “Эхлэл ба Төгсгөл, Эхнийх бөгөөд Сүүлчийнх” гэдгийг бэлгэддэг.

Сургаал ба Гэрээ 81:2— Тэргүүн Зөвлөл “Хаант улсын түлхүүрүүдийг” үргэлж эзэмшдэг

Тэргүүн Зөвлөл хаант улсын түлхүүрүүдийг байнга эзэмшдэг гэдэг бодит үнэнийг Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит санваартны ерөнхий хурал дээр тайлбарласан нь:



“Түлхүүрүүд [дэлхий дээрх Бурханы хаант улсын түлхүүрүүд] бол Ерөнхийлөгчийн Зөвлөлийн эрх юм. Түлхүүрүүд нь дэлхий дээрх Их Эзэний бүх ажил хэргийг удирдаж, чиглүүлэх хүч болон эрх мэдэл мөн. Түлхүүрүүдийг эзэмшдэг хүмүүс нь санваараар үйлчилж болох бусад бүх хүмүүсийн ажиллах арга маягийг удирдан чиглүүлж, хяналт тавих эрхтэй байдаг. Бид бүгд санваарыг

эзэмшиж болно, гэвч түлхүүрүүдийг эзэмшдэг хүмүүс эрх мэдэл олгож, чиглүүлсэн үед л бид санваарыг ашиглаж болно.”

“Эл санваар болон түлхүүрүүдийг Петр, Иаков, Иохан нар, түүнчлэн Мосе, Елиа болон эртний бусад бошиглогчид Иосеф Смит, Оливер Каудери хоёрт олгожээ. Энэ хоёр хүнийг Арванхоёрын Зөвлөлийн гишүүний хувьд тус бүрийг нь онцгойлон адисалж, түлхүүрүүдийг олгосон

ажээ. Гэвч түлхүүрүүд нь Ерөнхийлөгчийн Зөвлөлийн эрх учраас зөвхөн Сүмийн Ерөнхийлөгч, дэлхий дээрх Бурханы ахлах Төлөөлөгч л түлхүүрүүдийг бүрнээр нь ашиглаж чадна.

“Бидэнд ариун санваар болон Бурханы хаант улсын түлхүүрүүд байдгийг би эдүгээ нэн тодорхойгоор бас нэн чухалчлан хэлж байна. Санваар болон Бурханы хаант улсын түлхүүрүүд нь зөвхөн Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд байдаг.

“Эдгээр түлхүүрүүд ‘Дээд Санваартны Ерөнхийлөгчийн Зөвлөлд үргэлж харьяалагддагийг’ (С ба Г 81:2) Их Эзэн Иосеф Смитэд илчлэлтээр хэлсэн билээ. . . .

“Эдүгээ, ах нар аа, бид оюун бодолдоо үлэмж тод байлгах ёстой нэг зүйл бий гэж би боддог. Энэ нь юув гэвэл, Сүмийн Ерөнхийлөгч ч, Тэргүүн Зөвлөл ч, Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрын нэгдмэл дуу хоолой ч Гэгээнтнүүдийг хэзээ ч буруу удирдахгүй, Их Эзэний оюун бодол, хүсэл таалалд харшлах зөвлөгөөг дэлхийд хэзээ ч өгөхгүй.

“Хувь хүн Сүмийн идэвхгүй гишүүн байж болох юм эсвэл Их Эзэний оюун санаанд тохирохгүй үзэл бодолтой байж, эсвэл ийм зөвлөгөө өгч мэднэ. Гэвч Тэргүүн Зөвлөлийн дуу хоолой, мөн тэдэнтэй хамт хаант улсын түлхүүрүүдийг эзэмшдэг хүмүүсийн нэгдмэл дуу хоолой Гэгээнтнүүд болон дэлхийг Их Эзэний хүсдэг тэрхүү замаар үргэлж удирдах болно. . . .

“Хэрэв бид Тэргүүн Зөвлөлийг харж, тэдний зөвлөгөө, удирдлагыг дагах юм бол Сүмийн гишүүд бидний замналыг саатуулах болон өөрчилж чадах хүч дэлхий дээр байхгүй. Бас бид хувь хүмүүсийн хувьд энэ амьдралд амар амгалан олж, ирэх дэлхийд мөнхийн алдар сууг өвлөгчид болно” хэмээн мэдэгджээ (In Conference Report, 1972 оны 4-р сар, 98–99; *Ensign*, 1972 оны долдугаар сар, 87–88).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 81-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Хянах жагсаалт хий


Сургаал ба Гэрээ 81-р хэсгийг нэгтгэн дүгнэж, Их Эзэн Фредерик Г.Виллямсаас юу хий гэж хүссэнийг жагсаан бич. Зөвхөн Тэргүүн Зөвлөлд хамаатай гэж бодсон зүйлүүдийг хажууд нь тэмдэглэж, Сүмийн гишүүн бүрд хамаатай гэж бодсон зүйлүүдийг дугуйл.

Сургаал ба Гэрээ 82

Сионыг байгуулахтай холбоотой зааврууд

Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн өмнө Сионы хот Миссурийн Индепенденст байгуулагдана гэдэгт бид итгэдэг. Энэ агуу үйл явдалд чи ямар үүрэг гүйцэтгэх

вэ? Чи энэ үйл явдалд оролцоход хэрхэн бэлтгэж болох вэ? Бид ямар арга замаар сайжирч, өөрчлөгдөх хэрэгтэй вэ? Сүмийн эхэн үеийн удирдагчдад өгсөн Их Эзэний зөвлөгөө тэдэнд чухал байсны нэгэн адилаар бидэнд ч чухал ач холбогдолтой юм. Учир нь Сионыг үндэслэн байгуулах үйл хэргийн нэг хэсэг байхын тулд бид бас анхааралтай сонсож, дуулгавартай дагах ёстой.



Сүмийн алс хол тархсан цугларалтууд (гадаснууд) Сионыг бэхлэн тулж, өсч хөгжихөд нь Сионд хэрхэн түслэхыг дүрслэн харуулахын тулд Их Эзэн майхан болон майхны гадаснуудыг дүрслэл болгон ашиглажээ.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 82

Зөрчил гаргагчид (ш. 4)—
Хууль зөрчигчид, нүгэлт-
нүүд

Холбогтун (ш. 15)—
Үйлдэгтүн, үүрэг хүлээгтүн

Сатаны тамлал (ш. 21)—
Тамлаж зовоох (С ба Г
78:11–12-ын “Судруудыг
ойлгох нь” хэсгийг үз).

Сургаал ба Гэрээ 82:14—“Сион өндийн босч ирэх ёстой”

Сион гэдэг үг Библи болон Мормоны Номонд 200 гаруй удаа гардаг. Мөн Сургаал ба Гэрээнд бараг л төдийчинээ удаа давтагддаг. Сион бол эцсийн өдрүүдэд хамаарах маш чухал зарчим юм. Бошиглогч Иосеф Смит Миссурийн Индепенденст очиж, Сионы газрыг онцгойлон адислах үед сэтгэл ихэд догдолсон байжээ. Тэрээр Сионы тухай хэлэхдээ: “Сионыг байгуулах нь эрин зуун бүхэн дэх Бурханы хүмүүсийн сонирхлыг татдаг учир шалтгаан байлаа. Энэ бол бошиглогчид, санваартнууд, хаадын өдрийн бодол, шөнийн зүүд байсаар өнөө үеийг хүрч ирсэн сэдэв юм. Тэд бидний амьдарч байгаа өнөө үеийг оргилуун баяр баясалтайгаар хүсэн хүлээсээр ирсэн билээ. Тэд өнөө үеийн тухай гал цогтойгоор, бадруун хийморьлигоор, тэнгэрлэг хүсэн хүлээлтээр дуулж, бичиж, бошиглосоор ирсэн юм. . . . Бид бол хожмын үеийн алдар сууг тохиолгон авчрахаар Бурханы хайр ивээлийг хүлээсэн, Түүний сонгосон хүмүүс мөн. Хожмын үеийн алдар сууг нүдээр харж, цогцлон байгуулахад оролцон, хөгжиж дэвжин урагш ахихад туслах нь бидний үйл хэрэг юм” гэжээ (*History of the Church* 4:609–610).

Сургаал ба Гэрээ 82:22—“Шударга бус байдлын эд баялгийг ашиглан өөрсдийгөө найз нөхөдтэй болгох нь”

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит тайлбарласан нь: “Шударга бус байдлын эд хөрөнгийг ашиглан” өөрсдийгөө найз нөхөд болгох Их Эзэний зарлигийг Гэгээнтнүүд зохих ёсоор ойлгохгүй бол хэцүү хэллэг юм шиг санагддаг.

‘Шударга бус байдлын эд хөрөнгийг ашиглан’ найз нөхөдтэй болох гэдэг нь ах нар хүмүүсийн нүгэлд оролцож, тэднийг халуун дотноор хүлээн авч, тэдэнтэй гэрлэж, нэг үгээр хэлбэл, тэдний төвшинд доошоо орох хэрэгтэй гэсэн үг биш. Гэгээнтнүүд дайснуудтайгаа эв найртай амьдрахад итгэлтэй байж болно. Зөв шударга, ариун журамт зарчмууд Гэгээнтнүүдэд ийм боломж олгох болно. Тэд хүмүүст эвтэй найрсаг, нөхөрсөг хандах ёстой боловч, тэдэнд хэзээ ч андгай тангараг өгөх эсвэл хэзээ ч тэдэнтэй хамт ууж, наргиж цэнгэх ёсгүй. Хэрэв хүмүүс атгаг санаагаа орхиж, эвтэй найртай, нөхөрсөг байх хүслээ харуулбал, гацуун байдлаа орхиход энэ нь тэдэнд тусалж болно. Шүүлтийг Их Эзэнд үлдээх ёстой” гэжээ (*Church History and Modern Revelation*, 1:323).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 82-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 82:3

- 1 Нифай 3:7-г Сургаал ба Гэрээ 82:3-тай хамт уншиж, энэ хоёр хэсэг дуулгавартай байх тухай юу зааж байгааг тайлбарла. Хоёр судраас хоёулангаас нь санаануудыг оруулахад анхаар.
- 2 Энэ хоёр судрын гол санааг тусгасан уриа бичих буюу үзүүлэн зур.

Б Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 82:10

- 1 Ифер 3:12-ыг уншиж, Тэнгэрлэг Эцэг өгсөн амлалтуудаа үргэлж биелүүлдгийг бид хэрхэн мэддэгийг тайлбарла.
- 2 Сургаал ба Гэрээ 82:10-ыг нэгтгэн дүгнэж, Бурхан юу амласныг тайлбарлаж, “хэрэв-тэгвэл” гэсэн нотолгоо болгон бич.
- 3 Сургаал ба Гэрээ 59:12–20-д судалсан, Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих тухай зарлигт зориулан, “хэрэв-тэгвэл” гэсэн нэг нотолгоо бич.
- 4 Өөрийнхөө сонгосон өөр нэг зарлигт зориулан, “хэрэв-тэгвэл” гэсэн нэг нотолгоо бич.

В Шалтгаан ба үр дүнг ол

Их Эзэн Бошиглогч Иосеф Смитэд Сионыг байгуулах тухай өөр олон зааврыг Сургаал ба Гэрээ 82-р хэсэгт өгчээ.

- 1 Дараах схемийг тэмдэглэлийн дэвтэртээ зурж, дор харуулснаар гарчигла.




- Их Эзэн Сионд тохиолдохыг хүссэн зүйлүүдийг “Хүссэн үр дүн” хайрцагт жагсаан бич (С ба Г 82:14-ийг үз).
- Шүлэг 15-д *тиймийн тул* гэсэн үгийг олж, тэмдэглэ.
- Шүлэг 15–19-ийг нэгтгэн дүгнэж, “Холбогдох зарлигууд” хайрцагт, хүссэн үр дүнд хүрэхийн тулд Гэгээнтнүүдэд Их Эзэний өгсөн зарлигуудыг жагсаан бич.
- Тохиохыг нь Их Эзэний хүсдэг зүйлүүд, хэрэв зарлигуудад дуулгавартай байхгүй бол, яагаад тохиохгүй гэж бодогоо тайлбарла.



Эх хүн хүүхдүүдээ өөрөө өсгөн хүмүүжүүлнэ гэдэг хэцүү хэрэг. Сүм өргөлийн хуулийн дагуу энэ хэрэгт хэрхэн туслах ёстойг Их Эзэн Сургаал ба Гэрээ 83-р хэсэгт тайлбарлажээ. Эл зарчим өнөөдөр ч гэсэн хэвээр үйлчилж байна.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 83

Сургаал ба Гэрээ 83:6—“Бэлэвсэн хийгээд өнчин хүмүүс тэрчлэн ядуусын адилаар хангагдах ёстой” Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит хэлэхдээ: “Бэлэвсэн эмэгтэйчүүдэд гачигдал тохиолдсон үед тэднийг харж хандах шаардлагатай. Эцэггүй эсвэл өнчин хүүхдүүдийг Сүмийн сангаас ханган тэтгэх ёстой. Тэднийг хувцаслаж, хооллох ёстой. Тэд бас эцэг эх нь халамжилдаг бусад хүүхдүүдтэй нэгэн адил боловсролтой болох боломжтой байх ёстой. Хүүхэд эцэггүй, эхгүй байх юм бол Сүм тэр хүүхдийн эцэг эх болж, анхаарал халамж тавих үүрэгтэй. Тэр хүүхэд Сүм дэх бусад хүүхдүүдтэй адил тэгш боломжтой байхыг анхаарах ёстой. Энэ бол асар их хариуцлага юм” гэжээ (In Conference Report, 1899 оны 10-р сар, 39).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 83-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Сонины өгүүлэл бич

Чи өөрийгөө орон нутгийн жижиг сонины сурвалжлагч бөгөөд ослоор эцэг нь нас барсан нэг гэр бүлийн тухай бичих даалгавар авчээ гэж бод. Тэр бэлэвсэн эмэгтэйтэй ярилцлага хийж, орлогогүйгээр, нөхрийнхөө дэмжлэггүйгээр хэрхэн амьдарч буйг нь түүнээс асуухад, тэрээр өөрийгөө Хожмын Үеийн Гэгээнтэн гэж тайлбарлажээ. Сургаал ба Гэрээ 83-р хэсэгт уншсан зүйлээсээ, энэ хүнд бэрх цагт түүнд өөрт нь бас хүүхдүүдэд нь туслахын тулд Сүм юу хийсэн талаар тэр эмэгтэй юу ярьж болох тухай нэг өгүүлэл бич. (Шаардлагатай бол эцэг эхээсээ эсвэл Сүмийн аль нэг удирдагчаас тусалцаа хүс.)



Бурханы санваарын талаар та нар юу мэдэх вэ? Санваарын зорилго юу вэ? Санваар амьдралд чинь хэрхэн нөлөөлсөн бэ? Санваар дэлхийн үлдсэн хэсэгт яагаад чухал вэ? Санваарын тангараг ба гэрээ гэж юу вэ? Санваар хүлээн авсан хүмүүс биеэ хэрхэн авч явах ёстой вэ? Санваарын тухай олон чухал ойлголт, санваарыг эзэмшдэг хүмүүс Сүмийг хэрхэн удирдаж, бидний амьдралыг, түүнчлэн бүх дэлхийг хэрхэн адисалдаг тухай олон ойлголт Сургаал ба Гэрээ 84-р хэсэгт байдаг.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 84


Дээд санваар (ш. 19)—Мелкизедек санваар
Доод санваар (ш. 26)—Аароны санваар
Зуурдын (ш. 27)—Дэлхийн, материаллаг зүйлүүдтэй холбоотой (энэ амьдралд хийх ёстой зүйлүүд)
Шулуун болгох (ш. 28)—Бэлтгэх
Тангараг (ш. 39)—Албан ёсны мэдэгдэл буюу амлалт
Цээрлүүлэлт (шүлэг 58, 96)—Шийтгэл, зовлон
Гуйвшгүй (ш. 61)—Итгэлтэй, бат бөх, шийдвэр төгс

Чанд байдал (ш. 61)—Ариун хандлага, цэвэр ариун санаа бодолтой байх
Дуншиж, хүч чадлаа урагш авчирлаа (ш. 101)—Энэ нь төрөх үеийн өвдөлтийг хэлж байна. Энэ нь Мянган Жилийн “төрөлтөөс” үүдэлтэй, Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн өмнөх дэлхий дээрх гай зовлонгийн бэлгэдэл юм.
Материаллаг ажлууд (ш. 113)—Сүмтэй холбоогүй ажил хэргүүдийг эрхлэх

Сургаал ба Гэрээ 84:2—“Өөрийн хүмүүсийг сэргээхийн тулд”

Сургаал ба Гэрээ 84:2 дахь *Сэргээлт* гэдэг үг хожмын өдрүүдэд сайн мэдээний бүрэн байдлыг дэлхийд буцаан авчрахтай холбоогүй юм. Энэ нь Бурханы хүүхдүүдийг дэлхий дээрх Түүний хаант улс-Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд буцаан авчрах, улмаар дараа нь мөнх амьдралыг эдлэхийн тулд Түүний оршихуйд эргүүлэн авчрах гэсэн утгатай үг юм. Мөнх амьдралд сэргээх энэхүү Сэргээлт Сургаал ба Гэрээ 84-р хэсэгт авч үзсэн ёслолууд болон санваарын хүчинд илэрхийлэгдсэний адилаар, Есүс Христийн Цагаатгалын хүчээр боломжтой болдог.

Түүний Хүүхдүүдийн сэргээлт



Сургаал ба Гэрээ 84:4-5—Ямар Ариун сүм? Аль үеийнхэн?

Шинэ Иерусалим хотод (Миссурийн Жаксон дүүрэгт) тусгай ариун сүм барих тухай Их Эзэн Сургаал ба Гэрээ 84:4-5-д өгүүлжээ. Уг ариун сүм “энэ үед” баригдах бөгөөд Түүний алдар суу ариун сүм дээр онцгой байдлаар орших болно гэдгийг Тэрээр бас хэлжээ.



Бошиглогч Иосеф Смит энэ ариун сүмийн газрыг онцгойлон адисалсан (С ба Г 57 болон С ба Г 58:57-гийн “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз, х.00 [69]) боловч, Гэгээнтнүүд ариун сүмийг тэр үед барих боломжгүй байлаа. Гэвч уг ариун сүм энэ эрин үед баригдана гэсэн амлалтыг Сургаал ба Гэрээ 84-р хэсэг бас нотолдог. “Энэ үе” (С ба Г 84:4-5-ыг үз) гэдэг нь энэ эрин үе, Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн өмнөх эцсийн эрин үе юм.

Сургаал ба Гэрээ 84:6—Орхигдсон санаа


Их Эзэн Шинэ Иерусалимд баригдах ариун сүмтэй холбогдуулан Мосегийн хөвгүүдийн тухай Сургаал ба Гэрээ 84:6-д эхлэн ярьсан байдаг. Түүний нээлтийн өгүүлбэрийн дараа “Мөн Мосегийн хөвгүүд” гэж эхэлсэн эхний өгүүлбэрийнхээ дараа Тэрээр Мосе болон Израилын хүүхдүүдийн эзэмшдэг байсан санваарын тухай өгүүлсэн нэг санааг орхижээ. Шүлэг 6-д Түүний эхэлсэн, Мосегийн хөвгүүд болон Шинэ Иерусалим дахь ариун сүмийн тухай тэр санаа шүлэг 31-д үргэлжилдэг.

Сургаал ба Гэрээ 84:33—Санваарыг хүртэхэд, мөн дуудлагаа эрхэмлэн биелүүлэх

“Бид санваарын дуудлагаа эрхэмлэн биелүүлэх гэдэг нь санваарын нэр хүнд, ач холбогдлыг өндөрт өргөн, бэжжүүлж, санваарын албан тушаалыг хашиж байгаа хүний ариун журам, зөв шударга байдлын улмаас уг албан тушаалд бусад хүмүүсийг хүндэтгэлтэй ханддаг болгох явдал мөн” гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлжээ (*Teachings of Ezra Taft Benson*, 453).

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Нийл А.Максвелл, “хүн дуудлагаа эрхэмлэн биелүүлнэ гэдэг нь өөрийнхөө гэр бүл, сүмийн гишүүд, найз нар болон бусад хүмүүст санваарын үйлчлэлийн өргөн боломжуудыг хүргэх явдал мөн” хэмээн заажээ (“I Will Arise and Go to My Father,” *Ensign*, 1993 оны 9-р сар, 66).

Сургаал ба Гэрээ 84:54-58—Мормоны Ном ба зэмлэл



Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон 1986 оны дөрөвдүгээр сарын ерөнхий чуулганыг нээж хэлсэн үгэндээ: I

“Хэрэв бид Мормоны Номыг уншиж, сургаалуудад нь анхаарал хандуулаагүй бол, Сүм бүхлээрээ зэмлэл хүртэх байсныг Их Эзэн Сургаал ба Гэрээний 84-р хэсэгт нотолсон байдаг. [Тэрээр С ба Г 84:56-57-г эш татжээ.]

“Эдүгээ бид Мормоны Номын тухай илүү ихийг зөвхөн *арих* төдийгүй, харин энэ талаар илүү ихийг *хийх* хэрэгтэй байна. Яагаад? Их Эзэн ийн хариулжээ: [Тэрээр С ба Г 84:58-ыг эш татсан байна.] Бид тэрхүү цээрлүүлэлт, шүүлтийг мэдэрч байна!

“... Мормоны Ном байгаагүй бол бидний хувиараа судар судлах, сургаалыг гэр бүлд заах явдал, номлолын ажил ч бас бий болоогүй байхсан. Энэ тухайд бид наманчлах ёстой” (*In Conference Report*, 1986 оны 4-р сар, 4; *Ensign*, 1986 оны 5-р сар, 5-6).

Арай хожуухан, мөн энэ ерөнхий чуулганы үеэр, Мормоны Номыг ашиглах нь бидэнд хэчнээн чухал болохыг Ерөнхийлөгч Бенсон дахин онцлон тэмдэглэж:

“Сүмийг санхүүгийн дарамтаас чөлөөлөхийн тулд аравны нэгийн зарчимд онцгой анхаарал хандуулахад Их Эзэн Өөрийн үйлчлэгч Лоренцо Снөүд сүнсээр нөлөөлсөн юм. . . .



“Манай өнөө үед Сүмийг болон Сионы бүх хүүхдийг ээмлэл, цээрлүүлэлт, шүүлтээс гаргахын тулд Мормоны Номонд онцгой анхаарал хандуулах хэрэгтэйг Их Эзэн илчилсэн билээ. (С ба Г 84:54–58-ыг үз.) Энэ захиасыг дэлхий даяарх Сүмийн гишүүдэд хүргэх ёстой. . . .

“ . . . Мормоны Номыг ойлгох гүнзгий ойлголтоор би та нарыг адисалж байна. Хэрэв бид энэ номын хуудсаас өдөр бүр судалж, үзэл бодлоор нь амьдрах юм бол энэ мөчөөс хойшид урьд өмнө үзэгдээгүй адислалыг Бурхан Сионы хүүхэд бүр дээр бас Сүм дээр юулнэ. Ийнхүү Тэрээр ээмлэл, цээрлүүлэлт шүүлтийг өөрсдөөс нь зайлуулахыг бид Их Эзэнээс гуйх болно гэдгийг би амлаж байна. Энэ тухай би хүндэтгэлтэйгээр гэрчилж байна” гэжээ (In Conference Report, 1986 оны 4-р сар, 100; Ensign, 1986 оны 5-р сар, 78).

Сургаал ба Гэрээ 84:77–90—Номлогчдод өгсөн заавар ба амлалтууд

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Брус Р.МакКонки: “Түрийвч эсвэл аяны цүнхгүйгээр дэлхий рүү очиж, сайн мэдээг номлох хүмүүс тусгай дүрэм хэрэглэдэг. Номлолын үйлчлэлийнхээ хугацаанд номлогчид бизнесийн үйл ажиллагаа буюу дэлхийн зүйлсийн ашиг сонирхолд санаа тавих ёсгүй. Сүнсний бус ажил хэргийг эрхлэн гүйцэтгэдэг хүмүүстэй үргэлж уулзаж учрах үүргээс тэд чөлөөтэй байх ёстой. Тэдний бүх анхаарал, бүх хүч чадал, авьяас чадвар тохинууллын ажил дээр төвлөрөх ёстой. Харин өдөр тутмын хэрэгцээг нь анхаарч байх амлалтыг Эцэг тэдэнд өгсөн юм” гэж хэлжээ (Doctrinal New Testament Commentary, 243).

Сургаал ба Гэрээ 84:92—“Хөлөө цэвэрлэ”

Сургаал ба Гэрээ 24:15 (х. 36)-ын “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз.

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 84-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа В, мөн өөр гурван үйл ажиллагааг хий.

А Мелкизедек санваарын тухай мэдэх нь

Доорхтой адил схемийг тэмдэглэлийн дэвтэртээ хий. Нэгдэх багананд, Мелкизедек санваарын тухай Сургаал ба Гэрээ 84:14–25-аас мэдсэн зүйлүүдээ жагсаан бич. Хоёрдахь багананд, эдгээр шүлгүүдээс сурч мэдсэн зүйлүүдийг анхааралтай авч үзэх үед гарсан асуултуудыг бич. Асуултуудаа эцэг эх, семинарын багш эсвэл Сүмийн аль нэг удирдагчтай ярилцаж, дараа нь Сургаал ба Гэрээ 84:14–25 болон Мелкизедек санваарыг илүү сайн ойлгоход чинь тусалсан юуг мэдсэнээ бич.

Мелкизедек санваар		
Сургаал ба Гэрээ 84:14–25-аас би юу мэдэж авав	Миний асуултууд	Үүнийг бусадтай ярилцсаны дараа би юу мэдэв

Б Аароны санваарын тухай чухал санаанууд

Сургаал ба Гэрээ 84:26–30 Аароны санваарын тухай юу өгүүлж байгааг анхааралтай унш. Эдгээр шүлгүүдээс, Аароны санваарын үүрэг, үйл ажиллагаа, зорилгыг ойлгоход чухал гэж өөрийн бодсон дөрвөн үг буюу санааг сонго. Эдгээр үгс, санаануудыг тэмдэглэлийн дэвтэртээ бичиж, ач холбогдлынх нь талаар товч тайлбар бич. Жишээ нь, эдгээр санаануудад илүү их анхаарал тавих нь эдүгээ Аароны санваар эзэмшиж байгаа хүмүүст хэрхэн тусалж болох вэ?

В Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 84:33–39

Сургаал ба Гэрээ 84:33–48-ыг “санваарын тангараг ба гэрээ” гэж нэрлэх нь нийтлэг тохиолддог. Тангараг гэдэг бол тухайн хүний үгийн баттайг нотолсон албан ёсны тунхаглал буюу амлалт юм. Гэрээ бол хоёр талын хоорондох ариун тохиролцоо мөн. “Санваарын тангараг ба гэрээ” бол эдгээр шүлгүүдэд Их Эзэний тодорхойлсон нөхцөлийг хангасан хүмүүст ирэх амлагдсан адислалуудын баталгаа юм. Өөрөөр хэлбэл, хэрэв бид гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх юм бол эдгээр бүх адислалууд биднийх болох андгай тангараг, гэрээг Бурхан хийдэг. Энэ тохиолдолд адислалуудыг хүлээн авах нөхцөл нь санваар болон санваарын ёслолууд дээр төвлөрдөг билээ.

1. Их Эзэн санваар эзэмшигчдээс юу хүсдэгийг мөн тэдэнд Түүний амласан адислалуудыг харуулах жижигхэн схемийг Сургаал ба Гэрээ 84:33–34-өөс уншсан зүйлээсээ хий.
2. Сургаал ба Гэрээ 84:33-ын “Судруудыг ойлгох нь” хэсэг дэх Ерөнхийлөгч Бенсон, Ахлагч Максвелл нарын үгсийг унш. Тэгээд дараах судруудыг уншиж, эдгээр судрууд дуудлага эрхэмлэн биелүүлэх талаар юу зааж байгааг тайлбарла: Матай 20:26; Иаков 1:19; Хиламан 10:4; Моронай 9:6; Сургаал ба Гэрээ 42:12–14; 58:27–28; 107:99–100. (Та нар эшлэлүүдийн заримыг нь судрууд дээрээ Сургаал ба Гэрээ 84:33-ын дэргэд бичихийг хүсч болно.)
3. Их Эзэн юу хүсч, юу амласан тухай Сургаал ба Гэрээ 84:35–38 дахь санаануудыг харуулсан өөр нэг схем хий.

Г Харанхуйн эсрэг тал нь гэрэл

Ямар ч гэрэлгүйгээр, түнэр харанхуйд нэг газраас нөгөөд очих нь хэчнээн хэцүүг бод. Бүдэгхэн гэрэлд өнгөнүүдийг ялгах нь хэчнээн хэцүүг бас анхаар. Хэрэв бид энэ амьдралд сайн шийдвэр гаргах чадвартай байхыг хүсдэг бол, Тэнгэрлэг Эцэгтэй хамт амьдрахаар эргэж очихыг хүсдэг бол, амьдралд маань Сүнсний хурц гэрэл бидэнд хэрэгтэй.

1. Сүнсний гэрлийн тухай Сургаал ба Гэрээ 84:43–47 юу заадаг вэ?
2. Амьдралдаа энэхүү хурц гэрлийг хэрхэн нэмэгдүүлж болох талаар Сургаал ба Гэрээ 50:24, 93:28-аас бид юу мэдэв?
3. Сургаал ба Гэрээ 84:49–57-д өгүүлснээр юу биднийг илүү их харанхуйд байхад хүргэдэг вэ? (мөн Алма 12:9–11-ийг үз).
4. Сургаал ба Гэрээ 84:43–57 дахь зарчмууд, санаануудыг заахыг чамаас хүсчээ гэж бод. Эдгээр санаануудаас нэгийг эсвэл илүү олныг дүрслэхэд амьдралынхаа ямар жишээг чиг ашиглах вэ?

Номлогчдыг урамшуулан дэмжих нь

Номлогчдын бүлгийг урамшуулан дэмжихэд туслахын тулд ашиглаж болох дөрвөн хэсгийг Сургаал ба Гэрээ 84:60–102-оос сонго. Хэсэг бүрийн талаар юу хэлэхээ, яагаад чи үүнийг сонгосноо тайлбарла.

Е Сургалт явуул

Сургаал ба Гэрээ 84:107–11-ээс мэдсэн зүйлээ ашиглан багш нарын чуулгын шинэ гишүүнийг сургахад зааж болох зүйлүүдийг бич.



Сургаал ба Гэрээ 85

Юмсыг өөрийнхөө эсвэл Их Эзэний аргаар хийх нь

Сүмд бидэнд ямар нэг ажил үүргийг өгөх үед, уг ажил үүргийг хэрхэн гүйцэтгэхийг тогтоох хариуцлагыг өгөх нь олонтаа байдаг (С ба Г 58:26–29-ийг үз). Зарим үед, ажил үүргийг тусгай зааврын дагуу хэрхэн гүйцэтгэхийг биднээс асуудаг. Эдгээр заавруудыг баримтлах нь хэр зэрэг чухал вэ?

Миссури дэх Гэгээнтнүүдэд өвийг нь (амьдрахад шаардлагатай өмч хөрөнгө болон бусад нөөц) бишоп Эдвард Партриж Их Эзэний хүссэн арга замаар өгөөгүйг Бошиглогч Иосеф Смит мэдсэн ажээ. Бишоп энэ ажлыг өөрийнхөө арга замаар хийсэн байна. Бишоп Партриж бол алдаа завхрал гаргасан цорын ганц хүн байсангүй. Нэлээд олон Гэгээнтнүүд Миссурид цугласан боловч тэр үед Сионд цугласан хүмүүсээс шаардагдана гэж Их Эзэний хэлсэн өргөлийн хуулиар амьдрахыг тэд хүсэхгүй байв. Сургаал ба Гэрээ 85-р хэсэг бол юмсыг зөв болгож залруулахын тулд Миссурид байсан Виллям В.Фелпст Бошиглогч Иосефын бичсэн захидлын нэг хэсэг юм. Үүнийг уншихдаа, зөвхөн энд өгүүлсэн зүйлийг төдийгүй, өгүүлсэн өнгө аясыг нь анхаар. Юу хийхийг Их Эзэн тэднээс хүсч байгаа талаар тодорхой зөвлөгөө өгсөөр байтал, юмсыг өөрийнхөөрөө хийхийг хүсдэг хүмүүсийн тухайд Их Эзэнд ямар бодол төрсөн талаар өгүүлэх өнгө аяс нь бидэнд ихийг хэлдэг.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 85

Урвагчид (ш. 2)—Сүмийг орхин явдаг, сайн мэдээний тухай гэрчлэлээ үгүйсгэдэг, ах нарын эсрэг тэмцдэг хүмүүс

Очирт таяг (ш. 7)—Эрх мэдлийн саваа (энэ тохиолдолд бэлгэдлийн утгатай)

Сургаал ба Гэрээ 85:5, 7, 11—“Хүчтэй болон хүчирхэг нэгэн”

Хэрэв бишоп Партриж наманчлаагүй бол, мөн юмсыг Их Эзэний арга замаар хийгээгүй бол биелүүлэх ёстой байсан үүргээ гүйцэтгэхийн тулд Их Эзэн “хүчтэй болон хүчирхэг нэгнийг” илгээх байсныг Сургаал ба Гэрээ 85:7-д тэмдэглэдэг. Бишоп Партриж наманчилсан юм, тиймээс түүнийг орлуулахаар дуудах “хүчтэй болон хүчирхэг нэгнийг” хэрэгцээ гараагүй ажээ.

Сургаал ба Гэрээ 85:7—“Бурханы хуулийн ном”

Бурханы хуулийн ном нь “аравны нэгийн хуульд шууд хамаатай гэж Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит хэлжээ. . . .



“Зарим хүмүүс нэр нь цэдэгт орох уу, үгүй юу гэдэг талаар нэг их санаа тавьдаггүй. Харин энэ нь үр дагаврыг нь үл тоомсорлосноос болдог. Хэрэв нэрс нь цэдэгт эс орох аваас . . . тэд Бурханы өргөөний ёслолуудаас таслагдах болно” (In Conference Report, 1899 оны 10-р сар, 42). Аравны нэгийн тайлан хэлэлцүүлэгт оролцох нь нэр чинь аравны нэгийн бүртгэлд цэдэглэгдэх нэг арга зам мөн.”

Сургаал ба Гэрээ 85:8—“Авдрыг тогтвортой болгох гэж юу гэсэн үг вэ”?

“Авдрыг тогтвортой болгох” гэсэн нийлэмж үгэн дэх авдар нь Израилын ариун сүм Табернеклд, Ариунаас Ариун газарт орших гэрээний авдар юм. Авдар нь дээрээ суудалтай байсан бөгөөд израилчуудын дунд Бурханы оршдог газрыг төлөөлдөг байжээ. 2 Самуел 6:6–7-д (мөн Пастирын Дээд 13:9–12) гэрээний авдрыг авч явсан тэрэгний хажууд Узза гэдэг нэртэй хүн явж байсан тухай нэг шастир байдаг. Тэрэг бартаан дээгүүр гарахад авдар унах шахжээ. Узза авдрыг унагахгүйн тулд түүнд хүртэл, үхэхийн унасан гэдэг. “Авдрыг тогтвортой болгох” гэсэн нийлэмж үг нь Их Эзэн болон Түүний үйлчлэгчдэд итгэх итгэл дутмагаас өөрсдийн мэргэн ухаанд тулгуурлан юмсыг хийдэг хүмүүст хамаатай юм.

Сургаал ба Гэрээ 85:9—Дурсамжийн Ном гэж юу вэ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Брус Р.МкКонки тайлбарласан нь:

“Адам итгэлтэй үр удмынхаа шастирыг бичгээр хөтөлдөг байв. Тэрээр уг шастирт тэдний итгэл, ажил үйлс, зөв шударга зан төлөв, нэгэн үзүүрт шийдвэр төгс байдал, тэдэнд өгөгдсөн илчлэлт болон үзэгдлүүд, илчлэгдсэн авралын төлөвлөгөөнд тэд хэр зэрэг үнэнч байсныг бичдэг байв. Зохистой өвөг дээдсээ хүндлэн, тэдэнд илчлэгдсэн агуу үнэнүүдийг сонсож дагахын ач холбогдлыг Адам өндөрөөр үнэлэн, уг цэдгийг дурсамжийн ном гэж нэрлэдэг байжээ. ‘Бурханы хуруугаар өгөгдсөн загварын дагуу’ (Мосе 6:4–6, 46) эл номыг бэлтгэсэн ажээ.

“Бүх эрин зуунд гэгээнтнүүд үүнтэй адил цэдгүүдийг хөтөлсөөр ирсэн юм. (Малахи 3:16–17; 3 Нифай. 24:15–16-г үз.) Бидний одоогийн судруудаас олныг нь, дурсамжийн номыг хөтөлсөн Адамын загварыг баримталсан бошиглогчид анх бичсэн учраас үеэс үед бидэнд дамжуулан өгсөөр ирсэн ажээ. Сүм өнөөдөр ийм цэдгүүдийг хөтөлдөг бөгөөд хувийнхаа болон гэр бүлийнхээ дурсамжийн номыг хөтөлхийг гишүүдээсээ шаргуу хүсдэг.” (Mormon Doctrine, 100).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 85-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Ямар өөрчлөлт гаргах вэ?

1. Сүмийн цэдгүүдийн ач холбогдлын талаар Сургаал ба Гэрээ 85-р хэсгээс та нар юу мэдэв? (С ба Г 85:7-гийн “Судруудыг ойлгох нь” хэсэг, мөн шүлэг 12-т Их Эзэний өгсөн судрын эшлэлийг үз).
2. Сүм дэх нарийн бичгийн дарга эсвэл бичиг хэргийн ажилтны дуудлагаа хэрэгжүүлэхэд чинь энэ илчлэлтээс өөрийн чинь сурч мэдсэн зүйл хэрхэн нөлөөлж болох вэ?

Б Жишээ гарга

1. Сургаал ба Гэрээ 85 болон Сургаал ба Гэрээ 85:8-ын “Судруудыг ойлгох нь” хэсгийг уншсаны дараа өөрийн чинь насны хүн өнөө үед “авдрыг тогтвортой болгох” талаар хэрхэн уруу татагдаж болох тухай товч жишээ бич.
2. Сургаал ба Гэрээ 85-р хэсэгт болон Хуучин Гэрээнээс авдрыг тогтвортой байлгах санааны талаар уншсанаасаа ойлгосон зүйл дээр тулгуурлан, “авдрыг тогтворжуулагч” байж мэдэх хүнд чи ямар зөвлөгөө өгөх вэ?



Сайн муу хоёр зэрэгцэн оршихыг Их Эзэн яагаад зөвшөөрдөг вэ? Хэрэв Тэрээр дэлхийгээс бүх муу муухайг үгүй хийвэл юу болох вэ? Сургаал ба Гэрээ 86-р хэсэгт улаан буудай ба зэрлэг өвсний тухай сургаалт зүйрлэлийнхээ утгыг Их Эзэн тайлж (Матай 13:24–30, 36–43-ыг үз), эдгээр асуултуудын хариуг ойлгох ойлголтуудаар хангажээ.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 86

Сургаалт зүйрлэл (ш. 1)—
Сургамж буюу ёс суртахуу-
ныг заадаг товч түүх

Зэрлэг өвснүүд (шүлэг 3,
6–7)—Хогийн ургамалууд

Өв залгамжлагчид (ш. 9)—
Бэлэг буюу адислалыг
эрхийн дагуу хүлээн аваг-
чид

Сургаал ба Гэрээ 86:5—Тэнгэр элчүүд хадахад бэлэн байна

Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф 1894 онд ариун сүмийн ажилчдын бүлэгт хандаж хэлсэн үгэндээ: “Устгалын элчүүд улаан буудайг зэрлэг өвсний хамт хадаж авахгүйн тулд Бурхан тэднийг олон жилийн турш саатуулан барьж байгаа билээ. Гэвч тэдгээр элчүүд тэнгэрийн хаалгыг орхиж, энэ хүмүүс болоод энэ үндэстний дээр зогсож, шүүлт юүлэгдэхийг хүлээн, дэлхий дээгүүр эргэлдэн байгаа билээ. Мөн яг энэ өдрөөс шүүлт юүлэгдэх болно. Гай зовлон, хүндрэл бэрхшээл дэлхий дээр өсөн нэмэгдэнэ. Эдгээр зүйлүүд үүдэн бий болсон шалтгаантай юм. Үүнийг санаж, эдгээр асуудлуудыг тунгаан бод. Хэрэв та нар үүргээ биелүүлэх юм бол би ч мөн үүргээ биелүүлэх болно. Ингэснээр бидэнд хамгаалалт бий болно, улмаар зовлон зүдгүүрээр дамжин амар амгалан, аюулгүй байдалд хүрнэ” гэж хэлжээ (Сюза Янг Гейтс, “The Temple Workers’ Excursion,” *The Young Woman’s Journal*, 1894 оны 8-р сар, 512–513-аас иш татжээ).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 86-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Сургаалт зүйрлэлийг тайлбарла


1. Матай 13:24–30, 36–43-ыг унш. Сургаал ба Гэрээ 86-р хэсгээс улаан буудай ба зэрлэг өвсний тухай сургаалт зүйрлэлийн талаар бид ямар нэмэлт ойлголттой болдог вэ?
2. Энэ сургаалт зүйрлэл Шинэ Гэрээний үеийнхээс их буюу бага аль нэг хэмжээгээр манай өнөө үед холбогдоно гэж чи бодож байна уу? Яагаад?

Б Захиасыг хэрэглэ

1. Өөртөө тохиолдсон эсвэл ямар ч залуу хүнд тохиолдож болох улаан буудай ба зэрлэг өвсний тухай сургаалт зүйрлэлийн утгыг санагдуулах нэг туршлагын тухай бичнэ үү.
2. Сургаал ба Гэрээ 86:8–11-ийн захиас улаан буудай ба зэрлэг өвсний тухай сургаалт зүйрлэлтэй хэрхэн холбогдох вэ?



1860 онд эхэлсэн Америкийн Иргэний Дайны тухай бошиглол Сургаал ба Гэрээ 87-р хэсэгт байдаг. Эл бошиглол дайн эхлэхээс бараг гучин жилийн өмнө цэдэглэгдсэнийг анхаарах юм бол илчлэлтийн яг оносон тодорхой байдал нь гайхалтай юм. Гэвч уг илчлэлт Иргэний дайнаас цаашир гарч, бүх дэлхийг хамарсан дайны тухай өгүүлдэг. Илчлэлт хожмын үеийн хүмүүсийн сэтгэлийг түгшүүлсэн ч, чухал захиасыг агуулдаг.



Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 87

Сабаотын Их Эзэн (ш. 7)— Түмний Их Эзэн; сабаот гэдэг энэ еврей үг “олон түмэн” буюу бүх хүмүүс гэсэн утгатай бөгөөд Их Эзэн бол бүхний дээгүүр

хүчтэй Бүтээгч мөн гэсэн утгыг олонтаа заадаг (мөн С ба Г 95:7-г үз).

Өс авагдах (ш. 7)— Үйлдэгдсэн буруу зүйлүүдийг зөв болгох

Сургаал ба Гэрээ 87:1—Өмнөд Каролины бослого

1832 онд Нэгдсэн Улсад, Өмнөд Каролин муж Европоос хүлээн авдаг бараанд онцгой татвар төлөхөөс татгалзав. Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч Анджо Жаксон Өмнөд Каролины эсэргүүцлийг дарахын тулд холбооны цэргийн ангиудаас тусламж хүсэн уриалга гаргаж хариулжээ. Муж буулт хийж, дайнаас зайлсхийсэн аж. Гэвч Бошиглогч Иосеф Смит бошиглолоо тохиох болно гэдэг дээр зогсоор байлаа (С ба Г 130:12–13-ыг үз).

Иосеф Смит энэ бошиглалыг анх хийснээс хойш хорин найм орчим жилийн дараа Өмнөд Каролин муж Нэгдсэн Улсын эсрэг дахин бослого гаргасан юм. Хожуу болсон энэ хэрэг явдалд Нэгдсэн Улсын өмнөд бусад мужууд нэгдэж, ингээд яг бошиглосончлон, Иргэний Дайн дэгдсэн билээ.

Сургаал ба Гэрээ 87:3—Өмнөд мужууд, Их Британи ба дэлхийн дайн

Сургаал ба Гэрээ 87:3 Америкийн Иргэний дайнаас цааш гарч илүү их зүйлийг өгүүлдэг. Өмнөд мужууд Америкийн Иргэний дайны үед өөрсдөдөө туслахад Их Британи болон бусад үндэстнүүдийг уриалан дуудсан билээ. Тийнхүү энэ шүлэгт бошиглосончлон хожим нь Их Британи, бусад үндэстнүүд дэлхий даяар ямар нэг байдлаар татагдан орсон дэлхийн хоёр удаагийн дайнд *дайснуудынхаа* эсрэг тэмцэхэд нь туслахад бусад үндэстнүүдийг уриалан дуудсан юм.

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 87-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Жишээ гарга

Сургаал ба Гэрээ 87-р хэсэг дэх бошиглолуудаас наад тал нь хоёрынх нь биелэлтийн жишээг тэмдэглэлийн дэвтэртээ бич.

Б Бусад хүмүүс дэмждэг саналаа хэл

Өнөө үеийн хүмүүсийн хувьд Сургаал ба Гэрээ 87-р хэсэг дэх хамгийн чухал захиас аль нь гэж та нар бодож байна? Яагаад?



Бараг л дааж давигүй мэт санагддаг асуудал, шийдвэртэй бид тулгарсан үед амьдрал маш хүнд байж болно. Ийм үед бид хүнд сорилтуудыг мөнхийн хэтийн төлвөөс авч үзэхэд Тэнгэрлэг Эцэг биднийг олонтаа урьдаг. Сургаал ба Гэрээ 88-р хэсэг дэх илчлэлт ийм хэтийн төлвөөр хангадаг. Энэ нь ердийн зүйлээс илүү агуу, Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын агуу төлөвлөгөөний голт зүрхэн дэх алдар суут үнэн бодит байдлын тухай бодоход бидэнд тусалдаг. Та нарыг гүнзгийгээр эргэцүүлэн бодоход хүргэх олон зүйл энэ илчлэлтэд байдаг. Амьдралын бэрхшээлийг мөнхийн хэтийн төлөвт тавьж үзэх боломж болгон судалгаагаа ашигла. Сургаал ба Гэрээ 87-р хэсгийн захиасыг тунгаан бодсоны дараа энэ нь эхэн үеийн Гэгээнтнүүдэд баяр баяслын тайтгарал болсон байх ёстой. Энэ нь та нарын хувьд ч мөн ийм байж болно.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 88

Энэ нь (шүлэг 18–20, 26)— Дэлхий

Бүтээлтийн хэмжүүр (шүлэг 19, 25)—Бүтээгдсэн зүйлийн зорилго

Хуулийг битүүмжлэн, гэрчлэлийг лацдаж (ш. 84)—Хүмүүс өөрсдийн үйлдлийн төлөө шалтаг зааж үлдэхгүйн тулд сайн мэдээг сонсох боломж хүн бүрд байх болно гэдгийг бэлгэдлээр өгүүлсэн хэлбэр

Жигшүүрт хэргийн эзгүйрэл (ш. 85)— Бурханыг гомдоодог байдлаар амьдрахаа үргэлжлүүлдэг хүмүүс дээр ирэх устгал
Зэвүүцэл (ш. 88)—Шүүлт буюу буруу хэрэг явдлын үр дагавар

Жигшүүрт хэргүүд (ш. 94)—Нүглүүд; Бурханыг гомдоодог бодол санаа, үйлдлүүд
Холбоо (ш. 125)—Гэрээ, амлалт

Сургаал ба Гэрээ 88:3—Өөр нэгэн Тайтгаруулагч
 Бошиглогч Иосеф Смит сургасан нь:



“Хоёр янзын Тайтгаруулагч байдаг. Нэг нь, Пентекостын өдөр өгөгдсөнтэй яг ижил, бүх Гэгээнтнүүд итгэл, наманчлал, баптисмын дараа хүлээн авдаг Ариун Сүнс. . . .

“... Хүн Христэд итгэх итгэлтэй болж, нүглээ наманчлан, нүглээсээ ангижрахын төлөө баптисм хүртэж, анхны Тайтгаруулагч болох

Ариун Сүнсийг (гар тавилтаар) хүлээн авсны дараа Бурханы өмнө өөрийгөө цаашид даруусган, зөв шударга ёсны төлөө эгээрэн тэмүүлж, Бурханы үг бүрээр амьдрах юм бол Хүү минь, чи өргөмжлөгдөнө гэж Их Эзэн түүнд удалгүй хэлнэ. Их Эзэн уг хүнийг бүх талаар нотолж, тэрээр аюул занал нүүрлэлээ ч, Түүнд үйлчлэхэд шийдвэр төгс байна гэдгийг мэдсэн үед, тэр хүн өөрийнх нь дуудлага, сонголт нь баттай болсныг мэднэ. Ингээд нөгөө Тайтгаруулагчийг хүлээн авах нь түүний хувьд онцгой боломж байх болно. . . .

“Харин энэхүү Тайтгаруулагч гэж юу вэ? Энэ бол Их Эзэн Есүс Христээс өөр юу ч, эсвэл хэн ч биш. Бас энэ бол бүх асуудлын нийлбэр, гол утга учир нь юм. Аливаа хүн энэхүү сүүлчийн Тайтгаруулагчийг олж авахад, Есүс Христ хүмүүн биеэрээ түүн дээрээ ирнэ, эсвэл түүн дээр үе үе хүрч ирэх болно” (*Teachings of the Prophet Joseph Smith*, 149–451).

Сургаал ба Гэрээ 88:6–13—Христийн Гэрэл
 Судруудын Удирдамж дахь “Христийн Гэрэл” (х.54) тайлбар, Моронай 7:16, 18–19-ийг үз.

Сургаал ба Гэрээ 88:74–86—Сүмийн Ахлагчид цэвэр ариун байх ёстой



Сайн мэдээг номлохоор явдаг хүмүүс цэвэр ариун байх ёстойг Их Эзэн Сургаал ба Гэрээ 88-р хэсэгт нэг биш удаа онцлон тэмдэглэсэн байдаг. Номлох дуудлага хүлээж байгаа хүмүүс улс үндэстнүүд, соёл заншлын тухай, мөн сайн мэдээний сургаалуудыг (шүлэг 77–80-ыг үз) судалснаар,

бас “гар, хөлөө цэвэршүүлж” (ш. 74), нүгэлд “орооцолдохоос” (ш. 86-г үз) зайлсхийснээр бэлтгэлээ хангадаг. “Хэрэв Ахлагч нар цэвэр ариун гар, цэвэр ариун зүрх сэтгэлтэйгээр явж чадахгүй бол тэд гэртээ үлдсэн нь дээр. Та нар Миссури мөрөн дээр, Миссиппид, Огайод, эсвэл Атлантад хүрээд ирэх юм бол өөрсдийгөө цэвэршүүлнэ гэж бүү бод. Харин эндээс цэвэр ариун гар, цэвэр ариун зүрх сэтгэлтэйгээр эхэл. Толгойнхоо оройгоос холийнхөө улыг хүртэл цэвэр ариун бай, бүх цаг үед ийм байдлаар амьдар. Ийм байдлаар яв, ийм байдлаар хөдөлмөрлө, тэгээд цэвэрхэн цагаан цаас лугаа адил эргэж ир. Энэ бол явах зам чинь; хэрэв та нар ингэхгүй юм бол зүрх чинь шархиран шаналах болно” гэж Ерөнхийлөгч Бригам Янг зөвлөжээ. (*Discourses of Brigham Young*, эмхтгэсэн, Жон Видцөү [1941], 323)

Далын Ахлагч Л.Алдин Портер цааш нь тайлбарласан нь: “Санваартны удирдагчид аа, шийдвэрлэгдээгүй зөрчилтэйгөөр номлолын талбарт очих боломжийг залуу номлогчдод олгохгүй байхад анхаарцгаа. Энэ бол чухамдаа хуяг дуулга, илд бамбайгүйгээр тулалдаанд орохтой агаар нэг юм. Уруу таталтын галыг эсэргүүцэх хүчийг хөгжүүлэхэд цаг хугацаа шаардлагатайг санацгаа. Жинхэнэ үнэн гэмшлээр зүрх сэтгэлд ямагт ирдэг аятай сайхан тайтгарлыг хүлээн авахад цаг хугацаа шаардагддаг. Залуу номлогчдод хангалттай цаг хугацаа олго.” (*In Conference Report*, 1992 оны 4-р сар, 67; *Ensign*, 1992 оны 5-р сар, 46).

Сургаал ба Гэрээ 88:127—Бошиглогчдын Сургууль
 Сургаал ба Гэрээ 88-р хэсэгт өгсөн зөвлөгөөг баримтлан Бошиглогчдын Сургуулийг 1833 оны эхээр зохион байгуулжээ. Энэ сургуулийн зорилго нь санваар эзэмшигч эрэгтэйчүүдийг сайн мэдээг номлоход бэлтгэх, Сүмийн ажил хэргийг удирдан зохион байгуулах, нийгэмдээ хувь нэмэр оруулах явдал байжээ. Хожим нь, Көртландын Ариун сүм баригдахад энэ сургууль ариун сүм дотор байв. Бошиглогчдын сургууль эхэн үеийн анхдагч нарын үеийг дуустал Ютагийн нутагт оршиж байв. Эдгээр анхны сургуулиуд уламжлалт боловсрол-сүнслэг болон сүнслэг бус боловсролыг шашны академи, их сургууль, семинар, институтийн зохион байгуулалтаар үндэслэн бий болгожээ. Их Эзэн Өөрийн хүмүүсийг боловсролтой байхыг хүсдэг нь мэдээж юм.

Сургаал ба Гэрээ 88:138–141—“Хөл угаах ёслол”
 Есүс повдлогдохынхоо өмнөхөн иудейчүүдийн хуулиар ёслол болж хэвшсэн нэг зан үйлийг гүйцэтгэхийн тулд Төлөөлөгчдийнхөө хөлийг угаасан билээ (ИСО, Иохан 13:10-ыг үз). Бошиглогчдын Сургуульд оролцдог Сүмийн удирдагчдад зориулж энэ ёслолыг сэргээснийг Сургаал ба Гэрээ 88:138–141-д дурддаг. Гэгээнтнүүд Көртландын Ариун сүмийг барьж байх үед, хөл угаах энэ ёслол ариун сүмд болдог байх ёстой гэж Бошиглогч Иосеф Смит хэлсэн аж (*History of the Church*, 2:307–10-ыг үз). Энэ ёслол ариун сүмд хүлээн авагддаг иж бүрэн агуу ёслолуудын нэг хэсэг болсноор энэ амьдралд хийхээр дуудагдсан ажлаа хийхэд энэ ёслолыг анх удаа гүйцэтгэсэн нь Сүмийн эхэн үеийн удирдагчдыг ажил хөдөлмөрт нь бэлтгэхэд тусалсан шиг тийм хүчийг бидэнд өгдөг билээ.



Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 88-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас тавыг (А-Е) хий.

А Чиний санаа бодол юу вэ?

Сургаал ба Гэрээ 88:6–13 нь Есүс Христ болон амьд бүхэнд хамаарах Түүний ач холбогдлын тухай эргэцүүлэн бодоход биднийг урьдаг. Энэ хэсгийг уншиж Аврагчийн тухай болон өөрийн чинь амьдралд ажиглагдсан, бас ерөнхийдөө ажиглагддаггүй Түүний нөлөөний тухай зарим санаа бодлынхоо тухай бичнэ үү. Ирээдүйн амьдралд чинь энэ хэсэг нөлөөлж болох зарим арга замын тухай санаа бодлоо оруул. Улам олон хүмүүс энэ хэсгийн заадаг зүйлүүдийг мэдэж, санаж явах юм бол юу өөр байхсан бол?

Б Сургаалыг тайлбарла

Сургаал ба Гэрээ 88:17–39-өөс сурч мэдсэн зүйлээ ашиглан, селестиел хаант улсад очихыг хүссэн хүн бүрд Бурхан яагаад зүгээр л зөвшөөрөл өгчидөггүйг мэдэхийг хүссэн хэн нэгэнд чадах чинээгээрээ бүрэн дүүрэн тайлбар өг.

В Үйл ажиллагаа ба үүний үр дагаврууд

1. Сургаал ба Гэрээ 88:62–69-д, бид Түүнд очиж болох арга замуудын тухай Их Эзэн өгүүлжээ. Бидний хийх ёстой наад тал нь найман зүйлийн тухай Тэр өгүүлсэн байдаг. Хэрэв бид Түүний зөвлөсөн зүйлүүдийг хийх юм бол, эдгээр найман зүйл тус бүрийг амлагдсан адислал дагалдаг. Тэмдэглэлийн дэвтэртээ хоёр багана зурж, “Хэрэв”, “тэгвэл” гэж гарчигла. “Хэрэв” багананд, хий гэж Их Эзэн бидэнд зөвлөсөн зүйлүүдийг жагсаан бич. “Тэгвэл” багананд, үйл ажиллагаа бүрийн үр дагаврыг бич.
2. Биднийг хий гэж Их Эзэний зөвлөсөн зүйлүүдээс хоёрыг сонгож, Түүний зөвлөгөөг дуулгавартай дагахын тулд хүн юу хийж болох тухай бич.

Г Номлогчийн бэлтгэлийн төлөвлөгөө

1. Сургаал ба Гэрээ 88:70–86-г нэгтгэн дүгнэж, сайн мэдээг дэлхийд заахад нь тэднийг бэлтгэсэн юуг Их Эзэн Иосеф Смитийн үеийн Сүмийн удирдагчдад ярьсныг жагсаан бич.
2. Цэвэр ариун гар, цэвэр ариун зүрх сэтгэлтэй байна гэдэг нь юу гэсэн утгатай гэж та нар боддог вэ?

3. Сүмийн удирдагчид болон гишүүд бүх хүмүүсийг сэрэмжлүүлэх ёстой учир шалтгаан болдог юуг шүлэг 81–86 заадаг вэ? (Езекиел 33:1–9-ийг үз).

Д Сургууль төлөвлө

Хожмын Үеийн залуу Гэгээнтнүүдийг амьдралд бэлтгэхийн тулд, ялангуяа Их Эзэн тэднээр хийлгэхийг хүсдэг ажилд зориулан шинэ сургууль нээхийг чамаас хүсчээ гэж бод. Сургаал ба Гэрээ 88:77–80-аас уншсан зүйл дээрээ тулгуурлавал, энэ сургуульд чи оюутнуудаараа ямар сэдвүүдийг судлуулахыг хүсэх вэ?

Е Үйл явдлуудыг жагсаан бич

Сургаал ба Гэрээ 88:87–116 дахь ирээдүйд тохиох үйл явдлуудыг жагсаан бич. Аврагчийн Хоёр дахь Ирэлтийн өмнө, Түүний Хоёр дахь Ирэлтээр, Мянган Жилийн эцэст гэсэн цаг хугацааны ерөнхий гурван үеэр тохиох үйл явдал бүрийг жагсаан бич.

Ё Судруудыг хэрэглэ

Сургаал ба Гэрээ 88:119 ариун сүмийн тухай өгүүлдэг ч, эл хэсэг бас л ариун газар байх ёстой бидний гэр орны тухай өгүүлдэг. Хэрэв хүмүүс гэр орноо “Бурханы өргөө” шиг байлгахыг хүсдэг бол өөрөөр хэлбэл, гэр орноо Түүний Сүнс оршдог газар, гэр бүлийн бүх гишүүдэд бэхжүүлэгч, хамгаалагч нөлөө үзүүлдэг газар байлгахыг хүсдэг байх юм бол энэ шүлэгт Их Эзэний өгүүлсэн зарчим бүрийг хэрэгжүүлэхийн тулд тухайн гэр бүл юу хийж чадна гэж боддоггоо тайлбарла.

Ж Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 88:123–124

1. Түүний зөвлөгөөг “Хийх зүйлүүд”, “Хийх ёсгүй зүйлүүд” гэсэн хоёр жагсаалтад зохион байгуулж, Сургаал ба Гэрээ 88:123–124-т Их Эзэн биднээс хийхийг хүссэн зүйлүүдийг жагсаан бич.
2. Жагсаалтаасаа хоёр зарлигийг сонгож, Их Эзэн яагаад биднээс юм бүрийг хийхийг, эсвэл яагаад хийхгүй байхыг хүсдэг гэж боддоггоо тайлбарла. Хувийн туршлагаасаа эсвэл судруудаас жишээ тат.



Сургаал ба Гэрээ 89 Мэргэн Ухааны Үг

1833 онд Бошиглогч Иосеф Смит гэр бүлийнхээ хамт Огайогийн Көртланд дахь Ньюэл К.Витнейн дэлгүүрт амьдарч байлаа (“Турамсан судрын төгсгөл дэх Сүмийн Түүхийн он дараалал, Газрын зургууд ба гэрэл зургуудын” 7-р гэрэл зургийг үз). Витнейн дэлгүүрийн дээд давхрын нэг өрөөнд Бошиглогчдын анхны сургуулийг

Бошиглогч зохион байгуулжээ (С ба Г 88-р хэсэгт зарлиг болгосноор). Ерөнхийлөгч Бригам Янг, тэр ч байтугай, тэр үед бошиглогчдын сургуулийн гишүүн байгаагүй ч гэсэн, заавар авахаар цугласан хүмүүсийн тухай, Сургаал ба Гэрээ 89-р хэсэг дэх илчлэлт хэрхэн ирсэн тухай: “Тэд өглөөний цайны дараа энэ өрөөнд цуглаад, хийдэг байсан анхны зүйл нь гаансаа нэрж, тамхилах зуураа, хаант улсын агуу зүйлсийн тухай хүүрнэлдэн, өрөөгөөр нэг нулимж, гаансаа амнаасаа авангуут дахиад тамхиар дүүртэл нь чихдэг байлаа. Бошиглогч хичээл заахаар өрөөнд байн байн орж ирэхдээ тамхины өшиглөсөн утаан үүлэн дунд байдаг байв. Бохиртож заваан болсон шалыг цэвэрлэх гэж эхнэр нь үглэн гомдоллодог байснаас, Бошиглогч уг асуудлыг тунгаан бодоход хурч, Ахлагч нар тамхи татаж байгаа талаар Их Эзэнээс асуусан юм” (in Journal of Discourses, 12:158) хэмээн өгүүлсэн байна. Мэргэн Ухааны Үг гэж нэрлэгддэг эл илчлэлт Бошиглогч ийнхүү асуусны хариуд иржээ.

Энэхүү илчлэлт бол “амлалт бүхий зарчим” юм хэмээн Сургаал ба Гэрээ 89:3-т Их Эзэн хэлснийг ажигла. Энэ хэсгийг уншихдаа Их Эзэний амлалтуудад онцгой анхаарал тавь. Мэргэн Ухааны Үгэнд өгсөн зөвлөгөөг дэмжигч анагаах ухааны олон нотолгоо өнөөдөр бидэнд байдаг ч гэсэн, эл илчлэлт өгөгдсөн үед энэ тухай бага мэдэгдсэн байлаа. Амлагдсан сүнсний адислалуудыг тусгайд нь ажигла. Их Эзэний амласан сүнсний адислалуудыг нотлох оролдлогыг шинжлэх ухаан хийдэггүй ч гэсэн, адислалууд үнэн гэдгийг сая сая хүмүүс гэрчилж чадна. Энэ илчлэлт бол Бошиглогч Иосеф Смитийн бошиглогчийн дуудлагын өөр нэг нотолгоо юм.

Сургаал ба Гэрээ 89:9—“Халуун ундаанууд” гэж юу вэ?



Бошиглогч Иосеф Смитийн ах, Сүмийн патриарх, Туслах Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Хайрум Смит: “Халуун ундаанууд нь биенд, эсвээс гэдэс доторг зориулагдаагүй юм. Халуун ундаа гэдэг чинь юу юм бэ? Энэ чинь цай юу, кофе юу, эсвэл биш үү гэж гайхдаг олон хүн бий. Халуун ундаа гэдэг бол цай, кофе юм гэдгийг би хэлье” гэжээ (“Word of Wisdom,” Times and Seasons, 1842 оны зургадугаар сарын 1, 800).

Сургаал ба Гэрээ 89:19—Мэргэн ухаан хийгээд мэдлэгийн нуугдмал сан хөмрөгүүдийг олох нь Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Гүйцэтгэх Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Боид К.Пакер заасан нь:

“Таны бие бол оюун ухааны тань зэмсэг юм. Сэтгэл хөдлөлд тань Сүнс, бие хоёр нэгдэхэд хамгийн ойрхон байдаг. Сүнслэг байдлын хувьд сурч мэдсэн зүйл тань, та бие бялдартаа хэрхэн хандахаас ямар нэг хэмжээгээр хамааралтай байдаг. Чухам иймээс Мэргэн Ухааны Үг их ач холбогдолтой юм.

“Зуршил бий болгодог бодисууд цай, кофе, ликёр дарс, тамхи нь донтуулдаг бусад бодисуудын нэгэн адил сүнслэг харилцааны нарийн нандин мэдрэмжүүдэд саад болдог.

“Мэргэн Ухааны Үгийг бүү үл тоомсорло. Учир нь Мэргэн Ухааны Үг таны хувьд ‘мэдлэгийн агуу эрдэнэс, бүр үүнийг сахидаг хүмүүст амлагдсан нуугдмал эрдэнэс’ байж болно [С ба Г 89:19]. Бас сайн эрүүл мэнд бол өсөн нэмэгдсэн адислал мөн” (In Conference Report, 1994 оны 10-р сар, 78; Ensign, 1994 оны 11-р сар, 61).

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 89

Хүчтэй ундаа (шүлэг 5, 7)—Согтууруулах ундаа

“Судруудыг ойлгох нь” хэсгийг үз

Халуун ундаанууд (ш. 9)—Кофе, цай (С ба Г 89:9-ийн

Хүйс (ш. 18)—Дотор эрхтнүүдийн бэлгэдэл

Сургаал ба Гэрээ 89:2—“Зарлигаар буюу албадлагаар бус”

“Мэргэн Ухааны Үг тэр үед яагаад ‘зарлигаар буюу албадлагаар бус’ өгөгдсөний эргэлзээгүй шалтгаан нь, наанадаж л, хэрэв үүнийг зарлиг болгон өгсөн бол, эдгээр хортой зүйлүүдийг хэрэглэх талаар донтсон хүн бүрд зэмлэл хүлээлгэх байлаа. Иймээс Тэрээр нигүүлсэнгүй байж, хүмүүсийг хуулийн өмнө аваачихаас өмнө, хортой зүйлүүдийг даван туулах боломжийг тэдэнд олгосон ажээ. Хожим нь, Ерөнхийлөгч Бригам Янг, Мэргэн Ухааны Үг бол илчлэлт бөгөөд Их Эзэний зарлиг болохыг зарласан юм” хэмээн Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит тайлбарлажээ (In Conference Report, 1913 оны 10-р сар, 14). Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагах нь ариун сүмийн зөвшөөрлийн бичигтэй байх нэг шаардлага мөн.

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 89-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас гурвыг (А-Г) хий.

А Санааг тайлбарла

Мэргэн Ухааны Үг бол “бүх гэгээнтнүүдийн сул болон хамгийн сул доройнх нь хүч чадалд тохирсон юм” хэмээн Их Эзэн Сургаал ба Гэрээ 89:3-т хэлжээ. Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай сахих нь амьдралын бүх талд-бие бялдар, оюун ухаан, сэтгэл хөдлөл, нийгмийн болон сүнсний хувьд хүчирхэг болоход хүнд тусалж чадна.

Б Нотолгоо гарга

1. Сургаал ба Гэрээ 89:4-т, Мэргэн Ухааны Үгийг өгсөн нэг шалтгааныг Их Эзэн тайлбарлажээ. Энэ шүлэг юу гэсэн утгатайг бич.
2. Мэргэн Ухааны Үгийн энэ зорилгыг дэмжигч нотолгоог ол. Жишээ нь, зарлалын самбар, сэтгүүл, сонин, телевизийн зар сурталчилгаануудыг ажигла. Эдгээр зүйлүүдээс нэгийг эсвэл хоёрыг тэмдэглэлийн дэвтэртээ дүрсэл. Гол захиас нь юу вэ? Энэ зүйлүүд чамд юуг хэлэхгүй байна? Хүмүүс шүлэг 4 дэх бошиглолыг ямар арга замаар хэрэгжүүлдэг вэ?

3. Дараах асуултуудад товч хариулт өг:

- Мэргэн Ухааны Үгээр хориглогдсон бодисуудыг хэрэглэхэд зарим хүмүүс та нарыг яагаад дэмждэг вэ?
- Та нар яагаад Мэргэн Ухааны Үгийг дагах ёстой вэ?

В Жагсаалт хий



1. Сургаал ба Гэрээ 89:5–17-д Их Эзэн нэлээд хэдэн хортой бодис мөн нэлээд хэдэн ашигтай бодисыг нэрлэн заасан байдаг. Нэгийг нь “Хортой бодисууд”, нөгөөг нь “Ашигтай хүнснүүд” гэж гарчигласан хоёр жагсаалтыг тэмдэглэлийн дэвтэртээ хий. Бодис буюу хүнсний зүйл бүрийн дараа үүнийг ашиглах талаар Их Эзэн юу гэж хэлснийг тэмдэглэ.

2. Бид юу идэж уух ёстой эсвэл ёсгүйг Мэргэн Ухааны Үгэнд Их Эзэн бүгдийг нь жагсаагаагүй юм. Сүмийн орон нутгийн болон ерөнхий удирдагчдын зөвлөгөө болон Сүнсний удирдамжийг ашиглах тухайд нийтээрээ адил санаа бодолтой байхыг биднээс хүсэн хүлээдэг. Ерөнхийлөгч Боид К.Пакер тэмдэглэсэн нь:

“Энэ зүйл, эсвэл тэр юм Мэргэн Ухааны Үгэнд харшилдаг уу гэж гишүүд асууж бичдэг. Цай, кофе, ликёр дарс, тамхи Мэргэн Ухааны Үгэнд харшилдаг нь тодорхой. Эдгээр зүйлүүдийг нэг бүрчлэн тоочоогүй л дээ. Харин бид уг зарчмыг амлагдсан адислалуудынх нь хамт заадаг. Бие, сүнс аль алинд нь хортой бөгөөд уудаг эсвэл зажилдаг, амьсгалж сордог эсвэл тарьдаг, муу зуршил үүсгэдэг буюу донтуулдаг олон зүйл байдгийг уг илчлэлтэд дурдаагүй юм.

“Хор уршигтай болгоныг нэг бүрчлэн жагсаагаагүй юм. Жишээ нь: Галдан шатаалт мэдээж хэрэг муу зүйл. Гэвч муу зуршил бий болгодоггүй! Бүх зүйлд зарлиглуулдаг хүн ‘лазан болон ухаалаг биш үйлчлэгч юм’ (С ба Г 58:26) гэж Их Эзэн хэлжээ” (In Conference Report, 1996 оны 4-р сар, 22; Ensign, 1996 оны 5-р сар, 17).

Мэргэн Ухааны Үгийн тухай Ерөнхийлөгч Пакерын үгс болон Сүмийн удирдагчдын бусад зөвлөгөөг авч үзэн, хийх ёстой, мөн хийх ёсгүй хэдэн зүйлийг жагсаалтдаа нэмж бич.

Г Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 89:18-21

- Мэргэн Ухааны Үгийг дуулгавартай дагадаг хүмүүст Их Эзэн Сургаал ба Гэрээ 89:18–21-д амласан адислалуудыг жагсаан бич.
- Хэрэв та Мэргэн Ухааны Үгийн талаар залуучуудад үг хэлэх гэж байгаа бол, эдгээр адислал нэг бүрийн талаар ямар жишээ дурдах вэ?



Сургаал ба Гэрээ 90

Хаант улсын түлхүүрүүд

Дэлхий дээрх Бурханы хаант улсын түлхүүрүүд бол “Ерөнхийлөгчийн Зөвлөлийн эрх юм. Түлхүүрүүд нь дэлхий дээрх Их Эзэний бүх ажил хэргийг удирдан чиглүүлэх хүч, эрх мэдэл мөн. Бусад бүх хүмүүсийн санваараар үйлчлэх арга хэлбэрийг удирдах болон хяналт тавих хүч түлхүүрүүдийг эзэмшдэг хүмүүст байдаг” гэж Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит сургажээ. (In Conference Report, 1972 оны 4-р сар, 98; Ensign, 1972 оны 7-р сар, 87) Сургаал ба Гэрээ 90-р хэсгийг уншихдаа, Бошиглогч Иосеф Смитэд санваарын түлхүүрүүдийн тухай Их Эзэний хэлсэн зүйлсийг ажигла.



Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 90

Зөгнөлүүд (шүлэг 4–5)—
Түүний бошиглогчдоор
дамжин Бурханаас ирдэг
илчлэлтүүд

Бурханыг мэддэггүй (ш.
10)— Сайн мэдээний тухай

эсвэл үнэн Бурханы тухай
мэдлэггүй (хүмүүс)
Мадлагдсан (ш. 17)—Хэлэх
үгтгүй болсон, басамжлагдсан

Сургаал ба Гэрээ 90:3—Хаант улсын түлхүүрүүд Бошиглогч Иосефоос хэзээ ч авагдахгүй

Энэ эрин үед, тэр ч байтугай, нас барсныхаа дараа ч, Бошиглогч Иосеф Смит хаант улсын түлхүүрүүдийг эзэмшинэ гэдгийг Их Эзэн Сургаал ба Гэрээ 90:3-т харуулжээ. Тэргүүн Зөвлөлийн зөвлөх асан, Ерөнхийлөгч Жорж К.Каннон хэлэхдээ, Бошиглогч Иосеф Смит “энэ эрин үеийн тэргүүнд зогсож байлаа, хэдийгээр Иосеф хөшигний цаана одсон ч, тэрээр түлхүүрүүдийг эзэмшдэг. Мөн тэр өөрөө [Бригам Янг] түлхүүрүүдийг түүний удирдлага дор эзэмшдэг байсныг” Ерөнхийлөгч Бригам Янг заасан юм гэсэн байдаг. Ерөнхийлөгч Каннон цааш нь хэлсэн нь: “Мөн тэрээр сургаалыг заадаг байсан, түүнчлэн Ариун санваарын жаягийг ойлгодог итгэлтэй Төлөөлөгчид буюу Бурханы үйлчлэгчид үүнээс өөр сургаал заахыг та нар хэзээ ч сонсохгүй гэж Ерөнхийлөгч Жон Тейлор заадаг байлаа (*Gospel Truth*, 1:255).

Сургаал ба Гэрээ 90:6—“Адил тэгшид тооцогдсон” Тэргүүн Зөвлөлийн зөвлөхүүд

Тэргүүн Зөвлөл бол Сүмийн хамгийн дээд чуулга бөгөөд Сүмийн бүх ажил хэргийг удирддаг. Тэргүүн Зөвлөлийн зөвлөхүүд Ерөнхийлөгчийн хийдэг бүхнийг—Ерөнхийлөгч өөрөө хийж байгаа юм шиг хийж болдог. Гэвч тэд Ерөнхийлөгчийн удирдлага дор үйлчилж, түүний чиглүүлэл, зөвшөөрлөөр ажилладаг. “Арванхоёр бол Тэргүүн Зөвлөлөөс өөр юунд ч харьяалагдах ёсгүй . . . мөн намайг [Сүмийн Ерөнхийлөгчийг] байхгүй бол, Тэргүүн Зөвлөл Арванхоёрын дээр байхгүй” (*Teachings of the Prophet Joseph Smith*, 105–106) хэмээн Бошиглогч Иосеф Смит гэрчилжээ. Өөрөөр хэлбэл, Сүмийн Ерөнхийлөгч нас барахад Тэргүүн Зөвлөлийн зөвлөхүүд Сүмийг цаашид тэргүүлэхгүй гэсэн үг.

Сургаал ба Гэрээ 90:13—“Бошиглогчдын орчуулга”

Сургаал ба Гэрээ 90:13-т Библийн Хаан Жеймсийн Хувилбарыг орчуулсан Бошиглогч Иосеф Смитийн сүнсээр нөлөөлөгдсөн орчуулгын (Иосеф Смитийн Орчуулга) тухай өгүүлдэг. Тэрээр уг орчуулга дээр ажиллаж байжээ.

Сургаал ба Гэрээ 90:28–31—Виенна Жаквес

Виенна Жаквес эгчийг Сионы нутаг руу очиж өв хүлээн авахыг Их Эзэн урьжээ. Тийшээ очих зардлыг нь төлөх мөнгийг түүнд өгнө гэж Тэрбээр бас хэлсэн аж. Виеннад мөнгө хэрэгтэй байлаа. Яагаад гэвэл тэрээр баптисмынхаа дараахан бүх эд хөрөнгөө Сүмд өргөл болгосон ажээ. Энэ илчлэлтийн дараа Жаквес эгч, Миссурийн Жаксон дүүрэгт очиж, газар хүлээн авсан боловч мөрдлөг хавчлагын улмаас тэрээр эндээс хойд зүгт, Миссури руу явахаас аргагүйд хүрсэн гэнэ. Тэр олон нийтэд мэдэгдээгүй олон арга замаар үйлчилдэг асан, үнэнхүү итгэлтэй гишүүн байв. Жаран насандаа тэрээр хээр талыг туулан Солт Лейкийн Хөндий рүү морин тэргээ жолоодон очжээ. Жаквес эгч 96 настайдаа өөд болсон юм. “Тэрбээр гэрээнүүддээ үнэнч байсан бөгөөд Сайн мэдээний Сэргээлтийг үнэлж баршгүй эрдэнэс лүгээ адил эрхэмлэн дээдэлдэг байлаа” гэж эмгэнэлийнх нь бичигт дурджээ (“*In Memoriam: Vienna Jaques*,” *Woman’s Exponent*, 1884 оны 3-р сарын 1, 152).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 90-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг (А-В) хий.

А Хаант улсын түлхүүрүүд

1. Сургаал ба Гэрээ 90:1–6-д өгүүлснээр, Бошиглогч Иосеф Смитэд ямар түлхүүрүүд өгөгдсөн бэ?
2. Өөр хэн энэ эрх мэдлийг хүлээж авсан бэ?
3. Өнөөдөр дэлхий дээр түлхүүрүүдийг эзэмшдэг хүмүүсийг нэрлэ.
4. Шүлэг 5-д заагддаг нэг чухал үнэнийг ганцхан өгүүллээр товчлон бич.

Б Өөрийнхөө үгсээр



1. Сургаал ба Гэрээ 90:4–5 чамд ямар холбогдолтойг бич.
2. Чи Бурханы үгсэд хөнгөмсгөөр хандаагүй учраас ихэд хэцүү байсан тийм үе өөрт чинь байж болох юм. Энэ тухайд өөрт чинь хүчтэй мэдрэмж төрсөн үеийнхээ тухай бичнэ үү. Хэрэв чи тийм үеийн тухай санахгүй байвал, гэр бүлийн гишүүн, Сүмийн удирдагч, эсвэл найзаасаа түүнд тохиолдсон туршлагынх нь тухай асуу. Ярилцсан зүйлээ тэмдэглэлийн дэвтэртээ товчлон бич.

В Үүрэг хариуцлага

1. Сургаал ба Гэрээ 90:13–18-д өгүүлснээр, Тэргүүн Зөвлөлийн үүрэг хариуцлага юу вэ?
2. Эдгээр үүрэг хариуцлагуудаас аль нь Залуу Эмэгтэйчүүдийн ангийн эсвэл Арооны санваартны чуулгын ерөнхийлөгчид бас хамаатай байж болох вэ? Энд хамааралгүй үүрэг хариуцлага байвал үүрэг бүр нь яагаад хамааралгүйг тайлбарла.



Библийн зарим хувилбарууд Апокриф буюу “нууцлагдмал” гэж нэрлэгдсэн номуудын хэсэгтэй байдаг. Ерөнхийдөө, эдгээр номууд Апокриф гэж нэрлэгддэг гэж бодож болно. Учир нь энэ номууд үнэн үү, яг судар мөн үү гэдэг нь мэдэгддэггүй. Бошиглогч Иосеф Смит Библийн орчуулга дээр ажиллаж байхдаа, Апокрифийг орчуулж, оруулах ёстой эсэхийг мэдэхийг хүсчээ. Сургаал ба Гэрээ 91-р хэсэг бол Их Эзэний хариулт юм. Хэрэв та Апокрифыг уншихыг хүсвэл энэ нь таны сонирхлыг татдаг бусад сайн номуудын адил ашигтай зөвлөгөө болон мэдээллийг өгөх болно.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 91

Сургаал ба Гэрээ 91—Апокриф

Апокриф бол Хуучин Гэрээний үеийн Еврейн бичээсүүдийн цуглуулга юм. Эл бичээсүүд тэр үед еврей хэл дээр бичигдсэн судруудад ороогүй боловч Аврагчийн мөнх бус байдал дахь тохинууллын үед грек хэл дээр бичигдсэн судруудад орсон ажээ. Гэвч бүр тэр үед ч гэсэн, Апокрифыг хэн бичсэн, бас энэ номнууд сүнсээр нөлөөлөгдсөн бичээсүүд мөн үү гэдэг талаар олон асуулт гардаг байв. Апокриф дахь номууд нь Хуучин Гэрээний төгсгөл, Шинэ Гэрээний эхлэлийн хоорондох Иудей хүмүүсийн зарим түүхийг ойлгоход бидэнд тусалж чадна.

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 91-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Найздаа хариул

Чи найзтайгаа шашны тухай ярилцаж, өөрийнхөө библийг түүнд үзүүлж байна гэж төсөөлөн бод. Найз чинь чиний Библид ямар нэг зүйл алга байна гээд, яагаад энд Апокриф байхгүйг асуужээ. Сургаал ба Гэрээ 91-р хэсгээс мэдсэн зүйлээ ашиглан, найзынхаа асуултанд хариул.

Б Харьцуул

1. Сургаал ба Гэрээ 91-р хэсэгт Их Эзэн Апокриф үнэн гэдгийг хэрхэн мэдэх тухай юуг илчилсэн бэ?
2. Сургуулийн сурах бичиг зэрэг судруудаас бусад номуудад энэ зөвлөгөө хэрхэн холбогдох вэ?

Сургаал ба Гэрээ 92 Цог золбоотой гишүүн бай

Сургаал ба Гэрээ дэх зарим илчлэлтүүд нэн их хувь хүний шинжтэй бөгөөд Сүмийн түүхийн өвөрмөц үетэй холбоотой, практик шинжтэй байж болно. Эдгээр илчлэлтүүд өнөө үед бидэнд холбогдолгүй мэт санагдаж болох юм. Гэвч эдгээр илчлэлтүүдэд өөр өөр цаг үед янз бүрийн арга замаар хэрэглэж болох зарчмууд заагдсан байдаг. Сургаал ба Гэрээ 92 –р хэсэгт маш богинохон бөгөөд өвөрмөц илчлэлтийг уншихдаа өнөө үед хэрэглэх талаар бод.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 92

Сургаал ба Гэрээ 92:1—Нэгдсэн Журам

Сургаал ба Гэрээ 92-р хэсэг дэх, “нэгдсэн журам” гэдэг нэр томъёо нь Сүмийн өр төлбөрийн асуудлыг хамтран шийдвэрлэхээр ажиллахын тулд Их Эзэний дуудсан бүлэг хүмүүсийг нэрлэдэг (С ба Г 82:11–19-ийг үз). Эдгээр хүмүүс өргөлийн хуулийн дагуу амьдрах гэрээнд нэгдсэн бөгөөд Сүмийг өрнөөс чөлөөлөхөд шаардлагатай мөнгийг олохын төлөө чадах бүхнээ хийж байлаа. Тэдний хурлын зарим тэмдэглэлд энэ бүлгийг бас “нэгдсэн пүүс” гэж нэрлэсэн байдаг. Хэдийгээр тэд бүхэлдээ амжилттай байгаагүй ч, Сургаал ба Гэрээний нэлээд хэдэн хэсэгт орсон эл бүлэгт өгсөн Их Эзэний зааврууд нь өргөлийн хууль болон дуулгавартай хүмүүст үүнээс ирэх адислалуудыг илүү сайн ойлгоход бидэнд тусалдаг. Сургаал ба Гэрээ 92-р хэсэгт, Бошиглогч Иосеф Смитийн зөвлөхөөр өмнөхөн нь дуудагдсан Фредерик Г.Виллямсыг энэ журмын гишүүнээр хүлээн авахыг Их Эзэн зарлиг болгожээ (С ба Г 90:6-г үз).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 92-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Жишээ гарга



Сүмд үйлчлэх зарим боломжуудыг дор харуулав. Сургаал ба Гэрээ 92:2-т Их Эзэний зөвлөсний дагуу, “цог золбоотой” гишүүн байхын тулд дараах дуудлагатай хүн юу хийж болох тухай хүн бүр дээр жишээ гарга.

1. Хүүхдийн Хэсгийн долоон настай хүүхдүүдийн багш
2. Гэрийн багшийн хамтрагч
3. Бийхайв ангийн ерөнхийлөгч
4. Тойргийн залуучуудын үйлчлэлийн хорооны гишүүн
5. Ахмад гэр бүлийн хосын хөрш

Сургаал ба Гэрээ 93 Гэрэл ба үнэн

Сургаал ба Гэрээ 93-р хэсэг дэх илчлэлтийн үүслийн талаар Бошиглогч Иосеф Смит өгүүлээгүй байна. Яг тэр өдөр илчлэлтийг тэмдэглэхийнхээ өмнө тэрээр ердөө л: “Би дараах зүйлийг хүлээн авлаа” гэж бичжээ

(History of the Church, 1:343). Гэвч шүлэг 19 нь энэ илчлэлтийн зорилгын тухай нэг санааг бидэнд өгдөг. Хэрхэн шүтэн бишрэх, хэнийг шүтэн бишрэх талаар бид энэ илчлэлтээс илүү ихийг мэдэж болно.



“Шүтэн бишрэх гэж юу гэсэн үг вэ?” гэж чи асууж болно. Энэ нь шашны албан ёсны үйл ажиллагаануудад оролцож, Бурханыг хүндлэн дээдэлж, улам бурханлаг болоход бидэнд туслах арга замуудаар амьдрах гэсэн утгатай юм. Тэнгэрлэг Эцэг Есүс Христ хоёрыг шүтэн бишрэхийг эрэлхийлэх ёстойг бид мэднэ. Гэвч Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Жеймс И.Талмейж, “хэнийг шүтэн бишрэх нь тухайн хүний эрхэмлэн хүндлэх зүйлийн үнэ цэнийг тодорхойлогч, бүх талын ойлголтоос нь хамаарах чадвар юм. Хүний шүтэн бишрэх чадвар бол Бурханыг ойлгох чадварынх нь хэмжүүр мөн” гэж бичжээ (Итгэлийн Тунхаг, 12 дахь хэвлэл. [1961], 395–396). Сургаал ба Гэрээ 93-р хэсгийг судлахдаа, энэ нь Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын тухай юу зааагчийг, Тэдэнтэй илүү адилхан болохын тулд бид юу хийж болохыг эрж ол. Энэ хэсгийн талаар гүнзгий эргэцүүлэн бод. Учир нь энэ хэсэг хүүхдүүд ойлгоход энгийн бөгөөд илүү сурч боловсорсон сүнснээс хүмүүст чадлыг нь хангалттай сорих хүчирхэг үнэнүүдийг агуулдаг юм.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 93

Асар (шүлэг 4, 35)—Хүн суудаг майхны нэг төрөл \Аж төрөх газар\

Ач ивээл (шүлэг 11–13, 20)—Мөнх амьдрал болон

• өргөмжлөлийг олж авах боломжийг бидэнд олгодог Бурханы хүч болон хүч чадал

Надаар дамжин төрдөг (ш. 22)—Баптисм хүртэж, Сүнснээс дахин төрөх

• замаар Христийн хөвгүүд, охид болох
• **Элемент** (ш. 33)—
• Материйн үндсэн нэгж

Сургаал ба Гэрээ 93:6–18—Иоханы цэдэг

Сургаал ба Гэрээ 93-р хэсэгт дурьддаг Иоханы цэдэг бол Иохан Баптистын хөтөлсөн цэдэг юм. Иохан Баптистын бүрэн цэдэг хараахан илчлэгдээгүй ч, ирээдүйд гарч ирэх болно. Энэ цэдгийг Шинэ Гэрээнд байдаг Илчлэгч, Төлөөлөгч Иоханы бичээсүүдтэй андуурч болохгүй. (Нийл А.Максвелл, “Not My Will, But Thine” [1988], х. 44-ийг үз.)

Сургаал ба Гэрээ 93:11–17—“Эхлээд бүрэн байдлыг хүлээн авсан нь үгүй”

Ерөнхийлөгч Лорензо Снөү сургахдаа: “Есүс, өчүүхэн нялх хүүхэд, тэжээлийн тэвшинд хэвтэж байхдаа Бурханы Хүү гэдгээ, бас газар дэлхийг бүтээснээ мэдэхгүй байжээ. . . . Түүнийг эрийн цээнд хүрэх үед, бас өсөлт хөгжилтийнх нь үед Тэр хэн бэ гэдэг нь, мөн ямар зорилгоор Тэр дэлхийд ирсэн нь Түүнд илчлэгдсэн юм. Дэлхийд ирэхээс өмнө Түүнд байсан алдар суу, хүчийг мэдүүлсэн юм” гэжээ (In Conference Report, 1901 оны 4-р сар, 3).

Сургаал ба Гэрээ 93:12–13, 19–20—“Ач ивээл дээр ач ивээлийг,” “Ач ивээлээс ач ивээлд”

Ач ивээл гэдэг нь Бурханаас хүч чадал болон хүчийг хүлээн авахыг хэлдэг. Есүс Христ “ач ивээл дээр ач ивээлийг” хүлээн авсныг Сургаал ба Гэрээ 93:12 заадаг. Тэрээр өсч том болсон үедээ Эцэгээсээ тусламж болон Сүнсний бэлгүүдийг хүлээн авчээ. Есүс “бүрэн байдлыг хүлээн авах хүртлээ ач ивээлээс ач ивээлд үргэлжлүүлж байсныг” шүлэг 13 заадаг. Тэрээр бүрэн байдлыг хүлээн авах хүртлээ-Эцэгээсээ тусламж, хүч чадал, хүчийг нэг төвшинээс нөгөө төвшинд хүлээн авч өсч хөгжиж байлаа. Бид зарлигуудад итгэлтэй, дуулгавартай хэвээр байсан цагт, бид ч бас “ач ивээл дээр ач ивээлийг хүлээн авна” (ш. 20). Улмаар “тогтоосон цагт түүний бүрэн байдлыг хүлээн авна” (ш. 19).

Сургаал ба Гэрээ 93:21–23, 25, 29, 38—“Эхлэлд”

Бид бүгд мөнхийн биетүүд бөгөөд мөнхийн эхлэл ба төгсгөлгүй. Сургаал ба Гэрээ 93-р хэсэг дэх “эхлэлд” эсвэл “эхлэлээс” гэсэн нийлэмж үг нь энэхүү мөнх бус байдалд хамаарах зүйлүүд өөрсдийн эхлэлд байсан цаг үеийг нь заадаг. Тэнгэрлэг Эцэгтэй адилхан болох боломжийг бидэнд олгодог аз жаргалын агуу төлөвлөгөөгөө Тэрээр энэхүү эхлэлд танилцуулсан билээ .

Сургаал ба Гэрээ 93:40–50—“Хүүхдүүдээ гэрэл ба үнэнээр хүмүүжүүл”

Гэрэл ба үнэн гэж юу болох хийгээд эдгээр нь хэрхэн алдагдах эсвэл гэрэл ба үнэн нь хэрхэн холдуулан зайлуулагдаж болохыг Сургаал ба Гэрээ 93:36–39-д Их Эзэн заасан байдаг. Иймээс, “хүүхдүүдээ гэрэл ба үнэнээр хүмүүжүүлэхийг” Тэрээр шүлэг 40-д эцэг эхчүүдэд зарлиг болгожээ. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, мөн хожим нь Тэргүүн Зөвлөлийн зөвлөх болсон Ахлагч Марион Г.Ромни “эцэг эхчүүд хүүхдүүдээ заадаггүй байх нь зөвхөн хүүхдэд нь төдийгүй, соёл иргэншилд бүхэлд нь нөлөөлдөг.

“Ийм байдал нь үерийг тохиолгон авчирсан ёс бус байдалд, эртний Израилын уналтанд, тэрчлэн Мормоны Номын хүмүүсийн устгалд нэрмээс болсон юм” гэж сэрэмжлүүлжээ (In Conference Report, 1969, 108–109).



Сүмийн санваар эзэмшигчдэд хандаж, Ерөнхийлөгч Харольд Б.Лий хэлэхдээ: “Манай залуучууд аюул заналын дунд байна. Ах нар аа, гэр бүлийнхээ хэлхээ холбоог хүчтэй байлгацгаа. Түүнийг эрж хай тэгвэл бид бүгд хэлж сургахыг хичээдэг мөн би олон удаа дахин давтан хэлдэг . . . та бүгдийн хийх “хамгийн агуу Их Эзэний ажил гэр оронд чинь байх болно”. Эхнэрээ бүү үл тоомсорло, ах нар аа. Хүүхдүүдээ

бүү хайхрамжгүй орхи . Гэр бүлийн үдэштээ цаг гаргаж бай. Хүүхдүүдээ дэргэдээ ойр байлга. Тэдэнд зааж бай, тэднийг удирдаж, хамгаалж бай. Гэр бүлийн эв нэгдэл, бат бөх байдал нь үе үеэс илүү одоо бидэнд чухал шаардлагатай байна. Хэрэв бид ийнхүү бат бөх, эв нэгдэлтэй байх аваас энэ Сүм дэлхий дахинд хүч чадал, нөлөөгөөрөө маш түргэн өсөх болно” (In Conference Report, 1973 оны 4-р сар, 130; Ensign, 1973 оны 5-р сар, 98).

“Эцэг эхчүүд ээ, гэр бүлээ хамгаал. Хүүхдүүдээ Их Эзэний зарлиг болгосон гэрэл ба үнэнээр хүмүүжүүл. Тэдэнд хайраа харуул. Харин бүү эрхлүүл. Гэрчлэлээ хүүхдүүдтэйгээ хуваалц. Судруудыг хамтдаа унш. Тэднийг удирд, тэднийг хамгаал. Их Эзэн хүүхдүүдийг тань анхаарал халамжинд тань өгсөн юм. Үүнээс илүү агуу адислал гэж та бүгдэд үгүй, хүүхдүүдийнхээ төлөө хүлээдгээс илүү агуу хариуцлага гэж та бүгдэд үгүй. Хамтдаа залбирч бай. Их Эзэний өмнө бүгд хамтдаа өвдөг сөгдөх үе болох гэр бүлийн залбирлыг орлох юу ч байдаггүй” гэж Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли зөвлөжээ (In Conference Report, 1999 оны 4-р сар, 117; Ensign, 1999 оны 5-р сар, 89).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 93-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Та нар юу суралцав?

Сургаал ба Гэрээ 93:19-д, “та нар хэрхэн шүтэхээ мэдэж мөн ойлгож, бас та нар юуг мэдэж болохын тулд эдгээр айлдваруудыг би та нарт өглөө” (налуу бичлэг нэмэгдсэн) [шүлэг 1–18] хэмээн, өргөмжлөл болох Эцэгийн бүрэн байдлыг бид эцэстээ хүлээн авахын төлөө Их Эзэн хэлсэн юм (С ба Г 132:6, 19–20-ийг үз). Энэ судлах гарын авлага дахь Сургаал ба Гэрээ 93-р хэсгийн оршил, шүтэн бишрэх тухай товч өгүүлийг дахин нэгтгэн дүгнэхийг та нар хүсч болно.

1. Тэмдэглэлийн дэвтэртээ хоёр багана хийж, “Хэрхэн шүтэн бишрэх вэ?”, “Хэнийг бид шүтэн бишрэх вэ” гэж гарчигла. Сургаал ба Гэрээ 93:1–18-аас сурч мэдсэн зүйлүүдээ холбогдох багананд жагсаан бич. Үнэн бүр нь хэрхэн шүтэн бишрэх, юуг шүтэн бишрэх талаар та нарт юу зааж байгааг тайлбарла.
2. Сурч мэдсэн зүйлийнхээ улмаас та нар юуг цаашид өөр байдлаар хийх вэ?

Б Зарлигуудыг сахих нь хэр зэрэг чухал вэ?

Зарим үед маш энгийн үнэнүүд туйлын чухал, нэн хүчирхэг байдаг. Сургаал ба Гэрээ 93:20, 26–28, 36–39-ийг судалж,

зарлигуудыг сахихын ач холбогдлын талаар эдгээр шүлгүүд юу зааж байгааг бич.

В “Би та нарт зарлиг болгосон”

1. Тэргүүн Зөвлөлийн гурван гишүүн, түүнчлэн Огайогийн Көртланд дахь бишопт Их Эзэн Сургаал ба Гэрээ 93:40–50-д өгсөн зөвлөгөөг нэгтгэн дүгнэ.
2. Сүмийн эдгээр удирдагчдад гэр бүлийнх нь талаар зөвлөгөө өгөх нь Их Эзэнд яагаад чухал байсан бэ?
3. Та нар эцэг эх болсон үедээ дээрх шүлгүүдэд Их Эзэний өгсөн зөвлөгөөнд нийцүүлэн гэр бүлээ авч явахын тулд хийхээр төлөвлөж байгаа гурван зүйлээ жагсаан бич (Сургаал ба Гэрээ 93:40–50-ийн “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз).



Сургаал ба Гэрээ 94 Сүмийн Барилгын Хороонд зориулсан зааврууд

Тойргийн болон гадасны цуглааны байр, ариун сүм, семинар, институтын барилгууд гэхчилэн олон барилгыг Сүм эдүгээ дэлхий даяар барьж байна. Гэвч Сургаал ба Гэрээ 94-р хэсэг дэх илчлэлт өгөгдсөн үед Гэгээнтнүүд ямар ч барилга бариагүй байлаа. Көртландын Ариун сүмийн барилгыг барих зарлигийг Их Эзэн өгсөн боловч, гишүүд уг барилгыг барьж хараахан эхлээгүй байв. Энэ илчлэлтэд дахиад хоёр барилга барихыг Их Эзэн Сүмд зарлиг болгосон юм. Эдгээр илчлэлтийг судлахдаа энэ хоёр барилга болон ариун сүм барих тухай Их Эзэний зарлиг юу зааж байгааг, Бурханы ажлын үндэс суурийг тавихад юу чухал болох тухай бод.



Судруудыг судлах нь


Сургаал ба Гэрээ 94-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Барилга ба эн тэргүүний зүйлс

Их Эзэн энэ эрин үед барихыг Сүмд зарлиг болгосон эхний гурван барилгыг нэрлэж, (С ба Г 94:1, 3, 10-ыг үз) барилга тус бүрийн зорилгыг тайлбарла.

Б Зарчмыг хэрэглэ

Сүмийн бүх барилгыг эрх мэдэлтэй хүмүүсийн томилсон санваартны удирдагчийн хэлдэг залбирлаар онцгойлон адисалдаг. Онцгойлон адисалсан барилгуудаас Их Эзэн юу хүсэн хүлээдгийг мэдэхийн тулд Сургаал ба Гэрээ 94:8–9, 12-ыг унш. Их Эзэний хүсэн хүлээдэг зүйл манай Сүмийн барилгуудад өнөөдөр хэрхэн хамаатайг тайлбарла.



Көртландын эхэн үеийн зааг шугам

Сургаал ба Гэрээ 95 Миний өргөөг барь!

Яагаад хүмүүс заримдаа Их Эзэнээс үүрэг даалгавар ирэхийг хүлээж суудаг вэ? Көртланд дахь ариун сүмийн барилгыг барих тухай Их Эзэн зарлиг болгосноос хойш бараг зургаан сар өнгөрөөд байхад барилгын ажил нь эхлээгүй байлаа. Түүний хийхийг хүссэн зүйлийг хойшлуулсан үед Их Эзэнд ямар санагддагийг ойлгоход Сургаал ба Гэрээ 95-р хэсэг бидэнд тусалдаг. Бид хийх ёстой зүйлдээ ийм байдлаар идэвхгүй хандсаны үр дагавруудын тухай, Их Эзэн биднийг хэрхэн залруулж, наманчлахад хэрхэн тусалдгийг бид бас мэдэх болно.

Бошиглогч Иосеф Смит болон энэ илчлэлт өгөгдөхөд түүнтэй хамт байсан бусад хүмүүстэй бид бүгд адилхан байх болно гэдэгт найддаг. Ерөнхийлөгч Бригам Янг хожим нь хэлэхдээ: “Илчлэлт байгаагүй бол, Иосеф юу хүссэнээ бусдаас илүүтэйгээр мэдэж чадахгүй байсан. Зарлиг байхгүй байсан бол Сүм итгэлээр сул дорой нэн цөөхөн гишүүдтэй ийм өргөн цар хүрээтэй ажил хэрэг өрнүүлэхэд санхүүгийн хувьд тарчиг ядмагхан байхсан. Гэвч илчлэлт, зарлигаар жигүүрлэн, ердөө хэдүүлхнээ задгай хээрээр орон гэрээ хийж, сүүгээр гол зогоож, сүү олодохгүй үед ихэнхдээ давстай давсгүй жижиг эрдэнэ шишээр хооллон, Их Эзэний хоёр дахь өргөө-Көртландын Ариун сүмийг дуусгаж, онцгойлон адислалтад хүлээлгэн өгөх нь өдий хол байсан ч танхайрагчдаас өөрсдийгөө хамгаалахын тулд нэг гартаа илд барьж, нөгөө гараараа чулуу өрж, барилга дээр нийвий барин хөдөлмөрлөж байсан ажилчид, агуу Бошиглогч Иосеф чулууны аж ахуйд улаан нүцгэн гараараа чулуу бэлтгэж байв. Юунаас ч илүү хэрэгтэй байсан Бошиглогчийн дуулавартай байдал, нөр хичээнгүй хөдөлмөрч чанарын үлгэр дуурайлыг дагадаг хүмүүс Сүмд цөөхөн байлаа. Эдгээрийн тухай нийтлэгдсэн шастир түүх дэлхийд бидэнд байдаг билээ” гэжээ (Discourses of Brigham Young, 415).

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 95

Хишиг хүртээх (ш. 8)—
Сүнсний бэлэг өгөх, адислах

Сургаал ба Гэрээ 95:4—“Миний ер бусын үйл”

“Миний ер бусын үйл” гэсэн нийлэмж үг нь, наманчлах ямар ч хэрэгцээ байхгүй гэдэгт итгэдэг хүмүүсийг засч залруулах болно гэж Их Эзэн хэлсэн Исаиа 28:21-ээс үүдэлтэй юм. Өнөө үед сэргээгдсэн сайн мэдээний захиасыг аль хэдийнээс тэдэнд үнэн байгаа гэж итгэдэг олон хүмүүст номлодог. Ийм нөхцөл дэх хүмүүс бидний хүч чармайлтыг хачирхалтай гэж үзэж болно. Түүнээс гадна, илчлэлт, тэнгэрээс ирдэг айлчлалууд, бусад сүнслэг асуудлуудыг тэнэг хэрэг гэж үздэг хүмүүст сэргээгдсэн сайн мэдээ болон дэлхий дээр үнэн Сүм байгуулагдсан нь хачирхалтай санагдаж болно.

Сургаал ба Гэрээ 95:14—Их Эзэн төлөвлөгөөг гурван хүнд үзүүлсэн нь

Тэргүүн Зөвлөлийн гурван гишүүдэд Их Эзэн Көртландын Ариун сүмийн барилгын төлөвлөгөөг үзүүлсэн юм. Ариун сүмийн уран барилгач Труман О.Анжел:

“Ерөнхийлөгч Смитийн зөвлөхүүдийн нэг Фредерик Г.Вилльямс ариун сүм дээр хүрч ирсэн үед дараах яриа миний дэргэд болов.

“Мужаан Рольф хэлсэн нь: ‘Доктор оо, та ариун сүмийн талаар юу гэж бодож байна?’

“[Фредерик Г.Вилльямс] хариулсан нь: ‘Надад загвар нь яг тодорхой юм шиг санагдаж байна.’ Тэгээд тэрээр дараах зүйлийг ярилаа: ‘Иосеф өөрийн зөвлөхүүд, Вилльямс, Ригдон нартайгаа Их Эзэний өмнө ирэхэд Тэрээр ариун

сүмийг барих загвар буюу төлөвлөгөөг тэдэнд харуулах болно гэсэн үгийг Их Эзэнээс хүлээн авчээ. Бид өвдөг сөгдөн Их Эзэнд хандан залбирахад барилга бидэнд харагдах зайд гарч ирсэн, би үүнийг түрүүлж олж мэдсэн. Тэгээд бид бүгдээрээ үүнийг хамтдаа харсан. Бид барилгын гадна талыг сайн харсны дараа нөгөөх барилга яг бидний дээр гарч ирэх шиг боллоо. Тэгтэл энэ танхимын хийц нь [бүр нарийн тодорхой байдлаараа] миний тэнд харсантай яг адилхан байх шиг санагдсан” хэмээн илтгэжээ (in Marvin E. Смит, “The Builder,” *Improvement Era*, 1942 оны 10-р сар, 630).



Кертландын Ариун сүм

Сургаал ба Гэрээ 95:16–17—Кертландын Ариун сүмийн зорилго

Кертландын Ариун сүмийн үндсэн зорилго бол ариун сүмүүдэд өнөөдөр хийгддэг ажилд зайлшгүй шаардлагатай санваарын түлхүүрүүдийг Их Эзэн сэргээх газар болох ёстой байв (С ба Г 110-ыг үз). Уг ариун сүм бас цуглааны байр, сургууль болдог байжээ.

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 95-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Их Эзэн яагаад биднийг цээрлүүлдэг вэ?

Биднийг цээрлүүлэх буюу сахилгажуулахад бид ихэвчлэн дургүй байдаг. Заримдаа бид залруулгыг даруухнаар хүлээж авдаг ч гомдох эсвэл бүр уурлаж уруу татагдах нь олонтаа байдаг. Сургаал ба Гэрээ 95:1–2-т өгүүлсэнээр, Их Эзэн биднийг яагаад цээрлүүлдэг вэ?

Б Их Эзэнийг юу гомдоодог вэ?

1. Сургаал ба Гэрээ 95:3, 6, 10-аас “нэн гашуудалтай нүгэл” гэсэн нийлэмж үгийг ол. Сүмийн гишүүдийн үйлдсэн, Их Эзэнийг гомдоосон гурван нүглийг жагсаан бич.


- Шүлэг 4–8, 11–12-т өгүүлсэнээр, эдгээр нүглийн үр дагаврууд юу байсан бэ?
- Шүлэг 13–14-т, Ариун сүм барих тухайд хайхрамжгүй байсныхаа төлөө Гэгээнтнүүд хэрхэн наманчилж болох талаар Их Эзэн юу хэлсэн бэ?

В Загвар зураг буюу жишиг зураг

Сургаал ба Гэрээ 95:12-т Их Эзэнийг заасан зарчмыг авч үз (2 Нифай 7:10–11-ийг үз). Уг зарчмыг төлөөлж чадах загвар зураг буюу жишиг зураг зур.

Г Зургийг нэрлэ

Доор харуулсантай адилаар Кертландын Ариун сүмийн энгийн зургийг тэмдэглэлийн дэвтэртээ зур. Сургаал ба Гэрээ 95:13–17-д уншсан зүйлээ ашиглан, ариун сүмийн хэсгүүдэд нэр өгч, давхар буюу өрөө бүрийн зорилгыг тэмдэглэ.



Сургаал ба Гэрээ 96

Кертланд дахь газрыг хуваасан нь



Ариун сүм барихын тулд мөн түүнчлэн Огайогийн Кертланд дахь Их Эзэнийг ажлыг урагш ахиулахын тулд, Петр Френч гэдэг хүнээс 103 акр газрыг Сүм худалдаж авчээ (“Судруудыг ойлгох нь” хэсэг дэх схемийг үз). Худалдаж авсан газарт нийтийн байр, зочид буудал болдог байсан нэг барилга орсон аж (С ба Г 96:9-д дурдагддаг өргөө). Газрыг хүн бүрд ашигтайгаар хэрхэн хуваах тухайд Сүмийн удирдагчид тохиролцож чадсангүй. Иймээс Бошиглогч Иосеф Смит Их Эзэнээс асуув. Сургаал ба Гэрээ 96-р хэсгийг уншихдаа цаг зуурын энэ асуудлаар өгсөн зөвлөгөөнд нь Их Эзэнийг хэлсэн юу чухал ач холбогдолтой байсныг ажигла.

Судруудыг ойлгох нь




Сургаал ба Гэрээ 96

Миний журам, журам
(шүлэг 4, 8)—Нэгдсэн
журам (С ба Г 92:1-ийн

“Судруудыг ойлгох нь” хэс-
гийг үз, х.00 105)

Сургаал ба Гэрээ 96—р хэсгийн хэсгийн тойм— Френчийн ферм



Сургаал ба Гэрээ 96:2—Ньюел К.Витней газрын асуудлыг хариуцаг

Ньюел К. Витней бол Огайогийн Көртландын бишоп байв. Өмнө нь илчлэгдсэнчлэн (С ба Г 42; 51; 72-ыг үз), Сүм дэх түр зуурын (сүнсний бус) асуудлуудыг бишоп хариуцдаг байжээ. Тиймээс ариун сүм баригдах ёстой байсан газрыг түүнд хариуцуулсан байна. Сүмийг удирдан зохион байгуулахад тулгардаг асуудлыг шийдвэрлэх арга замуудыг олон-таа агуулдаг-судар, бошиглогчдын сургаал, Сүмийн гарын авлагууд нь өнөөдөр бидэнд чухал сануулагч болж байна.

Сургаал ба Гэрээ 96:6–9—Жон Жонсон

Жон Жонсон Бошиглогч Иосеф Смиттэй анх уулзаж, Сүмд нэгдэхдээ Огайогийн Хайрамд амьдарч байжээ. Бошиглогч Иосеф гэр бүлийнхээ хамт хэсэг хугацаанд Жонсоныхонтой цуг амьдарч байв. Сургаал ба Гэрээ 76-р хэсэг дэх илчлэлтийг Жонсоныхны гэрт хүлээн авсан юм. Сургаал ба Гэрээ 96-р хэсэгт, Петр Френчийн зочид буудалд анхаарал тавьж, тэнд Сүмийн хэвлэлийн үйл ажиллагааг зохион байгуулах даалгаврыг Их Эзэн Жонсон ахад өгсөн аж. Нэгдсэн Журам татан буугдахад уг зочид буудлыг Жонсон ахад өгсөн бөгөөд “Жонсоны Дэн Буудал” гэх болжээ.



Жонсоны дэн буудал

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 96-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Юуг, яагаад?

Сургаал ба Гэрээ 96:1-д, Көртланд дахь гадсыг хүчирхэг болгох нь “шаардлагатай” байсныг Их Эзэн хэлжээ.

1. Сургаал ба Гэрээ 96-р хэсэг дэх Их Эзэний зөвлөгөөн дээр тулгуурлан, Көртландын гадсыг юу хүчирхэг болгох байсан гэж та нар бодож байна?
2. Өөрийн чинь гаргасан санал бүр яагаад гадсыг хүчирхэг болгоно гэж бодож байгаагаа тэмдэглэ.

Б Судруудын үнэ цэнэ

1. Сургаал ба Гэрээ 96:5-д өгүүлснээр, Их Эзэний үг хүмүүст ямар нөлөө үзүүлж болох вэ?
2. Судруудын Удирдамжаа ашиглан, хүмүүст үзүүлж болох судрын өөр хоёр чухал үр нөлөөг ол. Эдгээр үр нөлөө болон энэ талаарх судрын эшлэлүүдийг тэмдэглэлийн дэвтэртээ бич. Та нар эшлэлүүдийг Сургаал ба Гэрээ 96:5-ын дэргэд судрууд дээрээ бичихийг хүсч болно.

Сургаал ба Гэрээ 97 Ариун сүмүүд ба Сион



Хожмын өдрүүдэд сэргээгдсэн сайн мэдээний зорилгуудын нэг нь Сионыг үндэслэн байгуулах-Бурханаа угтаж, Түүнтэй хамт амьдрахад ариун хүмүүсийг бэлтгэх явдал гэдгийг та нар Сургаал ба Гэрээг судалснаар мэдэх болно. Сургаал ба Гэрээ 97-р хэсэгт, Их Эзэн Сионы тухай илүү ихийг, тухайлбал: Сион “цэцэглэн хөгжиж, өөрийгөө өргөжүүлэн тэлж, мөн туйлын сүр жавхлантай болоход” (ш. 18) юу туслах тухай өгүүлжээ. Их Эзэн энэ илчлэлтэд юу заасныг анхааралтай авч үз. Учир нь бид өнөө үед Сионыг үндэслэн байгуулж, төлөвшүүлэхийг эрэлхийлж байгаа учраас энэ нь бидэнд бас хамаатай юм.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 97

Өргөө (шүлэг 10, 12, 15)—
Ариун сүм

Өс хонзон (шүлэг 22, 26)—
Хилэнцэт үйлдлийн төлөөх
шүүлт

Гэгсгээн цээрлүүлэлт (ш.
23)—Шийтгэл

Сургаал ба Гэрээ 97:3-6—Сион дахь сургууль

Парли П.Пратт Миссури дэх сургуулийг тэргүүлж байв. Энэ сургуулийг Ахлагчдын Сургууль гэдэг байсан бөгөөд долоо хоногт нэг удаа гадаа задгай газарт цуглан уулздаг жар орчим оюутантай байжээ. Энэ сургуульд олон агуу, гайхалтай зүйлс тунхаглагдан заагдаж байв.

Сургаал ба Гэрээ 97:21—“Сион—зүрх сэтгэлдээ цэвэр ариун тэд болой”

“Зүрх сэтгэлдээ цэвэр ариун-цэвэршсэн бөгөөд Хурганы цусаар дамжин өмсгөл нь цагаан болж угаагдсан хүмүүсээс Сион бүрддэг (Алма 13:11-ийг үз). Тэдгээр нь энэрлийг нөмрөг мэт авч яван, цэвэр ариун зүрх сэтгэлээр бусдад үйлчилдэг хүмүүс юм” гэж Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл тайлбарласан байдаг (In Conference Report, 1978 оны ес-аравдугаар сар, 114; *Ensign*, 1978 оны 11-р сар, 76).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 97-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Тодорхойлолт гарга

Сургаал ба Гэрээ 97:2-т, номхон дөлгөөн хүмүүст Тэрээр нигүүлслийг үзүүлэх болно хэмээн Их Эзэн хэлжээ. *Номхон дөлгөөн байдал* гэдгийн үндсэн гол утга нь шүлэг 1-ийн төгсгөлд байдаг. Хожмын Үеийн Гэгээнтний судрын хэвлэлүүд дэх судлах тусламжийг ашиглан номхон дөлгөөн байдлын талаарх өөр судруудыг эрж ол. Тэгээд *номхон дөлгөөн байдал* гэсэн нь юу гэсэн утгатайг бич. Энд дүрсэлсний дагуу чи яагаад номхон дөлгөөн байхыг хүсдэг шалтгаануудаас наад тал нь хоёрыг бич.

Б Их Эзэнээр хүлээн зөвшөөрөгдөх нь

“Сүм үнэн гэдгийг би мэднэ, бас би зөвийг хийхийг хүсдэг. Амьдралын минь арга маяг Их Эзэний хувьд хүлээн зөвшөөрөгдөхөөр байгааг би яаж мэдэх юм бэ?” гэж нэг найз чинь чамд хэлж гэж бод. Сургаал ба Гэрээ 97:8-9-ийг тайлбарлах замаар энэ асуултанд хариул. Юу гэж хэлэхээ тэмдэглэлийн дэвтэртээ бич.

В Асуултууд бич

Сургаал ба Гэрээ 97:10-19-д, Их Эзэн Сионд (Миссурид) ариун сүм барихтай холбоотой хэд хэдэн чухал зарчмыг тайлбарлажээ. Эдгээр шүлгүүдэд заасан зарчмуудаар хариулагдах ариун сүмийн тухай наад тал нь дөрвөн асуулт бич. Энэ зарчмуудыг өнөө үед ч ариун сүм барихад хэрэглэдэг.

Г Ариун сүмийн зөвшөөрлийн бичигтэй байхын шалтгаан

Сургаал ба Гэрээ 97:15-17-г уншиж, дараах асуултуудад хариул:

1. Ариун сүмд орж, ёслолуудад оролцохыг яагаад хүн болгонд зөвшөөрдөггүй вэ?
2. Бид ариун сүмд орохын тулд зохистой байдлынхаа хувьд яагаад шударга байх ёстой вэ?

Сургаал ба Гэрээ 98

Мөрдлөг хавчлагад өгсөн хариу



1833 оны долдугаар сарын 20-нд Мормоны шашныг эсэргүүцэгч танхайрагч бүлэг Фелпсийн гэр байсан Сүмийн хэвлэх газар луу довтлов. Тэд хэвлэлийн суурь машиныг сүйтгэж, бараг дуусаад байсан Зарлигуудын Номын ихэнхийг устгаж, тавилгыг гудамжинд гаргаж хаян, барилгын ихээхэн хэсгийг эвджээ. Дараа нь тэд Бишоп Эдвард Партриж, Чарльз Аллен хоёрыг баривчлан авч, Мормоны Номын тухай гэрчлэлээ үгүйсгэх эс бөгөөс гүнлэгийг орхин явахыг албадан шаардсан аж. Гэрчлэлээ үгүйсгэхээс татгалзахад нь танхайрагч бүлэг тэр хоёрын биенд давирхай түрхэж, өд наажээ.

Гурван өдрийн дараа танхайрагч бүлэг эргэж ирэн Сүмийн гишүүдийн гэр орон, бизнесийн байгууллагуудыг нь устгав. Сүмийн зарим удирдагчид өөрсдийн амийг тэдэнд өгч үлдсэн Гэгээнтнүүдийг зүгээр орхиныхууссан ч танхайрагч бүлэг эл саналыг хүлээн авахаас татгалзсан юм. Үүний оронд тэд Миссурийн Жаксон гүнлэгийг нэгдүгээр сар гэхэд орхин явах гэрээнд гарын үсэг зурахыг Сүмийн удирдагчдад тулган хүлээлгэжээ. Эдгээр үйл явдлуудын тухай Бошиглогч Иосеф Смитэд мэдэгдэхийн тулд Оливер Каудерийг Огайо руу явуулав. Каудери ахыг ирэхээс өмнө Сургаал ба Гэрээ 98-р хэсэг дэх илчлэлтийг Бошиглогч хүлээн авч, Миссури дэх Гэгээнтнүүдэд хариу болгон илгээсэн байна.

Сүмийн эдгээр гишүүдэд ямар санагдсан байж болохыг төсөөлөн бод. Ойлоход чинь тусалсан туршилага та нарт байж болно. Ийм нөхцөлд бид Их Эзэний хүссэн зүйлийг хийхийг хичээж байхад заримдаа бидэнд яагаад муу зүйлүүд тохиолддог юм бэ? Энэ тохиолдолд бид

лах ёстой вэ? Ийм үед бид ямар сургамж авч болох вэ? Хэрэв хүн биднийг гомдоовол, өс хонзон авахыг бодох нь зөв үү? гэж асууж болох юм. Сургаал ба Гэрээ 98-ыг уншихдаа, энэ хэсгийн үгс Их Эзэн Есүс Христийнх гэдгийг сана. Энэ хэсэг мөрдлөг хавчлагад хэрхэн хариулахыг Тэрээр биднээс хүсдэг тухай заадаг. Энэ илчлэлт зөвхөн Миссури дэх Гэгээнтнүүдэд ямар хамаатай байсныг ойлгохыг хичээх бус, харин энэ нь өнөөдөр та нарт хэрхэн хамаатай байж болохыг авч үз.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 98

Сургаал ба Гэрээ 98:16—“Дайнаас татгалзаж, энх тайвныг тунхагла”

Дэлхийн II Дайны үед хийсэн нэгэн мэдэгдэлд Сургаал ба Гэрээ 98:16-гийн эхний хэсгийг эш татсаны дараа Тэргүүн Зөвлөл өгүүлсэн нь:

“Хэрэв Их Эзэн шинэ зарлиг өгөхгүй бол бас шинэ зарлиг өгөх хүртэл Сүм өөрөө дайн дэгдэж болохгүй. Ийнхүү Сүм дайны эсрэг байх ёстой. Дайн нь олон улсын маргааныг шийдвэрлэх зөв шударга арга зам болж чадахгүй. Олон улсын маргааныг энхийн хэлэлцээр болон зохицуулалтаар-улс үндэстнүүд зөвшилцөн тохиролцоо замаар шийдвэрлэх ёстой, мөн ингэж чадна.

“Тэвч Сүмийн гишүүнчлэл нь Сүмийн хяналтаас гадна тусгаар тогтнолт улс гүрний харъяат иргэд юм. ‘Үндсэн хууль болох уг нутгийн хуульд нөхөрсгөөр хандахыг’ [Тэдгээрийг Сургаал ба Гэрээ 98:4–7-д эш татсан байгаа.] Их Эзэн Өөрөө бидэнд хандан өгүүлсэн юм.

“Энэхүү илчлэгдсэн үг нь нөхцөл байдлын хувьд Америкийн энэ нутагт бүр ч илүү ихээр хамаатай ч, зарлагдсан зарчмууд нь учир холбогдлоороо дэлхий дахины шинжтэй юм. Мөн эдгээр нь ‘чамд’ (Йосеф Смит), ‘мөн миний Сүмийн та нарын ахан дүүст’ онцгой учир холбогдолтой юм. Иймээс, эдгээр зарчмуудыг чанд баримталсан, үндсэн хуулийн хүрэн дэх хууль нь Сүмийн эрэгтэйчүүдийг эх орондоо үнэнч байж, улс орныхоо зэвсэгт хүчинд алба хаахыг уриалдаг. Энэхүү уриа дуудлагад хариулахыг тэдний иргэний эрхэм дээд үүрэг шаардаж байна” (In Conference Report, 1942 оны 4-р сар, 94).

Сургаал ба Гэрээ 98:23—“Үүнийг хүлээцтэйгээр тэвч”

Сургаал ба Гэрээ 98-р хэсгийн сүүлчийн хагаст Их Эзэний өгсөн зөвлөгөөний жишээ нь бишоп Эдвард Партриж байлаа. Миссурийн Жаксон гүнлэг дэх үеийн тухай өгүүлж, биендээ давирхай түрхүүлэн, өд наалгасан тухайгаа тэрээр: “Би зовлонгоо үлэмж тэвчээр хатуужил, номхон дөлгөөн байдлаар даван туулсан. Тэвчээр, номхон дөлгөөн байдал нь намайг нам чимээгүй байлгаж, олон түмнийг гайхшруулсан билээ. Олон хүмүүс надад нэн хүндэтгэлтэй хандаж, миний бодож байсанчлан тэд жаргал зовлонгоо надтай хуваалцсан юм. Харин миний хувьд гэвэл би Бурханы Сүнс, Бурханы хайраар дүүрч, өөрийгөө мөрдөн хавчигчдыг ч, бас өөр хэнийг ч үзэн ядахгүй байлаа” хэмээн бичжээ (in *History of the Church*, 1:391).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 98-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Амар бус

Миссурид мөрдөгдөн хавчигдаж байсан Гэгээнтнүүдэд Сургаал ба Гэрээ 98-р хэсэгт өгсөн Их Эзэний зөвлөгөө нь зүй ёсны биш буюу ийм нөхцөлд амар бус хариу шиг санагдаж болох юм.

1. Мөрдөгдөн хавчигдаж, гэр орноосоо хөөгдсөн Миссурийн Гэгээнтнүүдийн байдал ямар байсныг бодоод үз. Сургаал ба Гэрээ 98:1–3 дахь ямар зөвлөгөө тэдэнд хүндрэлтэй байсан гэж та нар бодож байна?
2. Хэн нэгэн хүн түмэн зовлонд унасан боловч, “эмээгээгүй,” “харин тайтгарлыг хүлээн авч,” “үүрд мөнхөд баясаж,” “талархал илэрхийлсэн,” эсвэл энэ нь хожим нь “та нарын сайн сайхны төлөө хамтдаа ажиллахыг” өөрөө үзсэн, эсвэл өөр хэн нэгэн үзсэн тухай жишээг бичнэ үү.

Б Зөвлөгөө өг

Сүмд шинээр хөрвөгч нэг хүн ойртож байгаа сонгуульд Сүмийн баримтлах байр суурийн талаар өөрөөс чинь асуужээ гэж бод. Сургаал ба Гэрээ 98:4–10-ыг удирдамж болгон ашиглаж, чи ямар санаануудыг энэ хүнд тайлбарлаж болох вэ? Санаа бүрийг дэмжигч шүлгүүдийг зааж, наад тал нь гурван санааг бичнэ үү.

В Зарлиг ба амлалтууд

1. Тэмдэглэлийн дэвтэртээ хоёр багана хийж, “Зарлигууд”, “Амлалтууд” гэж нэрлэ. Сургаал ба Гэрээ 98:11–18-аас өөрсдийн олсон зарлиг, амлалт нэг бүрийг холбогдох багананд жагсаан бич.
2. Хэрэв чи энэ илчлэлт өгөгдөх үед Миссурид амьдарч байсан бол эдгээр зарлигууд болон амлалтуудаас аль нь чамд хамгийн ихээр нөлөөлөх байсан бол? Яагаад?

Сургаал ба Гэрээ 99

Жон Мурдокийн НОМЛОЛЫН ДУУДЛАГА



1830 оны намар анхны номлогчид Огайогийн Кертландаар дамжин өнгөрөх үед Жон Мурдок (1792–1871) гэр бүлийнхээ хамт Сүмд нэгдсэн ажээ. Тэд Оранж хотхонд амьдарч байсан үед, 1831 оны тавдугаар сарын 1-нд эхнэр Жулия нь ихэр хүүхэд төрүүлэх үедээ нас баржээ. Өмнөх өдөр нь дөрөвдүгээр сарын 30-нд эндээс арвантаван бээр зайтай Кертландад

Эмма Смит бас ихэр хүүхэд төрүүлж, ихэр хүүхэд хоёул нас барсан аж. Мурдок ах эхгүй хүүхдүүдийг зохих ёсоор анхаарч халамжлах боломжгүй байсан болохоор ихэр хоёр-Жулия, Жозеф хоёрыг үрчилж авахыг Бошиглогч Иосеф, Эмма Смит нарт зөвшөөрсөн аж. Жаал хүү Жозеф Бошиглогч Иосеф Огайогийн Хайрамд давирхай түрхүүлж, өд наалгасан үед нэг шөнө өвчний улмаас, гадаа байснаас нас барсан гэдэг.

Сургаал ба Гэрээ 99-р хэсгийг уншихдаа, Мурдок ахаас Их Эзэний хүссэн золиослолуудын тухай бод. Өнөөдөр номлогчдоос ямар золиослолууд шаардагддаг вэ? Өнөө үеийн номлогчдоос шаардагддаг золиослолууд Их Эзэн Мурдок ахаас хүссэн золиослолуудтай хэр зэрэг адилхан байна вэ? Мөн ямар ялгаатай байна вэ?

Жон Мурдок номлолоо гүйцэтгээд, дараа нь бусад олон дуудлагыг бүх амьдралынхаа туршид хүлээн авчээ. Тэрээр Их Эзэнд болон Сүмд итгэлтэй хэвээр нас барсан юм.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 99

Сургаал ба Гэрээ 99:4—“Хөлөө цэвэрлэ”

Сургаал ба Гэрээ 24:15-ын “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз (х.00[36]).

Сургаал ба Гэрээ 99:6—Явахаасаа өмнө хүүхдүүдээ ханга

“1832 онд [Жон Мурдокоос] өөрийн том гурван хүүхдээ тэднийг тэжээж хувцаслах зарим нэгэн зүйлстэйгээр Миссурийн бишоп Партриж руу явуулжээ. Ихрийн өрөөсөн эрэгтэй нь (Жозеф) мөрдлөг хавчлагын үеэр 1832 оны 3-р сард Хайрамд нас барж, Жулияг Иосеф [Смит] авч үлджээ. Мурдокоос ах өмч хөрөнгөө зарснаас олсон мөнгөнийхөө заримыг хүүхдүүдээ тэжээж, хувцаслахын тулд Миссурид байсан бишоп Партрижид явуулж, мөн заримыг нь Иосеф ахад өгчээ. Тийнхүү тэрээр сайн мэдээг номлоход бэлэн болов.” (Андрю Женсон, *Latter-day Saint Biographical Encyclopedia*, боть 4, [1901–1936], 2:363).

Эхнэр, долоон хүүхэдтэй эцэг Жорж Т.Бенсон нь номлолын дуудлага хүлээн авсан тухай Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон ярихдаа:

“Бид том өрөөндөө хуучин диваныхаа дэргэд цугларахад аав номлолынхоо дуудлагын тухай бидэнд хэллээ. Дараа нь ээж: ‘Аавыг нь номлолд явахаар зохистой гэж үзсэнийг мэдээд бид бахархаж байна. Энэ бол хоёр жил тусдаа байна гэсэн үг учраас бидэнд жаахан хэцүүхэн л байна’... гэж хэллээ.

“Ингээд аав маань номлолдоо явах нь тэр. Тэр үед би аавынхаа шийдвэр төгс байдлыг бүрэн ухаарч ойлгоогүй ч гэсэн, энэ дуудлагыг аав маань хүлээн авах хүсэлтэй байсан нь агуу итгэлийнх нь нотолгоо байсныг би эдүгээ илүү сайн ойлгодог” гэжээ (In Conference Report, 1986 оны 10-р сар, 60; *Ensign*, 1986 оны 11-р сар, 46).



Өнөө үед эрэгтэйчүүд эхнэр хүүхдээ орхин номлолд үйлчлэхийг Сүм хүсдэггүй. Гэхдээ бид гэр бүлээ ардаа орхин Их Эзэнд үйлчлэх номлолын дуудлага хүлээн авахад нь өвөө, эмээ нарыгаа урамшуулан дэмжиж болдог. Ингэснээр, өмнөх үеийнхний Сүмийн гишүүдийн эдэлдэг байсан тэрхүү адислалуудыг бид бас хүлээн авч чадна.

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 99-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А, Б эсвэл В-г хий.

А Ярилцлага явуул

Сургаал ба Гэрээ 99:2-т дурдсанчлан, Ариун Сүнсний хүчээр дамжуулан Бурханы үгийг тунхаглах нь ямар байдаг тухай асуултуудыг үйлчилж буй номлогчоос эсвэл буцаж ирсэн номлогчоос асуу. Хариултуудыг тэмдэглэж ав. Энэ нь шүлэг 2-ын тухай ойлголтуудыг та нарт өгнө.

Б Тодруулахын тулд бусад судруудыг ашигла

Түүний үйлчлэгчдийг бид “бяцхан хүүхэд адилаар” хүлээн авах ёстой гэж Их Эзэн Сургаал ба Гэрээ 99:3-т хэлжээ. Мозай 3:19-ийг уншиж, энэ нь юу гэсэн үг болохыг эл судар хэрхэн тодруулж байгааг тайлбарла.

В Үүнийг өнөө үед хэрэгжүүл

1. Гэр бүлээ орхин, номлолд үйлчлэхийг Их Эзэн Жон Мурдокоос хүсчээ. Үйлчлэхийн тулд өнөөдөр номлогчид ямар золиослолууд хийдэг вэ?
2. Яагаад Мурдокоос ах эдгээр золиослолуудыг хийсэн юм бол, мөн өнөө үед номлогчид яагаад эдгээр золиослолуудыг хийдэг вэ?

Сургаал ба Гэрээ 100

Номлолын талаар Бошиглогч
Иосеф Смит, Сидней Ригдон
хоёрт өгсөн зөвлөгөө

Гэр орон, гэр бүл, найз нөхдөө орхих нь номлогчийн хувьд заримдаа хэцүү байдаг. Бошиглогч Иосеф Смит,

Сидней Ригдон хоёрын хувьд ч бусад номлогчдоос ялгаа байсангүй. Сургаал ба Гэрээ 100-р хэсэгт Их Эзэн тэдэнд (мөн бидэнд) юу гэж хэлсэн бэ?

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 100

Мадлагдах (ш. 5)—
Ичгүүртэй болох буюу хэлэх
үггүй болох, басамжлагдах,
дорд үзэгдэх

Чанд байдал (ш. 7)—
Хүндэтгэлтэй, буурь
суурьтай

Сургаал ба Гэрээ 100:3—“Үр дүнтэй хаалга нээгдэх болно”

Бошиглогч Иосеф Смит, Сидней Ригдон хоёрын богинохон номлолын нэг үр дүн нь “Иосефын айлчлал тэндэх ажилд үлэмж урам зориг өгсөн явдал байлаа” (Church History in the Fulness of Times, 117).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 100-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Захидал бич

Номлолд үйлчилж байгаа найз чинь гэрээ их санаж байгаа тухайгаа өөрт чинь бичжээ. Найздаа урам хайрлахын тулд чи юу бичих вэ? Сургаал ба Гэрээ 100:1–8, 12–17-гоос ямар сургаалуудыг чи захидалдаа ашиглаж болох вэ? Ашигласан сургаал бүрийнхээ талаар, уг сургаалыг хэрхэн, яаж ашиглаж болохыг товч тайлбарла.

Б Ялгааг дүрсэл

Сургаал ба Гэрээ 100:9–11-д, Бошиглогч Иосеф Смитийн үүрэг, Сидней Ригдоны үүргийн хоорондох ялгааг Их Эзэн тодорхойлсон байна. Эдгээр ялгааг тэмдэглэлийн дэвтэртээ дүрсэл.

Сургаал ба Гэрээ 101 Миссурийн Жаксон гүнлэг дэх зовлон зүдгүүрүүдэд хариулсан нь

Миссури дэх Гэгээнтнүүд 1833 оны зун дааж давшгүй мөрдлөг хавчлагад өртөж эхлэв. Үүний улмаас Сүмийн гишүүд 1834 оны нэгдүгээр сар гэхэд Жаксон гүнлэгийг орхин явахыг зөвшөөрчээ. Учир нь 1833 оны арав, арван-нэгдүгээр сард, мөрдлөг хавчлага улам гаарсан аж. Танхайрагч бүлгүүд цугларч, зарим Гэгээнтнүүдийг

зодож занчин, орон гэр, тавилга, эд хогшил, үр тариа, мал амьтныг нь устгаж, өвөл хаяанд ирчихээд байхад олон зуун Гэгээнтнийг орон гэрээс нь хөөж байлаа.



БИС-ийн Урлагийн Мухейн зөвшөөрлөөр нийтлэв. Бүх эрх хамгаалагдсан.

Сүмийн гишүүдийн ихэнх нь Миссури мөрнийг гаталж, Клей гүнлэг рүү очин, түр зуур толгой хоргодох оромжууд барьж байв. “Үйл явдал дүрслэхийн аргагүй байв. Улайрсан дарлан хүчирхийлэгч, атгаг санаатан, өөрийнхөө санаа бодлоос өөрийг үл хүлцэгч бүдүүлэг авиртнаас бусад, газар дэлхий дээрх аль ч хүмүүний зүрх сэтгэл шимширч уяран хайлмаар байлаа” гэж Бошиглогч Иосеф Смит бичжээ (History of the Church, 1:437).

Гэгээнтнүүд гэр орноосоо хөөгдөхийг Их Эзэн яагаад хүлцэн тэвчсэн юм бол? Миссурийн хүмүүс юуны улмаас Гэгээнтнүүдийн эсрэг өгүүлгийг харгис хэрцүгийг авирласан юм бол? Сион юутай адилхан болов оо? Сургаал ба Гэрээ 101 дэх илчлэлтийг хүлээж авахаасаа зургаан хоногийн өмнө Бошиглогч Иосеф Смит: “Эдүгээ миний мэдэхгүй хоёр зүйл байна. Бас Их Эзэн энэ хоёр зүйлийг надад үзүүлэхгүй. Түүнд байх мэргэн зорилгын учир болов уу. Би зарим талаар бодож үзээд л ингэж хэлж байна. Энэ нь юув гэвэл: Сион дээр түмэн гай зовлон ирэхийг Бурхан юуны учир хүлцэн тэвчив? Бас энэхүү түмэн зүйлийн гай зовлонгийн ер бусын хөдөлгөгч хүч нь юу вэ? Мөн дахин, Тэрбээр Сионыг тэргүүн дээр нь үүрдийн баяр баяслын дуутайгаар өвд нь ямар арга хэрэгслээр эргүүлж оруулах юм бол? Ах нар минь, энэ хоёр зүйл надад тодорхой үзүүлэгдэхгүй, саатуулагдаж байна. Гэвч Бүхнийг Чадагчийг хилэгнүүлэхэд хүргэсэн зарим зүйл тодорхой харагдлаа” гэж бичжээ (History of the Church, 1:454).

Сургаал ба Гэрээ 101-р хэсгийг уншихдаа, мэдэгдэхгүй байна гэж түүнд бодогдсон энэ хоёр зүйл: Сүмийн гишүүд тийм харгис хатуу мөрдлөг хавчлагад өртөхийг Бурхан яагаад хүлцэн тэвчсэнийг, түүнчлэн Сионы эзэмшлийг дахин олж авахад нь Тэрээр тэдэнд хэрхэн тусалж болох талаар Бошиглогчид Их Эзэний өгсөн илчлэлтийг ажигла. Амьдрал бидний бодсоноор буюу найдсанаар үргэлж байдаггүй үед, бидний хүн нэг бүр цөхөрч, урам хугардаг учраас, энэ илчлэлт хүн бүрийн хувд ашигтай заавар болдог. Түүнээс гадна, Бошиглогч Иосефын асуултуудад Их Эзэний өгсөн хариулт нь хожмын өдрүүд дэх Түүний ажил, Түүний Хоёр дахь Ирэлтийн тухай бидэнд илүү ихийг заадаг.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 101

Асар (ш. 23)— Их Эзэний орших газар

Гэтэлгэл (шүлэг 43, 76)— Сэргээлт, аврал

Арилжаачид (ш. 49)— Банкны эзэд, хөрөнгө оруулалт хийдэг хүмүүс

Миний өс хонзонг ав (шүлэг 58, 83)—Шударга шүүлтэд авчир

Зэрлэг өвс (шүлэг 65–66)— Тариан талбай дахь зэрлэг ургамал


Даамлууд (ш. 90)—Ямар нэг зүйлийн төлөө хариуцлага хүлээдэг хүмүүс

Сургаал ба Гэрээ 101—р хэсгийн тойм—1833 оны арванхоёрдугаар сард Гэгээнтнүүд хаана байсан бэ?



Сургаал ба Гэрээ 101:21–22—Сионы гадаснууд

Дэлхий дээрх Их Эзэний хаант улсыг заримдаа гадсуудаар бэхлэгдсэн майхантай зүйрлүүлсэн байдаг (жишээ нь, Исаиа 54:2; Моронай 10:31-ийг үз). Сүм нь, майхны адилаар, аюулгүй байдал, хоргодох газар болдог бөгөөд гадсууд буюу бие биендээ зааж, бие биенээ дэмжихээр цугладаг Гэгээнтнүүдийн бүлгүүдээр бат бөх бэхлэгдсэн байдаг (С ба Г 45:66–67; 82:14-ийг үз). Сүм дэлхий даяар тархан, дэлхийг бүрхэж байна.



Сүмийн бүх гишүүд Миссурийн Жаксон гүнлэгт цуглахгүй. Учир нь тэнд хангалттай зай байхгүй байх болно гэдгийг Сургаал ба Гэрээ 101-р хэсэгт Их Эзэн харуулсан билээ. Үүний оронд гишүүд Сионы гадаснуудад цугларах ёстой байв. Тэдгээр гадаснууд бол бас Сионы төв газарт амьдардаг хүмүүстэй нэгэн адил Сүмийн гишүүд адислалуудыг хүлээн авдаг “ариун газрууд” юм (мөн С ба Г 115:5–6-г үз).

Сургаал ба Гэрээ 101:30—“Модны нас”

Мянган Жилийн үед “хүмүүс өндөр настай болтлоо үхэхгүй болно. Хүүхдүүд үхэхгүй, бүр модны насыг насална. Энэ бол 100 жил юм гэж Исаиа хэлсэн байдаг хэмээн Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит заажээ [Исаиа 65:20–22-ыг үз]” (Doctrines of Salvation, 1:86–87).

Сургаал ба Гэрээ 101:39–40—Амтаа алдсан давс

Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн гишүүн асан, Ахлагч Карлос И.Асей санваар эзэмшигчдийн тухай өгүүлсэн нь:

“Цаг хугацаа өнгөрлөө ч гэсэн давс амтаа алддаггүй гэж дэлхийд нэрд гарсан нэгэн химич надад ярьж билээ. Амт нь юм холих буюу бохирдуулснаар алдагддаг. Үүний адилаар, санваарын хүч нь цаг хугацаа өнгөрснөөр сарниж замхардаггүй. Санваарын хүч нь бас юм холих буюу бохирдуулснаар алдагддаг.

“Залуу эр хүн болон нас ахимаг эр хүн ухаан бодлоо порнографийн ном зохиолтой хольсон үед амтаа алддаг.

“Санваар эзэмшигч худал хэлэх эсвэл хэл яриагаа бүдүүлэг үг хэллэгтэй холих үед амтаа алддаг.

“Бидний хэн нэг нь олон түмнийг дагаж, ёс суртахуунгүй үйлдлүүдэд оролцож, мансууруулах бодис, тамхи, архи, хор хөнөөлтэй бусад бодисууд хэрэглэсэн үед амтаа алддаг.” (In Conference Report, 1980 оны 4-р сар, 60; Ensign, 1980 оны 5-р сар, 42)

Сургаал ба Гэрээ 101:81–90—Нэг эмэгтэй ба шударга бус шүүгчийн тухай сургаалт зүйрлэл

Сургаал ба Гэрээ 101-р хэсгийг хүлээн авсны дараа, Сүмийн удирдагчид орон нутгийн шүүгчдээс тусламж хүсчээ. Харамсалтай нь, тэднээс олон нь Гэгээнтнүүдийг уугуул нутаг ус, унасан газар дахь гэр орноос нь хөөсөн танхайрагчид байсан аж. Дараа нь тэд Миссурийн захирагч Данклины өмнө очиж, юмсыг зөв болгон залруулахыг түүнээс хүсэв. Ямар буруу зүйлүүд болсон гэж бодож байгаагаа бичгээр баримтжуулахыг захирагч тэдэнд зөвлөв. Сүмийн удирдагчид тэр дагуу хийж, эргээд захирагч дээр очсон аж. Тэгэхэд нь Даклин тэдэнд аар саар зүйлээр тусалсан байна. Таван жилийн дараа Гэгээнтнүүд Миссури мужаас хөөгдсөн юм. Тэгэхэд Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч Мартин Ван Буренд гомдол мэдүүлж, давж заалдав. Бошиглогч Иосеф Смит өөрөө эл хэргийг Ерөнхийлөгчид мэдүүлжээ. “Намайг тэнд байх үеэр надад туйлын хүндэтгэлгүйгээр хандсан Ерөнхийлөгч Мартин Ван Бурентэй би ярилцлаа. Тэрээр бидний үгсийг ихэд дурамжхан сонсов. Тэрээр сонсож дуусаад: “Эрхэм ээ, мэдүүлж байгаа хэрэг чинь шударга юм байна. Гэвч би таны төлөө юу ч хийж чадахгүй нь. Хэрэв би таныг бодож ямар нэг арга хэмжээ авах юм бол би Миссурийн саналыг алдана шүү дээ” гэв хэмээн Бошиглогч тэмдэглэжээ (History of the Church, 4:80).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 101-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас дөрвийг хий.

А Өгүүлбэрүүдийг төгсгө

Сургаал ба Гэрээ 101:1–9-өөс сурч мэдсэн зүйлээ ашиглан, дараах өгүүлбэрүүдийг төгсгө:

1. Их Эзэн Миссури дэх Гэгээнтнүүдийн мөрдлөг хавчлагыг хүлцэн тэвчсэн юм. Учир нь . . .
2. Миссурийн Гэгээнтнүүдийн алдааг Их Эзэн эс хайхран, . . . бодолтой байжээ.
3. Бошиглогч Абрахамын адил, Сүмийн гишүүд . . . байх ёстой.
4. Хэрэв Сүмийн гишүүд шүүмжлэлийг хүлцэн тэвчиж чадахгүй бол, тэд . . . чадахгүй.
5. Миссури дэх Гэгээнтнүүд . . . гэм буруутай байв.
6. Миссури дэх Гэгээнтнүүд Бурханыг сонсож дагахдаа удаан байв, иймээс Тэрээр . . .
7. Амьдрал хөнгөн байхад Сүмийн зарим гишүүд Их Эзэнийг сонсдоггүй, харин амьдрал хүнд хэцүү болоход . . .
8. Миссурийн Гэгээнтнүүдийн бүтэлгүйтлийг эс харгалзан, Их Эзэн . . . болно.

Б Есүс Христийн Хоёр дахь Ирэлт

Сион үндэслэн байгуулагдах нь хэвээр байна. Эцсийн эцэст сайн нь мууг ялан дийлнэ. Мөн Тэрээр дэлхийд эргэн ирж, зөв шударгын Мянган Жилийн үүд хаалгыг нээнэ гэдгийг Их Эзэн Сургаал ба Гэрээ 101-р хэсэгт нотолсон билээ. Христийн Хоёр дахь Ирэлт болон Мянган Жилийн тухай Сургаал ба Гэрээ 101:23–35-аас хариулж болох таван асуулт бич. Асуулт бүрийн дараа хариултыг тэмдэглэхдээ шүлгийг хаанаас авсныг заа.

В Бэлгэдлийг тайлбарла


Сургаал ба Гэрээ 101:39–40-д Их Эзэн Өөрийн хүмүүсийг давстай зүйрлүүлжээ. Давсыг хэрэглэдэг янз бүрийн аргын тухай бодож, Сүмийн гишүүд давстай адилхан байх ёстой хоёр арга замын тухай бич (мөн С ба Г 101:39–40-ийн “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз).

Г Орчин үеийн сургаалт зүйрлэл бич

1. Сургаал ба Гэрээ 101:43–62 дахь язгууртан ба чидуны моддын тухай сургаалт зүйрлэлийг судалсны дараа, үүнтэй адилхан захиас бүхий орчин үеийн нэг сургаалт зүйрлэл бич. Сургаалт зүйрлэлдээ дараах бүрдүүлбэр хэсгүүдийн шинэчилсэн хувилбарыг оруул:

Хүмүүс	Газрууд	Үйл явдлууд
1. Язгууртан	1. Жимсний цэцэрлэг	1. Арванхоёр мод тарь гэж үйлчлэгчдэд хэлжээ
2. Үйлчлэгчид	2. Чидуны модод	2. Аюулаас сэргийл гэж харуулуудад хэлэв
3. Харуулууд	3. Цамхаг	3. Тэд чидуны модод тарив
4. Дайсан	4. Шивээ	4. Энх тайван цаг байхад яагаад харуул хэрэгтэй юм бол гэж тэд гайхжээ
		5. Тэд залхуу, дуулгаваргүй боллоо
		6. Дайсан жимсний цэцэрлэгийг устгав
		7. Язгууртан зарц нартаа уурлав
		8. Жимсний цэцэрлэгийг сэргээв
		9. Дайсны хүчирхэг бэхлэлтийг эвдэв

2. Дараах асуултуудад хариулахдаа язгууртан ба чидуны моддын тухай сургаалт зүйрлэлийг ашигла:
 - а. Та нарын насны Сүмийн гишүүд энэ сургаалт зүйрлэл дэх зарц нартай хэрхэн адилхан байж болох вэ?
 - б. Харуулууд хэнийг төлөөлж болох вэ?
 - в. Цамхаг юуг төлөөлж болох вэ?



Д Одоо яах вэ?

Их Эзэн Сүмийн гишүүдийг дайснуудынх нь эсрэг адислахуйцаар дуулгавартай байгаагүй. Тиймээс тэд мөрдлөг хавчлагад өртсөн билээ. Сүмийн гишүүд яах ёстой байсан бэ? Сионоос болон гэр орноосоо хөөгдсөн Гэгээнтнүүдэд зориулсан зөвлөгөөг Сургаал ба Гэрээ 101:63–101 агуулдаг. Их Эзэний зөвлөгөөг гишүүдэд зориулсан сануулагч байхаар жагсаалт болгож, нэгтгэн дүгнэ.

Е Нэгдсэн Улсын Үндсэн Хууль

Сургаал ба Гэрээ 101:77–80-д Нэгдсэн Улсын Үндсэн Хуулийг юун дээр тулгуурласан гэж Их Эзэн хэлсэн талаар гурван нотолгоо бич.

Ё Анхны асуултуудад хариул

Энэ илчлэлт өгөгдөхөөс өмнө Бошиглогч Иосеф Смит, Их Эзэнээс юуны талаар мэдэхийг хүсч байсныг ойлгоход бидэнд туслах нэг эшлэл эл судлах гарын авлагын Сургаал ба Гэрээ 101-р хэсгийн оршилд байдаг. Бошиглогчийн мэдэхгүй байсан хоёр зүйлд өгсөн Их Эзэний хариултуудыг нэгтгэн дүгнэ.

Сургаал ба Гэрээ 102

Дээд Зөвлөлүүд ба Сүмийн
сахилга бат



Бошиглогч Иосеф Смит хэдийгээр Сүмийг зохион байгуулахын өмнө Сүмийн удирдлагад шаардлагатай санваарын түлхүүрүүдийг Петр, Иаков, Иохан нараас хүлээж авсан ч (С ба Г 27:12–13), Сүмийн гишүүнчлэл өсөхийн хэрээр Сүмийг хэрхэн зохион байгуулж, удирдах талаар Их Эзэн улам олон зүйлийг илчилжээ. Жишээ нь, 1830 онд Сүмийн ерөнхий удирдлага нь Сүмийн Нэгдэх Ахлагч, Хоёр дахь Ахлагч хоёроос (Иосеф Смит, Оливер Каудери хоёр) бүрдэж байв. 1832 онд Дээд Санваартны Ерөнхийлөгчийн Зөвлөл зохион байгуулагдаж (С ба Г 81-р хэсгийг үз), уг Ерөнхийлөгчийн Зөвлөл нь 1833 онд Сүмийн Тэргүүн Зөвлөл болжээ. Сургаал ба Гэрээ 102-р хэсэг өгөгдөхөд Сүм 3,000 орчим гишүүнтэй байсан нь өнөөдрийн нэг гадасны орчим хэмжээ юм. Ийнхүү Сүмийн анхны дээд зөвлөлийг зохион байгуулахад Их Эзэн Бошиглогч Иосеф Смитийг чиглүүлснээр, өсөн хөгжиж байгаа Өөрийн Сүмийг удирдах талаар нэмэлт илчлэлт өгчээ.

Сүмийн энэхүү анхны дээд зөвлөлийг Тэргүүн Зөвлөл удирдаж, нийт Сүмийн талаарх асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэдэг байв. Гэвч бусад гадаснууд зохион байгуулагдсан үед Сүмийн “Тэргүүлэх Дээд Зөвлөлийн” (С ба Г 107:33-ыг үз) тухай илчлэлтийг Их Эзэн өгчээ. Энэ нь Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга байсан бөгөөд нийт Сүмийн хэмжээний асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэдэг бол, гадас бүрд “байнгын дээд зөвлөл” нь (С ба Г 107:36-г үз) зөвхөн тухайн гадсанд хамаарах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэдэг.



Өнөөдөр, Сүмийн гадас бүрийг гадасны ерөнхийлөгч хоёр зөвлөхийнхөө хамт тэргүүлдэг бөгөөд Сургаал ба Гэрээ 102-р хэсэгт өгөгдсөн загварын дагуу тэдний ажил үүрэгт гадасны дээд зөвлөл тусалдаг. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад болон Тэргүүн Зөвлөлийн зөвлөхөөр насан туршидаа үйлчилсэн, Ерөнхийлөгч Стефен Л.Ричардс: “Манай Сүмийн жинхэнэ удирдлага нь зөвлөлүүдээр дамжин хэрэгждэг удирдлага мөн” гэж хэлжээ (In Conference Report, 1953 оны 10-р сар, 86).

Өнөөдөр, Сүмийн гадас бүрийг гадасны ерөнхийлөгч хоёр зөвлөхийнхөө хамт тэргүүлдэг бөгөөд Сургаал ба Гэрээ 102-р хэсэгт өгөгдсөн загварын дагуу тэдний ажил үүрэгт гадасны дээд зөвлөл тусалдаг. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад болон Тэргүүн Зөвлөлийн зөвлөхөөр насан туршидаа үйлчилсэн, Ерөнхийлөгч Стефен Л.Ричардс: “Манай Сүмийн жинхэнэ удирдлага нь зөвлөлүүдээр дамжин хэрэгждэг удирдлага мөн” гэж хэлжээ (In Conference Report, 1953 оны 10-р сар, 86).

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 102

Сургаал ба Гэрээ 102:2, 12–33—“Чухал учир холбогдолтой бэрхшээлүүдийг шийдвэрлэх нь”

Дээд зөвлөл нь Сүмийн хөтөлбөрүүдийг зохион байгуулахад тусалдагас гадна Сургаал ба Гэрээ 102-р хэсэгт тодорхойлсон загварыг баримтлан-Сүмийн сахилгын асуудлуудад Ерөнхийлөгчийн Зөвлөлд тусалдаг. Нэмэлт зааврууд Сүмийн Заавруудын Гарын Авлагад байдаг. Завхайрал, садар самууныг үйлдэх, ижил хүйстэнтэй хурьцах, үр зулбуулах, гэмт хэрэг, урвалт, хүүхэд эсвэл эхнэр, нөхөртэйгөө зүй бусаар харьцсан зэрэг сайн мэдээний зарчмуудыг гишүүн ноцтойгоор зөрчсөн тохиолдолд Сүмийн сахилгын зөвлөл хуралддаг. Зарим сахилгын зөвлөл тойргийн эсвэл салбарын түвшинд болдог бол илүү ноцтой хэргүүдийг гадасны болон дүүргийн түвшинд авч хэлэлцдэг. Сүмийн эдгээр зөвлөлүүд Есүс Христийн Цагаатгалаар дамжуулан нүгэлтнийг наманчлалд авчрахыг хичээхийн хамт Сүмийн ёс суртахууныг сахиж, гишүүдээ хамгаалахыг зорьдог.

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 102-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий.

А Орлох тогтолцоо

Сургаал ба Гэрээ 102:9–11 нь Сүмийн Ерөнхийлөгчид холбогдоно. Энэ нь бас гадасны ерөнхийлөгчид ч хамаарч болно. Эдгээр шүлэгт өгүүлснээр, хэрэв ерөнхийлөгч зөвлөлд ирж оролцох боломжгүй байвал яах вэ?

Б Юу болдог вэ?

Сургаал ба Гэрээ 102:13–29 дээр тулгуурлан, гадасны сахилгын зөвлөлд юу болдгийг нэгтгэн дүгнэ.

Сургаал ба Гэрээ 103

Сион гэтэлгэгдэх үү?



Миссурийн Жаксон гүнлэг дэх Гэгээнтнүүд 1833 онд зүсэн зүйлийн мөрдлөг хавчлагад өртөв. 1834 онд Миссури дэх Сүмийн гишүүд өөрсдийнхөө байдлын талаар Бошиглогч Иосеф Смитээс удирдамж хүсч, Парли П.Пратт, Лайман Вайт хоёрыг Огайогийн Кертланд руу явуулав. Энэ хоёр хүн хурч ирэн Бошиглогчид илтгэсний дараа Сургаал ба Гэрээ 103-р хэсэг өгөгдсөн ажээ.

Сионоос Гэгээнтнүүдийг хөөхийг дайснуудад нь зөвшөөрсний зарим шалтгааныг Их Эзэн Сургаал ба Гэрээ 101-р

хэсэгт тайлбарласан ч, Сүмийн удирдагчид, гишүүдэд янз бүрийн асуулт бас л байсаар байв. Ялангуяа тэдний зарим нь Сургаал ба Гэрээ 101:55–60 дахь Их Эзэний амлалтыг биелүүлж чадах болов уу гэдгийг, “[Түүний] өргөөний хүч чадал” нэгэн цагт ирж, Сионыг гэтэлгэх үү гэдгийг мэдэхийг хүсч байв. Сургаал ба Гэрээ 103-ын сүүлчийн хэсэг нь энэ асуултын хариу болж ирсэн бөгөөд Сионы Хуаран хэмээн нэрлэгдсэн-Бошиглогч Иосеф Смитийн удирдлага дор урагшилсан алхалж, Сионыг гэтэлгэхийн төлөө тулалдаж, амь насаа өгөхөд бэлэн 11 эмэгтэй, 11 хүүхэд дагалдсан 207 эрчүүдийн бүлэг билээ.



Сургаал ба Гэрээ 103-р хэсгийг судлахдаа, энэ илчлэлтийн эхний хэсэгт Их Эзэний хэлсэн зүйлд, түүнчлэн Сион цэргийн хүчээр гэтэлгэгдэхгүй нь тодорхой юм гэдэгт онцгой анхаарал тавь. Зөрчлийн улмаас Сион алдагдсан агаад Сион зөв шударга байдлаар гэтэлгэгдэх ёстой. Хэдийгээр энэ илчлэлт эхэн үеийн Гэгээнтнүүдэд тэдний цаг үе, нөхцөл байдлын талаар зөвлөгөө өгсөн ч, уг хэсэгт агуулагддаг зарчмууд нь бидэнд ч мөн хамаатай юм. Бид өнөө үеийн бошиглогчдын удирдлага дор Сионд хамаарах бүх зүйлийг хэрэгжүүлэхийн төлөө Сионыг сэргээж, өөрсдийгөө бэлтгэх ёстой.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 103

Сунгасан гар (ш. 17)—
Бурханы идэвхтэй оролцоо
буюу хүчийг Түүний хүмүү-
сийн төлөө ашигласны бэл-
гэдэл утга
Өс хонзон (шүлэг 25–26)—
Шударга шийтгэл

Сургаал ба Гэрээ 103:15–16—Сионыг гэтэлгэхийн тулд Мосе шиг нэг хүнийг Их Эзэн дээш нь бэлтгэх болно

Сүмийн Ерөнхийлөгч бол Мосе шиг (С ба Г 28:2; 107:91-ийг үз) хүн юм хэмээн Сургаал ба Гэрээ заадаг.

Сургаал ба Гэрээ 103:20—Сионыг гэтэлгэх хүмүүсийн өмнө, мөн тэдэнтэй хамт Их Эзэний оршихуй явах болно

Их Эзэний оршихуй нь үүнийг эдлэх зохистой хүмүүст л боломжтойг онцлон тэмдэглэх нь чухал юм (С ба Г 100:13-ыг үз). Тиймээс, энэхүү онцгой боломжийн төлөө сүнслэг байдлын хувьд өөрсдийгөө бэлтгэсэн хүмүүсийн дунд эл илчлэлт гүйцэлдэнэ.

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 103-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас гурвыг хий.

А Юу тохиолдсон бэ? Юу тохиолдох вэ?

Их Эзэн Гэгээнтнүүдийн дайснуудын нүгэл, бас Гэгээнтнүүдийн өөрсдийнх нь нүглийн тухай Сургаал ба Гэрээ 103:1–14-т өгүүлсэн байдаг. Эдгээр шүлгүүдэд өгүүлсэн зүйл дээр тулгуурлан, дараах асуултуудад хариул:

1. Гэгээнтнүүдийн дайснууд юу хийсэн бэ? Их Эзэн яагаад үүнийг хүлцсэн бэ?
2. Гэгээнтнүүдийн дайснуудад юу тохиолдох вэ?
3. Хэрэв Гэгээнтнүүд зарлигуудыг сахих юм бол Их Эзэн тэдэнд юу амласан бэ?
4. Хэрэв тэд зарлигуудыг сахихгүй бол тэдэнд юу тохиолдоно гэж Их Эзэн сэрэмжлүүлсэн бэ?

Б Холбоог тогтоо

Та нарын судрууд дахь зүүвэр тайлбарууд нь Сургаал ба Гэрээ 35:24-ийг Сургаал ба Гэрээ 103:7, Сургаал ба Гэрээ 58:4, Сургаал ба Гэрээ 103:12-той харьцуулах эшлэлүүд болгон өгдөг. Харьцуулах эшлэлүүдийг уншиж, эдгээр нь Сургаал ба Гэрээ 103-р хэсэг дэх шүлгүүдтэй хэрхэн холбогдохыг тайлбарла.

В Харьцуул

Их Эзэн Сургаал ба Гэрээ 103:15–21-д Сүмийн Ерөнхийлөгчийг Мосетой (мөн С ба Г 28:2; 107:91-ийг үз) зүйрлүүлжээ. Сүмийн Ерөнхийлөгч Бурханы хүмүүсийг “Мосегийн адилаар” удирддаг арга замуудыг жагсаан бич.

Г Элсүүлэх зарлал гарга

Сургаал ба Гэрээ 103-р хэсэг хүлээн авагдсаны дараа, Сүмийн удирдагчид Сионы Хуаранд элсэлт авч эхэлжээ. Сургаал ба Гэрээ 103:22–36-д мөн эл судлах гарын авлагын Сургаал ба Гэрээ 103-р хэсгийн оршилд өгүүлсэн зүйлүүдийг уншаад, чи өөрийгөө Огайогийн Көртланд дахь Сионы Хуарангийн хүмүүс элсүүлэх хороонд байсан гэж бод. Энэхүү онцгой армид нэгдэхийг хүмүүст уриалсан зарлалын төслийг тэмдэглэлийн дэвтэртээ хий.

Сургаал ба Гэрээ 104 “Миний өөрийн аргаар”



1832 онд Сургаал ба Гэрээ 104-р хэсэг дэх илчлэлтийг өгөхөөс хоёр жилийн өмнө, Их Эзэн Огайо, Миссури дэх Сүмийн удирдагчдыг “нэгдсэн журамд” зохион байгуулжээ (С ба Г 82:11–12-ыг үз). Нэгдсэн журам нь өргөлийн хуультай адилхан байгаагүй аж. Энэ бол өргөлийн хуулийг практикт хэрэгжүүлэх нэг арга зам байв.

Огайогийн Көртланд дахь эдийн засгийн бэрхшээлүүд болон Миссури дахь мөрдлөг хавчлага нь нэгдсэн журмыг анх зохион байгуулсан байдлаар нь цаашир үргэлжлүүлэхэд улам ихээр хүндрэлтэй болгов. Юу хийх ёстойг Сүмийн удирдагчид авч үзэхийг Их Эзэн Сургаал ба Гэрээ 104-р хэсэгт өгчээ. Тэрээр энэ илчлэлтэд өргөлийн хуулийн зарим чухал зарчмуудыг тоймлон үзэж, тухайн үед Сүмд тулгарч байсан бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд Миссури, Огайогийн удирдагчдыг тус тусдаа журам буюу байгууллага болгон салгаж нэгдсэн журмыг өөрчлөн зохион байгуулжээ. Анхны нэгдсэн журамд оролцсон Сүмийн удирдагчид туршилагаасаа их зүйлийг суралцаж, өргөлийн хуулийг шинэ арга замаар хэрэглэхэд бэлтгэгдсэн байлаа.



Сүм эдүгээ нэгдсэн журмыг эхэн үеийнх шиг тийм байдлаар зохион байгуулдаггүй. Өнөөдөр бид Сүмийн санхүүгийн хэрэгцээг аравны нэг болон бусад өргөл, түүний дотор мацгийн өргөлийн төлбөрөөр хийдэг. Бид хүмүүнлэгийн тусламжууд болон гишүүдийн хандивын сангуудаар дамжуулан бусдад тусламж үзүүлдэг. Сургаал ба Гэрээ 103-р хэсэгт заасан зарчмууд нь бид “[Их Эзэний] арга замаар” (С ба Г 104:16) өнөөдөр аравны нэг болон өргөлүүдийг төлөхөд хамаатай юм.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 104

Даамал (шүлэг 13, 56–57, 74, 77, 86)—Ямар нэг ажил үүргийн төлөө хариуцлага хүлээдэг хүн

Ажил үүрэг (шүлэг 11–12, 20, 22, 24, 30, 32, 37, 40–41, 44, 54, 63, 68, 72–73, 75)—Даамлын хариуцдаг ажил үүрэг

Худалдааны байгууламж (шүлэг 39–41)—Төрөл бүрийн барааны дэлгүүр

Сан хөмрөг (шүлэг 60–62, 64–69, 71)—Мөнгө болон бусад үнэт зүйлсийг хадгалдаг газар

Сургаал ба Гэрээ 104:13–18, 55–56—Бүх зүйл Их Эзэнийх юм

Бидэнд байгаа юм бүхэн Их Эзэнээс ирдэг бөгөөд Түүнийх гэдгийг заримдаа бид хэрхэн мартдагийг харуулсан дараах түүхийг тухайн үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан Ахлагч Спенсер В.Кимбалл ярьсан юм:

“Нэг өдөр найз маань намайг өөртэйгөө хамт ферм рүүгээ очихыг хүсэв. Тэр цоо шинэхэн машиныхаа хаалгыг нээж,

жолооныхоо ард суугаад, ‘Миний шинэ машин чамд ямар санагдаж байна?’ гэж асуулаа. Бид тансаг сайхан агааржуулагчтай, туйлын тохилог машин дотор хөдөөгийн үзэсгэлэнт эдлэн газар руу салхи татуулан давхиж явлаа. Тэгснээ найз маань, ‘Энэ бол миний гэр’ . . . хэмээн нэлээд бардмаар өгүүлэв.

“ . . . Найз маань гараа алдлан өргөн дэлгэж занган, ‘Тэр бөөн моддоос нуур хүртэл, нуурын цаадах толгод хүртэл, бас фермийн барилгууд хүртэл энэ бүгдийн хоорондох бүх юмс минийх шүү дээ хэмээн онгиrow. Нугын дунд бэлчих үхэр сүрэг ч бас минийх.’ . . .

“Энэ бол олон жилийн тэртээ болсон явдал. Хожим нь би найзыгаа орд харш мэт орон гэртээ тансаг тавилгуудынхаа дунд үхлүүт хэвтэж байхыг нь харж билээ. . . . Би түүний оршуулгын ёслол дээр үг хэлээд тэрээр өөрийгөө оршуулаарай гэж захисан нилээд сайн газар болох өндөр бүдүүн том биетэй хүний хэмжээтэй, жижигхэн тэгш өнцөгт газар дээрээс хөдөлсөн оршуулгын цувааг даган явж билээ.

“Саявтархан би нөгөөх эдлэн газрыг харлаа, тариа алтран шаргалтаж, намгийн хөвд ногоорон, хөвөнгийн тариалан цас мэт цайран, эдлэн газрыг өөрийнх нь хэмээн бардамнан хэлж байсан нөгөөх хүнд огт хамаагүй юм шиг санагдав” (Faith Precedes the Miracle [1972], 281–284).

Сургаал ба Гэрээ 104:78–83—“Бүх өрөө төл”

Ерөнхийлөгч Хебер Ж.Грант: “Хэрэв хүмүүний зүрх сэтгэлд, гэр бүлд амар амгалан, сэтгэл ханамж авчирдаг ямар нэг зүйл байдаг бол, энэ нь бид нөөц боломжийнхоо хүрээнд багтаан амьдрах явдал мөн. Хэрэв ямар нэг ядаргаатай, урам хугалдаг, сэтгэл санааг мохоодог зүйл байдаг бол энэ нь дааж давшгүй өр төлбөр юм” гэжээ (Нийгмийн Халамжийн Бүлгийн Чуулган дээр хэлсэн үгнээс [1932 оны 4-р сарын 6], Relief Society Magazine, 1932 оны 5-р сар, 302).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 104-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас гурвыг хий.

А Түлхүүр үгсийг сонго

Гэрээгээр зөрчдөг хүмүүст Их Эзэн Сургаал ба Гэрээ 104:1–10-т ноцтой сэрэмжлүүлэг өгчээ. Их Эзэний заасан зүйлээс өөрийн чухал гэж бодсон таван үгийг дээрх шүлгүүдээс сонго. Үг бүрийг тэмдэглэлийн дэвтэртээ бичиж, эдгээр үгс яагаад чухал гэж бодож байгаагаа тайлбарла.

Б Их Эзэний зам, Хэсэг 1

Олон хүмүүс хоол хүнс, орон байр, эмнэлгийн үйлчилгээ, бусад зүйлс дутагдсанаас зовж зүдэрдэг. Эдгээр асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар олон санаа оноонууд байдаг. Сургаал ба Гэрээ 104:11–18-д эдгээр асуудлуудыг шийдвэрлэх арга замууд Өөрт нь байдаг гэж Их Эзэн хэлжээ.

1. Энэ шүлгүүдийг анхааралтай уншиж, дараах зүйлүүдийг тэмдэглэлийн дэвтэртээ жагсаан бич:
 - a. Гачигдалтай хүмүүсийг халамжлахыг ойлгох нь чухал хэмээн Их Эзэний хэлсэн үгнүүд.
 - b. Хэрэв бидний олонх нь хэрэгжүүлэх юм бол одоогийн асуудлуудад чухал өөрчлөлт гаргаж болох хандлага.
 - v. Эдгээр асуудлыг шийдвэрлэж болох үйл ажиллагаанууд.

2. Дээрх шүлгүүдэд Их Эзэний зөвлөсөн зүйлүүдийг хийх боломжийг Сүм бидэнд олгодог наад тал нь гурван арга замыг нэрлэ.

В Схемийг бөглө

Их Эзэн анхны нэгдсэн журмыг өөрчлөн зохион байгуулсан ч өргөлийн болон ажил үүргийн мөнхийн зарчмуудыг өөрчлөөгүй юм. Сургаал ба Гэрээ 104:19–46-д Их Эзэн нэлээд хэдэн ах нарт ажил үүргийнх нь талаар тусгай заавруудыг өгсөн байна. Дараахтай төстэй схемийг тэмдэглэлийн дэвтэртээ хийж, Сургаал ба Гэрээ 104-р хэсгээс уншсан зүйлээсээ бөглө.

Сургаал ба Гэрээ 104	Хүн	Зааврууд	Амлалт
шүлэг 20–23			
шүлэг 24–26			
шүлэг 27			
шүлэг 28–33			
шүлэг 34–38			
шүлэг 39–42			
шүлэг 43–46			

Г Их Эзэний зам, Хэсэг 2

Хүмүүс өртэй болсон үедээ заримдаа энэхүү боолчлолоос амархан, хурдан, эсвэл гайхалтай арга замаар гарахыг эрж хайдаг. Тэд их хэмжээний өрийг төлж дуусгах нь хэцүү бөгөөд олон жилийг авах нь гэдгийг ухамсарлан сэтгэлээр унаж гутардаг. Их Эзэн өрнөөс гарах Өөрийн арга замыг амар хялбар, эсвэл түргэн байх албагүй, харин баттай арга замыг Сургаал ба Гэрээ 104:78–83-г зааж өгчээ. Өрнөөс гарах Их Эзэний зөвлөгөөг өнөөдөр бид хэрхэн хэрэглэж болохыг тэмдэглэлийн дэвтэртээ тайлбарла.



Их Эзэн Сионы Хуаран буюу Миссури рүү аян хийж, гэр орноосоо хөөгдсөн Гэгээнтнүүдэд туслах бүлгийг зохион байгуулах тушаалыг Сургаал ба Гэрээ 103:22–35-д өгчээ (эл судлах гарын авлагын С ба Г 103-р хэсгийн оршлыг үз, х.00 117). Миссурийн захирагч Данклин тус мужийн цагдаагийн газар, гэр орон, өмч хөрөнгө, ажил төрлөө эргүүлэн авахад нь тусална гэж Гэгээнтнүүдэд амласан байна. Жаксон гүнлэгт эргэж ирсний дараа тэдний эрхийг хамгаалах өөрсдийн сайн дурын цагдаагийн алба тэдэнд

хэрэгтэй байж болох юм гэж тэр бас зөвлөсөн аж. Сионы Хуаран нь эл цагдаагийн алба болох учиртай байв.

Гэвч дайснуудынх нь дарамт шахалтын улмаас Гэгээнтнүүдэд туслахын тулд мужийн цагдаагийн газрыг ашиглах тухай бодлоо захирагч өөрчилсөн ажээ. Тэрээр энэ шийдвэрийг гаргах үед, Сионы Хуаран Миссурийн зүг аль хэдийн хөдөлсөн байв. Сионы Хурангийн гишүүн асан, хожим нь энэ эрин үеийн анхны Төлөөлөгчдийн нэг болсон Парли П.Пратт Миссурид ирснийхээ дараа: “Бидний шаардлага шударга гэдгийг шууд хүлээн зөвшөөрсөн боловч, энэ талаар хуулиудыг хэрэглэж зүрхлэхгүй байгаагаа бидэнд илэн далангүй ярьсан Захирагчтай бид ярилцав. Учир нь тэрээр улс орныг нийтэд нь иргэний дайн, цус урсгалтад живүүлэхээс айж байсан аж. Энх амгалангийн төлөө эрхээсээ татгалзаж [бууж өгөх] хөөгдсөн газраа зарахыг тэрээр бидэнд зөвлөмж болгов” гэжээ (Парли П.Праттын намтар [1985], 94).

Сионы Хуарангийн хүмүүс өлсөж, цангаж, хахир хатуу цаг агаар, өвчин эмгэгт нэрвэгдэн, 1609 орчим километр урт аяныхаа бүх үед орон байраар дутагдаж байв. Хэрээс хэтэрсэн их хүч чармайлт, түмэн бэрхшээлийн дараа аянаа зогсоох тухай бодох нь тэдний хувьд хэцүү байв. Бошиглогч Иосеф Смит Их Эзэний зөвлөгөөг эрэлхийлж, ингээд Сургаал ба Гэрээ 105-р хэсэг дэх илчлэлт иржээ. Уг илчлэлтэд, Сион тэр үед яагаад гэтэлгэгдээгүй тухай, мөн Сион гэтэлгэгдэхийн өмнө юу тохиох ёстой талаар нэмэлт мэдээллийг Их Эзэн өгчээ. Эл илчлэлтэд Сионы Хуарангийн гишүүдийн хийсэн золиослолыг Тэрээр хүлээн авснаа, мөн хийхийг хүссэн зүйлийнх нь төлөө тэднийг адисална гэдгийг Их Эзэн бас хэлсэн байна. Нэг жилийн дараа Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга болон Далын Нэгдүгээр Чуулга зохион байгуулагдахад тэдний дийлэнх нь Сионы Хуаранд аян хийж, итгэлээ нотлон харуулсан, аяны бүх үеийн туршид Бошиглогч Иосеф Смитээс суралцан түүнийг харж ажиглахад бүх цаг заваа зориулсан эрчүүд байлаа’.

Та нар сайн дураараа 1609 километр газар явган аян хийх үү? Зарим үед бид сайн дураараа хүнд хүчир ажил хийж бусдад тусалсан үед улам их зүйлийг сурч мэддэг. Сүмийг удирдах онцгой эрчүүд Их Эзэнд хэрэгтэй байсан юм. Сорилтыг туулж, уг ажилд туслах шийдвэр төгс байдлаа нотлон харуулах боломжийг хамгийн их итгэлтэй үнэнч дэмжигч нарт Сионы Хуаран олгосон ажээ. Өнөөдөр ирээдүйн удирдагчдыг бэлтгэдэг зарим туршилага юу вэ?

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 105

Хишиг хүртээх (хүртээгдэх), хишиг (ариун сүмийн) (шүлэг 11–12, 18, 33)—Сүнсний бэлэг хүртэх (хүртээх)

Доромжлох (ш. 15)—Ариун зүйлүүдийг тохуурхах



Сургаал ба Гэрээ 105—р хэсгийн тойм-Сионы Хуарангийн товч түүх

Сионы Хуаранд хүмүүсийг элсүүлэх талаар Их Эзэн зөвлөгөө өгсний дараа (С ба Г 103-р хэсгийг үз), Сүмийн удирдагчид бэлтгэлийг цаг алдалгүй хийжээ. Миссури дахь Гэгээнтнүүдэд үлэмж аюулыг араасаа дагуулах танхайрагч бүлгүүд балмад хэрцгийгээр харьцаж, тэрхүү үйлдлээ давтахаар заналхийлж байсан тэр үед Огайогийн Көртландад олон хүмүүс зоригтойгоор Сионы Хуаранд сайн дураараа элсэж байлаа. Энэ эрин үеийн анхны Төлөөлөгчдийн нэгээр дуудагдсан Хебер К.Кимбалл тэр цаг үе дэх олон хүний бодол санааг илэрхийлэх: “Бид аянаа (1834 оны) тавдугаар сарын 5-нд эхэлсэн бөгөөд энэ нь миний хувьд баяр ёслолын өглөө байлаа. Би эхнэр, хүүхэд, найз нараа орхин явахдаа, намайг мөн ах нарыг ч гэсэн, орон даяар дайснауд биднийг устгаж, биднийг газрын хөрснөөс арчин зайлуулахаар заналхийлж байсан болохоор, ойр дотны хүмүүстэйгээ амьд мэнд уулзах эсэхээ мэдэхгүй байлаа” (Оорсон Ф.Витни, *Life of Хебер С.Кимбалл* [1945], 40). Көртландад үлдсэн тэдгээр нь сайн дурынхны гэр бүлд туслахыг зөвшөөрч байв.

Энэхүү “Израилын их цэрэг” (С ба Г 105:26) тавдугаар сарын эхээр аянаа эхэлжээ. Замд нь Огайо, Мичиган, Иллинойгоос шинэ хүмүүс элсэн тэдэнтэй нэгдэж байв. Тэд цэргийн дүрмийг сахин, өглөөний дөрвөн цагт босч, өдөрт 56 километрээс багагүй зайг туулдаг байв. Тэд бас цэргийн сургууль хийдэг байсан боловч, ихэнх армиудтай адилгүй нь, залбирал хийж, дуу дуулан, сайн мэдээг судалдаг байв.

Харамсалтай нь, зарим хүмүүс зовлон бэрхшээлд, бас удирдагчдынхаа шийдвэрт гомдоллон дургүйцдэг байв. Нэг удаа зөрчил бүр дэндэхэд, хэрэв хүмүүс хуаранг орхин явбал маргааш нь Их Эзэн тэдэнд уурласнаа тэмдгээр үзүүлнэ гэж Бошиглогч Иосеф Смит сэрэмжлүүлжээ. Маргааш нь хуарангийн бараг бүх морьд өвчилсөн эсвэл хөл нь доголсон байв. Хэрэв тэд өөрсдийгөө даруусгаж, наманчлан, нэг бүлэг болж нэгдэх юм бол, бүх морьд тэр даруй зүгээр болж эдгэрнэ гэж Бошиглогч хэлсэн аж. Үд гэхэд атгаг санаагаа орхилгүй, бусдыг өдөөн хатгаж байсан нэг хүний мориноос бусад бүх морьд эдгэрч зүгээр болсон байлаа.

Сионы Хуарангийн ихэнх хүмүүс Бурханы бошиглогчтой ойр дотно холбоотой байсны ачаар тэд хатуу бэрх зовлонг даван туулсан юм. Хэдэн жилийн дараа Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Вилфорд Вудрафф: “Бид өөр ямар ч арга замаар, хэзээ ч олж авч чадахгүй туршлагыг олж авсан юм. Бошиглогчийг нүүр тулан харах онцгой боломж бидэнд байсан, түүнтэй хамт мянган бээрийн аян хийх онцгой боломж бидэнд байсан, бас Бурханы Сүнс түүнтэй хамт ажиллахыг, Есүс Христээс түүнд илчлэлтүүд ирж, эдгээр илчлэлтүүд гүйцэлдэхийг харах онцгой боломж бидэнд байсан” хэмээн гэрчилжээ (in *Journal of Discourses*, 13:158).



Фишинг гол

Сионы Хуаран дахь туршлагынхаа тухай, Ерөнхийлөгч Бригам Янг дурсан ярихдаа: “Намайг номлолоос Көртландад эргэж ирэхэд, нэг ах, ‘Бригам ах аа, энэ аянаас та юу олж авав?’ гэж надаас асуухад нь, ‘Бид юуны төлөө явлаа, түүнийгээ л би олсон. Харин би энэ удаад олсон мэдлэгээ бүх Гиоуга гүнлэг [түүний амьдарч байсан гүнлэг]-ээр ч солихгүй. Учир нь ямар ч өмч хөрөнгө, эд баялгийг мэдлэгийн үнэ цэнэтэй харьцуулшгүй юм” гэж би хариулж билээ (in *Journal of Discourses*, 2:10).

Сионы Хуаранг Миссурид ирэхэд, дайснууд нь тэднийг угтахар бэлтгэсэн байв. Фишинг гол (С ба Г 105-р хэсэг дэх илчлэлт энд хүлээн авагджээ) дээр буудаллахаар бэлтгэж байтал, хэсэг Миссуричүүд хуаран руу хүрч ирсэн аж. Бошиглогч Иосеф Смит тэмдэглэхдээ: “Буутай таван хүн манай хуаран руу давхиж ирээд, ‘өглөө болохоос өмнө’ та нар тамыг үзэх болно гэж бидэнд хэллээ. Мөн тэд чөтгөр шулмасын бүхий л хорслоор тангараглав. Биднийг нэг мөсөн зүйл дуусгахаар андгай тангараг тавьсан Жаксон гүнлэгийн танхайрагчидтай нэгдэхээр Рей дүүргийн Ричмондоос жаран хүн, Клей гүнлэгээс дахиад далан хүн ирж яваа гэж тэд бидэнд хэллээ” гэжээ (*History of the Church*, 2:102–103). Гэвч Бошиглогч Сионы Хуарангийн гишүүдийг тайтгаруулж, Их Эзэн биднийг хамгаална гэж амлав. Тун ч удалгүй их шуурга шуурч эхлэх нь тэр. Сионы Хуарангийн олон хүмүүс ойролцоох хуучин Баптист сүмд хоргодсон бол, шуурга танхайрагчдын төлөвлөгөөг нурааж, тэд “Мормоны армитай” тулалдах санаархлаа орхиж, амь зулбан арилж өгчээ.

Тулалдаан болоогүйн улмаас зарим хүмүүс Сургаал ба Гэрээ 105-р хэсэг дэх илчлэлтэд урам нь хугарч Бошиглогч болон Их Эзэнд дургүйцсэн гэдэг. Үүний улмаас булчин задрах тахал хуаранг арчих нь тэр. Арван дөрвөн хүн, түүний дотор итгэлтэй хэвээр үлдсэн зарим хүмүүс нас барав. Тэдний дунд ёс бус хүмүүс байгаа үед зөв шударга хүмүүс ч бас зарим үед гай зовлонд нэрвэгддэг ажээ. Хэрэв эсэргүүцэгчид өөрсдийгөө даруусгаж, наманчлах юм бол, тахал тэднийг орхино гэж Бошиглогч Иосеф Смит амлажээ. Түүний үгс гүйцэлдсэн юм.

Сионы Хуаран зарим гишүүдийн бодсон шиг болоогүй ч гэсэн, Сургаал ба Гэрээ 105:19-д Их Эзэний хэлснээр, “тэдний итгэлийн сорилт” болсон юм. Зарим хүмүүс сорилтыг даалгүй, Сүмийг орхиж явсан бол итгэлтнүүд туршлагаараа хүчирхэгжсэн байв. Энэ эрин үеийн Арванхоёр Төлөөлөгчийн ес нь, Далын анхны долоон Ерөнхийлөгч, Далын Нэгдүгээр Чуулгын бусад жаран гурван гишүүн бүгд Сионы Хуарангийн гишүүд байжээ. Хэн нь итгэлтэй байсныг, Тэрээр хэнд итгэж болохыг харуулахын тулд Их Эзэн энэ туршлагыг ашигласан бололтой (мөн С ба Г 105:35-ыг үз).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 105-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Жагсаалт хий

1. Тэр үед “хувь хүмүүсийн биш, харин Сүмийн талаар ярихад, миний хүмүүсийн зөрчил” Сион байгуулагдсаныг харахаас хойш татсан хэмээн Их Эзэн Сургаал ба Гэрээ 105:1–6-д нэгтгэн дүгнэжээ. Эдгээр шүлгүүдийг судалж, хүмүүс юу хийгээгүй гэж Их Эзэн хэлснийг жагсаан бич. Сионы зарчмыг илүү бүрэн дүүрэн байгуулан бэхжүүлэхийн тулд өнөөдөр бид Сүмд юу хийж байгаа гэж бодлогоо тайлбарла.
2. Сионыг авчрахын тулд Сүмийн гишүүдэд юу хэрэгтэйг Их Эзэн шүлэг 9–12, 31-д дэлгэрэнгүй тайлбарлажээ.

Энд хүмүүс ямар нэг зүйлийг буруу хийсэн тухай биш, харин тэдний хийгээгүй юмны тухай өгүүлжээ. Сүм юу хийх хэрэгтэй байсныг тайлбарла.

3. Дээрх шүлгүүдээс сурч мэдсэн зүйлээрээ, Сионы зарчмыг байгуулан бэхжүүлэхэд туслахын тулд та нар юу хийж байгаагаа эсвэл юу хийх ёстой гэж бодлогоо тайлбарла.

Б Жишээ гарга

Сургаал ба Гэрээ 105:6-д заагддаг зарчим та нарын амьдралд, эсвэл өөр хэн нэгний амьдралд хэрхэн нөлөөлж байгаа талаар жишээ гарга.

В Чи тэдэнд юу гэж хэлэх вэ?

Сионы Хуарангийн дараах гурван гишүүнтэй ярилцаж боломж өөрт чинь олджээ гэж бод. (“Судруудыг ойлгох нь” хэсэг дэх товч түүхийг тоймлон үзэхийг хүсч болно) Нэгдүгээрт, Сургаал ба Гэрээ 105:17–19-д Их Эзэний хэлсэн зүйлүүдийг Бошиглогч Иосеф Смит хүмүүст хэлсний дараа тэдний хүн нэг бүр юу гэж хэлж болохыг бод. Дараа нь тэдний хүн тус бүрд юу гэж хэлэх байснаа бич.



Сионы Хуаран

1. Мянган бээр газрыг огт хэрэггүй зүйлийн төлөө явганаар туулсан, удирдагчид нь түүнээс урван тэрсэлсэн гэж боддог дунд насны эцэг хүн.
2. Эл туршлага түүнд хэцүү байсан ч, хий гэж өөрөөс нь хүссэн ямар ч зүйлийг үргэлж хийх хүсэлтэй байдаг, уг туршлагынхаа төлөө талархаж явдаг ахимаг насны нэгэн гишүүн.
3. Аяны үед зарим гишүүдийн зан авирт урам нь хугарсан, энэ шинэ Сүмд үлдэх эсэх талаар эргэлзэж байгаа, саяхны хөрвөгч, гэрлээгүй залуу гишүүн.

Г Юу хийх ба юу хийх ёсгүй вэ?

1. Сургаал ба Гэрээ 105:23–40-өөс уншсан зүйлээсээ хоёр жагсаалт хий. Нэгдүгээрт: “Эргэн тойрныхоо бүс нутгуудад” (Миссурид) юу хий гэж Их Эзэн Гэгээнтнүүдэд хэлснийг жагсаан бич. Хоёрдугаарт: Тэрээр юу хийхгүй бай гэж хэлснийг жагсаан бич.
2. Жагсаалтаас нэг зүйлийг сонгож, өнөө үед энэ нь Сүмд хэрхэн хэрэглэгддэгийг тайлбарла.

Сургаал ба Гэрээ 106

“Шөнийн хулгайч мэт”



1834 оны эхээр Сионы Хуаранд зориулж, хүмүүсийг элсүүлж, мөнгө цуглуулж байх үеэр Бошиглогч Иосеф Смит Сүмийн олон салбарт очжээ. Тэр үед тэрээр Оливер Каудерийн ах, Сүмд 1831 онд нэгдсэн Воррентай хамт Нью-Йоркийн Фрийдомд байв. Хожим нь, толгой өндийх завгүй байсан сар (History of the Church, 2:170-ыг үз) хэмээн Бошиглогчийн дүрсэлсэн сарын дундуур, Сургаал ба Гэрээ 106-р хэсэг дэх Воррен Каудерид чиглэгдсэн илчлэлтийг тэрээр хүлээн авчээ.

Сургаал ба Гэрээ 106-р хэсгийг уншихдаа, хүлээж авсан дуудлагуудынхаа тухай, мөн дуудлагынх нь тухай Ворренд Их Эзэний хэлсэн үгс өөрийн чинь дуудлагад хэрхэн хамаатай байж болохыг бод.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 106

Бүсээ бүслэгтүн (ш. 5)—
Өөрийгөө бэлтгэгтүн

Очирт таяг (ш. 6)—
Захирах эрх мэдлийг бэл-
гэдсэн саваа буюу таяг

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 106-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Үйлчлэх дуудлага

1. Сургаал ба Гэрээ 106-р хэсэгт, Воррен Каудеригаар юу хийлгэхээр Их Эзэн түүнийг дуудсан бэ?
2. Их Эзэний хэлснээр, дуудлага яагаад чухал вэ?
3. Каудери ах тайтгарал, урам зоригийг олж болох юуг илчлэлтэд хэлснийг жагсаан бич. Жагсаалтаасаа хоёр зүйлийг сонгож, эдгээр зүйлүүд түүнд хэрхэн тусалж болох байсныг тайлбарла.

Б Үүнийг өөртөө хэрэглэ

Сургаал ба Гэрээ 106-р хэсэг өөрт чинь болон Сүмд өөрийн чинь хүлээн авдаг дуудлагад холбогдож болох хоёр арга замыг дүрсэл.

В Ялгааг ажигла

Их Эзэн хоёр өөр бүлэг хүмүүсийн тухай мөн Хоёр дахь Ирэлтийнхээ тухай Сургаал ба Гэрээ 106:4–5-д, өгүүлсэн байдаг. Эдгээр хоёр бүлэг хүмүүс хэн бэ? Хоёр дахь Ирэлтийн талаарх тэдний ялгаа юу вэ?

Сургаал ба Гэрээ 107

Санваарын тухай илчлэлт



Санваарын талаар чи юу мэдэх вэ? Жишээ нь: Аароны санваарыг Мелкизедек санваартай харьцуулбал энэ санваарын хүч, эрх мэдэл нь юу вэ? Санваар тус бүрд ямар албан тушаалууд байдаг вэ? Албан тушаалууд нь хэрхэн зохион байгуулагддаг вэ? Яагаад санваар шаардлагатай вэ?



Сургаал ба Гэрээ 107-р хэсэг дэх санваарын тухай асуултуудад та нар хариултуудыг олж болно. Энэ илчлэлт 1835 онд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга дуудагдсаны дараахан өгөгджээ. (Энэ эрин үеийн анхны Төлөөлөгчдийн жагсаалт “Сургаал ба Гэрээ Ном үнэн болох тухай Арванхоёр Төлөөлөгчийн гэрчлэлд” байдаг.) Эдгээр эрчүүд дэлхий дээрх Сүмийн санваар болон Их Эзэний ажлыг удирдах дуудлагынхаа талаар илүү сайн ойлголтыг хүсч, Бошиглогч Иосеф Смит дээр хурч ирсэн аж. Үүгээрээ энэ илчлэлт энэ эрин үеийн санваартны гарын авлагатай адил юм.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 107

Дэг жаяг (шүлэг 3, 9–10, 29, 40–41, 71, 73, 76)— Бурханы санваарын эрх мэдлийн зохион байгуулалт
Үйлчлэх (шүлэг 8, 12, 20)— Чиглэл өгөх, удирдах

Түлхүүрүүд (шүлэг 15–16, 18, 20, 35, 70, 76)—Тэргүүлэх болон удирдан чиглүүлэх эрх мэдэл

Зууч (ш. 19)— Хоёр хувь хүн эсвэл бүлгүүдийн хооронд энхийн харилцааг бий болгохын тулд эвлэрүүлэх оролдлого хийдэг хүн

Аялагч дээд зөвлөл (ш. 38)—Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга

Евангелийн тохинуулагчид (ш. 39)—Патриархууд

Тэргүүн тэнгэр элч (ш. 54)—Хамгийн дээд зиндааны тэнгэр элч

Сургаал ба Гэрээ 107:1, 6—Левийн санваар

Мосегийн үед, Мелкизедек санваарыг израилчуудаас татан авсан бөгөөд доод (Аароны) санваар тэдний дунд цаашид байх болжээ (С ба Г 84:23–26-г үз). Энэ санваар зөвхөн Левийн овгийн эрчүүдэд олгогддог байсан учраас энэ нь бас Левийн Санваар хэмээн нэршжээ. Сургаал ба Гэрээ 107:1-д харуулснаар, Левийн санваарын эрх, эрх мэдэл нь Аароны санваарын хэсэг юм.

Сургаал ба Гэрээ 107:2—Агуу дээд санваартан Мелкизедек



Мелкизедекийн тухай уншихын тулд, ИСО, Эхлэл 14:25–40 (Библийн ХҮГ Хэвлэлийн газрын зургийн өмнөх “Иосеф Смитийн Орчуулга”-ын хавсралт); Алма 13:14–19; Сургаал ба Гэрээ 84:6–14; мөн Судруудын Удирдамж, “Мелкизедек,” х.126-г үз.

Сургаал ба Гэрээ 107:5—

Санваар аль ч албан тушаалаасаа илүү чухал

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Брус Р.МкКонки заахдаа:

“Санваар бол өөрийнхөө аль ч албан тушаалаасаа илүү чухал юм. Албан тушаал нь санваарт аливаа хүч, алдар хүндэтгэл болон эрх мэдлийг нэмдэггүй. Бүх албан тушаал нь өөрийн эрх, онцгой эрх мэдэл, ач ивээл болон хүчийг санваараас авдаг. Тойргийг хэсгүүд болгон хуваах замаар энэ зарчмыг дүрслэн харуулж болно. Санваар бол тойрог юм. Тойргийн хэсгүүд нь санваарын дуудлагууд эсвэл албан тушаалууд юм. Тойрог бүрд үйлчилдэг хэн ч гэсэн бүхэл тойргийн хүчийг эзэмших ёстой. Хэн ч эхлээд санваарыг эзэмшихгүйгээр санваарын албан тушаалыг эзэмшиж чадахгүй.

“Тийнхүү санваарыг зохистой хувь хүмүүст олгодог бөгөөд дараа нь тэд санваарын албан тушаалуудад томилогддог. Ийнхүү санваарын болон Сүмийн бүх албан тушаал нь уг санваарын нэмэлт болохын хувьд тусгай зорилготой байдаг. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, нэмэлт нь санваараас хөгждөг, нэмэлтүүд нь санваарт хавсралт болох бөгөөд ач холбогдлын хувьд санваараас доогуур юм. . . .

“Цааш нь, Мелкизедек санваарын хүрээнд нэг албан тушаал нь нөгөөгөөсөө илүү дээд шатанд байдаггүй. Ахлагч бүр Төлөөлөгч буюу Сүмийн Ерөнхийлөгчийнхтэй адил санваарыг эзэмшдэг ч, сүүлчийн хоёр албан тушаал нь хаант улсад илүү их захиргааны ажил үүргийг гүйцэтгэдэг” гэжээ (Mormon Doctrine, 595–596).

Сургаал ба Гэрээ 107:15–17, 68–73—“Аароны шууд удам”

“Патриарх тэднийг адисалж, Левийн удам гэж зарладаг зарим хүмүүс Сүмд байдаг. Гэвч тэд бишопын албан тушаалыг авах шаардлага тавьдаггүй. Учир нь энэхүү нөхцөлийг удирдан зохицуулдаг илчлэлт нь Левийнх биш, харин Аароны шууд удам гэдэг. Гэтэл Аароны биш, харин Левийн шууд үр удам болох үй олон хүмүүс байдаг нь тодорхой юм” хэмээн Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит заажээ (*Doctrines of Salvation*, 3:92).

Сургаал ба Гэрээ 107:23–38—Чуулгууд “эрх мэдлээрээ адил тэгш”

Сүмийн Ерөнхийлөгч нас барахад Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга нь “эрх мэдэл, хүчээр” Тэргүүн Зөвлөлтэй адил байдгийг Их Эзэн Сургаал ба Гэрээ 107:24-т заажээ. Учир нь, тэд бол бошиглогч, үзмэрч, илчлэгчид бөгөөд дэлхий дээр Бурханы хаант улсын түлхүүрүүдийг эзэмшдэг. Гэвч шүлэг 33-т зааснаар Арванхоёр Төлөөлөгч нь Тэргүүн Зөвлөлийн “удирдлага дор ажилладаг.”

Дал нь “эрх мэдлээр Арванхоёртой адил тэгш юм” (С ба Г 107:26). Тэд хүчээр Арванхоёр Төлөөлөгчтэй адил тэгш хэмээн сударт заадаггүйг ажигла, учир нь Дал бол Бурханы хаант улсын түлхүүрүүдийг дэлхий дээр эзэмшдэггүй. Гэвч Арванхоёр болон Тэргүүн Зөвлөлтэй адил Сүмийн Ерөнхий Эрх Мэдэлтнүүд юм. Тиймээс тэд “Арванхоёрын удирдлага дор” (ш. 34) ажилладаг учир, Сүмд эрх мэдлээр адил тэгш юм (ийм учраас нэр нь “Ерөнхий Эрх Мэдэлтэн байгаа юм”). Энэхүү хүчин чадлаар тэд “Сүмийг байгуулах болон Сүмийн бүх ажил хэргийг зохицуулан” (ш. 34) дэлхий даяар явуулахад тусалж чадна.

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 107-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас тавыг хий.

А Нэмэлт ойлголттой бол

1. Сургаал ба Гэрээ 107:1–4-т өгүүлснээр, дээд санваарыг яагаад Мелкизедек санваар гэж нэрлэдэг вэ?
2. Сургаал ба Гэрээ 107:2-ын “Судруудыг ойлгох нь” хэсэгт Мелкизедекийн талаар өгөгдсөн эшлэлүүдийг унш. Түүний нэрээр санваарыг эзэмших хүндэтгэлийг харуулдаг Мелкизедекийн тухай юу сурч мэдсэнээ тэмдэглэлийн дэвтэртээ бич.

Б Асуулт хариулт бич

Сургаал ба Гэрээ 107:1–20-д сурч мэдсэн зүйлээ ашиглан, Аароны санваар, Мелкизедек санваарын тухай мэдлэг сорих найман асуулт хариулт бич. Асуулт бүрийн дараа хариуг, мөн уг шүлгийг хаанаас олж үзэж болохыг бич.

В Схем хий

Санваарын албан тушаал болон чуулгуудын тухай Сургаал ба Гэрээ 107-р хэсгээс сурч мэдсэн зүйлээ зохион байгуулалтад оруул. Тэмдэглэлийн дэвтэртээ дараахтай адил схем зурж, доорх шүлгүүдээс мэдсэн зүйлээ дотор нь бич:

Сүмийн Ерөнхийлөгч (С ба Г 107:8–9, 65–67, 82, 91–92-ыг үз)	Тэргүүн Зөвлөл (шүлэг 21–22, 27, 33, 78–79-ийг үз)
Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга (шүлэг 23–24, 27–28, 30–31, 33, 35, 38–39, 58-ыг үз)	Дал (шүлэг 25–28, 30–31, 34, 38, 93–98-ыг үз)
Дээд санваартнууд (шүлэг 10, 12, 17-г үз)	Ахлагч нар (шүлэг 10–12, 60, 89–90-ийг үз)
Бишопууд (шүлэг 13–17, 68–76, 87–88-ыг үз)	Санваартнууд (шүлэг 10, 61, 87–88-ыг үз)
Багш нар (шүлэг 10, 62–63, 86-г үз)	Диконууд (шүлэг 10, 62–63, 85-ыг үз)

Г Ач холбогдлыг нь тайлбарла

Сургаал ба Гэрээ 107:27-д өгүүлснээр, Сүмийн чуулгуудыг удирдах шийдвэрийг яаж гаргадаг вэ? Энэ зарчмыг ойлгох нь бидний хувьд яагаад чухал гэж та нар бодож байна?

Д Хэрэв чи тэнд байсан бол

Сургаал ба Гэрээ 107:41–57-д Их Эзэн Адам болон түүний гэр бүлийн тухай өгүүлжээ. Дараах асуултуудад хариул:

1. Адамын патриархын үүрэг юу байсан бэ?
2. Адамын патриархын үүргийг өнөө үеийн патриархын үүрэгтэй хэрхэн харьцуулж болох вэ?

Е Жишээ гарга

Сургаал ба Гэрээ 107:85-д диконы чуулгын ерөнхийлөгчийн үүрэг хариуцлагуудыг өгүүлжээ. Энэ шүлэгт тэмдэглэсэн үүрэг хариуцлагын дөрвөн гол чиглэл-тэргүүлэх, зөвлөлд хуралдах, заах, гэгээрүүлэх үүргийг хэрэгжүүлэхийн тулд диконы чуулгын ерөнхийлөгч юу хийж болох тухай жишээ гарга.

Ё Чиний туршлага

Сургаал ба Гэрээ 107:91–92 нь Сүмийн Ерөнхийлөгчийн үүргийг дүрсэлжээ. Эдгээр шүлгүүд дэх санаануудын нэгнийх нь үнэнийг ойлгосон үед өөртөө тохиолдсон туршлагын тухай бичнэ үү.

Ж “Хүн бүрийн хариуцлага”

Сургаал ба Гэрээ 107:99–100-г тэмдэглэлийн дэвтэртээ нэгтгэн дүгнэхдээ, хүн бүрийн үүрэг хариуцлагын тухай Их Эзэн юу гэж хэлснийг мөн Түүний сэрэмжлүүлгийг онцгойлон авч үз.



Сургаал ба Гэрээ 107:99–100 нь үүрэгтээ идэвхтэйгээр суралцахыг санваар эзэмшигчдэд зөвлөдөг. Энэ зөвлөгөөг хэрхэн биелүүлсний үлгэр жишээ нь Лайман Шерман байлаа. Тэрээр Сионы Хуарангийн гишүүн, энэ эрин үед дуудагдсан Далын долоон Ерөнхийлөгчийн нэг байсан. Мөн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүнээр дуудагдсан боловч, томилогдож чадаагүй (цаг бусаар нас барсан учир) ажээ. Шерман ах Их Эзэнд үйлчлэхийг хүсэн, үүргээ мэдэхийн тулд Бошиглогч Иосеф Смит дээр хүрч иржээ. Сургаал ба Гэрээ 108-р хэсэг дэх илчлэлт бол Их Эзэний хариу юм.

Сургаал ба Гэрээ 108-р хэсгийг уншихдаа, Шерман ахад өгсөн Их Эзэний зөвлөгөө өнөөдөр Их Эзэнд үйлчлэхийг хүсдэг хүн бүхэнд хэрхэн хамаатайг бод. Шерман ахад хэлсэн зүйлсийг өөрт чинь хэлэхийг чи хүсэх үү?

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 108

Тангаргууд (ш. 3)—
Гэрээнүүд ба амлалтууд

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 108-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Тайлбарла

Дараах өгүүлбэрүүдийг тэмдэглэлийн дэвтэртээ бичиж, өгүүлбэр тус бүр нь юу гэсэн утгатайг тайлбарла. Энд өгүүлсэн зүйлийг та нар амьдралдаа хэрхэн хэрэглэж болох вэ?

1. “Бодгаль чинь амралтад байг” (С ба Г 108:2; мөн ш. 1-ийг үз)
2. “Миний дуу хоолойг хойшид бүү эсэргүүц” (ш. 2)
3. “Энэ цагаас хойш, хийсэн тангаргуудаа дагахад илүү анхааралтай байгтун” (ш. 3)
4. “Тэвчээртэйгээр хүлээгтүн” (ш. 4)
5. “Чи дурсагдах болно” (ш. 4)

Б Зорилго тавь

Бусдыг бэхжүүлэх дөрвөн арга замыг Их Эзэн Лайман Шөрманд Сургаал ба Гэрээ 108:7-д зөвлөсөн байдаг. Эдгээр арга замуудыг тэмдэглэлийн дэвтэртээ жагсаан бич. Арга зам бүрд, бусдыг бэхжүүлэх өөрийнхөө нэг зорилгыг бичиж, юу хийхээр төлөвлөж байгаагаа, бас энэ ажлыг хэрхэн хийх тухайгаа ярь.

Сургаал ба Гэрээ 109

Көртландын Ариун сүмийг онцгойлон адисалсан нь

Чи Ариун сүмийн онцгойлон адислалтад оролцсон уу? Ариун сүмийг онцгойлон адислах залбиралд юу хэлэх ёстой гэж чи бодож байна? Сургаал ба Гэрээ 109-р



хэсэг бол энэ эрин үеийн анхны ариун сүм-Көртландын Ариун сүмийг онцгойлон адислахад Бошиглогч Иосеф Смитийн хэлсэн залбирал юм. Тэрээр онцгойлон адислалтын өмнө Сүнсний нөлөөгөөр энэ залбирлыг бичиж, онцгойлон адислах үйлчлэлийн үеэр адислалыг

унижжээ. Тэр үеэс хойш уг залбирал загвар болсон юм. Ариун сүмийн онцгойлон адислалтын бүх залбирлыг сүнсний нөлөөгөөр бэлтгэж, онцгойлон адислалтыг гүйцэтгэхээр томилогдсон ах нар уг залбирлыг унишдаг.

Сургаал ба Гэрээ 109-р хэсэг дэх залбирал нь ийм залбирлуудын хэлний хувьд бас загвар болдог.

Сүмийн болон дэлхийн түүхэнд Көртландын Ариун сүм чухал учир холбогдолтой байв. Энд Их Эзэн хүмүүний бүх гэр бүлийн авралын түлхүүрүүд-амьд байгаа хүмүүс болон нас барагсдын өмнөөс хийлгэх авралын ёслолуудад

үүд хаалгыг нээсэн санваарын түлхүүрүүдийг Бошиглогч Иосеф Смит, Оливер Каудери хоёрт илчилжээ.

Сүнсний гайхалтай илэрхийлэлтүүд Көртландын Ариун сүмийг онцгойлон адислахад болсон юм. Тэнд байсан хүмүүсийн зарим нь Төлөөлөгч Петр, Иохан хоёр болон бусад олон тэнгэр элчийг харжээ. Онцгойлон адислалтын орой ариун сүмд болсон цуглааны үеэр Бошиглогч Иосеф Смит, “Хүчтэй салхи хүнгэнэн хуйлрах мэт чимээ сонсогдож, ариун сүмийг дүүргэхэд Жорж А.Смит ах босч, бошиглож эхлэв. Тэгтэл бүх цугларагсад үл үзэгдэх хүчээр нөлөөлөгдөн нэгэн зэрэг бослоо. Олон хүмүүс бошиглолын хэлээр бас олон өөр хэлээр ярьж эхлэв. Бусад хүмүүс сүр жавхлантай үзэгдлүүдийг харлаа. Ариун сүм тэнгэр элчүүдээр дүүрснийг би хараад, цугларагсдад мэдэгдэв. Ойр хавийн хүмүүс хамтдаа гүйлдэн ирж (Ариун сүм дотор гарах ер бусын чимээг сонсож, дээр нь тогтсон галан багана мэт хурц гэрлийг хараад), болж байгаа үйл явдалд мэл гайхицран байв” гэж цэдэглэжээ (History of the Church, 2:428).

Ариун сүмийн онцгойлон адислалтын хэсэг болгон, эл үйл явдалд зориулан В.В.Фелпсийн бичсэн “Бурханы Сүнс” дууллыг (Сүмийн Дуулал болон Хүүхдийн дуу, х.28) найрал дуу дуулжээ. Энэ дуулал ариун сүмийн онцгойлон адислалтын хэсэг болсоор байна.

Сургаал ба Гэрээ 109-р хэсгийг уншихдаа, ариун сүмийн болон хожмын өдрүүдийн талаарх чухал сургаалуудыг хайж ол.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 109

Хуулийг лацдан (шүлэг 38, 46)—Үнэнийг гэрчлэн

Серафууд (ш. 79)—Тэнгэр элчүүд

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 109-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Ариун сүмээс ирдэг адислалууд

Их Эзэний амласан адислалууд Гэгээнтнүүд дээр ирэхийн төлөө Бошиглогч Сургаал ба Гэрээ 109:11-д залбирчээ. Дараах шүлгүүд буюу бүлэг шүлэг тус бүрд нийт Сүмийн нэрийн өмнөөс ямар адислалыг Бошиглогч гуйж залбирсныг тайлбарла: Сургаал ба Гэрээ 109:12, 13, 14–15, 21, 22–23, 25–30, 35, 38. Эдгээр адислалууд ариун сүмийн шүтлэг бишрэлтэй холбогдсон адислалуудын зөвхөн хэдхэн нь юм.

Б Бусдын төлөө залбирах нь

1. Сургаал ба Гэрээ 109:47–72-т Бошиглогч Иосеф Смит тэдний төлөө залбирсан хувь хүмүүс болон бүлгүүдийг жагсаан бич.
2. Жагсаасан хүн болгоны чинь төлөө Бошиглогч залбирсанд чи гайхаж байна уу? Яагаад гэдгийг тайлбарла.

3. Тэдний төлөө залбирах хэрэгтэй гэж бодсон хоёр хувь хүн буюу бүлгийг жагсаалтаасаа сонго. Тэдний төлөө залбирах нь яагаад чухал гэж бодож байгаагаа тайлбарла.

В Жишээ гарга

Бошиглогч Иосеф Смит энэ залбирлыг хэлснээс хойш гүйцэлдсэн гэж үзэж байгаа нэг жишээг Сургаал ба Гэрээ 109:54–67-гоос гарга. Түүний хүсэлтүүдийн нэг нь хэрхэн зарим талаар гүйцэлдсэнийг сонгосон жишээ чинь харуулж болно.

Г Үүнийг хүмүүст тайлбарла

1. Ариун сүм онцгойлон адислагдсаны дараа хүмүүс яагаад тийшээ орж болдоггүйг асуусан гишүүн бус найздаа чи юу гэж хэлэх вэ?
2. Сургаал ба Гэрээ 109-р хэсэг дэх ямар шүлгүүд хүмүүсийн асуултанд хариулахад чинь тусалж болох вэ?

Сургаал ба Гэрээ 110

Көртландын Ариун сүмд Их Эзэн хүрэлцэн ирж, түлхүүрүүдийг сэргээсэн нь



Их Эзэн “өөрийгөө өөрийнхөө хүмүүст харуулж” (С ба Г 109:5) болохын тулд Гэгээнтнүүд Көртландын Ариун сүмийг барьсныг Бошиглогч Иосеф Смит онцгойлон адислалтын залбиралдаа хэлжээ. Эл хүсэлт гүйцэлдсэнийг Сургаал ба Гэрээ 110-р хэсэгт цэдэглэдэг. Их Эзэн хүрч ирэн ариун сүмийг

Өөрийнх хэмээн хүлээн авчээ. Аврагчийн дараа удалгүй тэнгэрийн өөр гурван элч хүрч ирсэн юм. Тэд санваарын чухал түлхүүрүүдийг Бошиглогч Иосеф Смит, Оливер Каудери хоёрт сэргээсэн билээ.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 110


Хишиг (ш. 9)—Сүнсний бэлэг

Эрин үе (шүлэг 12, 16)—
Сайн мэдээ хүн төрөлхтөнд
өгөгдсөн тодорхой нэгэн үе

Сургаал ба Гэрээ 110:2—Ариун сүмийн индэр

Дараах зураг Көртландын Ариун сүмийн дотор талыг харуулж байна. Бошиглогч Иосеф Смит, Оливер Каудери хоёр дээр Аврагч ариун сүмийн баруун төгсгөл дэх индэр дээр хүрч ирснийг анхааран үз. Зураг дээр индэр болон

түүний хосгүй өвөрмөц хийц харагдаж байна. Индэр нь Сүмийн тэргүүлэх ажилтнуудын суудал байжээ. Тусгай цуглаануудын үеэр, бас ариун сүмийн онцгойлон адислалтын үеэр тэд энд суудаг байжээ.



Сургаал ба Гэрээ 110:11—Мосе ба Израилын цугларалт

Их Эзэн Израилын угсааны гишүүдийг Ариун нутгаас дэлхий даяар үе үе тараах буюу шилжүүлэн суурьшуулж ирсэн билээ. Ихэвчлэн Израилын умард хаант улсад аж төрж байсан арван овгийг МЭӨ 721 онд ассиричууд боолчлолд аваачсан юм. Иудагийн өмнөд хаант улс дахь Иуда болон Бениамины (Бенжамин) овог тэнд амьдарч байсан бусад овгуудын үлдэгдлийн хамт Лихайн үед Вавилонд боолчлогдож, улмаар Есүс Христийн Амилалтын дараа ромчууд тэднийг дахин тараасан ажээ. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Брус Р.МкКонки тайлбарлахдаа, “Тэд сайн мэдээг эсэргүүцэж, санваарыг бузарлан, Сүмийг бүрмөсөн орхиж, хаант улсаас салан одсоны учир Израил тараагдсан юм. . . Урвалтын улмаас Израил тараагдсан билээ. Тэдний ёс бус явдал, эсэргүүцлийн улмаас Их Эзэн тэднийг уур хилэгнэлээрээ дэлхийн бүх үндэстнүүдийн дунд, үнэн бурхангүйчүүдийн дунд тараасан юм” (A New Witness for the Articles of Faith, 515) гэжээ.

Көртландын Ариун сүмд Бошиглогч Иосеф Смит, Оливер Каудери хоёр дээр Аврагч хүрч ирсний дараа Хуучин Гэрээний бошиглогч Мосе хүрч ирсэн ажээ. Тэрбээр Израилын цугларалтын, түүний дотор алдагдсан арван овгийг цуглуулах, сэргээгдсэн сайн мэдээний адислалуудын түлхүүрүүдийг сэргээсэн юм. “Израилын цугларалт нь үнэн Сүмд нэгдэх хийгээд. . . үнэн Бурханы тухай мэдлэгт ирэхээс бүрддэг” гэж Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл заажээ (Teachings of Spencer W.Kimball, 439).

Сургаал ба Гэрээ 110:12—Елиас гэж хэн байсан бэ? Тэр ямар түлхүүрүүд авчирсан бэ?

“Елиас” бол замыг бэлтгэдэг элчид өгсөн нэр юм (Судруудын Удирдамж, “Елиас,” х. 70-ыг үз). Сургаал ба Гэрээ 110-р хэсэг дэх Елиас хэн болох нь тодорхой бус ажээ.

Их Эзэн Абрахамд амласан адислалуудад хамаарах Елиасын авчирсан түлхүүрүүдийг гагцхүү ариун сүмийн ёслолуудаар дамжуулан бүрнээр нь хүлээн авч болно. Тийнхүү, тэрээр “Абрахамын сайн мэдээний эрин үеийг итгэмжлэн даатгажээ” (С ба Г 110:12).

Сургаал ба Гэрээ 110:13-15—Елиагийн ирэлт

Хуучин Гэрээний сүүлчийн шүлгүүд, гэр бүлийг лацдан холбох хүчийг сэргээхийн тулд Елиаг илгээх тухай Их Эзэний амлалтыг цэдэглэсэн байдаг (Малахи 4:5-6; мөн 3 Нифай 25; С ба Г 2-ыг үз). Түүнээс гадна, хэрэв Елиа ирэхгүй бол, хүн бүрийн хувьд үүний үр дагаврууд ноцтой байх болно гэдгийг Тэрээр нотолжээ. Олон иудейчүүд энэхүү амлалт бол Дээгүүр Өнгөрөх Баярынх нь нэг хэсэг гэдгийг санан, Елиад зориулан ширээн дээрээ зай гаргаж, үйлчлэлийн тодорхой хэсэгт хаалгаа нээдэг нь Елиа эргэж ирэн, нээлттэй хаалгаар орохыг бэлгэддэг ажээ. 1836 оны дөрөвдүгээр сарын 3-нд, Дээгүүр Өнгөрөх Баярын үеэр Көртландын Ариун сүмд Елиа хүрч ирсэн нь нэн сонирхолтой юм.

Елиагийн сэргээсэн түлхүүрүүд Сионы Уулан дээр аврагчид байх боломжийг Гэгээнтнүүдэд олгосныг Бошиглогч Иосеф Смит зааж: “Тэд хэрхэн Сионы Уулан дээр аврагчид болдог вэ? Ариун сүмүүдээ барьсанаар, баптисмын сангуудыг босгосноор, мөн урагш гарч, бүх ёслол, баптисм, гишүүний баталгаа, угаалга, тослолт, ёслолууд болон лацдан холболтын хүчнүүдийг, нас барсан бүх өмнөх үеийнхнийхээ нэрийн өмнөөс тэргүүн дээрээ хүлээн авснаар, түүнчлэн тэд эхний амилуулалтаар урагш гарч ирэн, алдар суугийнхаа хаан ширээнд өргөмжлөгдөхийн төлөө хүмүүсийг гэтэлгэснээр эцгүүдийн зүрх сэтгэлийг хүүхдүүдтэй нь, хүүхдүүдийг эцгүүдтэй нь холбох гинжин хэлхээ болдог. Энэ нь Елиагийн үүрэг зорилгыг гүйцэлдүүлдэг” гэжээ (*History of the Church*, 6:184).

“Елиагийн олгосон энэхүү санваарын хүчээр эхнэр нөхөр хоёрыг лацдан холбох буюу үүрд мөнхөд гэрлүүлж болно. Хүүхдүүд эцэг эхчүүдтэйгээ үүрд мөнхөд лацдан холбуулж болно. Тийнхүү гэр бүл үүрд мөнхөд орших болж, үхэл гэр бүлийн гишүүдийг салгахгүй. Энэ бол дэлхийг бүрмөсөн устгагдахаас аврах агуу зарчим мөн” хэмээн Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит заажээ (*Doctrines of Salvation*, 2:118).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 110-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Схем хий

Сургаал ба Гэрээ 110-р хэсэг дэх дөрвөн айлчлалыг доорхтой адил схем болгон зохион байгуул. Энэ хэсгээс сурч мэдсэн зүйлүүдээрээ схемийг бөглө.

Шүлгүүд	Хэн хүрч ирсэн бэ?	Тэр юу хэлж, юу хийсэн бэ?	Түүний хэлсэн, хийсэн зүйл яагаад чухал вэ?

Б Чухал үгс ба өгүүлбэрүүд

Сургаал ба Гэрээ 110:1-10 дахь Аврагчийн үзэгдлээс авсан дараах өгүүлбэр тус бүрийн ач холбогдлыг тайлбарла:

1. “Хөшиг бидний оюунаас авагдсан байв” (ш. 1)
2. “Бибээр та нарын өмгөөлөгч билээ” (ш. 4)
3. “Тэргүүнээ өргөж, мөн баясагтун” (ш. 5)
4. “Бибээр өөрийгөө өөрийн хүмүүст үзүүлэх болно” (ш. 7)
5. “Энэ ариун өргөөг бохирлохгүй бай” (ш. 8)
6. “Мянга мянган зүрх сэтгэл агуу ихээр баясах болно” (ш. 9)

В Гүйцэлдэлт

Сургаал ба Гэрээ 110:9-10 дахь бошиглол манай үед хэрхэн гүйцэлдсэнийг тайлбарла. Энэхүү бошиглолын гүйцэлдэлт амьдралыг чинь хэрхэн адисалсныг оруул.

Г Хаалгуудыг юунд зориулж нээх вэ?

Моце, Елиас, Елиа нар санваарын түлхүүрүүдийг Бошиглогч Иосеф Смит, Оливер Каудери хоёрт өгсөн юм. Түлхүүрүүд гэдэг нэр томьёо нь уг эрх мэдлээр тодорхой адислалууд нээгддэг гэсэн санааг бэлгэддэг. Көртландын Ариун сүмд сэргээгдсэн түлхүүрүүдийн үр дүн болж (С ба Г 110-ыг үз), Сүм болон дэлхийд ямар адислал болоод боломжууд нээгдсэн бэ?



Виллям Бөргесс Огайогийн Көртландад очиж, Массачусетсын Салемд их хэмжээний мөнгө байгаа газрыг мэднэ гэжээ. Миссури дэх мөрдлөг хавчлага болон Көртландын Ариун сүмийг барьсантай холбогдон Сүмд тулгарсан санхүүгийн асуудлыг шийдвэрлэх оролдлого хийж, Бошиглогч Иосеф Смит болон бусад хүмүүс Салем дахь энэхүү нуусан эрдэнэсийг олж авахын тулд Бөргесстэй уулзав. Тэднийг тэнд хүрч очиход эрдэнэс чухам хаана байсныг Бөргесс санахгүй янзтай байв. (Б.Х.Робертс, A Comprehensive History of the Church, 1:411-ийг үз.) Их Эзэн Бошиглогчийн чин сэтгэлийг ойлгож таагүй биш байсан ч, магадгүй энэ гэнэн явдал нь бидэнд ханддаг Түүний арга барилын талаар зааж чадна.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 111

Сургаал ба Гэрээ 111:2— Салемд Сүмд зориулсан ямар сан хөмрөг Их Эзэнд байсан бэ?



Салем дахь эрдэнэс бол Христэд тэдний авчирч чадах хүмүүс юм гэдгийг Бошиглогч Иосеф Смит болон Массачусетсын Салем руу түүнийг дагалдан явсан хүмүүст Их Эзэн хэлжээ. Таван жилийн дараа 1841 онд, Эраст Снөүд (хожим нь Төлөөлөгчөөр дуудагдсан) Сургаал ба Гэрээ 111-р хэсэг дэх илчлэлтийн нэг хувийг өгч, түүнийг Салем руу

номлолд явуулав. Дээрх илчлэлт гүйцэлдэх цаг болсныг Хайрум Смит түүнд хэлсэн аж. Снөү ах тэнд жил гаруй байж, зуу гаруй хөрвөгчид баптисм хүртээсэн гэдэг.

Сургаал ба Гэрээ 111:9–10—“Салемын нэн эртний оршин суугчид болон үндэслэгчдийн талаар” асуусны дараа “өөр нэг сан хөмрөгийн” тухай хэрхэн өгүүлсэн бэ?

Массачусетсын Салемд байсан өөр нэг сан хөмрөг бол “энэ хотын нэн эртний оршин суугчид болон хотыг үндэслэгчдийн талаар хичээнгүйлэн асууж болох” (С ба Г 111:9) Эсекс гүлнэгийн цэдгүүд байв. Сүмийн эхэн үеийн гишүүдийн олон өвөг дээдэс, түүний дотор Америкт ирсэн Бошиглогч Иосеф Смитийн анхны өвөг дээдэс Салемд оршин сууж байжээ. Иосеф Смит бяцхан хөвгүүн байхдаа авга ах Жесси Смитийн хамт Салемд богинохон хугацаагаар сууж байх үеэр Иосеф мэс заслын дараа хөлөө эдгээж байв. Мэс заслын дараа “Иосеф тэр даруй илааршиж, хүч тамиртай, эрүүл саруул болсоор байв. Тэр бүр явж чадах хүртлээ илааршсан үед, далайн сэвэлзсэн зөөлөн салхи түүнд ашиг тустай байж болно гэж найдан, эрүүл мэндийнхээ төлөө авга ах Жесси Смитийн хамт Салем руу явсан аж. Үүндээ ч сэтгэл санаа нь өөдрөг байлаа” гэж түүний ээж Люси Мак Смит тэмдэглэжээ (*History of Joseph Smith*, 58).

Хожим нь нас барагсдын төлөө хийх ажлын талаарх сургаалуудыг Их Эзэн илчилсэн үед эдгээр цэдгүүдийг олж авсны ач холбогдол нь мэдэгдсэн ажээ.

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 111-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Түүнд ямар санагдсан гэж та нар боддог вэ?

Бошиглогч Иосеф Смит Сургаал ба Гэрээ 111-р хэсэгт Их Эзэний хэлсэн зүйлүүдийг анхааралдаа авахад өөрийнхөө тухай бас Их Эзэний тухай юу мэдэрсэн бол?

Б Сургамжууд нь юу вэ?

Сургаал ба Гэрээ 111-р хэсгээс бидний авч болох зарим чухал сургамжийн тухай, бас уг сургамж руу хөтөлдөг үйл явдлууд, дараа нь болох үйл явдлуудын тухай бич (Мөн энэ судлах гарын авлагын С ба Г 111-р хэсгийн оршил болон “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз).

В Жишээ гарга

1. Сургаал ба Гэрээ 111:11-ийн эхний хэсэгт Түүний үйлчлэгчид юу хийхийг Их Эзэн хүссэн гэж бодож байгаа талаараа жишээ гарга.
2. Энэ жишээ та нарт хэрхэн хамаатай байж болох вэ?



Сургаал ба Гэрээ 112

Арванхоёр Төлөөлөгчийн ажил

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга бол Их Эзэний тусгай гэрчүүд байж, дэлхий даяар сайн мэдээг номлоход хяналт тавих ёстой гэж Тэрээр Сургаал ба Гэрээ 107:23, 33, 35-д хэлсэн байдаг. Хойд Америк тивээс номлолд мордсон номлогчдын анхны бүлгийг Төлөөлөгч Хебер К.Кимбалл, Оорсон Хайд нар удирдсан юм. Тэд 1837 оны долдугаар сард Англид ирж, Престон дахь Сүмд анхныхаа ням гарагт номлосон аж. Мөн энэ өдөр Их Эзэн Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Сургаал ба Гэрээ 112-р хэсэг дэх илчлэлтийг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Томас Б.Маршид өгсөн өдөр байлаа. Энэ илчлэлтэд Их Эзэн энэ эрин үе дэх Өөрийн ажлыг чиглүүлэхэд Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын түлхүүрүүд болон эрх мэдлийн ач холбогдлын тухай дахин өгүүлжээ.



Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 112

Гутаан доромжлох (ш. : зүйлүүдийн тухай хүндэт-26)— Бурханы тухай, ариун : гэлгүйгээр ярих

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 112-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Үүрэгт ажлуудыг нь жагсаан бич

Сургаал ба Гэрээ 112-р хэсэгт уншсан зүйлүүдээсээ, (1) Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын, (2) Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгчийн үүрэгт ажлуудыг жагсаан бич. Үүрэгт ажил бүрд холбогдох шүлгийг хаанаас олсноо бич.

Б Хэрэв . . . (тэгвэл), . . .



Их Эзэн аль нэг адислалыг амлахдаа, уг адислалыг олж авахын тулд бид юу хийх ёстойг тайлбарладаг. Заримдаа Их Эзэн, “Хэрэв та нар [адислалыг хүлээн авахад шаардлагатай аливаа үйл ажиллагааг хийх юм бол], [Тэрээр ирэх адислалыг дүрслэн]” тусгайлан хэлдэг учраас эдгээр адислалуудыг танин мэдэж, хүлээн авахад амар хялбар байдаг.

Бусад тохиолдолд “хэрэв-тэгвэл” загварыг бид илүү анхааралтай ажиглах хэрэгтэй. Сургаал ба Гэрээ 112:3, 10, 21–22-ыг судалж, “Хэрэв та нар . . . бол, Тэрээр . . .” гэсэн загварыг тайлбарласан гурван нотолгоог өөрийнхөө үгээр бич.

В Энэ зарчим хэрхэн хэрэглэгддэг вэ?

1. Сургаал ба Гэрээ 112:20-д заасан зарчим нь ерөнхий чуулган дээр хэлсэн үгс, Сүмийн сэтгүүлүүдэд нийтлэгддэг Ерөнхий Эрх мэдэлтнүүдийн захиасууд, Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын тунхагууд, тэрчлэн *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө* товхимолд хэрхэн холбогдож болохыг тайлбарла.
2. Хожмын өдрүүдийн тухай Сургаал ба Гэрээ 112:24–26-д Их Эзэний хэлсэн зүйлсийг нэгтгэн дүгнэ.
3. Шүлэг 24–26 дахь Их Эзэний сургаалууд шүлэг 30-д Түүний хэлсэн зүйлтэй хэрхэн холбогдож болох вэ?



Сургаал ба Гэрээ 113 Судрын тухай асуултууд


Исаиагийн номон дахь зарим шүлгийн тухай Бошиглогч Иосеф Смитийн асуусан асуултуудад өгсөн Их Эзэний хариултуудыг Сургаал ба Гэрээ 113-р хэсэг агуулдаг. Та нар мэдэж авсан зүйлсээ өөрсдийнхөө Библид Исаиа дахь шүлгүүдийн хажууд тэмдэглэхийг хүсч болох юм.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 113

Сургаал ба Гэрээ 113:1–6—Иш, мочир, үндэс
Дараах зураг нь Бошиглогч Иосеф Смитийн асуусан Исаиагийн номын дүрслэлүүдийг харуулдаг.



Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 113-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Хариулт ба асуулт

1. Сургаал ба Гэрээ 113-р хэсэг дэх асуултуудыг жагсаан бичиж, Их Эзэний хариултуудыг нэгтгэн дүгнэ.
2. Их Эзэний хариултууд Бошиглогч Иосеф Смитэд болон Сүмд ямар ач холбогдолтой байсан гэж та нар бодож байна? (Энэ асуултанд хариулахдаа Исаиа 11, 52-ыг харж болно.)


Б Чухал үгс, нийлэмж үгсийг ол

Сургаал ба Гэрээ 113:7–10 дахь асуулт, хариулт нь хожмын өдрүүд дэх Израилын цугларалтын тухай юм. Эдгээр шүлгүүдэд авч үзсэн санаануудын жагсаалтыг доор өгөв. Тухайн санаанд холбогдох шүлгүүдийн үгс буюу нийлэмж үгсээр санаа бүрийн тухай тэмдэглэлийн дэвтэртээ бич.

1. Бурханы ажлыг хийх зөвшөөрөл
2. Израилын угсааны гишүүд
3. Ёс бус явдлаар бий болдог хязгаарлалтууд
4. Мөнх бус байдлын өмнөх амьдралд урьдчилан томилогдосод

Сургаал ба Гэрээ 114

Давид В. Паттенд өгсөн илчлэлт



Бошиглогчоос ирсэн номлолын дуудлагыг гэр бүлийн гишүүн задлах нь сэтгэл догдлом мөч байдаг.

Сургаал ба Гэрээ 114-р хэсэгт Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Давид В. Паттен үйлчлэх дуудлага хүлээн авдаг.

Харамсалтай нь Ахлагч Паттен номлолд ерөөсөө үйлчилж чадаагүй аж. Тэрээр дуудлага хүлээн авснаасаа хойш зургаан сарын дараа 1838

оны аравдугаар сарын 25-нд Крукед гол

дээр болсон тулалдаанд алагджээ. Урьд нь, Ахлагч Паттен “егүүтгэлээр амь үрэгдэхийг Их Эзэн өөрт нь зөвшөөрөөч хэмээн асууж өгөхийг Бошиглогчоос хүсэхэд, Бошиглогч сэтгэл нь ихэд догдолж, ‘үүний төлөө’ гүн харамсал илэрхийлээд, ‘тань шиг итгэлтэй хүн Их Эзэнээс юуг ч хүслээ гэсэн, хүссэнээ олж авдаг’ гэж [Ахлагч Паттенд] хэлжээ (Лайкөргус А.Вилсон, Life of David W. Patten: The First Apostolic Martyr [1900], 67).

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 114

Бишопын зөвлөл (ш. 2)—
Удирдан зохион байгуулах
үүрэг хариуцлагын дуудлага

Сургаал ба Гэрээ 114:2—“Тэдний оронд бусад нь тавигдах болно”

Энэ илчлэлтийн үед, мөрдлөг хавчлагын улмаас Сүмийн олон гишүүн Бошиглогч Иосеф Смитийг шүүмжилж, Сүмээс урвасан ажээ. Тэдний зарим нь Сүмийн удирдагчид байв. Тэдний оронд бусад хүмүүс тавигдах болно гэж Их Эзэн Сургаал ба Гэрээ 114:2-т хэлжээ. Эдгээр урвагчид Их Эзэний ажил өсөн дэвжихийг зогсоож чадаагүйг цаг хугацаа харуулсан билээ. Бурханы хаант улсыг үндэслэн байгуулахад туслахын тулд дуудагдсан ажлаа хийгээгүй хүмүүсийг орлуулахын тулд Их Эзэн бусад хүмүүсийг томилно. Бурханы ажил гүйцэлдэх болно!

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 114-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Юу хийснийг тайлбарла

Сургаал ба Гэрээ 114:1-д, “арилжаа наймааныхаа ажлаас салахыг” Их Эзэн Ахлагч Петр В.Паттенаас хүсчээ. Эл хүсэлтийг биелүүлэхэд төвөгтэй байж болох зүйлсийн талаар юу гэж бодож байгаагаа тайлбарла. Ахлагч Паттенаас хийхийг хүссэн зүйлтэй адил юуг өнөөдөр номлогчид номлолынхоо өмнө хийдэг вэ?

Б Чи юу гэж хэлэх байсан бэ?

Тойргийнхоо 17 настай санваартны найз гэж өөрийгөө бод. Номлолын дуудлага хүлээн авахгүй гэж боддогоо найз чинь өөрт чинь ярьжээ. Сургаал ба Гэрээ 114-р хэсгээс болон өөр газраас сурч мэдсэн зүйлээ ашиглан, яагаад найз чинь шийдвэрээ эргэн харах ёстой талаар түүнд юу хэлж болохыг бич.

Сургаал ба Гэрээ 115

Фар Вестийн Ариун сүм

“Хойд Миссурийн Гэгээнтнүүд шаргуу байсан тариа тарьж [1838 оны] зунжингаа дүнзэн байшингууд барин цаашид амар амгалан сайн сайхан байх мэт санагдаж байлаа. Тэд Жаксон гүнлэгийн иргэдтэй эцэстээ эвлэрч төв газартаа эргэж очиж чадна гэдэгт найдсан хэвээр байв. Гэвч энэ зуур байсан газартаа тэд хөгжин дэвжих бодолтой байв. Фар Вест ариун сүмийн хот болох ёстой нь илчлэлтээр (С ба Г 115:7) мэдэгдэв. Ийнхүү дараагийн хавар нь, Арванхоёрын Чуулга Их Британид номлолоор явахасаа өмнө (С ба Г 118:4) ариун сүмийн газрыг онцгойлон адислав. Фар Вест дэх илчлэлт нь Сүмийн албан ёсны нэр, ‘Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм’ гэсэн нэрийг (С ба Г 115:4) бас тогтоож, Сүмд санхүүгийн тогтвортой байдлыг бий болгон, гишүүдийг нь цаашид адисалсаар байх аравны нэгийн тогтолцоог бий болгосон билээ (С ба Г 119, 120)” (Даниел Х. Людлөү хянан тохиолдуулсан, Encyclopedia of Mormonism, боть 5, [1992], 2:926).

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 115

Жишиг (ш. 5)—Туг, далбаа
мэтийн бэлгэдэл

Сургаал ба Гэрээ 115:1—Бошиглогч Иосеф Смитийн зөвлөхүүд хэн байсан бэ?

“Огайогийн Көртландад 1837 оны есдүгээр сарын 3-нд болсон чуулган дээр Оливер Каудери, Эцэг Иосеф Смит, Хайрум Смит, Жон Смит нар туслах зөвлөхүүдээр дэмжигдэн батлагджээ.

“Тэвч, Сургаал ба Гэрээ 115-р хэсэг дэх илчлэлт өгөгдсөн үед, зөвхөн Эцэг Иосеф Смит, Жон Смит хоёр л туслах зөвлөхүүдээр үйлчилжээ (1838 оны дөрөвдүгээр сарын 26). Хайрум Смит Тэргүүн Зөвлөлд Фредерик Г.Виллямсын орыг эзэлж, Оливер Каудери Сүмийн гишүүнчлэлээ алдсан байлаа” (*Doctrine and Covenants Student Manual* [Religion 324–325, 1981], 286).

Сургаал ба Гэрээ 115:14—Миссурийн Фар Вестэд Ариун сүм яагаад огт баригдаагүй вэ?

“Тэр үед [1838 оны дөрөвдүгээр сар] Фар Вестэд 150 орчим байшин байсны дотор дэлгүүр, зочид буудлууд бас сургуулийн нэг сайхан байшин байжээ. Хот хээр толгодын дунд гайхалтайгаар, цоройн дүүлэх мэт сүндэрлэн боссон байв. . . .



Фар Вест, Миссури

“Ариун сүмийн суурийн чулууг 1838 оны долдугаар сарын 4-нд тавьжээ. . . . Өөр бага сага ажил хийгдсэн ч, мөрдлөг хавчлагын хар хүч дэндүү гаарсан тул тэндхийн Гэгээнтнүүд дахин цөллөгт явсан юм” (Смит, Сходал нар, *Doctrine and Covenants Commentary*, 742; мөн гурамсан судрын хавсралт дахь гэрэл зураг 11-ийг үз).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 115-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Үг бүрийг тайлбарла

Сургаал ба Гэрээ 115:4-т өгөгдсөн Сүмийн бүрэн нэрний үг бүрийг авч үз. Үг бүр нь яагаад чухал болохыг мөн энэ нэр Сүмийн тухай дэлхийд хандан юу өгүүлж байгааг тэмдэглэлийн дэвтэртээ тайлбарла.

Б Захидал бич

Нэг найз чинь ирээдүйн талаар санаа зовниж явдгаа, мөн дэлхий хэчнээн тогтворгүй, айдас төрүүлэм болж байгааг ярьжээ гэж бод. Түүний санаа зоволтыг хүлээн зөвшөөрч,

Сургаал ба Гэрээ 115:4–6-гаас сурч мэдсэн зүйлээ ашиглан айсуу яваа хатуу бэрх цагт аюулгүй байдлыг олохын тулд бид юу хийх ёстойг тайлбарласан захидлыг найздаа зориулж тэмдэглэлийн дэвтэртээ бич.



Эцсийн өдрүүдэд Аврагч Хоёр дахь Ирэлтдээ бэлтгэн Адамын тэргүүлэх нэгэн ариун цуглаанд хүрч ирнэ хэмээн Хуучин Гэрээний бошиглогч Даниел бошиглогсон байдаг (Даниел 7:9–14-ийг үз). Уг цуглаан дээр ямар хүмүүс байхыг Сургаал ба Гэрээ 27-р хэсэгт тайлбарлажээ. Эл цуглаан хаана болохыг бид Сургаал ба Гэрээ 116-р хэсгээс мэддэг.



Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 116

Эртний өдрүүд (ш. 1)—
Анхны хүн Адам

Сургаал ба Гэрээ 116:1—“Адам-ондай-Аман” гэж юу гэсэн үг вэ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Брус Р.МакКонки: “Аман бол Адамд Бурхан өөрийгөө мэдүүлсэн нэг нэр юм. Адам-ондай-Аман гэдэг бол цэвэр Адамын хэлнээс англи хэлэнд дамжин орж ирсэн нэр бөгөөд үгчилсэн орчуулга нь бидэнд илчлэгдээгүй юм.

Энэ үзэл бодол нь энэ эрин үед уг нэрийг анх хэрэглэсэн хүн-Бошиглогч Иосеф Смиттэй холбоотой байсан эхэн үеийн ах нараас доош дамжиж ирсэн бөгөөд *Адам-ондай-Аман* гэдэг нь *Адамын оршин суудаг байсан Бурханы орон гэсэн утгатайг* бид ойролцоогоор ойлгож болно” хэмээн тайлбарлажээ (*Mormon Doctrine*, 19–20).



Сургаал ба Гэрээ 116:1—“Адам өөрийн хүмүүст айлчлахаар ирнэ”

Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Жозеф Фиелдинг Смит заахдаа: “Адамын хүүхдүүд мянга мянгаараа, бүр хэдэн арван мянгаараа шүүлтэд цуглах нь зовлонт энэ дэлхий хэзээ ч үзээгүй нэгэн агуу үйл явдал байх болно. Энэхүү их хуралдай буюу их зөвлөлд эрин үеүдийн түлхүүрүүдийг эзэмшдэг бүх хүмүүс ажил үүргийнхээ тайланг тавина. Адам ч бас тайлангаа тавина. Дараа нь тэр бүх эрх мэдлийг Христэд [шилжүүлж] өгнө. Тэгээд Адам үр удмынхаа дээр хунтайж байх дуудлагадаа батлагдаж, тэргүүлэх энэхүү дуудлагадаа албан ёсоор тавигдан, алдар суугийнхаа титмийг үүрд мөнхөд өмсөх болно. Тэр үед Христийг Хаадын Хаан, Эздийн Их Эзэн болгон хүлээн зөвшөөрнө. Энэхүү хуралдай болох цаг хэр зэрэг удаан байхыг, эсвэл энэхүү их зөвлөл хэчнээн хэсэгтэй болохыг бид мэдэхгүй. Энэ бол энэ дэлхийн эхлэлээс хойш өнөөг хүртэлх хугацаанд байсан Бурханы санваартнуудын цугларалт гэдгийг мэдэх нь хангалттай юм. Энэ хуралдай дээр бүх эрин үеийн хүмүүс гүйцэтгэсэн тохинууллынхаа тухай мэдэгдэж, эзэн ба зарц нарын тухай сургаалт зүйрлэлд өгүүлдэг шигээр ажил үүргийнхээ тайланг тавина. Тэд шүүгдэх болно. Учир нь энэ бол дэлхий дээр Бурханы хаант улсын түлхүүрүүдийг эзэмшиж байсан эсвэл эзэмшиж байгаа зөв шударга хүмүүсийн цугларалт юм. Энэ бол ёс бусчуудын шүүлт биш. Бүх зүйл бэлтгэгдэж, хүн бүрийн ажил үүргийн бүрэн төгс тайлангаараа түлхүүр бүрийг бас хүчийг зохих эмх цэгцэд тавьсан үед, Христ тайлангуудыг хүлээн авч, энэ дэлхийн эрх бүхий Захирагч болон тавигдана. Санваарын эрхээр цугласан мянга мянган хүмүүсийн нэгдмэл саналаар энэхүү их зөвлөгөөн дээр тэрбээр байр сууриа эзэлнэ. Энэ үйл явдал ёс бусчуудын устгагдах агуу өдрийн өмнө болох бөгөөд Мянган Жилийн Хаанчлалын бэлтгэл болно” (*The Progress of Man*, 3 дахь хэвлэл, [1944], 481–482; мөн Брус Р. МкКонки, *The Millennial Messiah: The Second Coming of Son of Man* [1982], х. 578–588-ыг үз).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 116-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Шастир бич

Сургаал ба Гэрээ 27, 116-р хэсгүүдийг уншсанаасаа, Адам-ондай-Аман дахь хуралдай дээр юу харж, юу сонсож болох тухай шастир бич. Тусламж хэрэгтэй бол зүүвэр тайлбарууд болон “Судруудыг ойлгох нь” хэсгийг ашигла (мөн гурамсан судрын хавсралт 10 дахь гэрэл зургийг үз).

Сургаал ба Гэрээ 117 “Нэрийн төдий бус харин ажил үйлсээрээ”

Амьдрал чинь дууссаны дараа та нар өөрсдийгөө хэрхэн дурсан санаасай гэж хүсдэг вэ? Нэр тань “ариун дурсамжид” байх гэдэг юу гэсэн үг вэ? Энэ илчлэлт дэх зарим ах нарт наманчлах нь хэрэгтэй байхад харин нэг хүнийг үүргээ биелүүлснийх нь төлөө магтан сайшаажээ. Сүмийн эдгээр удирдагч нэг бүрд юу гэж хэлснийг ажиглан, эл зөвлөгөө өөрт чинь хэрхэн хамаатай байж болохыг бод.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 117

Сургаал ба Гэрээ 117:1–2—Их Эзэн мэдэж байлаа

“Цугларч, Фар Вестийг яаралтай барихыг Их Эзэн Гэгээнтнүүдэд зарлиг болгожээ [С ба Г 115:17-г үз]. *Көртландын Хуаран* гэж нэрлэгдсэн 515 хүнтэй бүлэг 1838 оны долдугаар сарын 6-нд Көртландаас Сионыг зорин хөдөлжээ. Есдүгээр сарын 14-нд уг бүлэгт дөнгөж 260 гишүүн үлдэж, бусад нь ‘ертөнцийн дөрвөн зүг, найман зовхист’ тарж бутран алга болсон байв. Аравдугаар сарын 4-нд бүлэг Адам-ондай-Аманд хүрч ирсэн аж. Маркс ч, Витней ч, бас Гранжер ч энэ бүлгийн гишүүн байсангүй. [Оливер Гранжер Миссурийн Фар Вестэд аль хэдийн хүрч ирсэн байв. Тэрээр энэ илчлэлтийг Огайогийн Көртландад Вилльям Маркс, Ньюэл К.Витней нарт хүргээд, Сионы нутагт яаралтай эргэж ирэхийг түүнд мэдэгджээ.] Тэр үед Иосеф Смит Фар Вестэд хэн нь Сионыг зорин явсан, хэн нь яваагүйг огт мэдэхгүй байсан ч харин Их Эзэн мэдэж байлаа. Иймээс энэ илчлэлтэд Тэрээр . . . Вилльям Маркс, Ньюэл К.Витней нарыг Сионд очуулахаар дуудаж, Көртланд дахь өмчийн талаар Гэгээнтнүүдэд зааварласан ажээ” (Смит, *Sходал нар, Doctrine and Covenants Commentary*, 744).



Адам-ондай-Аманы хөндий дэх Лайман Вайтын хоёр дахь жижиг байшин

Сургаал ба Гэрээ 117:8—“Олаха Шинехагийн тал”
“Олаха Шинехагийн тал буюу Адамын оршин сууж байсан газар [нэр нь] нь Адам-ондай-Аманы хэсэг эсвэл зэргэлдээх газар байх ёстой” гэж Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг бичжээ (*Church History and Modern Revelation*, 2:97).

Сургаал ба Гэрээ 117:8—“Жижигхэн тэр зүйд” шунах нь

“Сион дахь Гэгээнтнүүдтэй нэгдэхээр хөдөл хэмээн Их Эзэн тэдэнд зарлиг болгосон байхад Көртланд дахь өмчтэйгөө зууралдсаар байхыг хүссэн хүмүүс хамгаас ухаалаг бус байв. Өөрийнхөө хүмүүст Их Эзэний санал болгодог зүйлүүдтэй алгын чинээ газрыг харьцуулах нь хэчнээн өрөвдмөөр, хэчнээн өчүүхэн хэрэг билээ. Түүнээс гадна, Их Эзэн Өөрийнх нь хүсэл тааллыг дагасан хүмүүст газар, эсвэл тэдэнд хэрэгтэй юуг ч болов олж авахад нь мэргэн ухаанаараа тусалж чадахгүй гэж үү? (Марк 10:28–30-ийг үз.)” (*Сургаал ба Гэрээний Оюутны Гарын Авлага*, 289).

Сургаал ба Гэрээ 117:11—Николайчуудын бүлэг
Илчлэлт 2:6, 15-д *николайчууд* гэдэг үг байдаг. Энэ үгийн утга тодорхой биш юм. Гэхдээ николайчууд эхэн үеийн Христийн Сүмд хиймэл шүтээний зуршлуудаа авчрахыг хичээдэг байсанд зарим хүмүүс итгэдэг. Николайчууд бол дэлхийн арга маягаар амьдарч, өөрсдийнхөө Сүмийг хэвээр хадгалахыг хичээдэг Сүмийн гишүүд байлаа. . . . Өвөрмөц үйл хэрэг болон сургаал нь ямар ч байлаа гэсэн, тэд нэрсээ Сүмийн бүртгэлд байлгахыг хүсдэг байв. Гэвч сайн мэдээний зарчимд зүрх сэтгэлийн бүрэн эрмэлзэлтэйгээр өөрсдийгөө зориулахыг хүсдэггүй хүмүүсийг бий болгоход бодлого зорилго нь чиглэдэг байв” гэж Ахлагч Брус Р.МкКонки бичжээ (*Doctrinal New Testament commentary*, 3:446).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 117-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Их Эзэн юу санал болгодог вэ?

Нью-Йоркийг орхиж Огайог зорин явах, дараа нь Огайог орхиж, Миссурийг зорин хөдлөхийг Гэгээнтнүүдээс хүссэний адилаар гэрээ орхин явахыг өөрөөс чинь хүсчээ гэж бод.

Сургаал ба Гэрээ 117:1–9-д Их Эзэний хэлсэн зүйлүүдээс үзэхэд, ингэж шилжин явахыг өөрийн чинь хувьд юу илүү амар хялбар болгох вэ?

Б Танилцуулга бич

1. Оливер Гранжер танай тойрог эсвэл салбарт залуучуудад хандан үг хэлэх болж, чи түүнийг танилцуулах болжээ гэж бод. Сургаал ба Гэрээ 117:12–16 дахь мэдээллийг ашиглан түүний тухай товч танилцуулга бич.
2. Шүлэг 12–16-г дахин уншаад, Оливер Гранжерын оронд өөрийнхөө нэрийг тавь. Эдгээр шүлгүүд өөрт чинь хамаарснаар амьдралд чинь ямар өсөлт хөгжилт гарч болох тухай бод. Чи зарим бодол санаагаа хувийн тэмдгэлдээ бичихийг хүсч болно.



Сүмийн зарим гишүүд 1837–1838 онуудад Көртландад болсон асуудлуудын үед гэрчлэлээ алджээ. Нөхцөл байдал туйлын хүндэрч, анхны Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын дөрвөн гишүүн (Виллям И.МкЛеллин, Лук Жонсон, Лайман Жонсон, Жон Боинтон) урваж, гишүүн байх эрхээ хасуулав. Үүний улмаас Арванхоёрын Чуулгад суларсан орон тоонуудыг бөглөх хэрэгтэй болов. Хамгийн ойр дотно холбоотой ажилладаг хүмүүсээ алдсан нь Бошиглогч Иосеф Смитийн хувьд хэчнээн хэцүү байсныг та нар төсөөлж чадах уу? Мөрдлөг хавчлага болон бэрхшээлтэй тулгарсан үед итгэлтэй хэвээр үлдсэн хүмүүсээр бид бахархах ёстой. Тэр үед Чуулгыг бүрнээр нь бүрдүүлэхийн тулд шинэ Төлөөлөгчөөр дуудагдсан зарим хүмүүсийн нэрсийг та нар мэдэх болно. Тэднээс хоёр нь хожим нь Сүмийн Ерөнхийлөгч болсон билээ.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 118

Унасан (ш. 1)—Урвасан

Дэлгэрүүлэх (ш. 4)—
Зарлах, тунхаглах

Сургаал ба Гэрээ 118:4—Дараагийн хавар нь Төлөөлөгчид хаашаа явах ёстой байсан бэ?

Сургаал ба Гэрээ 118:4-д дурддаг “их ус” бол Атлантын далай юм. Атлантын далайг гатлан, сайн мэдээг Англид хүргэхийн тулд Их Эзэн Арванхоёр Төлөөлөгчийг дууджээ.

Сургаал ба Гэрээ 118:5—Төлөөлөгчид Фар Вестэд эргэж ирсэн үү?



“Бараг бүтэн жилийн дараа 1839 оны дөрөвдүгээр сарын 26-нд цугларах Их Эзэний тушаалыг Миссурийн хүмүүс мэдэж байсан бололтой. Тиймээс тэд Арванхоёрын ажилд саад тотгор учруулж, Мормоны шашныг боомлихоор санаа шулуудаад байжээ. Илчлэлт болон товлосон өдрийн хоорондох хугацаанд ‘Сүмийг Миссури мужаас бүхэлд нь хөөн гаргасан байлаа. Хэрэв хүн Хожмын Үеийн Гэгээнтэн гэдэг нь мэдэгдэх л юм бол, амь насанд нь халдах нь энэ мужид юу ч биш болоод байв. Ялангуяа Арванхоёрын хувьд бүр ч хэцүү байлаа. Ариун сүмийн суурийг тавих цаг болоход мужийн Захирагчийн зарлигаар Сүмийг Миссуригээс албадан гаргасан байлаа. Илчлэлтэд чиглүүлэгдсэний дагуу Сүм Иллинойд ирээд байв. Иосеф Смит, Хайрум Смит, Парли П.Пратт нар Есүсийн тухай гэрчилснийхээ төлөө Миссурид шоронд хоригдов. Энэ ажил хэрэгжих цаг ойртох тусам, “Яах вэ?” гэсэн асуулт тулгамдаад байв. Дөрөвдүгээр сарын 26-ны өдөр энд ариун сүмийн суурийг тавихын тулд Фар Вестэд ирсэн байхыг Арванхоёрт зарлиг болгосон илчлэлт биелэгдэх ёстой байлаа. Иосеф Смитээр дамжуулан өгсөн бусад бүх илчлэлт гүйцэлдэх ёсгүй, учир нь товлосон он сар, өдөр нь илчлэлт биелэгдэхгүй хэмээн миссуричууд үүрдийн бүх бурхдаараа андгайлсан аж. Ийм нөхцөлд Сүм дэх ерөнхий үзэл бодол нь, миний ойлгож байгаагаар, уг ажлыг гүйцэлдүүлэх нь боломжгүй боллоо, үйл хэргийн төлөө Их Эзэн үүнийг хүлээн авах болно” гэсэн байдалтай байлаа (Вилфорд Вудрафф, in *Journal of Discourses*, 13:159.)



“Гэвч Төлөөлөгчид өөрсдөд нь зарлиг болгосон үүргээ хойш тавьсангүй. 1839 оны дөрөвдүгээр сарын 25-ны шөнө, Төлөөлөгчдийн жижигхэн бүлэг, итгэлтэй ах нар, цөөн тооны дээд санваартнууд, ахлагч нар санваартнуудыг дагалдуулан Фар Вестэд хүрч иржээ. Шөнө дундаас хойш удалгүй, дөрөвдүгээр сарын 26-ны өглөө тэд Фар Вест дэх ариун сүмийн газар дээр цугларч, чуулган зохион байгуулжээ.” (Смит, *Church History and Modern Revelation*, х.196–197.)

“Бригам Янг тэргүүлсэн байна. Бичиг хэргийн ажилтан Жон Тейлор бичсэн нь:

“Зөвлөл Их Эзэний Өргөө барих газрын тухай цааш нь хэлэлцлээ. Ажил хэргийг явуулсны дараа: Арванхоёрын үүрэг зорилгын тухай нэг дууллын хэсгээс дуулав.

“Дараа нь Өргөөний мастер ажилчин Ахлагч Альфеус Катлер, илчлэлтийн дагуу, том чулууг зүүн өмнөд булан руу өнхрүүлэн Их Эзэний Өргөөний суурийг тавилаа.

“ ‘Арванхоёроос дараах хүмүүс байлцлаа: Бригам Янг, Хебер К.Кимбалл, Оорсон Пратт, Жон И.Пейж, мөн урвасан хүмүүсийн оронд. . . томилогдсон Вилфорд Вудрафф, Жорж А.Смит, Жон Тейлор нар байв’ (*History of the Church*, 3:336–338.)

“Төлөөлөгчдөөс хэдэн хүн залбирал хэлсний дараа, цугларгасад ‘Адам-ондай-Аманьг дуулж, Төлөөлөгчид явав’ (*Doctrine and Covenants Student Manual*, 291–92).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 118-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Шалтгаануудыг жагсаан бич

“Судруудыг ойлгох нь” хэсгийг Сургаал ба Гэрээ 118-р хэсгийн хамт унш.

1. Миссурийн Фар Вестэд цуглах нь Төлөөлөгчдийн хувьд яагаад хүнд байсан, бас тэд яагаад очсон шалтгааныг жагсаан бич.
2. Сургаал ба Гэрээ 118-р хэсэгт Их Эзэний хэлсэн зүйлүүдээс юу нь очихоор зориглоход нь тэдэнд тусалсан байж болох вэ?

Б Яаж гэдгийг тайлбарла

Үр ашигтай номлогчдын зарим зан чанарын талаар Их Эзэн Сургаал ба Гэрээ 118-р хэсэгт юу хэлснийг ол. Эдгээр зан чанарууд номлолын ажилд амжилт гаргахад хэрхэн нөлөөлж болохыг тайлбарла.



Жон Тейлор 1836 онд баптисм хүртжээ. Түмэн хүнд бэрхшээлийн үед тэрээр итгэлтэй хэвээр үлдсэн юм. Бошиглогч Иосеф Смитийг алагдахад тэр түүнтэй хамт Картейж Шоронд байв. Тэрээр Сүмийн гурав дахь Ерөнхийлөгч болсон билээ.



Жон И.Пейж 1833 онд баптисм хүртжээ. Тэр хэд хэдэн номлолд амжилттай үйлчилсэн боловч, хожим нь урваж, 1846 онд гишүүн байх эрхээ хасуулсан аж.



Вилфорд Вудрафф 1833 онд баптисм хүртсэн байна. Тэрээр сайн мэдээг Англид нэвтрүүлэхэд тусалж, найман сарын дотор 1800 гаруй хүнд баптисм хүртээжээ. Тэр Сүмийн дөрөв дэх Ерөнхийлөгч болсон билээ.



Виллард Ричардс 1836 онд баптисм хүртжээ. Тэр Төлөөлөгчөөр дуудагдах үедээ Англид номлолд үйлчилж байв. Бошиглогч Иосеф Смитийг алагдахад тэр түүнтэй хамт Картейж Шоронд байв. Хожим нь тэр Ерөнхийлөгч Бригам Янгийн зөвлөхөөр үйлчилж байв.

болно' (3 Нифай 24:10-12; мөн Малахи 3:10-12-ыг үз) гэж аравны нэгээ төлөгчдөд бас амласан юм. . .

“Аравны нэгийг төлөх нь бас төлөгч хувь хүнд хосгүй өвөрмөц сүнсний адислалуудыг авчирдаг. Аравны нэгийг төлөх нь бид золиослолын хуулийг хүлээн авсны нотолгоо болдог. Энэ нь бас өргөлийн хууль болон селестиел хаант улсын илүү дээд бусад хуулиудад биднийг бэлтгэдэг” гэжээ (In Conference Report, 1994 оны 4-р сар, 44-45; *Ensign*, 1994 оны 5-р сар, 34).

Сургаал ба Гэрээ 120

Захиран зарцуулагддаг : ямар нэг зүйлд зориулан
(ш. 1)—Зарцуулагддаг, : зарцуулдаг

Сургаал ба Гэрээ 120:1—“Зөвлөлөөр захиран зарцуулагддаг”

Тэргүүн Зөвлөлийн зөвлөх асан, Ерөнхийлөгч Ж. Рюбен Кларк аравны нэгийг хэрхэн захиран зарцуулдгийг тайлбарласан нь:

“Тэргүүн Зөвлөлийн удирдлага дор төсөв зохиогддог. . . Төсөвт аравны нэгээс төлөвлөж байгаа бүх зардал орно. Мөнгө зарцуулах хариуцлага хүлээдэг бүх газар, хэлтсүүд энэ төсвийг анхааралтайгаар нягтлан судалж үздэг.

“Дараа нь илчлэлтийн дагуу Тэргүүн Зөвлөл, Арванхоёрын Зөвлөл, Тэргүүлэх Бишопын Зөвлөлөөс бүрддэг Аравны Нэгийн Зөвлөл [өнөөдөр энэ нь Аравны Нэгийг Захиран Зарцуулах Хороо] төсвийг авч хэлэлцдэг. Энэ зөвлөл өргөн барьсан төсвийг хэлэлцэж, батлах уу, батлахгүй юу гэдгийг төсвийн төрөл зүйл бүрээр авч хэлэлцсэний эцэст төсвийг баталдаг.

“... Энэ хороо баталж, эрх мэдэл олгоогүй үед [аравны нэгийг] хэн ч захиран зарцуулж болохгүй” (In Conference Report, 1943 оны 10-р сар, 12).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 119-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Яагаад аравны нэг байдаг вэ?

1. Сургаал ба Гэрээ 119-120, мөн “Судруудыг ойлгох нь” хэсгийг уншсанаасаа, түүнчлэн эцэг эх, багш нар болон Сүмийн удирдагчдаас мэдсэн зүйлээсээ, Сүмийн аравны нэгийг юунд ашигладгийг жагсаан бич.
2. Аравны нэгийг хэрхэн зарцуулахыг хэн шийддэгийг тайлбарла.
3. Аравны нэгийг шударгаар төлснөөс ирдэг адислалуудын хоёр дахь жагсаалтыг хий.

Сургаал ба Гэрээ 121

“Олон нь дуудагддаг боловч цөөхөн нь сонгогддог”

Чи хэзээ нэгэн цагт сэтгэл санаагаар унаж байсан уу? Хүнд хэцүү нөхцөл байдалд чи залбирч үзсэн үү? 1838 оны аравдугаар сарын 27-нд Миссурийн захиррагч Лилберн В.Боггс: “Мормончуудыг дайсан гэж үзэн харьцах ёстой. Мөн тэднийг хүйс тэмтрэх буюу хэрэв шаардлагатай бол олон нийтийн сайн сайхан байдлын төлөө тус мужаас хөөн гаргах ёстой” (in *History of the Church*, 3:175) гэсэн үгтэй, хүйс тэмтрэн устгах, олиггүй муухай захирамж гаргажээ. Дөрвөн өдрийн дараа урвагчид Бошиглогч Иосеф Смит болон Сүмийн өөр хэдэн удирдагчийг Миссурийн Фар Вестэд Миссури мужийн цагдаагийн газарт барьж өгчээ. Гэгээнтнүүдийг хамгаална гэж бидний бодож байсан, Сүмийн гишүүн, тэргүүлэх офицер, хурандаа Хинкл, “захирагчаас хүлээн авсан хүйс тэмтрэн устгах захирамжийг хэрэгжүүлэхгүйгээр хүндрэл бэрхшээлийг шийдвэрлэж болно гэж найдан, цагдаагийн офицерууд надтай болон бусад зарим хүмүүстэй ярилцлага хийхийг хүсч байна гэж хэлэв. Би хүсэлтийг тэр даруйд биелүүлж, тэгээд . . . цагдаагийн хуаран руу хүрч очлоо. Гэтэл харин гайхалтай нь иргэн хүний хувьд хүн хүнтэйгээ хүндэтгэлтэйгээр харьцах ёс жудгийн оронд биднийг [Бошиглогч болон түүний хамтрагчдыг] дайны олзлогдогсод мэтээр баривчилж, бидэнтэй дээд зэргийн жигшүүртэйгээр харьцаж байлаа. . . . Тэнд гэрчилсэн үйл явдлаа би ярьж чадаагүй нь. Агаарыг нэвтлэн хэдэн бээрийн газарт сонсогдохоор мянга гаруй хүний чанга хашираах, орилох дуу чимээ, аймшигтай, гутаан доромжлох харьцаа, хараал зүхэл бидэн дээр урсан цутгах лугаа адил бууж байсан нь чулуу мэт хатуу зүрх сэтгэлийг ч сэрэхийн цочоомоор байлаа. Зөвхөн Бурханы хүч л амь насыг маань бүрэлгэхээс саатуулж чадах хүчирхэг харуулаар бид оройдоо хүрээлүүлэн, хүйтэн газар дээр хэвтэхээс аргагүй байлаа. . . .

“Цагдаа нар хотод орж ирэн, огтхон ч эрээ цээргүйгээр байшингуудыг тонон дээрэмдэж, гэм зэмгүй, хууль зөрчөөгүй оршин суугчидтай зүй бусаар харьцан, олон хүмүүсийг ядуу тарчиг болгож орхив” хэмээн Бошиглогч бичжээ. (*History of the Church*, 3:188-191)



Либерти шорон

Дараагийн хэдэн долоо хоногийн турш Бошиглогч Иосеф Смит болон түүний хамтрагчидтай зүй бусаар харьцан, доромжилж, яс янгинам хүйтнээр хол газар албадан явган явуулж байгаад, 1838 оны арванхоёрдугаар сарын

1-нд тэднийг Миссурийн Либерти шоронд хорьжээ. Тэдгээр эрчүүдийг ямар ч гэмт хэрэгт яллаагүй атал, хэдэн сарын турш аймшигтай нөхцөлд шоронд хорив.

“1839 оны гуравдугаар сарын 20–25-ны хооронд, бүх хоригдол гарын үсэг зурсан урт захидлыг (үнэн хэрэгтээ хоёр захидал байсан ч, Бошиглогч хоёр дахь захидлыг нэгдэхийн үргэлжлэл гэж үзсэн аж) Бошиглогч Иосеф хэлж бичүүлжээ. Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит энэ захидлын тухай бичихдээ: ‘Энэ бол хүний гараар бичигдсэн хамгийн агуу захидлуудын нэг юм. Чухамдаа энэ захидал бол даруухан сүнслэг нөлөөний үр дүн мөн. Энэ бол залбирал, бошиглол болон Их Эзэнээс ирсэн илчлэлтийн хариу юм. Христийн хайрын сүнсээр дүүрсэн, уужуу сэтгэлт хүмүүн биш аваас, өөр хэн ч ийм захидал бичиж чадахгүй. [Тэдний зовлон зүдиүүрүүдийг] авч үзэх юм бол Бошиглогч тусламжийн төлөө бие сэтгэлийнхээ шаналлаар хүчтэйгээр гуйн залбирсанд гайхах юун. Гэвч түүний чин сэтгэлийн гуйлтад тэсвэр хатуужлын болон нөхдөө хайрлах хайрын сүнс амьсгалж байсан юм’ гэжээ (Church History and Modern Revelation, 2:176.)” (Сургаал ба Гэрээний Оюутны Гарын Авлага [Шахин 324, 325], 295–296).



Сургаал ба Гэрээ хэсэг 121–123-ыг Либерти шоронд байхдаа Бошиглогч Иосеф Смитийн хэлж бичүүлсэн захидлуудаас авчээ. Эдгээр хэсгүүдийг 1876 оны Сургаал ба Гэрээний хэвлэлд анх удаа оруулжээ.



Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 121

Асар (ш. 1, 4)—Том майхан
Тослогдогсод (ш. 16)—
Үйлчлэхээр томилогдогсод
Хэвлий (ш. 45)—Зүрх (судруудад, хэвлий нь хүний

сэтгэл хөдлөлийн төвийг олонтаа бэлгэддэг)
Очирт таяг (ш. 46)—Таяг, эрх мэдлийн бэлгэдэл

Сургаал ба Гэрээ 121:3—“Хууль бус доромжлол” гэж юу байв?

Бошиглогч Иосеф Смит болон Сүмийн бусад удирдагчид Миссурийн Либерти шоронд байх үед (судлах гарын авлагын С ба Г 121-р хэсгийн оршлыг үз), “хүйс тэмтрэн устгах [Захирагч Лилбөрн В.Боггсын гаргасан] тушаалаас зугтахын тулд 8,000 гаруй Гэгээнтэн Миссурийг зүүн талаар нь гатлан Иллиной руу дүрвэжээ. Тэднийг хөхөө өвлийн хүйтнээр тэндээс албадан гаргасан юм. Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч Бригам Янг тэднийг удирдаж, боломжтой бүх тусламжийг үзүүлж байсан ч, тэд түмэн зовлон бэрхшээлийг амссан билээ (Бидний Өв: Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Товч Түүх [1996], 55).



Сургаал ба Гэрээ 121:7—Бэрхшээлийн ашиг тус

“Ахлагч Жеймс И.Фаустын [тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан] хэлснээр хүний амьдралд бэрхшээлээс ашиг тус ирж болно: ‘Бид өвчин эмгэг, гай зовлон, амьдралын баатарлаг хүч чармайлтаар цэвэршүүлэгчийн галан дундуур өнгөрдөг. Ингэснээр бидний амьдралд байдаг ач холбогдолгүй, шалих шалихгүй зүйлүүд хог шороо лугаа адил хийсэн алга болж, итгэл маань гэрэл гэгээтэй, эвдэрч гажаагүй, бат бөх болдог. Энэ замаар бодгалиас бурханлиг дүр төрх урган гардаг. Энэ бол зарим хүмүүсийн хувьд Бурханыг мэдэх цэвэршүүлэгч арга хэрэгслийн нэг хэсэг юм. Бид сул дорой байгаа үедээ, бас амьдралын зовлон зүдгүүр дунд Бурханлиг Хоньчны тэнгэрлэг шивнээг илүү сайн сонсдог бололтой.’ (In Conference Report, 1979 оны 4-р сар, х.77; Ensign, 1979 оны 5-р сар, х.53.)

“Зарим хүмүүс учирсан гай зовлонг Бурханы шийтгэл гэж боддог нь буруу. Харин гай зовлонгийн шалтгаан юу вэ гэдгийг ойлгох, үүнийг ашиг тустай зүйл болгож хувиргах нь асуудлын гол нь юм: ‘Харамсалтай нь, бидэнд учирдаг

хамгийн ноцтой гай зовлонгийн зарим нь өөрсдийн маань тэнэг үйлдэл сул дорой байдлын үр дагавар байдаг. Бас бидний хэнэггүй байдал эсвэл зөрчил зовлон зүдгүүрт хүргэх нь бий” (Жеймс И.Фауст, In Conference Report, 1979 оны 4-р сар, х.78; *Ensign*, 1979 оны 5-р сар, х.54). Зарим зовлон зүдгүүр нь өвчин эмгэг, төгс бус үйлдлийн эрхшээлд байдаг мөнх бус бие махбодын сул дорой, ялзрамтгай байдлын үр дагавар байдаг. Сонгох эрхийг ёс бус хүмүүс буруугаар ашигласнаас үүдэлтэй өөр учир шалтгаан ч бас бий. . . .

“ . . . Иосеф Смит бол шоронд хоригдож, доромжлуулан, аймшигтай бусармаг, шударга бус явдлыг олон удаа нүдээр үзэж, биеэр туулсан нэгэн. Энэ тухай Ерөнхийлөгч Бригам Янг хэлэхдээ, Бошиглогч өгүүлшгүй бэрх зовлонгийн далайг туулж өнгөрүүлсэн. Ийм гай зовлонгүйгээр мянган жилд хүрч чадах төгөлдөржилтөд тэрээр гучин найман жил гаруй хугацаанд хүрч чадсан юм” гэжээ (*Journal of Discourses*, 2:7)” (*Сургаал ба Гэрээний Оюутны Гарын Авлага*, 296-г үз).

Сургаал ба Гэрээ 121:34–36—Дуудагдаж бас сонгогдсон нь

Сургаал ба Гэрээ 121:34-ийн эхний хэсгийг иш татсаны дараа, Ерөнхийлөгч Харольд Б.Лий хэлэхдээ: “Хэдийгээр бидэнд сонгох эрх байдаг ч гэсэн, дэлхий бий болохоос өмнө урьдчилан томилогдож, энд ажиллахын тулд өөрсдийгөө их хэмжээгээр бэлтгэсэн олон хүмүүс байдаг. Бүр Эцэгийн Өөрийнх нь сонгосон удирдагчид байхаар тунхаглагдсан язгууртан, агуу хүмүүсийн дунд сонгогдсон хүмүүс байж болох ч гэсэн, дэлхийд мөнх бус байдалд тэд уг дуудлагадаа алдаа гарган бүтэлгүйтэж болно” гэжээ (In Conference Report, 1973 оны 10-р сар, 7; *Ensign*, 1974 оны 1-р сар, 5).

Сургаал ба Гэрээ 121:38—“Шилбүүрийн эсрэг өшиглөх” гэж юу гэсэн үг вэ?

Шилбүүр эсвэл үзүүрлэсэн саваа, заримдаа төмрөөр үзүүрийг нь ороосон байдаг, мал туухад хэрэглэдэг зүйл. Сайн мэдээний утгаар бол, “шилбүүрийн эсрэг өшиглөх” гэдэг нь биднийг зөв чиглэлд өсч хөгжихөд урамшуулан өдөөдөг Бурханы зарлигууд эсвэл сүнсний мэдрэмжийг эсэргүүцэх гэсэн утгатай.

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 121-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Бошиглогчид хандсан тайтгарлын үгс

1. Сургаал ба Гэрээ 121:1–3-т Бошиглогч Иосеф Смит Их Эзэнээс асуусан асуултуудыг өөрийнхөө үгээр бич.
2. Гэгээнтнүүдийн төлөө Бошиглогч яагаад тийм их гунигтай байсныг тайлбарлах юу тохиолдсон байж болох вэ? (энэ судлах гарын авлагын С ба Г 121-р хэсгийн оршил, хэрэв тусламж хэрэгтэй бол “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз).
3. Бошиглогчийг тайтгаруулахын тулд Их Эзэн шүлэг 7–10-т юу хэлснийг өөрийнхөө үгээр бич.

4. Өөрт чинь тохиолдох хүнд сорилт болон бэрхшээлдүүдийн талаар илүү хөнгөнөөр бодоход шүлэг 7–10-т Их Эзэний хэлсэн зүйлүүд чамд хэрхэн тусалж болох вэ?

Б Үр дагавруудыг тайлбарла

Ёс бусчууд итгэлтнүүдийг мөрдөн хавчсанаа төлөө шийтгүүлэхгүй байгаа юм шиг зарим үед санагдаж болно. Бурхан болон Түүний үйлчлэгчдийн эсрэг тэмцсэн хүмүүст ямар үр дагаврууд тохиохыг Сургаал ба Гэрээ 121:11–25-ыг уншсанаасаа тайлбарла. Таны хариултад дараах үгс буюу нийлэмж үгс хэрхэн хэрэглэгдэж болохыг тусгайлан эрж хай: *Сохлох*, “өөрсөд дээр нь ирж болох бөлгөө,” *арчигдах*, *таслагдах*, *үзэн ядагдах*, *санваар*, *тээрмийн чулуу*.



Их Эзэний үйлчлэгчдийг мөрдөн хавчдаг хүмүүс “хүзүүндээ тээрмийн чулуу зүүгээд, далийн гүнд живсэн нь дээр байсан юм” (С ба Г 121:22).

В Амлалтуудыг тоол

Их Эзэн итгэлтнүүдэд зориулсан адислалуудыг Сургаал ба Гэрээ 121:26–33-т амлажээ. Судрууддаа эдгээр адислалуудыг тоолж, өөрийнхөө хувьд чухал нэг адислалын тухай бич.

Г Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 121:34–36

Санваар эзэмшигч санваараа хүндэтгэж, үр ашигтайгаар хэрэглэхийн тулд юу хийх ёстойг Сургаал ба Гэрээ 121:34–46 дүрсэлжээ. Эдгээр шүлгүүдийг судлаад, дараах асуултуудад хариул:

1. Яагаад зарим хүмүүс “сонгогдоход” бусад нь сонгогддоггүй вэ?
2. “Санваарын эрх,” “тэнгэрийн хүчний” хооронд ямар холбоо байдаг вэ?
3. Ямар зарчим дээр тэнгэрийн хүчнүүд хянагддаг вэ?
4. Санваар эзэмшигч юуны улмаас санваарын хүчээ алдаж болох вэ?
5. Бусдад зохих ёсоор нөлөөлөхийн тулд зөв шударга санваартан ямар аргуудыг ашиглах ёстой вэ?
6. Санваарыг зохих ёсоор ашигладаг хүмүүст ямар адислалууд амлагдсан бэ?

Сургаал ба Гэрээ 122

“Хүмүүсийн чамд хийх зүйлээс бүү эмээ”

Амьдрал шударга биш бөгөөд өөрийгөө бусад хүмүүсээс илүү их зовсон гэж боддог хүмүүсийн нэгэн адил чи нэг удаа ч гэсэн ингэж бодсон байж болох юм. Сургаал ба Гэрээ 121–123-р хэсэгт бичигдсэн үед Бошиглогч Иосеф Смит болон түүний хамтрагчид ямар ч гэмт хэрэгт буруутгагдаагүй, эсвэл ямар ч шүүх хурлаар хэрэг таслуулаагүй атлаа Либерти Шоронд дөрвөн сар хоригдоод байв. Сургаал ба Гэрээ 122-р хэсгийг судлаад, Их Эзэн яагаад бүр зөв шударга хүмүүсийг ч гэсэн зовохыг зөвшөөрдгийг ажигла.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 122

Сургаал ба Гэрээ 122:7—Бэрхшээл зовлон хэрхэн бидний сайн сайхны төлөө байж болох вэ?

Ерөнхийлөгч Харольд Б.Лий: “Амьдралын сорилт, бүр хүнд сорилтуудаас ч бүү ай. Зарим үед та нар хамгийн хүнд сорилтуудыг туулан гарснаар, Их Эзэн Өөрийн биеэр уулан дээрх, Гетсеманийн Цэцэрлэгт, Калварид загалмай дээрх уруу таталтуудыг туулан гарсан туршлагауудын адил, судруудын цэдэгт хэлсэнчлэн, ‘Мөн, болгоогтун, тэнгэр элчүүд ирж, Түүнд үйлчилж эхлэв’ (Матай 4:11) гэснээр та нар бодож байснаасаа илүүгээр Бурханд ойртох болно. Зарим үед энэ нь чамд учирсан хүнд сорилтуудын дунд тохиож болно” гэж хэлжээ (*The Teachings of Harold B. Lee*, хянан тохиолдуулсан Клайд Ж.Виллямс [1996], 192; мөн “С ба Г 121:7-гийн Судруудыг ойлгох нь” хэсэг, х.[00] 138-ыг үз).



Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 122-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Хүнд сорилтуудынхаа үед тусламжийг хайж ол

1. Хүмүүс тулгарсан хүнд зовлон, бэрхшээлүүдийн талаар бухимдан, санаагаар унан тэнгэр өөд харж, “Яагаад би?” хэмээн олонтаа асуудаг. Бошиглогч Иосеф Смитийн хандлага өөр байлаа. Сургаал ба Гэрээ 121:2–3-ыг нэгтгэн дүгнэж, “Яагаад би?” гэхийн оронд Иосеф Смитийн асуусан асуултуудыг жагсаан бич.
2. Өөрт нь болон Сүмийн үлдсэн хэсэгт яагаад ийм хүнд бэрхшээл зовлон тохиолдсоныг Бошиглогч асуугаагүй ч, Их Эзэн зарим шалтгааныг түүнд хэлжээ. Сургаал ба Гэрээ 122:5–9-өөс, Бошиглогчид Их Эзэний хэлсэн зүйлүүдийг нэгтгэн дүгнэ.
3. Сургаал ба Гэрээ 122-р хэсгээс амьдралд хүнд зовлон, бэрхшээл тохиолдох үед тусалж болох, танд гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн зүйлийн талаар бич.

Сургаал ба Гэрээ 123

Цэдэг хөтлөхийн ач холбогдол


Эцсийн шүүлтэнд бүх хүн төрөлхтөн “өөрсдийн үйлсийн дагуу энэхүү номонд бичигдсэн зүйлсээр шүүгдэх” (*Илчлэлт 20:12*) болно. Сургаал ба Гэрээ 123-р хэсгийг судлаад, уг шүүлтэнд хэрэглэгдэж болох зарим цэдгийн тухай, мөн эдгээр цэдгүүд эцсийн шүүлтийн өмнө хэрхэн хэрэглэгдэж болох талаар юу мэдсэнээ шалга.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 123

Албан мэдүүлгүүд (ш. 4)—Бичгээр гаргасан гэрчийн мэдүүлэг



*“Шуурганы үед маш том хөлөг онгоц нэн жижигхэн залууртай явснаар салхи хийгээд давалгаатай зохицолдон нэн их ашигтай байдаг”
(С ба Г 123:16).*

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 123-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Чи юу хийх хэрэгтэй вэ?

1. Хэрэв чи 1839 онд Сүмийн гишүүн байсан бол Сургаал ба Гэрээ 123:1–5 дахь Их Эзэний зарлигийг биелүүлэхийн тулд чамаас юу хийхийг хүсэн хүлээх байсан бол?
2. Шүлэг 5–15-аас сурч мэдсэн зүйлээсээ, цуглуулсан мэдээллээрээ юу хийхийг жагсаан бич.
3. Сүмийн ирээдүйн үеийнхнийг адисалж болох ямар цэдгүүдийг та нар эдүгээ хөтөлж болох вэ?

Иллинойн Науву дахь Сүм

“Миссури муж дахь мөрдлөг хавчлагын улмаас Гэгээнтнүүд Миссиссиппи мөрнийг гатлан, Иллиной руу зүүн хойд зүгт гурван зуун хорь орчим километр явж, тэнд илүү ая тухтай нөхцөлийг олжээ. Эцэстээ Гэгээнтнүүд хөгжөөгүй хот Коммерсийн ойролцоо газар худалдаж авав. Энэ газар хэдхэн энгийн барилгатай, нэлэнхүй намагтай, эзлүүд газар байлаа. Гэгээнтнүүд газрыг хатааж, орон гэрээ барин төвхнүүлсэн аж. Иосеф Смит гэр бүлээ жижигхэн дүнзэн байшинд оруулав. Коммерс хотын нэрийг ‘үзэсгэлэнт’ гэсэн утгатай еврей үгээр Науву болгон өөрчилжээ” (Судруудын Удирдамж, “Науву, Иллиной (АНУ),” х.139–140).

Бошиглогч Иосеф Смит Сургаал ба Гэрээний нэлээд хэдэн хэсгийг, түүний дотор, Наувуд ариун сүм барих зарлигийг энд цэдэглэжээ (С ба Г 124–129, 132, С ба Г 124:26–27-г үз). Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байсан Ахлагч Жон Тейлор, Бошиглогч Иосеф Смит, ах Хайрум хоёрын аллагын тухай гэрчлэлээ мөн Наувуд баримтжуулсан юм (С ба Г 135-р хэсгийг үз).

Гэгээнтнүүд Наувугийн Ариун сүмийг барьж, Сионы тойрог болон гадаснууд, Нийгмийн Халамжийн Бүлгийг зохион байгуулжээ. Мөн 1846 онд орон гэрээсээ хөөгдөхийн өмнө нас барагсдын өмнөөс гүйцэтгэх ёслолуудыг эхэлсэн байна. Тэд мөрдлөг хавчлагын улмаас Ерөнхийлөгч Бригам Янгийн удирдлага дор уг нутгийг орхин өрнө зүгт аянд гарсан билээ.



Сургаал ба Гэрээ 124

Ариун барилгууд ба ариун дуудлагууд

Иллинойн Науву дахь Сүмийн эхэн үед анхаарал хандуулах хэрэгтэй байсан олон нарийн ширийн зүйл байлаа. Сургаал ба Гэрээ 124-р хэсэг хоёр чухал барилгын тухай зааврууд, хувь хүмүүст өгсөн олон дуудлагыг агуулдаг. Энэ илчлэлтийг судлахдаа, ариун сүмүүд болон ариун сүмийн ёслолуудын ач холбогдлын тухай Их Эзэн юу заасныг эрж ол. Өөрт чинь тулгарч байгаа сорилтуудад шууд холбогдох үр ашигтай зааврыг Их Эзэн чамд өгөхийг чи хүсэх үү? Тэрээр өнөөдөр үр ашигтай зааврыг хэрхэн өгдөг вэ?

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 124

Айлчлалын өдөр (шүлэг 8, 10)—Есүс Христийн Хоёр дахь Ирэлт
Зөгнөлүүд (ш. 39, 126)—Илчлэлтүүд

Алдарт ургамлууд (ш. 61)—Сүмийн удирдагчид
Шинэ орчуулга (ш. 89)—Библийн Иосеф Смитийн Орчуулга

Сургаал ба Гэрээ 124:2—“Ордны маягаар засан сайжруулснаар өнгөлөгдсөн”

Иллинойн Науву дахь Сүмийн гадсыг “Сионы суурийн чулуу” эсвэл харш орд шиг үзэсгэлэнтэй сайхан болгохыг Их Эзэн Гэгээнтнүүдэд зарлиг болгосон юм. Их Эзэн итгэлтэй Гэгээнтнүүдээ хаана ч хамтад нь цуглууллаа гэсэн, “та нарын гэрэл үндэстнүүдийн хувьд жишиг байж болохын тулд босч, урагш гэрэлтүүл” (С ба Г 115:5) хэмээн тэдэнд зарлиг болгож байлаа.

Сургаал ба Гэрээ 124:2–6—“Бүх үндэстнүүдэд . . . хүндэтгэлтэйгээр тунхагла”

“Их Эзэний энэ захирамж 1845 он хүртэл хэрэгжээгүй юм. Уг баримт бичгийг бэлтгэхэд нэлээд олон хүмүүс туслах ёстой байсан ч, баримт бичгийг батлан гаргах Арванхоёрын нөхцөл байдал үүнийг хойшлуулсаар байсан бололтой (History of the Church, 6:80; 7:320, 558-ыг үз)” (Doctrine and Covenants Student Manual, 304).

Сургаал ба Гэрээ 124:6—Ямар “тус” Сион дээр ирсэн бэ?

“1841 онд эл илчлэлт өгөгдөх үед энэхүү үзэсгэлэнт хот 3,000 орчим оршин суугчтай байв. Иллинойн Хууль Тогтоох Байгууллага дүрэм батлан гаргав. Уг дүрмээр Науву нь цагдаагийн газар бий болгож, их сургууль байгуулах эрх мэдэлтэй, чөлөөт хотын захиргаатай болжээ. Ариун сүм барих гэж байлаа. Тараагдсан Гэгээнтнүүд цугларч, Иллиной дахь суурьшилт түргэн өсч байв. Их Британи дахь номлол өндөр амжилт олов. Эл илчлэлт өгөгдсөн үеийн ерөнхий нөхцөл байдал ийм байлаа. Сүм түр зуур амсхийв. Дараагийн шуурганы өмнө нам гүм байв” (Смит, Сходал нар, Doctrine and Covenants Commentary, 768).

Сургаал ба Гэрээ 124:19, 130—“Давид Паттеныг би өөртөө авсан”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн Ахлагч Давид В.Паттен 1838 оны аравдугаар сарын 25-нд Миссурийн Крукед гол дээр болсон тулалдаанд алагджээ. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан Ахлагч Хебер К.Кимбалл, Ахлагч Паттеныг үхлүүт хэвтэж байхад нь очиж уулзсан аж. Ахлагч Кимбалл өгүүлсэн нь:

“Өмнө нь түүнд өдий их үнэ цэнэтэй байсан Сайн мэдээний зарчмуудад тэрээр эцсийнхээ мөчийг хүртэл ихэд хүндэтгэлтэйгээр хандаж байлаа. Түүнийг өөд болоход энэ нь түүнд дэмжлэг, тайтгарлыг өгч, үхлийн ялзрал, айдсыг үгүй болгосон юм. Туйлбартай байдлаасаа урваж няцсан хүмүүсийн тухай тэрээр өгүүлж, ‘Ай тэд миний байдалд байсан болоосой! Учир нь би итгэлээ хадгалж үлдсэнээ мэдэрч байна. Би мөр замаа дуусгалаа. Энэ цагаас хойш шударга Шүүгч Их Эзэн өгөх титмээ надад зориулан хадгална’ хэмээн дуу алдав.

“Амьсгалаа хураах мөчид дэргэд нь байсан хайрт гэргийдээ хандан, тэрээр, ‘чи өөр юу ч хийлээ гэсэн, итгэлийг л бүү үгүйсгэ! гэж билээ’ ” хэмээн бичжээ (in “History of Brigham Young,” Millennial Star, 1864 оны 7-р сарын 16, 454–455).

Сургаал ба Гэрээ 124:22-24, 56-83, 119-121— Наувугийн Өргөө



“Наувугийн Өргөөний зочид буудлын барилгыг бараг л ариун сүмийн барилгатай адил яаралтай барих ёстой гэж Бошиглогч үздэг байв. Тэрээр энэ барилгыг Гэгээнтнүүд хүмүүсийг урьж ‘эд баялаг, зан төлөв, нөлөөний тухай’ [History of the Church, 5:328; мөн 5:137-г үз] үнэнийг заах хэрэгсэл гэж үздэг байсан аж. Барилгын суурийн чулууг 1841 оны аравдугаар сарын 2-нд тавьсан ба нэлээд хэдэн үнэ цэнэтэй цэдэг, түүний дотор Мормоны Номын гар бичмэлийг хамт байрлуулжээ. Зочид буудал дээр ажиллахыг хурал цуглааны индэр дээрээс ах нарт байнга урамшуулан дэмжиж байв. Гэвч хөрөнгө мөнгө, ажиллах хүч хомс байснаас ажил удааширч байлаа. 1844 оны гуравдугаар сард Иосеф Смит ариун сүмийг хурдавчлахын тулд зочид буудлын барилгын ажлыг хойшлуулжээ” (Church History in the Fullness of Times, 243).

Сургаал ба Гэрээ 124:25-36—Нас барагсдын өмнөөс хийх баптисм



Бошиглогч Иосеф Смит 1843 оны зургадугаар сард хэлсэн нэгэн үгэндээ ариун сүм болон ариун сүмийн ёслолууд, түүний дотор нас барагсдын өмнөөс хийх баптисмын ач холбогдлын тухай заажээ:

“Санваарын зарчмууд болон хуулиуд энэ дэлхийн эрин зуун бүрд хүмүүсийн цугларалтын үеэр батлагдах ёстой нь дэлхий бий болохоос өмнөх тэнгэрийн зөвлөгөөний загвар

байв. Хүмүүсийг цуглуулахын тулд Есүс бүхнийг хийсэн, харин тэд цуглараагүй юм. Иймээс Тэрээр тэдэн дээр зүхлийг юүлсэн. Дэлхийн сууринаас өмнө хүмүүний авралын төлөө санваараар тэнгэрт үндэслэгдэн бий болсон ёслолууд өөрчлөгдөөгүй, эсвэл хувираагүй юм. Бүх хүмүүс нэг адил зарчмаар аврагдах ёстой.

“Эцсийн өдрүүдэд Бурхан Өөрийн хүмүүсийг цуглуулан, тэднийг ёслолууд болон хишиг хүртээлтүүд, угаалга болон тослолтууд гэх мэтчилэнд бэлтгэх Их Эзэний өргөөг барих нь мөн л ийм зорилготой юм. Их Эзэний өргөөний нэг ёслол бол нас барагсдын өмнөөс хийх баптисм юм. Эл ёслолыг энэхүү зорилгын төлөө Их Эзэний өргөөнд тусгайлан бэлтгэсэн баптисмын санд гүйцэтгэх ёстойг Бурхан дэлхийн сууринаас өмнө хуульчилсан юм” (History of the Church, 5:423-424).

Нас барагсдын өмнөөс хийх баптисмын тухай анх дурдсан орчин үеийн судар бол Сургаал ба Гэрээ 124:29-36 юм. Гэвч энэ бол энэ эрин үед заагдсан анхны тохиолдол биш. 1840 оны аравдугаар сараар хаяглагдсан Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгынханд явуулсан нэг захидалд Бошиглогч Иосеф Смит бичихдээ:

“Нас барагсдын өмнөөс хийх баптисмын’ сургаал та нарын сонорт хүрсэн хэмээн би бодож байна. Энэ сэдвийн талаар оюун ухаанд тань зарим асуулт гарч ирж болох юм. Уг асуудлын талаар хүсч байгаа бүх мэдээллийг тань би энэ захидалд өгч чадахгүй. Гэвч Библийг мэддэг байсны зэрэгцээгээр эртний сүмүүд нас барагсдын өмнөөс хийх баптисмыг хэрэглэж байсан нь тодорхой юм. Иймээс үхлээс амилуулагдах сургаалыг Гэгээнтэн Паул нотлохыг хичээн, ‘Тийм биш бол үхэгсдийн төлөө баптисм хүртэгч нь юу хийж байгаа хэрэг вэ? Хэрэв үхэгсэд амилуулагдаулахгүй юм бол юунд тэдний төлөө хүмүүс баптисм хүртдэг вэ?’ [1 Коринт 15:29] гэж хэлсэн байдаг.

“Би Сеймоюр Брансон ахын оршуулга дээр [1840 оны наймдугаар сарын 15] үг хэлэхдээ уг сургаалыг нийтийн өмнө анх удаа дурдсан. Ингээд тэр үеэс хойш би энэ сэдвээр Сүмд ерөнхий зааврууд өгсөөр байгаа. Хэрэв Сайн мэдээг сонсох боломж хүмүүст байсан бол, мөн Сайн мэдээг сүнсний шоронд байхад нь тэдэнд номлох итгэмжлэл хүлээсэн хүмүүсийн зэмсгээр нас барагсдын төлөөх баптисмыг сүнсээр хүлээн авах болно гэдэгт итгэдэг Гэгээнтнүүдэд нас барсан садан төрлүүдийнхээ өмнөөс баптисм хүртэх онцгой боломж бий.

“Эл сэдвийн хүрээг өргөжүүлэлгүйгээр байнгын болон учир шалтгааных нь үндсийг та бүгд харж байгаа нь эргэлзээгүй. Энэ сэдэв зарим хүмүүсийн төсөөлдөгөөс илүү өргөн хүрээгээр Христийн Сайн мэдээг төлөөлдөг нь дамжиггүй” (History of the Church, 4:231).

“Нас барагсдын өмнөөс хийх баптисмыг зөвхөн Их Эзэний тогтоосон газарт хийх ёстойг дээрх илчлэлт тайлбарладаг. Онцгой нөхцөл байдалд ариун сүмээс гадуур уг ёслолыг гүйцэтгэхийг хүлээн зөвшөөрсөн цорын ганц тохиолдол нь Наувугийн Ариун сүмийг дуусгахаас өмнө ёслолыг Миссисиппи мөрөнд гүйцэтгэхийг Их Эзэн зөвшөөрсөн явдал байлаа. Ариун сүмийн баптисмын сан дуустал нас барагсдын өмнөөс хийх баптисм дахиад болохгүйг 1841 оны аравдугаар сард Бошиглогч зарласан ажээ. Ариун сүмийн баптисмын сан арваннэгдүгээр сард дуусч, хорин нэгэнд баптисм дахин эхлэв” гэжээ (С ба Г 124:27-30-ийг үз) (Doctrine and Covenants Student Manual, 307).

Сургаал ба Гэрээ 124:28—Энд дурдсан “санваарын бүрэн байдал” юу вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли хэлсэн нь: “Их Эзэн тэдний дунд алхаж явсан үед Арванхоёрт олгогдсон Ариун санваарын түлхүүрүүдээр дамжин, эрт дээр үед эдгээр түлхүүрүүдийг эзэмшиж байсан хүмүүсээр энэ эрин үед сэргээгдсэн түлхүүрүүдээр дамжин-өсөн нэмэгдсэн агуу адислалууд, түүний дотор Их Эзэний өргөөнд гүйцэтгэдэг хосгүй өвөрмөц, гайхалтай ёслолууд ирсэн юм. ‘Санваарын бүрэн байдлыг’ ашиглах нь зөвхөн эдгээр ёслолуудаар хэрэгждэг.” (С ба Г 124:28) (In Conference Report, 1985 оны 10-р сар, 73; *Ensign*, 1985 оны 11-р сар, 59)

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Гүйцэтгэх Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Боид К.Пакер тайлбарласан нь: “Эрэгтэй хүн хажуудаа эмэгтэй хүнгүйгээр санваарын бүрэн байдлыг хүлээн авдаггүй. Учир нь Их Эзэний ариун сүмээс гадуур санваарын бүрэн байдлыг ямар ч эр хүлээн авч чадахгүй хэмээн Бошиглогч хэлжээ [С ба Г 131:1–3-ыг үз]. Ийнхүү эмэгтэй хүн тэрхүү ариун газарт эрэгтэй хүний дэргэд байх ёстой. Эрэгтэй хүний хүлээн авдаг бүхнийг эмэгтэй хүн хуваалцдаг юм. Эрэгтэй хүн эмэгтэй хүн хоёр ариун сүмийн хишигт агуулагддаг ёслолуудыг тус тусдаа хүлээн авдаг билээ. Гэвч эрэгтэй хүн хажуудаа эмэгтэй хүнгүйгээр хамгийн дээд ёслол-лацдан холболтын ёслолууд руу өгсөн очиж чадахгүй” (In Conference Report, 1998 оны 4-р сар, 96; *Ensign*, 1998 оны 5-р сар, 73).

Сургаал ба Гэрээ 124:87–91, 97–102—Виллям Лоо
Виллям Лоо Бошиглогч Иосеф Смитийн хоёрдугаар зөвлөхөөр дуудагдсан бөгөөд бусад цөөхөн хүнд амлагдсан адислалууд болон бэлгүүд түүнд амлагдсан ажээ. Гэвч тэрээр итгэлтэй хэвээр үлдсэнгүй. Ингээд “Христийнхтэй адилгүй зан авирын улмаас” (*History of the Church*, 6:341) 1844 оны дөрөвдүгээр сарын 18-нд гишүүн байх эрхээ хасуулсан аж. “Виллям Лоо хэдийгээр Иосефын зөвлөх байсан ч, түүнд хамгийн хорсолтойгоор дайсагнагч, бас гүтгэн гүжирдэгч болсон юм . . . Тэр бас Иосеф Смитийн амийг хорлохоор зарим миссуричүүдтэй сэм хуйвалдаж байсан нь хожим нотлогджээ. . . . Гэвч, тэрээр аллагыг санаандаа төлөвлөж байсан ч, хувь хүний хувьд түүний зан төлөв нь ерөнхийдөө эелдэг дөлгөөн, хувирч өөрчлөгдөх нь амархан байжээ” (in *History of the Church*, 7:57).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 124-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас тавыг хий.

А Ариун сүмийн зорилгыг ол

1. Сургаал ба Гэрээ 124:25–41-ийг уншаад, ариун сүм барих тухай Их Эзэний өгүүлсэн шалтгаануудыг жагсаан бич.
2. Дээрх шалтгаануудаас хоёрыг сонгож, эдгээр адислалууд өөрт чинь яагаад чухлыг хэл. Жишээ нь: Ариун сүмийн ёслолууд яагаад өөрт чинь чухлыг хэл.

Б Үр дагавруудыг тайлбарла

Сургаал ба Гэрээ 124-т, Их Эзэнд зориулан ариун сүм барих нь чухал боловч, зөвхөн ийм барилгатай байх нь хангалтгүйг Их Эзэн Бошиглогчид хэлсэн байдаг.

1. Сургаал ба Гэрээ 124:42–48-д хэрэв гэдэг үг гарч ирэх бүрд үүнийг дугуйлан зур. Тэгээд “хэрэв” гэдэг үг бүрийн

хувьд юу тохиолдох болно гэж Их Эзэний хэлсэн зүйлүүдийг жагсаан бич.

2. Эдгээр шүлгүүдээс мэдсэн зүйлүүдээ-нэг нь дуулгавартай байдлын адислалуудыг дүрсэлсэн, нөгөө нь дуулгаваргүй байдлын үр дагавруудыг дүрсэлсэн, “хэрэв-тэгвэл” гэсэн хоёр нотолгоо болгож нэгтгэн дүгнэ.

В Зарчмыг тайлбарла

Их Эзэн өөрийн зарлиг болгосон юуг боловч биелүүлэхэд нь өөрт нь туслах болно гэсэн итгэлээ 1 Нифай 3:7-д Нифай илэрхийлсэн байдаг. Гэгээнтнүүд Түүний хүссэн зүйлийг итгэлтэйгээр хийхийг хичээсэн боловч, гүйцэлдүүлж чадаагүй нөхцөл байдлыг Их Эзэн Сургаал ба Гэрээ 124:49–54-т дүрсэлжээ. Энэ хоёр судрыг харьцуулж, эдгээр судруудын заадаг дуулгавартай байдлын зарчмыг тайлбарла.

Г Хайрум Смитийн дуудлага

Сургаал ба Гэрээ 124:91–96 Хайрум Смитийн дуудлагын тухай заадаг.

1. Хайрум Смитийн үүрэгт ажлуудыг жагсаан бич.
2. Тэр хэний оронд томилогдсон бэ?

Д Удирдагчдыг тогтоо

Сургаал ба Гэрээ 124:124–144-ийг судалж, дараах санваарын албан тушаалуудыг хэн эзэмшиж байсныг тогтоо:

1. Патриарх
2. Сүмийн Ерөнхийлөгч
3. Тэргүүн Зөвлөлийн зөвлөхүүд
4. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч
5. Гадасны Дээд Зөвлөлийн гишүүд
6. Дээд санваартнуудын Ерөнхийлөгч
7. Ахлагч нарын Чуулгын Ерөнхийлөгчийн Зөвлөл
8. Далын Ерөнхийлөгчийн Зөвлөл
9. Бишопын зөвлөл

Сургаал ба Гэрээ 125 Зарахемла, Айова



Яагаад Айова дахь хотод Зарахемла гэх Мормоны Номын нэрийг өгсөн юм бол? Энэ хот хаана байдаг юм бол, бас Их Эзэн Яагаад тэнд амьдарч байсан Гэгээнтнүүдэд хандаж ярьсан юм бол? “Миссуригээс хөөгдсөн бүх Гэгээнтнүүд Иллинойд хоргодох газар олоогүй аж. Зарим хүмүүс Наувугаас Миссиссиппи мөрнийг гатлан Айовад суурьшив. Тэд Айовад үлдэх ёстой юу, эсвэл Иллинойн дэргэд цуглах уу гэдгийг асуусан асуултад хариу болон эл илчлэлт [Сургаал ба Гэрээ 125] иржээ. Гэгээнтнүүдийг Айовад байршуулахыг анх зөвлөсөн хүмүүсийн нэг бол Науву хот баригдсан газрыг зарсан доктор Исаак Галланд байлаа. “Ноён Галланд, Петр В.Рожерст бичсэн захидалдаа, бие даасан нутаг байсан Айовад Гэгээнтнүүдийг суурьшуулахыг санал болгосон юм. Учир нь тэд “аллага, дээрэм тонуул хүн амьх нь зан авирт гайхмаар сүрхий шингэсэн, бас хамгийн олиггүй хүмүүс хамгийн өндөр албан тушаалуудад хүрдэг нэгэн Мужийн харъяалалд байснаас Нэгдсэн Улсын харъяалалд хамаарагдах газар байсан нь танхайрагчдаас хамгаалагдахад илүү тохиромжтой гэж тэр боджээ. Мөн тэрээр “Огайо дахь “Мормоны” хүмүүсийг мэддэг байсан, бас тэднийг сайн иргэд хэмээн ихэд өндөрөөр үнэлэн ярьдаг байсан Айовагийн Захирагч Роберт Лукаст бичсэн байв” гэж Ахлагч Жозеф Фиелдинг Смит бичжээ (Essentials in Church History, х. 220.)” (Doctrine and Covenants Student Manual, 311).

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 125

Нутаг (ш. 1)—Муж хараахан болоогүй байсан Нэгдсэн Улсын хэсэг

Сургаал ба Гэрээ 125:3—Зарахемла ба Нашвилл Миссуригээс зугтсан Гэгээнтнүүдийн зарим нь Миссиссиппи мөрний баруун талд, Айовагийн Монтрөүз, Нашвилл тосгонуудын орчимд суурьшжээ. Энэ нутагт Сүм 8094 га орчим газар худалдан авав. Ингээд тэнд Зарахемла нэртэй хот байгуулахыг Их Эзэн зарлиг болгосон аж. 1839 онд Гэгээнтнүүдийг ирэхэд, эдгээр хотхонуудын оршдог Айовагийн Лий дүүргийн хүн ам 2,839 байв. 1846 он гэхэд хүн ам 12,860 болтлоо өссөн байлаа. 1846 онд Гэгээнтнүүд өрнөд рүү эндээс явахад энэ суурингууд хаягдаж, цаашид оршихоо больсон гэдэг.

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 125-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Газрын зураг зур


Сургаал ба Гэрээ 125 –р хэсэг дэх мэдээллийг, түүнчлэн гурамсан судрын ар дээрх газрын зургуудыг ашиглан, Миссурийн Жаксон дүүрэг; Науву, Иллиной; Айовагийн

Монтрөүзийг харуулсан газрын зургийг тэмдэглэлийн дэвгэртээ зур. Гэгээнтнүүд Миссуригээс Науву, Монтрөүзийн бүсийг хүртэл хэр зэрэг хол аялж вэ?



Ирэх арван жилийн турш зун бүр номлолд үйлчлэх боллоо гэвэл чамд хэрхэн санагдах вэ? Бригам Янг 1832 онд баптисм хүртсэнээсээ хойш 1841 он хүртэл номлолд, түүний дотор Их Британид нэг жил номлолд үйлчилсэн байлаа. Сургаал ба Гэрээ 126-р хэсгийг судлахдаа, тэр үед Их Эзэн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч асан Бригам Янгд ирээдүйн номлолын талаар өгсөн зөвлөгөөг эрж ол.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 125

Сургаал ба Гэрээ 126:1—“Энэ нь дахин шаардагдахгүй”

Бригам Янг номлолд дахин үйлчлэхийн тулд гэр бүлээ орхин явахыг Их Эзэн түүнээс шаардаагүй ч тэрээр богино хугацааны зарим номлолыг хийжээ. Урвагч Жон К. Беннет Сүмийн тухай худал цуу үг тарааж байхад, тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч асан Янг, хүмүүстэй уулзаж, худал үгийг залруулахын тулд аялан явж байв. Тэрээр бас Наувугийн Ариун сүмд зориулж мөнгө цуглуулахын тулд, бас Бошиглогч Иосеф Смитийг Нэгдсэн Улсын ерөнхийлөгчид нэр дэвшүүлэхийг дэмжихийн тулд аялан явжээ.

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 126-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Нийлэмж үгийг тайлбарла

- Сургаал ба Гэрээ 126:1-д Их Эзэн Бригам Янгд хэрхэн хандсан бэ? Энэ илчлэлтээс мэдсэн зүйлээс чинь үзвэл, Их Эзэн түүний талаар яагаад ингэж бодсон гэж та нар бодож байна?
- Сүмийн дуудлагууд болон үүргүүдээ итгэлтэйгээр биелүүлэх тухай дээрх шүлэг та нарт юу зааж байна вэ?

Сургаал ба Гэрээ 127–128

Нас барагсдын өмнөөс
хийх баптисмын ёслолын
тухай зааврууд

Сургаал ба Гэрээ 127, 128-р хэсгүүд нь Бошиглогч Иосеф Смитийн хувьд хүнд хэцүү цагт бичигджээ. Түүний дайснууд энэ эцэс төгсгөлгүй мөрдлөг хавчлагаас түүнийг зайлан нуугдахаас өөр аргагүйд хүргэв. Гэвч энэ үе бол бас Сүнсний агуу ололт амжилтын үе байлаа. “Цаг хугацааны бүрэн байдлын эрин үе нь өмнөх бүх эрин үеүүдэд илчлэгдсэн зүйлүүдийг, бас өмнө нь илчлэгдээгүй бусад зүйлүүдийг гэрэлд авчрах болно” гэдгийг Бошиглогч Гэгээнтнүүдэд хэлжээ (History of the Church, 4:426).

Эдгээр хэсгүүд бол Бошиглогч Иосеф Смитээс Иллинойн Науву дахь Сүмийн гишүүдэд бичсэн захидал юм. Тэрээр дайснуудаасаа зугтан нэг газраас нөгөөд шилжин явж байсан үед уг захидлууд бичигджээ. 1840 онд Бошиглогч анх дурдсан нас барагсдын өмнөөс хийх ёслолын тухай нэмэлт зааврууд эдгээр захидлуудад орсон ажээ (С ба Г 124:25–36-гийн “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз, х. 00 [142]). Сургаал ба Гэрээ 127–128-р хэсгийг уншихдаа аргагүйн эрхэнд нуугдаж амьдрах нь Бошиглогчид ямар санагдсаныг эрж ол. Гэгээнтнүүд нас барагсдын өмнөөс хийх баптисмын сургаалын тухай илүү их ойлголтыг хүлээн авсан нь тэдний хувьд ямар байсныг бас төсөөлөн бодохыг хичээ.



Нас барагсдын өмнөөс бид баптисм хүртэж болох тухай сургаалыг Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Их Эзэн илчилсэн юм.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 128

Анхны хүн (ш. 14)—Адам

Сургаал ба Гэрээ 128:16–18—Яагаад бид нас барагсдын өмнөөс баптисм хүртдэг вэ?

Хуулбарлагч хатуу хоригоно



Нас барагсдын өмнөөс баптисм гүйцэтгэх нь тэдний төлөө ариун сүмийн бусад ёслолуудыг гүйцэтгэхийг боломжтой болгодог. Эдгээр бүх ёслол авралын хувьд зайлшгүй шаардлагатай юм. Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит сургасан нь:

Анхдагч нарын Ожидын Ютагийн Олон Улсын Нийгэмлэг



“Хэрэв Елиа ирээгүй бол, өнгөрсөн үеүдийн бүх ажил ашиг багатай байх байсан. Учир нь ийм нөхцөлд бүх дэлхий Түүний ирэлтээр бүрмөсөн устгагдах байсан гэж Их Эзэн хэлжээ [С ба Г 2:1–3-ыг үз]. Тиймээс Түүний үүрэг зорилго дэлхийд асар их ач холбогдолтой юм. Энэ бол дан ганц нас барагсдын баптисмын асуудал биш. Харин эхлэлээс цаг хугацааны төгсгөлийг хүртэл ‘бүхэл хийгээд бүрэн төгс нэгдэл байхын тулд, мөн эрин үе, түлхүүрүүд, хүчнүүд болон алдар сууг хамтад нь гагнахын тулд’ [С ба Г 128:18] эцэг эх, хүүхдүүдийг эцэг эхчүүдтэй нь лацдан холбох явдал мөн.

“Хэрэв энэхүү лацдан холболтын хүч дэлхий дээр байгаагүй бол, Их Эзэнийг ирэх өдөр төөрөгдөл ноёрхож, эмх замбараагүй байдал газар авах болно. Харин ийм явдал болохгүй л дээ. Учир нь бүх зүйл Бурханы хаант улс дахь төгс хуулиар удирдагдаж, хянагддаг билээ.

“Хэрэв энэхүү лацдан холболтын хүч дэлхий дээр байгаагүй бол, Их Эзэнийг ирэх өдөр төөрөгдөл ноёрхож, эмх замбараагүй байдал газар авах болно. Харин ийм явдал болохгүй л дээ. Учир нь бүх зүйл Бурханы хаант улс дахь төгс хуулиар удирдагдаж, хянагддаг билээ.

“Яагаад дэлхий устгагдах учиртай юм бэ? Хэрэв эцэг хүүхдүүдийн хооронд гагнагч холбоос буюу нас барагсдын өмнөөс хийх ажил байхгүй бол, биднийг бүгдийг нь хүлээн авахгүй. Бурханы бүх ажил нурж, бүрмөсөн устгагдана. Ийм нөхцөл байдал бий болохгүй нь мэдээж юм” (Doctrines of Salvation, 2:121–122).

Сургаал ба Гэрээ 128:24—Левийн хөвгүүд ба Их Эзэнд зориулсан тэдний өргөл

“Түүхийн хувьд, Левийн хөвгүүд, түүний дотор Аароны болон Мосегийн хөвгүүд (Египетээс Гарсан нь 6:16, 18, 20-ийг үз) Бурханы өргөөний харгалзагчид байсан юм. Тэд Бурханы өргөөнд болдог ёслолуудыг хариуцдаг байсан аж (Египетээс Гарсан нь 25–28; Тооллого 8:24–26; 10:21-ийг үз). Өнөөдөр Левийн хөвгүүд нь ‘Түүний Сүмийг барихаар’ Их Эзэнээр дуудагддаг, мөн ‘миний өгүүлсэн энэ хоёр санваарыг олж авахад итгэлтэй байдаг, түүнчлэн дуудлагуудаа эрхэмлэн гүйцэтгэдэг, өөрсдийнхөө биесийг шинэчлэхийн тулд Сүнсээр ариусгагддаг’ (С ба Г 84:31–33) хүмүүс юм. Тэд ‘бэлтгэл сайн мэдээ’ (С ба Г 84:26–27) болон ‘дээд санваар’ мөн сайн мэдээний ёслолууд (ариун сүмийн ажил) ‘бурханлиг чанарын хүчээр илэрхийлэгддэг’ (С ба Г 84:19–21) ажлыг тус тус хариуцдаг. Хэрэв өнөө үед Их Эзэний үйлчлэгчид энэхүү ариун ажил үүрэгт итгэлтэйгээр үйлчлэх юм бол, тэд ‘Мосегийн хөвгүүд, Аароны хөвгүүд, түүнчлэн Абрахамын үр сад, Сүм ба хаант улс, тэрчлэн Бурханы сонгогдогсод’ (С ба Г 84:34) болдог.

“Зөв шударга Гэгээнтнүүд эдгээр ёслолуудаар Их Эзэнд үйлчлэхэд амьд байгаа болон нас барагсдын хувьд Сионы Уулан дээрх аврагчид болдог. Үйлчлэлээрээ дамжуулан тэдний хийдэг золиослол нь Левийн хөвгүүд, түүний дотор Мосегийн болон Аароны хөвгүүдийн зөв шударга байдал дахь өргөлийн хэсэг болж, Христийн ирэлтийн өмнө Их Эзэнд өргөгдөнө” (Doctrine and Covenants Student Manual, 319).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 127–128-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас дөрвийг хий.

А Сонины мэдээ бич

Чи өөрийгөө 1842 онд сонины сурвалжлагч байсан гэж бод. Тэгээд Бошиглогч Иосеф Смитийн нуугдаж байгаа газарт түүнээс ярилцлага авахаар очжээ. Сургаал ба Гэрээ 127:1–3-ыг санаа болгон ашиглаж, нуугдан амьдарч байсан үеийнх нь талаар Бошиглогчийн сэтгэгдлийг сонины товч сурвалжлага болгон бич.

Б Үүрэг хариуцлагуудыг жагсаан бич

Сургаал ба Гэрээ 127:5–10, 128:1–5-д сурч мэдсэн зүйлүүдээс, ариун сүмийн цэдэг хөтлөгчийн үүрэг хариуцлагууд юу байх ёстой гэж бодлогоо жагсаан бич.

В Хариу бич

Сүмийн гишүүн биш боловч, ариун сүм, нас барагсдын өмнөөс хийх баптисмын тухай сонссон нэг найз чамд байдаг гэж бод. Нас барагсдын өмнөөс хийх баптисм гэж юу болох, мөн яагаад уг баптисмыг хийдгийг найз чинь чамаас асуужээ. Сургаал ба Гэрээ 127, 128-р хэсгүүдээс юу сурч мэдсэнээ ашиглан, асуултуудад нь хариул. Хариултууддаа эрх мэдлийн ач холбогдол, лацдан холбох хүч болон гагнагч холбоосууд, мөнхийн гэр бүл, мөн Елиагийн тухай оруулахад анхаар.

Г Жагсаан бичиж, харьцуул

Сургаал ба Гэрээ 128:20–21-ийг нэгтгэн дүгнэж, Бошиглогч Иосеф Смитийн дурдсан тэнгэрийн элчүүдийг жагсаан бич. Сайн мэдээний Сэргээлтийн үед илчлэлт хүлээн авахыг үргэлжлүүлэх нь түүний хувьд яагаад чухал байсан гэж бодож байгаагаа тайлбарла.

Д Үзүүлэн хий

1. Тэр үе дэх Бошиглогч Иосеф Смитийн хувь хүний нөхцөл байдлыг авч үзвэл (С ба Г 127:1–4-ийг үз), Сургаал ба Гэрээ 128:22-т түүний бичсэн зүйл чамд ямар сэтгэгдэл төрүүлж байна?
2. Бошиглогч Иосеф Смитийн үйл ажиллагаа болон сайн мэдээний төлөөх түүний урам хайрлагч уриалгыг дүрслэн харуулсан үзүүлэн хий.

Е Шүлгүүдийг харьцуул

Сургаал ба Гэрээ 13:1-д та нар “Левийн хөвгүүдийн” өргөл эцсийн өдрүүдэд хийгдэнэ (С ба Г 13:1-ийн “Судруудыг

ойлгох нь” хэсгийг үз, х. 00 [26]) гэснийг уншдаг. Эндээс мэдсэн зүйлээ Сургаал ба Гэрээ 128:24-тэй харьцуул. Бошиглогч Иосеф Смитийн өгүүлснээр, бошиглогдсон энэхүү өргөл гүйцэлдэх нэг арга зам юу вэ?



Чи хэзээ нэгэн цагт тэнгэр элчүүдийн тухай бодож үзсэн үү? Тэд хэн юм бэ? Тэд Бурханаас ирдгийг бид яаж мэдэж болох вэ? Сургаал ба Гэрээ 129-р хэсэгт Бошиглогч Иосеф Смит эдгээр асуултуудад хариулж, “гурван их түлхүүр” (ш. 9) буюу тэнгэрийн элчүүдийг таних арга замуудыг өгүүлжээ.



Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 129

Төгс болгогдсон шударга хүмүүс (ш. 3)—Уучлагдсан бөгөөд Есүс Христийн

Цагаатгалаар цэвэршсэн хүмүүс

Сургаал ба Гэрээ 129:1—Тэнгэр элч, Сүнс хоёрын хооронд ямар ялгаа байдаг вэ?

Бурханаас ирсэн аливаа элчийг тэнгэр элч гэж хэлж болно. Гэвч Сургаал ба Гэрээ 129-р хэсэг дэх *тэнгэр элч* гэдэг нэр томъёо нь “маханбод хийгээд яс бүхий амилуулагдсан хүмүүн биес” (ш. 1)-ээр хязгаарлагддаг. “Сүнснүүд бол мөнх бус байдалд хараахан орж ирээгүй [төрөөгүй байгаа] Бурханы хүүхдүүд юм. Ийнхүү тэд бие махбод олоогүй [биегүй] байдаг. Өөрөөр хэлбэл, сүнс бол үхлийн дараа биеэсээ салсан сүнс юм” (Сургаал ба Гэрээний Оюутны Гарын Авлага, [00] 320).

Науву дахь Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад Бошиглогч Иосеф Смит өмнө нь өгсөн заавруудаа “тэнгэр элч болон тохинуулагч сүнсний хоорондох ялгааг тайлбарлажээ. Тэнгэр элч бол бие махбодтой сүнснүүдэд тохинуулдаг, сүнснэстэй амилуулагдсан буюу зөөгдсөн бие юм. Харин тохинуулагч сүнс бол бие махбодгүй сүнс юм. Есүс Христ (цогцос нь булшинд байсан үед) үүрэг зорилгынхоо чухал хэсгийг гүйцэлдүүлэхийн тулд шорон дахь сүнснүүдэд тохинуулагч Сүнс болсон билээ. Ингэхгүйгээр Тэрээр Өөрийн ажлыг төгс болгох буюу Амралтдаа орж чадахгүй байсан юм. Амилалтынхаа дараа Тэрээр тэнгэр элч [амилуулагдсан хүмүүн бие] болж, шавь нар дээрээ хүрч иржээ” (in *History of the Church*, 4:425; мөн 1 Петр 3:18-20-ийг үз).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 129-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Чи яаж мэдэж болох вэ?

Сургаал ба Гэрээ 129-р хэсэгт Бошиглогч Иосеф Смитийн илчилсэн “гурван их түлхүүрийг” өөрийн үгээр жагсаан бич. Энэ нь тэнгэр элч үү, Бурханаас илгээгдсэн Сүнс үү, эсвэл чөтгөр үү гэдгийг хэрхэн таньж болох талаар бич.



Хэрэв чамд боломж олдсон бол Бошиглогч Иосеф Смитээс ямар асуултууд асуух байсан бэ? Сургаал ба Гэрээ 130-р хэсэг бол Бошиглогчийн өгүүлсэн сургаалуудын түүвэр юм. Нотолгоо бүрийг уншсанаар уг сэдвийн талаар хэчнээн их зүйлийг мэдэж болох тухайд та нар гайхаж мэднэ.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 130

Шашны бүлэглэлийн төсөөлөл (ш. 3)— Бусад Сүмүүдийн итгэл бишрэл

Сургаал ба Гэрээ 130:8–10—“Урим ба Туммим” гэж юу вэ?

Судруудын Удирдамж дахь “Урим ба Туммим”-ыг үз (х.199).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 130-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас гурвыг хий.

А Асуулт хариулт бич

Сургаал ба Гэрээ 130-р хэсэг нь асуултуудын талаарх янз бүрийн заавар болон хариултуудыг агуулдаг. Мэдэх нь чухал гэж өөрийн бодож буй зүйлээр дараах бүлэг шүлэг бүрд нэг, нийт сорилын найман асуулт бич. Үүнд: 1–3, 4–7, 8–9, 10–11, 12–17, 18–19, 20–21, 22–23. Асуулт бүрийн дараа хариулт тавь.

Б Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 130:18–19

Тэмдэглэлийн дэвтрийнхээ хуудасны дунд босоо шугам зур. Амьдралд үнэ цэнэтэй бөгөөд чухал гэж үздэг зүйлүүдээр хүрээлүүлсэн хүний зургийг шугамны зүүн талд зур. Баруун талд нь хүн нас барахдаа авч явж болох зүйлсийг нэрлэн бичих буюу ийм зураг зур. Сургаал ба Гэрээ 130:18–19-ийг ашиглан, дараагийн амьдралд үнэ цэнэтэй хэвээр байх юуг бид энэ амьдралд олж авах ёстойг илэрхийлсэн зургийн тайлбар болон уриаг зургандаа зориулж бич.

В Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 130:20–21

Бид Бурханы хуулиудад дуулгавартай байх болон бидний хүлээн авдаг адислалуудын хооронд уялдаа холбоо байдаг гэж Сургаал ба Гэрээ 130:20–21-д Бошиглогч Иосеф Смит тайлбарлажээ. Мэргэн Ухааны Үгээр амьдрахтай холбоотой гэхчлэн нэн өвөрмөц зарим амлалтууд зарлигуудад байдаг (С ба Г 89-р хэсгийг үз). Бусад зарлигуудын хувьд амлалтууд нь илүү ерөнхий шинжтэй байдаг (жишээ нь, Иошуа 1:8-ыг үз). Өөр гурван зарлигийг, мөн эдгээр зарлиг бүрд амлагдсан адислалуудыг жагсаан бич. Эл амлалтууд өвөрмөц буюу ерөнхий аль нь болохыг харуул. Хэрэв та нарт туслалцаа хэрэгтэй бол, эцэг эхтэйгээ эсвэл Сүмийн аль нэг удирдагчтай ярилц.

Г Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 130:22–23

Сургаал ба Гэрээ 130:22–23-т заагддаг үнэнүүд нь Сүмд нэгдээд олон жил болсон гишүүдийн хувьд зүй ёсны бөгөөд учир шалтгааны үндэслэлтэй байж болох юм. Гэвч энэ сургаал Христийн бусад ихэнх Сүмийн итгэлээс маш их ялгаатай юм. Бурхан тэргүүтэн гэж үнэхээр юу болохыг та нар мэддэг учраас амьдралыг үзэх бодол санаа чинь, зан төлөв хийгээд залбирлууд тань ялгаатай байдаг гурван хэлбэрийг жагсаан бичиж тайлбарла.

“Бошиглогч Иосеф Смит тохинууллынхаа хожмын жилүүдэд, тухайлбал, Гэгээнтнүүд өөрсдийн дуудлага болон сонгогдсоноо баттай болгох хүртэл: ‘Хүү минь, чи өргөмжлөгдөх болно’ (*Teachings of the Prophet Joseph Smith*, х.150) хэмээх тэнгэрлэг дуу хоолойг сонсох хүртлээ зөв шударга байдалд урагш тэмүүлэхийг тэднээс цөхрөлтгүй шаргуугаар хүсдэг байжээ.

“Тэр өөрөө энэ эрин үе дэх ийм бүх ололт амжилтын загвар нь болсон бөгөөд тэнгэрээс түүнд дуу хоолой ирж: ‘Учир нь бибээр Их Эзэн чиний Бурхан билээ, бас бүр дэлхийн төгсгөл хүртэл бүх үүрд мөнхөөр дамжин чамтай хамт байх болно, учир нь өргөмжлөлийг чинь би чам дээр үнэнээр лацдан мөн чамд зориулж, эцэг Абрахамын чинь хамт Эцэгийнхээ хаант улсад хаан сэнтийг бэлтгэх бөлгөө’ (С ба Г 132:49.)” хэмээн хэлсэн билээ (In Conference Report, 1977 оны 10-р сар, 51–52; *Ensign*, 1977 оны 11-р сар, 34; онцлон тэмдэглэлт эх сэдэвт байгаа).

Сургаал ба Гэрээ 131:6—Аврагдахын тулд ямар мэдлэг хэрэгтэй вэ?

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит тайлбарласан нь:

“Хүн үл тоомсорлосон байдалд аврагдаж чадахгүй гэж Бошиглогч хэлсэн билээ. Гэвч юуг үл тоомсорлох гэж? Есүс Христийн сайн мэдээний аврагч зарчмуудыг үл тоомсорлох юм бол хүн аврагдаж чадахгүй гэж тэр хэлжээ [*Teachings of the Prophet Joseph Smith*, 297, 324, 331–332-ыг үз]. Өнөө үеийн хүмүүсийн бодол санааг бүрдүүлэн тэдгээрийг хянагч агуу хүчирхэг хүмүүсийн цөөнгүй нь Бурханы хаант улсад авралыг [өргөмжлөлийг] олохын төлөө явж байна. Яагаад? Учир нь тэд замыг олоогүй байна. Тэд үнэний гэрэлд явахгүй байна. Тэдэнд мэдлэг байдаг ч, оюун билэг дутагдаж байна.

“Оюун билэг бол үнэний гэрэл юм. Оюун билэг буюу үнэний гэрэлтэй хүн хилэнцэт нэгнийг орхидог гэдэг нь бидэнд мэдээлэгдсэн юм [С ба Г 93:36–37-г үз]. Оюун билэгтэй хүн Бурханыг шүтэн биширч, нүглүүдээ наманчлаж болно. Тэрээр Бурханы хүсэл тааллыг мэдэж, дагахыг эрмэлзэнэ” (*Doctrines of Salvation*, 1:290).

Сургаал ба Гэрээ 131:7–8—“Бүх сүнс матери мөн”

“Ямар нэг зүйлийн үндэс суурь руу нь хөөн очиж, гүн ухааны үүднээс харах юм бол, бие болон сүнсний хоорондох нэн бодит ялгааг бид олж харж болох бөгөөд бие нь зохион байгуулалттай матери, харин сүнс нь материгүй, бодит бус гэж олонх хүмүүс боддог. Хожмын үеийн энэхүү нотолгооноос бид өөр үзэл бодолтой. Бид сүнс нь бодит гэж үздэг. Энэ нь матери бөгөөд харин биенээс илүү цэвэр, уян хатан, сайжирсан матери мөн. Сүнс нь биенээс өмнө оршиж байсан бөгөөд бас биенд оршиж чадна. Мөн бие тоос болон замхарч байхад, сүнс биенээс тусдаа оршиж чадна. Улмаар амилуулалтад сүнс биетэй дахин нэгдэнэ” хэмээн Бошиглогч Иосеф Смит тайлбарлажээ (*Teachings of the Prophet Joseph Smith*, 207).

Сургаал ба Гэрээ 132

Сургаал ба Гэрээ 132:1—Татвар эмс гэж юу вэ?

Ахлагч Брус Р.МкКонки *татвар эмс* гэдэг нэр томъёог тодорхойлж, тайлбарласан нь: “Эрт дээр үед тэднийг *хоёр дахь эхнэрүүд* гэж үздэг байж. Энэ нь юу гэсэн үг вэ гэвэл, хөрөнгө чинээгээр ялгаж нийгмийн тогтолцоонд тэд өөр зиндааны буюу доод зиндааны эхнэрүүд ба мөн тэр үед татвар эмс хэмээн нэрлэгддэггүй байсан эхнэрүүд тэднийг ноёрхдог байв. Энэ эрин үе дэх олон эхнэр авах заншилтай татвар эмс ямар ч холбоогүй. Учир нь зарим эхнэрийг

ингэж хөрөнгө чинээгээр ялгаварлан тогтоох нийгмийн тогтолцоо байгаагүй юм” (*Mormon Doctrine*, 154–155).

Сургаал ба Гэрээ 132:7—“Амлалтын Ариун Сүнсээр лацдагдах нь”

Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байсан Ахлагч Жеймс И.Фауст хэлэхдээ:

“Ариун Сүнсний лацдагч, батлагч хүч болох Амлалтын Ариун Сүнсний тухай ганцхан үг хэлэхийг би хүсч байна. Амлалтын Ариун Сүнсээр лацдагдсан гэрээ буюу ёслолтой байх нь адислалыг эрэлхийлдэг, үнэнч, итгэлтэй хүмүүс үүгээр дамжуулан төрөлхийн адислалуудыг олж авах гэрээ юм (С ба Г 76:50–54-ийг үз).

“Жишээ нь, сайн мэдээний оргил ёслол, энэ амьдралд болон үүрд мөнх дэх гэрлэлтийн гэрээ Амлалтын Ариун Сүнсээр лацдагдахад, эдгээр адислалуудыг эрэлхийлдэг гэрлэсэн хост агуу адислалуудын төлөө тэнгэрийн цонхыг шууд нээж чадна. Ийм гэрлэлт баялаг агуулгатай, эрүүл саруул, ариун нандин болдог. Гэрлэлтэд оролцогч бүр нь бие даасан тусгаар байдлаа хадгалж чадах ч, тэд гэрээнүүд дээ хамтдаа, бие биетэйгээ салшгүйгээр уягдсан жимсний хоёр мод лугаа адил юм. Хос бүр нь өөрийнхөө тухай бодохоосоо өмнө ханийнхаа тухай боддог.

“Амлалтын Ариун Сүнсээр дамжин ирдэг агуу адислалуудын нэг нь сайн мэдээний ёслолуудаар дамжуулан бидний хүлээн авдаг гэрээ, андгай тангараг болоод гүйцэтгэл нь Амлалтын тэрхүү Ариун Сүнсээр батлагдах төдийгүй, лацдагдаж болно. Гэсэн ч, энэхүү лацдалт шударга бус байдлаар цуцлагдаж болно. Хэрэв хүн лацдалтын адислалыг хууран мэхлэлтээр хүлээн авах юм бол, ‘ёслолыг гүйцэтгэсэн хүн ариун журамтай, эрх мэдэлтэй байлаа ч, адислал лацдагддаггүй’ санах нь бас чухал юм.” [Жозеф Фиелдинг Смит, *Doctrines of Salvation*, 2:98–99].

“Амлалтын Ариун Сүнсээр лацдагдсан гэрээ буюу ёслолтой байх гэдэг нь газар дээр ч, тэнгэрт ч холбогддог гэрээтэй байна гэсэн утгатай юм” (In Conference Report, 1989 оны 4-р сар, 41–42; *Ensign*, 1989 оны 5-р сар, 33).

Сургаал ба Гэрээ 132:15–16—Бид яагаад мөнхийн гэрлэлтийн төлөө хичээн чармайх ёстой вэ?



Энэ эрин үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын анхны гишүүдийн нэг асан, Ахлагч Парли П.Пратт, мөнхийн гэрлэлтийн сургаалыг ойлгосноор амьдрал нь хэрхэн өөрчлөгдсөнийг тайлбарлахдаа:

“Энэхүү мөнх бус амьдралд бүхэлдээ хамаарах цусан төрлийн хайр, элгэн халуун сэтгэл нь, тэнгэрлэг байдалдаа нийцсэн байхын тулд, хүн сэтгэл хөдлөлийн хувьд хөдөлбөргүй тууштай хэвээр үлдэх ёстой зүйл болохыг би эрхэмлэн хайрлаж сурсан юм.

“Эцэг эх хоёр, эхнэр нөхөр хоёр, ах эгч дүүс, хүү охин хоёрын дотно нандин харилцааг хэрхэн үнэлэхийг Иосеф Смит надад зааж сурсан билээ.

“Миний хайртай гэргий, намайг энэ амьдралд болон бүх үүрд мөнхөд хамгаална гэдгийг; бие биенээ хайрлах бид хоёрын хөршгүй хайр, оргилуун халуун сэтгэл мөнхийн бурханлиг хайрын оргилуураас ундрэн гардгийг би түүнээс мэдсэн

юм. Бид хоёр ийм хайрыг бий болгон, үүрд мөнхөд энэхүү хайрыг өсгөн нэмэгдүүлж болно гэдгийг мэдсэн. Бид хоёрын эцэс төгсгөлгүй эв нэгдлийн үр дүн нь тэнгэрийн одод лугаа адил, далайн эргийн элс лүгээ адил үй олон бид хоёрын үр удам байх болно. . . . гэдгийг би түүнээс мэдсэн юм.

“Би өмнө нь хайрладаг байсан, гэвч яагаад гэдгийг мэддэггүй байлаа. Харин эдүгээ би сэтгэл санааг минь энэхүү зусарч хуурмаг хорвоогийн түр зуурын зүйлсээс эрчимтэйгээр өргөн гаргаж, өргөмжлөн, зах хязгааргүй далай лугаа адил өргөжүүлэн, цэвэр ариунаар хайрлаж байлаа” гэжээ (*Autobiography of Parley P. Pratt* [1985], 259–260).



Мөнхийн гэрлэлтийн дэлхийн хувилбарын тухай, тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан Ахлагч Гордон Б. Хинкли хэлсэн нь:

“Би төгсгөлд нь нэгэн түүхийг та нарт үлдээ. Энэ бол уран зөгнөл, гэвч зарчим нь үнэн юм. Сар бүтэн гийж, сарнай цэцэглэсэн үед хоёр залуугийн халуухан ариун хайр бялхаж байжээ. Та нар үүнийг төсөөлөн бодоод үз л дээ. Жонни Мэрид, ‘Мэри, би чамд хайртай. Би чамайг эхнэрээ, мөн миний хүүхдүүдийн ээж байхыг хүснэ. Гэвч би чамтай, мөн хүүхдүүдтэйгээ үүрд байхыг хүсэхгүй. Зүгээр л хэсэг хугацаанд тийм байгаад дараа нь баяртай гэнэ шүү дээ’ гэжээ. Харин Мэри сарны гэрэлд нулимс мэлмэрүүлэн, хайртай залуугийнхаа өөдөөс харж, ‘Жонни, чи бол гайхалтай хүн. Чам шиг хүн бүх дэлхийд өөр байхгүй биз ээ. Би чамд хайртай, чамайг миний нөхөр, хүүхдүүдийн минь эцэг байгаасай гэж би хүсч байна, гэхдээ зөвхөн түр хугацаанд шүү, тэгээд дараа нь хагацах цаг ирнэ’ гэж хэлжээ.

“Энэ тэнэг сонсогдож байгаа биз, тийм биш гэж үү? Гэвч энэ бол ‘шинэ бөгөөд үүрдийн гэрээгээр’ мөнхийн холболтын боломж олгогдсон гэрлэхийг хүссэн хөвгүүн нэгэн охинд хандсан эсвэл нэгэн охин тэр нэгэн хөвгүүнд хандсан хэрэг биш ч гэсэн, харин тэд үхэл ирэх хүртэл үргэлжлэх хайрыг л сонгохоор шийдсэн аж” гэжээ (*In Conference Report*, 1974, оны 4-р сар 33; *Ensign*, 1974 оны 5-р сар, 24).

“Наманчлалын сүнсгүйгээр өргөмжлөлд орж болохыг Их Эзэн хэн нэгэнд хэзээ ч амлаагүй билээ. Энэ хэсэгт наманчлалын тухай дурдаагүй ч, энэ тухай битүүгээр хэлсэн байх учиртай. Шүлэг 26-гийн тухай хүн бүр мэддэг хэрнээ, Матай 12:31–32-ыг ерөөсөө уншаагүй эсвэл сонсоогүй юм шиг байдаг нь надад хачирхалтай санагддаг. Энд 132-р хэсгийн, шүлэг 26-д байдагтай мөн чанартаа адилхан зүйлийг Их Эзэн бидэнд хандан өгүүлсэн байдаг. . . .

Сургаал ба Гэрээ 132:26–39—Ариун сүмийн гэрлэлт өргөмжлөлийг баталгаатай болгодог уу?

Сургаал ба Гэрээ 132:26-г тайлбарлаж, Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит заасан нь:

“Наманчлалын сүнсгүйгээр өргөмжлөлд орж болохыг Их Эзэн хэн нэгэнд хэзээ ч амлаагүй билээ. Энэ хэсэгт наманчлалын тухай дурдаагүй ч, энэ тухай битүүгээр хэлсэн байх учиртай. Шүлэг 26-гийн тухай хүн бүр мэддэг хэрнээ, Матай 12:31–32-ыг ерөөсөө уншаагүй эсвэл сонсоогүй юм шиг байдаг нь надад хачирхалтай санагддаг. Энд 132-р хэсгийн, шүлэг 26-д байдагтай мөн чанартаа адилхан зүйлийг Их Эзэн бидэнд хандан өгүүлсэн байдаг. . . .

“Их Эзэн Өөрийн амаар хэлэхдээ: ‘Мөн эцсээ хүртэл үл гэвчсэн тэрбээр, чухамхүү тэр нь түүнчлэн тас цавчигдаж мөн тэд тэндээс дахин эргэж ирэх аргагүй галд хаягдах тэр нь мөн, учир юун гэвэл Эцэгийн шударга ёсны юм. Мөн хүмүүний үрсэд түүний өгсөн үг нь энэ юм. Мөн энэхүү шалтгааны учир тэрээр өгсөн үгсээ гүйцэлдүүлнэ, мөн тэрбээр худал хэлдэггүй, харин өөрийн бүх

үгсийг гүйцэлдүүлдэг. Мөн ямар ч цэвэр бус зүйл түүний хаант улсад орж чадахгүй; тиймийн тул өөрсдийн итгэл, мөн өөрсдийн бүх нүглийн наманчлал, мөн төгсгөл хүртэлх өөрсдийнх нь үнэнч шударга байдлын учир миний цусанд өөрсдийн өмсгөлийг угаасан тэднээс бусад юу ч түүний амралтад орохгүй’ гэжээ [3 Нифай 27:17–19].

“Иймээс шүлэг 26-д өгүүлэгдсэн хүмүүс бол нүгэл үйлдээд бүрэн наманчилсан, нүглийнхээ төлөөсийг төлөхөд бэлэн байгаа хүмүүс бөгөөд хэрэв ингэхгүй бол өргөмжлөлийн адислалууд тэдэнд ирэхгүй гэдгийг бид үүнээс эцэст нь ойлгох ёстой. Уучлалд наманчлал туйлын чухал бөгөөд нүгэл үйлдсэн хүн заавал цэвэрших ёстой” гэжээ (*Doctrines of Salvation*, 2:95–96).

Ариун Сүнсний доромжилсон хүнд ямар ч уучлал байх боломжгүй гэж Их Эзэн Сургаал ба Гэрээ 132:27-д хэлсэн байдаг.

Сургаал ба Гэрээ 132:27—“Ариун Сүнсний эсрэг доромжлол”

Ариун Сүнсний эсрэг доромжлол үйлдсэн хүмүүс аллага болон гэмгүй хүний цусыг урсгасны төлөө ямар гэм буруутай байдаг вэ? Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит, “хамгийн том энэхүү нүглийг үйлдсэн бүх хүмүүс, Кайн Люсиферт худалдагдсаны нэгэн адил өөрсдийгөө худалддаг. Тэд үнэнийг мөнхийн үзэн ядалтаар жигшин хардаг, мөн тэд ёс бусыг хайрлаж сурдаг. Тэд наманчлахгүй байх нөхцөлийг хайдаг ба наманчилж ч чаддаггүй. Аллагын сүнс тэдний зүрх сэтгэлийг дүүргэдэг. Ингээд, хэрэв тэдэнд хүч байдагсан бол тэд Түүний ажилтай тэмцэлдэж, Түүний ажлыг болон бошиглогчдыг нь устгахыг чухамдаа бидний Их Эзэнийг дахин цовдлохыг эрэлхийлдэг.

“Хүн бодгалийн энэхүү гашуун зовлонд живэхээс өмнө хамгийн түрүүнд үнэнийг огтхон ч эргэлзээгүйгээр цэвэр зөн совингоор мэдэж, ойлгох ёстой. Зүрх сэтгэлийн өөрчлөлт нэг дор ирдэггүй. Харин зөрчлийн зарим хэлбэрүүд наманчлаагүй бодгальд отон нуугдсаар Ариун Сүнс хүнээс татан авагдаж, дараа нь тэрээр сүнсний харанхуйд үлдэх хүртэл үргэлжилдэг. Нэг нүгэл нөгөөг төрүүлнэ. Үнэнийг хайрлах хайр нь үзэн ядалт болон хувирах хүртэл харанхуй нь өсөн нэмэгдсээр шударга, үнэн зөв бүхнийг устгах ёс бус хүсэл нь Бурханы хайрыг даван гардаг. Ийм байдлаар Христийг илт ичгүүрт тавьж, өргөмжлөгсдийг гутаан доромжилдог” хэмээн тайлбарлажээ (*Doctrines of Salvation*, 1:49).

Сургаал ба Гэрээ 132:58–66—Олон эхнэр авах ёс

Сургаал ба Гэрээ 132-р хэсгийн шүлгийн товч тайлбарт харуулснаар, шүлэг 58–66 нь “олон эхнэр авах ёсыг зохицуулдаг хуулиудад” хамаатай ажээ. Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан, олон эхнэр авах ёсыг Сүмийн эхэн үед хэрэгжүүлэхийг Их Эзэн зарлиг болгосон юм. 1890 онд Ерөнхийлөгч Вилфорд Вудраффаар дамжуулан Тэрээр уг зуршлыг зогсоожээ (Албан Тунхаг 1-ийг үз). Ахлагч Брус Р.МкКонки тайлбарласан нь:

“Олон эхнэр авах ёс нь аврал буюу өргөмжлөлд зайлшгүй хэрэгтэй зүйл биш. Нифай болон түүний хүмүүс нэгээс илүү эхнэртэй байх хүчийг үгүйсгэдэг байсан ч, Их Эзэн аливаа хүмүүст үүрд мөнхөд санал болгосон адислал нэг бүрийг тэд авч чадсан. Бидний үед, өргөмжлөлийн бүхэл бүтэн сургаалыг Их Эзэн илэрхийллээр нэгтгэн дүгнэж, нэг эрэгтэй нэг эмэгтэйтэй гэрлэх гэрлэлтийг тогтоогоод байна. (С ба Г 132:1–28-ыг үз.) Мөн түүнчлэн тэр олон эхнэр авах ёстой

холбоотой гэрлэлт нь зөвхөн Сүмийн Ерөнхийлөгч зөвшөөрөл өгсөн тохиолдолд хүчинтэй байж болох тодорхой болзолтой зарчмуудыг нэмж оруулсан юм. (С ба Г 132:7, 29–66-г үз.)

“Өнөө үед олон эхнэр авах ёсыг горилдог эсвэл санаархдаг бүх хүмүүс, тэдний эзэмшиж байсан түлхүүрийн толилуулах хүч татан авагдаж, ёс бус явдлын үлэмж гэм буруутан болно.” (Mormon Doctrine, 578–579; налуу бичлэг эх сэдэвт байдаг).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 131–132-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас тавыг хий.

А Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 131:1–4

1. Сургаал ба Гэрээ 131:1–4-ийг уншсанаасаа, Селестиел алдар суугийн талаар Их Эзэний хэлсэн зүйлүүдийг дүрсэлсэн жишиг зураг хий. Зургийн нэг хэсэг болгон эдгээр шүлгүүдэд өгөгдсөн шаардлагыг жагсаан бичиж, уг шаардлага нь селестиел алдар суугийн зэрэглэлүүдэд хэрхэн холбогдох болохыг харуул.
2. Селестиел алдар суугийн зөвхөн ганцхан хэсгийг дурьдаж, бусдынх нь талаар яагаад өгүүлээгүй гэж та нар бодож байна? Селестиел гэрлэлтийн ач холбогдлын талаар энэ нь та нарт юу өгүүлж байна вэ? (С ба Г 131:1, 131:1–4-ийн “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз).

Б Асуулт хариулт бич

Сургаал ба Гэрээ 131:5–8 бол янз бүрийн сэдвүүдээр Бошиглогч Иосеф Смитийн хүлээн авсан мэдээллийн эмхэтгэл юм. Эдгээр шүлгүүдийг нэгтгэн дүгнэж, шүлэг 5, шүлэг 6, шүлэг 7–8-д зориулж тус бүр нэг асуулт хариулт бич. Асуулт бүрийн дараа хариултыг тавихад анхаар. (Хэрэв тусламж хэрэгтэй бол, “Судруудыг ойлгох нь” хэсэг дэх мэдээллийг үз.)

В Амлалт ба анхааруулгууд

Бошиглогч Иосеф Смит гэрлэлтийн гэрээний мөнхийн мөн чанарын талаарх илчлэлтийг хүлээн авсан үед, Их Эзэн бас үүнтэй холбоотой амлалтууд болон анхааруулгыг илчилсэн ажээ (С ба Г 132:1–6-г үз). Их Эзэний өгсөн эдгээр амлалт болон анхааруулгын заримыг нь тэмдэглэлийн дэвэртээ бич.

Г Тодорхойлолт бич

1. Сургаал ба Гэрээ 132:7–14-өөс уншсан зүйлээрээ, “Амлалтын Ариун Сүнс”-ийг тодорхойлж, энэ нь Сүм дэх гэрлэлт болон ёслол бүртэй хэрхэн хамаатайг тайлбарла (Хэрэв тусламж хэрэгтэй бол, “Судруудыг ойлгох нь” хэсэг дэх мэдээллийг үз.)
2. Гэрлэлтийг “Амлалтын Ариун Сүнсээр” лацдахын тулд гэрлэсэн хос юу хийх хэрэгтэй гэж бодлогоо тайлбарла.

Д Мөнхийн гэрлэлт гэж юу вэ?

Өөр юу ч болж байсан хамаагүй, ариун сүмийн гэрлэлт нь мөнхийн гэрлэлт, мөнх амьдралыг баталгаатай болгодог гэж зарим гишүүд итгэдэг нь буруу юм.

1. Гэрлэлтийг ариун сүмд гүйцэтгэхээс гадна ариун сүмийн гэрлэлт, мөнхийн, селестиел гэрлэлт байхын тулд өөр юу шаардлагатай вэ? (Хэрэв тусламж хэрэгтэй бол С ба Г 132:7, 26; мөн С ба Г 132:7-гийн “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз).
2. Сургаал ба Гэрээ 132:26–44-өөс уншсан зүйлээс харахад, мөнхийн гэрлэлтийн амлалтуудыг юу хүчингүй болгож болох вэ? (Хэрэв тусламж хэрэгтэй бол С ба Г 132:26–39-ийн “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз).

Е Яагаад мөнхийн гэрлэлтийн төлөө тэмцэх ёстой вэ?

Сургаал ба Гэрээ 131:1–4, 132:6–7, 15–20, 46–49-ийг нэгтгэн дүгнэ. Мөн Сургаал ба Гэрээ 132:15–16-гийн “Судруудыг ойлгох нь” хэсгийг унш.

1. Сурч мэдсэн зүйлээсээ үзэхэд, гэрлэлт ба гэр бүл үүрд мөнхөд үргэлжлэхэд Их Эзэний амлалтын ач холбогдол юу вэ? Энэ амлалт чиний хувьд, мөн ирээдүйн үр хүүхдийн чинь хувьд яагаад чухал вэ?
2. Яагаад мөнхийн гэрлэлтийн төлөө чармайлт гаргах ёстой вэ? (Чармайлтад төлөвлөлт, ажил хэрэг, золиослол, залбирал багтана)
3. Мөнхийн гэрлэлтэд өөрийгөө бэлтгэхийн тулд чи одоо юу хийж болох вэ?





Сургаал ба Гэрээ 133-р хэсэг дэх илчлэлт Сургаал ба Гэрээнд өмнө нь орсон олон хэсгээс нэлээд эрт хүлээн авагджээ. Бошиглогч Иосеф Смитийн хүлээн авсан илчлэлтүүдийг хэвлэх эс-

хийг шийдэхийн тулд 1831 оны арваннэгдүгээр сарын 1-нд Сүмийн чуулган чуулжээ. “Зарлигуудын Номыг” хэвлэх шийдвэрийг уг чуулган дээр Их Эзэн зөвшөөрч, эдүгээ Сургаал ба Гэрээ 1-р хэсэг болох энэхүү номын “оршлыг” илчилжээ. Чуулганыг хаах үед, хожмын өөрүүдийн агуу ажлын талаарх асуултуудыг Бошиглогч Иосеф Смитээс асуух боломж цугларасдаг олдсон аж. Бошиглогч тэдний өмнөөс Их Эзэнээс асууж, 133-р хэсэг дэх илчлэлтийг хүлээн авчээ. Сургаал ба Гэрээний анхны хэвлэлд эл илчлэлт Хавсралт гэсэн нэртэй байв. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан Ахлагч Жон А.Видцөү, энэ нь “оршлыг” [эсвэл өмнөх үг болох С ба Г 1-р хэсгийг] хавсаргадаг учраас энэ нэр тохиромжтой байлаа. Хоёр хэсэг нь хураангуйлсан хэлбэрээр хамтдаа эл номын агуулгыг бүрдүүлдэг. . .

“Хавсралт гэдэг бол номон доторх зүйл дээр нэмж өгүүлэх буюу онцгойлон авч үзэх, эсвэл үүнд илүү хүч нэмэх буюу агуулгыг илүү бүрэн дүүрэн болгох ёстой гэж зохиогчийн үзсэн зүйл юм” хэмээн бичжээ (The Message of the Doctrine and Covenants, Г.Хомер Дурхам [1969], 17).

Өөрөөр хэлбэл, бид Сургаал ба Гэрээ 1, 133-р хэсгийг унисанаар Сэргээлтийн зорилгын талаар ихийг мэдэж чадна. Хэсэг тус бүр нь Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн өмнө юу тохиох ёстойд онцгой анхаарал төвлөрүүлдэг.

дэлхийн амжилтаа харуулах газар болгон, ихэд ёс бус бусармаг явдал болон хиймэл шүтээний үед энэ хотыг байгуулжээ. Израйлын хүүхдүүд дэлхийн шинжтэй, ёс бус болон хиймэл шүтээнийг шүтдэг болсон үед, олон израилчуудыг боолчлохыг Их Эзэн вавилончуудад зөвшөөрсөн ажээ. Энэ нь: Хэрэв бид дэлхийтэй адилхан болохыг хичээх юм бол, биднийг дэлхий боолчлох болно гэсэн бэлгэдлийн сургамжийг Израйлын гэр бүлийн бүх гишүүдэд сануулдаг. Эдгээр шалтгааны улмаас, дэлхийн шинж чанар, ёс бус бусармаг явдал болон эдгээрийн үр дагавруудыг Вавилон бэлгэдэх болсон ажээ. Их Эзэнтэй ойр дотно байхаас ирдэг амар амгалан, зөв шударга байдлыг төлөөлдөг Сионы хотын эсрэг талыг Вавилон төлөөлдөг.

Сургаал ба Гэрээ 133:26–35—Ефраимын хүүхдүүдэд өгсөн “илүү баялаг адислал”

Эрт дээр үед, өв залгамжлах хүү эцгийнхөө хөрөнгөнөөс хоёр дахин их хувийг хүлээн авдаг байжээ. Энэхүү илүү хувийг гэр бүлийнхээ гачигдалтай гишүүдэд анхаарал халамж тавихад ашигладаг байв. Их Эзэн мөн энэ ёсыг сүнсний адислалуудад ашигладаг ажээ. Ефраим бол Иосефын (Иаков буюу Израйлын өв залгамжлах хүү) өв залгамжлах хүү юм. Их Эзэн түүний үр удмыг Израйлын угсааны өв залгамжлах гэр бүл болгосон билээ (Эхлэл 48:13–20; Дэд Хууль 33:13–17; Шастырын Дээд 5:1–2-ыг үз).

Эцсийн өдрүүдэд Ефраимын үр удам хамгийн түрүүнд цугларах учиртай аж. Их Эзэн сэргээгдсэн сайн мэдээний “илүү баялаг адислалыг” (сэргээгдсэн үнэнүүд, санваарын эрх мэдэл болон түлхүүрүүд, нэмэлт судар, ариун сүм гэхчилэн) тэдэнд итгэмжлэн хүлээлгэх болно. Ингэснээр тэд Израйлын гэр бүлийн үлдсэнийг-гэр ч байтугай Бурханы бүх гэр бүлийг-аврах учиртай болно. Эдгээр адислал болон үүрэг хариуцлага нь Бурхан Абрахамтай хийсэн гэрээнд холбогдох бөгөөд өгүүлэгдсэн зүйлүүдийг Сургаал ба Гэрээ 133:26–35-д тусгажээ.

Энэхүү “илүү баялаг адислал” нь Ефраимын хүүхдүүд аливаа бусад бүлгүүдээс илүү дээр гэсэн үг биш -сайн мэдээний гэрээнүүдийг хүлээн авч, сахидаг бүх хүмүүс селестиел алдар сууг өвлөх болно. Аврагчийн нэгэн адил, өөрсөддөө хүсэх тэрхүү алдар сууг мөн тэд бүгд олж болохын тулд өөрсдийн мэдлэг, онцгой боломжуудаа Бурханы бүх хүүхдэд туслахын тулд ашиглах ёстой.

Судруудыг ойлгох нь 

Сургаал ба Гэрээ 133

Их Эзэний савуудыг авч явах (ш. 5)—Их Эзэний ажлыг хийхээр томилогдох (Хуучин Гэрээний үед, Табернеклд анхаарал тавьж, Их Эзэний өргөөний савнууд буюу ариун зүйлүүдийг авч явахын тулд санваар хүртсэн хүмүүс)

Цохих (ш. 59)—Салгах, тусгаарлах (энэ нь тариаг иш, хальснаас нь салгаж, “хальсыг” шатаахаар үлдээх үйл явцыг заадаг бөгөөд Их Эзэний үйлчлэгчид “улаан буудайг” дэлхийгээс эсэн мэнд буюу аюулгүйгээр салган “цуглуулж” авахыг бэлгэддэг байжээ)

Сургаал ба Гэрээ 133:5–14—Вавилон

Эрт дээр үед, Вавилон нь Вавилони хэмээн нэрлэгддэг нутгийн нийслэл хот байв. Энэ хот дэлхийн хамгийн том хотуудын нэг байсан бололтой. Вавилонийн олон захирагчид

Судруудыг судлах нь 

Сургаал ба Гэрээ 133-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас гурвыг хий.

А Бид юу хийх вэ?

Сүмийн гишүүд Түүнийг сонс, тэгвэл Түүний ирэлтэд бэлтгэхийн тулд тэд юу хийх хэрэгтэйг тэдэнд хэлэх болно гэж Их Эзэн Сургаал ба Гэрээ 133:1–3-т хэлсэн байдаг. Дараа нь шүлэг 4–14-т Тэрээр тэд хийх ёстой зүйлээ яаж хийхийг хэлжээ.

1. Шүлэг 4–14-т Их Эзэний өгсөн зарлигуудаас наад тал нь тавыг жагсаан бич.
2. Их Эзэн эдгээр шүлгүүдэд ямар зарлигийг гурван удаа давтсан бэ? (Та нар үүнийг судрууддаа тэмдэглэхийг хүсч болно.)

3. Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан Ахлагч Стефен Л. Ритчардс: “Сионных буюу зүрх сэтгэлдээ цэвэр ариун байхын тулд хүн ‘дэлхийгээс’ гарах ёстой. Энэ нь оршин суугаа газраа өөрчлөх хэрэгтэй гэсэн үг биш. Энэ бол зүрх сэтгэлээ өөрчлөх хэрэгтэй гэсэн үг. Дэлхийгээс гарахын тулд, хүн дэлхийн философийг орхих ёстой. Тэгээд Сионд ирэхийн тулд хүн Сионы философи-ийг хүлээн авах ёстой” гэж хэлжээ (“Building Zion Today,” *Improvement Era*, 1935 оны 4-р сар, 231).

Вавилоньг орхих Их Эзэний зарлигийг дуулгавартай дагахын тулд та нар юу хийж болох вэ? Та нар Сүнсний шивнээг сонссоноор, Их Эзэн та нараар юу хийлгэхийг хүсдэгийг мэдэх болно.

4. Вавилоньг орхих нь зарим хүмүүст ихэд хэцүү байж болохыг Их Эзэн мэдэж байсан. Сион руу хийх аянаа амжилттай дуусгахад бидэнд туслах ямар чухал зөвлөгөөг Тэр Сургаал ба Гэрээ 133:5, 14–15-д өгсөн бэ? (Ёс бус хотоос зугтсан Лот болон түүний гэр бүлийн тухай, бас эхнэр нь эргэж харсны балгийн тухай Эхлэл 19:17–26-д өгүүлдэг. Та нар үүнийг С ба Г 133:5-тай харьцуулах эшлэл болгон ашиглаж болно.)

Б Хоёр дахь Ирэлтийн үед Их Эзэн хүрч ирэх нь



“Бүх махан бие [Түүнийг] хамт-даа үзэх” (Исаиа 40:5) тэрхүү цаг руу хөтлөх Есүс Христийн хэд хэдэн ирэлт байх болно. Сургаал ба Гэрээ 133:2–3, 17–25-аас мэдсэн зүйлээсээ, Хоёр дахь Ирэлтийн хэсэг болж Түүний үгс сонсогдох, Тэрээр харагдах арга замууд болон газруудыг жагсаан бич. (С ба Г 133-т дурдсан зарим үйл явдлын тухай нэмэлт ойлголтуудыг С ба Г 45:48–53; 77:11; 84:2-оос үз.)

В Ойлгоход нь тэдэнд тусал

Сургаал ба Гэрээ 133-р хэсгээс сурч мэдсэн зүйлээрээ, Ефраимын овгийнх байх гэдэг нь юу гэсэн утгатайг бич (хэрэв тусламж хэрэгтэй бол мөн С ба Г 133:26–35-ын “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз).

Г Есүс Христийн Хоёр дахь Ирэлт

1. Сургаал ба Гэрээ 133:44–56-д гардаг Есүс Христийн Хоёр дахь Ирэлттэй холбоотой үнэнүүдээс заримыг нь жагсааж бич.
2. Эдгээр үнэнүүдээс хоёрынх нь тухай бичиж, эдгээр нь яагаад сонирхлыг чинь татдагийг тайлбарла.

Д Харьцуул

Есүс Христийн Хоёр дахь Ирэлт зөв шударга хүмүүсийн хувьд гайхалтай, харин ёс бус хүмүүсийн хувьд аймшигтай байх болно. Ёс бус хүмүүсийн талаар хэлсэн зүйлүүдийг зөв шударга хүмүүст (эсвэл нөгөө талаар нь) хамааруулан бодохгүй байхын тулд Хоёр дахь Ирэлтийн тухай судруудыг анхааралтай унших нь чухал юм. Сургаал ба Гэрээ 133:52–74-г бичигдсэн зүйлүүдээс тэмдэглэлийн дэвтэртээ хоёр жагсаалт хий. Нэг дэх жагсаалтад Аврагчийн Хоёр дахь Ирэлтээр зөв шударга хүмүүст юу тохиолдоно гэж эдгээр

шүлгүүдэд өгүүлснийг бич. Нөгөө жагсаалтад, ёс бус хүмүүст юу тохиолдоно гэж дээрх шүлгүүдэд өгүүлснийг бич.

Е Номлогчдод зөвлөгөө өг

Сайн мэдээг номлох болон Израилын цугларалтын талаар илүү сайн ойлгохын тулд Бошиглогч Иосеф Смит Их Эзэнээс асуусны дүнд Сургаал ба Гэрээ 133-р хэсэг дэх илчлэлтийг хүлээн авчээ. Номлогч мэдэх нь чухал гэж бодсон хоёр сургаалыг энэ хэсгээс тэмдэглэлийн дэвтэртээ бич. Энэ хоёр сургаалыг номлогч яагаад мэдэх ёстой гэж бодож байгаагаа тайлбарла.



Хэрхэн сайн иргэд байх талаар дэлхий дахинд олон янзын үзэл бодол байдаг. Энэ сэдвийн талаар Их Эзэн юу гэж хэлсэн байдаг вэ? Бидний шийдвэрийг удирдахад тусалж чадах илчлэгдсэн ямар нэг

үнэн байдаг уу? Сургаал ба Гэрээ 134-р хэсгийг уншихдаа хэрэв бүх үндэстнүүд энэ илчлэлтэд заадаг зарчмуудыг дагах юм бол ямар их өөр байх байсныг бод. Түүнчлэн эдгээр зарчмуудын талаарх хувийн үүрэг хариуцлагынхаа тухай бод.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 134

Бүгд найрамдах улс (ш. 3)—Хууль боловсруулж, хэрэгжүүлэх төлөөлөгч-дөөр хүмүүсийг сонгож, эрх мэдлийг тэдэнд өгдөг засаг төрийн хэлбэр

Эмх замбараагүй явдал (ш. 6)—Хууль дүрэм журамгүй, захиргаагүй байдал

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 134-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

Судруудыг хэрэглэ

1. Сургаал ба Гэрээ 134-р хэсэг нь олон өөр нөхцөл байдалд хэрэглэгдэж болох итгэл болон зарчмуудыг агуулдаг. Дараах зохиомол үйл явдлуудыг авч үзэн, Сургаал ба Гэрээ 134-р хэсэг дэх аль нэг итгэл эсвэл зарчим нь эдгээр үйл явдал тус бүрд хэрхэн хамаарагдаж болохыг тайлбарла:
 - а. Нэг эмэгтэй ажил олгогчийнхоо мөнгийг хулгайлжээ. Үйлдсэн хэргийнхээ талаар тэр санаа нь ихэд зовж, хэргээ бишоптоо хүлээв. Наманчлахад өөртөө туслалхын тулд тэр эмэгтэй юуг сэргээх ёстой вэ?
 - б. Нэг хүн Сүмийн гишүүн байх эрхээ хасуулсан байна. Тэр маш их уурлаж, Сүм түүний гишүүнчлэлийг хасах эрхгүй гэж нэг сонин сурвалжлагчид ярьжээ.
 - в. Цонх хагалах нь хөгжилтэй гэж хэсэг залуус боддог байж. Чи тэднийг харах үедээ нэг найзтайгаа хамт машинаар гэр рүүгээ явж байв. Энэ хэрэг тэр хоёрын хэнд нь ч хамаагүй учраас хайхрах хэрэггүй гэж найз чинь хэлжээ. Чи яах ёстой вэ?
2. Сургаал ба Гэрээ 134-р хэсгийн аль нэг шүлэг дээр тулгуурлан өөртөө тохиолдсон хоёр үйл явдлын тухай бич.

Сургаал ба Гэрээ 135 Үнэний төлөө өгүүтгэгдсэн нь



Мөрдлөг хавчлага
Бошиглогч Иосеф
Смитийн хувьд “ердийн
мөн чанар” (С ба Г 127:2)
болов. 1820 он дахь
Анхны Үзэгдлээс хойш
Сэргээлтийн энэ агуу
бошиглогчийг дайсан эсэргүүцээр байлаа. Наувуд
Бошиглогчийн өнгөрүүлсэн
таван жил хэдийгээр агуу
илчлэлтүүд болон Сүмийн
өсөлт хөгжилтийн
жилүүд байсан ч, бас байнгын
мөрдлөг хавчлагын
жилүүд байв.

1843, 1844 онд Бошиглогч
Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад Сүмийг удирдахыг зааж,
тэднийг бэлтгэжээ. Альд явах цаг нь богинохон болсныг
тэр мэдэрч байв. Үүний хажуугаар, Сүмийг орхисон
зарим хүмүүс Сүмийг зүгээр байлгахгүй байлаа. 1844 оны
зургадугаар сарын эхээр Сүмийн гишүүн байсан зарим
хүмүүс, мөн Их Эзэний ажилд дайсагнагчид Бошиглогч
болон Сүмийн бусад удирдагчдын талаар худал зүйлүүдийг
нийтэлсэн Nauvoo Expositor сонинь гаргажээ. Энэ

нь Гэгээнтнүүдийг баруун Иллинойгоос гаргаж явуулах
арга замыг сүвэгчилж байсан энэ нутгийн Мормоньг
эсэргүүцэгчдийн дунд аль хэдийнээс газар авч байсан үзэн
ядалтын гал дээр тос нэмсэн ажээ.

Науву хотын даргын үүрэг гүйцэтгэж байсны хувьд
Бошиглогч Иосеф Смит Nauvoo Expositor-т өгсөн
хариунд, Науву хотын зөвлөл Nauvoo Expositor сонинь
хэвлэлийн газрыг устгаж, сонинь бүх хувийг шатаах
тушаал өгснийг мэдэгджээ. Хэвлэлийн газрыг эзэмшигчид
өөрсдийн нөхцөл байдлыг Науву дахь шүүгчид өгч,
Бошиглогч болон хотын зөвлөлийн эсрэг захирамж гар-
гуулсан аж. Тэднийг ямар ч гэм буруугүй гэж үзжээ.
Бошиглогчийн дайснууд эл шийдвэрт сэтгэл ханамж-
тай биш байлаа. Учир нь сайхь шүүгч Сүмийн гишүүн
байсан аж. Иймд Бошиглогч болон бусад хүмүүс гишүүн
бус өөр нэг шүүгчид асуудлаа өргөн толилуулав.
Тэднийг дахин хэрэгссэнгүй.

Энэ удаад Иллинойн Воорсоогийн ойролцоох нэг сонин
мормончуудыг “тамын чөтгөрүүд” гэж нэрлэн, энэ
асуудлыг “буу зэвсгээр” (Church History in the Fulness of
Times, 275-ыг үз) бүрмөсөн нэг тийш болгон шийдвэрлэх
цорын ганц арга замыг санал болгосон гэдэг. Хурцадмал,
аюултай энэ үед, Бошиглогч Иосеф Смит тусламж
болон харилцан ойлголцохын төлөө Иллинойн Захирагч
Томас Фордод ханджээ. Үүний хажуугаар Бошиглогчийн
дайснууд мормончуудын эсрэг тусламж эрж, бас захирагчид
хандсан байлаа. Захирагч Бошиглогчийг эсэргүүцэгч-
дийн талд байсан бололтой. Үүний дүнд, тэд бүгд түү-
нийг болон ах Хайрумыг нь гартаа оруулахыг үнэхээр
хүсч байгаа юм байна гэдгийг Бошиглогч ойлгожээ. Тэрээр
хотыг түргэн орхих болон Гэгээнтнүүд өрнө зүгт дүр-
вэж эхлэх төлөвлөгөөг хамтад нь тэр даруйд дэвшүүлэв.
Дүрвэлт зайлшгүй болно гэдгийг тэрээр илчлэлтээр
мэдсэн ажээ. Хэрэв тэр эндээс явчихвал мөрдлөг хавчла-
га намдах болно гэдэгт итгэж байв. Сүмийн зарим
гишүүд, Бошиглогч тэднийг мөрдлөг хавчлагын өмнө
орхих гэж байна гэж гомдоллон, түүний төлөвлөгөөтэй
санал нийлэхгүй байлаа. “Хэрэв миний амь нас найз
нарт минь үнэ цэнэгүй юм бол энэ нь надад өөрт минь
юу ч биш” гэж Бошиглогч хариулж, ингээд Наувуд эргэж
иржээ (History of the Church, 6:549).



© 1979 Харольд И. Хопкинсоны эрдэн газар

Бошиглогч Иосеф Смит, Хайрум Смит болон Науву
хотын зөвлөлийн гишүүдийг үймээн самуун гаргасан
хэргийн учир сайн дураараа баривчлагдахад болгон

Картейжид хожим нь аваачсан аж. Зургадугаар сарын 25-нд “энхийн шүүгч, бас ахмад бөгөөд Картейж Грейсийн Мормоны эсрэг намын идэвхтэн Роберт Ф.Смитийн өмнө урьдчилсан хэрэг сонсолт болов. Науву хотын зөвлөлийн гишүүн бүрийг таван зуун долларын баталгаагаар чөлөөлж, тойргийн шүүхийн дараагийн хуралд очихыг тушаажээ. Хэрэг таслагдсан хүмүүсийн ихэнх нь Науву руу явсан боловч, Иосеф, Хайрум хоёр Захирагч Фордтой ярилцахын тулд үлдэв. Иосеф, Хайрум хоёрыг эх орноосоо урвасан хэргийн учир дээд хэмжээ буюу цаазаар авах ялыг өгч, энэ хэргийн учир шүүгдэх хүртэл тэднийг шоронд хорих тухай Шүүгч Смитийн гарын үсэг зурсан зарлан дуудахыг тэр орой нэг цагдаа авчирч өгөв. Тэдний хэргийг сонсох үед уг ялын талаар дурдаагүй учраас Иосеф болон түүний өмгөөлөгчид эл зарлан дуудахыг хууль бус гэж эсэргүүцэв. Тэд голдлоо захирагчид тавьсан боловч үүргээ биелүүлэхэд нь иргэний ажилтанд саад учруулж болохгүй гэж захирагч хэлжээ” (Church History in the Fulness of Times, 278). Гэвч, хэрэв тэрээр Науву руу явах юм бол Бошиглогч, Хайрум Смит хоёрыг өөртэйгөө хамт авч явж болно гэж амласан аж.

1844 оны зургадугаар сарын 27-ны пүрэв гарагт, шоронг дайрч, ах дүү хоёр Смитийг алах гэж байгаа төлөвлөгөөний талаар сонсоноо Захирагч Фордод хэлүүлэхээр, - бас Картейж шоронд ахлагч Жон Тейлор, Виллярд Ричардс нартай хамт шөнийг өнгөрүүлсэн- Дан Жөүнсийг Бошиглогч илгээв. Захирагч Форд Бошиглогчид аюул учраагүй байгаа гэж Дан Жөүнст итгүүлсэн аж. Жөүнс ахыг шорон руу буцахыг зөвшөөрсөнгүй, ингээд тэр Науву руу гэдрэг буцсан аж. Захирагч Форд ч бас Науву руу явсан боловч, Бошиглогчийг өөртэйгөө хамт авч явсангүй.




Тэр өдрийн үдээс хойш сэтгэлийн хүнд дарамт Бошиглогч Иосеф Смитийг эзэмджээ. “A Poor Wayfaring Man of Grief” (Уй гашууд автсан, явганаар аялагч ядуу эр,

Дуулууд, д. 29-ийг үз) дууг дуулж өгөхийг тэрээр Жон Тейлороос хүсэв. Хайрум Смит энэ дууг дахин дуулахыг Ахлагч Тейлороос хүссэнд, хэдийгээр уйтгар гуниг сэтгэлийг нь эзэмдэж, таагүй байсан ч тэрээр энэ дууг дахин дуулав.

Тэднийг шоронгийн дээд давхрын унтлагын өрөөнд байхыг зөвшөөрсөн боловч, шоронгийн хуяг орж ирэн, тэднийг гяндангийн өрөөнд шилжин орохыг зөвлөжээ. Тэнд тэдэнд илүү аюулгүй байх болно гэж тэр бодсон аж. Бошиглогч Иосеф Смит тэдэнтэй хамт гяндангийн өрөө рүү шилжих үү гэж Виллярд Ричардсаас асуужээ. Хэрэв Бошиглогчийн амь насыг егүүтгэхээр оролдох юм бол, түүний оронд би үхэх болно гэж Ахлагч Ричардс Бошиглогчид хэлжээ. “Та тэгж болохгүй” гэж Бошиглогчийг хэлэхэд, “Би тэгэх

болно” гэж Ахлагч Ричардс хариулсан гэдэг. (Robertс, Comprehensive History of the Church, 2:283-ыг үз.)

“Шоронгийн урд талын нэг цонхны дэргэд сууж байх үед нүүрээ будсан нэлээд олон хүмүүс шоронгийн булан тойрон ирж, шат руу чиглэхийг би харсан.. Бусад ах нар ч бас үүнийг харсан байв. Учир нь намайг хаалга руу хүрч очиход Хайрум Смит ах, доктор Ричардс хоёр аль хэдийн хаалга тулан зогсож байлаа. Тэр хоёр цоож түгжээ нь хэрэгцээгүй болсон хаалгыг онгойлгохоос сэргийлж мөрөөрөө тулан дарж зогссон байсан” гэж Ахлагч Жон Тейлор тэмдэглэжээ (Gospel Kingdom, 359). “Цаг дөнгөж тав өнгөрч байх үед шоронгийн гадна хаалга шаржигнан, харуулууд руу бархиран хашираах, галт зэвсгээр буудах чимээ гарч, дараа нь улангасан галзуурсан мэт өс хонзонгоор дүүрэн согтуу, эмх замбараагүй зэвсэгт танхайрагчид шорон руу дайран орж ирсэн” гэж Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит бичжээ (Church History and Modern Revelation, 2:401). Хаалгыг сум нэвтлэн, Хайрум Смитийн нүүрэнд туслаа. Гаднаас хоёр дахь сум нуруунд нь тусахад, “Би үхлээ” гэж тэр хэлээд шалан дээр унав. Бошиглогч, “Эй, хөөрхий ах минь, эрхэм Хайрум минь” гэж хэлээд унав. Тэрээр зургаа үсэрдэг гар буу шүүрч аваад, хамгаалах гэж дэмий л оролдов. Жон Тейлор цонхоор гарч зугтах гэж оролдоод буудуулав. Тэр шархадсан байлаа. Нэг сум хантаазных нь халаасанд байсан цагийг онож тэрээр үхлээс аврагдсан байсан ба үүрд-1844 оны зургадугаар сарын 27, Пүрэв гараг, оройн 5:00 цаг 16 минут 26 секунд хэмээн аллагын хугацааг тамгалан үлджээ.



Картейж шорон

Бошиглогч Иосеф Смит бас цонх руу ухасхийв. Замд нь түүнийг хоёр сум араас нь, бас нэг сум гаднаас түүнийг гэдсэнд нь оножээ. Тэрээр хашиа руу доошоо уналгүй, цонхны тавцан дээр тээглэн тогтсон байв (С ба Г 135:1-ийг үз).

Гэнэт гаднаас, “Мормончууд ирж явна!” гэж хашираах сонсогдов. Мормончууд ирээгүй, харин энэ үг танхайрагчдыг цочоон түгшүүлж, гэдрэг түргэн зугтахад хүргэжээ. Захирагч Форд болсон явдлыг сонсоод, Картейж хотыг хамгаалах арга хэмжээ авсан гэдэг. Гэвч Гэгээнтнүүд өс хонзон авах төлөвлөгөөгүй байлаа. Бошиглогч нь алагдаж, тэд уй гашууг тэсэн өнгөрүүлж байлаа. Өс хонзон авахгүй гэдгийг нотлохын тулд Виллярд Ричардс ах Наувуд олон нийтийн цуглаан дээр

үг хэлэхдээ, хариугаа авахгүй байхыг хүмүүсээс хүсчээ. Алагдсан бошиглогчдын цогцсыг 1844 оны зургадугаар сарын 28-нд Наувуд буцаан авчрав. Тэндхийн мянга мянган хүмүүс тэдэнтэй салах ёс гүйцэтгэж, хүнд гарз хохиролдоо гишүүдахаар Манишен Ордонд цугласан байв.

Төлөөлөгч Жон Тейлор болсон явдлыг нүдээр үзсэн гэрчийн хувьд энэ тухай албан ёсны үздгийг дэлхийд гэрчлэл болгон бичих нь чухал гэж боджээ. Сургаал ба Гэрээ 135-р хэсгийг уншихдаа, өөрийн чинь амьдралд мөн дэлхий даяарх сая сая хүмүүсийн амьдралд үзүүлсэн Бошиглогч Иосеф Смитийн тохинууллын үр нөлөөний тухай бод.

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 135

Сургаал ба Гэрээ 135:5—“Тэдний гэрчлэл хүчин төгөлдөр байна”



Бошиглогч болон Хайрум Смитийн ээж Люси Мак Смит амь үрэгдсэн хөвгүүдийнхээ тухай дараах зүйлийг бичжээ: “Цогцсуудыг угааж, оршуулгын хувцсыг нь өмсгөсний дараа, тэднийг үзэхийг бидэнд зөвшөөрөв. Би удаан хугацаанд бухимдал болгоноо барьж, сэтгэлээ чангалан, намайг хүчтэй болгохыг Бурханд хандан

залбирч байсан ч, харин намайг өрөөнд ороход, нүдний өмнө нэг дор егүүтгэгдсэн хоёр хүүгийн минь цогцоснуудыг харсан. Гэрийнхэн маань мэгшин уйлж, уй гашуу болон, ‘Аав аа! Хань минь! Ах нар минь!’ хэмээн эхнэр, үр хүүхэд, эрэгтэй, эмэгтэй эгч дүү нар нь уйлан хайлахыг сонсоход даанч хэцүү байлаа. Сэтгэлийн эмзэглэлээр амь тэмцэн бачимдаж, ухаан минь самууран, Их Эзэнд хандан ‘Бурхан минь, Бурхан минь, та яагаад энэ гэр бүлийг орхив доо?’ хэмээн сэтгэлээсээ хашгирахад, “Тэд амарч болохын тулд би тэднийг өөртөө авсан.” . . . хэмээн нэгэн дуу хоолой хариулав. Бидний хамтдаа амссан уй гашуу, сэтгэл санааны хүнд дарамтын үйл явдал бүр оюун ухаанд минь жирэлзэн өнгөрөхөд тэдгээр нь хөвгүүдийн минь гэм буруугүй, хайр энэрлээр дүүрэн гэнэн цайлган зүрх сэтгэлийг харуулж байлаа. Хөвгүүдийнхээ амар амгалан, инээмсэглэсэн дүр төрхийг харахад, тэд бараг л дуулдахаар, “Ээж ээ, бидний төлөө бүү уйл. Бид хоёр хайраар дэлхийг яллаа. Хүмүүний бодгаль аврагдаж болохын тулд бид сайн мэдээг тэдэнд хүргэсэн. Гэрчлэлийн маань төлөө хүмүүс биднийг егүүтгэлээ. Ингэснээрээ тэд биднээс саллаа. Тэдний давамгайлал түр зуурынх юм. Мөнхийн ялгуусан ялалт биднийх шүү” гэж хэлэх шиг санагдаж билээ (History of Joseph Smith, 324–325).

Судруудыг судлах нь



Сургаал ба Гэрээ 135-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудыг хий.

А Сонины сурвалжлага бич

Бошиглогч Иосеф Смит, Хайрум Смит хоёр алагдсаны маргааш нь Картейж шоронгийн гадаа зогсож байгаа телевизийн мэдээний сурвалжлагч гэж өөрийгөө бод. Сурвалжлага авахын тулд чамд дөчин таван секундын хугацаа байна. Ийм богинохон хугацаанд хэлэх зүйлээ бичихэд туслахаа авахын тулд Сургаал ба Гэрээ 135-р хэсэг болон энэ судлах гарын авлага дахь Сургаал ба Гэрээ 135-р хэсгийн оршил дахь мэдээллийг ашигла.

Б Жагсаалтад нэм

1. Сургаал ба Гэрээ 135:3-ын эхний өгүүлбэрт, Бошиглогч Иосеф Смитийн тохинууллын тухай Ахлагч Жон Тейлор зоримог мэдэгдэл хийжээ. Мэдэгдэл яагаад үнэн болохыг тайлбарла.
2. Шүлэг 3-т өгүүлснээр, Бошиглогч Иосеф Смит хүн төрөлхтөнд ямар хувь нэмэр оруулсныг жагсаан бич.

В Та нар юу гэж бодож байна?

Хайрум Смит Картейж руу явж байхдаа Ифер 12:36–38 дахь бошиглогч Моронайн үгсийг уншжээ. Эл судар болон Сургаал ба Гэрээ 135:4–5-ыг үзэж, энэ нь Бошиглогч Иосеф Смит, ах Хайрумынх нь байдалд хэрхэн холбогдохыг бич.

Г Түүний амьдрал чамд хэрхэн нөлөөлсөн бэ?

Бошиглогч Иосеф Смитийн тухай мэдсэн бүх зүйлээ авч үзэн түүний амьдрал өөрт чинь нөлөөлсөн арга замуудын тухай бич.

Сургаал ба Гэрээ 136



Сургаал ба Гэрээ 136-р хэсгийн материал “Сүм Өрнөд рүү шилжсэн нь” (х.[00] 164) хэсэгт байгаа болно.

Сургаал ба Гэрээ 137

Селестиел Хаант улсын тухай үзэгдэл



1832 онд Бошиглогч Иосеф Смит цуврал үзэгдэл хүлээн авчээ. Мөнх бус байдал болон шүүлтний дараа бидний

томилогдон очих хаант улсуудын тухай их зүйлийг тэдгээр үзэгдлүүдэд Бурхан түүнд илчилсэн ажээ (С ба Г 76-г үз). Селестиел хаант улсыг өвлөх хүмүүс Есүс Христийн тухай гэрчлэл хүлээн авч, уг гэрчлэлдээ зоригтой байж, баптисм хүртэн, Ариун Сүнсний бэлэг хүлээн авах зэрэг зүйлүүдийг хийх ёстойг дээрх үзэгдлүүдээс мэджээ. Харин Есүс Христийн тухай ерөөсөө заалгаж байгаагүй учраас Түүний тухай гэрчлэл хүлээж авах боломж огт олдоогүй хүмүүс яах вэ? Бурханы эрх мэдэлтэй үйлчлэгчдийн гараас баптисм болон бусад ёслолуудыг хүлээн авах боломж ерөөсөө олдоогүй хүмүүс яах вэ? 1836 оны нэгдүгээр сард Бошиглогч Иосеф Смитийн хүлээн авсан илчлэлт эдгээр асуултад хариулахад тусалдаг.

Сургаал ба Гэрээ 137-р хэсгийг уншихдаа, Бошиглогчийг эргэцүүлэн бодоход хүргэсэн зарим нэг зүйлийг тэрээр харсныг та нар ажиглах болно. Түүний эргэцүүлэн бодсон зүйлд Их Эзэн хариулж, бүх хүүхдийнхээ авралтай холбоотой чухал сургаалыг тодруулжээ. Энэхүү илчлэлтээр Бошиглогчийн мэдсэн зүйлүүд ойролцоогоор гурван сарын дараа Көртландын Ариун сүмд санваарын чухал түлхүүрүүдийг хүлээн авахад бас тусалжээ (С ба Г 110:11–16-г үз).

Сургаал ба Гэрээ 137-р хэсэгт агуулагдсан илчлэлтийг, Сүмийн албан ёсны судруудад оруулах саналыг Сүмээр дэмжүүлэн батлуулахын тулд 1976 оны дөрөвдүгээр сарын ерөнхий чуулган дээр танилцуулжээ. Эл илчлэлт анх Агуу Үнэт Сувдын нэг хэсэг болж нийтлэгдээд, хожим нь Сургаал ба Гэрээний 1981 оны хэвлэлд анх удаа 137-р хэсэг болон хэвлэгдсэн юм. (In Conference Report, 1976 оны 4-р сар, х. 29; Ensign, 1976 оны 5-р сар, х. 19; мөн “Three Additions to Be in Doctrine and Covenants,” Ensign, 1979 оны 1-р сар, 75-ыг үз).

Судруудыг ойлгох нь



Сургаал ба Гэрээ 137

Хариуцлагын нас—
(ш.10)—Найман нас

Сургаал ба Гэрээ 137:1—“Биенд үү эсвээс гадна уу гэдгийг би хэлж үл чадна”

“Бид зуурдын байдалд амьдарч байгаа үед бидний мөнх бус биеийн талаар, бидэнд илчлэх нь тохиромжтой хэмээн Бурхан хязгааргүй мэргэн ухаанаараа болгоосон бүх зүйл, юу ч байлаа гэсэн хийсвэр байдлаар бидэнд илчлэгддэг. Харин . . . биенд биш, бидний оюун ухаанд дээрх зүйлүүд яг тодорхой байдлаар илчлэгддэг” гэж Бошиглогч Иосеф Смит сургажээ (Teachings of the Prophet Joseph Smith, 355). Ийм үзэгдэл дэлхийн зүйлүүдтэй холбоотой байх нь ерөөсөө боломжгүй сүнсний хувиралтыг өөртөө багтаадаг. Төлөөлөгч Паул үүнтэй төстэй тохиолдлыг 2 Коринт 12:2–4-т дүрсэлсэн байдаг. Бас бусад бошиглогчид үзэгдэл хувирахын үр дагаврыг тэмдэглэсэн нь бий (Моисе 1:10–11-ийг үз).



Сургаал ба Гэрээ 137:5—“Аав минь, ээж минь; бас ах Алвин минь”

Бошиглогч Иосеф Смит аав, ээж, ах Алвин нараа Селестиел хаант улсад харсан нь түүнд сонин санагдсан байх. Бошиглогч энэ үзэгдлийг хүлээн авах үед аав Иосеф нь Көртландын Ариун сүмийн дээд давхрын өрөөнд байсан гэдэг. Ээж нь ч бас амьд сэрүүн байсан. Ирээдүйд тохиох ямар нэг зүйлийг Бошиглогч харсныг энэ үйл явдал тодорхой харуулж байна.

Ах Алвин нь Сүмийг сэргээхээс өмнө нас барсан байтал яагаад селестиел хаант улсад байгааг Бошиглогч эргэцүүлэн бодсоныг Сургаал ба Гэрээ 137:6 цэдэглэдэг. Алвин Смит 1823 оны арваннэгдүгээр сард, тэнгэр элч Моронай Бошиглогч дээр хүрч ирсний дараахан, авралын ёслолуудыг гүйцэтгэх хүч сэргээгдэхээс нэлээд эрт нас барсан ажээ. Нэгэн үйл явдлыг тохиолдуулан Бошиглогч хэлэхдээ, Алвин бол “аавын минь гэр бүлд ууган нь, бас хамгийн уужуу сайхан сэтгэлтэй нь байсан юм. Тэр бол хүмүүний хөвгүүдийн дээж нь болсон, өгөөмөр сайхан сэтгэлтэй нэгэн байсан . . . Заль мэх түүнд байсангүй. Тэрээр бүр бага балчир байхаасаа толбогүйгээр амьдарч байлаа. . . . Алвин ах маань хамгийн эрүүл, тунгаан сэтгэх чадвартай хүмүүний нэг байв. Тиймээс ахыг маань амьсгалаа хураах эцсийнх нь мөчүүдэд Их Эзэний тэнгэр элч түүн дээр хүрч ирсэн юм” гэжээ (History of the Church, 5:126–127). Тэрээр баптисм огт хүртээгүй буюу Сүмд нэгдээгүй учраас Алвин Смит там руу одсоныг түүний оршуулга дээр номлосон шашны нэг тохинуулагч хэлсэн гэдэг (“Another Testimony: Statement of William Smith, Concerning Joseph, the Prophet,” Deseret Evening News, 1894 оны 1-р сарын 20, х.11-ийг үз).

Сургаал ба Гэрээ 137:9—“Тэдний зүрх сэтгэлийн хүслийн дагуу”

Хариуцлага, тайтгарал аль алиныг нь бидэнд өгдөг нэг үнэний тухай Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Нийл А.Максвелл Сүмийн гишүүдэд сануулан:

“Хүсэл нь . . . бидний зөвийг сонгох эрх, бидний хувь хүний онцлогтой шууд холбоотой юм. Өөрсдийн үзэл бодлоо эсвэл өөрсдийгөө илэрхийлэхийн аль нь ч бай бидний хүсэл нь сонгох эрхээ ашиглахад гүнзгийгээр нөлөөлдөг.

Ийнхүү бид хүслийнхээ үр дагаврыг үнэхээр хүсээгүй байхад ч гэсэн, хүсэл нь. . . шийдвэрлэгч хүчин зүйл болдог.

“Хүсэл нь үнэхээр урт удаан хугацааны буюу эгээрэл хүслэн юм. Эндээс үзэхэд, зөв шударга хүсэл нь идэвхгүйгээр эрхэмлэдэг зүйл, түр зуурын мэдрэмжээс хавьгүй чухал юм. Мэдээж бидний гарал үүсэл, нөхцөл байдал, хүрээлэн байгаа орчин биднийг төлөвшихөд чухал ач холбогдолтой. Гэвч бидний дотор нэгэн дотоод зурвас хэсэг, хэрэв бид өөрсдөө л татгалзахгүй аваас, эдгээр хүчин зүйлст өртөхгүйгээр үлддэг. Энэ зурвас хэсэгт бидний хувь хүний онцлог, хариуцлага хүлээх чадвар оршдог.

“Тиймээс, бидний өдрийн бодол шөнийн зүүд болсон хүслэн бол эцсийн эцэст бид ямар хүмүүс болох, мөн бидний үүрд мөнхөд хүлээн авах тэр зүйл болно” гэжээ (In Conference Report, 1996 оны 10-р сар, 26; *Ensign*, 1996 оны 11-р сар, 21; мөн Алма 41:3–6-г үз).

Сургаал ба Гэрээ 137:10—Бага насны хүүхдүүд Селестиел хаант улсад аврагддаг



Бага насны хүүхдүүд хариуцлагын нас-найман нас-хүрэхээс өмнө нас барсан бол тэдэнд ариун сүмийн ёслолууд хэрэгтэй гэж зарим хүмүүс боддог. Тэдэнд баптисм хэрэггүйг Их Эзэн тодорхойгоор ойлгуулсан билээ (Моронай 8:10–13-ыг үз).

Бага насны хүүхдийн төлөө гүйцэтгэх ёстой ариун сүмийн цорын ганц ёслол бол, хэрэв тэд гэрээнд төрөөгүй бол эцэг эхтэй нь лацдан холбох ёслол юм.

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 137-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

A Судрын гарамгай мэдлэг-Сургаал ба Гэрээ 137:7–10

1. Селестиел хаант улсыг өвлөж болно гэж Сургаал ба Гэрээ 137:7–10-т заасан бүлэг хүмүүсийг жагсаан бич.
2. Шүлэг 7–9-д өгүүлсэн хүмүүс селестиел хаант улсад очиход бэлтгэгдэхийн тулд *бид* юу хийх ёстой вэ?
3. Бурханы тухай эдгээр шүлгүүд юу заадаг вэ?
4. Бидний үүрэг хариуцлагын тухай эдгээр шүлгүүд юу заадаг вэ?

B Сайн мэдээ юү, эсвэл муу мэдээ юү?

1. Сургаал ба Гэрээ 137:9-т өгүүлсэнээр, Их Эзэн биднийг шүүхдээ ямар хоёр зүйлийг харгалзах вэ?
2. Их Эзэний дурдсан хоёр дахь зүйлийг авч үз. Шүүлтийн тухай үнэнийг мэдэх нь хүмүүст сайн мэдээ байж болох нөхцөлийн талаар жишээ гарга. Бас уг нөхцөл нь муу мэдээ байж болох жишээ гарга.

B Чи юу гэж хэлэх вэ?

Долоон настай хүү нь ослоор нас барсан нэг гэр бүл гашуудаж байгааг өөрөө мэджээ гэж бод. Ариун сүмд хүүгийнх нь өмнөөс хэн нэгэн хүн баптисм хүртэх хэрэгтэй эсэхийг эцэг нь мэдэхгүй байв. Нас барагсдын өмнөөс хийх баптисм бага насны хүүхдүүдэд шаардлагагүйг тэрээр ойлгоход туслахын тулд Сургаал ба Гэрээ 137:10-аас мэдсэн зүйлээсээ чи энэ эцэгт юу гэж хэлэх вэ? (мөн Моронай 8; С ба Г 137:10-ын “Судруудыг ойлгох нь” хэсгийг үз).

Сүм Өрнөд рүү шилжсэн нь

Өвлийн дундуур Наувугаас хөдөлж, Айоваг гатлах хүнд аян хийснээр Гэгээнтнүүд Сүмийн түүхэнд шинэ хуудсыг эхэлсэн билээ. Алс өрнөд рүү хийсэн Гэгээнтнүүдийн аян амьдралын шинэ нөхцөл байдал болон Солт Лейкийн Хөндийд суурьшин гэр орноо шинээр төвхнүүлэх үеийг авчирсан юм. “Энэ нутаг дорнод дахь хүн суурьшсан хамгийн ойрхон газраас бараг мянган бээр (1609 км), Номхон Далайн эргээс бараг найман зуун бээр (1287 км) хол байлаа. Цаг агаарт дасах нь тэдэнд хэцүү байлаа. Хүмүүс энд хэзээ ч тариа тарьж, ямар ч барилга байшин барьж байсангүй.

“Тэд цөлөгдөж, Миссиппи мөрөн дээрх үзэсгэлэнт сайхан хотоосоо Өрнөдийн эзгүй зэлүүд нутаг руу хөөгдсөн юм. Гэвч судруудаас үүдэлтэй үзэгдэл болон: ‘Тэр үндэстнүүдийн төлөө тугийг өргөн, газрын дөрвөн зүгээс Израилын цөлөгдсөн хүмүүс, Иудагийн бутрагсдыг цуглуулна’ (Исаиа 11:12)” гэсэн илчлэлтийн үгс тэдэнд байв (“Faith in Every Footstep: The Epic Pioneer Journey” нэртэй Тэргүүн Зөвлөлийн хүүрнэн өгүүлсэн видео хичээлээс, In Conference Report, 1997 оны 4-р сар, 86; *Ensign*, 1997 оны 5-р сар, 64).

Дараагийн тавин жилийн туршид Бригам Янг, Жон Тейлор, Вилфорд Вудрафф нарын бошиглогчдоор удирдуулсан “үндэстнүүдийн энэ туг” агуу эсэргүүцэл, хүнд сорилтууд зэрэгцсэн амгалан, өсөлт хөгжилтийн үеүд байлаа. Номлолын ажил Мексик, Америкийн Өрнөд нутаг, Полинез, Европт хүрч өргөжин тэлэв. Сейнт Жорж, Логан, Мантай, Солт Лейкийн дөрвөн ариун сүм баригдан онцгойлон адислагдаж, амьд байгаа хүмүүс болон нас барагсдын өмнөөс мөнхийн ёслолууд гүйцэтгэх газар болов. Хүүхдийн Хэсэг зохион байгуулагдлаа. Тив дамнасан төмөр зам баригдаж дууссан нь Юта дахь Гэгээнтнүүдэд эдийн засгийн өсөлт хөгжилтийг авчирсан ажээ. Үүний зэрэгцээгээр, Сүмийг болон зарим гишүүдийг нь мөрдөн хавчих явдал дахин гаарч эхлэв. Олон номлогчид дайралтанд өртөж, зарим нь энэ үеэр алагдав (*Бидний Өв*, х. 98). Олон эхнэр авах ёсыг дагасан хүмүүсийн олон эрхийг үгүй болгосон хуулиуд батлагдан гарсан төдийгүй, Сүмийн өмчийн эрхийг, түүний дотор ариун сүмүүдийг бас хязгаарлахыг Гэгээнтнүүд үзэв. Олон эхнэр авах ёсыг дуусгавар болгох цаг болсныг 1890 онд Их Эзэн Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф илчилсэн билээ.

Анхааруулга: Сургаал ба Гэрээ болон Сүмийн Түүх Судлах Оюутны гарын авлагад сүүлчийн долоон долоо хоног нь 1845 оноос одоог хүртэлх Сүмийн түүхийн үйл явдлууд болон Бригам Янгаас Гордон Б.Хинкли хүртэлх бошиглогчдын сургаалуудад анхаарал төвлөрүүлдэг. Та нарын унших даалгавар нь (Сургаал ба Гэрээ 136; 138; Албан Тунхаг 1, 2-ын хамт) *Бидний Өв:Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Товч Түүх* номноос Сүмийн түүхийг, тэрчлэн бошиглогч бүрийн үгсээс сонгож авсан хэсгүүд байх болно. Энэхүү унших даалгавар судлах гарын авлагын оршил бүрийн дараа байгаа. “Судруудыг ойлгох нь” хэсгийг “Уншсанаа ойлгох нь” хэсгээр сольсон болно. Энэ хэсэгт *Бидний Өвөөс* унших зүйл доторх зарим үг хэллэгийг ойлгоход туслах зорилготой юм. “Уншсанаа судлах нь” хэсэг нь өмнөх “Судруудыг судлах нь” хэсгийг орлоно. Энд та нарын хийх даалгавар, үйл ажиллагаанууд байгаа болно.

Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх залгамжлал Сүмийн шинэ Ерөнхийлөгчийг сонгосон нь

Бошиглогч Иосеф Смитийг алагдахад Сүмийн хувь заяа хэрхэх бол гэдэгт олон гишүүдийн санаа зовж байв. Сүмийг удирдахаар Бошиглогчийг хэн залгамжлах бол? “Анхны залгамжлал хэрэгжихэд Сүм сэргээгдээд дөнгөж 14 жил болж байлаа. Бошиглогчгүй, ‘нээлттэй үзэгдэл’-гүй олон зуун өнгөрсөн байв. Сүм, илчлэлт, бошиглогчид гээд үнэлж баршгүй бүх адислалыг эзэмшиж байсан хүний амь насыг Картейжид бууны сум бүрэлгэсэн тэр үед хүмүүст түмэн асуулт гарч ирсэнд гайхах юун. Төлөөлөгчид номлолоосоо буцаж ирээд, егүүтгэгдсэн бошиглогчоо нутаглуулж, ирээдүйг авч хэлэлцсэн тэр үед, бүх түлхүүрийг аль хэдийнээс эзэмшиж байсан хамгийн ахмад настай Төлөөлөгч, Мосегийн адилаар урагш гарч ирэн, замыг зааж удирдахад, бүх эргэлзээ сарнин арилсан юм” гэж Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл тайлбарлажээ (In Conference Report, 1970 оны 4-р сар, 119).

Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх залгамжлал

1. “Бошиглогч Иосеф, Хайрум Смит хоёр Картейж шоронд алагдахад Арванхоёрын Чуулга болон Сүмийн бусад удирдагчдаас олон нь номлолд үйлчилж, Наувуд байхгүй байв. Эдгээр хүмүүс аллагын тухай мэдэх хүртэл хэдэн өдөр өнгөрчээ. Бригам Янг энэ мэдээг сонссон үед, санваарын удирдлагын түлхүүрүүд Сүмд хэвээр байгааг мэдэж байв. Учир нь эдгээр түлхүүрүүд Арванхоёрын Чуулгад өгөгдсөн

байлаа. Гэвч Иосеф Смитийг Их Эзэний бошиглогч, үзмэрч, илчлэгчийн хувьд хэн орлон залгамжлахыг Сүмийн бүх гишүүд ойлгохгүй байжээ.

2. “Тэргүүн Зөвлөлийн нэгдүгээр зөвлөх Сидней Ригдон Пеннсилванийн Питтсбургээс 1844 оны наймдугаар сарын 3-нд ирэв. Тэрээр нэг жилийн өмнөөс Бошиглогч Иосеф Смитийн зөвлөгөөг сөрөн эсэргүүцэх замд орж, Сүмээс хөндийрсөн ажээ. Сидней Ригдон Наувуд ирчихээд байсан Арванхоёрын гурван гишүүнтэй уулзахаас татгалзаж, ням гарагийн үйлчлэлдээ цуглаад байсан Гэгээнтнүүдийн олон хүнтэй бүлэгт хандан үг хэлсэн байна. Иосеф Смитийг хэн ч орлож болохгүйг мэдсэн нэг үзэгдлийг хүлээж авснаа тэдэнд ярьжээ. Сүмд харгалзан хамгаалагч томилогдох ёстой, бас тэр харгалзан хамгаалагч нь Сидней Ригдон байх ёстой гэж тэр ярьжээ. Цөөхөн Гэгээнтэн түүнийг дэмжив.

3. “Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Бригам Янг 1844 оны наймдугаар сарын 6-ныг хүртэл Наувуд эргэж ирээгүй байв. Хэн Сүмийг удирдах ёстой талаар ‘Бурхан юу хэлэхийг’ л мэдэхийг хүсч байгаагаа тэр мэдэгджээ [History of the Church, 7:230]. 1844 оны наймдугаар сарын 8-нд Арванхоёр Төлөөлөгч хурал хийхээр зарлав. Сидней Ригдон өглөөний хуралдаан дээр цаг гаруй үг хэлэв. Өөрийнх нь байр суурийг баримтлагч цөөхөн хүний саналыг л тэр авч чадсан ажээ.

4. “Дараа нь Бригам Янг Гэгээнтнүүдийн санаа сэтгэлийг тайвшруулж, товчхон үг хэлэв. Бригамыг үг хэлж байхад ‘Иосефын дуу хоолой сонсогдож,’ бас тэдний өмнө яг л Иосеф зогсож байгаа юм шиг хүмүүсийн нүдэнд харагдсаныг Жорж К.Каннон дурссан байдаг.’ Бригам Янг яг л Бошиглогч Иосефын дуугаар ярьж байсныг Виллям К.Стейнс гэрчилжээ. ‘Энэ бол Иосеф мөн байна гэж би бодсон. ‘Мөн энэ дуу хоолойг сонссон олон мянган хүн ч бас тэгж бодсон’ гэж Стейнс хэлжээ. Вилфорд Вудрафф бас энэ гайхалтай мөчийн тухай эргэн санаж, ‘хэрэв би түүнийг өөрийн нүдээр хараагүйсэн бол, энэ нь Иосеф Смит байгаагүй гэж хэн ч надад итгүүлж чадахгүй байсан. Бас энэ хоёр хүнийг таньдаг байсан хэн боловч үүнийг гэрчлэхгүй байж чадахгүй байсан’ хэмээн бичжээ. [History of the Church 7:236 дахь иш таталтууд.] Олон хүний нүдээр харж, чихээр гэрчилсэн энэхүү гайхалтай илрэл нь Их Эзэн Бригам Янгийг Иосеф Смитийн залгамжлагч, Сүмийн удирдагчаар сонгосныг Гэгээнтнүүдэд тодорхой ойлгуулсан юм.

5. “Үдээс хойшхи хуралдаан дээр Бригам Янг дахин үг хэлж, Бошиглогч Иосеф Бурханы хаант улсын түлхүүрүүдийг бүх дэлхийд эзэмшүүлэхээр Төлөөлөгчдийг томилсныг гэрчлэв. Арванхоёрыг дагаагүй хүмүүс дэвжиж дээшлээгүй, түүнчлэн зөвхөн Төлөөлөгчид л Бурханы хаант улсыг байгуулахад ялалт байгуулах болно хэмээн тэрбээр бошиглов.

6. “Ерөнхийлөгч Янг үг хэлснийхээ дараа үг хэлэхийг Сидней Ригдонгоос хүссэн боловч, тэр үг хэлэхгүй байхаар шийджээ. Виллям В.Фелпс, Парли П.Прайт нарыг үг хэлсний дараа Бригам Янг дахин үг хэлэв. Наувугийн Ариун



сүмийг дуусгах тухай, эзлүүд нутаг руу явахын өмнө ариун сүмийн хишиг хүртээх болон судруудын ач холбогдлын талаар тэр ярьжээ. Бригам Янг Иосеф Смитийг болон гэр бүлийг нь хэрхэн хайрладаг байсан талаараа тэр ярьжээ. Дараа нь Гэгээнтнүүд Сүмийн удирдагчдаар Арванхоёр Төлөөлөгчийг санал нэгтгэйгээр дэмжин батлав.

7. “Өөр цөөхөн хүн Сүмийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн эрхийг өөрсдөдөө авахыг шаардсан боловч Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн олонхийн хувьд залгамжлалын асуудал амжилттай шийдвэрлэгдсэн юм. Хамгийн ахмад настай Төлөөлөгч, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Бригам Янгийг Бурханы Өөрийн хүмүүсийг удирдуулахаар сонгож, хүмүүс санал нэгтгэйгээр дэмжин баталжээ” (Бидний Өв, 66–67).



Уншсанаа ойлгох нь



Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх залгамжлал

Үзмэрч (догол мөр 1)—
Өнгөрсөн, одоо, ирээдүйн
зүйлүүдийг мэддэг хүн
(Мозая 8:13—17-г үз)

Харгалзан хамгаалагч
(догол мөр 2)—Харгалзан

хамгаалдаг буюу хадгалдаг хүн

Баримтлагчид (догол мөр 3)—Дэмжигчид

Хишиг (догол мөр 6)—
Ариун сүмд гүйцэтгэгддэг
ёслолууд болон гэрээнүүд

Уншсанаа судлах нь




“Ерөнхийлөгчийн Зөвлөл дэх Залгамжлал”-ыг судлахдаа үйл ажиллагаа А-г хий

А Тэр үед ба одоо

1. Бригам Янг Сүмийг удирдахаар сонгогдсон тухай шастирыг нэгтгэн дүгнэ. Чи тэнд, өмнө талын эгнээнд сууж байсан гэж бодон товч тэмдэглэлийг дэвтэртээ бич.
2. Энэ Сүм бол үнэхээр Есүс Христийн Сүм бөгөөд Тэрбээр Өөрийн Сүмийг удирдах бошиглогчийг сонгодог гэдгийг мэдэх нь та нарын хувьд ямар ач холбогдолтойг тайлбарла.

Өрнөд рүү хийсэн аян (1845–1847 он)

Эхэн үеийн анхдагч нараас бид юу сурч болох вэ?



© 1980 Глен С. Холкинсон

Гэгээнтнүүд Наувуг орхин явахаар албадуулав

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли сургасан нь: “Одоо үеэ дээдэлж, ирээдүйгээ харах чадвартай болохын тулд өнгөрснөө дурсан санах нь сайн байдаг. Ирээдүйд тулгарч болох зүйлд бэлтгэхийн тулд өмнөх үеийн хүмүүсийн хүч чадлаас суралцах нь сайн. Энэ дэлхийд хөлс хүүчээ шавхан ажиллаад өчүүхэн багыг олж авсан хүмүүсийн ажил үйлсийг эргэцүүлэн бодох нь бас сайн байдаг. Гэхдээ тэдний мөрөөдөл, сайтар бодож боловсруулсан төлөвлөгөөний үр ашиг агуу бөгөөд энэхүү үр шимийг хүртэгчид нь бид билээ.” (“The Faith of the Pioneers,” Ensign, 1984 оны 7-р сар, 3).

Гэгээнтнүүд Иллинойгоос Их Солт Лейк рүү шилжин нүүсэн түүх бол бүх шашины сэтгэл хөдөлгөм гайхалтай түүхүүдийн нэг билээ. Ерөнхийлөгч Бригам Янгийн удирдсан 15,000 гаруй Гэгээнтнүүд Наувугаас Солт Лейкийн Хөндий рүү шилжин суурьших нүүдэл нь Нэгдсэн Улсын түүхэн дэх хамгийн олноор шилжин нүүсэн түүх юм. Энэ бол мөрдлөг хавчлага, гачигдал бэрхшээл, гай зовлонгийн түүх мөн. Гэвч энэ бас сүнслийн нөлөө, гайхамигууд, чөлөөлөлт, Бурханыг, улс орноо, нөхдөө хайрласан хайрын түүх юм. 1845–1847 оны үед болсон үйл явдлыг судлахдаа, дээрх нөхцөл байдалд чи юу хийх байснаа өөрөөсөө асуу.

Наувуг орхин явахаар бэлтгэсэн нь

1. “Гэгээнтнүүд өрнө зүгт Хадат Уулс руу шилжин нүүж, тэнд амар амгалан аж төрөх тухай Сүмийн удирдагчид бүр 1834 оноос эхлэн ярилцаж байсан ажээ. Он жилүүд өнгөрөх тусам, удирдагчид шилжин суурьших зөв газрыг олж тогтоохын тулд тодорхой нутгуудын талаар судлаачидтай ярилцаж, газрын зураг шинжлэн судалж байв. 1845 оны сүүлч гэхэд, Сүмийн удирдагчид Өрнөд нутгийн талаар хамгийн сүүлийн үеийн мэдээлэлтэй болжээ.

2. “Наувуд мөрдлөг хавчлага гаарахад, Гэгээнтнүүд тэндээс шилжин нүүхээс өөр аргагүй болсон нь илт байв. 1845 оны арваннэгдүгээр сар гэхэд Наувуд бэлтгэл ажил ундарч байв. Гэгээнтнүүдийг шилжин нүүхэд удирдах зуут, тавьт, аравтын ахмадууд дуудагдав. 100 хүнтэй бүлэг бүр нэг буюу түүнээс дээш мухлаг тэрэгний засварын газар бий болгожээ. Тэрэгчин, мужаан, мухлаг хийгчид шөнө орой болтол ажиллаж, гуалин, мод бэлтгэн, тэрэг хийж байв. Төмөр худалдаж авахуулахаар гишүүдийг дорнод руу явуулж, дархчууд аян замд хэрэгтэй эд материал, шинэ Сионд суурьшихад шаардлагатай фермийн багаж хэрэгсэл хийж байлаа. Гэр бүлүүд хүнс, гэр ахуйн хогшлуудыг цуглуулж, чингэлүүдийг хагаасан жимс, гурил, будаа, эмээр дүүргэж байв. Гэгээнтнүүд нэгэн зорилготойгоор хамтран хөдөлмөрлөснөөр тийм богинохон хугацаанд хийх боломжтойгоос илүүтэй асар их ажлыг амжуулжээ” (Бидний Өв, 69).

Уншсанаа ойлгох нь



Наувуг орхин явахаар бэлтгэсэн нь

Хадат Уулс (догол мөр 1)— Хойд Америкийн баруун хэсэг дэх уулс	тэрэгний дугуй хийдэг, зас- даг хүмүүс
Тэрэгчид (догол мөр 2)— Морин буюу үхэр тэрэг,	Эзэмших (догол мөр 2)— Тухайн нутагт суурьшин амьдрах

Өвлийн аяны хүнд сорилтууд

3. “Наувугаас хүмүүсийг нүүлгэн шилжүүлэх ажлыг анх 1846 оны дөрөвдүгээр сард эхлэхээр төлөвлөж байжээ. Гэвч өрнө зүгт шилжихэд нь Гэгээнтнүүдэд саад учруулахаар мужийн цагдаагийн газар заналхийлж байсан учир Арванхоёр Төлөөлөгч болон тэргүүлэх гол иргэд 1846 оны хоёрдугаар сарын 2-нд зөвлөлдөхөөр яаралтай цуглав. Өрнөд рүү нэн даруй хөдлөхөөс өөр аргагүй болсныг тэд зөвшөөрч, нүүлгэн шилжүүлэх ажлыг хоёрдугаар сарын 4-нд эхлэв. Бригам Янгийн удирдлагаар Гэгээнтнүүдийн эхний бүлэг аян замдаа яаралтай гарчээ. Гэвч, яаруу тэвдүү гарсан нь хүнд сорилттой тулгарч эхлэв. Учир нь хавирга нэвтлэм өвлийн хүйтэн, хаврын бороон шамарганаас хамгаалалт болох газарт хүртэл олон километрийг туулж очих байв.

4. “Мөрдөн хавчигсдаасаа аюулгүй байхын тулд мянга мянган Гэгээнтнүүд Айовагийн нутаг руу орохын тулд эхлээд өргөн Миссисипи мөрнийг гатлах хэрэгтэй байв. Нэлээд олон Гэгээнтнүүдийн сууж явсан завийг нэг үхэр тийрч цоолоход, завь живж, аян замынх нь бүр эхэнд аюул заналхийлсэн ажээ. Өдөн гудас, нарийхан мод, гуалин, ер нь барьж болох юм бүхнээс зуурсан хөөрхий аянчид хүйтэн ус, ширүүн давалгаан дээр савлаж явахыг тэдний нэг нь харжээ. . . . Зарим хүмүүс нэг их доошлоогүй мухлаг тэрэгний орой дээр авиран гарсан байхад хаанаас ч юм хэдэн үхэр, сарлаг завин дээр эрэг рүү сэлж байгаа нь харагдаж байв” [Хуанита Брукс, *On the Mormon Frontier: The Diary of Hosea Stout*, боть 2, (1964) 1:114; мөн 1:117-г үз]. Эцэст нь бүх хүмүүсийг завинд суулгаж, нөгөө эрэг дээр гаргажээ .

© 1996 Глен С. Холкинсон



5. “Миссиппийг эхний удаа гаталснаас хойш хоёр долоо хоногийн дараа, мөрөн түр хугацаанд хөлдсөн ажээ. Мөс гулгамтгай байсан ч, мухлаг тэрэг, тэрэг чирсэн үхрийг дааж байсан болохоор, мөрнийг гатлах нь арай амар байлаа. Гэвч Гэгээнтнүүдийг цасан дундуур удаан мацах үед хүйтэн цаг агаар их бэрхшээл учруулж байв. Мөрний нөгөө эрэг дээрх Шугар Грийк дээр буудаллах үед байнгын салхи бараг хорин сантиметр зузаан хунгар үүсгэжээ. Дараа нь хяруу унаж, газар гулгамтгай болсон байв. 2,000 Гэгээнтэн цааш хөдлөх тушаал хүлээх зуур, эргэн тойронд нь, хаа сайгүй байж суухын аргагүй хүйтэн болж, майхан, мухлаг тэргэнд чихцэлдэн, толгой хоргодох оромжуудыг яаравчлан босгож байлаа.

6. “Аяны хамгийн хүнд хэсэг нь Айовагаар дамжин өнгөрсөн энэхүү эхний үе байлаа. Тэд ‘хувцас хунар овоолон, түр зуур толгой хоргодох майхан босгож, хоноглоход бэлтгэдэг байв. Энэ үед эхнэр маань арай ядан явган суудаг байв. Харин бяцхан хүү маань их халуурч, өвчлөн, бүр юу болоод байгааг ч анзаарах сөхөөгүй байлаа’ гэж Хосеа Стаут тэмдэглэжээ [Хуанита Брукс, *On the Mormon Frontier*, 1:117;]. Бусад олон Гэгээнтэн ч мөн ихэд зовж зүдрэн, шаналж байв” (Бидний Өв, 69–70).

Уншсанаа ойлгох нь




Өвлийн аяны хүнд сорилтууд

Мацах (догол мөр 5)—Удаан бөгөөд их хүч гаргаж явах	Яаруу тэвдүү босгох (догол мөр 5)—Түргэн, хам хум барих, босгох
--	---

Бүх юм сайн

7. “Гэгээнтнүүдийн итгэл, эрэлхэг зориг, шийдвэр төгс байдал нь тэднийг хүйтэн, өлсгөлөн, хайртай хүмүүс нь үхэж үрэгдэхийн гашуун зовлонг даван туулуулсан юм. Виллям Клейтон Наувуг орхин явах эхний бүлгүүдийн нэгэнд дуудагдаж, анхны хүүхдээ төрүүлэхэд ердөө ганцхан сар үлдээд байсан эхнэр Диантагаа эцэг эхтэй нь үлдээгээд аян замд гарсан аж. Шавартай замаар мацан, хүйтэн майханд хоноглож явсан нь сэтгэл зүрхийг нь эмзэглүүлж, Диантагийнхаа төлөө санаа нь улам ч зовох болжээ. Бүтэн хоёр сар өнгөрсөн ч эхнэр нь эсэн мэнд амаржсан эсэхийг тэр мэдэхгүй байв. Тэгсээр тэр эцэст нь ‘мантайсан сайхан цагаан хүү’ төрсөн тухай баяртай мэдээ хүлээн авчээ. Бараг л мэдээ хүлээж авсан даруйдаа, зөвхөн түүний хувьд онцгой учир холбогдолтой төдийгүй, сүнслэг

мэдрэмжийн мөн үе үеийн Сүмийн гишүүдийн төлөөх талархлын сүлд дуу болсон нэг дуу бичихээр Виллям шийдсэн гэдэг. Энэ дууг 'Ирцгээ, Ирцгээ, Гэгээнтнүүд ээ' гэдэг. Хэн бүхний мэдэх алдартай бадгууд нь түүний итгэлийг, бас зовлон зүдгүүрийн дунд: 'Бүх зүйл сайн! Бүх зүйл сайн!' хэмээн дуулж явсан мянга мянган Гэгээнтнүүдийн итгэлийг илэрхийлдэг байлаа [Жеймс Б.Аллен, *Trials of Discipleship: The Story of William Clayton, a Mormon* (1987), 202-ыг үз.] Араас нь аян замд гарсан гишүүдийн нэгэн адил тэд Бурханы хаант улс дахь золиослол, дуулгавартай байдлын баяр баясал, амар амгаланг олдог байжээ" (*Бидний Өв*, 71).



"Ирцгээ, ирцгээ, Гэгээнтнүүд ээ" дууллын үгийг Виллям Клейтон бичжээ

Уншанаа ойлгох нь



Бүх зүйл сайн

Мацах (догол мөр 7)—Их хүч гарган удаан явах

Сүлд дуу (догол мөр 7)—
Дуулал буюу магтаал,
талархлын дуу

Винтер Квортерс

8. "Гэгээнтнүүд 1846–1847 оны өвлийг өнгөрүүлж, Хадат Уулс руу хийх аяндаа бэлтгэхийн тулд Наувугаас баруун Айова дахь суурин газруудыг хүртэл 310 бээр (499 км) аялжээ. Энэ туршлага нь Америкийн уудам хээр талыг 1,000 бээр (1609 км) явж, илүү хурдан туулахад тусалсан аяны тухай олон зүйлийг тэдэнд сургажээ. Уудам хээр талыг дараагийн жил нь 111 өдөрт туулсан гэдэг.

9. "Миссури мөрний хоёр талаар Гэгээнтнүүдийн нэлээд олон суурин бий болов. Хамгийн том суурин Винтер Квортерсийн баруун талд, Небраскад байв. Винтер Квортерс ойролцоогоор Сүмийн 3,500 гишүүдийн гэр орон болсон билээ. Хүмүүс модон байшин, цонхтой газар нүхэн гэр амьдарч байв. 2,500 орчим Гэгээнтэн Миссури мөрний Айовагийн тал дээр Канесвилл гэдэг газрын орчимд амьдарч байлаа. Тэдгээр суурингуудад амьдрах нь бэрхшээл хүндрэл ихтэй байв. Зунд нь хүмүүс чичирдэг халуунаар өвчилнө. Өвөл болоход шинэ хоол хүнс олддоггүйгээс

хүмүүс булчин задрах гоц халдварт тахал, чийг бам, шүдний өвчин, шөнө нойр хүрэхгүй байх, суулгах зэрэг өвчинд нэрвэгддэг байжээ. Хэдэн зуун хүн нас барсан байна.

10. "Гэвч амьдрал өрнөсөөр байлаа. Нөхөр Самуел нь Шотландад номлолд байсан Мэри Ричардсын өгүүлснээр эмгэтэйчүүд угааж цэвэрлэн, юм индүүдэж, оёж нэхэн, захидал бичиж, хомс тарчиг хэдхэн зүйлээрээ хоол унд бэлтгэж, гэр бүлдээ анхаарал халамж тавин, борви бохисхийлгүй ажиллаж, өдрийг өнгөрүүлдэг байв. Гэгээнтнүүд Винтер Квортерст ирж, тэндээс явж байгааг, тухайлбал шашны сэдвээрх ярилцлага, бүжиг, Сүмийн цуглаан, үдэшлэг, зэлүүд нутаг дахь шашны сэргэн мандалт зэрэг үйл явдлуудыг тэрээр нэгд нэгэнгүй, хичээнгүйгээр тэмдэглэдэг байжээ.



Винтер Квортерс, Небраска

11. "Эрчүүд хамтран ажиллаж, аяны төлөвлөгөөний тухай, Гэгээнтнүүдийг ирээдүйд суурьшуулах газрын талаар олонтаа ярилцдаг байжээ. Тэд буудалласан газрынхаа дэргэдэх тал нутагт малаа бэлчээн хариулахад байнга хамтран ажилладаг байв. Эрчүүд тариан талбай дээр хамтран ажиллаж, суурингийн эргэн тойронд харуулд гарч, гурилын тээрэм байгуулан ажиллуулж, мухлаг тэрэгнүүдийг аян замд бэлтгэж, туйлдаж ядран өвчин эмгэгт олонтаа нэрвэгддэг байлаа. Тэд тариалангийн талбайг бэлтгэн тариалж, араасаа ирж яваа Гэгээнтнүүд ургацыг хурааж авахаар бодож, хайрын үндсэн дээр амь биеэ эс хайхран хөдөлмөрлөж байлаа. Энэ бүх ажил тэдний шаргуу ажлын зөвхөн нэг хэсэг нь байсан юм.

12. "[Лорензо] Янгийн хүү Жон Винтер Квортерсыг 'Мормончуудын хувьд Форжийн Хөндий' байлаа хэмээн нэрлэсэн ажээ. Тэрээр оршуулгын газрын ойролцоо амьдарч байсан аж. Гашуудлын бяцхан галт тэрэг шиг харагддаг байсан оршуулгын цуваа манай хаалганы дэргэдүүр олонтаа өнгөрдөг байлаа. Тэр бүлийнх нь хоол хүнс нь эрдэнэ шишийн талх, гахайн утсан мах, балга сүү л байв. Хоол унд нь хэчнээн тарчиг, нэг янз байсныг тэрээр санадаг ажээ. Бантан, гахайн утсан мах идсээр байгаад бүр залхсан аж. Ийм хоол идэх нь эм уухтай адил хоолой давдаггүй болж билээ" гэж тэр ярьжээ. [Рассел Р.Рич, *Ensign to the Nations* (1972), 92-ыг үз.] Зөвхөн Гэгээнтнүүдийн итгэл, нэгэн үзүүрт сэтгэл тэднийг энэхүү хүнд хэцүү цаг үеийн дундуур туулан гаргасан юм" (*Бидний Өв*, 71–72).

Уншанаа ойлгох нь



Винтер Квортерс

Газар нүхэн гэр (догол мөр 9)—Толгойн бэлд газар ухах хийсэн оромж, нүхэн гэрийг модны мөчир, хуурай шавраар дээвэрлэдэг байжээ

Гоц халдварт өвчин (догол мөр 9)—Маш хурдан халдварлан тархдаг өвчин

Чийг бам (догол мөр 9)—С витамин дутагдсанаас үүдэлтэй өвчин

Шашны сэргэн мандалт (догол мөр 10)—Шашны сонирхол сэргэн шинэчлэгдсэн үе

“Мормончуудын хувьд Форжийн Хөндий” (догол мөр 12)—Олон мормончууд зовж зүдрэн, нас барсан газар, Хувьсгалын Дайны үед Нэгдсэн Улсын цэргүүд Форжийн Хөндийд амь үрэгдсэнтэй адилтган зүйрлэжээ

Мормоны Суман

13. “Тэгээнтнүүдийг Айовад байхад, 1846 оны тавдугаар сард эхэлсэн Мексикийн дайнд алба хаах готдорхой тооны эрчүүд гаргахыг Нэгдсэн Улсын армийн удирдагчид Сүмийн удирдагчдаас хүссэн ажээ. Мормоны Суман хэмээн нэрлэгдсэн эрчүүд улс орны өмнөд хэсгийг Калифорнигаар гатлан хэрийн аян хийж, цалин, хувцас, оногдол хүнс хүлээн авах ёстой байв. Наувугаас ядуучуудыг нүүлгэн авчрахын тулд, бас цэргийн гэр бүлд туслах нэг арга зам болгон суман бүрдүүлэхэд оролцоход нь Бригам Янг эрчүүдийг урамшуулан дэмжив. Энэхүү хүч чармайлтад засгийн газартай хамтран ажиллах нь Сүмийн гишүүд улс орондоо үнэнч байдгийг харуулахын хамт улсын болон индианчуудын газар нутаг дээр түр хугацаагаар буудаллахыг зөвтгөх шалтгаан болсон аж. Ийнхүү, 541 хүн удирдагчдынхаа зөвлөгөөг хүлээн авч, Суманд элсэв. Тэднийг 33 эмэгтэй, 42 хүүхэд дагалдан явжээ.

14. “Дайнд явах хүнд хүчир сорилт дээр Сумангийн гишүүд хүнд хэцүү цагт эхнэр хүүхдээ орхин явж байгаа сэтгэл санааны гуниглал нэмэгджээ. Виллям Хайд энэ талаар дурсахдаа:

15. “Шийдвэрлэх ийм цаг үед гэр бүлээ орхин явж байсан нь санаа сэтгэлийн хувьд өгүүлэхийн аргагүй хэцүү байв. Тэд унасан газар, угаасан уснаасаа алс хол, мухлаг тэрэгнээс өөр толгой хоргодох оромжгүй, халуун нар хайр найргүй шарсан ээрэм талд торойтлоо үлдсэн дээ. Арванхоёрдугаар сарын хүйтэн жихүүн салхи тэднийг энэхүү айдас төрөм зэлүүд талд мөн л угтах болно.

16. “Би эхнэр, бага насны хоёр хүүхэдтэй гэр бүлээ настай аав, ээж хоёр, эрэгтэй дүүтэйгээ хамт үлдээгээд гарсан. Сумангийнхны ихэнх нь гэр бүлээ орхиод явсан. . . . Хэзээ бид тэдэнтэйгээ дахин уулзахыг зөвхөн Бурхан л мэдэх хэрэг. Гэсэн ч бид гомдоллон дургүйцдаггүй байлаа’ гэжээ [in *Readings in LDS Church History: From Original Manuscripts*, хянан тохиолдуулсан Виллям И.Бернетт, Алма П.Бартон, боть 3, (1965), 2:221].



17. “Суман 2,030 бээр (3267 км) газар баруун өмнөд зүгт Калифорни руу хоол хүнс, ус, амралт, эм хэрэгслээр дутагдан, хээрийн хурдавчилсан аян хийжээ. Суман Сан Диего, Сан Люис Рей, Лос Анжелест эзлэгдсэн нутгийг хамгаалах үүрэг гүйцэтгэсэн аж. Нэг жилийн дайчилгааны эцэст тэд халагдаж, гэр орондоо эргэж ирэх боломжтой болсон билээ. Тэдний хүч чармайлт, Нэгдсэн Улсын засгийн газарт үнэнч байсан нь удирдлагад нь нэр хүндийг авчирсан юм.

18. “Халагдсаны дараа Сумангийн гишүүдээс олон нь түр хугацаагаар ажил эрхлэхээр Калифорнид үлдэв. Тэднээс нэлээд олон нь хойд зүгт Америк гол руу очиж, Жон Саттерын хөрөө рамд, мөн 1848 онд тэнд алт олдоход нэрд гарсан California Gold Rush уурхайд ажилд орсон ажээ. Гэвч Хожмын Үеийн Гэгээнтэн ах нар азтай энэ завшааныг ашиглахын тулд Калифорнид үлдээгүй юм. Тэдний зүрх сэтгэл Америкийн хээр талыг туулж, өрнөдийг чиглэн Хадат Уулс руу тэмцэн тэмүүлж явсан ах эгч нартайгаа хамт байлаа. Тэдний нэг Жеймс С.Браун тайлбарласан нь:

19. “Ийм баян нутгийг би тэр цагаас хойш огт үзээгүй. Бас үүндээ ч харамсдаггүй. Учир нь алтнаас илүү өндөр зорилго надад ямагт байсан. . . . Биднийг явцуу ашиг сонирхолдоо харалган болсон хүмүүс гэж зарим хүмүүс боддог байсан байж болох юм. Бид хэдийгээр тэр нутагт мөнгөтэй болсон ч, тэнд үлдэхийг өдөөсөн олон шалтгаан байсан ч, дөч гаруй жилийн дараа эргэж хараад, харамсдаггүй.” Энд хөрсөн дор алт байдаг, толгодод, голын сайранд алт байдаг, ер нь газар сайгүй л алт байна. . . . Удалгүй та бие даагаад мөнгө хийж болно шүү дээ” гэж хүмүүс хэлдэг байсан. Энэ бүгдийг бид мэддэг байлаа. Үүрэг маань биднийг дууддаг байсан. Нэр төр маань гадсандаа байлаа. Бид бие биетэйгээ гэрээнд орсон байв. Бидний хувьд Бурхан, Түүний хаант улс нэгдүгээрт байдаг нэгэн чухал зарчим байсан юм. Аглаг буйдалд, тийм ээ, хүн суурьшаагүй зэлүүд нутагт бидний найз нөхөд, садан төрлүүд байсан шүү дээ. Хэн тэдний байдлыг мэдэж байсан бол? Бид л лав үгүй дэг. Иймээс баяр жаргалаас түрүүнд, эд баялгаас түрүүнд үүрэг гэж бидэнд байлаа. Биднийг чухамдаа энэхүү өдөөлт л хөдөлгөж байсан юм’ [Жеймс С.Браун, *Giant of the Lord: Life of a Pioneer* (1960), 120]. Бурханы хаант улс энэ дэлхийн ямар ч материаллаг зүйлстэй харьцуулашгүй илүү үнэ цэнэтэйг тэдгээр ах нар хэнээс ч илүү мэддэг байснаас явах замаа энэ дагуу сонгосон юм.” (Бидний Өв, 72–74).

Уншсанаа ойлгох нь

Мормоны Суман

Суман (дэд гарчиг)—
Цэргийн томоохон бүлэг

Бруклины Гэгээнтнүүд

20. “Олонх Гэгээнтнүүд Наувугаас Хадат Уулс руу хуурай газраар явсан бол, Нэгдсэн Улсын дорнод хэсгээс Гэгээнтнүүдийн нэг бүлэг далайгаар замд гарсан юм. 1846 оны хоёрдугаар сарын 4-нд, 70 эрэгтэй, 68 эмэгтэй, 100 хүүхэд Бруклин хөлөг онгоцонд сууж, Нью-Йорк боомтоос Калифорнийн



эрэг хүртэл 17,000 бээр (27, 358 км) аялжээ. Аяллын үед хоёр хүүхэд төрсөнд Атлант (Атлантик), Номхон Далай (Пасифик) гэсэн нэр өгч, бас 12 хүн нас барсан ажээ.

21. “Аяны зургаан сар маш хүнд байв. Зорчигчид халуун бүсийн аагим халуунд шахцалдан, зөвхөн ус, хомс тарчиг хоол хүнстэйгээр аяны замаа туулжээ. Кейп Хорныг тойрсны дараа тэд тав хоног амрахын тулд Хуан Фернандез арал дээр зогсов. ‘Хуурай газрыг харж, газар дээр дахин нэгэнтэй хөл тавьсан нь хөлөг онгоцон дээрх амьдралаас амсхийлт болсон юм. Бид энэхүү амсхийлтэд магнай тэнийн баярлаж билээ’ гэж Каролин Аугуста Перкинс дурсчээ. Хүмүүс усанд ээлж, цэнгэг усанд хувцсаа угаан, жимс, зэрлэг төмс түүж, загас, могой загас барин, ‘Робинзон Крузогийн агуйг’ сонирхон, арлын орчноор хэрэн хэсч явлаа [Каролин Аугуста Перкинс, “Бруклин Хөлгийн Гэгээнтнүүд,” *Our Pioneer Heritage* (1960)-эш татжээ, 506].

22. “Хүчтэй шуургатай учирч, хомс тарчиг хоол хүнстэйгээр, далайгаар урт удаан хөвсний эцэст 1846 оны долдугаар сарын 31-нд тэд Сан Францискод иржээ. Зарим хүмүүс энд үлдэж, Нью Хоуп (Шинэ Найдвар) хэмээх эзэмшил газрыг үндэслэн байгуулсан бол бусад нь Усны Их Сав газар дахь Гэгээнтнүүдтэй нэгдэхийн тулд зүүн зүгт уулсын зүг цааш хөдөлсөн аж (Бидний Өв, 74–75).

Уншсанаа ойлгох нь



Бруклины Гэгээнтнүүд

Халуун бүс (догол мөр 21)—Дэлхийн бөмбөрцгийн экваторт ойрхон оршдог газрууд

Усны Их Сав газар (догол мөр 22)—Ютагийн ихэнх хэсэг, Невадагаас бүрддэг газарзүйн бүс

Цугларалт үргэлжилсэн нь

23. “Америкийн бүх хэсгээс, түүнчлэн олон улс орноос итгэлтэй хөрвөгчид Гэгээнтнүүдтэй нэгдэхийн тулд гэр орон, унасан газар, угаасан усаа орхин янз бүрийн унаа хөсгөөр, мориор, явганаар Хадат Уулсыг чиглэн урт удаан аяныг эхэлсэн билээ.

24. “1847 оны нэгдүгээр сард, Ерөнхийлөгч Бригам Янг сүнсээр нөлөөлөгдсөн Израилын Хуарангийн талаарх Их Эзэний үг болон хүсэл тааллыг” (С ба Г 136:1) гаргасан нь, өрнөд рүү хийсэн анхдагч нарын шилжилтийг удирдах үндсэн хууль болсон билээ. Бүлгүүд болон зохион байгуулагдаж, өөрсдийнхөө дундах бэлэвсэн эмэгтэйчүүд, эцэггүй хүүхдүүдэд анхаарал халамж тавих үүрэг хүлээсэн ажээ. Бусад хүмүүстэй харилцах харилцаа нь хилэнц, атгаг санаа, зөрчил сөргөлдөөнгүй байх ёстой байв. Хүмүүс аз жаргалтай байж, хөгжим, залбирал, бүжигт сонирхол, талархалтай байх ёстой байлаа. Их Эзэн Ерөнхийлөгч Янгаар дамжуулан, ‘Замаараа явж мөн та нарт миний хэлсэнчлэнгээр хийгтүн, дайснуудаасаа бүү ай’ (С ба Г 136:17) хэмээн Гэгээнтнүүдэд хэлжээ.

25. “Винтер Квортерсыг орхин явахаар анхдагч нарын эхний бүлэг бэлтгэж байх үед, Парли П.Пратт Англи дахь номлолоосоо эргэн ирж, Жон Тейлор Английн Гэгээнтнүүдийн бэлгийг араас нь авчирч явааг илтгэжээ. Аялагчдад туслахын тулд Английн гишүүдийн хайр, итгэлийн нотолгоо болсон, тэдний илгээсэн аравны нэгийн мөнгийг маргааш нь Тейлор ах авчрав. Анхдагч нарын аяны зургийг гаргаж, орчны газрыг тандахад туслах үнэлж баршгүй чухал шинжилгээний багаж хэрэгслийг тэр бас авчирчээ. 1847 оны дөрөвдүгээр сарын 15-нд Бригам Янгийн удирдсан анхны бүлэг замд гарав. Дараагийн хорь хоногт ойролцоогоор 62,000 Гэгээнтэн Сионд цуглахын тулд хээр талыг туулан мухлаг тэрэг, гар тэргээр тэдний араас хөдөлсөн ажээ.

26. “Эдгээр аянчдыг гайхалтай үзэсгэлэнт газар, мөн хүнд бэрхшээл аян замд нь хүлээж байжээ. Жозеф Моенор Солт Лейкийн Хөндий хүрэхэд тохиолдсон ‘хүнд бэрх цагийн’ тухай дурссан байдаг. Гэвч тэр бас өмнө нь хэзээ ч үзээгүй зүйлүүд эерлэг үхрийн үй олон сүрэг, толгод дээрх аварга том хуш моддыг харжээ. [Utah Semi-Centennial Commission, *The Book of the Pioneers* (1897), 2 боть, 2:54; in LDS Church Archives.] Тэнгэрийн одноос ч олон наран цэцэг ургасныг бусад хүмүүс харсан байв.

27. “Гэгээнтнүүд бас бие махбодынх нь хэрэгцээг хөнгөвчилсөн, итгэлийг нь хөхүүлэн дэмжигч туршлагатай болсон ажээ. Аяны урт өдрийн дараа задгай гал дээр хоол хийж, эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд тэр өдрийн үйл ажиллагаануудыг хэсэг бүлэг болон ярилцдаг байлаа. Тэд сайн мэдээний зарчмуудын тухай ярилцаж, дуу дуулан, бүжиглэж, хамтдаа залбирдаг байв.



28. “Гэгээнтнүүд өрнөд зүг алгуурхан урагшлах үед үхэл хагачал тэдэнд үе үе тохиолддог байлаа. 1850 оны зургадугаар 23-нд Грандалынхан арван таван хүнтэй байлаа. Тэр долоо хоногийн эцэс гэхэд аймшигт булчин задрах тахлаар долоон хүн нь нас барсан байв. Дараагийн тав хоногт энэ гэр бүлийн таван хүн дахиад нас барав. Дараа нь зургадугаар сарын 30-нд Грандал эгч төрөх үедээ төрүүлсэн хүүхэдтэйгээ хамт нас барсан ажээ.

29. “Хэдийгээр Гэгээнтнүүд Солт Лейкийн Хөндий рүү хийсэн аяндаа түмэн зовлон, мянган гачаалыг амссан ч, эв нэгдлийн сүнс, хамтын ажиллагаа, өөдрөг үзэл давамгайлж байлаа. Тэд итгэлээрээ бас Их Эзэнд хандах хоёргүй сэтгэлээрээ нягт холбогдож, хүнд сорилтын үед баяр баяслыг олдог байжээ” (Бидний Өв, 75–76).

Уншсанаа ойлгох нь



Цугларалт үргэлжилсэн нь

Үндсэн хууль (догол мөр 24)—Бичмэл хууль

- Атгаг санаа (догол мөр 24)—Амин хувиа хичээх үзэл, шунал, муу санаа

Энэ бол зөв газар байна

30. “1847 оны долдугаар сарын 21-нд, Оорсон Прагт, Эраст Снөү нар Солт Лейкийн Хөндийд анхдагч нарын эхний бүлгийн хамт анх очжээ. Тэд өндөр маш шигүү өтгөн ургасан өвстэй, фермийн аж ахуй эрхлэхэд нэн таатай байхаар тал газар, хөндий дундуур мушгиран урсах хэдэн горхийг харжээ. Гурван өдрийн дараа, уулын чичиргээ халуунаар өвчилсөн Ерөнхийлөгч Бригам Янгийг сүйх тэргэн дотор нь, хөндий ил харагдах нэг хавцлын аманд авчирчээ. Ерөнхийлөгч Янг орчны газрыг тойруулан хараад: ‘За боллоо. Энэ бол зөв газар байна’ гэж зорьж ирсэн нутгийнхаа талаар аялагчдад хандан бошиглолын үгээ хэлжээ.



© 1987 Глен С. Холкинсон

“Энэ бол зөв газар байна”

31. “Араас нь дагаж явсан Гэгээнтнүүд ч бас уулсын дундаас гарч ирээд амлагдсан нутгаа нүд бэлчээн харжээ! Баруун зүгт наранд гялбан харагдах давст нууртай энэ хөндий бол зөгнөл, бошиглолын нутаг, тэдний хувьд бас араас нь ирж яваа мянга мянган хүмүүсийн хувьд мөрөөдлийн нутаг байлаа. Энэ бол тэдний аж төрөн суух газар, Хадат Уулсын дунд тэд хүчирхэг хүмүүс болох учиртай нутаг байв.

32. “Хэдэн жилийн дараа, Английн хөрвөгч, Жийн Рио Гриффитс Бейкер Солт Лейк хотыг анх үзсэн тухай сэтгэгдлээ тэмдэглэн үлдээжээ. ‘Тэд хотыг . . . хороолол хэмээн нэрлэсэн тэгш өнцөгтүүдэд хуваан барьжээ. Тэгш өнцөгт бүр нь арван акр (4га)-аас бүтэж, найман хэсэгт хуваагдана. Хэсэг бүрд нэг байшин байна. Би зогсоод харлаа, харж мэдэрсэн зүйлсээ арайхийн цэгцлэн дүгнэлээ. Миний дотор сэтгэлд давамгайлагч мэдрэмж нь баяр баясал, бас урт удаан, аюул ослоор дүүрэн аяны маань үед намайг хамгаалж байсны төлөөх талархал гэж би бодном’ [“Жийн Рио Гриффитс Бейкерийн Өдрийн Тэмдэглэл,” 1851 оны есдүгээр сарын 29; ХҮГ Сүмийн Архив]” (Бидний Өв, 76–77).

Уншсанаа ойлгох нь



Энэ бол зөв газар байна

Мормоны Анхдагч нарын замаар өнөө үед хүн явж чадах уу?

Мормончуудын аяны замын ихэнхээр нь өнөө үед даган аялж болно. Мөн сонирхсон аялагчдад туслах газрын зурагтай удирдамжууд байдаг. Аяллын зарим эд хогшил Сүмд байдаг. Бас замаа олоход нь аялагчдад туслах зочдын төвүүд баригдсан байгаа. Гэвч, аяллын замын олонх нь мужийн болон орон нутгийн төр засгийн газрын байгууллагуудад харьяалагддаг. Тэдний зарим нь л газар дээгүүрээ аялахыг зөвшөөрдөг. Уг замаар аялагчид орон нутгийн төр засгийн хуулиудыг дагаж, өмчийн эздийн эрхийг хүндэтгэх ёстой.

Уншсанаа судлах нь



“Өрнөд рүү хийсэн аян” (1845–1847)-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Өөрийгөө түүхэнд оруулан бич

Уншсан мэдээлэл болон түүхүүдээ ашиглан, Наувугаас Солт Лейкийн Хөндий рүү аян хийсэн хүмүүсийн дунд өөрийгөө байсан гэж төсөөлөн, амьдралынхаа тухай товч түүх бич. Товч түүхэнд чинь Наувугаас явсан, Айоваг гаталсан, Винтер Квоттерс дахь амьдрал, хээр талыг туулсан болон Их Солт Лейкийн Хөндийд ирсэн тухай орж болох юм. Аян замд өөрт чинь, мөн гэр бүлд чинь тохиолдсон туршлагуудын тухай, уулзсан хүмүүс, үзсэн газруудынхаа тухай бич.

Б Тэр үеийнхээс одоо илүү амархан уу?

1. “Өрнөд рүү хийсэн аяны (1845–1847)” унших материалд дурдагддаг он сар өдрийг дарааллаар нь жагсаан бич. Он сар өдөр бүрийн дэргэд тэр үед юу болсныг жагсаан бич.
2. Өнөөдөр сайн мэдээгээр амьдрах нь 1840 онд байснаас илүү амар гэж чи боддог уу? Яагаад тийм гэдгийг, эсвэл яагаад тийм биш болохыг тайлбарласан богинохон догол мөр бич.

В Замуудыг харьцуул

1. Хойд, Өмнөд Америкийн энгийн газрын зургийг тэмдэглэлийн дэвтэртээ зур. Уншсан зүйл дэх мэдээлэл болон судруудынхаа хавсралт дахь газрын зургуудыг ашиглан, Гэгээнтнүүдийн үндсэн хэсэг, Мормоны Суман болон

Бруклин далайн хөлгөөр Гэгээнтнүүдийн явж өнгөрсөн замыг газрын зураг дээрээ зур.

2. Хэрэв чи тэр үед амьдарч байсан бол Гэгээнтнүүдийн энэ гурван бүлгийн алинтай нь хамт аялахыг хүсэх вэ? Яагаад гэдгийг тайлбарла.

Сургаал ба Гэрээ 136

“Бүх хүмүүс ... бүлгүүдэд зохион байгуулагдаг”

Наувугаас явснаас хойш бараг нэг жилийн дараа, 1847 оны нэгдүгээр сарын 11-нд Ерөнхийлөгч Бригам Янг: “Өнгөрсөн шөнө би Бошиглогч Иосефтай уулзаж, түүнтэй ярилцаж байна гэж зүүдэлснээ ах нарт яриу. . . Шилжин суурьшихад бүлгүүдийг зохион байгуулах хамгийн шилдэг арга хэлбэрийн тухай гэхчлэн, чөлөөтэй ярилцаж байх юм” хэмээн бичжээ (Manuscript History of Brigham Young, 1846–1847, эмхтгэсэн Элден Ж.Вотсан, [1971], 501–502). Гурав хоногийн дараа, Ерөнхийлөгч Янг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын долоон гишүүнтэй хамт Небраскийн Винтер Квоттерст Ахлагч Хебер К.Кимбаллын гэрт цуглаж, аглаг буйд руу хийх аян замдаа бэлтгэх тухай ярилцжээ. Тэр үдэш, Ерөнхийлөгч Бригам Янг “Их Эзэний Үг ба Хүсэл”-ийг илчлэлтээр хүлээн авч, Гэгээнтнүүдэд зарлан мэдэгдсэн ажээ.

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 136

Сургаал ба Гэрээ 136:34–36—“Та нарыг хөөсөн үндэстэн”

1861–1865 онд Нэгдсэн Улсын Иргэний дайн хойд мужууд, өмнөд мужуудын хооронд болсон билээ. Эл дайн үндсэндээ мужуудын эрх болон боолчлолын асуудлаас болж дэгдсэн юм (С ба Г 87:1–7; 130:12–13-ыг үз). Тус улсад болсон бусад бүх дайнд алагдсан хүмүүсийг нийлүүлснээс илүү олон хүн энэ дайнд алагдсан ажээ. Дайн дэгдсэнээс хойш бараг нэг жилийн дараа, Өрнөдөд шилжин ирсэн нь Гэгээнтнүүдийн хувьд маш сайн болсон тухай Ерөнхийлөгч Бригам Янг хэлэхдээ: “Хэрэв биднийг мөрдөн хавчаагүй бол, эдүгээ бид энд нам гүмхэн, алс холын уулс, хөндийнүүдэд, амар жимэр гэр орондоо аятай тухтай аж төрөхийн оронд улс орныг үгүйрүүлэгч дайн, цус урсгалтын дунд байх байсан. . . Бурханы адислалууд бидний эдүгээгийн аюулгүй байдалд байгааг би ойлгож байна. Биднийг устгахыг хүсч байсан дайснууд маань даруусгагдсанаар бид агуу ихээр адислагдаж, агуу ихээр ивээгдэн, агуу ихээр өргөмжлөгдлөө” гэжээ (in *Journal of Discourses*, 10:38–39).

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 136-р хэсгийг судлахдаа үйл ажиллагаа А, мөн Б эсвэл В-г хий.

А Гэр бүлийн дүрмийн жагсаалт хий

Танай гэр бүл анхдагч нартай хамт аялж байсан гэж бод. Сургаал ба Гэрээ 136:1–32 дахь заавруудаас, аян замд гарахын тулд гэр бүлдээ зөвлөмж болгох арван дүрмийг жагсааж бич. Дүрэм бүрийн дэргэд холбогдох шүлгийг хаанаас үзэж болохыг зааж бич.

Б Схем зур

С ба Г 136:3, 12–15-ыг уншиж, Гэгээнтнүүд өрнөд рүү аян замд гарахад өөрсдийгөө хэрхэн зохион байгуулсныг харуулсан схем зур.

В “Та нарыг хөөсөн үндэстэн”


Бошиглогч Иосеф Смит яагаад алагдсаныг, мөн түүний үхэл болон Гэгээнтнүүдийг мөрдөн хавчиж байсны улмаас Америкийн Нэгдсэн Улсад юу тохиолдсоныг тайлбарласан Сургаал ба Гэрээ 136:33–42-оос наад тал нь таван сургаалыг олж, бич.

Бригам Янг Бурханы хаант улсад зориулж хоргодох газар барих нь

Анхдагч нар Солт Лейкийн Хөндийд анх ирэхэд энэ нутаг хүн суурьшаагүй, нэн алслагдсан бөглүү, өргөн уудам нутаг байлаа. Дорнодод тэдний орхисон усалгаа сайтай фермүүдтэй харьцуулахад энэ нутаг чухамдаа эзгүй зэлүүд газар байв. Энд суурьших нь итгэл, хүч чармайлт шаардах байв. Гэвч амжилт олоход нь Бурхан тусална гэдэгт Гэгээнтнүүд итгэлтэй байжээ. 1847 оны эцэс гэхэд хоёр мянга гаруй Гэгээнтэн Солт Лейкийн Хөндийд ирээд байлаа. Бас арванхоёр мянга орчим хүн Небраскийн Винтер Квоттерс, Айова дахь бусад суурин газруудаас тэдэнтэй нэгдэхийн тулд замд гарахаар хүлээж байв. Хожмын Үеийн Гэгээнтнүүд Ерөнхийлөгч Бригам Янгийн сүнсээр нөлөөлөгдсөн удирдлагаар Хадат Уулсад үргэлжлэн цуглаж, зэлүүд газрыг эзэмшин, бат найдвартай суурин газруудыг байгуулж, Есүс Христийн сайн мэдээг дэлхийн олон үндэстэнд зоримгоор хүргэж байлаа.

ТҮҮНИЙ АМЬДРАЛ (1801–1877)

- 1801 он** Вермонтын Вайтингхамд 6-р сарын 1-нд Жон Хаув Янг, Абигейл Хаув Янг нарын гэр бүлд төржээ
- 1824 он** 23 настайдаа, аравдугаар сарын 8-нд Мириам Вөркстэй гэрлэв. Мириам Вөркс 1832 онд нас баржээ
- 1832 он** 30 настайдаа, Нью-Йоркийн Мендоны ойролцоох тээрмийнхээ цөөрөмд дөрөвдүгээр сарын 14-нд баптисм хүртэв.
- 1832–1833 он** 31–32 настайдаа, Канадад номлолд үйлчилж, хөрвөгчдийн багахан бүлгийг Огайогийн Көртландад дагуулж иржээ
- 1834 он** 32 настайдаа, хоёрдугаар сарын 18-нд Мэри Анн Анжелатай гэрлэв. Тэр 1882 онд нас баржээ
- 1835 он** 33 настайдаа, хоёрдугаар сарын 14-нд Мормоны Номын Гурван Гэрч-Оливер Каудери, Давид Витмер, Мартин Харрис нараар Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын анхны нэг гишүүнээр томилогдов
- 1839–1841 он** 38–40 настайдаа, Их Британид номлолд үйлчлэв
- 1840 он** 38 настайдаа, дөрөвдүгээр сарын 14-нд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав
- 1844 он** 43 настайдаа, Бошиглогч Иосеф Смит зургадугаар сарын 27-нд наснаас хальсны дараа Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч байсан учир Сүмийн удирдагч болов
- 1846–1847 он** 44–46 настайдаа, Өрнө зүгт Солт Лейкийн Хөндий рүү шилжин суурьших ажлыг удирдаж, дараа нь Небраскийн Винтер Квортерст эргэж ирэв
- 1850–1858 он** 49–57 настайдаа, Ютагийн анхны захирагчаар үйлчилжээ
- 1853 он** 51 настайдаа, Солт Лейкийн Ариун сүмийн суурийн чулууг тавив
- 1877 он** 76 насандаа, Сүмийг гуч гаруй жил тэргүүлсний дараа наймдугаар сарын 29-нд Солт Лейк хотод таалал төгсөв



ТҮҮНИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ (1844–1877)

- 1846–1847 он** Гэгээнтнүүдийг Иллинойн Наувугаас шилжин суурьших ажлыг удирдав
- 1849 он** Ням Гарагийн Сургууль зохион байгуулагдав
- 1850 он** Номлогчдыг Скандинав, Франц, Итали, Швейцарь, Хавай руу илгээв

- 1851 он** Сүмийн гишүүд Нэгдсэн Улсын баруун хэсэг, Канад, Мексикийн нутагт 350 гаруй суурин газарт суурьшиж эхлэв. Мормоны Ном анх удаа дани хэлэнд орчуулагдав.
- 1853 он** Солт Лейкийн Ариун сүмийн барилга эхлэв
- 1867 он** Солт Лейкийн Табернекл дуусав. Сүмийн чуулган энд болжээ
- 1869 он** Залуу эмэгтэйчүүдийн байгууллага үйл ажиллагаагаа эхлэв
- 1875 он** Залуу эрэгтэйчүүдийн байгууллага үйл ажиллагаагаа эхлэв
- 1877 он** Сейнт Жоржийн Ариун сүм онцгойлон адислагдав

Гэгээнтнүүдийг Ютад суурьшуулсан нь

1. “Ерөнхийлөгч Бригам Янг Гэгээнтнүүдийн эхний бүлгийг хээр талыг туулан Ютад амжилттай авчирсны дараа, Бурханы хаант улсыг эзлүүд нутагт үндэслэн байгуулахад анхаарлаа хандуулах болжээ. Түүний зөн билиг, удирдлагаар, нэгэн цагт эзгүй эзлүүд байсан нутаг цэцэглэн хөгжсөн соёл иргэншлийн нутаг, Гэгээнтнүүдийн оршин суух өлгий нутаг болсон юм. Түүний энгийн ойлгомжтой удирдлага шинэ өлгий нутгийнхаа боломжуудыг төсөөлөхөд Гэгээнтнүүдэд тусалж, Бурханы хаант улсыг үндэслэн байгуулах эрэлд нь тэднийг хөтөлсөн юм.



2. “Эхний бүлэг ирснээс хойш хоёр өдрийн дараа Бригам Янг болон Арванхоёроос нэлээд хэдэн хүн, Наувугаас гарахын өмнө Ерөнхийлөгч Янг үзэгдэлд харсан уулын бэл дэх дугуй цохио хадан дээр гарчээ. Тэд өргөн цэлгэр хөндийг харж, дэлхийн бүх үндэстнүүд энэ газарт морилон ирж, энд Гэгээнтнүүд цэцэглэл хөгжилт, амар амгаланг эдлэх болно гэдгийг бошигложээ. Исаиагийн нэг сударт, “Тэр үндэстнүүдийн төлөө тугийг өргөн, Израилын цөлөгдсөн хүмүүсийг цуглуулах болно” (Исаиа 11:12) гэж амлагдсаны дагуу тэд энэ толгойг Ensign Peak (Тугийн Оргил) хэмээн нэрлэсэн ажээ [Journal of Discourses, 13:85–86-г үз].

3. “1847 оны долдугаар сарын 28-нд Ерөнхийлөгч Янгийн олон нийтийн өмнөх анхны үйл ажиллагаа нь ариун сүмийн газрыг сонгож, зураг төсөл зохиох, барилгын ажлыг төлөвлөх ажилд хүмүүсийг оруулсан явдал байлаа. Тэрээр сонгосон газар дээр таягаа тавьж, “Бид Бурхандаа зориулж энд ариун сүм барина” гэж хэлжээ. Ингэж хэлсэн нь Наувуг орхин явахгаар албадуулан ариун сүмийн шүтлэг бишрэлээ орхиод удаагүй байсан Гэгээнтнүүдийг тайвшруулжээ.

4. “Наймдугаар сард, Сүмийн удирдагчид болон анхдагч нарын анхны бүлгийн ихэнх нь дараагийн жил энэ хөндийд ирэхэд нь гэрийнхнээ бэлтгэхийн тулд Винтер Квоттерст эргэж ирэв. Тэднийг ирсний дараа удалгүй Тэргүүн Зөвлөлийг өөрчлөн зохион байгуулах цаг болсныг Бригам Янг болон Арванхоёрын Чуулга мэдэрчээ. Бригам Янг Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч байсан учраас Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдэв. Тэрээр Хебер К.Кимбалл, Виллард Ричардс хоёрыг тэрээр зөвлөхөөрөө сонгожээ. Гэгээнтнүүд энэ хоёрыг удирдагчаараа санал нэгтгэй дэмжин баталсан юм” (*Бидний Өв*, 81–82).



Хебер К.Кимбалл



Бригам Янг



Виллард Ричардс

Солт Лейкийн Хөндий дэх анхны жил

5. “1847 оны зун дуусахаас өмнө Гэгээнтнүүдийн өөр хоёр бүлэг Солт Лейкийн Хөндийд ирж, бараг 2,000 гишүүн Солт Лейк Гадас болж зохион байгуулагдав. Хожуу тариалсан болохоор бага ургац авч, хавар нь хүнс дутагдсанаас олон хүн нэрвэгджээ. Тэр үед хөвгүүн байсан Жон Р. Янг бичсэн нь:

6. “Ногоо ургаж эхлэх үеэр өлсгөлөн, өвчин эмгэг гаарч эхлэв. Бид хэдэн сарын турш талхгүй байлаа. Үхрийн мах, сүү, гишүүний үндэс, сийгөө хэмээх сараана цэцгийн үндэс, халгай бидний хоол хүнс болж байв. Би малчин хөвгүүн байсан болохоор малаа хариулж явахдаа, үхэр шиг л гэдсээ дүүртэл халгайны иш иддэг байлаа. Эцэстээ өлсөх нь бүр туйлдаа хүрэхэд аав шувуу тоншсон үхрийн ширийг мөчнөөс нь салгаж аваад чанахад маш сайхан амттай шөл болж билээ” [Жон Р.Янг, *Memoirs of John R. Young* (1920), 64]. Суурьшигсад үнэ хөлсгүйгээр хамтран ажиллаж, бие биетэйгээ хуваалцаж байсан болохоор энэ хүнд бэрх цагийг тэсэн гарч чадсан юм.



7. “1848 оны зургадугаар сар гэхэд суурьшигсад таваас зургаан мянган акр (2023–2428 га) газар тариалж, хөндий тэр чигээрээ ногоорон, ургац сайн байх төлөв харагдаж байлаа. Гэвч үй түмэн хүрэлзгэнэ ургацыг нөмрөн буух болсонд Гэгээнтнүүд айж эхлэв. Тэд шавжийг саваа, туужуураар цохиж, шатаах гэж оролдовч, хүч хөдөлмөр нь талаар болдог байв. Хүрэлзгэнэ бүр тоо томшгүй үй олноороо нөмрөн ирэх нь үргэлжилсээр байлаа. Солт Лейк гадасны

ерөнхийлөгч, патриарх Жон Смит мацаг барилт, залбирлын өдрийг зарласан аж. Удалгүй цахлайн том сүрэг тэнгэрт харагдаж, хүрэлзгэнийн дээрээс буух нь тэр. Сюзан Ноубл Грант энэ явдлын тухай өгүүлсэн нь: ‘Амь тэмцэн дэвхэрч байсан хүрэлзгэнийг бараг өлсгөлөн гэмээр цахлайнуд ховдоглон идэж байсан нь хэчнээн гайхалтай байсан гээч’ [Картер Э.Грант, *The Kingdom of God Restored* (1955), 446]. Гэгээнтнүүд баяр хөөр болж, мэл гайхан харж байв. Хүмүүсийн амьдрал аврагдлаа.

8. “Тэгээнтнүүд хүнд байдлаа эс хайхран, эрч хүч, итгэлтэйгээр ажиллаж байв. Иймээс тэд удалгүй их өсөлт дэвжилтэд хүрсэн юм. Нэгэн жуулчин 1849 оны есдүгээр сард Калифорни руу явах замдаа Солт Лейк хотоор дамжин өнгөрсөн аж. Тэрээр тэндхийн хүмүүст дараах байдлаар хүндэтгэл илэрхийлжээ: ‘Их дэг журамтай, хэрсүү, хөдөлмөрч, иргэншсэн хүмүүс юм. Би эдэн шиг хүмүүсийн дунд ерөөсөө байж үзсэнгүй. Энэ хүмүүс аглаг зэлүүд газарт ийм богинохон хугацаанд урьд хожид үзэгдэж дуулдаагүй их зүйлийг бүтээжээ. Дөрвөөс таван мянган оршин суугчтай энэ хотод би ганц ч залхуурагчтай, эсвээс дэмий сэлгүүцэгч болов уу гэж харагдахаар нэг ч хүнтэй тааралдсангүй. Сайн ургац хурааж авах найдвар тэдэнд байна. Бас миний очиж үзсэн аль ч хэмжээний, ямар ч хотод энэ хотынхтой эн зэрэгцэх тийм санаа бодол, эрч хүчийг та олж харахгүй’ [Б.Х.Робертс, *Life of John Taylor* (1963), 202]” (*Бидний Өв*, 82–83).

Зэлүүд нутгийг эзэмшсэн нь

9. “1848 оны зуны сүүлчээр, Ерөнхийлөгч Бригам Янг Винтер Квоттерсоос Солт Лейкийн Хөндий рүү дахин аялжээ. Тэрээр энд ирсэн үедээ шинэ нутагт ямар нөөц боломжууд байгааг Гэгээнтнүүд мэдэх хэрэгтэйг ойлгов. Тэр нутагт амьдардаг индианчуудаас ихийг мэдэж авсан ч, эмийн ургамал болон байгалийн баялгийг олж илрүүлэн ашиглахын тулд Ерөнхийлөгч Янг бас Сүмийн гишүүдийг явуулжээ.


10. “Тэрээр хүн суурьшуулах газруудыг олж мэдэхийн тулд судалгааны хэсгүүдийг явуулав. Эдгээр гишүүд явж, эрдсийн ордууд, их хэмжээний мод, усны эх үүсвэр, өвс ихтэй газрууд, мөн хүн суурьшихад тохиромжтой газруудыг олжээ. Газрыг дамлан худалдахаас сэрэмжлэн, хуваарилж олгосон газрыг бусдад худалдахгүй байхыг бошиглогч Гэгээнтнүүдэд сэрэмжлүүлжээ. Газар бол тэдэнд хариуцуулсан үүрэгт ажил байсан бөгөөд санхүүгийн ашиг сонирхлын үүднээс бус, харин ухаалгаар, хичээнгүй зүтгэлээр эрхлэх ёстой байлаа.

11. “1849 оны намар, Ерөнхийлөгч Янгийн удирдлагаар Цагаачлалын Байнгын Санг үндэслэн бий болгов. Сангийн зорилго нь Сүмийн үндсэн бие бүрэлдэхүүнтэй нэгдэн нийлэхийн тулд шилжин суурьших хөрөнгө мөнгөгүй ядуучуудад туслах явдал байлаа. Олон Гэгээнтнүүд их золиослол хийж, эл санд хандивлаж байсны ачаар олон мянган гишүүн Солт Лейкийн Хөндий рүү нүүж ирэх боломжтой болсон юм. Тусламж хүлээж авсан хүмүүс боломжтой болмогц тусламж болгон хүлээж авсан тоо хэмжээний мөнгийг эргүүлж төлөх ёстой байлаа. Энэ мөнгийг бас бусдад туслахад ашигладаг байв. Хамтын ажиллагааны энэхүү хүч чармайлтаар Гэгээнтнүүд гачигдалтай хүмүүсийн амьдралыг адисалсан юм” (*Бидний Өв*, 98–99).



БЯИС-ийн Урлагийн Музейн зөвшөөрлөөр нийтлэв. Бүх эрх хамгаалагдсан.

Уншсанаа ойлгох нь



Шинэ нутгийг эзэмшсэн нь

Газрыг дамлан худалдах (догол мөр 10)—Газрыг их мөнгөөр дахин зарахын тулд худалдаж авах

Хариуцуулсан үүрэгт ажил (догол мөр 10)—Өөр

хүний өмчийг хариуцан ажиллах

Цагаачлах (догол мөр 11)—Нэг газраас нөгөө газарт суурьшин амьдрахаар шилжин явах

Гар тэрэгтэй анхдагч нар

12. “1850 оны үед Сүмийн удирдагчид олон тооны цагаачдад туслах санхүүгийн тусламжийг өргөжүүлэхийн тулд зардлыг багасгах нэг арга зам болгож, гар тэрэгтэй бүлгүүдийг байгуулахаар шийдвэрлэв. Аялагч Гэгээнтнүүд энэ аргаар зөвхөн 100 фунт (45kg) гурил, нэн бага хэмжээтэй хүнсний зүйл, хувийн эд хогшлоо тэргэнд ачиж, хээр талаар түрж явдаг байв. 1856–1860 оны хооронд гар тэрэгтэй арван бүлэг Юта руу явжээ. Бүлгүүдээс найм нь Солт Лейкийн Хөндийд амжилттай хүрсэн боловч, хоёр нь, Мартин, Вилли нарын гар тэрэгтэй бүлэг өвлийн эхээр саатаж, тэдний дундаас олон Гэгээнтэн амь эрсэджээ.

13. “Хувь заяа нь өрөвдөлтэйгөөр эргэсэн бүлгүүдийн нэгнийх нь анхдагч Нелли Пусел хээр талд арван нас хүрсэн ажээ. Эцэг, эх хоёр нь аяны үед нас барав. Бүлэг уулсад ойртох үеэр цаг агаар тэсгим хүйтэн болж, хэмжээтэй хүнс нь дуусч, өлссөнөөс ядарч туйлдсан Гэгээнтнүүд аянаа цааш үргэлжлүүлэх тэнхэлгүй болсон байлаа. Нелли, бас эгч нь санаагаар ихэд унасан аж. Тэд ямар ч найдлагагүй болоод байтал, бүлгийн удирдагч нь мухлаг тэргээр хүрч ирэв. Тэрээр Неллиг мухлаг тэргэнд суулгаж, Магтийг тэрэгнээс чанга бариад, хажуугаар нь дагаад яв гэжээ. Хөдөлгөөн Магтийг осгож үхэхээс аварсан учир түүний аз гийсэн юм.

14. “Тэд Солт Лейк хотод хүрч ирээд, хээр талыг туулахад Неллигийн элээсэн гутал, оймсыг нь тайлж авахад, осгноос болж, хөлийнх нь арьс хуурсан байв. Зоригтой энэ охины хөлийг тайрсан учир тэрээр амьдралынхаа үлдсэн хугацаанд өвдөг дээрээ явдаг байжээ. Хожим нь тэр гэрлэж, зургаан хүүхэд төрүүлэн, гэр орноо авч яван, өнөр сайхан үр удмаа өсгөн бойжуулсан юм. [“Story of Nellie Pucell Unthank,” *Heart Throbs of the West*, эмхтгэсэн Кейт Б.Картер, 12 боть, (1939–1951), 9:418–420-ийг үз.] Өөрийнхөө байдлыг эс хайхарсан түүний зоримог шийдэмгий зан, өөрийг нь халамжилж байсан хүмүүст нинжин сэтгэлээр

ханддаг байсан нь эхэн үеийн Сүмийн гишүүдийн итгэл, золиослол хийх хүсэл эрмэлзлийн үлгэр жишээ болдог билээ. Тэдний үлгэр жишээ бол тэднийг дагах бүх Гэгээнтнүүдийн хувьд итгэлийн өв юм.



15. “Мартин гар тэрэгтэй бүлэгт хээр талыг туулсан нэг хүн Ютад олон жил амьдарч байлаа. Гар тэргээр авч явж чадахаас илүү хүнс, хувцас, хамгаалалтгүйгээр хээр талыг туулахыг Гэгээнтнүүдэд зөвшөөрсөн Сүмийн удирдагчдыг хурцаар шүүмжилсэн хэсэг хүмүүсийн дунд тэрээр нэгэн өдөр орсон байжээ. Настай хүн сонссоор байгаад цаашид тэсч чадахгүй болсон ажээ. Тэгээд тэр босч, сэтгэл ихэд догдлон ярьсан нь:

16. “Би тэр бүлэгт чинь байсан юм, бас миний эхнэр ч тэнд байсан. . . . Та нарын төсөөлж чадахаас илүү их гай зовлонг бид амссан. Олон хүн толгой халхлах юмгүй ил задгай хүйтэнд байснаас, бас өлссөнөөс амь эрсэдсэн юм. Гэвч тэр бүлгээс амьд мэнд үлдсэн ганц ч гэсэн хүн шүүмжилсэн үг хэлж байхыг та нар сонссон уу? . . . Өөрсдийн гай зовлонгийн үед бид Бурханаа танин мэдэж, Тэрээр амьд гэдэг төгс мэдлэгтэйгээр дамжин гарч ирсэн юм.

17. “Би ихэд ядарч, өвчнөөс болж туйлдсан үедээ, бас хоол хүнс дутагдсанаас нэг хөлөө нөгөө хөлийнхөө өмнө арай ядан зөөж явахдаа ч, гар тэргээ түрж л явсан. Би урагшаа харж, элсэн зурвас буюу толгойн бэл олж хараад, би зөвхөн тэр хүртэл явж чадна, тэгээд тэнд бууж өгөхөөс өөр аргагүй болно. Учир нь би ачааг элсээр эсвэл толгойн бэлээр түрж гаргаж чадахгүй. . . . гэж өөртөө хэлдэг байсан. Би тэр элс рүү хүрч очиход, тэрэг намайг аяндаа урагш нь татаж эхэлдэгсэн. Хэн тэргийг минь түрээд байгааг харах гэж би олон удаа эргэж хардаг байлаа. Гэвч нүдэнд минь хэн ч харагддаггүй байв. Бурханы тэнгэр элчүүд гэдгийг би мэддэг байсан.

18. “Гар тэргээ түрж явахаар шийдсэндээ би харамсдаг байсан уу? Үгүй ээ. Тэр үед ч, түүнээс хойшхи амьдралынхаа мөч болгонд тэр шүү. Бурханыг мэддэг болохын тулд бидний төлсөн төлөөс онцгой боломж байсан юм. Тиймээс би Мартин Гар Тэрэгтэй Бүлэгт орж явах онцгой боломж олдсонд талархаж явдаг” [Виллям Палмер, Давид О.МкКей, “Анхдагч Эмэгтэйчүүд,” *Relief Society Magazine*, 1948 оны 1-р сар, 8-аас эш татжээ].

19. “Сайн мэдээг зоримгоор хүлээн авч, соёл иргэншлийн манлайд амьдрахын тулд алс холын аянд гарсан Сүмийн эхэн үеийн гишүүдийн тухай нэг дуу манай дууллын номонд байдаг:

20. “Улс үндсээ байгуулагч тэд
Улбаа замын дагуу тэд
Урдаа байгаа үеийнхэнд тэдний
Урагш ахих гишгүүр өдөр бүрийнх нь үйлс
Шинэ бат бөх суурийг босгон
Зэлүүд хязгаар руу яаран
Урагшаа, ямагт урагшаа давшигч
Хүндэт Анхдагч, адислагдсан та!
21. “Тэдний үлгэр жишээ хэрхэн илүү их итгэл, илүү их эрэлхэг зоригоор улс орондоо амьдрахыг бидэнд заадаг:
22. Үйлчлэл ямагт тэдний уриа
Хайр тэдний хөтөч од болсон
Хол ойрд гэрэл цацруулсан
Эр зориг тэдний бөхөшгүй гэрэлт цамхаг
Өдөр бүр ачаа үүрнэ
Өдөр бүр найдварыг гэрэлтүүлнэ
Хүндэт Анхдагч, адислагдсан та!
[“They, the Builders of the Nation,” *Дуу.лууд*, дугаар 36]”
(*Бидний Өв*, х. 94).

Уншсанаа ойлгох нь



Гар тэрэгтэй анхдагч нар

Өв (догол мөр 14)—Өнгөрсөн үеэс өвлөгдөж ирсэн ямар нэг үнэ цэнэтэй зүйл

Номлогч нар дуудлагад хариулав

23. “Их хөдөлмөр оргилж, амьдрал оргилон буцалж байсан ч, Ерөнхийлөгч Бригам Янг Сүмийн талаар зовнин, гол анхаарлаа тавих болов. Тэрээр 1849 оны аравдугаар сарын 6-нд болсон ерөнхий чуулган дээр гадаадын номлолуудад үйлчлүүлэхээр Арванхоёрын хэдэн гишүүнийг шинээр дуудагдсан номлогчдын хамт томилов. Тэд гэр бүлээ, шинэ өлгий нутгаа, дуусаагүй олон ажил үйлсээ ардаа орхих болсон ч дуудлагыг хүлээн авчээ. Эраст Снөү болон өөр хэдэн ахлагч Скандинавт номлолын ажлыг эхлүүлсэн бол, Лорензо Снөү, Жозеф Торонто хоёр Итали руу явав. Аддисон Пратт, Люиза Барнес Пратт хоёр Сосайти арлууд (Тахитиг оруулаад Өмнөд Номхон далайн хэсэг арлууд) дээрх Аддисоны хуучин хөдөлмөрийн талбарт эргэн иржээ. Жон Тейлор Франц, Германт дуудагдав. Номлогчид дорнод зүг рүү явахдаа Хадат Уулс дахь шинэ Сионыг зорьж яваа Гэгээнтнүүдийн дэргэдүүр өнгөрчээ.



24. “Номлогчид хөдөлмөрийнхөө талбарт гайхамшгуудыг гэрчилж, Сүмд олон хүмүүст багтисм хүртээж байв. Хожим нь Сүмийн Ерөнхийлөгч болсон Лорензо Снөү Италид номлож байхдаа үхлийн ирмэг дээр байсан гурван настай жаал хүүтэй тааралджээ. Тэр хүүхдийг эдгээх болон уг бүс дэх хүмүүсийн зүрх сэтгэлийг нээх боломжийг тэрээр мэдэж байв. Тэр үдэш тэрээр Бурханаас удирдамж хүсч,

чин сэтгэлээсээ удаан залбирч, маргааш нь хамтрагчтайгаа нөгөөх хүүгийн төлөө мацаг барьж, дахин залбирчээ. Үдээс хойш нь тэд жаал хүүг адисалж, хөдөлмөртөө тусламж эрэн, чимээгүй залбирав. Жаал хүү шөнөжингөө тайван унтаж, гайхалтайгаар эдгэрсэн ажээ. Энэхүү эдгэрэлтийн тухай үг Италийн Пиедмонтын хөндий даяар тархав. Номлогчдод хаалгууд нээгдэж, тус бүсэд анхны багтисмууд боллоо. [Францис М.Гиббонс, *Лорензо Снөү: Spiritual Giant, Prophet of God* (1982), 64.]

25. “1852 оны наймдугаар сард Солт Лейк хотод болсон тусгай чуулган дээр дэлхий даяар номлолд явахаар 106 ахлагч дуудагдав. Эдгээр номлогчид мөн хожим нь дуудагдсан хүмүүс сайн мэдээг Өмнөд Америк, Хятад, Энэтхэг, Испани, Австрали, Хавай болон Өмнөд Номхон Далайд номлож байлаа. Эдгээр бүсүүдийн олонхид нь номлогчид эхний үед багахан амжилттай байжээ. Гэвч тэд хожмын номлогчдын хүч чармайлтаар Сүмд ирсэн олон хүмүүст нөлөөлсөн үрийг суулгасан билээ.

26. “Ахлагч Эдвард Стийвенсон Испанийн Гибралтарын Номлолд дуудагдав. Энэ дуудлага түүнийг төрсөн нутагтаа эргэн ирж, сэргээгдсэн сайн мэдээг эх орон нэгтгүүддээ зоригтойгоор тунхаглах боломжийг олгосон ажээ. Тэрээр номлосныхоо төлөө баривчлагдаж, харуул хамгаалалтын ханд зааснаас тэдний нэг нь бараг хөрвөгдөх шахсан гэдэг. Эрх баригчид үүнийг мэдсэнээр тэр хэсэг хугацааг шоронд өнгөрүүлжээ. Тэр суллагдсаныхаа дараа Сүмд хоёр хүнд багтисм хүртээж, 1854 оны нэгдүгээр сар гэхэд арван хүнтэй нэг салбар зохион байгуулав. Долдугаар сард зургаан гишүүн Ази дахь Британийн армид алба хаахаар явсан ч, салбар арван найман гишүүнтэй, түүний дотор нэг дал, нэг ахлагч, нэг санваартан, нэг багштай болж, өсөлт хөгжилт нь үргэлжлэхэд хэрэгтэй байсан удирдлага салбарт бий болсон байлаа.

27. “Францын Полинезийн орон нутаг дахь удирдлага 1852 онд номлогчдыг хөөн гаргасан байна. Гэвч хөрвөгдсөн Гэгээнтнүүд 1892 оны, номлолын дараагийн хүч чармайлт хүртэл Сүмийг авч явсан аж. Ахлагч Техоне, Маехеа хоёр бүр ч зоригтой байсан гэдэг. Тэд итгэлээ үгүйсгэснээс шоронд хоригдож, хүнд сорилтыг даван туулах нь дээр гэж үзсэн ажээ. Гэгээнтнүүдийг идэвхтэй, сайн мэдээнд итгэлтэй хэвээр байлгахыг тэд хоёул хичээж байв. [Р.Ланиер Бритц, *Unto the Islands of the Sea: History of the Latter-day Saints in the Pacific* (1986), 21–22-ыг үз.]

28. “Нэгдсэн Улсын гадна талд Сүмд нэгдсэн хүмүүс энэ үед Америкт усан онгоцоор ирж, Сионд цуглаж байлаа. Элизабет Вуд, Чарльз Вуд хоёр шилжин явахынхаа өмнө мөнгөтэй болохын тулд хэдэн жил ажил хийжээ. Тэд Өмнөд Африкаас 1860 онд гарав. Шаардлагатай байсан мөнгөө цуглуулах хүртэл Элизабет нэг баян хүний гэр орныг харж хандан, нөхөр нь тоосго цохидог байв. Элизабатыг хүү төрүүлээд дөнгөж 24 цаг болсны дараа орон дээр хэвтүүлээд усан онгоцонд өргөж оруулан, тав тухтай байлгахын тулд ахмадын орыг түүнд гаргаж өгчээ. Элизабет аяны үед нэн хүндээр өвчилж, хоёр удаа бараг үхэх шахсан боловч, Ютагийн Филлморед эсэн мэнд ирж, суурьшсан ажээ.

29. “Номлогчид үйлчилж байсан орнуудынхаа Гэгээнтнүүдэд өндөр нэр хүндтэй байлаа. Жозеф Ф.Смит 1857 онд Хавай дахь номлолынхоо төгсгөл хавьд их халуурдаг чичиргээ өвчнөөр өвчилж, өвчин нь түүнийг гурван сар ажлаас нь хөндийрүүлжээ. Тэрээр Хавайн итгэлтэй

35. “Түмэн бэрхшээл зовлон байдаг. Гэсэн ч бид хүлцэн тэвчиж . . . бэрхшээл зовлонг хамтдаа хуваалцдаг. Хэрэв та нар хаашаа ч юм, өөр газар руу явах гэж байгаа бол, яв л даа. Энэ бол та нарын эрх. Тэгэхлээр энэ нутгийг орхиж явах та нарын эрхийг би хасахыг хүсэхгүй байна. . . . Харин би бүр ганцаараа ч гэсэн хамаагүй, энд үлдэх ёстой. Ерөнхийлөгч Янг намайг энд дуудсан. Тийм ээ, тэрээр эндээс явахыг зөвшөөрч, намайг чөлөөлөх хүртэл би энд байна” гэжээ. Рич ах гэр бүлийнхээ хамт үлдэж, хорь, гучин жилийн турш дэвжин дээшилсэн хамт олны удирдагч болсон билээ. [Леонард Ж. Аррингтон, *Чарльз К. Рич* (1974), 264-ийг үз.] Тэрээр бусад мянга мянган хүмүүсийн нэгэн адил, Их Эзэний хаант улсыг байгуулахын тулд удирдагчдаа дуулгавартайгаар дагах оргилуун хүсэл эрмэлзэлтэй байсан юм” (*Бидний Өв*, 104, 105).

Уншанаа ойлгох нь



Шинэ нутаг эзэмших дуудлага

Эзэмших (дэд гарчиг)—	жаргалыг нэмэгдүүлдэг эд
Шинэ хот суурингуудыг байгуулах	хөрөнгө
Материаллаг ая тух (догол мөр 31)—Баяр баясал, аз	Тээрэм (догол мөр 32)—Тариаг тээрэмдэж гурил болгодог хэрэгсэл

Индианчуудтай тогтоосон харилцаа

36. “Шинэ нутаг эзэмшин суурьшигчид хил рүү цааш ахих тусам индианчуудтай олонтоо харилцдаг байв. Ерөнхийлөгч Бригам Янг Өрнөдөд суурьшигч зарим хүмүүсээс ялгаатай нь, нутгийн уугуул ах эгч нараа хоол хүнсээр тэтгэн тэднийг Сүмд авчрахыг хичээхийг Гэгээнтнүүдэд заадаг байлаа. Индианчуудын дунд номлох үйл ажиллагааг Айдахогийн нутгийн Салмон голын бүс дэх Форт Лимхай, Ютагийн нутаг дахь Колорадогийн Элк уулын нэг сууринд туршиж байв. Бас гишүүд нь индиан ах эгч нартаа зориулж хувцас оёх, тэднийг хооллоход туслах мөнгө цуглуулахыг Ерөнхийлөгч Янг Нийгмийн Халамжийн Бүлгүүдэд даалгажээ.

37. “Томас Л. Кейний эхнэр асан гишүүн бус, Гэгээнтнүүдийн агуу найз Элизабет Кейн Юта даяар аялж, нэгэн ядмагхан мормон эмэгтэйн гэрт буусан аж. Тэр эмэгтэй индианчуудтай хэрхэн харьцдагийг харахаасаа өмнө Элизабет түүний талаар төдий л бодоогүй байжээ. Нөгөөх эмэгтэй зочдыг хоолонд уриад, хүлээж байсан индианчуудад хэдэн үг хэлэв. Тэр индианчуудад юу гэж хэлснийг Элизабет асуухад гэрт байсан нэг хөвгүүн, ‘Гадны энэ хүмүүс эхлээд ирсэн болохоор би зөвхөн тэдэнд хүрэлцэх хоол хийлээ. Та нарын хоолыг одоо хийж байна. Хоол болмогч би та нарыг дуудна’ гэлээ гэж түүнд хэлжээ. Элизабет итгэсэнгүй, тэгээд тэр эмэгтэй индианчуудыг үнэхээр хооллох юм уу гэж асуув. Хөвгүүн түүнд, ‘Ээж танд үйлчилсэн шигээ бас тэдэнд үйлчилнэ. Индианчуудыг бүр ширээндээ суулгадаг юм’ гэжээ. Тэр эмэгтэй зочдыг хоол идэж дуустал индианчуудыг хүлээлгэж байгаад дараа нь хоолыг өгчээ. [Элизабет Вуд Кейн, *Twelve Mormon Homes Visited in Succession on a Journey through Utah to Arizona* (1974), 65–66.]” (*Бидний Өв*, 105).



Уншанаа ойлгох нь



Индианчуудтай харилцсан нь

Хил (догол мөр 36)—Аглаг буйд, зэлүүд газар

Санваартны болон Туслах байгууллагуудын үйл ажиллагаа

38. “Ерөнхийлөгч Янг сүүлчийнхээ жилүүдэд санваартны зарим чухал үүргийг бий болгож, тодруулсан юм. Тэрээр гадас болгонд чуулган хийж байх талаар Арванхоёрт чиглэл өгсөн аж. Үүний үр дүнд Юта даяар долоон шинэ гадас, 140 шинэ салбар бий болов. Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл, чуулгуудын ерөнхийлөгчийн зөвлөл, дээд зөвлөл, бишопын зөвлөл болон чуулгын ерөнхийлөгчийн зөвлөлүүдийн үүргийг тодорхой тогтоож, хэдэн зуун эрэгтэйчүүд эдгээр албан тушаалуудыг хашихаар дуудагдав. Амьдралаа дэг журамд захируулж, аравны нэг, мацгийн өргөл болон бусад хандивыг төлж байхыг тэрээр Сүмийн гишүүдэд зөвлөдөг байв.

39. “1867 онд боциглогч Жорж К. Каннон Ням гарагийн сургуулийн ерөнхий хянагчаар томилогдов. Хэдхэн жилийн дотор Ням гарагийн сургууль Сүмийн зохион байгуулалтын байнгын хэсэг болжээ. 1869 онд Ерөнхийлөгч Янг даруухан амьдралын тухай зааврыг өөрийнхөө охидод албан ёсоор өгчээ. Тэрээр эл зөвлөгөөг бүх залуу эмэгтэйчүүдэд өгч, 1870 онд Хэмнэлтийн Нийгэмлэгийг (*хэмнэлт* гэдэг нь хэтэрхий үрэлгэн зардлыг хорогдуулах гэсэн утгатай ажээ) үүсгэн бий болгов. Энэ бол Залуу Эмэгтэйчүүдийн байгууллагын эхлэл байв. 1877 оны долдугаар сард тэрээр гадасны анхны Нийгмийн Халамжийн Бүлгийг зохион байгуулахаар Ютагийн Огденд очжээ” (*Бидний Өв*, 106).

Уншанаа ойлгох нь



Санваартны болон Туслах байгууллагын үйл ажиллагааг зохион байгуулсан нь

Туслах байгууллага (дэд гарчиг)—Санваартны чиглэл доор ажилладаг Ням гарагийн сургууль,	Нийгмийн Халамжийн Бүлэг мэтийн байгууллага
	Хянагч (догол мөр 39)—Удирдагч

Калифорнийн Голд Раш Солт Лейкийн Хөндий дэх Гэгээнтнүүдэд ямар нөлөө үзүүлсэн бэ?



1848 онд Калифорнид алт илэрсэн нь итгэлтэй хүмүүсийн хувьд адислал, харин итгэлээрээ сул хүмүүст уруу таталт болсон ажээ. Алт хайгчдын үер мэт цуваа дорнодоос Солт Лейкийн Хөндийг дайран өнгөрдөг болов.

Хөндий дэх хатуу хахир нөхцөлд таагүй байсан Сүмийн зарим гишүүд мухлаг тэргэндээ ачаалан, явахад бэлтгэж эхлэв. “Бурхан Гэгээнтнүүдийнхээ цугларалтад зориулж энэ газрыг хуваарилан олгосон юм. Иймээс та нар алтны уурхай руу явснаас эндээ байх юм бол илүү амжилтад хүрнэ. . . . Учир нь алт, мөнгө, газрын эрдэс баялагаар энэ нутагтай эн зэрэгцэх өөр нутаг байхгүй. Харин хүмүүс өөрсдөө мэдэг. Бусад хүмүүс алт, мөнгө эрж хайг. Харин бид газрынхаа хөрсийг боловсруулъя” хэмээн Ерөнхийлөгч Бригам Янг зөвлөжээ (in Brown, *Giant of the Lord*, 132–33). Зарим хүмүүс Калифорнийг зорин явсан ч, ихэнх хүмүүс үнэнч хэвээр үлдэж, тэр жил сайн ургац хураасан юм.

1849 оны алтны тэр их үймээн бужигнаан Солт Лейкийн Хөндийд амьдарч байсан Гэгээнтнүүдийг шууд адисалсан юм. Калифорнид бараагаа авчирсан худалдаачид Солт Лейк хот хүрээд, усан онгоцоор илгээсэн хүнс, хувцас, багаж хэрэгсэл нь эндхийн зах зээлд аль хэдийн нэвтэрснийг мэдээд, Гэгээнтнүүдэд бараагаа маш хямд үнээр худалддаг байлаа. Бас алт эрэгчид мухлаг тэргээ засуулахаар Гэгээнтнүүдийг хөлсөлдөг байв. Түүнээс гадна, ачаагаа хөнгөлж, алтны талбайнуудад хурдан хүрэх гэсэн хүмүүсийн зам дагуу хаясан эд хогшил, барааг цуглуулж авахын тулд хоосон мухлаг тэрэгтэй бүлгүүдийг Солт Лейкээс явуулдаг байжээ.

Уншсанаа судлах нь



“Ерөнхийлөгч Бригам Янг”-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас гурвыг хий

А Шинэ өлгий нутаг

1. Шинэ өлгий нутагт хүмүүсийг суурьшуулахаар хэсэг хүмүүсийг чи удирдах боллоо гэж төсөөлөн бод. “Миний тушаал” гэсэн гарчигийн дор тэмдэглэлийн дэвтэртээ өөрийнхөө хийх дараах үйл ажиллагаануудыг жагсаан бич:
 - а. Хүмүүст газар хуваарилж өгөх
 - б. Хүндрэл бэрхшээлийг даван туулахын тулд мацаг барьж залбирах
 - в. Тариа тарих
 - г. Дэвшил хөгжилд хүрэхийн тулд шаргуу ажиллах
 - д. Ариун сүм барих газрыг тогтоох
 - е. Сүмийг зохион байгуулах
 - ё. Сүнсээр нөлөөлөгдсөн ирээдүйн төлөвлөгөө хийх
2. Догол 1–11-ийг нэгтгэн дүгнэ. Тэгээд, “Анхдагч нарын захирамж” гарчигийн дор Ерөнхийлөгч Бригам Янг

болон Гэгээнтнүүд Солт Лейкийн Хөндийд эхний хэдэн сарын дотор захирамжаар хийсэн ажлуудтай адил ажлуудыг жагсаан бич.

3. Эдгээр ажлуудыг хийдэг байсан журам чамд ямар санагдав?
4. Энэ үлгэр жишээг амьдралдаа эн тэргүүнд баримтлах зүйлүүдэд чи хэрхэн хэрэглэж болох вэ?

Б Дуулалд холбогдох түүхүүдийг ол

1. Догол мөр 20, 22 дахь “Улс орноо байгуулагч тэд” дууллын үгийг анхааралтай унш.
2. Дараах үгс, нийлэмж үгсийг тэмдэглэлийн дэвтэртээ бич. Тэгээд “Ерөнхийлөгч Бригам Янг”-аас уншсан зүйлээсээ үг буюу өгүүлбэр бүрд жишээ болох түүхийг олж, ганцхан өгүүлбэрээр бичсэн түүхийн товч хураангуйг жагсаалт дахь тэмдэглэлийн хажууд бич.
 - а. Улбаа зам
 - б. Зэлүүд нутаг руу тэмүүлэхүй
 - в. Яаран урагшлахуй
 - г. Үйлчлэл
 - д. Хайр
 - е. Зориг
 - ё. Адислагдсан нь

В Газрын зураг зур

1. Өөрсдийнхөө судрууд дахь “Сүмийн Түүхийн он дараалал, Газрын зургууд болон гэрэл зургууд” хэсгийн газрын зураг 7-гоос дэлхийн газрын зургийг тэмдэглэлийн дэвтэртээ зур. Ерөнхийлөгч Бригам Янг номлогчдыг илгээсэн бүх орныг газрын зураг дээрээ тэмдэглэ (догол мөр 23–29-ийг үз).
2. Дараах асуултуудад хариул:
 - а. Эдгээр орнуудаас алинд нь чи номлолд үйлчлэхийг хамгийн их хүсэх вэ? Яагаад?
 - б. Алс холын орнуудад номлолд үйлчлэхээр дуудагдсан хүмүүсийн хүүхдүүдийн хувьд амьдрал нь хэрхэн өөрчлөгдсөн гэж чи бодож байна?
 - в. Өөрөөр чинь хийлгэхээр Их Эзэний дуудсан хамгийн хэцүү ажил юу вэ? Туршлага чинь өсч хөгжихөд чинь хэрхэн тусалсан бэ?

Г Түүх бич

Одоогийн Юта болон эргэн тойрон дахь мужуудад шинэ нутгийг эзэмшүүлэхээр Ерөнхийлөгч Бригам Янг Сүмийн олон гишүүнийг дуудсан ажээ. Дараах даалгаврыг хийхийн тулд догол мөр 30–35-ыг унш:

1. Шинэ нутаг эзэмшихээр дуудагдсан хүн бүрийн нэрийг жагсаан бич. Сорилттой даалгаврыг биелүүлэх тухайн хүний чадварын хамгийн сайн жишээ болно гэж өөрийнхөө бодсон зан төлвийн шинжүүдийг жагсаан бич.
2. Хуудас 00 (69) дээрх дүнзэн байшингийн өмнөх гэр бүлийн зургийг хар. Өөрийгөө энэ гэр бүлийн гишүүн гэж бодоод, уг нутгийг эзэмш хэмээн Ерөнхийлөгч Бригам Янг өөрийг чинь дуудсан үед ямар бодолтой байхаа дүрсэлсэн товч түүх бич.

Ерөнхийлөгч Бригам Янгийн өв Хожмын үеийн Мосе




Тэргүүн Зөвлөлийн зөвлөх асан Ерөнхийлөгч Жорж К. Каннон Ерөнхийлөгч Бригам Янгийн тухай өгүүлж, мэдэгдэхдээ: “Та явж, Ерөнхийлөгч Янгийн номлолуудыг уншаад үз. Хэрэв тэрээр бошиглогч байсанд та одоо итгэхгүй бол, та дээрх номлолуудыг уншсаныхаа дараа түүнийг бошиглогч байсанд итгэнэ гэж би бодож байна. Учир нь тэрээр энэ хүмүүст хандан ирээдүйнх нь талаар яг бошиглогч лугаа адил ярьсан байна. Бас түүний үгс

Бурханых шиг мэргэн ухаанаар дүүрэн байна. Тэрээр эдгээр үгсийг тасралтгүй ундрах горхи лугаа адил насан туршидаа юүлж байлаа” гэжээ (Gospel Truth, 1:328).

Ерөнхийлөгч Бригам Янгийн нас баралт ба өв

1. “Ерөнхийлөгч Бригам Янг практикч, эрч хүчтэй удирдагч байв. Тэрбээр Гэгээнтнүүдийг зааварлаж, урамшуулан дэмжихийн тулд Сүмийн суурингуудаар явдаг байжээ. Бригам Янг удирдлага болон үлгэр жишээгээр Сүм дэх дуудлагаа хэрхэн биелүүлэхийг гишүүдэд заадаг байлаа.
2. “Ерөнхийлөгч Янг Нью-Йоркийн нэг сонин эрхлэгчийн асуултад хариулан, амьдралдаа үнэлэлт дүгнэлт өгч дараах зүйлийг бичжээ:
3. “Өнгөрсөн 26 жилийн хөдөлмөрийнхөө үр дүнг товчоор дүгнэвэл: Хожмын Үеийн Гэгээнтэн 100,000 орчим хүнийг энэ нутагт суурьшууллаа. Манай хүмүүсийн суурьшсан 200 гаруй хот, хотхон, тосгон . . . манай хамт олны амьдралыг сайжрууллаа. Тэдэнд зориулсан сургууль, үйлдвэр, тээрэм, бусад байгууллагуудыг үндэслэн бий болголоо. . .
4. “Бүх амьдрал маань Бүхнийг Чадагчид үйлчлэхэд зориулагдлаа [Хинкли, *Truth Restored*, 127–128-аас эш татжээ].

5. “Есүс бол Христ, дэлхийн Аврагч болон Гэтэлгэгч гэдгийг би гэрчилж байна. Би түүний айлдваруудыг дуулгавартай дагасан. Амлалтыг нь хэрэгжүүлсэн. Надад байдаг түүний тухай мэдлэгийг энэ дэлхийн мэргэн ухаан өгч чадахгүй, бас үүнийг булаан авч чадахгүй” гэсэн Аврагчийн тухай хүчирхэг гэрчлэлийг Ерөнхийлөгч Янг 1876 оны есдүгээр сард хэлжээ [in *Journal of Discourses*, 18:233].



6. “1877 оны наймдугаар сард Ерөнхийлөгч Янг хүндээр өвчилж, эмч нар хэчнээн асарч сувилсан ч, долоо хоногийн дараа 76-тайдаа нас барав. Тэрээр Сүмийг 33 жил удирдсан юм. Тэр бол өнөө үеийн Израилыг амлагдсан нутаг руу удирдсан эрч хүчтэй бошиглогч байсныг өнөөдөр бид дурсан санадаг. Түүний номлолууд, шашин бол өдөр тутмын туршлага мөн гэдгийг тодотгон, өдөр тутмын амьдралын бүх талыг хамардаг байлаа. Хилийн шугамын тухай түүний ойлголт, нарийн мэдрэмжтэй удирдлага нь ээлүүд нутагт хаант улсыг бий болгоход тэнгэрийн адислалууд тусалж, боломжгүй мэт санагдаж байсан хүнд хүчир ажлуудыг хэрэгжүүлэхэд түүний хүмүүст бурханлигаар нөлөөлсөн билээ” (Бидний Өв, 90–91).

Бригам Янгийн сургаалууд ба гэрчлэл



7. Ерөнхийлөгч Янг Матай 5:48-ыг дурдаж: “Бид энэ өгүүлбэрийн хэлбэрийг өөрчилж, ‘Та нар чадахынхаа хэрээр төгс бай’ гэж хэлж болох юм. Учир нь та нар тэнгэр дэх Эцэгийнхээ нэгэн адил төгс бай гэж бичсэн байдаг ч, энэ бол бид бүгдийн хийж чадах зүйл юм. . . . Бид хэрхэн хийхийг мэдэж байгаа цагт сайн хийж чадна . . . Бид Бурханы сэнтийний өмнөх тэнгэр элчүүд лүгээ адил зөвтгөгдөнө” гэж хэлжээ (*Discourses of Brigham Young*, 89).

8. Бошиглогч Иосеф Смитийг нас барснаас хойш бараг гурван жилийн дараа Бригам Янг түүнийг зүүдэнд буюу үзэгдэлд харсан ажээ. Сүмийн гишүүдэд өгөх захиас байна уу гэж Ерөнхийлөгч Янг Бошиглогчоос асуусан гэнэ. “Иосеф миний өөдөөс алхаж, ихэд бодлогошронгуй харснаа, баяртайгаар, ‘Даруу бөгөөд итгэлтэй бай. Мөн Их Эзэний Сүнснийг байлгахад анхаар гэж хүмүүст хэл. Тэгвэл Сүнс тэднийг зөв удирдах болно. Анхааралтай бай мөн намуухан, зөөлхөн дуу хоолойноос бүү нүүрээ буруул. Сүнс та нарт юу хийхийг, хаашаа явахыг заах болно. . . . Та нар бусад бүх сүнснээс Их Эзэний Сүнснийг ялган таньж чадна. Сүнс хүмүүсийн бодгальд амар амгалан, баяр баяслыг шивнэх болно. Сүнс хорон санаа, үзэн ядалт, зөрчил сөргөлдөөн, бүх хилэнцийг хүмүүсийн зүрх сэтгэлээс авч хаях болно. Ингээд тэдний бүх хүсэл нь сайныг үйлдэх, зөв шударгыг авчрах, Бурханы хаант улсыг байгуулах явдал байх болно” гэжээ (*Manuscript History of Brigham Young, 1846–1847*, эмхтгэсэн Элден Ж. Ватсон [1971], 529).

9. “Энэ хүмүүсийн тухайд миний хамгийн их айдаг зүйл бол тэд энэ нутагт хөлжин баяжиж, Бурхан болон Түүний хүмүүсийг мартан, бардам сэхүүн болж, өөрсдийгөө Сүмээс хөндийрүүлэн, там руу явахвий гэдэг айдас юм. Энэ хүмүүс танхайрал, дээрэм тонуул, ядуу тарчиг амьдрал, зүсэн зүйлийн мөрдлөг хавчлагыг тэсэн гарч, зөв шударга байна. Гэвч миний хамгийн их айдаг зүйл бол тэд эд баялагаас тэсэн гарч чадахгүй байхвий гэдэг айдас юм” (Кимбалл, *Miracle of Forgiveness*, 48-аас эш татжээ).

10. “Та нар эсвэл би залбирах дуртай юу гэдэг нь хамаагүй, залбирах цаг ирсэн л бол залбирч бай. Хэрэв бид залбирах дургүй байвал, залбирах дуртай болтлоо залбирах ёстой. . . . Сүнс тэдэнд залбирахыг сануулах хүртэл хүлээдэг хүмүүс энэ дэлхий дээр хэзээ ч төдийлөн залбирдаггүйг та нар мэдэх болно” (*Discourses of Brigham Young*, 44).

11. “Та нар судруудыг мянган жилийн өмнө, хоёр мянган жилийн өмнө эсвэл таван мянган жилийн өмнө өөрсдөө бичсэн юм шиг уншдаг уу, ах эгч нар минь ээ? Судруудыг бичсэн хүмүүсийн оронд өөрийгөө байна гэж бодоод та нар эдгээрийг уншдаг уу? Хэрэв та нар ингэж боддоггүй бол, Сүнс болон Бурханы бичигдсэн үгтэй танил байж, өдөр тутмын амьдрал, үг яриандаа сахих нь та нарын онцгой боломж юм” (*Discourses of Brigham Young*, 128).

12. “Энэ хүмүүс удирдагчдаа ихэд итгэн, Түүгээр удирдуулахыг өөрсдийнхөө төлөө Бурханаас асуухгүй болохвий гэж би бүр их айдаг. Тэд зөвхөн аюулгүй байдалд сэтгэл ханан, харалган болж, мөнхийн хувь заяагаа удирдагчдынхаа гарт, тэгэхдээ зөвхөн албан тушаалынх нь учраас л итгэл хүлээлгэн даатгаж, бүх юм болж бүтэж байна гэж санаа амрахвий гэдгээс би айдаг. Ингэх юм бол тэдний авралын төлөөх Бурханы зорилгуудыг нураахад, удирдагчид нь Есүсийн илчлэлтүүдээр өөрсдийнх нь өмнөөс мэдэж байгаа гэдэгт, тэд зөв замаар удирдуулж байгаа гэдэгт итгэн, удирдагчдад үзүүлэх нөлөө нь сулрахад хүргэнэ” (*Discourses of Brigham Young*, 135).

13. “Хүмүүс яагаад урвадаг вэ? Бид ‘Хуучин Хөлөг Онгоц Сион’ дээр байгааг та нар мэдэж байгаа. Бид далайн дунд байна. Шуурга болно, тэгэхээр далай ёстой үзүүлж өгнө дөө гэж далайчид хэлнэ. ‘Би ч энд үлдэхээ больё доо’ гэж нэг нь хэлнэ. ‘Энэ чинь “Сион Хөлөг Онгоц” мөн гэдэгт би итгэхгүй байна.’ ‘Бид чинь далайн дунд байна шүү дээ.’ ‘Энэ ямар хамаа байсан юм бэ, би энд үлдэхгүй ээ. ‘Хувцсаа тайлж хаяад тэр хөлгийн тавцангаас үсэрнэ. Тэр хүн живж

үхэхгүй гэж үү? Тийм ээ. Энэ Сүмийг орхидог хүмүүс ийм хувь тавилантай юм. ‘Энэ чинь Хуучин Хөлөг Онгоц Сион байна.’ Эндээ үлдэцгээ” (*Discourses of Brigham Young*, 85).

14. “Их Эзэн Бошиглогч Иосеф Смитийг гарыг нь ганзганд, хөлийг нь дөрөөнд хүргэж, томилон, дэлхий дээр Бурханы Хаант улсыг байгуулах, эл хаант улсыг цаашид авч явах хүч хийгээд түлхүүрүүдийг түүнд өгснийг мэддэгээ санах бүрдээ би Халлелуяа гэж хашгирмаар санагддаг. . . .

15. “Иосеф Смитийн талаар ямар нэг таагүй зүйлийг шударгаар хэлж чадах хүн бий болов уу? Хүн хүнтэй яаж танилцдаг вэ, тийм л байдлаар би түүнтэй танилцсан. Эцэг эх нь түүнийг миний мэддэгээс илүү сайн мэддэг байсан гэдэгт би итгэдэггүй. Миний мэддэгээс түүнийг илүү сайн мэддэг хэн нэгэн газар дээр амьдарч байсан гэдэгт би итгэдэггүй. Харин энэ дэлхий дээр түүнээс илүү сайн нэгэн хүн амьдарч байсныг нь эсвэл амьдарч байгааг нь Есүс Христ хүсэн хүлээгээгүй гэдгийг би зоригтой хэлье. Би бол Түүний гэрч билээ” (*Discourses of Brigham Young*, 458–459).

16. “Их Эзэн тэднээр хийлгэхээр оногдуулсан ажлыг Ерөнхийлөгч, Төлөөлөгчид, Ахлагч нар хийг, тэдэнд өгсөн зөвлөгөөг дуулгавартай дага. Тэгвэл Хаант улс урагш ахиж, хүч чадал, ач холбогдлоороо, хэмжээ болон хүчээрээ, мэргэн ухаан, оюун билиг болон алдар суугаараа өсч хөгжинө. Тэгвэл хэн ч санаа зовох хэрэггүй болно. Учир нь энэ хаант улсыг бидний Их Эзэн Бурхан байгуулсан юм. Энэ хаант улс эхлэлээс өнөөдрийг хүртэл Түүний зүйрлэшгүй мэргэн ухаан, хүчээр өсч өндийн дэгжин дээшилж ирсэн юм” (*Discourses of Brigham Young*, 149).

Уншсанаа судлах нь

“Бригам Янгийн өв”-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий

А Бригам Янгийн тухай асуултууд

Догол мөр 1–6 дахь мэдээлэл, Бригам Янгийн амьдрал ба Ерөнхийлөгчийн Зөвлөл (х.00 165) схемийг ашиглан дараах асуултуудад хариул.



1. Бригам Янг Төлөөлөгчөөр томилогдохдоо хэдэн настай байсан бэ? Сүмийн гишүүн болоод хэр зэрэг удсан байсан бэ?
2. Бошиглогч Иосеф Смитийг Либерти шоронд байхад Бригам Янг юу хийж байсан бэ? (С ба Г 121-ийн тоймыг үз).

3. Бригам Янгийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн үед Сүмд эхэлсэн ямар ажлын улмаас чи өөрөө бас гэр бүл чинь хүлээн авсан таван адислалыг жагсаан бич.

Б Өөрийнхөө үгээр

1. Догол мөр 7, 9, 13–16-гаас гурван догол мөрийг сонгож, тэдгээрийг өөрийнхөө үгээр бич.
2. Бичсэн догол мөр бүрийнхээ дараа, уг сургаалаар хариулагдаж болох ямар асуулт буюу асуудал хүнд тохиолдож болох тухай жишээ гарга. Жишээ нь, догол мөр 10 дахь сургаал нь залбирах дургүй байгаа юм шиг санагдаж байгаа хүнд тусалж болно.

Нотолгоонуудыг харьцуул

1. Дараах судрын хэсгүүдийг уншиж, эшлэлүүдийг тэмдэглэлийн дэвтэртээ багана болгон жагсаан бич: Даниел 2:44–45; Матай 5:48; 2 Нифай 32:8–9; Алма 24:30; Сургаал ба Гэрээ 11:12–14.
2. Догол мөр 7–8, 10, 13, 16-г нэгтгэн дүгнэ. Судрын хэсэг бүрд хамгийн сайн тохирох догол мөрийн дугаарыг эшлэлийн дараа тэмдэглэлийн дэвтэртээ бич.



Ерөнхийлөгч Бригам Янгийг нас барсан тэр даруйгаас эхлэн Гэгээнтнүүдэд хэдэн арван жил их хүндрэл бэрхшээл тохиолджээ. Нэгдсэн Улсын засгийн газар улс төрийн болон шашны шинэчлэгч олон бүлгийн шаардлага, дэмжлэгээр олон эхнэр авах ёсны эсрэг хуулиуд батлан гаргав. Шинэчлэгч бүлгүүд Сүмийн эсрэг мэдээллийн хэрэгслээр ширүүн дайралт дэгдээсэн 1875 онд тэдгээр хуулиудыг албадан хэрэгжүүлж эхэлжээ. Сүм засаг төрийн эрх баригчдын хүчтэй мөрдлөг хавчлагыг эс хайхран, Ерөнхийлөгч Жон Тейлорын чадварлаг удирдлагаар улам өсч хөгжин, өргөжин тэлсээр байлаа.

ТҮҮНИЙ АМЬДРАЛ (1808–1887)

1808 он Арваннэгдүгээр сарын 1-нд Английн Милнторпт Жеймс Тейлор, Агнес Тейлор нарын гэр бүлд төрсөн

1833 он 24 настайдаа, нэгдүгээр сарын 28-нд Леонора Каннонтай гэрлэв. Леонора 1868 онд нас барсан

1836 он 27 настайдаа, тавдугаар сарын 9-нд Канадын Онтариогийн Жоржтаун дахь Блэк Грийкт Леонорагийн хамт баптисм хүртжээ

1838 он Нас 30, арванхоёрдугаар сарын 9-нд Бригам Янг, Хебер К. Кимбалл нар түүнийг Төлөөлөгчөөр томилов

1839–1841 он 31–32 настайдаа, Англид номлолд үйлчлэв

1844 он 35 настайдаа, зургадугаар сарын 27-нд Бошиглогч Иосеф Смит, Хайрум Смит хоёр Картейж Шоронд алагдахад хүнд шархаджээ



1846–1847 он 37–38 настайдаа, Англид хоёр дахь номлолдоо үйлчлэв

1849–1852 он 40–43 настайдаа, Франц, Германд номлолд үйлчлэв. Мормоны Номыг франц, герман хэлээр хэвлүүлжээ

1854–1857 он 45–48 настайдаа, Дорнод мужийн Номлолыг тэргүүлж байв

1877 он 68 настайдаа, Бригам Янг наймдугаар сарын 29-нд нас барсны дараа Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч байсан учраас Сүмийг удирдав

1880 он 71 настайдаа, аравдугаар сарын 10-нд Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав. Ахлагч Жорж К. Каннон, Жозеф Ф. Смит нар зөвлөх нь болов

1887 он 78 насандаа, Сүмийн Ерөнхийлөгч болоод бараг долоон жил болсны дараа, долдугаар сарын 25-нд Ютагийн Кейсвиллд нас барав

ТҮҮНИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ (1877–1887)

1878 он Хүүхдийн Хэсэг зохион байгуулагдав

1880 он Агуу Үнэт Сувдыг судар хэмээн хүлээн авав

1884 он Ютагийн Логан дахь ариун сүмийг онцгойлон адислав

1886–1887 он Сүмийн улам олон гишүүд Мексик, Канадад суурьшин амьдрахаар явав

Ерөнхийлөгч Жон Тейлорын тухай

1. “Ерөнхийлөгч Бригам Янг нас барсны дараа, Жон Тейлорын тэргүүлсэн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга Хожмын Үеийн Гэгээнтнүүдийг гурван жил удирдсан юм. 1880 оны аравдугаар сарын 10-нд Жон Тейлор Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав. Ерөнхийлөгч Тейлор бол Цагаатгалын тухай нэг ном бичиж нийтлүүлсэн, Сүмийн хамгийн чухал зарим тогтмол хэвлэлүүд, түүний дотор *Times and Seasons* болон *Мормон-ыг* хянан тохиолдуулдаг байсан авъяаслаг зохиолч, сэтгүүлч байлаа. Тэрээр олон тохиолдолд, тухайлбал, Картейж шоронд ах нартайгаа сайн дураар очиж нийлэн, тэнд дөрвөн удаа буудуулсан нь түүний эрэлхэг зориг, сэргээгдсэн сайн мэдээнд гүн гүнзгийгээр, хоёргүй сэтгэлээр ханддаг чанарыг нь харуулсан юм. ‘Нэг бол Бурханы хаант улс, нэг бол юу ч хэрэггүй’ гэсэн түүний хувийн уриа Бурханд болон Сүмд тэрээр үнэнч байсныг илтгэн харуулдаг” (*Бидний Өв*, 109).

Уншсанаа ойлгох нь




Ерөнхийлөгч Жон Тейлорын тухай

Тогтмол хэвлэлүүд (догол мөр 1)—Сэтгүүлүүд

Номлолын ажил

2. “Сайн мэдээ дэлхийн бүх өнцөг буланд тунхаглахыг харыхын тулд Ерөнхийлөгч Тейлор чадах бүхнээ хийхэд шийдвэр төгс байсан юм. 1879 оны аравдугаар сарын ерөнхий

чуулган дээр тэрээр Мозес Татчерыг Мексикийн Мехико хотод номлол эхлүүлэхээр Сүмийн хамгийн сүүлчийн Төлөөлөгчөөр дуудав. Ахлагч Татчер өөр нэг номлогчийн хамт 1879 оны арваннэгдүгээр сарын 13-нд Мексик дэх анхны салбарыг Доктор Плотино К. Родаканатийн хамтаар зохион байгуулжээ. Доктор Родаканати испани хэл дээр Мормоны Номын тухай нэг өгүүлэл уншаад, Сүмийн тухай нэмэлт мэдээлэл хүсч Ерөнхийлөгч Тейлорт захидал бичсэний дараа хөрвүүлэгдсэн ажээ.



3. “Арванхоёр гишүүн, гурван номлогчтой гол цөмтэйгөөр сэргээгдсэн сайн мэдээ Мексик хүмүүсийн дунд алгуураар тархаж эхлэв. 1881 оны дөрөвдүгээр сарын 6-нд Ахлагч Татчер, Ферморз Янг, бас нэг ах [Пайз] Попакатепетл Уулан дээр 4742 метр орчим өндөрт явган гарч, онцгойлон адислах товчхон үйлчлэл хийжээ. Ахлагч Татчер Их Эзэний өмнө өвдөг сөгдөн, өөрсдийн жинхэнэ хоньчин Их Эзэний дуу хоолойг сонсохын тулд Мексикийн нутаг, хүмүүсийг нь тэд онцгойлон адислав.

4. “Ахлагч Татчер Солт Лейк хотод эргэж ирээд Мексикт үйлчлэх номлогчдыг нэмж дуудахыг зөвлөмж болгожээ. Удалгүй нэлээд хэдэн залуус, түүний дотор ирээдүйн Тэргүүн Зөвлөлийн гишүүн Антони В. Айвинс Мехико хотод хөдөлмөрлөж байлаа. Мексикийн Номлол дахь Сүмийн хүч чармайлтын нэг хэсэг болж, 1886 онд Мормоны Ном испани хэл дээр хэвлэгдэн гарав. Мормоны Ном болон Сүмийн бусад ном зохиолыг испани хэлэнд орчуулахад тусалсан Мелитон Трехогийн түүх нь Их Эзэн Өөрийн ажлыг хэрхэн чиглүүлдгийг харуулсан байдаг.

5. “Мелитон Трехо Испанид төрж, аливаа шүтлэг бишрэлгүйгээр өссөн аж. Тэрээр Хадат Уулс дахь мормончуудын тухай сонсох үедээ Филиппинд цэргийн алба хааж байсан бөгөөд мормончууд дээр очих оргилуун хүсэл түүнд төржээ. Хожим нь тэр хүндээр өвчилж, Ютад очих ёстой гэж зүүдэлсэн гэдэг. Тэр эдгэрээд Солт Лейк хот руу явав. Тэр Бригам Янгтай уулзаж, сайн мэдээний сонирхогч болсон аж. Тэрээр үнэнийг олсондоо баг итгэлтэй байлаа. Тэгээд Сүмийн гишүүн болов. Тэр Мексикт номлолд үйлчилсэн бөгөөд испани хэлээр яригч хүмүүс Мормоны Номыг төрөлх хэлээрээ унших боломжтой болоход нь гол үүрэг гүйцэтгэхээр сүнслэг байдлаар болон оюун ухаанаар бэлтгэгдсэн ажээ.

6. “Ерөнхийлөгч Тейлор бас Америкийн Өрнөдөд амьдарч байсан индианчуудад сайн мэдээг хүргэх номлогчдыг дууджээ. Вайомингийн Винд Ривер Резервшинд оршин сууж байсан шошоне овгийн дунд Амос Врайтын хөдөлмөр онцгой үр дүнтэй байлаа. Хэдхэн сар үйлчилсний дараа Врайт 300 гаруй хүн, түүний дотор овгийн ахлагч Вашакид баптисм хүртээжээ. Хожмын Үеийн Гэгээнтэн

номлогчид бас Аризона, Нью-Мексикт амьдарч байсан навахо, пуебло, зунис овгийнхонд сайн мэдээг хүргэв. Вилфорд Вудрафф индианчуудын дунд, түүний дотор хоппи, апачи, зунисчуудын дунд номлон, бүтэн жилийг өнгөрөөжээ. Аммон М. Тенни Зунийн 100 гаруй индианчуудад баптисм хүртэхэд нь тусалсан ажээ.



7. “Номлогчид Англи, Европт сайн мэдээг заахаа үргэлжлүүлж байв. Ютагийн Лихайд амьдарч асан, Германд төрсөн Томас Байзингер Европын номлолд үйлчлэх дуудлагыг 1883 онд хүлээн авав. Пол Хаммер тэр хоёр тухайн үед Австри-Унгарын эзэнт гүрний нэг хэсэг байсан Чехословакийн Прага руу илгээгджээ. Шашин номлохыг номлогчдод хориглосон учраас тэд уулзсан хүмүүстэйгээ энгийн яриа хөөрөө өрнүүлдэг байв. Тэдгээр ярианууд шашны сэдэв рүү орох нь олонтаа байдаг байлаа. Ийм байдлаар ганцхан сар ажилласны дараа Ахлагч Байзингер баривчлагдаж, хоёр сар шоронд хоригдов. Тэр суллагадад Антонин Иостад баптисм хүртээж, адислагдсан боловч, үүнд буруутгагдсан нь түүнийг баривчлагдахад хүргэжээ. Иост ах Чехословакийн анхны Хожмын Үеийн Гэгээнтэн болсон ажээ. [Калиле Мехр, “Enduring Believers: Czechoslovakia and the LDS Church, 1884–1990,” *Journal of Mormon History* (1992 оны намар), 112–113-ыг үз.]



8. “Сайн мэдээг бас Полинезид номлож байв. Хавайн хоёр хүн Ахлагч Кимо Пелио, Самуела Маноа хоёрыг 1862 онд Самоа руу илгээв. Тэд 50 орчим хүнд баптисм хүртээж, ахлагч Маноа хөрвөгчдийнхөө хамт дараагийн 25 жилийн турш Самоад амьдарсан ажээ. 1887 онд Ютагийн Солт Лейк хотын Жозеф Х. Дийн Самоад үйлчлэх дуудлага

хүлээн авав. Ахлагч Маноа түүний итгэлт гэргий хоёр хорь гаруй жилд Самоад гаднаас ирсэн анхны Хожмын Үеийн Гэгээнтнүүд, Ахлагч Дийн, түүний гэргий Флоренс нарт хаалгаа нээн өгчээ. Ахлагч Дийн удалгүй 14 хүнд Сүмд баптисм хүртээж, сар орчмын дараа самоа хэл дээр анхныхаа номлолыг хийсэн гэдэг. [Р. Ланиер Бритц, *Unto the Islands of the Sea: A History of the Latter-day Saints in the Pacific* (1986), 352–54-ийг үз]. Тийнхүү номлолын ажил тус арал дээр шинээр эхэлсэн аж.

9. “1866 оноос эхлэн, уяман яр өвчин тархахаас сэрэмжлэн Хавайн эрх баригчид эл өвчнөөр зовж шаналсан хүмүүсийг Молкай арал дээрх Калауапа хойг руу гаргажээ. Хожмын үеийн Гэгээнтнүүд болох Жонатан Напела, Китти Напела нар 1873 онд тэнд хөл хоригдов. Зөвхөн Китти л өвчилсөн байсан ч, харин Солт Лейкийн Хишгийн Ордонд лацдан холбуулсан Жонатан түүнийг ганцааранг нь орхихыг хүсээнгүй. Жонатан хожим нь өвчний халдвар авч, есөн жилийн дараа нэг сайн найз нь түүн дээр хүрч ирэхэд танигдахын аргагүй болсон байв. 1900 он гэхэд 200 гаруйгаар тоологдож байсан тус хойг дээрх Гэгээнтнүүдийг тэрээр хэсэг хугацаанд тэргүүлж байв. Энэхүү тамирдуулагч өвчнөөр зовон шаналж байсан атлаа салбартаа байнга ирж, сүнсний хэрэгцээгээ залгуулж байсан итгэлтэй гишүүдийг Сүмийн удирдагчид мартаагүй юм. [Лий Г. Кантвелл, “The Separating Sickness,” *This People* (1995 оны зун), 58.]” (*Бидний Өв*, 111–112).

Уншсанаа ойлгох нь



Номлолын ажил

Гол цөм (догол мөр 3)—
Үндсэн гол хэсэг

Буруутгах (догол мөр 7)—
Буруу зүйлд яллах, зэмлэл
хүлээлгэх

Уяман яр (догол мөр 9)—
Арьсны хүнд өвчин
Хөл хорих (догол мөр 9)—
Өөр тийш явахыг хориглох

Ойн баярын чуулган

10. “1880 оны дөрөвдүгээр сарын 6-нд, Сүмийн гишүүд Сүм зохион байгуулагдсаны тавин жилийн ойг тэмдэглэв. Эртний израилчууд тавь дахь жил бүрийг нэрлэдэг заншлаар хүмүүс энэ жилийг Ойн жил гэж нэрлэжээ. Ерөнхийлөгч Тейлор Сүмийн гачигдалтай гишүүдийн Сүмд төлөх ёстой байсан олон өрийг уучлав. Сүм бас 300 үхэр, 2.000 хонийг ‘тусламж авах ёстой ядуучуудад’ хуваарилан олгожээ [Робертс, *Comprehensive History of the Church*, 5:592-ыг үз.] Сүмийн Нийгмийн Халамжийн Бүлгийн эгч нар бараг 35.000 бушель (1 бушель = 36,3 литр; 35.000x36.3=1.270.500л) улаан буудайг гачигдалтай хүмүүст тусламж болгон өгсөн аж. Ерөнхийлөгч Тейлор хувийн өрийг, ялангуяа зовж зүдрэгсдийн өрийг уучлахыг Сүмийн гишүүдээс шаргуухан хүсчээ. “Энэ бол Ойн баярын үе шүү дээ!” хэмээн тэрээр мэдэгдсэн аж [Робертс, *Comprehensive History of the Church*, 5:593]. Хожмын Үеийн Гэгээнтнүүд уучлалын болон баяр баяслын сүнснийг оргилуунаар мэдэрч байлаа.

11. “Ойн баярын жилд зориулсан 1880 оны дөрөвдүгээр сарын ерөнхий чуулганы сүүлчийн өдөр ер бусын сэтгэл догдлом байлаа. Арванхоёр Төлөөлөгчийн арван нэг нь төгсгөлийн хуралдаан дээр гэрчлэлээ хэлэв. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын анхны гишүүдийн нэг Оорсон Пратт Сүм бүхлээрээ Нью-Йоркийн Фейетте дэх Ахмад Петр Витмерийн гэрт цугладаг байсан үеийн тухай ярьжээ. Тэрээр Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн хүнд сорилт, цугларалт, мөрдлөг хавчлага, түмэн зовлон зүдгүүрийг эргэн санаж, өөрөө эдүгээг хүртэл ‘энэ хүмүүстэй хамт тоологдож байгаадаа’ баяртай байдаг гэв. Дараа нь тэрээр Их Эзэн бидний Бурханы ‘өнгөрсөн тавин жилд хийсэн агуу ажлын талаар гэрчлэлээ хэлэв’ [Робертс, *Comprehensive History of the Church*, 5:590–591]. Ахлагч Пратт амьд явах нь ердөө хэдхэн сар үлдсэн ч, итгэлтэй Хожмын Үеийн Гэгээнтэн болж, эцсийг хүртэл тэвчсэндээ баяртай байлаа.



Оорсон Пратт



12. “Ойн баярын жилийг тэмдэглэхээс хоёр жилийн өмнө Ерөнхийлөгч Жон Тейлор шашны зааврыг хүүхдэд хүргэх байгууллага үндэслэн бий болгохыг зөвшөөрчээ. Анхны Хүүхдийн Хэсэг, Солт Лейк хотоос хойш 24 км орчимд орших Ютагийн Фармингтонд ажиллаж эхэлсэн бөгөөд 1880-аад оны дунд үе гэхэд Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн бараг бүх суурин газруудад Хүүхдийн Хэсэг зохион байгуулагдсан байв. Хүүхдийн Хэсэг сайн мэдээний заавар, хөгжим болон долоо хоног бүр тэдэнд таалагддаг уулзалтуудаар адислагдаж, дэлхий даяарх сая сая хүүхдийг эгнээндээ багтаан өргөжин хөгжсөөр байна” (*Бидний Өв*, 96).

Мөрдлөг хавчлага үргэлжлэв

13. “Бошиглогч Иосеф Смит 1830-аад оны эхэн үеэр Библийн орчуулга дээр ажиллаж байх үедээ Абрахам, Иаков, Петр болон Хуучин Гэрээний бусад удирдагчид нэгээс олон эхнэртэй байсан баримтын учрыг олоогүй ажээ. Бошиглогч ойлголтын төлөө залбирав. Тэгээд тодорхой цаг үед, өвөрмөц зорилгын учир, бурханлигаар өгөгдсөн хуулиудыг баримтлан, олон эхнэр авах ёсыг Бурхан зөвшөөрч, чиглүүлж байсныг мэджээ. Хожмын Үеийн Гэгээнтнүүд бурханлиг зөвшөөрлөөр нэгээс илүү эхнэртэй гэрлэх нь санваарын эрх мэдлээр удахгүй зөвшөөрөгдөж болохыг Иосеф Смит бас мэдсэн аж. Нэлээд олон Хожмын Үеийн Гэгээнтэн Наувуд олон эхнэр авсан боловч, энэ сургаал болон практикийн тухай Солт Лейк хотод болсон 1852 оны наймдугаар сарын ерөнхий чуулганыг хүртэл нийтэд зарлан мэдэгдээгүй байсан аж. Тэр чуулган дээр Ахлагч Оорсон Пратт, Ерөнхийлөгч Бригам Янгийн чиглүүлснээр,

эрэгтэй хүн нэгээс илүү эхнэр авах зуршил нь Их Эзэн бүх зүйлийг дахин бий болгосны нэг хэсэг мөн хэмээн мэдэгджээ (Үйлс 3:19–21-ийг үз).

14. “Ёс суртахуунгүй бөгөөд Христийн бус хэмээн өөрсдийнх нь үздэг гэрлэлтийн тогтолцоог Ютад амьдарч байсан Хожмын Үеийн Гэгээнтнүүд өөгшүүлэн дэмжиж байгааг Америкийн шашны болон улс төрийн олон удирдагч мэдээд ихэд уурлан хилэгнэсэн ажээ. Сүмийн эсрэг мөн гишүүдийнх нь эсрэг улс төрийн ширүүн дайн дэгдлээ. Нэгдсэн Улсын Конгресс Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн эрх чөлөөг хязгаарласан, Сүмийг эдийн засгийн хувьд хохироосон хууль тогтоомж батлан гаргав. Эл хууль тогтоомж эцэстээ Сүмийн удирдагчдыг баривчилж, нэгээс илүү эхнэртэй эрчүүдийг шоронд хорьж, сонгуульд санал өгөх, гэр орондоо амар амгалан аж төрөх болон иргэний бусад эрх чөлөөг эдлэх эрхийг нь хасахад хүргэв. Хожмын Үеийн итгэлтэй Гэгээнтэн хэдэн зуун эрчүүд, мөн цөөн тооны эмэгтэйчүүд Юта, Айдахо, Аризона, Небраск, Мичиган, Өмнөд Дакотад хэсэг хугацаагаар шоронд суужээ.



15. “Сайн мэдээг номлох дуудлага хүлээн авсан олон хүмүүсийн хувьд, ялангуяа Нэгдсэн Улсын өмнөд хэсэгт мөрдлөг хавчлага бас гаарав. Жишээ нь, Ахлагч Жозеф Стандинг Жорж Ромын ойролцоо ажиллаж байгаад 1878 оны долдугаар сард харгис хэргийгээр алагдсан байна. Түүний хамтрагч, ирээдүйн Төлөөлөгч Ражер Клоосон үхлээс арай ядан мултарчээ. Солт Лейк хот дахь Гэгээнтнүүд Ахлагч Стандинг алагдсан тухай мэдээнд ихэд цочирдон, Солт Лейкийн Табернеклд болсон түүний оршуулах ёслолд мянга мянган хүмүүс оролцжээ.

16. “Ахлагч Жон Гиббс, Виллям Берри, Виллям Жөүнс, Хенри Томпсон нар Сүмийн талаарх олон нийтийн ойлголтыг өөрчлөхийг хичээн Теннесийн ихэнх нутгаар хөндлөн гулд аялсан аж. Тэд Теннесий дэх Кейн Грийкийн ойролцоо Жеймс Кондорын гэрт 1884 оны наймдугаар сард Хүндэтгэлийн нэг өдрийн өглөө амарч байв. Ахлагч Гиббс номлолдоо тохирох сэдэв хайж, судар үзэж байтал, танхайрагч бүлэг ойгоос гарч ирэн буудаж эхлэх нь тэр. Ахлагч Гиббс, Ахлагч Берри хоёр алагдав. Сургуулийн багш Ахлагч Гиббс, эмгэнэн гашуудсан эхнэр, гурван хүүхдээ өнчрүүлэн талийгаач болов. Гиббс эгч 43 жил бэлэвсэн хэвээр үлдсэн юм. Тэрээр үр хүүхдээ өсгөн тэжээхийн тулд эх баригч болов. Тэрээр нөхөртэйгөө эргэн уулзахыг хүсэн хүлээж, сайн мэдээнд итгэлтэй хэвээр нас барсан ажээ. Аллагын үед номлолын гүйцэтгэх ерөнхийлөгч байсан Бригам Хенри Робертс, Гиббс, Берри нарын цогцсыг ухан гаргаж авахаар зүсээ хувирган явж, амь насаараа дэнчин тавьсан юм. Цогцсуудыг Ютад авчрахад олон гадас сайхь хоёр ахлагчид хүндэтгэл үзүүлсэн дурсгалын үйлчлэл хийжээ.

17. “Бусад бүсүүд дэх номлогчид нуруунаасаа цус гартал занчуулж, тэднээс олон нь ташуурын шарх сорвитойгоор хадан гэртээ одсон билээ. Сүмийн гишүүн байна гэдэг хэцүү цаг үе байлаа.

18. “Сүмийн олон удирдагч, нэгээс илүү эхнэртэй эрчүүдийг хайж байсан холбооны ажилтнуудад баривчлагдахаас зайлсхийн нуугдаж байлаа. Тэдгээр ажилтнууд бас гэрийнхэн нь шөнө гэр оронд нь дайран орж ирэхээс айдаг байв. Ерөнхийлөгч Жорж К. Каннон, Лорензо Снөү, Ражер Клоосон, Бригам Хенри Робертс, Жорж Ренольдс болон бусад олон хүмүүс шоронд оров. Тэд тэнд ном бичиж, сургуульд заан, гэр орныхондоо захидал бичиж цагийг өнгөрүүлдэг байжээ. Ерөнхийлөгч Жон Тейлорыг Солт Лейк хотоос хойш 32 км орчимд орших Ютагийн Кейсвиллд албадан цөлсөн юм. Тэрээр тэнд 1887 оны долдугаар сарын 25-нд нас баржээ. Жон Тейлор бол Есүс Христийн тухай гэрчлэх болон дэлхий дээр Бурханы хаант улсыг үндэслэн байгуулахад хоёргүй сэтгэлээр амьдралаа зориулсан, гүн итгэлтэй, эрэлхэг зоригтой хүн байсан юм” (Бидний Өв, 115, 116–117).

Уншсанаа ойлгох нь



Мөрдлөг хавчлага үргэлжлэв


Хууль тогтоомж (догол мөр 14)—Хуулиуд

Иргэний эрх чөлөө (догол мөр 14)—Хуулиар олгогдсон эрх чөлөө ба үндсэн эрхүүд

Эх баригч (догол мөр 16)—Төрөхөд нь эмэгтэйчүүдэд тусалдаг хүн

Дайран орж ирэх (догол мөр 18)—Хууль бусаар орж ирэх

Жон Тейлорын сургаал ба гэрчлэл



19. “Та нар гэртээ залбирдаг уу? . . . Та нар залбирахдаа машины хөтлөгч эд анги ажиллаж байгаа юм шиг л байдаг уу, эсвэл номхон дөлгөөн байдалд, чин сэтгэлээсээ Бурханы адислалыг өөр дээрээ, гэр орондоо хүсч залбирдаг уу? Бид өөрсдийгөө Түүнд зориулан, адислалуудыг нь эрэлхийлэн, бие сэтгэлээ зориулах сүнснийг, Бурханд итгэх итгэлийг тарин соёолуулах тийм арга замаар залбирах ёстой”

(in *Journal of Discourses*, 21:118).

20. “Хэрэв та дуудлагаа эрхэмлэн биелүүлдэггүй бол, өөрийн тань аварч болох хийгээд үйлчлэлээ зориулах хүмүүсээс Бурхан үүргийг чинь татан авна” (in *Journal of Discourses*, 20:23).

21. “Бид муу нөлөөнд автагдахгүй байхын тулд бүх итгэлээ, бүх эрч хүчээ, бүх найдвараа Бурханд тавихыг шаардах ирээдүйн үйл явдлууд тийм ч хол биш байна. . . . Бид оюун ухаандаа итгэж болохгүй. Бид эд баялагтаа найдаж болохгүй. . . . Биднийг удирдан, чиглүүлэх, биднийг хөтлөн, зааж зааварлах амьд Бурханд л бид итгэх ёстой” (Жозеф Фиелдинг Смит, *Essentials in Church History*, 23 дахь хэвлэл, [1969], 479-өөс эш татжээ).

22. “Бурханы гэгээнтнүүд итгэл бишрэлээрээ амьдарч, Бурханы зарлигуудыг сахихаас өөр ямар ч зүйл тэдний

дундах юмсыг сайн болгож чадахгүй. Тэд ингэхгүй бол, юмс өөдтэй байхаа больж, зөв замаас гажиж, үргэлж буруугаар эргэх болно. Харин тэд итгэл бишрэлээрээ амьдарч, зарлигуудыг сахих юм бол, "тэдний амар амгалан голын ундрага лугаа адил оргилж, зөв шударга байдал далайн давалгаа лугаа адил эрчтэй байх болно" (in *Journal of Discourses*, 26:71).

23. "Хэрэв ямар ч хүн гэр бүл, найз нөхдийнхөө дунд амар амгаланг бий болгохыг хүсвэл, амар амгаланг эхлээд зүрх сэтгэлдээ суулган бий болгог. Учир нь цэвэр амар амгалан нь зөвхөн тэнгэрийн хууль ёсны дүрэм журам, эрх мэдлийн дагуу, мөн тэдгээрийг дуулгавартай дагаснаар биеллээ олж чадна" (*The Gospel Kingdom: Selections from the Writings and Discourses of John Taylor*, эмхтгэсэн Г. Хомер Дурхам [1943], 319).

24. "Хэрэв хүн Бүхнийг Чадагчийн сүнсний нөлөөгөөр л бус аваас зөвийг ярьж чадахгүй. Мөн тэдэнд Түүний Сүнсний мэдрэмж байхгүй аваас зөвийг сонсож, зөвийг ойлгож чадахгүй" (*Gospel Kingdom*, 337–338).

25. 1885 оны дөрөвдгээр сард ерөнхий чуулган дээр уншсан захидалд Тэргүүн Зөвлөл мэдэгдсэн нь: "Бурхан Өөрийн Сионыг үндэслэн байгуулсныг, Түүний ажил урагш ахих болно гэдгийг, мөн Сионы эсрэг тэмцсэн бүхэн мөхнө гэдгийг бид өнгөрсөн үед олонтаа мэдэгдэж байсан билээ. Үүнийг эдүгээ Хожмын Үеийн Гэгээнтнүүд болон дэлхий дахинд хүндэтгэлтэйгээр гэрчилж байна." (Жеймс Р.



Кларкийн эмхтгэсэн, *Messages of the First Presidency of The Church of Jesus Christ of Latter-day Saints*, боть 6 [1965–1975], 3:12).

26. "Энэ гэрчлэлийг хэлэх зүйрлэшгүй агуу хүсэл надад төрдөг. Их Эзэний үг яс маханд минь шингэх лугаа адил болж, эцсийн өдрүүд дэх дэлхийн авралын төлөө Бурхан бидэнд илчилсэн алдар суут зүйлст та бүгд бидэнтэй хамт баясан цэнгэж болохын тулд та бүхний эрж хайдаг тэдгээг адислалуудыг та нарт тунхаглах боломж надад байгаасай хэмээх хүслэн надад төрдөг." (Б. Х. Робертс, *The Life of John Taylor* (1963), 78).

Уншсанаа ойлгох нь




Жон Тейлорын сургаал ба гэрчлэл

Тэргүүн Зөвлөлийг шинэчлэн зохион байгуулахад гарсан өөрчлөлт

Ерөнхийлөгч Бригам Янгийг нас барахад Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга, чуулгынхаа ерөнхийлөгч Жон Тейлорын жолоодлогоор Сүмийг удирдсан юм. Тэргүүн Зөвлөлийг өөрчлөн зохион байгуулж, 1880 оны аравдугаар сарын ерөнхий чуулган дээр гишүүд дэмжин батлав.

Ерөнхийлөгч Тейлорыг нас барахад, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга нь Чуулгын Ерөнхийлөгч Вилфорд Вудраффын хамт Сүмийг дахин тэргүүлсэн юм. Хоёр жилийн дараа 1889 оны ерөнхий чуулганы үеэр Тэргүүн

Зөвлөл өөрчлөн зохион байгуулагдаж, Вилфорд Вудрафф Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав.



Ерөнхийлөгч Вудрафф таалал төгсөхөөсөө бараг зургаан жилийн өмнө Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Лоренцо Снөүтэй ганцаарчлан уулзжээ. Ерөнхийлөгч Вудрафф "агуу санаа тавилт, эрч хүчээр" Ерөнхийлөгч Снөүгээс: "Би танаас чухалчлан хүсэх нэг зүйл байна. Та үүнийг биелүүлээрэй. Хэдэн сарын өмнө Сейнт Жоржид очих үеэрээ би бараг л мажийчих шахлаа. Эхнэр маань мэдээгүй байгаа. Би чухам хэзээ нүд анихаа мэдэхгүй байна. Харин намайг хадан гэртээ харимагц Тэргүүн Зөвлөлийг яаралтай өөрчлөн зохион байгуулахыг танаас хүсье, Снөү ах аа" гэж хүсчээ. Ерөнхийлөгч Вудрафф үүнийг илчлэлт гэж үзэхийг түүнээс хүсчээ ("Memorandum in the Handwriting of President Lorenzo Snow," *Elders' Journal*, 1906 оны 12-р сарын 1, 110–111).

1898 оны есдүгээр сарын 2-нд Ерөнхийлөгч Вудраффыг нас барсны дараа, Ерөнхийлөгч Снөүг ариун сүмийн үүдний өрөөгөөр дамжин өнгөрөх үед Аврагч өмнө нь гарч иржээ. Тэрээр Ерөнхийлөгч Вудраффыг залгамжлах ёстойг Аврагч түүнд хэлсэн аж. "Тэр даруй цааш явж, өмнөх ерөнхийлөгч нас барсны дараа хүлээлгүйгээр Сүмийн Тэргүүн Зөвлөлийг өөрчлөн зохион байгуулахыг" түүнд зааварлажээ (ЛиРой К. Снөү, "Remarkable Manifestation to Lorenzo Snow," *Church News*, 1938 оны 4-р сарын 2, 8). Ерөнхийлөгч Вудраффыг оршуулсны маргааш нь Төлөөлөгчид хуралдаж, Лоренцо Снөүг Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжин батлав. Өнөөдрийг хүртэл, өмнөх ерөнхийлөгч нас барснаас хойш богинохон хугацаанд Сүмийн шинэ ерөнхийлөгчийг дэмжин баталдаг.

Уншсанаа судлах нь



"Ерөнхийлөгч Жон Тейлор"-ыг судлахдаа үйл ажиллагаа А буюу Б, эсвэл В буюу Г-г хий

А Сонины мэдээ бич

1860–1900 оныг хүртэл, Нэгдсэн Улс дахь улс төрийн болон шашны бүлгүүд Гэгээнтнүүдийг мөрдөн хавчиж, Сүмийг устгахыг хичээж байв. Эдгээр хүнд сорилтуудыг эс хайран, номлолын болон ариун сүмийн ажил өсч хөгжсөөр байлаа. "Ерөнхийлөгч Жон Тейлор"-ын тухай уншсан зүйл дээрээ тулгуурлан, Түүний удирдлагын үед гарсан Сүмийн өсөлт хөгжилтийг дүрсэлсэн сонины өгүүлэл бич. Өгүүлэлдээ дараах асуултуудад хариул:

1. Дэлхийн ямар орнуудад номлогчид шинээр амжилт олсон бэ?
2. Энэ үед ариун сүмүүд ямар ажил хийж байсан бэ?
3. Одоогоос дөчин жилийн дараа Сүм нийт хэчнэн гишүүнтэй байна гэж чи тооцоолж байна вэ?
4. Их Эзэний ажлыг өсөлт дэвшлээс нь зогсоохыг хүмүүс яагаад хичээдэг гэж чи боддог вэ?

Б Баяр баяслын шалтгаанууд

Догол мөр 10–11-ээс мэдсэн зүйлүүдээрээ, дараах даалгаврыг бөглө:

1. Ерөнхийлөгч Жон Тейлор 1880 оныг яагаад “Ойн Жил” гэж нэрлэснийг тайлбарла.
2. 1830 оноос 1880 оныг хүртэл Сүм өөрчлөгдсөн үзүүлэлтүүдийг жагсаан бич.
3. Аз жаргалаа харуулахын тулд Сүм болон гишүүд юу хийснийг жагсаан бич.
4. Чиний амьдралын үед Сүм өсч хөгжсөн наад тал нь хоёр арга замыг бичиж, яагаад сайн мэдээнд баяр баясалтай байна гэж бодлогоо тайлбарла.

В Жон Тейлорын амьдрал ба Ерөнхийлөгчийн Зөвлөл

1. Сургаал ба Гэрээ 118:1, 6; 124:127–129; 135-ын тойм, 1–2; 138:53–56-г судал. Эдгээр хэсэг тус бүрээс Ерөнхийлөгч Тейлорын тухай юу мэдсэнээ жагсаан бич.
2. Ерөнхийлөгч Тейлорын амьдрал, Ерөнхийлөгчийнх нь Зөвлөлийн (х.00. 173–174) тухай схемэн дэх мэдээллээр мөн догол мөр 1, 12, 18-аас дараах асуултуудад хариул:
 - а. Жон Тейлор баптисм хүртэхдээ хэдэн настай байсан бэ? Картейж шоронд тэр хэзээ шархадсан бэ? Ерөнхийлөгч Бригам Янг хэзээ нас барсан бэ? Жон Тейлор хэзээ нас барсан бэ?
 - б. Хүүхдийн Хэсэг зохион байгуулагдахад Сүм дэх түүний албан тушаал юу байсан бэ?
 - в. 1880 оны аравдугаар сарын ерөнхий чуулган дээр ямар хоёр чухал үйл явдал болсон бэ?

Г Түүний үлгэр жишээг дага

Догол мөр 19–26 тус бүрд зориулан, Ерөнхийлөгч Жон Тейлорын сургаалууд болон зөвлөгөөнөөс өнөө үед Сүмийн гишүүн хэрэглэж болох ямар нэг зүйлийг бич.



Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф олон эхнэр авах ёс дуусгавар болсныг зарлахад Сүмийн эсрэг засгийн газрын өргөн

кампанит ажил зогссон ажээ. Юта Нэгдсэн Улсын засгийн газрын бүрэн төлөөлөлтэй муж болж, Солт Лейкийн Ариун сүм бүрмөсөн дуусч, онцгойлон адислагдав. Гэвч, орон нутгийн болон үндэсний сонинууд дахь мэдээллийн хэрэгслийн сөрөг кампанит ажил Сүм болон гишүүдийг нь гутаан доромжлохоо үргэлжлүүлээр байлаа.

ТҮҮНИЙ АМЬДРАЛ (1807–1898)

1807 он	Гуравдугаар сарын 1-нд Коннектикатын Авонд (одоогийн Фармингтон), Афек Вудрафф, Биола Томпсон Вудрафф нарын гэр бүлд төрсөн	
1833 он	26 настайдаа, арванхоёрдугаар сарын 31-нд Нью-Йоркийн Ричландын ойролцоох мөстэй горхинд баптисм хүртжээ	
1834–1836 он	27–29 настайдаа, Нэгдсэн Улсын өмнөдөд номлолд үйлчлэв	
1837 он	30 настайдаа, дөрөвдүгээр сарын 13-нд Фоиб Картертай гэрлэв. Фоиб Картер 1885 онд нас баржээ	
1837–1838	30–31 настайдаа, Нэгдсэн Улсын дорнодод болон Фокс (Баруун өмнөд Аляска дахь Алеутын арал дээр жижиг цуваа арлууд) арлууд дээр номлолд үйлчлэв	
1839 он	32 настайдаа, дөрөвдүгээр сарын 26-нд Бригам Янг түүнийг Төлөөлөгчөөр томилжээ	
1839–1841 он	32–34 настайдаа, Их Британид номлолд үйлчлэв	
1843 он	36 настайдаа, Нэгдсэн Улсын дорнодод номлолд үйлчлэв	
1844–1846 он	36–39 настайдаа, Европын Номлолын ерөнхийлөгчөөр үйлчлэв	
1847 он	40 настайдаа, долдугаар сарын 24-нд Бригам Янгтай хамт Их Солт Лейкийн Хөндийд хүрч ирэв	
1887 он	80 настайдаа, Ерөнхийлөгч Жон Тейлорыг нас барсны дараа долдугаар сарын 25-нд Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч байсан учир Сүмийг удирдав	
1889 он	82 настайдаа, дөрөвдүгээр сарын 7-нд Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав; Жорж К. Каннон, Жозеф Ф. Смит нар Тэргүүн Зөвлөлийн зөвлөхөөр хэвээр үлдэв	
1898 он	91 настайдаа, Сүмийн Ерөнхийлөгч болсноос хойш есөн жилийн дараа есдүгээр сарын 2-нд Калифорнийн Сан Францискод нас барав	


ТҮҮНИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ (1887–1898)

- 1888 он** Тавдугаар сарын 17-нд Ютагийн Мантай дахь ариун сүмийг онцгойлон адислав
- 1890 он** “Тунхаг Бичиг” (Албан Тунхаг 1) Сүмд өгөгдөв. Долоо хоногийн ажлын өдрүүдэд хичээллэх шашны боловсролын хичээл эхлэв
- 1893 он** Солт Лейкийн Ариун сүмийг онцгойлон адислав
- 1894 он** Угийн бичгийн (гэр бүлийн түүхийн ажил) болон нас барагсдын өмнөөс хийх ариун сүмийн ажилд онцгой анхаарал хандуулдаг болов
- 1896 он** Сар бүрийн эхний ням гарагийг Сүмд мацгийн өдөр болгон сонгов

Ерөнхийлөгч Вилфорд Вудраффын тухай

1. “Вилфорд Вудрафф бол Сүмийн хамгийн амжилттай номлогчдын нэг байсан юм. Тэрээр бас бошиглолын зөн билгээрээ, Сүмд үнэнчээрээ нэрд гарсан нэгэн байлаа. Вилфорд Вудрафф Сүмийн эхэн үеийн түүхийн талаар маш их мэдээлэл агуулсан нягт нямбай тэмдэглэл хөтөлдөг байжээ. Жон Тейлорыг нас барахад тэрээр Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгчөөр үйлчилж байв. Тэрээр бараг хоёр жилийн дараа Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагджээ.

2. “Түүний удирдлагын жилүүдэд Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн эсрэг улс төрийн дайн улам эрчимжсэн ч, Сүм урагш ахисан юм. Ютагийн гурван хотхон-Сейнт Жорж, Логан, Мантайд ариун сүмүүд ажиллаж байснаас гадна Солт Лейкийн Ариун сүм дуусах дөхөж байв. Их Эзэний эдгээр өргөөнүүд хувийнхаа хишгийг хүртэх болон нас барсан төрөл төрөгсдийнхөө өмнөөс ёслол үйлдэх боломжийг Гэгээнтнүүдэд олгосон билээ. Ерөнхийлөгч Вудрафф ариун сүмийн болон гэр бүлийн түүхийн ажилд насан туршдаа сонирхолтой байжээ. Тэрээр олон үйл явдлаар тохиолдуулан ариун сүмд өвөг дээдсийнхээ өмнөөс ёслол гүйцэтгэхийг Гэгээнтнүүдэд зөвлөдөг байв.



3. “Нас барагсдын өмнөөс Гэгээнтнүүдийн гүйцэтгэж байсан ажлын чухал ач холбогдлыг дараах үйл явдал тод харуулдаг. 1884 оны тавдугаар сард, Логаны Хоёрдугаар Хэсгийн бишоп Хенри Баллард ариун сүмийн зөвшөөрлийн бичгүүдэд гэртээ гарын үсэг зурж байв. Гэрийнхээ ойролцоох явган хүний зам дээр найз нартайгаа ярилцаж байсан, Хенригийн есөн настай охин ахимаг насны хоёр хүн ойртон ирж явахыг харсан ажээ. Тэд түүнийг дуудаж, нэг сонин өгөөд, аавдаа аваачиж өг гэв.

4. “Охин тэр хүний хүссэн зүйлийг ёсчлон биелүүлсэн аж. Өөрийнх нь болон аавынх нь танилуудын 60 гаруй нэр, мөн угийн бичгийн мэдээлэл агуулсан, Англид хэвлэгдсэн *Newbury Weekly News* сонинг бишоп Баллард харав. 1884

оны тавдугаар сарын 15-наар хаяглагдсан энэ сонин хэвлэгдсэнээсээ хойш гуравхан хоногийн дараа түүнд ирсэн байв. Агаарын тээвэр гарахаас хамаагүй өмнө, Англиас өрнөд Америк хүртэл шуудан хэдэн долоо хоног болж ирдэг үед энэ нь үнэхээр гайхамшиг байлаа.

5. “Маргааш нь бишоп Баллард сонинг ариун сүм рүү авч очин, уг сонин хүрч ирсэн түүхийг ариун сүмийн ерөнхийлөгч Марринер В.Меррилд ярьжээ. ‘Баллард ах аа, нөгөө талд байгаа хэн нэгэн өөрсдийнх нь төлөө ажил хийгдээсэй гэж ихэд санаа тавьсан юм байна. Тэгээд таныг энэ ажлыг хийнэ гэдгийг мэдэж байсан болохоор энэ сонинг таны гарт оруулсан хэрэг’ гэж Ерөнхийлөгч Баллард хэлжээ [Melvin J. Ballard: *Crusader for Righteousness* (1966), 16–17-г үз.]. Энэ сонин эдүгээ Ютагийн Солт Лейк хот дахь Сүмийн Түүхийн Номын санд хадгалагдаж байдаг.

6. “Сүмийн удирдагчид мөрдлөг хавчлагыг эс хайхран Америкийн өрнөд дэх хүн суурьшаагүй нутгуудыг эзэмшихийг урамшуулан дэмжсээр байлаа. 1885 оноос эхлэн, Хожмын Үеийн Гэгээнтэн олон гэр бүл Жуарез Эзэмшил, Диаз Эзэмшил зэрэг хотхонуудыг үндэслэн, Мексикийн Сонора, Чихуахуад суурьшжээ. Умард Мексик дэх бусад нутгууд мөн цагаачлагч Сүмийн гишүүдийг хүлээн авчээ.



7. “Сүмийн гишүүд бас умард зүгт Канадад эзэмших газар эрж байлаа. Кач Валли гадасны ерөнхийлөгчөөр үйлчилж байсан Чарльз О.Кард 1886 онд Өмнөд Альбертад Хожмын Үеийн Гэгээнтний нэгдлийг үндэслэн бий болгов. 1888 оны өвөл гэхэд өрнөд Канадад 100 гаруй Хожмын Үеийн Гэгээнтэн амьдарч байсан бол 1890-ээд оны үед улам олон хүмүүс ирж, услах систем болон төмөр зам барихад ажиллах хүчээр хангажээ. Сүмийн олон удирдагч Альбертад өсөн төлөвшсөн юм” (*Бидний Өв*, 116–117).

Уншсанаа ойлгох нь



Ерөнхийлөгч Вилфорд Вудраффын тухай

Хишиг (догол мөр 2)—
Ариун сүмд гүйцэтгэгддэг
ёслолууд болон гэрээнүүд
Эзэмшил (догол мөр 6)—
Хүн ам суурьшилт

Цагаачлагч (догол мөр 6)—
Ихэвчлэн очсон газартаа
байнга оршин суухын
төлөө нэг орноос нөгөөд
шилжин очдог хүн

Тунхаг Бичиг

8. “1880-аад оны сүүлчээр Нэгдсэн Улсын засгийн газар олон эхнэр авсан хүмүүсийн сонгуульд санал өгөх эрх, шүүхэд ажиллах эрхийг нь хассан нэмэлт хуулиуд батлан гаргаж, Сүмийн эзэмшиж болох өмч хөрөнгийн тоо хэмжээг хатуу хязгаарлав. Улам олон эцэг нуугдсанаас Хожмын Үеийн Гэгээнтэн гэр бүлүүд хохирчээ. Ерөнхийлөгч Вудрафф Их Эзэнээс удирдамж хүсэв. 1890 оны есдүгээр сарын 23-ны орой бошиглогч, бурханлиг нөлөөгөөр ажиллан, олон эхнэр авах ёсыг Сүмийн гишүүдийн хувьд төгсгөл болгосон баримт бичиг Тунхаг Бичгийг бичжээ. Хэрэв олон эхнэр авах ёсыг төгсгөл болгохгүй бол Нэгдсэн Улсын засгийн газар ариун сүмүүдийг хураан авч, ингэснээр амьд байгаа хүмүүс болон нас барагсдын өмнөөс хийх ажил төгсгөл болно гэдгийг Их Эзэн Ерөнхийлөгч Вудраффт үзэгдлээр харуулжээ.

9. “1890 оны есдүгээр сарын 24-нд Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга Тунхаг Бичгийг дэмжин батлав. Гэгээнтнүүд үүнийг 1890 оны аравдугаар сарын ерөнхий чуулган дээр зөвшөөрөн баталжээ. Өнөөдөр энэ баримт бичиг Сургаал ба Гэрээнд Албан Тунхаг 1 болж орсон байдаг.

10. “Сүмийн энэхүү үйлдлийн дараа холбооны удирдах ажилтнууд олон эхнэр авах ёсны эсрэг хуулиудыг зөрчсөн гэм буруугаар яллагдаж байсан Хожмын Үеийн Гэгээнтэн эрэгтэйчүүдээс хүлцэл очиж, их мөрдлөг хавчлага зогсон байна. Гэвч Ерөнхийлөгч Вудрафф: ‘Би бүх ариун сүмийг мэдлээсээ алдахад хүргэх байлаа. Би өөрөө шоронд суухаас аргагүйд хүрэх байв. Мөн өөр бусад олон хүнийг шоронгийн хаалга татахад хүргэх байв. Миний хийж байгааг хий хэмээн тэнгэрийн Бурхан надад зарлиг болгоогүй юм. Харин цаг нь ирэхэд үүнийг хий гэж надад зарлиг болгосон юм. Энэ бүгд надад тодорхой байлаа. Би Их Эзэний өмнө очиж, Их Эзэн бич хэмээн надад хэлснийг бибээр бичив’ (“Албан Тунхаг 1-ийн талаар Ерөнхийлөгч Вилфорд Вудраффын гурван удаагийн хэлсэн үгний хэсгийг хавсаргав”) хэмээн тайлбарлажээ. Нэгдсэн Улсын Конгресс биш, харин Бурхан олон эхнэр авах ёсыг албан ёсоор зогсоосон юм” (Бидний Өв, 100–101).



Уншсанаа ойлгох нь



Тунхаг Бичиг

Тунхаг Бичиг (догол мөр 8)—Олон эхнэр авах ёсны таларх бодлогын баримт бичиг

Угийн бичгийн нийгэмлэг

11. “Хожмын Үеийн Гэгээнтнүүд Угийн бичгийн нийгэмлэгийг үндэслэн байгуулахаас аль эрт Сүмийн гишүүд нас барсан өвөг дээдсийнхээ амьдралыг баримтжуулсан цэдгүүдийг цуглуулж байжээ. Нас барсан өвөг дээдсийнхээ төлөө ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэхийн тулд тэдний нэрсийг мянга мянгаар нь олж авсан хүмүүсийн дунд Вилфорд Вудрафф, Оорсон Прагт, Хебер Ж. Грант нар байлаа. 1894 онд Тэргүүн Зөвлөл Ахлагч Франклин Д. Ричардсыг Угийн бичгийн нийгэмлэгийн анхны удирдагч болгож, нийгэмлэгийн зохион байгуулахад түүнд удирдамж, чиглэл өгсөн ажээ. Номын сан байгуулагдаж, ариун сүмийн ёслолууд гүйцэтгэгдэж болох хүмүүсийн нэрсийг хайхын тулд нийгэмлэгийн төлөөлөгчид дэлхий даяар явжээ. Эл нийгэмлэгийн үндэс суурин дээр Сүмийн Гэр Бүлийн Түүхийн Газар бий болсон юм.



12. “1894 оны дөрөвдүгээр сарын ерөнхий чуулганы үеэр Ерөнхийлөгч Вудрафф угийн бичгийн ажлын талаар илчлэлт хүлээн авснаа зарлав. ‘Угийн бичгийг чадах чинээгээрээ аль болох холоос хөтөлж, эцэг эхчүүдтэйгээ лацдан холбуул. Хүүхдийг эцэг эхтэй нь лацдан холбуулж, энэхүү гинжин хэлхээг чадах чинээгээрээ цааш үргэлжлүүлэхийг Бурхан Хожмын Үеийн Гэгээнтнүүдээс хүссэнийг тэрээр мэдэгджээ. . . . Энэ бол Өөрийнхөө хүмүүсийн талаарх Их Эзэний хүсэл мөн. Та нар энэхүү хүслийг ухааран ойлгосноор уг хүсэл зөв гэдгийг мэдэх болно гэж би боддог’ гэж хэлжээ [in Clark, comp., *Messages of the First Presidency*, 3:256–257]. Хожмын Үеийн Гэгээнтнүүд өдгөөг хүртэл нас барсан өвөг дээдсийнхээ цэдгүүдийг эрж, тэдний өмнөөс ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэсээр байна.

13. “1885–1900 оныг хүртэл Сүмийн олон гишүүн угийн бичгийн номлолд үйлчилжээ. Тэд номлолынхоо төлөө Ерөнхий Эрх Мэдэлтнээс адислал авахаар Солт Лейк хотод уригддаг байв. Тэдэнд бас номлогчийн үнэмлэх, томилолтын захидал өгдөг байжээ. Номлогчид төрөл садангуудтайгаа уулзаж, булшны чулуунаас нэрс цуглуулж, сүм хийдийн цэдэг, гэр бүлийн Библийг судлан, ариун сүмийн ажлыг гүйцэтгэх үнэ цэнэтэй мэдээлэлтэйгээр гэртээ эргэж ирдэг байлаа. Их Эзэн тэдэнтэй хамт байж, шаардлагатай эх сурвалж буюу садан төрлөө олоход нь тэднийг олонтаа чиглүүлж байсныг баттай нотолсон сүнслэг туршлагын тухай олон номлогч илтгэдэг байжээ. [Жеймс Б. Аллен, Жесси Л. Эмбри, Калил Б. Мехр, *Hearts Turned to Fathers: A History of the Genealogical Society of Utah, 1894–1994* (1995), 39–41.]” (Бидний Өв, 118–119).

Солт Лейкийн Ариун сүмийг онцгойлон адисалсан нь

14. “Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф амьдралынхаа үлэмж хэсгийг ариун сүмийн ажилд зориулсан юм. Тэрээр Сейнт Жоржийн Ариун сүмийн анхны ерөнхийлөгч байсан бөгөөд Мантайн Ариун сүмийг онцгойлон адисалжээ. Солт Лейкийн Ариун сүмийн суурийн чулууг тавьснаас хойш 40 жилийн дараа Ерөнхийлөгч Вудрафф энэхүү гайхалтай өвөрмөц ариун сүмийг онцгойлон адислахаар өдрийн бодол шөнийн зүүд болон тэсч ядан хүлээж байлаа. Онцгойлон адислах үйлчлэл 1893 оны дөрөвдүгээр сарын 6-наас тавдугаар сарын 18-ныг хүртэл явагдаж, ойролцоогоор 75,000 хүн оролцжээ. [Робертс, *Comprehensive History of the Church*, 6:236-г үз.]

15. “Дөрөвдүгээр сарын 6-нд болсон онцгойлон адислах эхний үйлчлэлийн дараа Ерөнхийлөгч Вудрафф өдрийн тэмдэглэлдээ: ‘Бурханы Сүнс болон хүч бидний дээр оршиж байлаа. Бошиглолын сүнс болон илчлэлт бидний дээр байж, хүмүүсийн зүрх сэтгэл уяран хайлж, олон зүйл бидэнд нээгдсэн юм’ гэж бичжээ [“Wilford Woodruff” (1833–1898), 1893 оны 4- сарын 6; ХҮГ Сүмийн Архиваас]. Хожмын Үеийн зарим Гэгээнтнүүд тэнгэр элчүүдийг харсан бол бусад нь өнгөрсөн үеийн Сүмийн ерөнхийлөгчид, нас барсан Сүмийн бусад удирдагчдыг харсан байлаа [Ричард Нейцел Холзафпел, *Every Stone a Sermon* (1992), 71, 75, 80-ыг үз].



16. “Ерөнхийлөгч Вудраффьг ерэн насныхаа ойг тэмдэглэх үеэр Ням гарагийн сургуулийн мянга мянган хүүхдүүд түүнд хүндэтгэл үзүүлэхээр Ариун Сүмийн Талбай дахь Табернеклаар дүүрэн цугласан байлаа. Тэрээр сэтгэл нь ихэд догдлон, арван настай байхдаа Протестант Ням гарагийн сургуульд явж, төлөөлөгчид, бошиглогчдын тухай уншдаг байснаа өсвөр насныханд ярьжээ. Тэр гэртээ эргэж ирээд, төлөөлөгчид, бошиглогчдыг дэлхий дээр дахин харахын тулд хангалттай урт наслахын төлөө залбирсан аж. Эдүгээ тэр төлөөлөгчид, бошиглогчдын аль аль нь байсан хүмүүсийн дунд зогсож байлаа. Залбирал нь олон удаа хариулагджээ. [Маттиас Ф. Каули, *Wilford Woodruff* (1909), 602.]

17. “Нэг жилийн дараа, 1898 оны есдүгээр сарын 2-нд, Ерөнхийлөгч Вудрафф Сан Францискод айлчилж явахдаа таалал төгсчээ” (*Бидний Өв*, 120–121).



Вилфорд Вудраффын сургаал ба гэрчлэл

18. “Энэ үеэс эхлэн угийн бичгийг чадах чинээгээрээ аль болох холоос хөтөлж, эцэг эхтэйгээ лацдан холбуулахыг бид Хожмын Үеийн Гэгээнтнүүдээс хүсч байна. Хүүхдүүдийг эцэг эхтэй нь лацдан холбуулж, энэхүү гинжин хэлхээг чадах чинээгээрээ цааш үргэлжлүүл” (*The Discourses of Wilford Woodruff*, хянан тохиолдуулсан Г.Хомер Дурхам [1990], 157).

19. “Та нар агуу эрч хүчтэй, авъяас чадвартай, бусдад тусгай байж Их Эзэн, эцэг эх, болон бүх сайн санаат хүмүүсийн хайрыг хүлээж болохын тул Бурханы дуу хоолойг сонсож, Самуелын адилаар энэ дуу хоолойг бага балчраасаа дуулгавартай дагахыг би ухуулж бас зөвлөж байна, залуу найз нар минь. Эцэг эхээ дуулгавартай дагаж, хүндэлж бай. Ингэснээр Бурханы амласан агуу адислалуудыг та нар олж авна. . . .

20. “. . . Та нар эдүгээ гэрэл гэгээтэй, залуу зандан насандаа, хамгийн чухал эрин үед аж төрж байна. Хүмүүн урьд өмнө нь хэзээ ч энэ үеийнхэн шиг хүмүүсийн дунд амьдарч байгаагүй юм. Та нар бол энэ үеийнхний нэгэн тод томруун хэсэг нь билээ. Та нар амьдралынхаа эхний үе шатанд хөл тавьж байна. Ирээдүйн амьдралын дүр зураг тань, хүмүүст үзүүлэх нөлөө тань, энэ амьдралын хийгээд үүрд мөнхийн хувь тавилан тань эцсийн эцэст гал цогтой залуу халуун насандаа та нарын тавьсан сууринаас ихээхэн хэмжээгээр хамааралтай байх болно гэдэг үнэнийг би баттайяа хэлж чадна” (*Discourses of Wilford Woodruff*, 265–266).

21. “Дэлхий дээр, дэлхийн оршин суугчдын дунд Бурханы хүч, чөтгөрийн хүч гэсэн хоёр хүч байдаг. Манай түүхэнд зарим маш өвөрмөц онцгой туршлага байдаг. Дэлхий дээр Бурханд хүмүүс байгаа үед, аль эрин зуунд гэдэг нь хамаагүй, өглөөний хүү Люсифер мөн тэнгэрээс хөөгдсөн, унасан сая сая сүнс Бурханы эсрэг, Христийн эсрэг, Бурханы ажлын эсрэг, түүнчлэн Бурханы хүмүүсийн эсрэг тэмцсээр байна. Манай өнөө үед, бидний үед, тэд энэ тэмцлээсээ ухрахгүй байна. Их Эзэн аль нэг ажлыг гүйцэтгэхээр мутраа сунгахад, эдгээр хүчнүүд уг ажлыг нураахаар ажилладаг” (“Энэ үгийг 1896 оны аравдугаар сарын 5-ны даваа гарагийн үдээс хойш Солт Лейк хотын Табернеклд болсон Ерөнхий чуулган дээр хэлжээ” *Deseret Evening News*, 1896 оны 10-р сарын 17, 9).

22. “Дэлхий дээр хүмүүн урьд өмнө нь хэзээ ч энэ үеийнхэн шиг ийм чухал хүмүүсийн дунд амьдарч байгаагүй юм. Бид ийм л үеийнхний дунд амьдарч байна шүү дээ. Иймд бид Бурханы бошиглол, илчлэлтүүд бидний нүдний өмнө биелэгдэж байгаа чухал үйл явдлуудын шастирыг бичих ёстой” (*Wilford Woodruff's Journal, 1833–1898 Typescript*, хянан тохиолдуулсан Скотт Г.Кенни, боть 9, [1983–1885], 4:444).

23. “Бурханд итгэ. Түүний амлалтуудад найд. Өөрсдөдөө байгаа гэрэл болон мэдлэгээр урагш тэмүүлэн амьдар. Тэгвэл амьдрах уу, эс амьдрах уу гэдгийн тухайд бүх зүйл та нарт сайн сайхан байх болно” (*Discourses of Wilford Woodruff*, 260).

24. “Тэрээр дагалдагчиддаа үлгэр жишээ болж, бүх зүйлийн дээгүүр босч ирэхийн тулд бүх зүйлээс доогуурт бууж ирсэн Аврагчийнхаа амьдралыг би үргэлж хардаг. . . . Энд уй гашуутай зүйл байдаг. Гэвч Аврагч бүх зүйлээс дээгүүрт босч ирэхийн тулд бүх зүйлээс доогуурт бууж ирэх нь зайлшгүй байсан юм” (*Discourses of Wilford Woodruff*, 4).



25. “Зарим үед би тодорхой бэлэг болон ач ивээлээр, тодорхой илчлэлт болон тохиуллаар адислагддаг. Харин би энэ бүгдийг хүлээн авснаар Ариун Сүнсний намуун зөөлөн дуу хоолойнд итгэх итгэлийг орлуулж чадах ямар нэг зүйлийг хэзээ ч олоогүй билээ” (*Discourses of Wilford Woodruff*, 45).

Уншсанаа ойлгох нь



Вилфорд Вудраффын сургаал ба гэрчлэл

Ач ивээл (догол мөр 25)—
Бурханы адислал, онцгой
боломжууд

Вилфорд Вудраффын амьдралын бусад чухал үйл явдлууд

1838 онд Их Эзэн Вилфорд Вудраффыг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүнээр, бас түүнийг болон Арванхоёрын Чуулгын бусад гишүүдийг Их Британид номлолд явуулахаар дууджээ (С ба Г 118-ын тойм, 3–4, 6-г үз). Ахлагч Вудрафф Их Британи руу “их усыг” гатлан очиж, мянга мянган хүмүүсийг Сүмд авчрахад тусалжээ. 1840 онд таван сарын хугацаанд Английн Херефордширийн бүсэд Ахлагч Вудрафф болон түүний хамтрагчдын хүч чармайлтаар 1,800 гаруй хүмүүс баптисм хүртсэн юм. Үнэнийг олохын тулд хамтдаа цуглаж, хамтдаа залбирсан бараг 600 шахам хүнтэй нэг бүлэг баптисм хүртсэн хүмүүсийн дунд байв. “Херефордширийн энэ номлолын бүх түүх нь Бурханы Сүнсний намуун зөөлөн дуу хоолой, Ариун Сүнсний илчлэлтүүдийг сонсохын ач холбогдлыг харуулдаг. Гэрэл ба үнэний төлөө хүмүүс залбирсан. Иймээс Их Эзэн намайг тэдэн рүү илгээсэн юм” хэмээн Ахлагч

Вудрафф бичжээ (Маттиас Ф. Каули, *Wilford Woodruff, Fourth President of The Church of Jesus Christ of Latter-day Saints: History of His Life and Labors As Recorded in His Daily Journals* [1964], 120).

Ахлагч Вудрафф 1856 онд Сүмийн түүхчээр дуудагдав. Ингэснээр Иосеф Смитийн сургаалууд болон амьдралынх нь үйл явдлуудаас олныг нь агуулсан, бараг 7,000 хуудас хувийн тэмдэглэл нь Сүмийн түүхэнд их хувь нэмэр оруулжээ. Сүмийн түүхийг бичих нь түүний нэг дуудлага гэж тэр боддог байв. “Төрсөн өдрөөс минь эхлэн одоог хүртэл чөтгөр амь насыг минь бусад хүмүүсийн амь наснаас бүр ч илүүгээр бүрэлгэхийг сүвэгчилсээр байна. Би бол дайсны буугаа онилсон хохирогч юм даа, учир нь нэг шалтгааныг би мэднэ. Хэрэв би Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмд орох юм бол, энэ Сүмийн түүхийг бичиж, бошиглогчид, төлөөлөгчид, ахлагчдын ажил үйлс, сургаалуудыг цэдгээр үлдээнэ гэдгийг чөтгөр мэдэж байгаа” гэжээ (Каули, *Wilford Woodruff*, 477).

Ахлагч Вудраффийг Сейнт Жоржийн Ариун сүмийн ерөнхийлөгч байхад нь Нэгдсэн Улсын засгийн газрыг эмхлэн байгуулсан хүмүүсийн сүнс түүнд айлчлан иржээ. Тэд өөрсдийнхөө төлөө ариун сүмийн ажлыг хийхийг хүссэн аж. Тэдгээр хүмүүс болон түүхэн дэх бусад хүмүүс, түүний дотор Христофер Колумб болон сайн мэдээний Сэргээлтийн өмнө нас барсан шашны чухал удирдагчдын өмнөөс ариун сүмийн ажлыг хийхэд Ахлагч Вудрафф тусалсан юм. (*Journal of Discourses*, 19:229-ийг үз.)



Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф амьдралаа эргэцүүлэн бодоод: “Алхам бүрийг маань Бурхан удирддаг байсан гэдэгт би баттай итгэдэг байсан. Тиймээс Түүний шууд оролцоог нотлон харуулсан үйл явдлуудаар амьдрал маань дүүрэн юм. Би 27 удаагийн тодорхой тохиолдолд амь насанд минь заналхийлсэн аюулаас аврагдсан” гэжээ (Каули, *Wilford Woodruff*,) гэж бичжээ.

Уншсанаа судлах нь



“Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф”-ыг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Олон эхнэр авах ёсыг найздаа тайлбарла

Сүм зуу гаруй жилийн өмнө олон эхнэр авах ёсыг зогсоосон билээ. Гэвч, зарим хүмүүс уг сургаалыг одоо ч гэсэн буруу ойлгож, энэ талаар олон асуулт асуудаг. Догол мөр 8–10-ыг судалж, олон эхнэр авах ёсыг тайлбарлахыг өөрөөс чинь асуусан найздаа юу ярихыг бич. Сүмийн түүхийн тухай зарим нарийн ширийн зүйлүүдийг, мөн бидэнд орчин үеийн бошиглогчид байдгийг оруул.

Б Ерөнхийлөгч Вудраффын амьдралыг судал

1. Сургаал ба Гэрээ 118:1, 6; 124:127–129; 136:13; 138:53; Албан Тунхаг 1-ийг судал. Эдгээр судар тус бүрээс Вилфорд Вудраффын тухай юу мэдсэнээ жагсаан бич.
2. Догол мөр 1–7, 11–17, мөн түүний амьдрал ба Ерөнхийлөгчийн Зөвлөлийн тухай схем дэх мэдээллийг судал (х.00 (178)). Юуны учир түүнийг дурсан санах ёстой гэж боддог зүйлүүдийг жагсаан бичиж, эдгээр зүйл тус бүрийг бид яагаад санах ёстой гэж бодогоо товч тайлбарла.

В Ерөнхийлөгч Вудраффын сургаалууд

“Хэрэв та нар үүргээ биелүүлэх юм бол, би үүргээ биелүүлнэ. Ингэсэн тохиолдолд бидэнд хамгаалалт байж, бид гай зовлонгийн дундуур амар амгалан, аюулгүйгээр өнгөрнө” (in “A Remarkable Statement,” *Improvement Era*, 1914 оны 10-р сар, 1165) хэмээн Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф сургажээ. Догол мөр 18–25-ыг судалж, дараах даалгаврыг хий:

1. Сүмийн гишүүд юу хийх үүрэгтэй талаар Ерөнхийлөгч Вудраффын хэлсэн зүйлсийг жагсаан бич.
2. Жагсаалтаасаа гурван үүргийг сонгож, үүрэг тус бүрийг хэрхэн илүү сайн биелүүлж чадахаа товчхон бич.

Албан Тунхаг 1 болон “Гурван удаагийн хэлсэн үгнээс авсан хэсэг ...”

Олон эхнэр авах ёсыг Их Эзэн төгсгөл болгосон нь

Их Эзэн олон эхнэр авах ёсыг Бошиглогч Иосеф Смитэд илчилсний дараа Сүм үүнийг хэрэгжүүлж эхэлсэн юм (С ба Г 132:1–6-г үз). Хүчтэй мөрдлөг хавчлага болон олон эхнэр авах ёсны эсрэг хуулиудыг Нэгдсэн Улсын засгийн газар батлан гаргасны улмаас Сүм юу хийх ёстойг Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф Их Эзэнээс асуужээ. Хожим нь тэрээр:



“Хэрэв бид энэ практикийг зогсоохгүй бол юу болохыг Их Эзэн надад үзэгдлээр бас илчлэлтээр яг тодорхой харууллаа. . . .

“... Би бүх ариун сүмийг мэдлээсээ алдахад хүргэх байлаа. Би өөрөө шоронд суухаас аргагүйд хүрэх байв. Мөн бусад олон хүнийг шоронгийн хаалга

татахад хүргэх байв. Миний хийж байгааг хий хэмээн тэнгэрийн Бурхан надад зарлиг болгоогүй юм. . . Харин цаг нь ирэхэд үүнийг хий гэж надад зарлиг болгосон юм. Энэ бүгд надад тодорхой байлаа. Би Их Эзэний өмнө очиж, Тэрбээр бич хэмээн надад хэлснийг бибээр бичив” хэмээн өгүүлжээ (“Тунхаг Бичгийн талаар Ерөнхийлөгч Вилфорд Вудраффын гурван удаагийн хэлсэн үгнээс авсан хэсэг” [Албан Тунхаг 1-ийн дараа орсон], догол мөр 6–7). Түүний хүлээж авсан илчлэлтийг Сүмийн гишүүдэд танилцуулахад тэд дэмжин батлав. Энэ баримт бичгийг “Тунхаг Бичиг” гэж нэрлэдэг байв. Харин одоо “Албан Тунхаг 1” гэсэн нэртэй, Сургаал ба Гэрээ 138-р хэсгийн дараа байдаг.

Судруудыг ойлгох нь



Албан Тунхаг 1

Хишгийн Ордон (догол мөр 3)—Солт Лейкийн Ариун сүм дуусахаас өмнө ариун сүмийн ёслолууд гүйцэтгэхэд ашигладаг байсан Ариун Сүмийн Талбай дээрх нэг барилга

- **Замыг нь алдагдуулах** (догол мөр 1)—Буруу удирдах
- **Хураалгах** (догол мөр 5)—Өмчлөлийг засгийн газар өөртөө шилжүүлж авах
- **Тогтоосон** (догол мөр 9)—Зарлиг болгосон

Албан Тунхаг 1 буюу Тунхаг Бичиг өгөгдсөний дараа олон эхнэр авах гэрлэлт гүйцэтгэгдэж байсан уу?

Сүмийн зарим гишүүд Нэгдсэн Улсын хилийн гадна олон эхнэр авах ёсыг баримталж байв. Хэрэв тэд Нэгдсэн Улсын гадна амьдарч байгаа бол олон эхнэр авч болно гэж боддог байжээ. “Тунхаг Бичиг газар бүр хүчинтэй бөгөөд ‘Сүм олон эхнэртэй байх ёсыг Юта болон бусад бүх мужид зогсоосныг, мөн Сүмийн аль нэг гишүүн эсвэл ажилтан олон эхнэр авах ёслолыг гүйцэтгэх эсвэл олон эхнэр авах эрхгүй’ гэдгийг Ерөнхийлөгч Лорензо Снөү 1900 оны нэгдүгээр сарын 8-нд мэдэгджээ” (“Slanders Are Refuted by First Presidency,” *Millennial Star*, 1911 оны 5-р сарын 4, 275).

Зарим хүмүүс Их Эзний зарлигийг дагахаас татгалзсан юм. 1904 оны дөрөвдүгээр сард Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит ерөнхий чуулган дээр албан ёсны мэдэгдэл хийж: “Олон эхнэр авах аливаа гэрлэлтийг хориглосныг би зарлаж байна. Хэрэв Сүмийн аль нэг ажилтан буюу гишүүн ийм гэрлэлтийг гүйцэтгэх буюу олон эхнэр авах юм бол, Сүмийн эсрэг зөрчил үйлдсэнд тооцогдож, зохих журмын дагуу хариуцлага хүлээж, сүмээс хөөгдөх болно” гэжээ (In Conference Report, 1904 оны 4-р сар, 75). Тэр үеэс хойш Сүмийн Ерөнхийлөгч бүр олон эхнэр авах ёсны эсрэг энэ зааврыг давтан өгүүлсээр иржээ.

Судруудыг судлах нь

Албан Тунхаг 1-ийг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий.

А Хичээл заа

Албан Тунхаг 1 болон судруудад уг тунхагтай хамт хэвлэгдсэн гурван удаагийн хэлсэн үгнээс авсан хэсгийн тухай ч хичээл заах болжээ гэж бод. Ерөнхийлөгч Вилфорд

Вудраффын мэдэгдлийн тухай юу заахаа бичихдээ, дараах асуултуудын хариуг оруул:

1. Олон эхнэр авах ёсны тухай Их Эзэн Ерөнхийлөгч Вудраффт юу илчилсэн бэ?
2. Тэр үед Тэргүүн Зөвлөлийн зөвлөх байсан, Ерөнхийлөгч Лорензо Снөүгийн захиас энэ илчлэлтийг хүлээн авахад Гэгээнтнүүдэд хэрхэн тусалсан бэ?
3. Амьд бошиглогчийг дагах нь Сүмийн гишүүдэд яагаад чухал вэ?
4. “Гурван удаагийн хэлсэн үгнээс авсан хэсэг . . .”-ийн эхний догол мөрөнд Ерөнхийлөгч Вудраффын өгсөн амлалтын талаар та нар юу гэж боддог вэ?

Б Тайлбар хий

Сургаал ба Гэрээ 124:49–50-ийг судалж, энэ судар Ерөнхийлөгч Вилфорд Вудраффын үе дэх олон эхнэр авах ёсны практикт хэрхэн хэрэглэгдэж байсныг товч тайлбарла.

Өргөжилтийн үе


1898–1951 он хүртэл, өргөжин тэлж байсан Сүмийг дөрвөн бошиглогч-Лорензо Снөү, Жозеф Ф.Смит, Хебер Ж.Грант, Жорж Альберт Смит нар тэргүүлж байв. “Тэдгээр Ерөнхийлөгчид морь болон жижигхэн сүйх тэргэгнээс агаарын тээвэрт шилжсэнийг гэрчилжээ. Дэлхийн хоёр дайн болон дэлхийн бөмбөрцгийг хамарсан эдийн засгийн уналт Гэгээнтнүүдийг өөрчилсөн юм. Энэ үед есөн ариун сүм баригдаж байлаа. 1901 онд 50 гадаст ойролцоогоор 300,000 гишүүн байв” (Бидний Өв, 123). 1951 он гэхэд Сүм 1,111,000 гаруй гишүүнтэй болж, гишүүд нь дэлхий даяар 180 гадаст цуглаж байв.



Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф 1898 онд нас барахад бошиглогчийн суу билэг тэр үед наян таван настай байсан, туушлагатай Ерөнхийлөгч Лорензо Снөүд шилжжээ. Сүмийн өмнөх аль ч Ерөнхийлөгч ийм өндөр насандаа эл албан тушаалд орж байсангүй. Хожмын Үеийн Гэгээнтнүүд шинэ зууныг агуу найдвар, өөдрөг

үзлээр харж байлаа. Номлолын болон ариун сүмийн ажил өсч хөгжин, Сүмийн санхүүгийн ноцтой өр төлбөр шийдвэрлэгдсэн байв.

ТҮҮНИЙ АМЬДРАЛ (1814–1901)

1814 он	Дөрөвдүгээр сарын 3-нд Огайогийн Мантоад Оливер Петтибөөн Снөү, Розетта Петтибөөн Снөү нарын гэр бүлд төржээ	
1836 он	22 настайдаа, зургадугаар сарын 19-нд, Огайогийн Кертландыг нэвт урсан гардаг Чагрин гол дээр баптисм хүртжээ	
1837 он	Нас 23, Огайод номлолд үйлчлэв	
1838–1839 он	24–25 настайдаа, Иллиной, Миссури, Кентаки, Огайод номлолд үйлчлэв	
1840–1843 он	26–29 настайдаа, Их Британид номлолд үйлчлэв	
1845 он	31 настайдаа, Чарлотт Мерил Сквайрес, Мэри Аделайн Годдард, Сара Анн Прихард, Харриет Амелия Сквайрес нартай нэгдүгээр сарын 17-нд гэрлэжээ	
1849 он	34 настайдаа, хоёрдугаар сарын 12-нд Хебер К.Кимбалл түүнийг Төлөөлөгчөөр томилов	

- 1849–1852 он** 35–38 настайдаа, Итали, Англи, Швейцарь, Мальтад номлолд үйлчлэв
- 1864 он** 50 настайдаа, Сандвич (Хавайн) арлуудад богино хугацааны номлолд үйлчлэв
- 1873–1877 он** 59–63 настайдаа, Ерөнхийлөгч Бригам Янгийн зөвлөхөөр үйлчилж байв
- 1885 он** 71 настайдаа, Нэгдсэн Улсын баруун хойт хэсэгт индианчуудад номлолд үйлчлэв
- 1898 он** 84 настайдаа, есдүгээр сарын 2-нд Ерөнхийлөгч Вилфорд Вудрафф нас барсны дараа Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав. Ерөнхийлөгч Жорж К.Каннон, Жозеф Ф.Смит нар түүний зөвлөхөөр хэвээр үлдэв
- 1901 он** 87 настайдаа, Сүмийн Ерөнхийлөгч болсноос хойш гурван жилийн дараа аравдугаар сарын 10-нд Солт Лейк хотод таалал төгсөв


ТҮҮНИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ (1898–1901)

- 1898 он** Солт Лейкийн Ариун сүмд Есүс Христ түүн дээр хурч ирэн, Тэргүүн Зөвлөлийг өөрчлөн зохион байгуулахыг хүлээхгүй байхыг түүнд хэлжээ. Анхны бүрэн цагийн номлогч эгч нар дуудагдав
- 1899 он** Аравны нэгийн хуулийн ач холбогдлыг заах тухай илчлэлт хүлээн авав
- 1901 он** Мексик, Япон, Шинэ Зеланд, Германд шинэ номлол нээгдэв

Ерөнхийлөгч Лорензо Снөү ба аравны нэг

1. “Ерөнхийлөгч Вудраффьг нас барсны дараа, Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгч Лорензо Снөү Сүмийн Ерөнхийлөгч болов. Тэр бол үүрэгт ажилдаа сайн бэлтгэгдсэн, ухаалаг, хайраар дүүрэн удирдагч байлаа. Лорензо Снөү тухайн үеийг хүртэл байсан хожмын үеийн бошиглогч бүрээр танигдаж, сургагдсан байв. Тэрээр Бошиглогч Иосеф Смит болон түүний гэр бүлтэй олонтаа уулзаж, хамт хооллодог байснаа, бошиглогчтой аминчлан ярилцдаг байснаа Табернеклд цугласан Гэгээнтнүүдэд 1900 оны арваннэгдүгээр сард ярьжээ. Их Эзэн Иосефт энэ үнэнийг ‘хамгийн тод томруун, бүрэн дүүрнээр’ үзүүлсэн учраас Бурханы бошиглогч байсныг тэр мэддэг байжээ [“The Redemption of Zion,” *Millennial Star*, 1900 оны 11-р сарын 29, 754].

2. “Ерөнхийлөгч Снөүгийн удирдлагын үед, олон эхнэр авах ёсны эсрэг холбооны засгийн газрын хууль тогтоомжоос үүдэлтэй санхүүгийн ноцтой бэрхшээлтэй Сүм тулгарсан юм. Ерөнхийлөгч Снөү тунгаан бодож, Сүмийг доройтуулагч өрнөөс хэрхэн чөлөөлөгдөх талаар удирдамж хүсч залбирчээ. 1899 оны дөрөвдүгээр сарын ерөнхий чуулганы дараа Ютагийн Сейнт Жоржид очих бурханлиг мэдрэмж түүнд төрсөн аж. Тэрээр тэнд үг хэлж байхдаа хэсэг хугацаанд ярихаа зогсож, цааш нь үргэлжлүүлэхдээ, илчлэлт хүлээж авснаа мэдэгджээ. Сүмийн хүмүүс аравны нэгийн хуулийг үл тоомсорлож байв. Хэрэв Сүмийн гишүүд аравны нэгээ бүрнээр нь илүү их итгэлтэйгээр төлөх юм бол адислалууд тэдэн дээр юүлэгдэнэ гэдгийг Их Эзэн түүнд хэлжээ.



3. “Бошиглогч аравны нэгийн ач холбогдлыг Юта даяар цугларагсад номлов.

Гэгээнтнүүд түүний зөвлөгөөг дуулгавартай дагаж, тэр жил өмнөх жилийнхээс хоёр дахин их аравны нэгийг төлжээ. 1907 он гэхэд Сүм бүх зээлээ төлж, өргүй болоход хангалттай мөнгөн хөрөнгө эзэмшиж байлаа.

4. “1898 онд Залуу Эмэгтэйчүүдийн Мючелийн Сайжралтын Нийгэмлэгийн Ерөнхий зөвлөлд зориулсан хүлээн авалт дээр Ерөнхийлөгч Жорж К.Каннон, ‘манай ухаалаг, буурь суурьтай зарим эмэгтэйчүүдийг номлолын талбарт’ дуудах шийдвэрийг Тэргүүн Зөвлөл гаргасныг мэдэгдэв [“Biographical Sketches: Женни Бримхалл, Айнэз Найт,” *Young Women’s Journal*, 1898 оны 6-р сар, 245]. Энэ үеэс өмнө хэдхэн эгч нар л нөхрөө номлолд нь дагаж явсан бол, харин энэ удаад Сүм эгч нарыг Их Эзэн Есүс Христийн номлолын элчин сайд нар болгон анх удаа албан ёсоор дуудаж, онцгойлон адисалсан ажээ. Эгч нар номлолд үйлчлэх үүрэггүй байсан бол, өнгөрсөн хэдэн арван жилд мянга мянган эгч нар энэхүү онцгой боломжийг ашиглан бүрэн цагийн номлогчдоор Их Эзэнд зоримгоор үйлчилсэн билээ.

5. “Ерөнхийлөгч Лорензо Сүмийг хорьдугаар зуун руу удирдан золгуулсан юм. Шинэ зууны үүр гэгээрэх үеэр Сүм 43 гадас, 20 номлол, 967 тойрог, салбартай болсон байлаа. 283765 гишүүнээс ихэнх нь Нэгдсэн Улсын Хадат Уулсын бүсэд аж төрж байлаа. Дөрвөн ариун сүм үйл ажиллагаа явуулж, *Juvenile Instructor*, *Improvement Era*, *Young Women’s Journal* сэтгүүлүүд Сүм болон түүний гишүүдийн тухай өгүүллүүд нийтэлж байв. Хамгийн багаар бодоход жилд нэг шинэ номлол нээгдэнэ гэдэг үг ам дамжин яригдаж байсан болохоор, дараагийн зуун жилд юу болохыг Хожмын Үеийн Гэгээнтнүүд төсөөлөхөд амаргүй байсан биз ээ. Гэвч Сүмийн хувь заяаны талаарх бошиглолууд гүйцэлдэнэ гэдэгт тэд итгэлтэй байлаа” (*Бидний Өв*, 121–122).

Уншсанаа ойлгох нь



Ерөнхийлөгч Лорензо Снөү ба аравны нэг

Залуу Эмэгтэйчүүдийн Мючелийн Сайжралтын Нийгэмлэг (догол мөр 4)— Сүмийн Залуу

Эмэгтэйчүүдийн анхны байгууллагын нэр
Элчин сайдууд (догол мөр 4)—Албан ёсны төлөөлөгчид

Лорензо Сноэгийн сургаал ба гэрчлэл

6. Ерөнхийлөгч Лорензо Сноэ, “богинохон хугацаанд [1840 онд Англи руу номлолд явахаас өмнө] тохиолдсон нэг явдал миний санаанаас огт гардаггүй юм. Үнэхээр ер бусын зүйл болсон юм. Тэр үед би Ахлагч Х.Г.Шөөрвудын гэрт байлаа. Зарц нарыг хөлслөн, жимснийхээ цэцэрлэгт өдрийн өөр өөр цагуудад ажиллуулахаар тэднийг явуулсан эзний тухай тэрээр ярих үедээ бидний Аврагчийн сургаалт зүйрлэлийг тайлбарлахаар хичээж байлаа.

7. “Түүний тайлбарлахыг анхааралтай сонсож байх үед Их Эзэний Сүнс хүчтэйгээр мэдрэгдэж, миний ойлголтын мэлмий нээгдэн, Бурханы болон хүний замыг гайхалтайгаар, үд дундын наран лугаа адил яруу тод харлаа. Уг илчлэлт надад үзүүлэгдсэнийг илэрхийлсэн дараах хоёр мөрт шүлгийг би зохиов. . . .

8. Одоо хүн ямар байна, Бурхан нэгэнтээ тийм байсан:

Одоо Бурхан ямар байна, бас хүн тийм байж болно.

9. “Энэ бол ариун харилцаа байсан гэж бодсон” (Элиза Р.Сноэ, *Biography and Family Record of Lorenzo Snow* [1884], 46).

10. “Миний эгч Элиза Р.Сноэ Смит үгийг нь олон жилийн өмнө зохиосон нэг дуу байдаг. Манай цуглаанууд дээр олонтаа дуулдаг энэ дууг эгч нар та нарыг уншсан гэж би бодож байна [“Эцэг минь ээ,” *Сүмийн дуулал болон хүүхдийн дуу*, х. 42-ыг үз]. ‘Дээр алдар суут газарт’ бидэнд Эцэг байдаг төдийгүй, бидэнд бас Эх байдаг тухай энэ дуулал өгүүлдэг. Хэрэв эгч нар, та нар итгэлтэй байх юм бол, Эх шигээ агуу болно” (ЛиРой К. Сноэ, “Devotion to a Divine Inspiration,” *Improvement Era*, 1919 оны зургадугаар сар, 658).

11. Олон эхнэр авах ёсыг зогсоосон илчлэлтийг Вилфорд Вудрафф хүлээн авахаас өмнө Сүмээс мөнгө, өмч хөрөнгийг нь салган авсан хуулиуд батлагдан гарсны улмаас (Албан Тунхаг 1-ийг үз), Сүмийн олон гишүүд аравны нэгийг төлөө зогсоохоор шийдсэн ажээ. Ийм нөхцөл байдлын улмаас Сүм их хэмжээний өртэй болсон байв. Ерөнхийлөгч Лорензо Сноэ Сүмийн Ерөнхийлөгч болсныхоо дараа удалгүй, 1899 оны тавдугаар сарын 8-нд Ютагийн Сейнт Жоржид болсон нэг гадасны чуулган дээр үг хэлжээ. Тэрээр үг хэлж байхдаа хэсэг хугацаанд зогсож, Их Эзэнээс нэг илчлэлт хүлээн авчээ. Тэгээд тэр аравны нэгийн хуулийг хэрхэн үл тоомсорлож байсныг урьд өмнө нь хэзээ ч мэдээгүйгээ хэлсэн аж. “Та нарт хандан хэлсэн Их Эзэний үг ямар нэг шинэ зүйл биш. Энэ бол энгийнээр хэлэхэд: Ирээдүйд бэлтгэхийг мөн зохих суурин дээр бат бөх зогсохыг тооцоолдог Хожмын Үеийн Гэгээнтэн бүрийн хувьд Их Эзэний тааллыг биелүүлж, түүний аравны нэгийг бүрнээр нь төлдөг болох цаг иржээ. Энэ бол та бүгдэд хандсан Их Эзэний үг. Бас энэ нь Сионы нутаг даяарх суурин бүрд хүрэх Их Эзэний үг байх болно” гэжээ (“Discourse by President Lorenzo Snow,” *Millennial Star*, 1899 оны 8-р сарын 24, 533).

12. Лорензо Сноэ баптисм хүртсэнээсээ хойш хоёр долоо хоног орчмын дараа улам их гэрчлэлтэй болохын төлөө залбирахаар ойн цоорхойд очжээ. “Залбирах гэж чармайн намайг ууруулаа нээнгүүт торгон нөмрөг шажигнах шиг чимээ толгой дээр минь сонсогдсон тэр даруйд Бурханы Сүнс над дээр бууж ирэн, бүхэл биеийг минь ороон, толгойн оройноос өлмийг хүртэл дүүргэхэд, Ай би ямар их баяр хөөр, ямар их аз жаргалыг мэдэрсэн гээч! . . . Тэгэхэд би

Бурхан амьдардаг тухай, Есүс Христ бол Бурханы Хүү болох тухай, ариун санваарын Сэргээлтийн тухай, Сайн мэдээний бүрэн байдлын тухай төгс мэдлэг хүлээн авсан” гэж тэр бичжээ (Сноэ, *Biography and Family Record of Lorenzo Snow*, 8).



13. Ерөнхийлөгч Сноэгийн ач охин Алли Янг Понд дараах түүхийг хуваалцжээ:

14. “Нэг орой би Солт Лейкийн Ариун сүм дэх өрөөнд нь Сноэ өвөө дээрээ очиход, хаалганы сахиулууд явчихсан, шөнийн жижүүрүүд ирээгүй байсан үеийг хүртэл тэнд байсан болохоор өвөө маань намайг өмнө талын гол хаалган дээр аваачиж, түүгээр гадагш нь гаргаж өгье гэв. Тэр шургуулганаасаа бөөн түлхүүр гаргаж ирэв. Бид хоёр өвөөгийн өрөөнөөс гарч, селестиел өрөө уруу явдаг том коридороор явж байх үед би хэд алхаж өвөөгийнхөө өмнө гарахад өвөө намайг зогсоож: ‘Түр хүлээ, Алли, би чамд нэг юм хэлье. Ерөнхийлөгч Вудраффыг нас барахад Их Эзэн Есүс Христ над дээр яг энд хүрч ирсэн юм шүү дээ. Тэр намайг одоо явж, Сүмийн Тэргүүн Зөвлөлийг өөрчлөн зохион байгуул, өмнөх ерөнхийлөгчийг нас барснаас хойш хүлээх хэрэггүй гэж зааварласан. Ингээд л би Ерөнхийлөгч Вудраффыг залгамжилсан юм’ гэж билээ.

15. “Тэгээд өвөө нэг алхам ойртож ирээд, зүүн гараа сунган: ‘Тэр яг энд, шалнаас дээш гурван фут орчимд зогсож байсан. Их Эзэн бөх бат алтан тавган дээр зогсож байгаа юм шиг харагдсан’ гэв.

16. “Аврагч хэчнээн сүр жавхлантай хүн байсныг, гар, хөл, царайн төрх байдлыг нь, бүхнээс илүү нүд гялбам цав цагаан, хурцаар гэрэлтсэн гоёмсог цагаан нөмрөгийг нь, мөн Түүнийг хэрхэн нүд гялбан харж байснаа өвөө маань дүрслэн, ярьж билээ.

17. “Дараа нь тэр дахин нэг алхам ойртоод, баруун гараа миний толгой дээр тавьж: ‘За одоо, ач охин минь, өвөө чинь энд, ариун сүм дотор Аврагчийг үнэхээр харж, Түүнтэй нүүр нүүрээрээ учран ярилцсан нь өвөөгийн чинь гэрчлэл гэдгийг санаж яваарай гэж би чамаас хүснэ’ гэж билээ” (ЛиРой К.Сноэ, “An Experience of My Father’s,” *Improvement Era*, 1933 оны 9-р сар, 677).



Солт Лейкийн Ариун сүмийн орц

Хуилбарлахыг хатуу хориглоно

Уншсанаа ойлгох нь



Лорензо Снөүгийн сургаал ба гэрчлэл

Хоёр мөрт шүлэг (догол мөр 7)—Хоёр айзам бүхий хоёр мөрт шүлэг

Коридор (догол мөр 14)—
Үүдний өрөө


Уншсанаа судлах нь



“Ерөнхийлөгч Лорензо Снөү”-г судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий

А Номлолын үйлчлэлд бэлтгэх нь

1. Сургаал ба Гэрээ 4:1–7-г уншиж, амжилттай номлогч байхын тулд чухал гэж өөрийнхөө боддог, энд дурдсан таван шинж чанарыг жагсаан бич.
2. Эдгээр шинж чанарууд Ерөнхийлөгч Лорензо Снөүд байсан гэдэгт өөрийнхөө итгэдэг таван түүх, үйл явдал буюу сургаалыг түүний амьдралаас сонгож ав.
3. Амьдралдаа бүрэн дүүрэн хөгжүүлэхийг хүсдэг нэг шинж чанарыг дээрх шинж чанаруудаас сонгож, энэ шинж чанар яагаад өөрт чинь чухал болохыг, мөн энэ талаар илүү сайн бэлтгэгдэхийн тулд юу хийж болохоо тайлбарла.



Б Товч тайлбар хий

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн Ахлагч Даллин Х.Өүкс хэлсэн нь: “Би аравны нэгийг төлж чаддаггүй ээ” гэж зарим хүмүүс хэлдэг. Их Эзэний амлалтуудад итгэлээ төвлөрүүлдэг хүмүүс, “Би аравны нэгийг төлөхгүй байж чаддаггүй” гэж хэлдэг” (In Conference Report, 1994 оны 4-р сар, 44; Ensign, 1994 оны 5-р сар, 34).

1. Малахи 3:8–12-ыг судалж, аравны нэгийг шударгаар төлдөг хүмүүст энд амлагдсан адислалуудыг жагсаан бич.
2. “Лорензо Снөүгийн сургаал ба гэрчлэл”-ийг (догол мөр 6–17) уншсанаасаа, аравны нэгийн хуулиар амьдардаг итгэлтэй Гэгээнтнүүдийн улмаас Сүмд ирэхийг нь харсан адислалуудаа дүрсэл.
3. Аравны нэгийг шударгаар төлснөөс ямар адислалуудыг та нар хүлээж авсан бэ, ямар адислалуудыг хүлээж авах вэ?



Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит Сайн мэдээний сургаалын багш

“Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит Сүмийн Ерөнхий эрх мэдэлтэн- Арванхоёрын Чуулгын гишүүн, Сүмийн дөрвөн Ерөнхийлөгчийн зөвлөхөөр 52 жил гаруй, Сүмийн Ерөнхийлөгчөөр 17 жил үйлчилжээ. Тэрээр ‘бидний Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөтэй нийцэн амьдрахад’ хүмүүсийг уриалан дуудаж, Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээг уран цэцэн үг, өрөвч уян сэтгэл, итгэл үнэмшилээр заадаг байлаа. “Би Сүнсний гэрчлэлийг зүрх сэтгэлдээ хүлээн авсан хүн. Иймээс Гэтэлгэгч минь амьд гэдгийг би мэднэ хэмээн Бурханы өмнө, тэнгэр элчүүд болон хүмүүсийн. . . өмнө гэрчилж байна” (Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith [1998], v) гэсэн, Есүс Христийн тухай хүчирхэг гэрчлэлээр нь түүний үйлчлэл ялгардаг билээ.

ТҮҮНИЙ АМЬДРАЛ (1838–1918)

- | | | |
|--------------|---|--|
| 1838 он | Арваннэгдүгээр сарын 13-нд, Миссурийн Фар Вестэд Хайрум Фиелдинг Смит (Бошиглогч Иосеф Смитийн ах), Мэри Фиелдинг Смит нарын гэр бүлд төрсөн | |
| 1844 он | 5 настай байхад, Аав нь Иллинойн Картейж Шпорнд алагдав | |
| 1848 он | 9 настайдаа, Айовагийн Винтер Квотерсоос шаранд хөллөсөн мухлаг тэргийг Солт Лейкийн Хөндий рүү (1,600 километр) жолоодон авчрав | |
| 1852 он | 13 настайдаа, тавдугаар сарын 21-нд Солт Лейк хотын Сити Грийкт багтисм хүртжээ. Ээж нь есдүгээр сарын 21-нд нас барав | |
| 1854–1857 он | 15–19 настайдаа, Хавайд номлолд үйлчлэв | |
| 1860–1863 он | 21–24 настайдаа, Англид номлолд үйлчлэв | |
| 1866 он | 27 настайдаа, тавдугаар сарын 5-нд Жюлина Ламсонтой гэрлэв. Долдугаар сарын 1-нд Ерөнхийлөгч Бригам Янгаар Төлөөлөгчөөр томилогдож, Тэргүүн Зөвлөлийн Зөвлөхөөр онцгойлон адислагдав. Ерөнхийлөгч Бригам Янг, Жон Тейлор (1880), Вилфорд Вудрафф (1889), Лорензо Снөү (1898) нарын зөвлөхөөр үйлчилж байжээ | |
| 1874–1875 он | 35–36 настайдаа, Европын Номлолын ерөнхийлөгчөөр үйлчлэв | |

- 1877 он 38 настайдаа, Европын Номлолын ерөнхийлөгчөөр дахин үйлчлэв
- 1901 он 62 настайдаа, Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав
- 1918 он 80 настайдаа, арваннэгдүгээр сарын 19-нд Солт Лейк хотод нас нөгчив

ТҮҮНИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ (1901–1918)

- 1902 он Хүүхдэд зориулсан Сүмийн анхны сэтгүүлийг (*Хүүхдүүдийн Найз*) Сүм хэвлэн гаргав
- 1907 он Сүм өргүй болов
- 1911 он Америкийн Хөвгүүдийн Скаутыг Сүм Залуу Эрэгтэйчүүдийн байгууллагын нэг хэсэг болгон ашиглаж эхлэв
- 1912 он Семинар эхлэв
- 1914 он Эмэгтэйчүүдэд зориулсан Сүмийн анхны сэтгүүл нийтлэгдэв
- 1915 он Гэр бүлийн үдэш эхлэв
- 1918 он “Нас барагсдын гэтэлгэлийн тухай үзэгдэл”-ийг хүлээн авчээ (С ба Г 138-ыг үз)

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн амьдрал

1. “Жозеф Ф.Смит 1838 онд Миссури дэх мөрдлөг хавчлага дээд цэгтээ хүрээд байсан үед Фар Вест дэх ариун сүмийн газрын ойролцоо нэг жижигхэн байшинд төржээ. Жозефыг төрөх үед аав Хайрум Смит нь Миссурийн Ричмондод шоронд хоригдож байв. Ээж Мэри Фиелдинг Смит нь хүүхдүүдээ асрахаар гэртээ ганцаараа үлдсэн байжээ.


2. “Бяцхан Жозеф гэр бүлийнхээ хамт Миссуригээс Иллинойн Наувуд шилжсэн аж. Тэнд амьдралынх нь үлдсэн хугацаанд санаанаас нь огт гардаггүй нэг үйл явдал болж-Картейж шоронд аав, авга ах хоёр нь алагдсан хэрэг гарсан ажээ. Аав нь Картейж руу мориор явах замдаа хүүгээ дээр өргөн үнсээд, доош нь буулгасан тэр үед аавыгаа сүүлчийн удаа харснаа хэзээ ч мартдаггүй байжээ. Бас хөрш нь шөнө цонх тогшиж, Хайрум алагдсан тухай ээжид нь хэлэхийг сонссон аймшигт мөчийг тэр бас хэзээ ч мартдаггүй байв. Аав, авга ах хоёроо Науву дахь Маншен Ордонд авсан дотроо хэвтэж байхыг харсан нь ой ухаанаас нь хэзээ ч арилж алга болоогүй ажээ.



3. “Жозеф хөвгүүн бараг л нэг шөнийн дотор эрийн цээнд хүрсэн юм. Мэри Фиелдинг Смит болон түүний гэр бүл Наувугаас дүрвэгчидтэй нийлэхэд, 7 настай Жозеф мухлаг тэрэгнүүдийн нэгнийх нь жолооч болжээ. Ээж нь түүнийг өнчрүүлж нас барахад Жозеф 13 настай байв. Тэр 16 хүрэхээсээ өмнө Сандвич арлууд (хожим нь Хавайн арлууд гэж нэрлэсэн) руу номлолд явжээ. Жозеф Хонолулуд ирснээс хойш гурван сарын дотор нутгийн хэлээр чөлөөтэй ярьдаг болсон гэдэг. Түүнийг онцгойлон адисалсан Арванхоёрын Ахлагчид Парли П.Пратт, Оорсон Хайд нар түүнд сүнсний бэлэг өгсөн аж. Тэр 21 настайдаа өөр нэг номлолд явсан бөгөөд энэ удаа Британийн арлууд руу 3 жилээр явжээ.



4. “Ерөнхийлөгч Бригам Янг түүнийг Төлөөлөгчөөр томилох санаа төрсөн үед Жозеф дөнгөж 28 настай байлаа. Дараагийн жилүүдэд тэрээр Сүмийн дөрвөн Ерөнхийлөгчийн зөвлөхөөр үйлчлэв. 1901 оны аравдугаар сард Лоренцо Снөүг нас барахад Жозеф Ф.Смит Сүмийн зургаа дахь Ерөнхийлөгч болов. Сайн мэдээний үнэнүүдийг ухуулах, хамгаалах чадвараараа тэр гарамгай нэгэн байсан юм. Түүний номлол болон бичсэн зүйлүүдийг *Сайн Мэдээний Сургаал* гэсэн нэртэй боть болгон эмхтгэсэн нь Сүмийн сургаалын чухал ач холбогдолтой бүтээл болсон юм.



5. “Хорьдугаар зууны эхний хэдэн арван жилд Сүм хэд хэдэн чухал ахиц дэвшил гаргав. Аравны нэг болон Гэгээнтнүүдийн итгэлтэй хариултад анхаарал төвлөрүүлэхээ үргэлжлүүлснээр Сүм бүх өрөө төлөх боломжтой болжээ. Өрөө төлсний дараа цэцэглэл хөгжилтийн үе залгаж, ариун сүм, ариун ёслолын танхим, айлчлагчдын төвүүд барих, Сүмийн түүхэнд холбогдолтой газруудыг худалдаж авах боломж Сүмд бий болов. Өдгөөг хүртэл Сүмийн төв байр болж байгаа Захиргааны байрыг Солт Лейк хотод барьжээ.

6. “Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит дэлхий даяарх ариун сүмийн хэрэгцээг ухааран ойлгосон байлаа. Швейцарийн Бернд болсон 1906 оны нэг чуулган дээр тэр гараа дэлгэн, “Энэ газар ариун сүмүүдээр тэмдэглэгдэж, та нар тийшээ явж, нас барагсдаа гэтэлгэх тэр цаг ирнэ” хэмээн мэдэгджээ

[Сөөрж Ф. Баллиф, In Conference Report, 1920 оны аравдугаар сар, 90-ээс эш татжээ]. Европ дахь хожмын үеийн анхны ариун сүм, Швейцарийн Ариун сүмийг бараг хагас зууны дараа Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит бошиглолоо хийсэн хотын захад онцгойлон адисалсан ажээ. Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит 1913 онд Канадын Альбертын Кардстонд, 1915 онд Хавайд ариун сүм барих газрыг онцгойлон адисалсан юм.



7. “1900-аад оны эхэн үеэс Гэгээнтнүүдийг Ютад цуглахаас илүүгээр нутаг нутагтаа үлдэхийг нь Сүмийн удирдагчид урамшуулан дэмжих болов. 1911 онд Жозеф Ф.Смит болон Тэргүүн Зөвлөл дэх түүний зөвлөхүүд: ‘Манай хүмүүс төрөлх нутагтаа үлдэж, номлолын ажилд туслах байнгын шинжтэй цугларагсдыг бий болгохыг хүсч байна’ гэсэн мэдэгдэл хийв [Кларкийн эмхтгэсэн, *Messages of the First Presidency*, 4:222].

8. “Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит нас барахаасаа зургаан долоо хоногийн өмнө нас барагсдын гэтэлгэлийн талаар нэг чухал илчлэлт хүлээн авчээ. Тэрээр сүнсний дэлхий дэх Аврагчийн үйлчлэлийг үзэгдэлд харж, сүнсний дэлхийд сайн мэдээг үргэлжлүүлэн заах боломж итгэлтэй Гэгээнтнүүдэд байдгийг мэдсэн ажээ. Энэ илчлэлт 1976 онд Агуу Үнэт Сувдад нэмэгдэж, 1979 онд Сургаал ба Гэрээнд 138-р хэсэг болж орсон байна” (*Бидний Өв*, 124–125).

Уншсанаа ойлгох нь



Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн амьдрал

Дүрвэлт (догол мөр 3)—Үй олноороо шилжин явах	Байнгын шинжтэй цугларагсад (догол мөр 7)—
Ухуулах (догол мөр 4)—Заах	Байнгын салбар, хэсгүүд
	Гэтэлгэл (догол мөр 8)—
	Аврал

Жозеф Ф.Смитийн сургаал ба гэрчлэл



9. “[Ерөнхийлөгч Жозеф Ф. Смит] Сүмийн Ерөнхийлөгч байхдаа, ялангуяа зарим судрын хэсгүүд Есүс Христийг Эцэг гэж нэрлэсэн байдаг учраас Эцэг Хүү хоёр хэн болох тухай мөн тэдний үүргүүдийг тодруулахыг хичээж байжээ. Эцэг Хүү хоёрын талаарх зарим судруудыг ойлгоход нь Гэгээнтнүүдэд туслах хүч чармайлт гаргаж

Тэргүүн Зөвлөл, Арванхоёрын Чуулга 1916 оны зургадугаар сарын 30-нд ‘Эцэг ба Хүү’ гэсэн нэртэй сургаалын тайлбар гаргасан аж. Эл тунхаг Бурхан Эцэг, Түүний Хүү Есүс Христийн хоорондын нэгдлийг тодорхой зааж, авралын

төлөвлөгөөн дэх тэдний хүн тус бүрийн ялгаатай үүргийг тодруулсан юм. Энэ нь *Эцэг* гэдэг нэр томьёо Тэнгэр дэх Эцэг болон Есүс Христ хоёуланд нь холбогддог тохиолдлуудыг бас тайлбарлажээ” (*Teachings of Presidents of the Church: Joseph F. Smith*, 353). Сургаалын энэ тайлбар нь *Эцэг* гэдэг нэр томьёо гурван тохиолдолд Есүс Христэд холбогдогийг тайлбарласан байдаг: Есүс бол тэнгэр, газрын Эцэг мөн. Тэр бол Түүний сайн мэдээгээр амьдардаг хүмүүсийн Эцэг мөн. Бас Тэр бол бурханлиг эрх мэдлийг үндэслэсэнээр Эцэг юм.

10. “‘Эцэг’ гэдэг үгийн судрын [нэг] утга нь Бүтээгч мөн. . . .

11. “. . . Иехова хэмээн бидний мэддэг Есүс Христ бол бүтээлтийн ажилд Эцэг, Элохимын гүйцэтгэгч байсан билээ. . . . Есүс Христ Бүтээгчийн хувьд тэнгэр ба газрын Эцэг хэмээн нэрлэгддэг . . . Мөн Түүний бүтээлүүд мөнхийн шинжтэй учраас Тэрээр тэнгэр ба газрын Мөнхийн Эцэг гэж нэрлэгддэг нь туйлын тохиромжтой юм. . . .

12. “Есүс Христ ‘Эцэг’ гэж тооцогддог [өөр нэг] тохиолдол нь Түүний Сайн мэдээг хүлээн авдаг хүмүүсийн хоорондын харилцаанд хамаатай юм. Тэд үүгээрээ мөнх амьдралыг өвлөгчид болдог. . . .

13. “. . . Хүмүүн Сайн мэдээнд дуулгавартай байснаар Бурханы хөвгүүд, Есүс Христийн хөвгүүд, бас Түүгээр дамжин Түүний Эцэгийн хөвгүүд байж болно гэдэг нь энэ эрин үед өгөгдсөн олон илчлэлтэд тодорхой болсон билээ [С ба Г 11:28–30; 34:1–3; 35:1–2; 39:1–4; 45:7–8-ыг үз]. . . .

14. “Ус болон Сүнснээс шинээр төрснөөр—хүн төрөлтөн Есүс Христийн хүүхдүүд байж болно. . . .

15. “‘Эцэг’ гэдэг нэр Есүс Христэд холбогддог [өөр нэг] шалтгаан бол хүмүүний гэр бүлтэй харилцсан өөрийн бүх харилцаанд хүч, эрх мэдлийн хувьд Есүс Хүү Өөрийн Эцэг Элохимыг төлөөлж байсан эсвэл төлөөлсөөр байгаа баримт юм. Энэ нь Христийн хувьд түүний өмнөх оршихуй, мөнх бус байдлын буюу Иехова хэмээн нэрлэгддэг байсан, бие махбодтой болоогүй байдал; бас маханбодод Тэрээр биетэй болсон үед; мөн биегүй Сүнс байдлаар нас барагсдын ертөнцөд хөдөлмөрлөсний хувьд; мөн Түүний амилсан үеэс хойших байдалд үнэн юм [Иохан 5:43; 10:25, 30; 14:28; 17:11, 22; 3 Нифай 20:35; 28:10; С ба Г 50:43-ыг үз]. Тийнхүү Эцэг Өөрийн нэрийг Хүүдээ өгсөн юм. Иймээс Есүс Христ Эцэгийн нэрээр ярьж, үйлчилдэг байлаа. Чухам иймээс хүч, эрх мэдэл болон бурханлиг шинж чанар Түүний үг, үйл хэрэгт илэрдэг байсан, мөн илэрсээр байгаа нь Эцэгээс өвлөгдөн ирсэн шинж чанар юм” (“The Father and the Son: A Doctrinal Exposition by the First Presidency and the Twelve,” *Improvement Era*, 1916 оны 8-р сар, 935–937, 939–940).

16. Ерөнхийлөгч Жозеф Ф.ЖСмит болон Тэргүүн Зөвлөл дэх түүний зөвлөхүүд “хүний гарал үүслийн талаарх. . . . Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн байр суурийн тухай асуултуудад хариулах мэдэгдлийг 1909 онд гаргажээ.

17. “. . . Одоо бид асууя: Хүн анх бүтээгдэхдээ сүнсээр болон биеийн хэлбэр төрх нь ямар байсан юм бол? Энэ асуултанд хариулах ерөнхий арга зам эл шастирын бичвэрт сонгогдсон үгсэд өгөгдсөн байдаг. ‘Бурхан хүнийг өөрийн дүр төрхөөр бүтээжээ.’ . . . Иймээс, хэрэв бид ‘сүнсний Эцэг,’ ‘бүх махан биеийн сүнснүүдийн Бурханы хэлбэр төрхийг мэдэж чадах юм бол,’ бид анхны хүний хэлбэр төрхийг нээн мэдэх боломжтой болно.

18. “Бурханы Хүү Есүс Христ Эцэгийнхээ хүний ‘дүр төрхийг илэрхийлдэг’ (Еврей 1:3). Тэрээр төгс хүмүүн болж газар дээр амьдарч байсан билээ. Тэрээр Өөрт нь тавьсан асуултанд: ‘Намайг харсан хүн Эцэгийг харсан’ (Иохан 14:9) хэмээн хэлжээ. Энэ асуудлыг хэрсүү ухаанаар, хүндэтгэлтэй ханддаг оюун санаагаар, сэтгэл ханамжтайгаар шийдвэрлэхэд ганцхан дээрх хариулт л хангалттай юм. Бурханы Хүү л Эцэгийнхээ дүр төрхийг (адилхан байдлыг) илэрхийлэх нь няцаагдашгүй үнэн юм. Учир нь энэ бол зөвхөн Түүний мөнх бус амьдралын үе дэх төдийгүй, бас Түүний мөнх бус амьдралын өмнөх үеийн, бас Түүний Амилалтын дараах Бурханы Хүүгийн хэлбэр төрх байлаа. . . . Тэгвэл, хэрэв Бурхан хүнийг, анхны хүнийг—Өөрийн дүр төрх буюу адил төстэй байдлаар бүтээсэн юм бол, Тэрээр түүнийг Христтэй адилханаар, үүнээс үүдэн Христийн үеийн болон манай өнөө үеийн хүмүүстэй адилханаар бүтээсэн байх ёстой. . . .

19. “Бидний агуу өвөг дээдэс, ‘анхны хүн’ Адам Христтэй адилхан, өмнөх оршихуйн сүнс байсан бөгөөд Христтэй адилхан бие, хүний биеийг авч, ингээд ‘амьд бодгаль’ болсон ажээ. Ийм энгийн байдлаар, ялангуяа хожмын өдрүүдэд илчлэгдсэн, өмнөх оршихуйн сургаал нь хүний гарал үүслийн талаарх өөр байдлаар авч үздэг нууцлаг асуудал дээр гайхалтай гэрлийн үерийг буулгасан юм. Хүн сүнсэн хэлбэрээр Тэнгэрлэг эцэг эхээс төрсөн юм. Хүн мөнх бус байдалд туршлага олж авахын тулд зуурдын бие махбодтойгоор дэлхийд ирэхээсээ өмнө Эцэгийн мөнхийн харшид эрийн цээнд хүрч өсөн хүмүүжсэнийг энэ нь харуулж байна. Бүх хүмүүс махбодод оршихын өмнө сүнсээр оршиж байсныг, мөн Адамаас хойш дэлхий дээр аж төрж байсан бүх хүмүүс бие махбодтой байж, ийм замаар бодгаль болсныг энэ нь заадаг.



20. “Адам дэлхий дээрх анхны хүн байгаагүй, бас анхны хүн нь доод төвшний амьтны бүтээлтээс үүдэлтэй хөгжилт мөн гэж зарим хүмүүс үздэг. Гэвч энэ бол хүний онол юм. Адам бол ‘бүх хүмүүсээс анхны хүн’ (Моисе 1:34) байсныг Их Эзэний үг тунхагладаг. Иймээс бид түүнийг гарал үүслийнхээ анхны эцэг гэж үзэх үүрэгтэй юм. . . .

21. “Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм эртний болон өнөө үеийн бурханлиг илчлэлт дээр итгэлээ

тулгуурлан, хүмүүн бол Бурханы шууд үр удам хэмээн тунхагладаг билээ. Бурхан Өөрөө өргөмжлөгдсөн, төгс, хаан сэнтийд заларсан, хамгийн дээд хүн мөн. . . . Тэрбээр шанаган хорхой болон сармагчин, арслан болон зааныг бүтээсэн юм. Гэвч Тэр эдгээр амьтдыг өөрийн дүр төрхөөр бүтээгээгүй юм. Бас Тэрбээр эдгээр амьтдад Бурханых шиг учир шалтгаан, оюун билгээр хишиг хүртээгээгүй юм (“The Origin of Man,” *Improvement Era*, 1909 оны 11-р сар, 75, 77–78, 80–81).

22. “Нас барсан бага насны хүүхдүүд амилуулалтад хүүхэд чигээрээ босч ирэх болно гэсэн сургаалыг [Бошиглогч] Иосеф Смит заасан юм. Тэрээр амьгүй төрсөн хүүхдийн ээжид хандан: ‘Энэ хүүхэд сүнсний бүрэн байдалд хүрч, амилуулагдсаны дараа танд баяр баясал, аз жаргал болон энэ хүүхдийг тэжээж өсгөхийн сэтгэл ханамж ирнэ’ гэж хэлжээ. Үхлээс амилуулагдсаны дараа сэргээлт, өсөлт хөгжилт байдаг. Энэ үнэнд би дургтай. Энэхүү үнэн өгүүлшгүй аз жаргал, баяр баясал, талархлыг бодгальд минь өгүүлдэг. Эдгээр зарчмуудыг бидэнд илчилсэн Их Эзэнд талархагтун” (“Status of Children in the Resurrection,” *Improvement Era*, 1918 оны 5-р сар, 571).

23. 1915 онд Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит болон Тэргүүн Зөвлөл дэх түүний зөвлөхүүд “Тадасны ерөнхийлөгч, бишоп болон Сион дахь эцэг эхчүүдэд” зориулсан захидал гаргажээ.

24. “Тэр бүлийн үдшээр эцэг эхчүүд хөвгүүд охидоо гэртээ цуглуулж, Их Эзэний үгийг тэдэнд зааж байх ‘Тэр Бүлийн Үдшийг’ Сүм даяар нэвтрүүлэхийг бид зөвлөн, хичээнгүйлэн хүсч байна. . . .

25. “Хэрэв Гэгээнтнүүд энэ зөвлөгөөг дуулгавартай дагах юм бол, агуу адислалууд тэдэнд ирнэ гэдгийг бид амлаж байна. Гэр орон дахь хайр, дуулгавартай байдал өснө. Израилын залуучуудын зүрх сэтгэлд итгэл хөгжих болно. Аюул занал учруулдаг хилэнцэг нөлөө, уруу таталттай тэмцэх хүчийг тэд олж авна” (“Home Evening,” *Improvement Era*, 1915 оны 6-р сар, 733–34).

26. “Залуу халуун насаа ёс бус байдал, нүгэлд өнгөрүүлээд, дараа нь хожмын өдрүүдэд зөв шударга байдал руу эргэдэг хүнд ямар нэг зүйл үргэлж үгүйлэгдэж байдаг. Мэдээжийн хэрэг, Их Эзэн тэр хүний наманчлалыг хүндэтгэдэг. Хүн бүх амьдралаа нүгэлд үргэлжлүүлснээс, хожуу ч гэсэн нүглээс эргэх нь хамаагүй дээр. Гэвч тийм хүн амьдралынхаа хамгийн сайхан үе, хүч чадлыг дэмий хүр, харин Их Эзэнд үйлчлэх ядмаг, тааруухан үйлчлэл л түүнд үлдсэн байдаг нь үнэн юм. Залуу насны алдаа, нүглээс хожуу наманчлах нь харамсал, зүрх сэтгэлийн эмзэглэлийг авчирдаг. Харин насны залуу, нарны эртэд Их Эзэнд үйлчлэх нь тайтгарал, арвин баялаг шагналыг авчирна” (“A Lesson for the Boys,” *Improvement Era*, 1906 оны 2-р сар, 338).

27. Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит номлолд цэл залуухан эр байхдаа зүүдэлсэн нэг зүүдээ тэмдэглэн үлдээжээ:

28. “Би аялаар явж байх юм. Бас яарах хэрэгтэй юм шиг санагдаж байлаа. . . . Эцэст нь би нэгэн гайхалтай харшид хүрч ирэв. . . . Тэгээд би харшийг чиглэн хар хурдаараа гүйтэл, ‘Усанд ор’ гэсэн бичиг харагдахад, хажуу тийш түргэн эргэж, онгоцонд ороод биеэ цэвэрлэн угаалаа. Өөртөө байсан нэгэн жижигхэн боодолтой юмыг задалсан чинь, хос цэвэрхэн цагаан гармент байх юм. . . . Би гарментыг өмслөө. Тэгээд хаалга эсвэл нээлттэй их том нэг юм руу гүйлээ. Хаалга тогштол нээгдэж, нэг хүн зогсож байсан

нь Бошиглогч Иосеф Смит аж. Тэр над руу ялихгүй шүүмжилсэн байлаар, эелдэг зөөлхөн харлаа. Тэгээд тэрээр ам нээж: ‘Жозеф, чи хожимджээ’ гэх нь тэр. Гэвч надад итгэл төрж, ийн хэллээ:

29. “Тийм ээ, гэвч би цэвэрхэн байна—би цэвэрхэн байна шүү дээ!”

30. “Тэр миний гарыг атгаж, намайг дотогш оруулаад, нөгөөх том хаалгыг хаав” (*Gospel Doctrine*, 542).

31. Жозеф Ф.Смит анхныхаа номлолоос гэртээ эргэж ирэх үед, “мухлаг тэрэгтэй цөөхөн хүнтэй бүлэг ойрхон газрыг явж өнгөрөөд буудаллаад байтал, морьтой хэсэг согтуу хүмүүс буусан газар руу нь давхиж ирээд, хараал зүхэл болж, тэр хавиар явсан ‘Мормончуудыг’ хэнийг нь ч ялгаагүй тонилгох болно гэж заналхийлжээ. Дээрэмчин тонуулчидтай эхлээд нүүр халз тулах учрал Жозеф Ф.Смитэд тохиосон аж. . . . Тэр хүмүүсийг давхиж ирэхэд Жозеф Ф.Смит гал асаах мод түүхээр буудалласан газраасаа арай хол байсан аж. Буутай хүмүүсийг хараад, бусад ах нарын нэгэн адил ой уруу орж, нуугдах газар хайя гэж анх түүнд бодогдсон гэнэ. Дараа нь дахиад ингэж бодогдсонд, ‘Яагаад би энэ нөхдөөс зугатаах ёстой юм бэ?’ гэж өөрөөсөө асуув. Тэр ингэж бодон, тэвэр дүүрэн модтой, буудалласан газар руугаа зоригтойхон алхаж иржээ. Модоо газарт тавих гэтэл, танхайрагч нэг этгээд гартаа буу барьсан хэвээр залуу Ахлагч руу зааж, олиггүй архичны амнаас л гармаар үгсээр хараан зүхэж, өөртэйгөө тааралдсан ‘Мормон’ бүрийг хүйс тэмтрэх нь түүний үүрэг хэмээн чанга хашгирч, уурлан хилэгнэсэн дуугаар, ‘Чи “Мормон уу?” гэв.’



32. “Жозеф Ф.Смит агшин зуур ч эргэлзэлгүйгээр, нөгөөх танхай этгээдийн нүд өөд эгцлэн ширтэж, ‘Тийм ээ, ноёнтон. Би бол үнэнхүү шийдвэр төгс Хожмын үеийн нэгэн Гэгээнтэн байна’ гэж зоригтойгоор хариулав.

33. “Огт зэвсэггүй атлаа очүүхэн ч айсан шинжгүйгээр хариулсанд, нөгөөх түрэмгий авирт ичсэндээ номлогчийн гараас шүүрч аваад:

34. “‘Хөөе, чи чинь, харин надтай ерөөсөө таарч байгаагүй. . . тун аятайхан хүн байх чинь юу вэ! Гар барьчихья,

залуу нөхөр минь. Итгэл үнэмшлийнхээ төлөө хатуу зогсдог хүнтэй тааралдсандаа би баяртай байна’ гэжээ.

35. “Энэ хүнд буудуулах нь гарцаагүй боллоо. За ингээд миний үхлийн шороо энд пурхийх нь дээ гэж бодсоноо Жозеф Ф.Смит хожим нь дурсжээ. Бүлгийн толгойлогч байсан нь сайхь хүн давхиж одоход, бусад нь араас нь дагаж, Мормоны хүмүүсийг дахин хоргоохоо больж билээ” (Жозеф Фиелдинг Смит эмхтгэсэн, *Life of Joseph F. Smith*, 2 дахь хэвлэл, [1969], 188–189.)

36. “Бид зөв шударга ёсонд итгэдэг. Үнэн ямар субьектэд хамаатай нь чухал биш, бид бүх үнэнд итгэдэг. Бидний хүлээж авдаггүй эсвэл бидний эсэргүүцдэг үнэний ганц боловч зарчмыг баримталдаггүй ямар ч шашин буюу шашны бүлэглэл дэлхий дээр байдаггүй. Үнэн ямар ч эх

сурвалжаас үүдэлтэй байлаа гэсэн, бид бүх үнэнийг хүлээж авахыг хүсдэг. Учир нь үнэн оршсоор байх болно. Үнэн үргэлжлэх болно. Бүх дэлхий дээрх ямар ч хүний итгэл бишрэл, ямар ч хүний шашин, ямар ч шашны байгууллага хэзээ ч үнэнээс дээгүүр гарч чадахгүй. Шашны үндэс сууринд үнэн байх ёстой. Эс бөгөөс шашин хий хоосонд байж, зорилгоо биелүүлж чадахгүй. Үнэн үндэс сууринд, ёроол болон оройд хоёуланд нь байдгийг-бошиглогч Иосеф Смитийн хүч чармайлт, ажлаар дамжин үндэслэгдсэн Их Эзэний энэ агуу ажилд бүхэлд нь эл үндэс суурь нэвт шингэснийг би хэлнэ. Бурхан энэ үнэнтэй хамт байдаг. Хүний ажил бус, харин Түүний ажил, ямар ч эсэргүүцэл тулгарлаа гэсэн, амжилт олно” (In Conference Report, 1909 оны 4-р сар, 7).

37. “Гэтэлгэгч минь амьдыг би мэднэ. Үүнийг би биеийнхээ эс болгонд мэдэрдэг. Би хүмүүн биеийг олж төрсөндөө сэтгэл хангалуун байдагтайгаа адилхан энэхүү үнэнд бас сэтгэл хангалуун байдаг. Гэтэлгэгч минь амьд гэдгээс, миний Бурхан, миний Аврагчийн Эцэг амьд гэдгээс илүү баттайгаар би өөрийнхөө хүмүүн биеийг мэдэрч чаддаггүй. Үүнийг би сэтгэл санаандаа мэдэрдэг. Энэхүү үнэнд би бүхэл хүмүүн биеэрээ хөрвөгдсөн юм” (*Gospel Doctrine*, 69).

Уншсанаа ойлгох нь



Жозеф Ф.Смитийн сургаал ба гэрчлэл

Хишиг хүртээх (догол мөр 21)—Адислах, өгөх

Уншсанаа судлах нь



“Ерөнхийлөгч Жозеф Ф. Смит”-ийг судлахдаа, дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн амьдралыг нэгтгэн дүгнэ

Жозеф Ф.Смитийн амьдрал, түүний Ерөнхийлөгчийн Зөвлөлийг судалж, дараах үйл явдлуудын үед тэр хэдэн настай байсныг бич:

1. Аав Хайрум Смит нь Либерти шоронд байв (С ба Г 121-ийн хэсгийн тоймыг үз).
2. Аав нь, бас авга ах Бошиглогч Иосеф Смит алагдав (мөн С ба Г 135:1-ийг үз).
3. Тэрээр Солт Лейкийн Хөндий рүү үхэр тэрэг жолоодон явав.
4. Ерөнхийлөгч Хебер К.Кимбалл түүнд баптисм хүртээв.
5. Ээж нь нас барав.
6. Анхныхаа номлолд явлаа.
7. Төлөөлөгчөөр томилогдов.
8. Анхныхаа эхнэртэй гэрлэв.
9. Албан Тунхаг 1-ийг Сүм хүлээн авав.
10. Сургаал ба Гэрээ 138-р хэсэгт цэдэглэгдсэн үзэгдлийг хүлээн авав.
11. Нас барав.

Б Үлгэр жишээг ол

“Хожмын Үеийн Гэгээнтэн байх нь дэлхийн зорилго, зугаа цэнгэлийг золиослохыг шаарддаг. Ингэх нь үнэнч шударга зан, сэтгэлийн тэнхээ, үнэнийг эрхэмлэн дээдлэх, зарчимч шударга байх, амжилт ололтыг харах гандан бууршгүй хүсэлтэй байж, үнэн өөд эрчимтэй тэмүүлэхийг шаарддаг” хэмээн Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит бичжээ (“Principle, Not Popularity,” *Improvement Era*, 1906 оны 7-р сар, 733). Тэрээр жинхэнэ Хожмын Үеийн Гэгээнтэн байсныг харуулсан гурван жишээг амьдралаас нь гарга.

В Жагсаалт хий

Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн амьдрал, түүний Ерөнхийлөгчийн Зөвлөлийн (х.00 186) талаарх схемээс, семинар анх хэзээ зохион байгуулагдсаныг, Сүм хэзээ Хөвгүүдийн Скаутыг өөртөө хүлээн авсныг, гэр бүлийн үдэш хэзээ эхэлснийг жагсаан бич. Өнөөдөр дэлхийд уруу таталтыг эсэргүүцэх буюу үүнээс зайлсхийхэд эдгээр үйл ажиллагаа тус бүр нь гэр бүл, хувь хүмүүст хэрхэн тусалж чадах тухай бич.



Солт Лейк хотод Грантит Семинарт Сүмийн анхны хичээлийн цагийн хуваарьт орсон семинарын хичээл эхэлжээ.

Г Түүний сургаалыг тунгаан бод

Догол мөр 9–37 дахь Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн сургаалуудыг нэгтгэн дүгнэж, дараах асуултуудад хариул:

1. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёрын хэн нь Сургаал ба Гэрээ 25:1-д Эмма Смитэд хандан ярьж байна?
2. Хүн болон бусад төрлийн амьтдын амьдралын хооронд Бурханаас өгсөн зарим ялгаа юу вэ?
3. Нас барсан бага насны хүүхдүүд хэвээрээ амилуулагдах уу, насанд хүрэгчид болж амилуулагдах уу?
4. Гэр бүлийн үдшийг хийсний төлөө ямар адислалууд амлагдсан бэ?
5. Залуу насны он жилүүд яагаад амьдралын чухал хэсэг байдаг вэ? Хүн залуу насаа хэрхэн ашиггүй өнгөрүүлж мэдэх вэ?

Сургаал ба Гэрээ 138 Нас барагсдын гэтэлгэлийн тухай үзэгдэл

“Сүнсний дэлхий дэх зөв шударга хүмүүсийн хөдөлмөрийн талаар алдар суут нэгэн илчлэлт Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитэд өгөгджээ. 1918 оны аравдугаар сарын 3-нд, Ерөнхийлөгч Смит Есүс Христийн Цагаатгалыг тунгаан бодож байсан үед, Библиэ нээж, шорон дахь сүнснүүдэд Аврагч номлосон тухай 1 Петр 3:18–20, 4:6-гаас уншжээ. Тэрээр эдгээр хэсгийн талаар бясалгаж байх үед Их Эзэний Сүнс түүн дээр оршиж, сүнсний дэлхийд цугласан ‘үй олон нас барагсдыг’ үзэгдэлд харжээ.



Аврагч тэдний дунд хүрч ирэн, зөв шударга нас барагсдад сайн мэдээг номлохыг харсан аж. Номлолын энэ ажлыг үргэлжлүүлэхийг Их Эзэн бусад хүмүүст итгэмжлэн даатгасныг, түүнчлэн энэ эрин үеийн ахлагч нар мөнх бус байдлыг орхисны дараа нас барагсдад бас номлож болохыг түүнд үзүүлжээ. Тийнхүү бүх нас барагсад гэтэлгэгдэж болох ажээ.

“‘Нас барагсдын гэтэлгэлийн тухай энэ үзэгдлийг’ Ерөнхийлөгч Смит Тэргүүн Зөвлөл болон Арванхоёрт танилцуулахад, тэд үүнийг илчлэлт гэж үзэн санал нэгтэйгээр хүлээн авчээ. 1976 онд энэ илчлэлтийг Сүмийн жишиг бүтээлүүд дээр албан ёсоор нэмж, үүнээс хойш удалгүй Сургаал ба Гэрээний 138-р хэсэг болгожээ” (Church History in the Fulness of Times, 493).

Судруудыг ойлгох нь

Сургаал ба Гэрээ 138

Гэтэлгэл (ш. 2)—Аврал
Нойрсолтын тоос (ш. 17)—
Цогцос
Итгэмжлэлийг олгох (ш.
30)—Эрх мэдэл олгох

Төлөөлөн хийх баптисм
(ш. 33)—Нас барагсдын
өмнөөс амьд хүмүүсийн
хийдэг баптисм

Судруудыг судлах нь

Сургаал ба Гэрээ 138-р хэсгийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Захиа бич

1918 оны аравдугаар сар гэж төсөөлөн, Ерөнхийлөгч Жозеф Ф.Смитийн үзэгдлийн эргэн тойрон дахь үйл явдлуудыг өөрөө тайлбарлан, найздаа бичиж байна гэж бод. Эл үзэгдлийн өмнө мөн үзэгдлийн үеэр Ерөнхийлөгч Смит юу хийсэн тухай нэг догол мөр, мөн үзэгдлийн тухай товч хураангуйг, түүнчлэн Бурханаас илчлэлт хүлээн авахад бэлтгэх болон хүлээн авах тухай Сургаал ба Гэрээ 138:1-6, 11, 28-29 юу заадгийг оруул.

Б Ерөнхийлөгч Смит юу мэдсэн бэ?

Сургаал ба Гэрээ 138-р хэсгээс мэдсэн зүйлээсээ, дараах асуултуудад хариул:

1. Үхэл, Амилалтынхаа хооронд Есүс Христ хаашаа очсоныг 1 Петр 3:18-20, 4:6 (С ба Г 138:7-10-ыг үз) заадаг вэ?
2. Аврагч тэдэн дээр очсон болон очоогүй хүмүүсийн тухай Сургаал ба Гэрээ 138:11-22 ямар өөр ойлголт өгдөг вэ?
3. Сүнсний дэлхийд Есүс айлчилсан тухай Ерөнхийлөгч Смит ямар асуулт асууж, ямар хариулт авсан бэ? (шүлэг 25-37-г үз.)
4. Ариун сүмийн ач холбогдлын тухай Ерөнхийлөгч Смит юу мэдсэн бэ? (шүлэг 50-60-ыг үз.)

В Үй олон зөв шударга хүмүүсийн цугларалт

1. Сургаал ба Гэрээ 138:38-52-оос, Ерөнхийлөгч Смит сүнсний дэлхийд харсан, нас барсан хүмүүсийн нэрсийг жагсаан бич. Тэдэнд юу тохиолдсоныг тайлбарла.



2. Шүлэг 53-56-гаас, Ерөнхийлөгч Смит сүнсний дэлхийд харсан, Сүмийн түүхэт хүмүүсийн нэрсийг жагсаан бичиж, Ерөнхийлөгч Смит тэдний талаар юу “ажигласныг” бич.

3. “Үй олон хүмүүсийн цугларалтад” (шүлэг 39, 49-ийг үз) байж болно гэж өөрийн бодсон өөр таван хүний нэрсийг жагсаан бич.
4. Шүлэг 38-56-д дурдсан хүмүүсийг дүрсэлсэн үгс, өгүүлбэрүүдийг жагсаан бичиж, чи тэдэнтэй илүү адилхан болох арга замуудыг жагсаан бич.




Ерөнхийлөгч Хебер Ж.Грант Их Эзэнд үйлчлэхээр шийдсэн нь

Тэргүүн Зөвлөлийн зөвлөх, Ерөнхийлөгч Жеймс И.Фауст: “Хебер Ж.Грант бол миний хувьд танилцах онцгой боломж олдсон Сүмийн анхны Ерөнхийлөгч байлаа. Тэр үнэхээр агуу хүн байсан юм. Хүч чадлынх нь эх сурвалж өөртөө эзэн байх сэтгэлийнх нь хатад байсныг бид гайхан биширдэг байлаа” гэжээ. Хебер Ж.Грант бага залуу байхдаа бейсболын бөмбөг шидэж чаддаггүй, хэв муухай бичигтэй, дуулахдаа маруухан байсныг Ерөнхийлөгч Фауст цааш нь тайлбарласан байдаг. “Бүх амьдралынхаа туршид дадлага хийсээр байгаад дуулахдаа нэлээд сайжирсан ч, үнэхээр гаргуун тоглодог болсон бейсбол, гоё сайхан бичгийн хэвийг нь гүйцээгүй бололтой. ‘Бид хүсдэг юмаа цөхрөлтгүй шаргуу хийх юм бол амархан амжилтад хүрч болно. Тухайн юмны мөн чанар өөрөө өөрчлөгддөгт бус, харин түүнийг хийх бидний хүч чадал өсөн нэмэгддэгт учир нь байдаг” гэсэн Ральф Вальдо Эмерсоны үгийг Ерөнхийлөгч Грант эш татах дуртай байлаа. Тэр чухамдаа энэ үгээр амьдардаг байсан юм (In Conference Report, 2000 оны 4-р сар, 56-57; Ensign, 2000 оны 5-р сар, 44-45). Сайжрахын төлөө шийдвэр төгс байсан нь Ерөнхийлөгч Грантыг насан туршид нь адисалсан юм.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын туслах байсан Ахлагч Жон Лонгден, мөн Арванхоёрын Чуулгын туслах Ахлагч Клиффорд И.Янгийн ярьсан туршлагыг хуваалцжээ: “ [Ерөнхийлөгч Грантыг] талийгаач болохоос өмнө гурав эсвэл дөрвөн долоо хоногийн өмнө Янгах гэрт нь очиж түүнтэй уулзжээ. Ерөнхийлөгч Грант дараах залбирлыг хэлсэн ажээ: ‘Ай Бурхан минь, гэрчлэлээ алдахгүй байхын төлөө, [би] эцсийг хүртэл итгэлтэй хэвээр байхын төлөө намайг адислаач!’ ” (In Conference Report, 1958 оны 10-р сар, 70).

ТҮҮНИЙ АМЬДРАЛ (1856–1945)

- 1856 он** Арваннэгдүгээр сарын 22-нд Солт Лейк хотод Жедедия Морган Грант, Рачел Рижвей Айванс Грант нарын гэр бүлд төрсөн. Ерөнхийлөгч Бригам Янгийн зөвлөх байсан аав нь ес хоногийн дараа нас баржээ.
- 1872 он** 16 настайдаа, ахлах сургуулиа дүүргэж, банк, бизнесийн салбарт ажил албаа эхлэв
- 1877 он** 20 настайдаа, арваннэгдүгээр сарын 1-нд Люси Стрингемтай гэрлэв. Люси 1893 онд нас барсан.
- 1880 он** 23 настайдаа, гадасны ерөнхийлөгчөөр дуудагдав
- 1882 он** 25 настайдаа, Тэргүүн Зөвлөлийн зөвлөх Ерөнхийлөгч Жорж К.Каннон түүнийг Төлөөлөгчөөр томилов
- 1883–1884 он** 26–27 настайдаа, Америкийн индианчуудад номлолд үйлчлэв
- 1901–1906 он** 43–48 настайдаа, Японы анхны номлолын ерөнхийлөгчөөр, дараа нь Британийн болон Европын номлолын ерөнхийлөгчөөр үйлчлэв
- 1916 он** 60 настайдаа, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч болов
- 1918 он** 62 настайдаа, Ерөнхийлөгч Жозеф Ф. Смитийг нас барсны дараа Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав
- 1945 он** 88 настайдаа, тавдугаар сарын 14-нд Солт Лейк хотод нас барав



ТҮҮНИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ (1918–1945)

- 1919, 1923, 1927 он** Хавай, Альберта, Аризон дахь ариун сүмүүдийг онцгойлон адислав
- 1924 он** Ерөнхий чуулганы анхны радио нэвтрүүлэг эхлэв
- 1925 он** Өмнөд Америкт анхны номлол зохион байгуулагдав
- 1926 он** Шашны институтын хөтөлбөр эхлэв
- 1930 он** Сүм зуун жилийнхээ ойг тэмдэглэв (670,000 орчим гишүүнтэй болсон байлаа)
- 1936 он** Сүмийн халамжийн хөтөлбөрийг зохион байгуулав
- 1941–1944 он** Дэлхийн II Дайны үед Сүмийн гишүүдийг цэргийн алба хаахад туслах хөтөлбөр эхлэв

Ерөнхийлөгч Хебер Ж. Грантын амьдрал

1. “1918 оны арваннэгдүгээр сард, Ерөнхийлөгч Жозеф Ф. Смит нас барахаасаа өмнөхөн, тэр үед Арванхоёрын

Ерөнхийлөгч асан Хебер Ж. Грантын гараас барьж: ‘Их Эзэн чамайг адислаг, хүү минь, чамд агуу хариуцлага буй. Энэ бол хүний ажил биш, Их Эзэний ажил гэдгийг ямагт санаж яв. Их Эзэн ямар ч хүнтэй зүйрлэх аргагүй аугаа юм. Тэрээр Сүмээ хэнээр удирдуулахыг хүсдэгээ мэддэг. Их Эзэн хэзээ ч, ямар ч алдаа гаргадаггүй юм’ гэж хэлжээ [“Editorial,” *Improvement Era*, 1936 оны 11-р сар, 692]. Хебер Ж. Грант 62 насандаа Сүмийн долоо дахь Ерөнхийлөгч болж, 1882 оноос хойш Төлөөлөгчөөр үйлчилсэн ажээ.

2. “Хебер залуу байхдаа, бас насан туршдаа зорилгодоо хүрэхийн төлөө ер бусын шийдэмгий байлаа. Бэлэвсэн эхийнхээ өсгөн хүмүүжүүлсэн айлын ганц хүү байсан тэрээр өөрийнхөө насны бусад хөвгүүдийн үйл ажиллагаанаас ямар нэг байдлаар зожиг хөндий байжээ. Бейсболын багт орохыг хичээсэн үед нь түүнийг эв дүйгүй гэж шоолон, ур чадвар тааруухан байсан учир багийн гишүүнээр авсангүй. Тэрээр санаагаар унахын оронд шидсэн бөмбөг барьж авах дасгалыг уйгагүй шаргуу хийж, эцэстээ орон нутгийн аварга шалгаруулах тэмцээнүүдэд хэд хэдэн удаа ялалт байгуулсан өөр багийн гишүүн болжээ.



3. “Тэрээр хөвгүүн байхдаа данс хөтлөгч болохыг хүсдэг байсан гэдэг. Данс хөтлөгч гутал тослох ажлаас нь илүү цалинтайг тэр олж мэдсэн ажээ. Тэр үед данс хөтлөх нь бичгийн яггүй чадвар шаарддаг байжээ. Гэтэл бичгийнх нь хэв цасан дээрх шувууны мөр шиг муухай арзгар харагддаг гэдэг байв. Тэр бас л санаагаар унасангүй, харин бичгийнхээ хэвийг сайжруулах дадлагыг олон цагаар хийдэг болов. Тэрээр гоё бичих чадвараараа нэрд гарч, эцэстээ их сургуульд хичээнгүй бичиг заадаг болж, чухал баримт бичгүүдийг бичүүлэхээр түүнийг олонтаа урьдаг байжээ. Тэрээр Их Эзэнд болон нөхөддөө үйлчлэхийн төлөө чадах бүхнээ хийдэг хүн байв. Шийдэмгий зан чанарыг нь олж харсан олон хүний хувьд тэр агуу үлгэр дуурайл байлаа.

4. “Ерөнхийлөгч Грант бол ухаалаг, амжилттай бизнесмен байсан юм. Дэлхий дахиныг хамарсан санхүүгийн хямрал болон уг хямралаас үүдэлтэйгээр хувь хүмүүст тулгарсан хүнд бэрхшээлийн үед Сүмийг удирдахад ур чадвар нь түүнд тусалсан ажээ. Бие дааж амьдрах чадвартай байх, засгийн газраас бус, харин Их Эзэнээс болон уйгагүй шаргуу хөдөлмөрөөсөө хамааралтай байхад тэрээр итгэдэг байлаа. Тэрээр олсон мөнгөөрөө гачигдалтай олон хүнийг адисалсан ажээ.

5. “1930-аад онд Гэгээнтнүүд дэлхий дахины бусад хүмүүсийн нэгэн адил Их Уналтын үед ажилгүйдэл, ядууралтай тэмцэж байлаа. 1936 онд Их Эзэнээс ирсэн илчлэлтийн үр дүнд, Ерөнхийлөгч Грант гачигдалтай хүмүүст туслах, бие

дааж амьдрах чадвартай болоход нь бүх гишүүдэд дэмжлэг үзүүлэхийн тулд Сүмийн Халамжийн Хөтөлбөрийг үндэслэн бий болгосон юм. Тэргүүн Зөвлөл энэ хөтөлбөрийн тухай: 'Бидний үндсэн зорилго бол боломжийнхоо хэрээр, залхуурлын зүхлийг үгүй болгож, ажилгүйдлийн тэтгэмжийн хилэнцийг халсан тогтолцоо бий болгох, манай хүмүүсийн дунд ажилч хичээнгүй, арвич хямгач, өөрийгөө хүндэтгэдэг чанарыг эгнэгт төлөвшүүлэх явдал мөн. Сүмийн зорилго бол өөрсдөдөө эзэн болоход нь хүмүүст туслах явдал мөн. Манай Сүмийн гишүүд ажил хөдөлмөрийг амьдралынхаа тэргүүлэх зарчим болгож, эрхэмлэн дээдлэх ёстой' гэж хэлжээ. [Тэргүүн Зөвлөл, In Conference Report, 1936 оны 10-р сар, 3].



6. "[Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Альберт И.Баувен], 'Халамжийн Төлөвлөгөөний урт удаан хугацааны зорилго бол сэтгэлийнхээ гүн дэх хамаг сайн сайхныг бусдад өгөгч бас үүнийг хүлээн авагч байх зан чанарыг Сүмийн гишүүдэд төлөвшүүлж, сүнсний далд баялгийг харуулах явдал мөн' хэмээн онцлон тэмдэглэжээ [The Church Welfare Plan (Gospel Doctrine course of study, 1946), 44].

7. "Сүмийн халамжийн үйл ажиллагаанд хяналт тавихын тулд Халамжийн Ерөнхий Хороог 1936 онд үндэслэн байгуулжээ. Анхдагч нарын гадасны ерөнхийлөгч Харольд Б.Лий тус хорооны гүйцэтгэх захирал болов. Хожим нь ажилгүйдчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст туслахын тулд Дезерет Индастрын дэлгүүрүүд ажиллаж, чачигдалтай хүмүүст туслахын тулд ферм, үйлдвэрлэлийн төслүүдийг үндэслэн байгуулжээ. Халамжийн хөтөлбөр нь Сүмийн гачигдалтай гишүүд, дэлхий даяар ядуу зүдүү амьдарч байгаа бусад мянга мянган хүмүүсийг өнөө үед адисалсаар байна. [Нэмэлт мэдээллийг Глен Л.Радд, *Pure Religion: The Story of Church Welfare Since 1930* (1995)-ээс үз.]



8. "Номлолын ажил өргөн цар хүрээгээр үргэлжилсэн үед Ерөнхийлөгч Грант нэгэн ер бусын хөрвүүлэгт зэмсэг болсон ажээ. Шашны тохинуулагч Винжензо ди Франческа гэгч итали хүн Нью-Йорк хотын гудамжаар сүм рүүгээ явж

байгаад, торх дүүрэн үнсэн дотор нэг хавтастай ном байхыг харжээ. Тэр хүн нөгөөх номыг авч, хуудсыг нь эргүүлж үзвэл, Нифай, Мозая, Алма, Моронай гэхчлэн нэрүүдийг анх удаа харсан аж. Номын нэр, гарал үүслийг тэрээр мэдэхгүй байсан ч, энэ номыг уншиж үзмээр, бас үнэн эсэхийг нь залбирч үзмээр санагдсан аж. Тэгээд үзтэл, 'ямар нэг үнэтэй, ер бусын юм олсон мэт баяртай мэдрэмж төрж, бодгальд минь тайвшрал ирж, хүмүүний хэл дүрслэх үгс олдомгүй баяр хөөр надад ирж билээ' гэж тэр хэлжээ. Тэрээр уг номон дахь зарчмуудыг өөрийнхөө сүмийн гишүүдэд зааж эхэлсэн гэнэ. Ингэснийх нь төлөө сүмийнх нь удирдагчид түүнд хатуухан сануулж, номыг шатаа гэсэн боловч, тэрээр татгалзжээ.

9. "Хожим нь тэр Италид эргэн ирж, нөгөөх номыг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмээс хэвлэснийг 1930 онд мэдсэн гэнэ. Тэрээр Юта дахь Сүмд захидал бичсэнийг Ерөнхийлөгч Грантад гардуулжээ. Ерөнхийлөгч Грант итали хэл дээр хэвлэгдсэн Мормоны Номыг түүнд илгээж, Европын номлолын ерөнхийлөгчид нэрийг нь өгөв. Дайны хүнд бэрх цаг баптисм хүртэхийг нь Винжензод олон жилээр саатуулсан ч, тэр эцэстээ 1951 оны нэгдүгээр сарын 18-нд Сицил арлаас анхны баптисм хүртсэн хүн болж, Сүмийн гишүүн болох боломжтой болжээ. Таван жилийн дараа тэр Швейцарийн Ариун сүмд хишиг хүртсэн аж. [Винжензо ди Франческа, "I Will Not Burn the Book!" *Ensign*, 1988 оны 1-р сар, 18-ыг үз.]



10. "1922 оны тавдугаар сарын 6-нд Ерөнхийлөгч Грант Сүмийн анхны радио станцыг онцгойлон адислав. Хоёр жилийн дараа радио станц ерөнхий чуулганы хуралдаануудыг нэвтрүүлж эхлэн, Ерөнхий Эрх Мэдэлтнүүдийн захиасуудыг сонсох боломжийг Сүмийн улам олон гишүүдэд олгосон юм. Түүнээс хойш удалгүй

1929 оны долдугаар сард Табернеклын Найрал дуу, бурханлигаар нөлөөлөгдсөн *Music and the Spoken Word* (Хөгжим ба Хэлсэн Үг) долоо хоног тутмын хөтөлбөрийн анхны нэвтрүүлгийг агаар мандалд цацжээ. Энэ хөтөлбөр өнөө үеийг хүртэл долоо хоног тутмын нэвтрүүлэг болж үргэлжилсээр байгаа билээ.

11. "Ерөнхийлөгч Грант 1945 оны тавдугаар сарын 14-нд нас баржээ. Сүмийн Ерөнхийлөгчөөр үйлчилсэн түүний 27 жилийг зөвхөн Бригам Янгийн үйлчлэлийн жилүүд л хугацаагаараа илүү гарчээ" (*Бидний Өв*, 125-129).

Уншсанаа ойлгох нь



Ерөнхийлөгч Хебер Ж.Грантын амьдрал

Их Уналт (догол мөр 5)—
Дэлхий дахиныг хамарсан
хэт ядуурлын үе

Ажилгүйн тэтгэмж (догол
мөр 5)—Засгийн газраас
зүгээр олгодог мөнгө
болон үйлчлэлүүд

Хебер Ж. Грантын сургаал ба гэрчлэл



12. 1925 онд Ерөнхийлөгч Хебер Ж. Грант болон Тэргүүн Зөвлөл дэх түүний зөвлөхүүд мөрийтэй тоглоомын талаар дараах мэдэгдлийг гаргажээ: “Сүм эдүгээг хүртэл аливаа хэлбэрийн мөрийтэй тоглоомыг эсэргүүцээр ирсэн нь цаашид ч өөрчлөгдөхгүй. Мөнгийг эзнээс нь ямар нэг үнэт зүйлийг хариуд нь өгөлгүйгээр азаар, ажил буюу бизнес гэгчээр авах аливаа тоглоомыг Сүм эсэргүүцдэг. Буруу арга замаар амар хялбар

ашиг хонжоо олох сэтгэлийг дэвэргэн өөгшүүлэх хандлагатай бүх зуршил, ялангуяа Сүмийн гишүүдийн, өргөн хүрээгээр бол манай нийгмийн үргэлж баримталж ирсэн ёс суртахууны өндөр жишгийг гутаах буюу сулруулахад чиглэсэн зүйлийг Сүм эсэргүүцдэг” (“Мөрийтэй тоглоом,” *Improvement Era*, 1926 оны 9-р сар, 1100-гаас эш татав).

13. Дэлхийн II Дайны үед олон улс орны Сүмийн гишүүдийг дайнд явахыг, тэр ч байтугай заримдаа тэднийг бие биенийхээ эсрэг дайтахыг шаарддаг байлаа. 1942 оны дөрөвдүгээр сарын ерөнхий чуулган дээр уншсан мэдэгдэлд Ерөнхийлөгч Хебер Ж. Грант болон Тэргүүн Зөвлөл дэх түүний зөвлөхүүд өгүүлэхдээ:

14. “Христийн сайн мэдээ бол хайрын болон амар амгалангийн, хатуужил болон тэвчээрийн, тэсвэр болон уучлалын, нинжин сэтгэл болон сайн үйлсийн, энэрлийн болон ах дүү ёсны хайрын сайн мэдээ юм. . . .

15. “Зөв шударга хүмүүсийн санаа сэтгэлд үзэн ядалт байж чаддаггүй. . . .

16. “. . . Үзэн ядалт Сатанаас бий болдог. Хайрыг Бурхан төрүүлдэг. Бид, бидний хүн нэг бүр үзэн ядалтыг зүрх сэтгэлээсээ албадан зайлуулж, түүнийг бодгальдаа дахин оруулахгүй байх ёстой. . . .

17. “Зуун жилийн туршид Сүм дараах зарчмуудаар удирдуулж ирлээ: [Сургаал ба Гэрээ 134:1–6, 8-ыг тэд эш татжээ.]

18. “Сүмийн гишүүд эдгээр зарчмуудад дуулгавартай байснаар, цэрэгт дайчлагдахдаа эх орноо батлан хамгаалах үүргээ ямагт дээдлэн мэдэрсээр ирсэн билээ. . . .

19. “. . . Одоогийн дайнд, Сүмийн зөв шударга эрчүүд эх орныхоо төлөө хоёр талд аль алинд нь, зарим нь баатарлаг гавъяа байгуулан, амь эрсдэж байна. Энэ бүхэнд манай хүмүүс, иргэд нь байгаа эх орондоо үнэнчээр алба хааж байна. Өөрөөр хэлбэл бидний дээр нотолсон зарчмуудын субъект болж байна. . . .


20. “. . . Уг зарчмууд нь [Сургаал ба Гэрээ 98:4–7-д заагддаг] . . . үндсэн хуульд дуулгавартай байсан тохиолдолд, үнэнч байх үүрэг хүлээсэн эх орныхоо зэвсэгт хүчинд алба хаах иргэнийхээ эрхэм дээд үүргийг биелүүлэхэд Сүмийн эрчүүдийг уриалан дуудаж байна. Хэрэв энэ уриа дуудлагыг сонсон, өөрсдөд нь өгсөн тушаалыг дуулгавартай дагах юм бол, эсрэг талд тулалдаж буй хүмүүсийн амийг авах болно. Ингэснээр тэд алуурчид болохгүй. . . .

21. “Бүх дэлхий аль ч цаг үеийнхээс хамгийн адгийн муу дайны дунд байна. Энэ Сүм бол дэлхий дахины Сүм. Энэ Сүмийн чин үнэнч гишүүд хоёр талд хоёуланд нь байгаа.

Тэд бол дайтаж байгаа орнуудын дайны зэвсэг болсон гэм зэмгүй хүмүүс юм. Тэд гэр орныхоо төлөө, эх орныхоо төлөө, эрх чөлөөнийхөө төлөө тулалдаж байгаа гэдэгт хоёр талд аль алинд нь итгэлтэй байдаг. Хоёр талд бидний ах дүүс нэг Бурханд, мөн нэг нэрээр, ялалтын төлөө залбирдаг. Хоёр тал хоёул бүрэн зөв байж чадахгүй. Бас хоёулаа буруу байх ч учиргүй. Бурхан зөрчил тэмцлийг Өөрийн зохих цагт, Өөрийн дээд арга замаар, шударгаар бас зөвөөр шийдвэрлэнэ. . . .

22. “Манай залуу эрчүүд хэнд хаана цэргийн алба хааж байгаа нь хамаагүй, цэвэр ариунаар амьдар, Их Эзэний зарлигуудыг сахь. Үнэн, шударга ёсыг үргэлж сахихын тулд Түүнд хандан байнга залбирч, залбирсныхаа дагуу амьдарч бай. Та нарт юу ч тохиолдлоо гэсэн Их Эзэн та нартай хамт байх болно. Тэгвэл Бурханы шударга ёс болон алдар суу, та нарын аврал болон өргөмжлөлд үл нийцэх юу ч та нарт тохиолдохгүй гэдгийг бид хэлж байна” (In Conference Report, 1942 оны 4-р сар, 90–91, 93–96).

23. “Бурхан амьд, Есүс бол Христ, Иосеф Смит Бурханы бошиглөгч. . . .байсан гэдэг гэрчлэлээ би та нарт үлдээж байна. Би үүнийг яаж мэддэг вэ? Өнөө орой би та нарын өмнө зогсож байгаагаа мэдэж байгаагийн адилаар би үүнийг мэддэг. Би халуун, хүйтнийг мэднэ. Би баяр баяслыг бас уй гашууг мэднэ. Уй гашуу, зовлон зүдгүүрийн цагт, үхэл хагацлын цагт залбирлуудыг минь Бурхан сонсож, хариулдгийг, мөн тэрээр амьд гэдгийг би та нарт батлан хэлж байна. Би та нарт гэрчлэлээ үлдээж байна” (“Farewell Address of Apostle Heber J. Grant,” *Improvement Era*, 1901 оны 7-р сар, 691).



Уншсанаа судлах нь

“Ерөнхийлөгч Хебер Ж. Грант”-ыг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий

А Хоёр зорилго тавь

1. Догол мөр 1–11-ийг судалж, чухал ач холбогдолтой гэж өөрийнхөө боддог, Ерөнхийлөгч Хебер Ж. Грантын таван амжилтыг жагсаан бич.
2. Тэрээр дээрх зорилгуудыг биелүүлэхийн тулд, мөн зорилгодоо хүрэхийн тулд өөртөө тулгарсан хүнд сорилтуудыг хэрхэн даван туулах боломжтой байсан гэж боддог тухайгаа богинохон догол мөрөнд бич.
3. Өөрийнхөө хүрэхийг хүсдэг хоёр зорилгыг бичиж, уг зорилгуудад хүрэх замд тохиолдож болно гэж бодсон бэрхшээлүүдийг дүрсэл. Зорилгодоо хүрэхийн тулд юу хийхээр төлөвлөж байгаагаа, мөн эдгээрт хүрэхэд хэр зэрэг удаан хугацаа шаардагдана гэж бодож байгаагаа тайлбарла.

Б Чухал шийдвэр гаргах удирдамж

Дараах нөхцөлүүдийг уншиж, Ерөнхийлөгч Хебер Ж. Грантын аль сургаал буюу гэрчлэл нөхцөл тус бүрд илүү сайн холбогдож байгааг тогтоо. Бас, нөхцөл бүрд хүн юу хийх ёстойг, мөн яагаад гэдгийг товч тайлбарла.

1. Оливиягийн хамгийн дотнын найз нь саяхан автомашины ослоор нас баржээ. Тэр сэтгэл санаагаар унаж, Бурхан үнэхээр байдаг уу гэж эргэлзжээ.
2. Жеймс сая долларын хонжвортой сугалаа худалдаж авахаар бодож байгаа аж. Тэр үнэхээр энэ мөнгийг ашиглаж чадах болов уу?
3. Стефен бол дайны үеийн армийн цэрэг. Тэр дайсны цэргүүдийг алах хэрэг гарч мэднэ гэж санаа нь зовниж байгаа аж.
4. Мария ажил олох гэж зовж зүдэрчээ. Сар бүр засгийн газраас тэтгэмжийн мөнгө авч байх нь амар юм байна гэж тэр шийдсэн аж. Ийм болохоор ажиллах шаардлага түүнд байхгүй болжээ.



Тэргүүн Зөвлөлийн зөвлөх, Ерөнхийлөгч Томас С. Монсон Ерөнхийлөгч Жорж Альберт Смитийн тухай дараах түүхийг хуваалцжээ: “Солт Лейк хотын Стрийтс Департаментэд олон жил ажилласан Жюниус Берт нэгэн сэтгэл догдлом, сүнслэг нөлөө бүхий туршилагын тухай өгүүлжээ. Гудамж цэвэрлэгээний баг өвлийн тэсгим хүйтэн өглөө гудамжны ховилоос мөсний том хэлтэрхийнүүдийг цэвэрлэн зөөж байсан тухай тэр ярьсан байдаг. Тэр өөрөө энэ багийн гишүүн байсан гэнэ. Энэ ажилд чухал шаардлагатай байсан түр хугацааны ажиллагсад байнгын багт тусалдаг байв. Хөнгөн ноосон цамцтай түр хугацааны ажиллагсдын нэг нь бүр бээрчихсэн байв. Сахлаа сайхан гэгч нь зассан, нэгэн гоолиг эр багийн дэргэд зогсож, нөгөөх ажилчнаас, ‘Ийм хүйтэн өглөө та энэ ноосон цамцнаас өөр зузаан хувцас өмсөж байх хэрэгтэй шүү дээ. Хүрэм чинь хаана байна?’ гэж асуухад, нөгөөх хүн, хүрэм байхгүй гэж хариулж. Тэрүүгээр явж байгаад зогссон нөгөөх хүн хүрмээ тайлж, даарсан хүнд өгөөд, ‘Энэ хүрэм таных. Зузаан ноосон хүрэм таныг дааруулахгүй. Би ердөө энэ гудамжны цаана ажилладаг’ гэж хэлжээ. Тэр гудамж нь Саут Темпл гудамж байлаа. Сүмийн Захиргааны Барилга руу ажилдаа ирж, энэ удаа хүрэмгүйгээр орсон сайн самари хүн бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Жорж Альберт Смит байжээ. Өгөөмөр сэтгэлийнх нь өөрийгөө боддоггүй энэхүү үйлдэл зүрх сэтгэлийнх нь өрөөч зөвлөлийг илчлэн харуулсан юм. Тэр бол ахыгаа хамгаалагч байсан нь эргэлзээгүй” (In

Conference Report, 1990 оны гурав-дөрөвдүгээр сар, 62; Ensign, 1990 оны 5-р сар, 47).

ТҮҮНИЙ АМЬДРАЛ (1870–1951)

- | | | |
|--------------|---|--|
| 1870 он | Дөрөвдүгээр сарын 4-нд Солт Лейк хотод Жон Хенри Смит, Сара Фарр Смит нарын гэр бүлд төржээ | |
| 1891 он | 21 настайдаа, Өмнөд Ютад номлолд үйлчлэв | |
| 1892 он | 22 настайдаа, Люси Эмили Вудрафтай гэрлэв. Люси 1937 онд нас баржээ | |
| 1892–1894 он | 22–24 настайдаа, Нэгдсэн Улсын өмнөдөд номлолд үйлчлэв. Эхнэр Люси нь уг ажилд түүнтэй хамт явжээ | |
| 1903 он | 33 настайдаа, Ерөнхийлөгч Жозеф Ф. Смит түүнийг Төлөөлөгчөөр томилов | |
| 1919–1921 он | 49–51 настайдаа, Европын Номлолын ерөнхийлөгчөөр үйлчлэв | |
| 1921 он | 51 настайдаа, Сүмийн залуу эрэгтэйчүүдийн хөтөлбөрийн удирдагч болов | |
| 1943 он | 73 настайдаа, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч болов | |
| 1945 он | 75 настайдаа, Ерөнхийлөгч Хебер Ж. Грантыг нас барсны дараа Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав | |
| 1951 он | 81 настайдаа, Солт Лейк хотод дөрөвдүгээр сарын 4-нд, төрсөн өдрөөрөө таалал төгсчээ | |

ТҮҮНИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ (1945–1951)

- | | |
|---------|---|
| 1945 он | Дэлхийн II Дайны улмаас номлогчдыг илгээх боломжгүй байсан дэлхийн олон хэсгүүдэд номлогчдыг явуулж эхлэв. Айдахогийн Айдахо Фоллс ариун сүмийг онцгойлон адислав |
| 1946 он | Дэлхийн II Дайны дараа зовлон гачаалд нэрвэгдсэн Европ дахь Гэгээнтнүүдэд хүнс, хангамжийн бусад зүйлийг илгээж эхлэв |
| 1950 он | Өглөөний семинарууд эхлэв |

Ерөнхийлөгч Жорж Альберт Смитийн амьдрал

1. “Жорж Альберт Смит Хебер Ж. Грантыг залгамжилж Сүмийн Ерөнхийлөгч болов. Ерөнхийлөгч Смитийн амьдрал бол сайн мэдээгээр амьдарч, аз жаргалыг олсны жинхэнэ жишээ мөн. Тэрээр гэрчилсэн нь: ‘Бурханы зарлигууд, түүний зөвлөгөө, зөвлөмжийг сахихын үр дүн нь тухайн хүний зохистой байдал, аз жаргал, баяр баясал юм’ [In Conference Report, 1948 оны 4-р сар, 162].
2. “Бурханы зарлигууд, Сүмийн удирдагчдын зөвлөгөөг дуулгавартай дагах нь Ерөнхийлөгч Смитийн гэр бүлийн олон үеийнхний дунд зөв шударга байдлын загвар болсоор ирсэн юм. Бошиглогч Иосефын үеэл бөгөөд Ерөнхийлөгч

Бригам Янгийн зөвлөх асан аавынх нь талын өвөг эцэг Жорж А. Смитийн нэрээр түүнийг нэрлэсэн ажээ. Жорж Альбертын аав, Жон Хенри Смит Жозеф Ф.Смитийн удирдлаган дор Тэргүүн Зөвлөлд үйлчилж байжээ. Жорж Альберт Смит 33 настайдаа Арванхоёрын Чуулгад дуудагдсан нь энэ эрин үед эцэг хүү хоёр 1903–1910 онуудад уг Чуулгад хамт үйлчилсэн цорын ганц тохиолдол юм.



3. “Арванхоёрын Чуулгад үйлчилсэн Жорж Альберт Смитийн 42 жил нь, эрүүл мэнд нь муу байсан үеийг эс тооцвол, нэр хүндтэй үйлчлэлээр дүүрэн байлаа. Өмнөд Ютад төмөр замын судалгаа хийж байсан үед нүд нь наранд гэмтсэн ажээ. Бараг хараагүй болсон нүдэнд нь хийсэн мэс засал амжилтгүй болсон гэдэг. Даралт нь ихэсч, цаг үеийн нөр их ажил ядруу биеийг нь улам сульдуулж, ядаргаанаас болж бүр ч дорджээ. Бүрмөсөн амрах тухай эмчийн шийдвэр өөртөө итгэх итгэлийг нь алдагдуулж, хэнд ч хэрэггүй болсон мэт мэдрэмж төрүүлэн, бухимдлыг нь улам нэмэгдүүлсэн гэдэг.

4. “Энэ хүнд үед Жорж том нуурын ойролцоо нэгэн сайхан ой харсан зүүд зүүдэлсэн аж. Тэрээр ой дундуур хэсэг алхтал хайрт өвөө Жорж А.Смит нь өөдөөс нь ирж явахыг таньж гэнэ. Жорж урагш яаран алхтал, өвөө нь ойртож ирээд, зогсож, ‘Миний нэрээр юу хийснийг чинь би мэдмээр байна’ гэж хэлэв. Өвөөгийнх нь амьдралын дүр зураг Жоржийн оюун ухаанд зурсхийн бууж, тэрээр, ‘Таныг ичээх юуг ч би нэрээр тань хийгээгүй’ гэж даруухнаар хариулж гэнэ. Энэ зүүд Жоржийн сүнсийг бас бие бялдрынх нь тэвчээр хатуужлыг шинэчилж, тэрээр удалгүй ажилдаа эргэж орох боломжтой болжээ’. Хожим нь тэрээр энэ туршлагыг өөрийнх нь амьдрал дахь үндсэн эргэлтийн үе хэмээн олонтаа дүрсэлдэг байжээ [Жорж Альберт Смит, *Sharing the Gospel with Others*, эмхтгэсэн Престон Нибли (1948), 110–112].

5. “1945–1951 оныг хүртэл үргэлжилсэн Ерөнхийлөгч Жорж Альберт Смитийн удирдлагын үед Сүмийн гишүүдийн тоо нэг саяд хүрч, Айдахо дахь Айдахо Фоллсын ариун сүм онцгойлон адислагдаж, Дэлхийн II Дайны дараа номлолын ажил сэргэжээ.

6. “Түүнчлэн, дайны уршгаар ядуурч хоосорсон Европын Гэгээнтнүүдэд туслах хүч чармайлтууд зохион байгуулагдав. Хувцас хунар, бусад эд зүйлс хандивлахад нь Нэгдсэн Улс дахь Сүмийн гишүүдийг урамшуулан дэмжиж байлаа. Цуглуулсан хүнс, хувцас, ор дэрний хэрэглэлийг Европ руу

илгээх зөвшөөрөл авахаар Ерөнхийлөгч Смит Нэгдсэн Улсын ерөнхийлөгч Харри С.Трумантай уулзсан юм. Ерөнхийлөгч Смит энэ уулзалтыг дараах байдлаар дүрсэлсэн байдаг:



Ерөнхийлөгч Жорж Альберт Смит, Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч Харри С.Труман, Ютагийн захирагч Херберт Моо нар

7. “Эд юмсаа та юунаас өгөх гэж тийш нь ачуулах гэж байгаа юм бэ? Тэдний мөнгө огт хэрэггүй болсон шүү дээ” гэж “Ерөнхийлөгч Труман хэлэв: ‘

8. “Бид европчуудаас мөнгө авахыг хүсэхгүй байна” гэж би хэллээ. Тэр над руу харж: “Та үүнийгээ тэдэнд зүгээр өгнө гэж хэлэх гээгүй биз?” гэж асуулаа.

9. “Мэдээжийн хэрэг би үүнийг тэдэнд зүгээр өгнө. Тэд бол бидний ахан дүүс, тэдэнд зовлон зүдгүүр тохиолдоод байгаа шүү дээ. Бурхан биднийг элбэг дэлбэгээр адисалсан юм. Хэрэв бид засгийн газартай хамтран ажиллаж, эд юмсаа илгээвэл баяртай байх болно” гэж би хэлэв.

10. “Та зөв зам дээр байна гэж тэр хэлээд: “Бид танд чадах чинээгээрээ туслахдаа баяртай байх болно” гэж нэмж хэлэв” [In Conference Report, 1947 оны 10-р сар, 5–6].



11. “Хандивыг далайн чанад руу ачуулахаар Ютад ангилан, боож баглаж байхад Ерөнхийлөгч Смит бэлтгэлийг ажиглахаар иржээ. Өгөөмөр сэтгэлээр хандивласан их эд зүйлсийг хараад, түүний хацар дээгүүр нь нулимс урсаж байлаа. Хэдэн хормын дараа тэр цоо шинэхэн гадуур хүрмээ тайлж, ‘Үүнийг ачуулна уу’ гэв. Хүйтэн жихүүн салхитай тэр өдөр хүрэм нь түүнд хэрэгтэй гэж ойрхон зогсож байсан хэдэн хүн хэлсэн боловч, хүрмийг явуулах ёстой гэж тэр зүтгэсэн ажээ. [Радд, *Pure Religion*, 248-ыг үз.]

12. “Арванхоёрын Чуулгын Ахлагч Эзра Тафт Бенсон Европт номлолыг дахин нээх, тусламжийн зүйлсийг тараах ажлыг хянах, Гэгээнтнүүдийн сүнслэг хэрэгцээг адислахаар томилогдсон байв. Ахлагч Бенсон анхны айлчлалаараа Рейн мөрөн дээрх Германы Карлсрухе хот дахь Гэгээнтнүүдийн чуулганд оролцсон аж. Ахлагч Бенсон энэ туршлагынхаа тухай өгүүлэхдээ:

13. “Бид эцэстээ цуглааны байр болох, хорооллын доторх, нэг хэсгийг нь бөмбөгдсөн барилга руу очлоо. Биднийг чуулганд очих байх гэсэн үг хүмүүст дуулдсан учраас Гэгээнтнүүд биднийг ирнэ гэж найдан цуглаад, хоёр цаг

гаруй хүлээжээ. Тэгээд биднийг тавцан руу хүрч очиход бараг бүх цугларагсад нүдэндээ нулимстай байлаа. Би үүнийг амьдралдаа анх удаа харж байгаа нь энэ. Зургаа, долоон жилийн дараа Сионы төлөөлөгчид тэдэн дээр эргэн ирж байгаа нь энэ байлаа . . . Сионы үндэс суурийг тэд өөрсдөө тавьсан юм. Би хүмүүсийн уруу царайлсан, цонхигор, туранхай нүүрийг, Гэгээнтнүүдээс олон нь уранхай ноорхой хувцастай, зарим нь хөл нүцгэн байсныг харлаа. Хүмүүс энэхүү агуу ажлын бурханлиг чанарыг гэрчилж, Их Эзэний адислалуудын төлөө талархал илэрхийлж байх үед тэдний нүдэн дэх итгэлийн гэрлийг би олж харж билээ’ гэжээ [In Conference Report, 1947 оны 4-р сар, 154].

14. “Ахлагч Бенсоны олон ажил үүргийн нэг нь 127 вагон хүнс, хувцас хунар, ор дэрний хэрэглэл, эмийг Европ даяар тарааж өгөх ажилд хяналт тавих байв. Хэдэн жилийн дараа Ерөнхийлөгч Томас С.Монсон Звискауд шүтээний шинэ байр онцгойлон адисалсан үеэр ахимаг насны нэг ах нүдэндээ нулимс цийлэгнүүлэн, урагш гарч ирээд, өөрийг нь Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсонд сануулаарай гэж хүсчээ. ‘Америк дахь Сүмийн гишүүдээс илгээсэн хүнс, хувцсыг тэр бидэнд авчирч өгсөн юм. Ингэснээрээ тэр миний амьдралыг бас эх орон нэгтнүүд миний ах, эгч дүүсээс олных нь амьдралыг аварсныг түүнд хэлж өгөөч’ гэж нөгөөх настай эр хэлжээ [Герри Авант, “War Divides, but the Gospel Unites,” *Church News*, 1995 оны 8-р сар, 5-аас эш татжээ].

15. “Нидерландын Гэгээнтнүүд өлсгөлөнд нэрвэгдсэн Германы Гэгээнтнүүдэд жинхэнэ Христийн үйлчлэл үзүүлсэн юм. Нидерландын гишүүд дайны үед их зовлон амсчээ. Тэгээд тэд Нэгдсэн Улс дахь Сүмийн гишүүдээс халамжийн тусламж хүлээн авсан билээ. 1947 оны хавар өөрсдийнхөө халамжийн төслүүдийг эхлэхийг тэднээс хүсэхэд хүмүүс энэ төслийг амжилттай хэрэгжүүлсэн байна. Тэд төмс тариалж, арвин ургац авна хэмээн хүлээж байв.



16. “Энэ үед Зүүн Германы Номлолын ерөнхийлөгч Волтер Стөув Голландад ирж, нүдэндээ нулимс цийлэгнүүлэн Герман дахь Сүмийн гишүүдийн өлсгөлөн, үгүйрлийн тухай ярьжээ. Нидерландын Номлолын ерөнхийлөгч, ерөнхийлөгч Корнели Запшей, дайны үед дайсан нь байсан германчуудад ургаж байгаа төмсөө өгөх үү гэдгийг гишүүдээсээ асуув. Гишүүд дуртай зөвшөөрч, төмсөө сайн ургуулахад улам их анхаарч эхлэв. Ургац тэдний хэнийх нь ч хүлээж байснаас хавьгүй арвин гарчээ. Иймээс Нидерландын Гэгээнтнүүд Герман дахь ах, эгч нартаа 75 тонн төмс явуулах боломжтой болсон ажээ. Жилийн дараа Нидерландын Гэгээнтнүүд Германы Гэгээнтнүүдэд 90 тонн төмс, 9 тонн май загас илгээсэн ажээ.[Дэлгэрэнгүй мэдээллийг Радд, *Pure Religion*, 254–261-ээс үз.]

17. “Эдгээр Гэгээнтнүүдийн харуулсан Христийнхтэй адил бялхам хайр нь Христийнх шиг хайрыг үлэмж ихээр харуулдаг байсан Ерөнхийлөгч Жорж Альберт Смитийн хувьд түүний хэв шинж болсон зүйл байлаа. ‘Ах эгч нар минь, энэ дэлхийн хамгийн аз жаргалтай хүмүүс бол хөршүүдээ өөр шигээ хайрладаг, амьдралд хандах хандлагаараа Бурханы адислалуудын төлөө талархлаа харуулдаг хүмүүс юм гэдгийг би та нарт хэлж чадна’ гэж тэр хэлжээ [In Conference Report, 1949 оны 4-р сар, 10]” (*Бидний Өв*, 110–114).

Жорж Альберт Смитийн сургаал ба гэрчлэл

18. “Их Эзэний зарлигууд бол надад удирдамж болдог Түүний хууль, дүрмүүд юм гэдгийг би хүүхэд байхдаа ойлгосон. Өөрөөр хэлбэл би ингэж боддог байсан. Эдгээр хуулиудад дуулгаваргүй байх юм бол шийтгэл ирнэ гэдгийг мөн энэ амьдралын үйл хэрэг, асуудлуудад тодорхой хуулиудыг дуулгавартай дагах ёстой, эс тэгвэл хариу шийтгэл түргэн ирэхээр Их Эзэн бүхнийг зохион байгуулсан эсвэл томилсныг би бүр хүүхэд байхдаа мэддэг болсон гэж боддог байлаа. Гэвч би өсч том болохынхоо хэрээр өөр үзэл бодлоор нэг сургамжийг мэдсэн. Эдүгээ Их Эзэний хуулиуд миний хувьд . . . бидэнд нигүүлслээрээ хандсан Тэнгэр дэх бидний Эцэгийн аятай сайхан сонсголт хөгжим лүгээ адил дуу хоолой юм. Эдгээр хуулиуд бас хайраар дүүрэн эцэг эхийн зөвлөгөө юм . . . Үүний улмаас, нэг үед хуулийн хатуу нэрийг өөр дээрээ авах лугаа адил надад санагддаг байсан тэр зүйл эдүгээ, бүх зүйлд мэргэн цэцэн Тэнгэрлэг Эцэгийн хайрлагч, еелдэг ялдамхан зөвлөгөө юм” (In Conference Report, 1911 оны 10-р сар, 43–44; мөн Мозая 2:41-ийг үз).

19. “Есүс Христийн Сайн мэдээн дэх сайн сайхан зүйлүүдийн нэг бол сайн мэдээ бид бүгдэд адил төвшинг авчирдаг явдал мөн. Селестиел хаант улсад өндөр байртай байхын тулд хүн гадасны ерөнхийлөгч эсвэл, Арванхоёрын Чуулгын гишүүн байх албагүй. Хэрэв Бурханы зарлигуудыг сахих юм бол Сүмийн хамгийн даруухан гишүүн бусад ямар ч хүний адилаар селестиел хаант улсад өргөмжлөл олж авна. Есүс Христийн Сайн мэдээний охь нь Их Эзэний зарлигуудыг сахисан тохиолдолд бид бүгдийг адил тэгш болгодог явдал мөн. Бид Сүмийн хуулиудыг сахисан тохиолдолд, өргөмжлөлийн адил тэгш боломжууд бидэнд байдаг” (In Conference Report, 1933 оны 10-р сар, 25).



20. “Их Эзэний нутаг, чөтгөрийн нутгийн хооронд нарийн тогтоосон, зааглах шугам байдаг. Хэрэв та нар уг шугамын Их Эзэний тал дээр зогсох юм бол, Түүний нөлөөн дор байж, бурууг үйлдэх хүсэлгүй байх болно. Хэрэв та нар уг шугамын чөтгөрийн тал руу ганцхан сөөм давж орох юм бол уруу татагчийн эрхшээлд орно.


Ингээд уруу татагч амжилт олох юм бол та нар Их Эзэний Сүнийг алдах учраас, бодох, тэр тусмаа зохих ёсоор тунгаан бодох чадваргүй байх болно’ гэж өвөө маань [Төлөөлөгч Жорж А.Смит] гэрийнхэндээ хэлдэг байж билээ.

21. “Заримдаа ямар нэг буруу зүйлийг хийхээр уруу татагдсан үедээ, ‘Би зааглах шугамын аль талд байна вэ?’ гэж өөрөөсөө асуудаг. Хэрэв би аюулгүй талд, Их Эзэний талд байхаар шийдсэн бол тухай бүр зөв зүйлийг хийх болно.

Иймээс уруу таталт тохиолдоход, тулгарсан асуудлын талаар залбирч бод. Ингэвэл Их Эзэний Сүнсний нөлөө, ухаалгаар шийдэх боломжийг та нарт олгоно. Зааглах шугамын зөвхөн Их Эзэний талд байх нь бидэнд аюулгүй.

22. “Хэрэв та нар аз жаргалтай байхыг хүсвэл бүх аз жаргал зааглах шугамын Их Эзэний тал дээр, харин уй гашуу, цөхрөл гансрал зааглах шугамын чөтгөрийн тал дээр байдгийг санагтун” (*Sharing the Gospel with Others*, эмхтгэсэн Престон Нибли (1948), 42–43).

23. “Юмсыг хийлгэхээр бид хүмүүсийг албадаж болохгүй. Харин зөв зүйлийг, зөв шударга байдлаар хийхэд нь бид тэднийг хайрлах хэрэгтэй” (Мексикийн Номлолын ерөнхийлөгч асан, Ахлагч Арвелл Л.Пиерс эш татжээ, In Conference Report, 1951 оны 4-р сар, 114).



24. “Хэсэг хугацаанд ярилцсаны дараа нэг хүн надад, ‘За тийм ээ, танай Сүм бусад аль ч Сүмийн нэгэн адил сайн зүйлийг заадаг’ гэж хэлэв. Тэр хүн бидэнд овоо их магтаалын үг хэллээ гэж бодсон байх. Харин би түүнд: ‘Хэрэв энд миний төлөөлж байгаа Сүм хүмүүний үрсийн хувьд бусад аль ч Сүмээс илүү чухал биш юм бол, би үүргээ буруу ойлгосон

хэрэг. Үнэнийг, бас өөрийн тань эрхэмлэдэг ариун журмыг танаас салгаж авахаар бид энд ирээгүй. Танаас дутагдал олох гэж, эсвэл таныг шүүмжлэх гэж бид ирээгүй. Хийх ёстой юмсыг хийгээгүйн улмаас таныг зэмлэх гэж бид энд ирээгүй. Харин бид таны ах дүүсийн хувиар энд ирсэн. Бид цаг заваа, хөрөнгө мөнгөө сайн дураараа гаргаж, зүрх сэтгэлийнхээ хайраар, та нарыг сайныг үйлдээсэй гэсэн хүсэлтэйгээр, нүгэлтэй зүйлүүддээ та нарыг нүглээ наманчлахад, ариун журамтай байдаг зүйлүүддээ та нарыг ариун журамтайгаа үлдэхэд урамшуулан дэмжихийн тулд, бас: ‘Та нарыг улам аз жаргалтай байхын төлөө, бидний Тэнгэрлэг Эцэгийн оршихуйд ороход бэлтгэгдэхийн төлөө та нар өөрсдөдөө байгаа сайн сайхан бүхнийг хадгалаач, та нарын төлөө улам сайн сайхныг авчрах боломжийг бидэнд олгооч хэмээн та нарт хэлэхийн тулд бид танай нутагт ирсэн юм’ ” гэж хэллээ (*Sharing the Gospel with Others*, 12–13).

25. “Бид шүтэн бишрэхийн тулд цугладаг энэ өдөр, . . . Хүндэтгэлийн өдөр энэ агуу үндэстний тоглоом наргианы өдөр- маш эрт үед Бурханы өгсөн зарлигийг мянга мянгаараа зөрчдөг тогтсон өдөр болжээ. Ийнхүү хүн төрөлхтнийг зовоож байгаа бас цаашид зовоох уй гашуу, гай зовлонгийн ихээхэн нь Хүндэтгэлийн өдрийг ариунаар сахих Түүний зөвлөгөөг хүмүүс үл ойшоодог бодит үнэнтэй холбоотой гэдэгт би итгэдэг” (In Conference Report, 1935 оны 10-р сар, 120).



26. “Би дэлхийн олон хэсгээр аялж, олон агуу, сэтгэл татагдам эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдтэй уулзаж учирч явсан, мөнх бус байдал дахь наян жилийн дараа, Бурхан амьдардгийг; Есүс бол Христ гэдгийг; Иосеф Смит Амьд Бурханы бошиглогч байсныг; Сүм бидний

Тэнгэрлэг Эцэгийн удирдлага дор зохион байгуулагдсаныг, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм, аглаг буйд руу цөлөгдсөн тэр Сүм Петр, Иаков, Иохан нар Иосеф Смит, Оливер Каудери хоёрт олгосон тэрхүү санваарын хүч, эрх мэдлээр үйл ажиллагаа явуулдгийг өмнө нь мэддэг байснаасаа өнөөдөр бүр ч илүү сайн мэдэж байгаагаа та нарт гэрчилж байна. Би үүнийг өөрөө амьд байгаагаа мэддэг шигээ мэднэ. Мөн эл гэрчлэлийг та нарт хэлэх нь нэн чухал асуудал гэдгийг мөн Түүний нэрээр өөрийн заадаг бусад бүх зүйлийн төлөө Тэнгэрлэг Эцэгийнхээ өмнө хариуцлага хүлээх болно гэдгээ би ухаарч байна. Би энэ хариуцлагыг ухаарч, хэрэв би та нарыг буруу удирдвал, үүнийхээ төлөө хариуцлага хүлээнэ гэдгээ мэдэж байна. Би бүхнийг хайрлах зүрх сэтгэлийнхээ хайр болон нинжин сэтгэлээр энэ гэрчлэлийг Их Эзэн Есүс Христийн нэрээр хэлж байна” (“After Eighty Years,” *Improvement Era*, 1950 оны 4-р сар, 263–264).

Уншсанаа ойлгох нь



Жорж Альберт Смитийн сургаал ба амьдрал

Зааглах шугам (догол мөр 20)—Тусгаарлалт буюу хил хязгаар

Зэмлэх (догол мөр 24)—Загнах, буруутгах

Уншсанаа судлах нь



“Ерөнхийлөгч Жорж Альберт Смит”-ийг судлахдаа үйл ажиллагаа А, Б-г хий

А Ерөнхийлөгч Смит юу гэж хариулах байсан бол?

Ерөнхийлөгч Жорж Альберт Смиттэй ярилцлага хийх боломж өөрт чинь олджээ гэж бод. Догол мөр 1–17-г судалсны дараа, дараах асуултуудад тэр хэрхэн хариулах байсан гэж бодож байгаагаа бич:

1. Өөрийнхөө хамгийн агуу амжилтыг та юу гэж боддог вэ?
2. Гэр бүлийн чинь ямар гишүүн танд хамгийн их нөлөө үзүүлдэг вэ? Яагаад?
3. Нөхдөдөө ямар үйлчлэл үзүүлснээ та хамгийн ихээр санадаг вэ?
4. Бусдад хайр, энэрлийг үзүүлэх нь яагаад чухал гэж та боддог вэ?

Б Сургаалуудыг хэрэглэ

“Жорж Альберт Смитийн сургаал ба гэрчлэл”-ийг уншаад, түүний сургаалуудаас өөрийн чинь хувьд чухал учир холбогдолтой таван сургаалыг сонгож ав. Сургаал бүрийн хувьд Ерөнхийлөгч Смитийн сургасан зүйлүүдээр хариулагдах буюу энэ нь үүнд тусалж болох өнөө үеийн нэг нөхцөлийг дүрсэл. Нөхцөл бүрийн дараа Ерөнхийлөгч Смитийн сургасан үнэнүүд зөв зүйлийг хийхэд хүнд хэрхэн тусалж чадахыг тайлбарла.

Дэлхий дахины Сүм

Хорьдугаар зууны сүүлчийн тавь гаруй жилд урьд өмнө үзэгдэж дуулдаагүй өсөлт Сүмд гарсан билээ. Давид О.МкКейгээс Гордон Б.Хинклиг хүртэлх Сүмийн ерөнхий-лөгчдийн чадварлаг, сүнсээр нөлөөлөгдсөн удирдлагаар номлолын ажил өргөжиж, Сүмийн гишүүнчлэл 11,000,000-аас давсан юм. Эдүгээ Ариун сүмүүд дэлхийн өнцөг булан бүрд бий болж, сайн мэдээний оргил ёслолуудыг олон газарт улам олон Гэгээнтнүүд, тэдний өвөг дээдэст хүртээмжтэй болгож байна. Үнэхээр, Их Эзэний төлөвлөгөөг гүйцэлдүүлэхэд Сүм “тодорхой бус байдлаас болон харанхуйгаас” (С ба Г 1:30) урагш гарч байна. Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли манай өнөө үеийн тухай өгүүлж, хэлэхдээ:

“Эрт дээр үеийн хүмүүсийн ярьдаг байсан, бошиглогчид, төлөөлөгчдийн бошиглодог байсан, Бүхнийг Чадагчийн хожмын үеийн ажил ирж байна. Энэ ажил өрнөж байна. Энэхүү алдар суут эрин зуунд дэлхийд ирэх онцгой боломж бидэнд тохиосны учир шалтгаан бидэнд мэдэгдэхгүй байгаа ч, Бурханы мэргэн ухаанд буй. Шинжлэх ухаан агуу ихээр цэцэглэн хөгжиж байна. Мэдлэгийг жинхэнэ ёсоор хэрэглэж байна. Энэ эрин зуун бол хүмүүний хүч чармайлт, хүмүүний амжилт ололтоор бүх эрин зуунуудаас хамгийн агуу нь юм. . . .

“Бид түүхийн агуу, хүндэтгэлтэй мэдрэмжийг гайхан биширч, эрин зуунуудын оргил дээр зогсож байна. Энэ бол өнгөрсөн үеийн бүх зүйл энэ эрин үе рүү зааж, хүсэн тэмүүлж байсан сүүлчийн бөгөөд эцсийн эрин үе юм. . . .

“Урагш тэмүүлж, өсөн дэвшиж ирсэн энэ бүх эриний нэгэн үе шатанд, Есүс Христ дэлхий дээр хаанчлахаар сүр жавхландаа хүрч ирнэ. Тийнхүү хүрч ирэх нь хэзээ тохиохыг хэн ч мэдэхгүй. Тэр ч байтугай, Түүний эргэж ирэх цагийг тэнгэр элчүүд ч мэдэхгүй. Харин энэ нь хүсэн хүлээсэн өдөр байх болно” (In Conference Report, 1999 оны 10-р сар, 94-95; *Ensign*, 1999 оны 11-р сар, 74).

Ерөнхийлөгч Давид О.МкКей

“Тэр орон дахь бүтэлгүйтлийг
ямар ч амжилт нөхөж чадахгүй”



шиг, одоо бол бүр ч илүү хачирхмаар юм шиг санагдаж

Давид О. МкКей Шотландад 1898 онд номлогч байхдаа, нэг удаа гэрээ маш их санасан аж. Хотоор явж байгаад, “Хэдэн хаашааны цаана, явган хүний замын цаадах, дуусаагүй нэг барилгыг би харлаа. Урд талын хаалганы цаана чулуун дааман хаалга байсан нь хүн оршин суухад нэг л ер бусын юм

байв. Дааман хаалган дээр нэг бичиг сийлбэрлэснийг явган хүний зам дээрээс харж болохоор байв.

“Би хамтрагчдаа: ‘Нэг л хачирхмаар юм байна! Юу гэсэн бичиг байгааг би орж үзлээ’ гэж хэллээ. Бүр дөхөж очоод харсан чинь, зөвхөн чулуун дээрх бичиг байсан төдийгүй: ‘Чи хэн ч байлаа гэсэн, өөрт оногдсоноо сайн хий’ хэмээн, бид үйлчлэлд нь байгаа Түүнээс надад ирсэн захиас мэт санагдлаа.

“Би тэндээс эргэж явахдаа, бодлогоширон, хамтрагч дээрээ хүрч ирээд, нөгөөх бичгийг түүнд давтан хэллээ.

“Энэ бол Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн номлогчийн хувьд өөртөө оногдсон ажлыг тэр өглөө сайн хийхийг надад захьсан захиас байлаа” (Cherished Experiences from the Writings of President David O. McKay, comp. Clare Middlemiss [1955], 174-175).

ТҮҮНИЙ АМЬДРАЛ (1873–1970)

- | | | |
|--------------|--|--|
| 1873 он | Есдүгээр сарын 8-нд Ютагийн Хантсвиллд Петр Ийванс МкКей, Женнетт Ийванс МкКей нарын гэр бүлд төржээ | |
| 1881 он | 8 настайдаа, төрсөн өдрөөрөө баптизм хүртэв; аав нь Их Британид номлолд үйлчилж байв | |
| 1897–1899 он | 24–26 настайдаа, Шотландад номлолд үйлчлэв | |
| 1901 он | 27 настайдаа, коллежид сурч байхдаа хайр сэтгэлтэй болсон Эмма Рае Ригстэй нэгдүгээр сарын 2-нд гэрлэв. Эмма Рей 1970 онд нас баржээ | |
| 1906 он | 32 нас, Ерөнхийлөгч Жозеф Ф.Смит түүнийг Төлөөлөгчөөр томилжээ | |
| 1918–1934 он | 45–61 настайдаа, Ням гарагийн Сургуулийн ерөнхийлөгч байв | |
| 1920–1921 он | 47–48 настайдаа, дэлхий даяарх Сүмийн номлолуудаар явав; сайн мэдээг номлоход зориулж олон орныг онцгойлон адислав | |
| 1922–1924 он | 49–51 настайдаа, Европын Номлолын ерөнхийлөгч байв | |
| 1934–1951 он | 61–77 настайдаа, Ерөнхийлөгч Хебер Ж.Грант, Жорж Альберт Смит нарын зөвлөх байв | |
| 1950 он | 77 настайдаа, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч болов | |
| 1951 он | 77 настайдаа, Ерөнхийлөгч Жорж Альберт Смитийг нас барсны дараа Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав | |
| 1970 он | 96 настайдаа, нэгдүгээр сарын 18-нд Солт Лейк хотод нас барав | |

ТҮҮНИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ (1951–1970)

- 1955–1956 он Швейцарь, Калифорнийн Лос Анжелес дахь ариун сүмүүд онцгойлон адислагдав
- 1958 он Шинэ Зеланд, Хавайд Сүмийн коллежууд нээгдэв; Шинэ Зеланд, Английн Лондон дахь ариун сүмүүд онцгойлон адислагдав. Хойд Америкаас гадна анхны гадас зохион байгуулагдав (Шинэ Зеландад)
- 1961 он Сүмийн үйл ажиллагааг уялдуулах зохицуулалт эхлэв
- 1964 он Калифорнийн Өүкландад ариун сүм онцгойлон адислагдав
- 1966 он Өмнөд Америкт анхны гадас зохион байгуулагдав (Бразилд)

Ерөнхийлөгч Давид О.МкКейн амьдрал

1. “Давид О.МкКей Ерөнхийлөгч Жорж Альберт Смитийн Тэргүүн Зөвлөлд түүний зөвлөх байв. 1951 оны хавар Ерөнхийлөгч Смитийн эрүүл мэнд бага зэрэг сайжрахад Ерөнхийлөгч МкКей, эхнэр Эмма Раегийнхаа хамт хойшлуулаад байсан амралтаараа Солт Лейк хотоос Калифорни руу явахаар шийдэв. Тэд Ютагийн Сейнт Жоржид хонохоор түр саатжээ. Маргааш өглөө нь эрт сэрэхэд, Сүмийн Төв Байр руу эргэж очих ёстой гэсэн хүчтэй сэтгэгдэл Ерөнхийлөгч МкКейд төржээ. Түүнийг Солт Лейк хотод ирснээс хойш хэдхэн хоногийн дотор Ерөнхийлөгч Смит хүнд өвчнөөр өвчилж, өвчин нь огцом даамжирч түүнийг 1951 оны дөрөвдүгээр сарын 4-нд нас барахад хүргэжээ. Тийнхүү Давид О. МкКей Сүмийн ес дэх Ерөнхийлөгч болов.

2. “Ерөнхийлөгч МкКей Сүмийг удирдахын тулд сайн бэлтгэгдсэн юм. Тэр найман настай хөвгүүн байхдаа аавыгаа Британийн арлуудад номлолд дуудагдахад, өрхийн тэргүүн, эр хүний үүргийг өөр дээрээ авсан ажээ. Хоёр эгч нь нас бараад удаагүй байв. Бас ээж нь өнөө маргаашгүй хүүхэд төрүүлэх болчихоод байжээ. Тиймээс фермийн ажил ээжид нь ахадна гэж аав нь бодож байв. Ийм нөхцөлд МкКей ах эхнэртээ, ‘Мэдээжийн хэрэг би явах боломжгүй байна шүү дээ’ гэж хэлжээ. МкКей эгч түүн рүү харж, ‘Мэдээж хэрэг та хүлээж авах ёстой. Та надад санаа зовох хэрэггүй. Давид бид хоёр дажгүй дээ. Бүгдийг хийхдээ л хийнэ!’ гэсэн аж. [Льюлин Р.МкКей, *Home Memories of President David O. McKay* (1956), 5—6-гаас эш татжээ]. Эцэг эхийнх нь итгэл бишрэл, хоёргүй сэтгэл, нь Их Эзэнд насан туршдаа үйлчлэх хүслийг залуу Давидад яс маханд нь хүртэл шингээжээ. Тэрээр 1906 онд 32 настайдаа Арванхоёрын Зөвлөлд дуудагдаж, Сүмийн Ерөнхийлөгч болохоосоо өмнө уг Зөвлөл болон Тэргүүн Зөвлөлд (Ерөнхийлөгч Хебер Ж.Грант, Ерөнхийлөгч Жорж Альберт Смит нарын зөвлөхөөр) 45 жил үйлчилсэн юм.



3. “Ерөнхийлөгч МкКей дэлхий дахины Сүмийн гишүүдтэй уулзах аяллын өргөн цар хүрээтэй хуваарийг эхлүүлсэн юм. Тэрбээр Их Британи, Европ, Өмнөд Африк, Латин Америк, Өмнөд Номхон Далай мөн бусад газрын Гэгээнтнүүдтэй уулзсан ажээ. Европт байхдаа Лондон, Швейцарьт ариун сүм бариулах зохицуулалтыг урьдчилан хийсэн байлаа. Өөрийнх нь Ерөнхийлөгчийн Зөвлөл дуусгавар болохын өмнө, тэрбээр Сүмийн гишүүдийг адислан, тэдэнд бурханлигаар нөлөөлж, бараг бүх дэлхийгээр айлчилжээ.

4. “Ерөнхийлөгч МкКей гишүүн бүр жил болгон наад тал нь нэг шинэ гишүүнийг Сүмд авчирч байх зорилготой ажиллахыг шаргуу хүсэх замаар номлолын ажилд шинэ түлхэц өгсөн юм. ‘Гишүүн бүр номлогч’ гэсэн байнга давдагддаг санамжаараа тэр нэрд гарсан билээ.

5. “1952 онд бүрэн цагийн номлогчдын үр ашгийг дээшлүүлэх хүч чармайлтаар анхны албан ёсны номлолын төлөвлөгөөг дэлхий даяарх номлогчдод илгээв. Энэ төлөвлөгөө *Сайн Мэдээг Заах Байнгын Хөтөлбөр* гэсэн нэртэй байлаа. Уг хөтөлбөр Сүнсээр заах болон Бурхан тэргүүтний мөн чанар, авралын төлөвлөгөө, Урвалт ба Сэргээлт, Мормоны Номын ач холбогдлыг заахад анхаарал төвлөрүүлсэн, номлогчийн долоон ярилцлагыг агуулдаг байв. Дэлхий даяар Сүмд хөрвүүлэгдсэн хүмүүсийн тоо эрс өсөв. 1961 онд Сүмийн удирдагчид номлолын бүх ерөнхийлөгчдийн семинар зохион байгуулж, гэр бүлүүд найз нартайгаа нөхөрлөл тогтоож, номлогчдоор тэдэнд гэр оронд нь заалгуулахыг урамшуулан дэмжихийг заажээ. Шинээр дуудагдсан номлогчдод зориулсан хэлний сургалтын хөтөлбөр 1961 онд бий болж, хожим нь номлогчдын сургалтын төв баригджээ.

6. “Ерөнхийлөгч МкКейн удирдлагын үед зэвсэгт хүчинд алба хааж байсан Сүмийн гишүүд Ази дахь Сүмийн өсөлт хөгжилтийн үндсийг тавьсан юм. Юта дахь Америкийн Форкоос Өмнөд Солонгост алба хааж байсан нэг залуу цэрэг, Нэгдсэн Улсын цэргүүд Солонгосын энгийн иргэдтэй тааралдахад, хажуугаараа өнгөрч байгаа цэргүүдэд зам тавьж өгөн, хажуу тийшээ шалавхан зайлдгийг ажиглажээ. Үүний эсрэгээр, Сүмийн тэр залуу гишүүн, хажуу тийшээ болж, солонгосчуудад замаар явах боломж олгодог байв. Тэр бас солонгосчуудын нэрийг тогтооход хүч чармайлт гарган, хажуугаар нь өнгөрөхдөө тэдэнтэй баяртайгаар мэндэлдэг байжээ. Нэг өдөр тэр таван найзтайгаа хамт эмх цэгц муутай нэг өрөөнд оржээ. Хоол авах дараалал нэн урт байсан болохоор тэр хэсэг хугацаанд ширээний ард хүлээлээ. Удалгүй нэг солонгос ажилчин тосгуур дээр хоол барин хүрч ирэв. Нөгөөх цэрэг (Давид О.МкКей) дүрэмт хувцасныхаа мөр дээрх нэг зураасыг зааж, ‘Та надад үйлчлэх хэрэггүй. Би бол ердөө л нэг байлдагч’ гэж хэлэхэд тэр солонгос

хүн, 'Би танд үйлчилнэ. Та бол нэгдүгээрт бичигдэх Христэд итгэгч' гэж хэлжээ [Жорж Дуррант, "No.1 Christian," *Improvement Era*, 1968 оны 11-р сар, 82–84].

7. "1967 он гэхэд номлогчид болон цэргийн албан хаагчид Солонгост сайн мэдээг заахад маш их үр ашигтай байж, Мормоны Ном солонгос хэлэнд орчуулагдан, энэ оронд удалгүй гадас, тойргууд бий болов.



8. "Номлогчид бас Японд их амжилт оллоо. Дэлхийн II Дайны дараа, Япон дахь Сүмийн гишүүд хэдэн жилийн турш Сүмийн төлөөлөгчидтэй хааяа нэг холбоо барьдаг байв. Гэвч Японд байрласан Хожмын Үеийн Гэгээнтэн цэргийн албан хаагчид дайны

дараа хүчирхэг болон өсөхөд нь Сүмд тусалсан юм. 1945 онд Тацуй Сато цай уухаас татгалздаг Хожмын Үеийн Гэгээнтэн цэргийн албан хаагчдын талаар өндөр сэтгэгдэлтэй болж, улмаар дараа жил нь, түүнийг өөрийг нь болон гэр бүлийнх нь гишүүдээс нэлээд хэдэн хүнийг баптисм хүргэхэд хүргэсэн асуултуудыг тэднээс асуусан ажээ. Эллойт Ричардс Тацуйд, хожим нь Арванхоёрын Чуулгын гишүүн болсон Боид К.Пакер Сато эгчид тус тус баптисм хүртээжээ. Сатогийнхны гэр олон япончуудад сэргээгдсэн сайн мэдээний захиасыг сонссон газар нь болсон аж. Дэлхийн II Дайны үед япончуудын эсрэг дайтаж явсан Хожмын Үеийн Гэгээнтэн номлогчид удалгүй Японы хотуудыг номлолын ажилд нээлттэй болгосон билээ.

9. "Сүм Филиппинд бий болсон нь бас л Дэлхийн II Дайны дараах Америкийн цэргийн албан хаагчдын хүч чармайлттай шижмийн холбоотой бөгөөд Сүмийн эрчимтэй өсөлт тэнд 1961 онд эхэлсэн юм. Сүмийн гишүүн биш байсан нэгэн залуу филиппин эмэгтэй Мормоны Номын тухай сонсож, улмаар Хожмын Үеийн хэдэн Гэгээнтэнтэй уулзжээ. Үүний үр дүнд тэрээр Хожмын Үеийн Гэгээнтэн номлогчид Филиппинд ирэх зөвшөөрөл хүсэхийн тулд өөрийнхөө танил засгийн газрын ажилтнуудад хандах санаа түүнд төрсөн аж. Зөвшөөрөл өгөгдөж, ингээд хэдхэн сарын дараа Арванхоёрын Чуулгын Ахлагч Гордон Б. Хинкли энэ орныг номлолын ажлын төлөө дахин онцгойлон адисалжээ.

10. "1950-иад оны үед Сүм эрчимтэй хөгжсөний үр дүнд, Ерөнхийлөгч МкКей санваартны нэгтгэн зохицуулах хөтөлбөр эхэлснийг зарлав. Арванхоёрын Чуулгын Ахлагч Харольд Б.Лийгийн даргалсан хороо Сүмийн бүх хөтөлбөр Сүмийн хамгийн чухал зорилгуудад хэрхэн нийцэж байгааг магадлахын тулд тэдгээрийг бүх талаас нь, залбирч судлахаар томилогджээ. 1961 онд, Тэргүүн Зөвлөлийн зөвшөөрснөөр Ахлагч Лий Сүмийн сургалтын хөтөлбөрийн бүх материалыг төлөвлөх, бичиж боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг нэгтгэн зохицуулж удирдах бодлогыг хөгжүүлэн гэж зарлав. Сүмийн туслах эдгээр материалаас олныг өмнө нь хэрэгжүүлж байсан ажээ. Энэ шинэ удирдлага сайн мэдээг дэлхий дахины олон өөр хэлээр ярьдаг, бүх насны гишүүдэд үр ашигтайгаар заахын тулд хөтөлбөр болон хичээлийн материалуудын шаардлагагүй давхцалыг арилгасан ажээ.



11. "Хөтөлбөр, үйл ажиллагаанууд, түүний дотор, халамжийн, номлолын болон гэр бүлийн түүхийн ажлыг Сүмийн үүрэг зорилгын дагуу илүү үр ашигтайгаар хэрэгжүүлж, уялдуулан зохицуулахын тулд бусад өөрчлөлтийг Сүм бас хийжээ. Иосеф Смитийн үеэс Сүмийн нэг хэсэг байгаа гэрийн багшлалтыг Сүмийн бүх гишүүдийн сүнсний болон материаллаг хэрэгцээнд анхаарал халамж тавих арга зам гэж үзэн, 1960-аад онд дахин онцгой анхаарал хандуулах болсон юм. Заах үйл явцыг өргөжүүлэхийн тулд цуглааны байрны номын сан бий болгож, багшийг хөгжүүлэх хөтөлбөрийг эхлүүлсэн ажээ. 1971 онд Ерөнхий Эрх мэдэлтний хяналтан дор англи хэлээр гурван сэтгүүл: хүүхдүүдэд зориулсан *Найз*, залуучуудад зориулсан *New Era* (Шинэ Үе), насанд хүрэгчдэд зориулсан *Ensign* (Туг) сэтгүүлийг Сүм нийтэлж эхлэв. Мөн энэ үе орчимд, өмнө нь номлолууд өөрсдөө бие даан гадаад хэлээр гаргадаг байсан сэтгүүлүүдийг нэгтгэжээ. Эдүгээ нэг сэтгүүл орчуулагдаж, дэлхий даяарх гишүүдэд илгээгдэж байна.



12. "Ерөнхийлөгч Давид О. МкКей гэр орны болон гэр бүлийн амьдралыг өнөө үеийн амьдралд тохиолддог хүнд сорилтууд, уруу таталтуудын эсрэг бат найдвартай хамгаалалт, аз жаргалын эх сурвалж гэж үзэн дээр үеэс чухал

ач холбогдол өгдөг байв. Тэрээр гэр бүлээ хайрлах хайрыг эрхэмлэдэг байсан тухайгаа, бас гэргий Эмма Раегийнхаа үнэнч хайрын тухай олонтаа ярьдаг байжээ. Ерөнхийлөгч МкКейн удирдлагын үед эцэг эхчүүд хүүхдүүддээ ойр дотно байж, сайн мэдээний зарчмуудыг тэдэнд заах нэг арга зам болгон, долоо хоног бүр гэр бүлийн үдэш явуулдаг практикт дахин онцгой анхаарал хандуулах болсон байна.

13. "Нийгмийн Халамжийн Бүлэг гэр орон, гэр бүлийг бэхжүүлэхийн чухлыг онцгойлон анхаарахад нь боцшиглогчийг дэмждэг байлаа. Нийгмийн Халамжийн Бүлэг Наувуд үндэслэгдсэн байгуулагдсанаасаа хойш заах явцад болон Нийгмийн Халамжийн Бүлгээр дамжсан хэлхээ холбоогоор өөрийгөө болон гэр бүлээ адисалсан, дэлхий даяарх хэдэн зуун мянган эмэгтэйчүүдийг эгнээндээ багтаан өсч хөгжсөн билээ. 1945–1974 он хүртэл Нийгмийн Халамжийн Бүлгийн ерөнхий Ерөнхийлөгч нь 1968–1970 онуудад Нэгдсэн Улсын Эмэгтэйчүүдийн Үндэсний Зөвлөлийн ерөнхийлөгчөөр үйлчилж байхдаа улс орны хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, чадварлаг удирдагч, Белле С.Спаффорд байлаа.

14. "Ерөнхийлөгч МкКей 1970 оны нэгдүгээр сард 96 настайдаа өөд болжээ. Сүмийн гишүүнчлэл бараг гурав дахин өсч, сайн мэдээний захиасыг бүх дэлхийд хүргэхэд агуу дэвшил гаргасан үед тэрбээр Сүмийг бараг 20 жил тэргүүлжээ" (*Бидний Өв*, 134–139).

Уншсанаа ойлгох нь

Ерөнхийлөгч Давид О.МкКейн амьдрал

Байлдагч (догол мөр 6)
Нэгдсэн Улсын Армийн
хамгийн доод тушаалын
цэрэг

Дүрэмт хувцасны мөр
дээрх нэг зураас (догол
мөр 6)—Дүрэмт хувцсан
дээрх армийн байлдагчийн
таних тэмдэг

Давид О.МкКейн сургаал ба гэрчлэл

15. “Хүүхдийн хувьд амьдралын сургамжууд: үнэн, нэр төр, ариун журам, өөртөө хяналт тавихад суралцах; боловсролын үнэ цэнэ, шударга ажил хөдөлмөр, амьдралын зорилго болон онцгой боломжийг ойлгож мэдэх анхдагч, хамгийн үр ашигтай газар бол гэр орон юм. Хүүхдийг хүмүүжүүлж, сургахад гэр орныг юу ч орлож чадахгүй, мөн өөр ямар ч амжилт гэр орон дахь бүтэлгүйтлийг нөхөж чадахгүй” (*Family Home Evening Manual* [1968], iii).

16. “Ханийн аз жаргалтай амьдралын эх үндэс нь залуу насанд тавигддаг. Аз жаргал нь [гэрлэлтийн] тахилын ширээний дэргэдээс эхэлдэггүй, энэ нь залуу нас, үерхэл нөхөрлөлийн үед эхэлдэг” (*Pathways to Happiness*, эмхтгэсэн Ллюлин Р.МкКей [1957], 49).

17. “Бүх сайн зүйлийн дээж нь Назарын Есүсийн сургаал, ялангуяа түүний амьдрал юм. Иймээс Христтэй хамгийн их адилхан хүн үнэнхүү хамгийн агуу юм.



18. “Христийн тухай та зүрх сэтгэлдээ чин үнэнээсээ юу боддог нь таныг хэн бэ гэдгийг тодорхойлно, бас үйлс тань ямар байхыг үлэмж хэмжээгээр тодорхойлно” (*In Conference Report*, 1951 оны 4-р сар, 93).

19. “Жинхэнэ Мормон хүний гэр орон бол Христ орж ирэн, энд байх, энд амрахдаа баяртай байх тийм газар юм” (*Gospel Ideals* [1953], 169).

20. “Ажил хэрэг, зугаа цэнгэлийг, эсвэл нэмэлт орлого олохыг гэр орноосоо дээгүүрт тавьдаг хүн ийм болсон үедээ бодгалийн сул дорой байдлын доод хэмжээнд орсон байдаг. Хэн нэгний хувьд нийгмийн амьдралд оролцох шохоорхол нь гэр орноос нь давж гарах юм бол, тэр хүн амьдралынхаа дээд боломжид гологдож, жинхэнэ хүн байх эцсийн шалгалтад унасан гашуун ичгүүрээ хүлээн зөвшөөрөх цаг нь болж гэсэн үг.

21. “Ядуухан оромжинд нь эв нэгдэл, хайр ноёрхсон гэр бүл Бурханд болон ирээдүйн хүн төрөлхтөнд бусад ямар ч баялагаас хавьгүй илүү үнэ цэнэтэй юм. Ийм гэр оронд Бурхан гайхамшгуудыг үйлдэж болно, мөн үйлдсээр байх болно. Цэвэр ариун гэр орон дахь цэвэр ариун зүрх сэтгэл гэртээх холын Тэнгэрийн шивнээнд үргэлж оршдог” (*in “A Prophet’s Counsel,” Church News*, 1968 оны 9-р сарын 7, 4).

22. “Гэр орныг тэнгэрийн жижигхэн хэсэг болгох боломж бий. Тэнгэр бол чухамдаа төгс гэр орны үргэлжлэл хэмээн би дүрсэлж байна” (*Gospel Ideals*, 490).

23. Ахлагч Гордон Б.Хинкли, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишгүүн байхдаа, Ерөнхийлөгч МкКейн дараах зөвлөгөөг эш татжээ: “Аав нь ээжийг нь хайрладаг юм байна гэдгийг хүүхдүүддээ бодогдуулахаас илүү агуу зүйлийг эцэг хүн хийж чадахгүй” (*In Conference Report*, 1971 оны 4-р сар, 82; *Ensign*, 1971 оны 6-р сар, 72).



24. “Бурханы нэрийг хүндэтгэлгүйгээр хэрэглэдэг эцэг эх Христэд итгэх итгэлийг зохих ёсоор зааж чадахгүй. Дэг журамтай гэр оронд бүдүүлэг үг яриа хэзээ ч сонсогддоггүй. Хараал зүхлийн үг бол хүмүүжлийн доод жишгийг харуулдаг согог юм. Ариун бус үг хэллэг нь хүндэтгэлийн сүнсийг хөөн зайлуулдаг” (*Gospel Ideals*, 420).

25. “Үүрэг хариуцлагадаа, дуудлагадаа, ялангуяа Сайн мэдээний баяртай зарыг найз нөхөд, хөршүүддээ хүргэх үүрэг хариуцлагадаа үнэнч байхад Бурхан бидэнд тусалдаг. Энэ нь хүмүүний амьдралыг өөрчилж, эмэгтэйчүүд, хүүхдийг урьд нь байснаас илүү сайн болгодог. Хилэнцэт санаа бодолтой хүмүүсийг сайн хүмүүс болгох, сайн хүмүүсийг улам сайн болгох нь Есүс Христийн Сайн мэдээний үүрэг зорилго юм” (“Every Member a Missionary,” *Millennial Star*, 1961 оны 10-р сар, 469).

26. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын туслах асан, Ахлагч Роберт Л.Симпсон залхуурлаас зайлсхийх тухай ярихдаа Ерөнхийлөгч МкКейн дараах эшлэлийг татжээ: “Хүний жинхэнэ хэмжүүр бол хийх юмгүй байхдаа цаг заваа хэрхэн өнгөрүүлдэг нь юм” (*In Conference Report*, 1972 оны 10-р сар, 146; *Ensign*, 1973 оны 1-р сар, 113).

27. Тэргүүн Зөвлөлийн зөвлөх асан, Ерөнхийлөгч Марион Г. Ромни залуу насандаа номлолын талбарт Сүнсийг дагахад эргэлзсэн болон Сүнсийг дагахаас ирж болох байсан боломжийг алдсан тухай ярихдаа: “Их Эзэн намайг уучилсан гэж бодоход хүргэсэн цорын ганц зүйл бол, ‘Намайг номлолын талбарт байхад нэг удаа тодорхой нэг зүйлийг хий хэмээн сүнсээр нөлөөлөгдөхөд, би үүнийг хийгээгүй юм. Тэр цагаас хойш би үргэлж харамсаж явдаг. Сүнсийн шивнэлтүүдэд хариулахаас хэзээ ч бүү татгалз. Сүнсийг хүлээж авсныхаа дагуу амьдар, тэгээд Сүнс заасны дагуу үйлдэх зоригтой бай’ гэж Ерөнхийлөгч МкКей хэлснийг сонссон явдал мөн” гэжээ (*In Conference Report*, 1975 оны 4-р сар, 110; *Ensign*, 1975 оны 5-р сар, 74).

28. “Амилан босч ирсэн Их Эзэний тухай миний гэрчлэл бол, амилсан Христ шавь нар дээрээ хүрч ирэхэд, [Есүсийн шавь] Томас: ‘Эзэн минь, Бурхан минь’ (Йохан 20:28) гэж хэлсэнтэй яг ижил бодитой юм. Тэрээр амьдыг би мэднэ. . . .

29. “Даруу байдал, зөв шударга ёсонд түүнийг эрэлхийлдэг үйлчлэгчдэдээ тэр хандан ярих болно гэдгийг би мэднэ. Түүний дуу хоолойг сонссон учраас би мэднэ. Мөн дэлхий дээрх Түүний хаант улсад хамаарах асуудлуудаар би Түүний удирдамжийг хүлээн авсан билээ.

30. “Биднийг бүтээгч Түүний Эцэг амьд гэдгийг би мэднэ. Эцэг Хүү хоёр Бошиглогч Иосеф Смит дээр хүрч ирснийг би мэднэ. . . . Энэ мэдлэг миний хувьд бидний өдөр тутмын амьдралд тохиолддог зүйлтэй адилхан үнэн бодитой юм. Бид нар өглөө мандаж, гэрлээ бүх дэлхийд цацруулах болно гэдэгт баттай итгэдгээ шөнө унтахдаа мэддэг. Христ оршдог болон сэргээгдсэн энэ Сүмийн бурханлиг шинж чанарын тухай мэдлэг надад нэн ойр дотно юм” (*In Conference Report*, 1968 оны 4-р сар, 9–10).



Уншсанаа ойлгох нь



Давид О.МкКейн сургаал ба гэрчлэл

Нөхөх (догол мөр 15)—
Төлөөлөх, орлох

Уншсанаа судлах нь



“Ерөнхийлөгч Давид О.МкКейн”-г судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий

А Эсээ бич

Догол мөр 1–14-ийг судал. Ерөнхийлөгч МкКейн амьдралаас юуг нь бахархан биширдэг түүний амьдралын үлгэр жишээ Есүс Христэд ирэхэд та нарт хэрхэн тусалж чадах тухай товчхон бич.

Б Газрын зураг зур

1. Судрууд дахь газрын зургуудыг гарын авлага болгон ашиглаж, дэлхийн энгийн газрын зураг зур.
2. Ерөнхийлөгч МкКейн очсон дэлхийн бүсүүд болон түүний удирдлагын үед Сүмд эрс өсөлт гарсан газруудыг өнгөөр ялган буд.
3. Тэрээр гадаснуудыг зохион байгуулсан дэлхийн бүсүүд дээр таван хошуу тавь.
4. Түүний Ерөнхийлөгчийн Зөвлөлийн үед Сүмийн сургуулиуд эхэлсэн дэлхийн бүсүүд дээр С үсэг тавь.
5. Түүний Ерөнхийлөгчийн Зөвлөлийн үед ариун сүмүүдийг онцгойлон адисалсан бүсүүдэд А үсэг тавь.

В Гэр орноо чимэглэ

Өөрөө саяхан ариун сүмд гэрлэсэн бөгөөд гэр орноо яаж чимэглэхийг эхнэр буюу нөхөртэйгөө ярилцаж байна гэж төсөөлөн бод.

1. Өрөөнүүдийг харуулсан гэрийнхээ шалны план зургийн схемийг тэмдэглэлийн дэвтэртээ зур.
2. “Давид О.МкКейн сургаал ба гэрчлэл”-ийг уншсанаасаа, аль нэг өрөөнд байх нь хамгийн тохиромжтой гэж өөрийнхөө бодсон нотолгоо бүрд тохирох догол мөрийн дугаарыг бич. (Зарим нотолгоо нэг догол мөрнөөс урт байж болно. Өрөө бүрд нэгээс дээш нотолгоо бичиж болно.)
3. Зургийнхаа дор сонголтуудаа тайлбарла. Жишээ нь, Христийг орж ирэхэд танай гэр түүнийг баярлуулахаар

газар байхыг та нарт сануулж байхын тулд догол мөр 19 дэх Ерөнхийлөгч МкКейн сургаалыг орох хаалган дээр өлгөж болно.

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит

Сайн мэдээний шашны
номлогч ба зохиолч

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смитийг 1910 оны дөрөвдүгээр сарын 7-нд тэр үед Сүмийн зургаадах Ерөнхийлөгч асан, өөрийнх нь эцэг, Ерөнхийлөгч Жозеф. Ф.Смит Төлөөлөгчөөр томилжээ. . . .

“Хайрум Смитийн ач хүү, Ерөнхийлөгч Смит бол Сүмийн Ерөнхийлөгч болсон Жозеф Смит нэртэй гурав дахь хүн юм. . . .

“[Тэрээр] Сүмийн сургаал, Сүмийн түүхээр бичиж туурвисан олон зүйлээрээ Сүмийн утга зохиолд жинтэй хувь нэмэр оруулсан билээ.

“Тэр бол сайн мэдээний зарчмуудад насан туршид хоёргүй сэтгэлээр зүтгэсэн, ихэд хайр хүндэлэл хүлээсэн удирдагч, үнэхээр чин үнэнч, голч шударга, зөв шударга хүн байсан хэмээн түүнийг Арванхоёрын Зөвлөлийн гишүүд дүрсэлдэг байжээ” (“Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит Сүмийн арав дахь Ерөнхийлөгч болов,” Improvement Era, 1970 оны 2-р сар, 3). Ерөнхийлөгч Смитийн амьдрал, сургаалуудыг уншихдаа, тэрээр юуны улмаас, яаж ийм хүн болсныг тайлбарлахад тусалж болох нотолгоог амьдралынх нь эхэн үеэс эрж хай.

ТҮҮНИЙ АМЬДРАЛ (1876–1972)

1876 он	Долдугаар сарын 19-нд Солт Лейк хотод Жозеф Ф.Смит, Жюлина Ламсон Смит нарын гэр бүлд төржээ	
1884 он	8 настайдаа, төрсөн өдрөөр нь Солт Лейк хотод аав нь түүнд баптисм хүртээв	
1893 он	16 настайдаа, Солт Лейкийн Ариун сүмийг онцгойлон адислахад оролцов	
1898 он	21 настайдаа, Люиз Эмили Шөртлифтэй гэрлэв	
1899–1901 он	22–24 настайдаа, Англид номлолд үйлчлэв	
1901 он	24 настайдаа, Сүмийн түүхчийн албан тушаалд ажиллаж эхлэв	

1908 он	32 настайдаа, анхных нь эхнэр нас барсны дараа Эфел Рейнольдстой гэрлэв
1910 он	33 настайд нь, Ерөнхийлөгч Жозеф Ф. Смит түүнийг Төлөөлөгчөөр томиллов
1921–1970 он	44–93 настайдаа, Сүмийн түүхчээр үйлчлэв
1938 он	61 настайдаа, хоёр дахь эхнэр нь нас барсны дараа Жесс Ийванстай гэрлэв
1945–1949 он	68–72 настайдаа, Солт Лейкийн Ариун сүмийн ерөнхийлөгч байв
1951 он	74 настайдаа, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч байв
1970 он	93 настайдаа, Ерөнхийлөгч Давид О. МкКейг нас барсны дараа Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав
1971 он	94 настайд нь, гурав дахь эхнэр нь нас барав
1972 он	95 настайдаа, долдугаар сарын 2-нд Солт Лейк хотод нас барав

ТҮҮНИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ (1970–1972)

1970 он	Африкт (Өмнөд Африкт) анхны гадас зохион байгуулагдав
1970 он	Азид (Японд) анхны гадас зохион байгуулагдав
1971 он	Сүмийн анхны бүсийн чуулган болов (Англид)
1972 он	Ютагийн Огден, Провод ариун сүмүүд онцгойлон адислагдав
1972 он	Сүмийн гишүүнчлэл 3,218,908-д хүрэв

Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смитийн амьдрал

1. “Давид О. МкКейг нас барахад тэр үед бараг 93 хүрч байсан Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит Сүмийн Ерөнхийлөгч болов. Тэр бол Сүмийн Ерөнхийлөгч асан Жозеф Ф. Смитийн хүү юм.
2. “Жозеф Фиелдинг Смит хөвгүүн байхдаа Их Эзэний тааллыг хүсдэг байсан учраас арван нас хүрэхээсээ өмнө Мормоны Номыг хоёр дахин уншиж, юманд явахдаа ч судраа авч явдаг байв. Түүнийг байхгүй бол ихэвчлэн өвс хадгалдаг дээврийн хөндийд судар уншиж байхад нь олдог байжээ. ‘Би мэдээ орсон цагаасаа, анх уншиж сурсан цагаасаа судруудыг судалсан болохоор, Их Эзэн Есүс Христийн тухай, Бошиглогч Иосеф Смитийн тухай, хүмүүний авралын төлөө хийгдсэн ажлын тухай уншсанаас бүх дэлхий дээрх өөр юунаас ч илүү агуу сэтгэл ханамж авдаг байлаа’ гэж тэр хожим нь дурсчээ [In Conference Report, 1930 оны 4-р сар, 91].



сэдвүүдээр хорь гаруй ном, олон чухал өгүүлэл бичжээ.

4. “Түүний удирдлагын үед Ази (Японы Токио), Африкт (Өмнөд Африкийн Иоханнесбург) анхны гадаснууд зохион байгуулагдав. Сүмийн гишүүнчлэл өссөнтэй холбогдуулан Ерөнхийлөгч Смит болон түүний зөвлөхүүд орон нутгийн удирдагчдыг сургаж, Ерөнхий Эрх мэдэлтнүүдтэй уулзах боломжийг гишүүдэд олгохын тулд, дэлхий даяар бүсийн чуулган хийж байх ажлыг эхлүүлэв. Ийм анхны чуулган Английн Манчестерт болжээ. Дэлхий даяар хүмүүст илүү сайн үйлчлэхийн тулд эрүүл мэндийн үндсэн зарчмууд болон эрүүл ахуйг заалгахаар эрүүл мэндийн номлогчдыг дуудав. Удалгүй олон оронд 200 гаруй эрүүл мэндийн номлогчид үйлчилж байлаа.

5. “1912 оноос хойш Нэгдсэн Улсын өрнөд хэсэгт ахлах сургуулиудтай залгаа оршдог байрнуудад семинарын ангиудыг Сүм ивээн тэтгэсээр байлаа. 1920-иод онд Хожмын Үеийн Гэгээнтнүүд олноор сурдаг коллеж, их сургуулиуд дээр шашны институтууд эхлэв. 1950-иад оны эхээр өглөө эрт хичээллэдэг семинарын ангиуд Калифорнийн бүсийн Лос Анжелест эхэлж, удалгүй 1800 оюутан явдаг болов. Хожмын Үеийн Гэгээнтэн 15–18 насны залуучууд долоо хоногийн таван өдөр шашин судлах семинарт явахар өглөөний 5:30-д босдог гэхэд гишүүн бус хүмүүс гайхдаг байв. 1970-аад оны эхээр дэлхий даяар Хожмын Үеийн Гэгээнтэн оюутнууд шашны заавар хүлээн авахын тулд семинарын хичээлийг гэрээр судлах хөтөлбөрүүдийг нэвтрүүлжээ. Ерөнхийлөгч Смитийн удирдлагын үед семинар, институтийн элсэлт эрс өсөн нэмэгдсэн юм.

6. “1972 оны дөрөвдүгээр сарын ерөнхий чуулган дээр Ерөнхийлөгч Смит сүүлчийн удаа олон нийтэд хандаж хэлсэн үгэндээ: ‘Их Эзэн Есүс Христийн сайн мэдээнээс өөр дэлхийн өвчин эмгэгийг эдгээх зүйл байхгүй. Амар амгалан, зуурдын болон сүнслэг байдлын цэцэглэл хөгжилт, Бурханы хаант улс дахь амин чухал өвийн төлөөх бидний найдвар гагцхүү сэргээгдсэн сайн мэдээгээр дамжин хэрэгждэг билээ. Сайн мэдээг номлох, дэлхий дээр Сүм болон Бурханы хаант улсыг байгуулахаас илүү чухал оролцох ажил бидний хэнд нь ч байхгүй’ гэжээ [In Conference Report, 1972 оны 4-р сар, 13; Ensign, 1972 оны 7-р сар, 27].

7. “Жозеф Фиелдинг Смит Сүмийн Ерөнхийлөгчөөр хоёр жил хагас үйлчилсний дараа охиныхоо гэрт анир чимээгүйхэн таалал төгсчээ. Тэрбээр 95 нас хүрсэн бөгөөд Их Эзэнд насан туршдаа зоримог шийдэмгий үйлчилсэн билээ” (Бидний Өв, 141–143).



Сүмийн бүсийн анхны чуулган Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смитийн удирдлагаар 1971 оны наймдугаар сард Англид болжээ. Индэр дээр байгаа нь Ахлагч Ховард В. Хантер.

Уншсанаа ойлгох нь



Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смитийн амьдрал

Удирдлага (догол мөр 4) — **Өв** (догол мөр 6) — Оршин Ерөнхийлөгчийн Зөвлөл : суух газар, шагнал

Жозеф Фиелдинг Смитийн сургаал ба гэрчлэл



8. “Сайн мэдээний зарчмуудын хувьд аливаа ажлыг хойш тавих нь Эцэг Хүү хоёрын оршихуй дахь амьдрал-мөнх амьдралыг хулгайлагч юм. Сайн мэдээний зарчмуудыг баримтлах болон зарлигуудыг сахихад яарах хэрэггүй гэж боддог олон хүмүүс, тэр ч байтугай Сүмийн гишүүд бидний дунд байдаг” (In Conference Report,

1969 оны 4-р сар, 121).

9. “Хэрэв та нар Бурханы хаант улс дахь өргөмжлөл болох авралыг бүрнээр нь хүсдэг бол, Түүний хөвгүүд, охид байхыг хүсдэг бол, Их Эзэний ариун сүмд орж, уг өргөөнд хамаарагддаг, өөр хаана ч хүлээн авч чадахгүй ариун ёслолуудыг хүлээж авах хэрэгтэй. Эрэгтэй хүн ганцаараа үүрд мөнхийн өргөмжлөлийг бүрнээр нь хүлээн авч чадахгүй. Харин эрэгтэй хүн эхнэртэйгээ хамт Их Эзэний ариун сүмд лацдалтын хүчийг хүлээн авч, тэр цагаас хойш бүх зарлигуудыг сахих юм бол, өргөмжлөлд хүрч, улмаар Их Эзэнтэй адилхан болно. Энэ бол хүмүүний хувь тавилан юм. Энэ бол Их Эзэн хүүхдүүдээсээ хүсэн хүлээдэг зүйл мөн” (Doctrines of Salvation, 2:44).

10. “Хэлсэн үг нь Их Эзэний илчилсэн зүйлтэй зөрчилдөж байвал, хэн юу гэж бичсэн буюу хэн юу гэж хэлсэн нь ялгаагүй, бид үүнийг хэрэгсэхгүй байж болно. Миний үгс, түүнчлэн Сүмийн бусад аль ч гишүүний заадаг өндөр буюу доогуур түвшний зүйлс нь хэрэв илчлэлтүүдтэй нийцэхгүй байвал, бид ийм зүйлүүдийг хүлээн авах хэрэггүй. Энэ асуудал бидэнд тодорхой байг. Бид хүмүүний сургаал

бүрийг хэмждэг хэмжүүр буюу тэнцвэржүүлэгч дөрвөн жишиг бүтээлийг хүлээн зөвшөөрсөн билээ” (Doctrines of Salvation, 3:203).

11. “Энэ Сүмийн аль ч гишүүн Мормоны Номыг дахин дахин уншиж, энэ ном бол үнэн хэрэгтээ Бүхнийг Чадагчийн сүнсний нөлөө бүхий цэдэг мөн, энэ номонд өгүүлсэн түүх үнэн гэдгийг гэрчлэхийн тулд номыг бүх талаас нь авч үзэх хүртлээ хэзээ ч сэтгэл ханамжтай байдаггүй юм шиг надад санагддаг. . . .

12. “... Мормоны Номыг нягт нямбай, анхааралтайгаар уншаагүй энэ Сүмийн гишүүн хэн ч гэсэн Бурханы оршихуйд хүлээн зөвшөөрөгдөж чадахгүй” (In Conference Report, 1961 оны 10- сар, 18).



13. “Би Сайн мэдээний Сэргээлтийн тухай, бидний Гэтэлгэгчийн үүрэг зорилгын тухай, Бошиглогч Иосеф Смитийн дуудлагын тухай, Цаг хугацааны бүрэн байдлын эрин үе гэгддэг бидний амьдарч байгаа эрин үед энэ ажлыг үндэслэн бий болгосон тухай гэрчлэлээ хэлэхийг хүсч байна.

Есүс Христ бол Бурханы Төрүүлсэн Ганц Хүү, дэлхийн Гэтэлгэгч, хүмүүн нүглээ наманчилж, сайн мэдээг хүлээн авсан тохиолдолд хүмүүний Аврагч гэдгийг би төгс мэднэ. Тэрээр үхлээрээ бүх хүмүүнийг гэтэлгэж, бид өөрсдөө хариулж үл чадах золиослолыг өөр дээрээ авсан билээ. Хэрэв бид түүнийг хүлээн авч, сургаалуудад нь үнэнч, итгэлтэй байх юм бол энэхүү золиослол биднийг нүглээс ангижруулна.” (In Conference Report, 1956 оны 4-р сар, 58).

Уншсанаа ойлгох нь



Жозеф Фиелдинг Смитийн сургаал ба гэрчлэл

Хойш тавих (догол мөр 8) — Хий ёстой зүйлийг хойшлуулах, санаатайгаар алгуурлах : **Өргөмжлөл** (догол мөр 9) — Бурханлиг шинж чанар : **Нийцэх** (догол мөр 10) — Тохирох, таарах

Догол мөр 13—“Цаг хугацааны бүрэн байдлын эрин үе” гэж юу вэ?

Ерөнхийлөгч Спенсер В. Кимбалл: “Эрин зуунуудын дотор Их Эзэн Өөрийн хүмүүсийг хамтад нь цуглуулж, сайн мэдээний болон авралын тодорхой ёслолуудыг тэдний дунд бий болгосон үеүд байдаг. Эдгээр үеүдийг бид сайн мэдээний эрин үеүд гэж нэрлэдэг” гэж сургажээ (“The Things of Eternity—Stand We in Jeopardy?” *Ensign*, 1977 оны 1-р сарын, 3). Бид “Цагийн дүүрний үе” (Ефес 1:10) буюу Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн өмнөх эрин үед аж төрж байна.

Уншсанаа судлах нь



“Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит”-ийг судлахдаа үйл ажиллагаа А, мөн Б буюу В-г хий

А Хариуг ол

1. Хэрэв чи эмч байсан бол ямар өвчнийг эмчлэхэд хамгийн хэцүү гэж бодох вэ? Яагаад?
2. Догол мөр 2-3, 5-6-г нэгтгэн дүгнэж дараах даалгаврыг хий:
 - а. Дэлхийн сүнсний зарим “өвчнүүдийг” жагсаан бич.
 - б. Эдгээр өвчнүүдийг эмчлэхэд туслах ямар “жоруудыг” Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смит санал болгосон бэ?
 - в. Ерөнхийлөгч Смит залуу байхдаа сүнсний өвчнүүдээс яаж зайлсхийдэг байсан бэ?
 - г. Амьдралдаа ийм “эмчилгээтэй” байх боломжийг семинар хэрхэн хангадаг вэ?

Б Хулгайчийг зогсоо

Чи ямар нэг үнэтэй зүйлээ хулгайд алдсан уу? Энэ тухайд ямар санагдсан бэ?

1. Догол мөр 8-ыг нэгтгэн дүгнэж, дараах асуултуудад хариул:
 - а. Биднээс ямар үнэт зүйлийг хулгайлж болох вэ?
 - б. Эдгээр үнэт зүйлсийг яаж хулгайлдаг вэ?
 - в. Хулгайч нь хэн бэ?
2. Догол мөр 11-12-ыг нэгтгэн дүгнэж, дараах даалгаврыг хий:
 - а. Хойшлуулахыг сэрэмжлүүлсэн, мөнх амьдралын тухай өгүүлсэн нэг судрыг Мормоны Номоос ол.
 - б. “Бурханы оршихуйд хүлээн зөвшөөрөгдөхийн” тулд чи юу хийж болохоо бич.

В Тэмдэглэл бич

Догол мөр 9-ийг нэгтгэн дүгнэж, өөрсдийгөө саяхан ариун сүмд гэрлэсэн гэж бодон тэмдэглэл бич. Тэмдэглэлдээ дараах асуултуудын талаар бодож, хариултуудыг оруул:

1. Ямар ариун сүмд чи лацдан холбуулахыг хүсэх вэ?
2. Ерөнхийлөгч Смитийн сургаалууд дээр тулгуурлавал, ариун сүмд лацдан холбуулах нь та нарт яагаад чухал вэ?
3. Чи тэнд хэн болохыг хүсдэг вэ? Яагаад?
4. Ариун сүмд зохих ёсоор шүтэн бишрэх нь Их Эзэнтэй илүү адилхан болоход та нарт хэрхэн тусалж болох вэ?



Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл Ерөнхийлөгч Харольд Б. Лийгийн оршуулга дээр хэлсэн үгэндээ, Ерөнхийлөгч Лийг “Бурханы хамгийн уужуу сэтгэлтэй, хүчирхэг, хоёргүй сэтгэлтэй, урьдчилан томилогдсон аварга улаан моддын нэг” хэмээн дүрсэлжээ (Л.Брент Гэутс,

Харольд Б.Лий: Бошиглогч бөгөөд Үзмэрч [1985], 595). Өөр нэг тохиолдолд, Ерөнхийлөгч Кимбалл Ерөнхийлөгч Лийг “турилагажсан, үнэнч шударга, хөтөлбөрөөр [Сүмийн] боловсорсон, сүнслэг, юуны түрүүнд Их Эзэнээр дуудагдсан хүн . . . хэмээн дүрсэлжээ. Аль хэдийнээс сургагдсан, сүнслэг, дуудлагаа нөр хичээнгүй зүтгэлээр биелүүлдэг энэ хүнийг бид харсан. Түүнийг мэдэгдэл хийж, шийдвэр гаргахыг нь бид харгаад, энэ бүгдэд хоньчин, хүмүүний удирдагч, Их Эзэний бошиглогч, нөмрөг өмсөгчийн дуу хоолойг бид ялан таньдаг” (Teachings of Spencer W. Kimball, 467). Ерөнхийлөгч Лийгийн сургаалууд ба амьдралыг судлахдаа түүний амьдралыг тодорхойлсон, дэлхий дахиныг адислах болно гэдэгт тэрээр итгэдэг байсан, хувь хүнийх нь энгийн итгэлийг ажигла.

ТҮҮНИЙ АМЬДРАЛ (1899–1973)

1899 он	Гуравдугаар сарын 28-нд Айдахогийн Клифтонд Самуел Бингхам Лий, Люиза Бингхам Лий нарын гэр бүлд төржээ	
1907 он	8 настайдаа, зургадугаар сарын 9-нд Байби Цөөрөмд баптисм хүртжээ	
1916 он	17 настайдаа, Айдаход сургуулийн багшаар ажиллаж эхлэв	
1920–1922 он	21–23 настайдаа, Нэгдсэн Улсын өрнөдөл номлолд үйлчлэв	
1923 он	24 настайдаа, Фөрн Таннертай гэрлэв	
1932 он	33 настайдаа, Солт Лейк хотын засгийн газарт удирдагч болов	
1935 он	36 настайдаа, Сүмийн Халамжийн хөтөлбөрийг зохион байгуулахаар дуудагдав	
1941 он	42 нас, Ерөнхийлөгч Хебер Ж. Грант түүнийг Төлөөлөгчөөр томилов	
1961 он	62 настайдаа, Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын зохион байгуулсан Сүмийн Нэгтгэн Зохицуулалтын даргаар нэрлэгдэв	
1963 он	64 настайдаа анхных нь эхнэр нас барсны дараа Фреда Женсентэй гэрлэв	
1970 он	70 настайдаа, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав	
1970–1972 он	71–73 настайдаа, Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смитийн Нэгдүгээр зөвлөх байв	
1972 он	73 настайдаа, Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав	
1973 он	Арванхоёрдугаар сарын 26-нд Солт Лейк хотод нас барав	

ТҮҮНИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ (1972–1973)

- 1972 он** Ганц бие насанд хүрэгч залуучуудын шинэ байгууллага бий болов
- 1973 он** Сүмийн эрүүл мэндийн үйлчлэлүүд, нийгмийн үйлчлэлүүд, тэрчлэн халамжийн хөтөлбөрүүдийн хамт зохион байгуулагдав; хөдөө аж ахуй эрхлэх аргаа сайжруулахад хүмүүст туслахын тулд хөдөө аж ахуйн номлогчдыг дэлхийн янз бүрийн хэсгүүд рүү илгээв. Сүмийн гишүүнчлэл 3,306,658-д хүрэв

Ерөнхийлөгч Харольд Б.Лийгийн амьдрал

- “Ерөнхийлөгч Жозеф Фиелдинг Смитийг таалал төгссөний дараагийн өдөр Арванхоёрын Чуулгын хамгийн ахмад гишүүн, Ерөнхийлөгч Харольд Б.Лийгийн гэрийнхэн гэр бүлийн үдэш хийхээр цуглажээ. Ерөнхийлөгч Лийд хамгийн ихээр туслахын тулд тэд юу хийж болохыг гэр бүлийнх нь нэг гишүүн асууж. ‘Итгэлдээ үнэнч бай. Та нарт миний заадаг шиг яг тийм байдлаар сайн мэдээгээр амьдар’ гэж тэр хариулжээ. Энэ захиас Сүмийн бүх гишүүдэд хамаатай юм. Харольд Б.Лий Сүмийн Ерөнхийлөгч болоод хийлгэсэн анхныхаа хэвлэлийн бага хурал дээр: ‘Бурханы зарлигуудыг сахигтун. Ороо бусгаа энэ цагт чухам үүнд л хувь хүмүүсийн болоод улс үндэстнүүдийн аврал оршино’ хэмээн мэдэгджээ [in Francis M. Gibbons, *Harold B. Lee: Man of Vision, Prophet of God* [1993], 459].
- “Харольд Б.Лий 1972 оны долдугаар сарын 7-нд Сүмийн Ерөнхийлөгч болоход тэр 73 настай, Хебер Ж.Грантаас хойш Ерөнхийлөгч болсон хамгийн залуу Төлөөлөгч байв. Тэрээр 1935 онд Сүмийн халамжийн хөтөлбөрийг удирдахаар дуудагдсанаасаа хойш Сүмийн удирдлагад гол чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Тэр бас Сүмийн хөтөлбөрүүд болон сургалтын материалуудыг хянан засварлахад гол үүрэг гүйцэтгэсэнээр Сүмийн хөтөлбөрүүдийг хялбаршуулан, зохицуулалт хийх боломжтой болгосон ажээ. Тэрээр тэнгэрээс хүлээн авсан санаа бодлуудад түргэн хариулдаг, гүнзгий сүнслэг хүн байв.
- “Ерөнхийлөгч Лий болон түүний зөвлөхүүд Мехико хотод болсон бүсийн хоёр дахь чуулганыг тэргүүлсэн ажээ. Энэ чуулганд цугласан Сүмийн гишүүд бол Сүмийн шинэ Тэргүүн Зөвлөлийг дэмжин баталсан анхны Хожмын Үеийн Гэгээнтнүүд байв. ‘Сүмийн агуу өсөлтийг авчрахад . . . нэн чухал тус дэмжлэг болсон олон хүний гайхалтай хөдөлмөрийг хүлээн зөвшөөрч, магтан сайшаахын тулд цугларалтыг Мехикод хийсэн юм’ гэж Ерөнхийлөгч Лий тайлбарлажээ.



- “Мексик болон Төв Америк дахь Гэгээнтнүүд бүсийн чуулган Мехико хотод болох нь гэдгийг мэдээд, олон хүн чуулганд оролцохоор төлөвлөж эхэлсэн гэдэг. Нэг эгч айлаас айлд очиж угаалгах юм байна уу гэж асууж явав. Тэр эгч таван сарын турш хөршүүдийнхээ хувцсыг угааж цэвэрлэснээс олсон песог хадгалсаар байгаад чуулганд очиж, бүх хуралдаануудад оролцох боломжтой болжээ. Олон Гэгээнтэн цуглаануудад оролцохын тулд ажил хийж, мөнгө хадгалснаас хоол хүнс авах мөнгөгүй болж, чуулганы өдрүүдэд сайн дураараа мацаг барьж байжээ. Золиослол хийсэн хүмүүс сүнсний агуу хүч чадлаар адислагдсан юм. Чуулган ‘амьдралд минь тохиолдсон хамгийн сайхан туршлага байлаа!’ гэж нэг гишүүн хэлсэн ажээ. Өөр нэг гишүүн, ‘Энэ өдрүүдэд бидний энд мэдэрсэн хайрыг мартаж гэвэл олон жил шаардагдана’ гэж сурвалжлагчид ярьжээ [Жей М. Тодд, “The Remarkable Mexico City Area Conference,” *Ensign*, 1972 оны 11-р сар, 89, 93, 95-ыг үз.]
- “Ерөнхийлөгч Лий өөрийнхөө удирдлагын үед Ариун Нутагт очсоноор, энэ эрин үед тийшээ очсон Сүмийн анхны Ерөнхийлөгч болов. Бас жижиг ариун сүмүүд баригдаж, эцэстээ дэлхий даяар олшрох болно гэдгийг тэр зарласан юм.
- “1973 оны Христийн Мэндэлсний Баярын нэг өдрийн дараа Сүмийн Ерөнхийлөгчөөр ердөө арваннайман сар үйлчилсний эцэст Ерөнхийлөгч Лий таалал төгсөв. Аварга сүнслэг хүн тэрбээр мөнхийн гэртээ харьжээ” (*Бидний Өв*, 143–145).

Уншсанаа ойлгох нь



Ерөнхийлөгч Харольд Б.Лийгийн амьдрал

- | | |
|---|---|
| Нэгтгэн зохицуулалт (догол мөр 2)—Уялдаа холбоог нэг мөр болгон зохицуулах | сэн нэгж. Нэг песо 100 центавостой тэнцэнэ. |
| Песо (догол мөр 4)—Мексикийн мөнгөний үнд- | Энэ эрин үе (догол мөр 5)—Есүс Христийн Хоёр дахь Ирэлтийн өмнөх эцсийн үе |

Харольд Б. Лийгийн сургаал ба гэрчлэл



7. Харольд Б. Лий бяцхан хөвгүүн байхдаа хашааны завсраар хөршийнхөө хашаан дахь хэдэн эвдэрхий барилгыг хараад үүнийг ашиглахсан гэж боддог байж. Түүнийг хашаа дамжин авиртал, нэг хүн дуугарч, “Харольд тийшээ бүү ор” гэжээ. Хожим нь тэр: “Хэн ингэж хэлснийг мэдэх гэж би тал тал тийшээ харлаа, гэвч хэн ч

байсангүй. Хэн ч харагдсангүй. Нэг хүн намайг үл харагдагч аюулаас сэрэмжлүүлж дээ гэж би бодов. . . . Үл харагдагч ертөнцөөс ирдэг дуу хоолойг бид үүгээр дамжуулан сондог, үүрд мөнхийн үзэгдлүүдийг үүгээр дамжуулан өөрсдөдөө авчирдаг, хүмүүнд үл мэдэгдэх үйл явц байдгийг би тэр үеэс эхлэн эргэлзээгүйгээр хүлээн зөвшөөрсөн юм” гэж тайлбарлажээ (“The Way to Eternal Life,” *Ensign*, 1971 оны 11-р сар, 17).

8. “Миний бие Сүнсний заасан нэг зүйлийг сайн мэдсэн. Энэ дэлхийн аюулгүй байдал аль нэг тодорхой газарт байдаггүйг би мэднэ. Дэлхийн аюулгүй байдал бидний амьдардаг газрыг төдийлөн өөрчилдөггүй. Харин хамгийн чухал зүйл бол бид хэрхэн амьдардаг нь юм. Израил [Сүмийн гишүүд] гагцхүү зарлигуудыг сахиж, Их Эзэний Ариун Сүнсний нөхөрлөл, чиглүүлэл, тайтгаруулал, удирдамж тэдэнд байгаа үед, өөрийгөө төлөөлөн яригчид болгон тэргүүлүүлэхээр Бурханы томилсон эрчүүдийн үгсийг сонсох хүсэлтэй байгаа үед, мөн бид Сүмийн зөвлөгөөг дуулгавартай дагасан үед Израил аюулгүй байх болно гэдгийг би мэдсэн юм.” (In Conference Report, 1943 оны 4-р сар, 129).

9. “Энэ амьдралд хүний үүрч болох хамгийн хүнд ачаа бол нүглийн дарамт мөн” (In Conference Report, 1973 оны 4-р сар, 177; *Ensign*, 1973 оны 7-р сар, 122).

10. “Амьдралыг гүнзгий харах тутам, би нэг зүйлд улам бүр итгэдэг болсон. Энэ нь юув гэвэл, бид гагцхүү наманчлалын арга замыг зааснаар сэтгэл ханах биш, харин нүглийн аймшигийг залуу хүмүүс та нарт ой тойнд ортол нь ойлгуулах ёстой. Ёс суртахууны нүгэл үйлдсэний дараа ирдэг тамын харанхуй шөнийн тухай та нарт сэрэмжлүүлдэг хэн нэгэн байхыг би хүснэ” (*Youth and the Church* [1945], 90).

11. Далын гишүүн асан Ахлагч Хенри Д. Тейлор судар судлахын ач холбогдлын талаар Ерөнхийлөгч Лийгийн хэлсэн үгнээс эш татсан байдаг: “Хэрэв бид судруудыг өдөр бүр уншихгүй бол бидний гэрчлэл нимгэрэн хорогдож, сүнс-лэг байдал маань өсөн нэмэгдэхээ больдог” (In Conference Report, 1976 оны 10-р сар, 89; *Ensign*, 1976 оны 11-р сар, 62).

12. “Гэрчлэл бол өнөөдөр та нарт байгаа зүйл биш, харин та нарт байнга байх ёстой зүйл. Гэрчлэл эмзэг хэврэг юм. Сарны туяаг барихтай адил гэрчлэлийг барьж байх нь хэцүү. Энэ бол та нар амьдралаасаа өдөр бүр дахин барьж авч байх ёстой зүйл” (“President Harold B. Lee Directs Church; Led by the Spirit,” *Church News*, 1972 оны 7-р сарын 15, 4).

13. “Энэ Сүмд бидний заадаг бүх зүйл судруудад агуулагдадаг байх ёстой. Энэ бүхэн судруудад байдаг байх ёстой. Бид сэдвүүдээ судруудаас сонгодог байх ёстой. Хэрэв бид үнэнийг хэмжиж үзэхийг хүсвэл, тухайн юмыг хэн бичсэн нь

хамаагүй, дөрвөн жишиг бүтээлээр үүнийг хэмжиж үзэх ёстой. Хэрэв энэ зүйл жишиг бүтээлүүдэд байхгүй бол, бид үүнийг хүмүүний үзэл бодол, хувийн санаа гэж ойлгох ёстой. Хэрэв энэ зүйл судруудад байдагтай харшилж байвал, үнэн биш байдаг. Энэ бол бүх үнэнийг хэмжих бидний хэмжүүр мөн” (“Using the Scriptures in Our Church Assignments,” *Improvement Era*, 1969 оны 1-р сар, 13).

14. “Судрууд өгүүлдэг зүйлээс гадна, бошиглогчид өнөө үед бидэнд хандан ярьж байгаа зүйлүүд бас байдаг” (*Teachings of Harold B. Lee*, 471).

15. “Хэрэв та нар Гэгээнтнүүдийг мэдээсэй хэмээн Их Эзэний хүсч байгаа зүйлийг мэдэхийг хүсч байгаа бол, мөн дараагийн зургаан сард Түүний удирдамж, чиглүүллийг авахыг хүсч байгаа бол, [ерөнхий] чуулган дээр хэлсэн үгсийн нэг хувийг олж ав. Тэгвэл Гэгээнтнүүдийн санаа сэтгэлийг эзэмдсэн Их Эзэний хамгийн сүүлчийн үг та нарт байх болно. [Бас] манайхан биш боловч, хэлсэн зүйл нь Их Эзэний оюун ухаан, Их Эзэний хүсэл таалал, Их Эзэний дуу хоолой, авралын төлөөх Бурханы хүч” (С ба Г 68:4-ийг үз.) мөн гэдэгт итгэдэг бусад бүх хүмүүст энэ үг мөн нэгэн адил байх болно” (In Conference Report, 1973 оны 10-р сар, 168; *Ensign*, 1974 оны 1-р сар, 128).



16. “Энэ ажлын бурханлиг шинжийг би мэддэг учраас ариун гэрчлэлээ хэлэхийг хүсч байна. Энэ ажил амжилт олно гэдгийг би мэднэ. Дэлхийд Сүмийн нөлөөг бууруулах, Сүмээс дутагдал олж харахыг оролддог дайснууд Сүмийн дотор бас сүмийн гадна байж болох ч гэсэн, Их Эзэний үгийн эсрэг хүмүүний бодож олсон бүх хүч чармайлт, зэвсгүүд замын хажууд унахад энэ Сүм сорилтын цаг үеийн дундуур туулан ялалтад хүрч, тэсэн гарна. Бидний Их Эзэн Есүс Христ бол энэ Сүмийн тэргүүн гэдгийг; мөн Тэрээр Өөрт нь мэдэгдсэн арга замуудаар дамжуулан зөвхөн өндөр албан тушаалтай Сүмийн удирдагчидтай төдийгүй, бас Бурханы зарлигуудыг сахидаг хувь гишүүдтэй өдөр бүр харилцаагааг би мэднэ” (In Conference Report, 1973 оны 4-р сар, 10; *Ensign*, 1973 оны 7-р сар, 6).

Уншсанаа ойлгох нь



Харольд Б. Лийгийн сургаал ба гэрчлэл

Харшлах (догол мөр 13)— : Бууруулах (догол мөр 16)—
Эсрэг байх, нийцэхгүй байх : Сулруулах, устгах

Уншсанаа судлах нь



“Ерөнхийлөгч Харольд Б. Лий”-г судлахдаа үйл ажиллагаа А, үйл ажиллагаа Б буюу В-г хий

А Нотолгоо хай

1. Догол мөр 1-ийг нэгтгэн дүгнэж, хүнд хэцүү цаг үеийг туулан гарахад нь тэдэнд тусалж болох ямар зөвлөгөөг Ерөнхийлөгч Харольд Б. Лий гэр бүлдээ болон Сүмийн гишүүдэд өгснийг эрж ол.

2. Догол мөр 4-ийг нэгтгэн дүгнэж, Мексик, Төв Америк дахь Гэгээнтнүүд Ерөнхийлөгч Лийгийн дараах хоёр сургаалын дагуу амьдарч байсан нотолгоог жагсаан бич:
 - а. “Итгэлдээ үнэнч бай.”
 - б. “Бурханы зарлигуудыг сахь.”

3. Өөрийгөө өмгөөлөгч гэж бод. Мексик, Төв Америк дахь Гэгээнтнүүдийн итгэл бишрэлийг хамгаалахын тулд хэлэх үгээ харуулсан товчхон нэг догол мөр бич.

Б Найздаа тусал

Нэг найзын чинь саяхан гаргасан шийдвэр түүнийг үл үзэгдэх аюул руу хөтөлж байгаа талаар санаа чинь зовж байна гэж төсөөлөн бод. Догол мөр 7–10-ыг нэгтгэн дүгнэж, найздаа туслахын тулд юу хэлэхээ жагсаан бич. Дараах асуултуудын хариуг ол:

1. Бидэнд хүнд дарамт учруулж болох үл харагдах ямар аюулууд байдаг вэ? (догол мөр 9–10-ыг үз).
2. Үл харагдах аюулаас хол байхад нь залуу Харольд Б.Лийд юу тусалсан бэ? (догол мөр 7-г үз).
3. Ариун Сүнсний хангадаг найдвартай, аюулгүй байдал бидэнд байхын тулд бид юу хийж болох вэ? (догол мөр 8-ыг үз).

В Үзүүлэн хий

Гадасны буюу дүүргийн залуучуудын чуулганыг төлөвлөж байгаа хорооны бүрэлдэхүүнд өөрийгөө оржээ гэж бод. Чуулганы сэдвийг зарлах нь өөрийн чинь хариуцсан ажил. Догол 11–15-ыг нэгтгэн дүгнэж, дараах зүйлүүдийг багтаасан үзүүлэн төлөвлө:

1. Дээрх догол мөрүүдэд Ерөнхийлөгч Лийгийн заасан зүйл дээр үндэслэгдсэн сэдэв.
2. Уг сэдвийг хураангуйлан дүгнэсэн, Ерөнхийлөгч Лийгийн хэлсэн нэг өгүүлбэр буюу нийлэмж үг.
3. Ерөнхийлөгч Лийгийн заасан, мөн уг сэдвийг дүрслэхэд туслах зүйлийг төлөөлсөн нэг буюу хоёр зураг.
4. Амьдралдаа хүч чадлыг олоход нь эл сэдэв залуу хүмүүст тусалж чадах арга замууд.

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл “Алхаагаа уртасга”

Тэр үед Тэргүүн Зөвлөлийн зөвлөх асан Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли Ерөнхийлөгч Спенсер В. Кимбаллын тухай өгүүлж, хэлэхдээ: “Бид бүгдийн хувьд тэрээр ямар гайхалтай үлгэр дуурайл байсан билээ. Тэрбээр энэ ажилд гайхалтай арга замаар шижим түлхэц [өсөлтийн урам дэм] өгсөн юм. Сүм бүхлээрээ алхаагаа

түргэсгэж, Түүний яруу тод [тодорхой] уриалагд хариулахад алхаагаа уртасгасан юм. Тэр бол бидний бошиглогч. Хүлээн авсан үзэгдэл, илчлэлт нь яс үндэс, арьсны өнгө, амьдралын түвшинг нь эс харгалзан, Есүс Христийн сайн мэдээний юутай ч зүйрлэшигүй адислалыг хүлээж авах бүх хүмүүст чөлөөтэйгөөр санал болгогдож, бүх дэлхийн хүмүүст хүрсэн бошиглогч юм” гэжээ (In Conference Report, 1983 оны 4-р сар, 3–4; Ensign, 1983 оны 5-р сар, 5). Ерөнхийлөгч Кимбаллын амьдралыг авч үзэхдээ, Сүмд өнөөдөр ч гэсэн нөлөөлсөөр байгаа түүний хүлээн авч байсан “үзэгдэл болон илчлэлтийн” нотолгоог эрж ол.

ТҮҮНИЙ АМЬДРАЛ (1895–1985)

1895 он	Гуравдугаар сарын 28-нд Солт Лейк хотод Андрю Вуллей Кимбалл, Олайв Вуллей Кимбалл нарын гэр бүлд төржээ	
1903 он	8 настайд нь, төрсөн өдрөөр нь аав нь түүнд баптисм хүртээжээ	
1916 он	11 настайд нь, ээж нь нас барав	
1914–1916 он	19–21 настайдаа, Нэгдсэн Улсын төв хэсэгт номлолд үйлчлэв	
1917 он	22 настайдаа, арваннэгдүгээр сарын 16-нд Камилла Айрингтай гэрлэв	
1943 он	48 нас, Ерөнхийлөгч Хебер Ж. Грант түүнийг Төлөөлөгчөөр томилов	
1946 он	51 настайдаа, Америкийн индианчуудтай ажиллахаар томилогдов	
1964–1967 он	69–72 настайдаа, Өмнөд Америк дахь номлолын ажилд хяналт тавьж байв	
1972 он	77 настайдаа, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав	
1973 он	78 настайдаа, Ерөнхийлөгч Харольд Б. Лийг нас барсны дараа Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав	
1985 он	90 настайдаа, арваннэгдүгээр сарын 5-нд Солт Лейк хотод нас барав	

ТҮҮНИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ (1973–1985)

1974–1985 он	Дэлхий даяар хорин нэгэн ариун сүм онцгойлон адислагджээ
1976 он	Бошиглогч Иосеф Смит болон Ерөнхийлөгч Жозеф Ф. Смитэд өгөгдсөн илчлэлтүүд судрууд дээр нэмэгдэв (С ба Г 137–138-р хэсгүүдийг үз). Далын Нэгдүгээр Чуулгыг өөрчлөн зохион байгуулав
1978 он	Санваарын талаарх илчлэлт хүлээн авагдав (Албан Тунхаг 2-ыг үз)

1979 он	Израилын Иерусалимд баригдсан Дурсгалын Цэцэрлэгийг Оорсон Хайд онцгойлон адислав; Сүмийн 1000 дахь гадас зохион байгуулагдав. Библийн Хаан Жеймсийн Хувилбар судрын нэмэлт тусламжийн хамт хэвлэгдэв
1982 он	“Есүс Христийн Бас Нэгэн Гэрээ” Мормоны Номын туслах нэр болон нэмэгдэв
1984 он	Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлүүд анх дуудагдав. Сүмийн гишүүд 5,641,054 болов

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын амьдрал

1. “Өвчин эмгэг, гай зовлонгийн талаар ихийг мэддэг хүн байсан Арванхоёрын хамгийн ахмад гишүүн асан Спенсер В.Кимбалл, Ерөнхийлөгч Лийг таалал төгссөний дараа, Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав. Хавдрын улмаас хоолойнх нь ихэнх хэсгийг тайрсан учир тэр маш намуухан сөөнгө дуугаар ярьдаг байсан нь Хожмын Үеийн Гэгээнтнүүд түүнийг хайрлахад хүргэдэг байжээ. Даруу байдал, шийдэмгий зан, ажиллах чадвар, ‘Үүнийг хий’ гэдэг хувийн уриагаараа нэрд гарсан Ерөнхийлөгч Кимбалл хадуураараа бүх хүч чадлаараа хаддаг байв. . . .



2. “Их Эзэн Өөрийн хүмүүсээс хүсэн хүлээдэг итгэл бишрэлээр Сүм хэрхэн бүрэн дүүрэн байгаагүйг, мөн энэ нь тодорхой хэмжээгээр, бид юмсын байгаа байдалд маадгар, сэтгэл ханамжтай байдаг тийм сүнсэнд нүд дассаныг Ерөнхийлөгч Кимбалл удирдагчдад харуулсан юм. “Бид алхаагаа уртасгах ёстой” гэсэн түүний алдарт уриа үүнийг нотолж байна. Дэлхийн үндэстнүүдэд сайн мэдээг тунхаглах нэгэн үзүүрт шийдвэр төгс байдлаа нэмэгдүүлэхийг

тэрээр цугларасдад сануулав. Тэр бас эх орондоо үйлчилж чадах номлогчдын тоог үлэмж хэмжээгээр нэмэгдүүлэхийг уриалжээ. Уг номлолын төгсгөлд, ‘Израилд үнэхээр бошиглогч байгаа юм байна’ гэж Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлжээ [В. Грант Бангертер, In Conference Report, 1977 оны 10-р сар, 38–39; *Ensign*, 1977 оны 11-р сар, 26–27-г үз].

3. “Ерөнхийлөгч Кимбаллын эрчимтэй удирдлагын дор улам олон гишүүн бүрэн цагийн номлолд үйлчилж, дэлхий дахинд Сүм урагш ахисан юм. 1977 оны наймдугаар сард Ерөнхийлөгч Кимбалл Варшавт очиж, тэнд Их Эзэний ажил урагш ахихын төлөө Польшийн нутгийг онцгойлон адисалж, бас хүмүүсийг нь адисалсан ажээ. Номлогчийн сургалтын төвүүд Бразил, Чили, Мексик, Шинэ Зеланд, Японд бий болов. Тэрээр 1978 оны зургадугаар сард Бурханаас илчлэлт хүлээн авснаа зарласан нь дэлхий даяарх номлолын ажилд асар их нөлөө үзүүлэв. Санваарыг олон жилийн туршид Африкаас гаралтай хүмүүст олгохоос татгалзсаар ирсэн ч, энэ үеэс эхлэн санваар болон ариун сүмийн адислалуудыг бүх зохистой эрэгтэй гишүүдэд хүртээх болсон билээ. . . .

4. “1978 оны зургадугаар сарын илчлэлтээс өмнө Ерөнхийлөгч Кимбалл Африкаас гаралтай хүмүүст санваар олгохыг татгалзаж ирсэн тухай зөвлөхүүдтэйгөө болон Арванхоёр Төлөөлөгчтэй олон сарын турш хэлэлцжээ. Сайн мэдээний бүрэн адислалыг Сүмийн зохистой гишүүдэд олгож болохгүй байсан дэлхийн бүсүүдэд номлолыг нээхэд Сүмийн удирдагчид дургүй байв. Өмнөд Африкт болсон бүсийн нэг чуулган дээр Ерөнхийлөгч Кимбалл: ‘Би их эрч хүчтэйгээр залбирлаа. Бурханы хүүхдүүдийн олных нь тухайд туйлын чухал нэг зүйл бидний өмнө байгааг би мэдэж байв. Зөвхөн зохистой байснаар, бас илчлэлтүүдийг хүлээн авахад бэлэн байснаар, эдгээр зүйлүүдийг зохих байранд нь тавьснаар бид Их Эзэний илчлэлтүүдийг хүлээн авч чадна гэдгийг би мэдлээ. Би өдөр дараалан ганцаараа, бас үлэмж хүндэтгэл, буурь суурьтайгаар ариун сүмийн дээд өрөө рүү очиж, өөрийн санаа бодлыг, мөн уг хөтөлбөрийг урагш ахиулах хүч чармайлтаа өргөн мэдүүлдэг байлаа. Их Эзэний хийхийг хүсдэг зүйлийг би хийхийг хүсч байв. Энэ тухай би түүнд ярьж, “Их Эзэн, би зөвхөн зөв зүйлийг л хүснэ” гэлээ гэжээ [Teachings of Spencer W. Kimball, 451].

5. “Ариун сүм дэх тусгай цуглаан дээр хар арьстан эрэгтэйчүүдэд санваар олгох тухай үзэл бодлоо чөлөөтэйгөөр илэрхийлэхийг Ерөнхийлөгч Кимбалл зөвлөхүүдээсээ болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгаас бүгдээс нь хүсэв. Тийнхүү тэд тахилын ширээний дэргэд Ерөнхийлөгч Кимбаллтай хамт чангаар залбирав. Тэнд байсан Ахлагч Брус Р.МкКонки хожим нь өгүүлэхдээ, “Энэ үйл явдлаар, шаардлага болон итгэлийн улмаас, цаг нь болсны улмаас, Их Эзэн Тэргүүн Зөвлөл, Арванхоёрын дээр бурханлиг зөн билгээрээ, гайхалтай, гайхан биширмээр байдлаар, тэнд байгсаас хэн нь ч өмнө нь үзээгүй тийм онцгой байдлаар Ариун Сүмийг тэдэн дээр юүлсэн юм” гэжээ [“All Are Alike unto God,” *Charge to Religious Educators*, 2nd ed. (1981), 153]. Бүх зохистой эрэгтэйчүүд санваарын бүрэн адислалыг хүлээн авах цаг болсон нь Сүмийн удирдагчдад тодорхой байлаа.

6. “Сүмийн бүх зохистой эрэгтэй гишүүд яс үндэс, арьсны өнгөнөөс үл хамааран, санваарт томилогдож болох тухай” Их Эзэн илчилснийг Тэргүүн Зөвлөл тайлбарлан, 1978 оны зургадугаар сарын 8-наар хаяглагдсан захидлыг санваартны удирдагчдад илгээжээ. 1978 оны есдүгээр сарын 30-нд Гэгээнтнүүд ерөнхий чуулганаар удирдагчдынхаа үйлдлийг санал нэгтгэйгээр дэмжин батлав. Эдүгээ энэ захидал Сургаал ба Гэрээнд Албан Тунхаг 2 болж орсон байна . . .

7. “Ерөнхийлөгч Кимбаллын удирдлагын үед Далын Нэгдүгээр Чуулга өөрчлөн зохион байгуулагдаж, Ням гаригийн турван цагийн цуглааны хуваарийг нэвтрүүлж, ариун сүмүүд түргэн хурдацтай баригдаж байлаа. 1982 онд төлөвлөлтийн шатандаа байгаа буюу баригдаж байгаа ариун сүм дэлхий даяар 22 байсан нь тэр үедээ Сүмийн түүхэн дэх хамгийн олон ариун сүм байв. Ерөнхийлөгч Кимбалл бас аяллын шахуу хуваарь гаргасан нь бүсийн чуулган хуралдуулахын тулд түүнийг олон оронд очиход хүргэсэн аж. Эдгээр хурлууд дээр тэр хувийнхаа хэрэгцээг эс хайхран, орон нутгийн Гэгээнтнүүдтэй уулзаж, тэднийг нэгтгэн, адислах боломж бүрийг төлөвлөдөг байв.

8. “Олон оронд Сүмийн гишүүд, ариун сүмд хүртээдэг авралын ариун ёслолуудыг хүлээн авахын төлөө эгээрэл хүсэл болдог байв. Ийм хүмүүсийн дунд олон номлолд үйлчилсэн, номлолын ерөнхийлөгчийн зөвлөлд ажиллаж байсан, Шведийн нэг Хожмын Үеийн Гэгээнтэн байлаа. Тэр нас барахдаа, эх оронд нь ариун сүм баригдахаас удаан хугацааны өмнө өмч хөрөнгийгөө үлэмж хэсгийг Шведийн

ариун сүмийн санд үлдээсэн ажээ. Ерөнхийлөгч Кимбалл ариун сүмийг зарлахад, энэ хүний хандив хүүгээрээ өсч асар их хэмжээтэй болсон байв. Ариун сүмийг онцгойлон адисалсны дараа удалгүй, амьддаа хишиг хүртсэн сайхь итгэлтэй ах, барихад нь өөрийнх нь мөнгө тусалсан ариун сүмд эцэг эхтэйгээ лацдан холбуулсан гэдэг.



Ерөнхийлөгч Кимбаллын удирдлагын үед, ариун сүмүүд дэлхий даяар баригдан, тоо нь олширч байлаа. Сүмийн гишүүд, тэдний өвөг дээдсийн амьдралыг эдүгээ адисалж байгаа олон ариун сүмийн нэг нь Германы Франкфуртын Ариун сүм юм.

9. “Сингапурт нэг аав ээж хоёр лацдан холбуулж, ариун сүмийн адислалуудаа хүлээж авахын тулд гэр бүлээ ариун сүмд аваачъя гэж боджээ. Тэд шаардлагатай мөнгийг олохын тулд олон зүйлээ золиосолсны дүнд эцэстээ аялал хийж, ариун сүмд орох боломжтой болсон аж. Тэд хэдэн жилийн өмнө өөрсдөд нь зааж байсан номлогчийн гэрт буусан гэнэ. Хүнсний дэлгүүрт очих үед энэ эгч, нөхөр, номлогч хоёроосоо төөрчихжээ. Тэд түүнийг олоход тэр эгч гартаа шампунь барьчихсан уйлж байсан гэнэ. Ариун сүмд орохын тулд түүний хийсэн золиослолуудын нэг нь, долоон жилийн турш тэрээр шампунь хэрэглээгүй байсан гэнэ. Тэдний хийсэн золиослол хэцүү байсан ч, одоо бол ялигүй юм шиг санагдаж болно. Учир нь гэр бүл нь Их Эзэний өргөөний ёслолуудаар үүрд мөнхөд хамтдаа холбогдсоныг тэр мэдэж байлаа.

10. “Ерөнхийлөгч Кимбаллын удирдлагын үед тохиосон өөр нэг томоохон дэвшил бол, 1979 онд Сүм Хаан Жеймсийн Библийн англи хэлээрх шинэ хувилбарыг нийтлүүлсэн явдал мөн. Бичвэр нь өөрчлөгдөөгүй боловч, Библийг Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувдтай эшлэлүүдийг нь харьцуулсан зүүвэр тайлбар нэмэгдсэн ажээ. Том хэмжээний Topical Guide (Сэдэвчилсэн Удирдамж), Bible Dictionary (Библийн Толь Бичиг)-д өнөө үеийн судруудын талаарх хосгүй өвөрмөц ойлголтууд байдаг. Энэ хэвлэл бүх бүлгүүддээ тойм тайлбаруудтай бөгөөд Хаан Жеймсийн Библийн Иосеф Смитийн бурханлигаар нөлөөлөгдсөн засваруудаас энд түүвэрлэн оруулсан болно.

11. “1981 онд бас Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувд шинээр хэвлэгдэн гарав. Эдгээр хэвлэлүүд зүүвэр тайлбарын шинэ тогтолцоо, шинэ бүлэг, хэсгийн тойм, газрын зургууд, товъёогийг (индекс) багтаажээ. Мөн энэ үеэс Сүм хожмын үеийн судруудыг олон хэлэнд орчуулахад онцгой анхаарал тавьж эхэлжээ. . . .



12. “Бүх хүмүүст санаа тавих нь түүний ердийн зан чанар байсныг түмэн хүн бужигнасан нисэх онгоцны буудал дээр хоёр настай бяцхан охинтой залуу ээж, цаг агаарын муухайд хавчигдан, очих газрынхаа нислэгийн тийз олж авахаар дараалалд зогсож байхад болсон үйл явдал харуулсан юм. Жирэмслээд хоёр сар болж байсан тэр эмэгтэй ядарч, өлссөн бяцхан охиноо авч явж болохгүй гэж эмч нар шаардсан ажээ.

Уйлж байгаа хүүхдийнх нь талаар нэлээд хэдэн хүн дургүйцэн шүүмжилсэн атлаа, хэн ч түүнд тусалъя гэсэнгүй. Тэр эмэгтэй хожим нь өгүүлэхдээ:

13. “Бидэн рүү нэг хүн хүрч ирээд ялдамхан инээмсэглэж, “Танд туслахын тулд миний хийж чадах юм байна уу?” гэв. Би түүнд талархан санаа алдаж, санал болгосныг нь хүлээн авлаа. Эхэр татан уйлж байсан бяцхан охиныг минь хүйтэн шалан дээрээс өргөж аваад, нурууг нь аяархан илж, охиныг минь хайраар энгэртээ тэвэрлээ. Бохь зажлах уу гэж охиноос минь асуув. Охиныг тайвшрахад тэр түүнийг аваад миний өмнө дараалалд зогсож байсан хүмүүст ямар нэг юм хэлсэн нь тэдний туслалцаа надад хэрэгтэй байна гэсэн болов уу. Тэд зөвшөөрөв бололтой, нөгөөх хүн дарааллын өмнөх тийзний лангуу руу хүрч очоод, удахгүй явах нислэгт намайг оруулж өгөхийг тийзний ажилтантай тохиролцов. Тэр хүн бидэнтэй хамт вандан сандал руу хүрч очоод, хэсэгхэн хугацаанд надтай ярилцаж сууснаа, миний хувьд одоо санаа зовох юмгүй болсныг хараад яваад өглөө. Долоо хоног орчмын дараа би Төлөөлөгч Спенсер В.Кимбаллын зургийг хараад, тэр хүн бол нисэх онгоцны буудал дээр тааралдсан нөгөөх хүн болохыг таньж билээ’ [Спенсер В.Кимбалл, хянан тохиолдуулсан, Эдвард Л.Кимбалл, Бага Андрою Кимбалл (1977), 334].

14. “Ерөнхийлөгч Кимбалл таалал төгсөхөөс хэдэн сарын өмнө эрүүл мэнд нь ноцтойгоор муудсан ч, хүнд сорилттой тулгарсан үед тэсвэр тэвчээр, сэтгэлийн хат, нөр хичээнгүй зүтгэлийн үлгэр жишээ ямагт болдог байлаа. Сүмийн Ерөнхийлөгчөөр 12 жил үйлчилсний эцэст тэрбээр 1985 оны арваннэгдүгээр сарын 5-нд таалал төгсчээ” (Бидний Өв, 145–148, 50, 52–53).

Уншсанаа ойлгох нь

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбаллын амьдрал

Удирдлага (догол мөр 7)— : Эгээрэл хүсэл (догол мөр
Ерөнхийлөгчийн Зөвлөл : 8)—Ихэд хүсэх, эрмэлзэн
: тэмүүлэх

Спенсер В.Кимбаллын сургаал ба гэрчлэл

15. “Залуу эрэгтэй хүн бүр номлолд үйлчлэх ёстой юу? гэсэн асуултыг асуудаг. Сүмийн хариулт бол, тийм ээ, бас Их Эзэнийн хариулт бол, тийм ээ. Бид эл хариултыг өргөжүүлэн: Сүмийн эрэгтэй гишүүн бүр, аравны нэгээ төлөх ёстой шигээ, цуглаануудаа оролцох ёстой шигээ, амьдралаа дэлхийн муу муухай зүйлүүдээс ангид, цэвэр ариун байлгаж, Их Эзэний ариун сүмд селестиел гэрлэлтийг төлөвлөх ёстой шигээ, номлолд үйлчлэх ёстой” гэж хэлдэг (In Conference Report, 1974 оны 4-р сар, 125; *Ensign*, 1974 оны 5-р сар, 87).



16. “Бидний хүн нэг бүр амьдралынхаа аль нэгэн үед өөрсдийнхөө хувьд судруудыг нээдэг-судруудыг ганцхан удаа нээдэггүй, харин дахин дахин нээсээр байдаг” (“How Rare a Possession-the Scriptures!” *Ensign*, 1976 оны 9-р сар, 4).

17. “Би бурхантай харилцах харилцаандаа хайш яйш байгаага мэдсэн үед бурханлиг бус

чих сонсож, бурханлиг бус дуу хоолой ярьж байгаа юм шиг санагдаж, ингэхлээрээ бүр ч холддог. Хэрэв би судруудыг шимтэн судлах юм бол, холын зай хумигдаж, сүнслэг байдал эргэж ирдэг” (*Teachings of Spencer W. Kimball*, 135).

18. “Хүмүүний хувьд бид бие махбодын өвдөлт, сэтгэл санааны зовлон шаналлыг амьдралаасаа шахан зайлуулж, сэтгэл санааны байнгын амар амгалан, тайтгарлыг өөрсдөдөө баталгаатай болгож болно. Харин бид уй гашуу, зовлон зүдгүүрийн хаалганд ойрхон байх юм бол хамгийн агуу найз нараа, бас өөрсдөдөө тусалдаг хүмүүсийг алдаж болно. Зовлон зүдгүүр нь гэгээнтнүүдийг тэсвэр тэвчээр, сэтгэлийн хатад сурган, өөртөө эзэн болдог хүмүүс болгож чадна” (*Faith Precedes the Miracle*, 98).

19. “Бурхан биднийг ажиглан харж байдаг бас хянаж байдаг. Гэвч тэрээр өөр хүнээр дамжуулан бидний хэрэгцээг хангадаг. Тиймээс, хаант улсад бид бие биедээ үйлчлэх нь амин чухал юм” (“Small Acts of Service,” *Ensign*, 1974 оны арванхоёрдугаар сар, 5).

20. Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Гордон Б. Хинкли Ерөнхийлөгч Кимбаллыг тайвшруулах гэж оролдсон нэг тохиолдлын тухай өгүүлжээ. Ерөнхийлөгч Кимбалл түүнд: “Миний амьдрал гуталтай минь адилхан- үйлчилсээр байгаад элэгдэж дуус ч дээ” гэжээ (“He Is at Peace,” *Ensign*, 1985 оны арванхоёрдугаар сар, 41).

21. “Хүндэтгэлийн Өдөр бол зохистой, ариун зүйлсийг хийх ёстой ариун өдөр юм. Энэ өдөр ажил хийхгүй байж, амрах нь чухал. Гэвч энэ нь хангалтгүй. Хүндэтгэлийн Өдөр үр бүтээлтэй бодол санаа, ажил үйлсэд уриалан дууддаг. Хэрэв хүн Хүндэтгэлийн Өдөр юу ч хийлгүй амрах юм бол, ариун өдрийг зөрчиж байгаа хэрэг. Хүндэтгэлийн өдрийг сахихын тулд хүн өвдөг сөгдөн залбирч, хичээлд бэлтгэн, залбирч, сайн мэдээг судлан, бясалган бодож, өвчтэй буюу зовж зүдэрсэн хүмүүстэй очиж уулзан, унтах буюу эрүүл саруул материал уншиж, тэр өдрийнхөө очих ёстой бүх цуглаанд оролцох ёстой. Хийх ёстой эдгээр зүйлсийг хийхгүй байх нь зөрчил мөн” (*Miracle of Forgiveness*, 96–97).

22. “Эдгээр хүчирхэг эрчүүд болон эрт дээр үеийн Төлөөлөгчид, нэгэн Эзэний үйлчлэлд байсан бидний ах нарын гэрчлэл дээр би өөрийн гэрчлэлийг нэмж байна. Есүс Христ бол амьд Бурханы Хүү бөгөөд тэрээр дэлхийн нүглийн төлөө цовдлогдсоныг би мэднэ.



23. “Тэр бол найз минь, Аврагч минь, Их Эзэн минь, бас Бурхан минь юм.

24. “Гэгээнтнүүд Түүний зарлигуудыг сахидаг байхын төлөө, Түүний Сүнстэй байхын төлөө, селестиел алдар сууд түүнтэй хамт мөнхийн өвийг залгамжлахын төлөө би бүх зүрх сэтгэлээрээ залбирч байна” (In Conference Report, 1978 оны 10-р сар, 110; *Ensign*, 1978 оны 11-р сар, 73).



25. “Бурхан амьдыг би мэднэ. Есүс Христ амьдыг би мэднэ. Учир нь би түүнийг харсан” гэж миний өмнөх ерөнхийлөгч Жон Тейлор хэлдэг байсан. Ах нар та нарт би энэ гэрчлэлийг Есүс Христийн нэрээр хэллээ. Амен” (In Conference Report, 1978 оны 4-р сар, 72; *Ensign*, 1978 оны 5-р сар, 48).

Уншсанаа ойлгох нь



Спенсер В.Кимбаллын сургаал ба гэрчлэл

Шахан зайлуулах (догол мөр 18)—Хаях

Өв (догол мөр 24)—Оршин суух газар, шагнал

Уншсанаа судлах нь



“Ерөнхийлөгч Спенсер В. Кимбалл”-ыг судлахдаа үйл ажиллагаа А болон бусад үйл ажиллагаануудаас хоёрыг хий.

А Жагсаалт хий

1. Догол мөр 1–2-ыг уншиж, Ерөнхийлөгч Кимбаллын хэрэглэсэн хоёр уриаг ол.
2. Догол мөр 7–9-ийг нэгтгэн дүгнэж, эдгээр уриануудыг Ерөнхийлөгч Кимбалл болон бусад Гэгээнтнүүд хэрхэн биелүүлсний жишээг жагсаан бич.

3. Догол мөр 15, 21-ийг уншиж, эдгээр уриаг хэрэгжүүлэхийн тулд Гэгээнтнүүдэд Ерөнхийлөгч Кимбаллын заасан арга замуудыг жагсаан бич.
4. Эдгээр урианууд амьдралын чинь нэг хэсэг байхын тулд юу хийж болохоо жагсаан бич.

Б Сонины өгүүлэл бич

Өөрийгөө орон нутгийн нэг сонины сурвалжлагч гэж бод. Догол мөр 10–11, 16–17-г нэгтгэн дүгнэж, өөрийгөө Ерөнхийлөгч Кимбаллаас ярилцлага авч байна гэж бодон ХҮГ судруудын шинэ хэвлэлийн тухай өгүүлэл бич. Ярилцлагын хэсэг болгон дараах асуултуудад хариул:



1. “Судрууд яагаад танд тийм чухал байдаг вэ?”
2. “ХҮГ судруудын хэвлэл танай гишүүдийг ямар өвөрмөц онцлогуудаар хангадаг вэ?”
3. “ХҮГ судрууд ямар арга замаар Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд тусалж, тэднийг адисалж болох вэ?”

В Зураг зур

1. Догол мөр 20-ийг нэгтгэн дүгнэ. Ерөнхийлөгч Кимбалл амьдралыг юутай харьцуулсан бэ?
2. Ерөнхийлөгч Кимбалл үйлчлэлд зориулсан амьдралынхаа тухай хэлсэн үгийг нь төлөөлсөн нэг зураг зур.
3. Догол мөр 12–14-ыг нэгтгэн дүгнэж, үйлчлэлийн талаарх Ерөнхийлөгч Кимбаллын сургаалуудыг дүрсэлсэн нэг товчхон догол мөр бич.

Г Тайлбарла

1. Догол мөр 22–24-ийг нэгтгэн дүгнэж, Есүс Христ Ерөнхийлөгч Кимбаллын хувьд хэн болохыг дүрсэлсэн өгүүлбэрийг тэмдэглэлийн дэвтэртээ бич.
2. Өөрийнхөө амьдралаас жишээ гаргаж, дараах тохиолдол бүрд Есүс Христ та нарын хувьд хэн болохыг тайлбарласан судрын эшлэлийг жагсаан бич:
 - а. Найз
 - б. Аврагч
 - в. Их Эзэн
 - г. Бурхан



Албан Тунхаг 2
Зохистой эрэгтэй хүн бүр санваарыг эзэмших болно



Хожмын Үеийн Гэгээнтнүүдийг бусад шашинуудаас ялгаатай болгодог нэг зарчим бол бид орчин үеийн илчлэлтэд итгэдэг явдал мөн. Орчин үеийн илчлэлтгүйгээр: Бурхан тэргүүтний талаар бид юу мэдэж болох байсан бэ? Сүмийн Ерөнхийлөгч, эсвэл тойргийн бишоп хэн болох ёстойг бид яаж мэдэх вэ?

Мормоны Номын бошиглогч Иаковын заасанчлан, “Түүнд илчлэгдээгүй аваас ямар ч хүмүүн [Бурханы] замуудыг үл мэднэ; иймийн тул, . . . Бурханы илчлэлтүүдийг бүү басамжил” (Иаков 4:8). Албан Тунхаг 2-ыг судлахдаа, энэ чухал илчлэлт дэлхий дахины Сүмийн гишүүдэд хэрхэн агуу адислал болсныг тунгаан бод.

Судруудыг ойлгох нь



Албан Тунхаг 2

Удаан бясалгал (догол мөр 2)—Буурь суурьтайгаар удаан тунгаан бодох
Анхаарах (догол мөр 7)—Сонсож дагах

Мэдэл бүхий хуралдай (догол мөр 8)—Сүмийн ерөнхий чуулганд Гэгээнтнүүд цугларах

Албан Тунхаг 2 (догол мөр 8)—“Их Эзэний үг бас хэсэл зориг”



Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан, дэмжигдэн батлагдсан бошиглогч, үзмэрч, илчлэгчдийн хэлсэн үгс нь “Ариун Сүнсээр урагш хөдөлгөгдөх үед юуг ч ярилаа гэсэн судар байх болно, Их Эзэний таалал байх болно, Их Эзэний оюун ухаан байх болно, Их Эзэний үг байх болно” (С ба Г 68:4). Өөр нэг тохиолдолд, бошиглогчдын

сүнсээр нөлөөлөгдсөн зөвлөгөөг хүмүүс дуулгавартай дагасан үед “тамын үүд [тэднийг] дийлэх нь үгүй; тийм ээ, мөн Их Эзэн Бурхан [тэдний] өмнөөс харанхуйн хүчнүүдийг сарниулах болно” (С ба Г 21:6) хэмээн Их Эзэн Сүмийн гишүүдэд амласан билээ.

Судруудыг судлах нь



Албан Тунхаг 2-ыг судлахдаа үйл ажиллагаа А-г хий.

А Эрхлэгчид захидал бич

Санваарын тухай мэдэгдлийг хэвлэлээр хийсний дараа удалгүй, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Петр Б. Хейт Иллинойн Чикагод нисэх онгоцны буудал дээр байсан тухайгаа өгүүлж: “*Chicago Tribune* сонин сонин зардаг лангуун дээр байхыг би ажиглалаа. Сонины тэргүүн гарчиг нь, ‘Мормончууд хар арьстнуудад санваар олгох болов’ гэсэн

байв. Мөн дэд гарчиг нь, 'Ерөнхийлөгч Кимбалл илчлэлт хүлээн авсан мэтээр мэдэгдэв' гэжээ. Би энэ сониноос нэгийг худалдаж авлаа. Дэд гарчиг дахь нэг үг-мэтээр мэдэгдэв гэсэн үгийг би ширтэн харж байв. Энэ үг надад яг л улаан неон гэрэл шиг содон байлаа. Би нислэгийнхээ зохицуулалт хийхээр үүдний хонгилоор явж байхдаа, *Одоо би энд Чикагод хөл хөдөлгөөн ихтэй нисэх онгоцны буудал дотуур явж байхдаа ч уг илчлэлтийн гэрч байсаар байна. Би тэнд байсан. Би үүнийг гэрчилсэн. Тэрхүү тэнгэрлэг нөлөөг би мэдэрсэн. Би үүний нэг хэсэг байсан. . . .* гэж бодож явлаа. Уг илчлэлт үнэн гэдгийг сонины эрхлэгч мэдэж байсан нь юу л бол. . . . Тэр, эсвэл, хэвлэгч, хэвлэлийн будагчин, сонин хүргэгч гээд тэдний хэн нь ч, энэ бол үнэхээр Бурханаас ирсэн илчлэлт гэдгийг мэдэж байсан нь юу л бол. Үүний гэрч нь би байсныг мөн үүнийг би мэдэж байсныг тэд яаж мэдэх вэ дээ" (In Conference Report, 1996 оны 4-р сар, 31; *Ensign*, 1996 оны 5-р сар, 23).

1978 оны зургадугаар сард өөрийгөө Иллинойн Чикагод амьдарч байсан, мөн Ахлагч Хейтийн дурдсан сонины тэргүүн гарчгийг уншсан гэж бод. "Ерөнхийлөгч Спенсер В. Кимбаллын амьдрал" (х.[00] 208–209) дахь догол мөр 3–6, мөн Албан Тунхаг 2-ын догол мөр 3–8-ыг нэгтгэн дүгнэ. Тэгээд *Chicago Tribune* сонины эрхлэгчид захидал бичиж, уг илчлэлт яагаад зүгээр нэг "мэдэгдэл"-ээс илүү чухал зүйл гэдэгт итгэдэг тухай нотолгоо, учир шалтгаанаа тайлбарла.

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон Мормоны Номоор газар дэлхийг дүүргэсэн нь

Шери Л. Дью Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны намтрыг бичихээсээ өмнө түүний амьдралыг судалжээ. Тэрээр уг төслийг дуусгасны дараа: "Бошиглогчийн амьдралыг анхааралтай судлах, бүр анхааралтайгаар нягтлан судлах нь даруусагч туршилага юм. Намтар судлагч нь өдий төдий олон зүйл- сайн болон муу; хүнд сорилт болон алжилт; баяр баясал болон сэтгэл санааны эмзэглэлийг хардаг. Дүн шинжилгээ хийх нарийн мэдрэмжийг тухайн хүний амьдралын төлөв байдалд тавьж, түүний амжилт ололт, хүсэл мөрөөдөл, эрмэлзэл тэмүүлэл гэхчилэнгийн тухай дүгнэлт хийх хэрэгтэй болдог. Энэ үүднээс би Ерөнхийлөгч Бенсоныг бурханлиг дуудлагатай хүн гэж үзэн хүндэтгэдэг. Гэвч би илүү их судалгаа хийж, уншиж, тунгаан бодохын хэрээр Эзра Тафт Бенсон үнэхээр хэчнээн гайхалтай хүн болохыг илүү ихээр ухаарч мэдсэн юм" гэжээ. "Эзра Тафт Бенсон бол өмнөх ерөнхийлөгчдийнхөө нэгэн адил үнэхээр Бурханы бошиглогч мөн" гэдэг нь уг төслөөс өөрийнх нь сурсан олон зүйлийн нэг юм гэж Дью эгч бас гэрчилжээ (Ezra Taft Benson: A Biography [1987], xi).

ТҮҮНИЙ АМЬДРАЛ (1899–1994)

1899 он	Наймдугаар сарын 4-нд Айдахогийн Витнейд Жорж Т.Бенсон, Сара Данкли Бенсон нарын гэр бүлд төрсөн	
1907 он	8 настайдаа, төрсөн өдрөөрөө, Айдахогийн Витней дэх Логан голын сувагт баптисм хүртжээ	
1921–23 он	21–24 настайдаа, Их Британид номлолд үйлчлэв	
1926 он	27 настайдаа, есдүгээр сарын 10-нд Флора Смит Амюссентай гэрлэв; тэр 1992 онд нас баржээ	
1943 он	44 нас, Ерөнхийлөгч Хебер Ж.Грант түүнийг Төлөөлөгчөөр томилов	
1946 он	46 настайдаа, Европын Номлолын ерөнхийлөгчөөр үйлчилж эхлэв. Дэлхийн II Дайны дараа, дайнд нэрвэгдсэн Европ дахь Сүмийн гишүүдийн хэрэгцээнд тэрээр тусалж байв.	
1952–1960 он	53–61 настайдаа, Нэгдсэн Улсын Хөдөө Аж Ахуйн Нарийн бичгийн дарга байв	
1964–1965 он	64–66 настайдаа, Европын Номлолын ерөнхийлөгч байв	
1973 он	74 настайдаа, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав	
1985 он	86 настайдаа, Ерөнхийлөгч Спенсер В. Кимбаллыг нас барсны дараа Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав	
1994	94 настайдаа, тавдугаар сарын 30-нд Солт Лейк хотод нас эцэслэв	

ТҮҮНИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ (1985–1994)

1985–1993 он	Дэлхий даяар есөн ариун сүм онцгойлон адислагдав
1990–1992 он	Чехословак, Унгар, Польш, Болгар, Орос, Украин, Германы Зүүн Берлинд (эдгээр бүх бүсэд өмнөх засгийн газрууд нь номлолын ажлыг зөвшөөрдөггүй байв) номлолууд байгуулагдав; Армения, Уганда, Кени, Зимбабве, Украин, Замбия, Ботсвана, Намибия, Конго орнуудыг сайн мэдээг номлолын төлөө онцгойлон адисалжээ
1992 он	Сүмийн 1,900 дахь гадас зохион байгуулагдав
1994 он	Сүмийн гишүүнчлэл 9,024,368-д хүрэв

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны амьдрал

1. "Спенсер В.Кимбаллыг таалал төгссөний дараа Эзра Тафт Бенсон Сүмийн Ерөнхийлөгч болов. Түүний удирдлагын эхэн үед Мормоны Номыг уншиж, судлахын чухлыг

тэрээр онцгойлон анхаарч байв. ‘Мормоны Ном хүмүүсийг Христэд авчирдгийг,’ мөн энэ ном ‘манай шашны тулгуурын чулуу,’ мөн бусад ямар ч номноос илүүгээр үүний зааврыг мөрдсөнөөр хүмүүн Бурханд илүү ойртох болой’ гэсэн Иосеф Смитийн үзэл баримтлалыг давхар баталдгийг тэрээр гэрчилжээ [A Witness and a Warning (1988), 3, 21; мөн History of the Church, 4:461-ийг үз].

2. “1986 оны дөрөвдүгээр сарын ерөнхий чуулган дээр, Ерөнхийлөгч Бенсон: ‘Сүмийг санхүүгийн боолчлолоос гэтэлгэхийн тулд аравны нэгийн зарчимд дахин онцгой анхаарал хандуулахад Их Эзэн Өөрийн үйлчлэгч Лорензо Снөүд бурханлигаар нөлөөлсөн юм. . . . Эдүгээ, манай өнөө үед, Мормоны Номонд дахин онцгой анхаарал хандуулах хэрэгтэйг Их Эзэн илчлээд байна. . . . Хэрэв бид энэ номын хуудсуудаас өдөр бүр шимтэн уншиж, зааврыг нь мөрдөх юм бол, Сионы болон Сүмийн хүүхэд бүр дээр өдийг хүртэл мэдэгдээгүй адислалыг Бурхан юүлэх болно гэдгийг би энэ хормоос эхлэн та нарт амлаж байна’ хэмээн мэдэгджээ [In Conference Report, 1986 оны 4-р сар, 100; Ensign, 1986 оны 5-р сар, 78]. Дэлхий дахины сая сая хүмүүс сорилтыг, мөн амлагдсан адислалуудыг хүлээн авсан юм.



3. “Өөр нэг гол сэдэв бол бардамналаас зайлсхийхийн ач холбогдол юм. Тэрбээр 1989 оны ерөнхий ерөнхий чуулган дээр, ‘бардамналыг ялан дийлэх замаар дотор саваа цэвэршүүлэхийг’ Сүмийн гишүүдэд уриалсан нь нифайчуудын үндэстэн устгагдсан учир шалтгаанаас сэрэмжлүүлсэн хэрэг байлаа. ‘Бардамналаас хамгаалах ерөндөг нь (хэрэгсэл) даруу зан, номхон дөлгөөн байдал, туйлын дуулгавартай байдал мөн’ гэж хэлсэн юм [In Conference Report, 1989 оны 4-р сар, 6-7; Ensign, 1989 оны 5-р сар, 6-7].



лэгээр Нэгдсэн Улсын ерөнхийлөгч Двайт Эйзенхауэрын удирдлага дор Хөдөө Аж Ахуйн Нарийн бичгийн даргаар томилогдсон байна. Энэ бол Сүмийн түүхэнд Арванхоёрын Чуулгын гишүүн Нэгдсэн Улсын ерөнхийлөгчийн кабинетэд алба хашсан цорын ганц тохиолдол байв. Энэхүү албыг хашсан найман жилийн хугацаанд тэрээр ёс суртахууны эрхэм чанараараа, Нэгдсэн Улсын засгийн газрын хөдөө аж ахуйн бодлогыг удирдан хэрэгжүүлэхэд харуулсан мэргэжлийн мэдлэгээрээ эх орондоо болон хилийн чанадад

4. “Эзра Тафт Бенсон Арванхоёрын Чуулгын гишүүнээр үйлчилж байхдаа, сайн мэдээгээр амьдрахын жинхэнэ үлгэр дуурайлыг үзүүлдэг байжээ. 1952 онд тэрээр Ерөнхийлөгч Давид О.МкКейн дэмж-

өндөр хүндэтгэл хүлээсэн юм. Тэрээр улс орнуудын удирдагчидтай хэлхээ холбоо тогтоож, Сүмийн төлөөлөгчдөд дэлхий дахинд үүд хаалгыг нээж өгсөн билээ.

5. “Ерөнхийлөгч Бенсоны удирдлагаар Сүм дэлхий дахинд чухал амжилт олсон юм. Тэрээр 1987 оны наймдугаар сарын 28-нд, Холбооны Бүгд Найрамдах Герман улсад Франкфуртын Ариун сүмийг онцгойлон адисалсан нь түүний хувьд чухал учир холбогдолтой онцгой боломж байв. Учир нь 1964–1965 онуудад түүнийг Европын номлолын ерөнхийлөгчөөр үйлчилж байхад төв байр нь Франкфуртэд байрлаж байжээ.

6. “Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улс дахь Фрейбергийн Ариун сүм 1985 оны зургадугаар сарын 29-нд онцгойлон адислагдав. Энэхүү онцгойлон адислалтын дараа уг ариун сүмийг баригдах боломжтой болгосон нэлээд хэдэн гайхамшиг тохиосон ажээ. Арванхоёрын Чуулгын Ахлагч Томас С.Монсон 1968 онд Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсад анх удаа айлчлахдаа: ‘Хэрэв та нар Бурханы зарлигуудад үнэнч итгэлтэй хэвээр байх юм бол, аль ч бусад оронд Сүмийн аль ч гишүүнийг эдэлдэг адислал бүхэн та нарынх байх болно’ хэмээн Гэгээнтнүүдэд амлажээ. 1975 онд Ахлагч Монсон энэ оронд томилолтоор ирсэн үедээ, ‘Аав аа, энэ орон дахь Таны сүмийн гишүүдийн хувьд энэ амлалт шинэ үеийн эхлэл байх болтугай’ гэж хэлэн, энэ орныг Их Эзэнд Сүнсээр онцгойлон адислах сэтгэгдэл төржээ. ‘Ариун сүмийн адислалуудыг хүртэх’ Гэгээнтнүүдийн зүрх сэтгэлийн чин эрмэлзэл биелэгдэхийг тэрээр гуйжээ. Бурханлигаар нөлөөлөгдсөн түүний амлалт, онцгойлон адисалсан бошиглолын залбирал нь биелэгдсэн билээ [In Conference Report, 1989 оны 4-р сар, 66; Ensign, 1989 оны 5-р сар, 51; мөн In Conference Report, 1985 оны 10-р сар, 44; Ensign, 1985 оны 11-р сар, 34-ийг үз].

7. “1989 оны гуравдугаар сарын сүүлчийн өдөр, Хожмын Үеийн Гэгээнтэн номлогчдыг Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улсад орохыг зөвшөөрсөн юм. 1989 оны арваннэгдүгээр сарын 9-нд зүүн, баруун Европын хоорондох саад тотгор арилж эхлэхэд, олон Гэгээнтний итгэл, залбирал хариулагдсанаар, хөрвөгчдийн баптисм нээгдэж, сүмийн барилгууд баригдахад хүргэсэн юм. Нэгэн хөрвөгч 1990 оны тавдугаар сарын 1-нд Германы Дрезденд шинээр баригдаж дууссан ариун ёслолын байрны нээлтийн ёслолд очоод Сүмийн тухай анх мэдсэн ажээ. Долоо хоног хүрэхгүй хугацааны дараа, тэрээр номлогчийн хичээлүүдийг хүлээн аваад баптисм хүртжээ. Мормоны Номыг хоёр удаа эхнээс нь дуустал уншиж, сайн мэдээ үнэн болох талаар хүчирхэг гэрчлэлтэй болжээ. [Гарольд Давис, Норма Давис, “The Wall Comes Down,” Ensign, 1991 оны 6-р сар, 33-ыг үз.]

8. “1991 оны зургадугаар сарын 24-нд Москвад Мормоны Табернеклын Найрал дууны концертын дараа болсон хүлээн авалт дээр Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Оросын Холбооны Улсын дэд ерөнхийлөгч улс оронд нь Сүм албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөнийг мэдэгдэв. Энэ нь эл том бүгд найрамдах улс даяар цуглаануудыг зохион байгуулах боломжийг Сүмд олгосон юм. 1990-ээд оны үед хуучин Зөвлөлтийн нэлээд хэдэн бүгд найрамдах улс, төв болон зүүн Европын орнууд, түүний дотор Албани, Армен, Беларусь, Болгар, Латви, Литва, Орос, Румын, Украйны, Унгар, Эстони сайн мэдээний номлолын төлөө онцгойлон адислагдсан байлаа. Эдгээр орон бүрд Сүмийн барилга байгууламжуудыг түрээслэх буюу барьж, олон хүмүүс сайн мэдээний үнэний тухай гэрчлэлтэй болж байлаа. Дэлхийн II Дайны өмнөх үеэс хойш Польшид Хожмын Үеийн

Гэгээнтний анхны цуглааны байрыг онцгойлон адислахад Арванхоёрын Чуулгын Ахлагч Рассел М. Нелсон уг цуглааны байр нь 'зовлон зүдгүүр тохиолдсон хүмүүст амар амгалангийн хоргодох газар, зөв шударга ёсны төлөө өлсөж, цангадаг хүмүүст амрах газар нь болж үйлчлэхийн төлөө' залбирсан ажээ [Church News, 1991 оны 6-р сарын 9, 12]. Сайн мэдээний амар амгалан, баяр баяслыг олсон олон оронд энэхүү адислал Гэгээнтнүүдийн амьдралд хэрэгжиж байна.



Ерөнхийлөгч Бенсоны удирдлагын үед, сайн мэдээний номлолын төлөө Сүмийн удирдагчид нэлээд олон орныг онцгойлон адисалжээ.

9. "Сүмийн гишүүнчлэлийн агуу өсөлт, номлолын ажилд Ерөнхийлөгч Бенсон онцгой анхаарсны үр дүнд, түүний удирдлагын төгсгөлд бараг 48 000 номлогч Сүмийн 295 номлолд үйлчилж байв.
10. "Бас түүний удирдлагын үед Сүмийн халамжийн хөтөлбөр өөр сүсэг бишрэлтэй хүмүүст хүмүүнлэгийн тусламж болгон, үлэмж хэмжээний өргөлийг дэлхий даяар эхэлсэн юм. Зовлон зүргүүрийг нимгэлэх, удаан хугацааны туршид бие даан амьдрах чадварыг урамшуулан дэмжихэд зориулан уг тусламжийг олгодог. Их хэмжээний хүнс, хувцас хунар, эмнэлгийн хэрэгсэл, хөнжил, бэлэн мөнгө болон бусад зүйлийг гачигдалтай хүмүүст хуваарилан тарааж, урт хугацааны төслүүдээр эрүүл мэндийн үйлчилгээ, бичиг үсэгт сургах болон бусад үйлчлэлийг үзүүлж байна. Нинжин сэтгэлийн энэхүү үйлчлэл өнөөдөр дэлхийн олон хэсэгт, мянга мянган хүнд хүрч байна.
11. "Насны доройтол болон хайрт гэргий Флорагаа алдснаар зовлон шаналалд унасан Ерөнхийлөгч Бенсон 1994 оны тавдугаар сарын 30-нд 94 настайдаа, Их Эзэний бошиглогчийн үүрэг зорилгоо эрэлхэг баатарлагаар дуусгаад, таалал төгсчээ. Тэр үед Арванхоёрын Чуулгын Ерөнхийлөгчөөр үйлчилж асан Ховард В.Хантер түүнийг залгамжлав" (Бидний Өв, 155–159).

Уншсанаа ойлгох нь



Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсоны амьдрал

Үзэл баримтлал (догол мөр 1)—Сургаал, зарлиг

Санхүүгийн боолчлол (догол мөр 2)—Өр

Дотор сав (догол мөр 3)—Хүмүүсийн амьдрал, бодол санаа, төлөвлөгөө, хүсэл эрмэлзэл

Ерөндөг (догол мөр 3)—Эмчилгээ, эдгээлт

Саад тотгор (догол мөр 7)—Бэрхшээл, хориг хязгаарлалт

Амрах газар (догол мөр 8)—Аюулгүй байх газар

Эзра Тафт Бенсоны сургаал ба гэрчлэл



12. "Хэрэв бид Мормоны Номыг уншихгүй, доторх захиасуудад нь анхаарал тавихгүй бол, Сүм бүхлээрээ буруушаалт дор байх болно гэдгийг Их Эзэн Сургаал ба Гэрээ 84-р хэсэгт: 'Мөн энэхүү буруушаалт Сионы хүүхдүүд, бүр бүгд дээр байх болно' (С ба Г 84:56) хэмээн мэдэгдсэн билээ. 'Мөн тэд наманчилж,

тэрхүү шинэ гэрээ, бүр Мормоны Номыг мөн тэдэнд миний өгсөн урьдын зарлигуудыг зөвхөн хэлэхээр төдийгүй, харин миний бичсэний дагуу үйлдэхээр дурсан санах хүртэл тэд энэхүү буруушаалт дор үлдэх болно' (С ба Г 84:57) гэж Их Эзэн цааш нь хэлжээ.

13. "Эдүгээ бид Мормоны Номын тухай зөвхөн илүү ихийг хэлэх төдийгүй, харин энэ талаар илүү ихийг хийх хэрэгтэй байна. Яагаад? Их Эзэн хариулсан нь: 'Тэд Эцэгийгээ хаант улсад тохирох үр жимсийг авчирч болохын тулд буюу; эс бөгөөс Сионы хүүхдүүд дээр цутгагдах цээрлүүлэлт хийгээд шүүлт хэвээр үлдэх болно' (С ба Г 84:58). Энэхүү цээрлүүлэлт, шүүлтийг бид мэдэрч байна шүү дээ!" (In Conference Report, 1986 оны 4-р сар, 4; Ensign, 1986 оны 5-р сар, 5).

14. "Мормоны Ном бидэнд зөвхөн үнэнийг заадаг төдийгүй, энэ нь чухамдаа өөрөө үнэн юм. Мормоны Ном зөвхөн Христийн тухай гэрчилдэг төдийгүй, энэ ном бас өөрөө үнэн юм. Бас өөр нэг юм байдаг. Энэ номыг та нар нухацтайгаар судалсан үед амьдралд тань ирэх нэг хүч уг номд байдаг. Уруу таталтыг эсэргүүцэх илүү их хүчийг та нар олох болно. Залилан мэхлэхээс зайлсхийх хүчийг та нар олох болно. Нарийн бөгөөд шулуун зам дээр байх хүчийг та нар олох болно. Судрууд 'амьдралын үгс' хэмээн нэрлэгддэг (С ба Г 84:85-ыг үз). Мормоны Номноос илүү үнэн ном гэж хаа ч үгүй. Та нар эдгээр үгсийн төлөө өлсөж, цангасан үед амьдрал тань улам илүү, бүр илүү элбэг дэлбэг болно. . . .

15. "Ах эгч нар аа, Мормоны Номын ач холбогдлыг агуу хүндэтгэлтэйгээр, хувиараа болон Сүм дээр, хамт олноороо авч үзэхийг би та нараас чин сэтгэлээсээ хүсч байна" (In Conference Report, 1986 оны 10-р сар, 6; Ensign, 1986 оны 11-р сар, 7).

16. "Мормоны Ном бол бидний хийдэг юм болгонд Өөрөө суурийн чулуу нь байдаг Есүс Христийн тухай бидний гэрчлэлийн суурийн чулуу юм. Эл ном Түүний үнэн бодитойн тухай хүч хийгээд яруу тодоор гэрчилдэг. Хуулбарлагч, орчуулагчид, бичигдсэн үгст дураараа гар хүрсэн, завхарсан

шашныхны үе үеийнхнээр дамжин ирсэн Библиетэй адилгүй нь, Мормоны Ном сүнсээр нөлөөлөгдөн, ердөө ганцхан алхам зайтайгаар бичигчээс нь уншигчид ирсэн юм. Тиймээс, Эзэний тухай энэ номын гэрчлэл тов тодорхой, сарнин замхраагүй хүчээр дүүрэн байдаг. Бас үүнээс ч илүү чухал нэг зүйл бий. Өнөөдөр Христийн ертөнцийн ихээхэн хэсэг нь Аврагчийн бурханлиг чанарыг үгүйсгэж байна. Тэд Түүний гайхалтай төрөлтийн талаар, Түүний төгс төгөлдөр амьдралын талаар бас Түүний алдар суут амилалтын талаар эргэлзэж байна. Гэтэл эдгээр бүх үнэний тухай Мормоны Ном энгийн тодорхой, андуурах аргагүйгээр заадаг. Эл ном бас Цагаатгалын сургаалын талаар хамгийн бүрэн гүйцэд тайлбарласан юм. Бурханлигаар нөлөөлөгдсөн эл ном, Есүс бол үнэхээр Христ гэдгийг дэлхийд гэрчлэх суурийн чулуу юм (Мормоны Номын эхний хуудсыг үз) (In Conference Report, 1986 оны 10-р сар 4; *Ensign*, 1986 оны 11-р сар, 5).

17. “Манай гадаснууд дахь үйл ажиллагааны төвшинг дээшлүүлэх гэж бид олонтаа хичээн үлэмж хүч чармайлт гаргадаг. Бид ариун ёслолын цуглаанд оролцогчдын хувь хэмжээг дээшлүүлэхийн төлөө хичээнгүйлэн ажилладаг. Бид номлолд байгаа залуу эрэгтэйчүүдийн хувь хэмжээг илүү өндөр болгохын төлөө хөдөлмөрлөдөг. Бид ариун сүмд гэрлэж байгаа хүмүүсийн тоог нэмэгдүүлэхийг хичээдэг. Энэ бүхэн бол магтан сайшаавал зохих хүч чармайлт бөгөөд хаант улсын өсөлт хөгжилтөд чухал юм. Харин хувь гишүүд болон гэр бүлүүд судруудыг тогтмол, зохих ёсоор шимтэн судлах юм бол үйл ажиллагааны бусад төрөл аяндаа бий болно. Гэрчлэл өсөн нэмэгдэнэ. Шийдвэр төгс байдал хүчирхэгжих болно. Гэр бүлүүд бэхжинэ. Хувиараа илчлэлт хүлээн авах нь ихсэнэ” (“The Power of the Word,” *Ensign*, 1986 оны 11-р сар, 81).


18. “Та нар бурууг хийчихээд зөвөөр мэдэрч чадахгүй. Энэ бол боломжгүй зүйл!” (“To the Rising Generation,” *New Era*, 1986 оны 6-р сар, 5; *Залуучуудын Бат Бөх Байдлын Төлөө*, 4).



19. “Ээж гэдэг үгнээс илүү ариун нандин үг шашны бус хэллэгт ч, ариун сударт ч байдаггүй. Бурханаас эмээдэг сайн эх хүний ажлаас илүү эрхэм чухал ажил гэж үгүй билээ. . . .

20. “Мөнхийн гэр бүлд эцгүүд гэр орондоо тэргүүлэх ёстойг Бурхан үндэслэжээ. Эцгүүд гэр бүл, үр хүүхдээ тэжээн тэтгэж, хайрлан, зааж, удирдан тэргүүлэх ёстой.

21. “Гэвч эхийн үүргийг бас Бурхан томилсон юм. Эхчүүд хүүхэд тээж, өсгөн тэжээж, хайрлан, хүмүүжүүлэх ёстой. Илчлэлтүүд үүнийг тунхагласан билээ” (*To the Mothers in Zion* [говхимол, 1987], 1–3).



22. “Бардамнал бол ихэд нийтлэг нүгэл, том гэм согог мөн. . . .

23. “Бардамналыг эдгээх хэрэгсэл нь номхон дөлгөөн, хүлцэнгүй байдал юм (Алма 7:23-ыг үз). . . .

24. “Бурхан даруу хүмүүстэй хамт байх болно. Нэг бол бид даруу байж болно эсвэл даруу байхаар албадуулж

болно. ‘Даруу байхыг албадуулалгүйгээр өөрсдийгөө даруу болгодог тэд адислагдсан болой’ (Алма 32:16) хэмээн Алма хэлжээ.

25. “Даруу байцгаая.

26. “Бид ах эгч нартаа дайсагнах үзлийг даван туулж, тэднийг өөрсдийнхөө адил хүндэтгэн, бүр өөрсдөөсөө илүү өндөрт өргөх хэрэгтэй. Ингэвэл бид өөрсдийгөө даруусгаж байгаа хэрэг (С ба Г 38:24; 81:5; 84:106-г үз).

27. “Зөвлөгөө, шүүмжлэлийг хүлээн авснаар бид өөрсдийгөө даруусгаж чадна (Иаков 4:10; Хиламан 15:3; С ба Г 63:55; 101:4–5; 108:1; 124:61, 84; 136:31; Сургаалт Үгс 9:8-ыг үз).

28. “Бид өөрсдийгөө гомдоосон хүмүүсийг уучилснаар өөрсдийгөө даруусгаж чадна (3 Нифай 13:11, 14; С ба Г 64:10-ыг үз).

29. “Амь бие хайргүй үйлчлэл үзүүлснээр бид өөрсдийгөө даруусгаж чадна (Мозая 2:16–17-г үз).

30. “Номлолд явж, бусдыг даруусгаж чадах үгийг номлосноор бид өөрсдийгөө даруусгаж чадна (Алма 4:19; 31:5; 48:20-ийг үз).

31. “Ариун сүмд илүү олон удаа явснаар бид өөрсдийгөө даруусгаж чадна.

32. “Нүглээ хүлээж, орхисноор мөн Бурханаас төрснөөр бид өөрсдийгөө даруусгаж чадна (С ба Г 58:43; Мозая 27:25–26; Алма 5:7–14, 49-ийг үз).

33. “Бурханыг хайрласнаар, өөрсдийнхөө хүслийг Түүнд захируулж, амьдралдаа Түүнийг нэгдүгээрт тавьснаар бид өөрсдийгөө даруусгаж чадна (3 Нифай 11:11; 13:33; Моронай 10:32-ыг үз).

34. “Даруу байхаар сонгоцгооё. Бид даруу байж чадна. Бид ийм байж чадна гэдгийг би мэднэ” (In Conference Report, 1989 оны 4-р сар, 6; *Ensign*, 1989 оны 5-р сар, 6–7).

35. “Энэ ажилд бид хаана ч үйлчиллээ гэсэн Сүнс заавал хэрэгтэй. Би Сүнсэнд найдах ёстойгоо мэднэ. Энэ Сүнсийг олж аван, Сүмийн итгэлтэй гишүүд байцгаая” (In Conference Report, 1986, 98; *Ensign*, 1986 оны 5-р сар, 77).

36. “Энэ ажилд Сүнснээс илүү чухал ямар ч зүйл байхгүй” (In Conference Report, 1986 оны 10-р сар, 60; *Ensign*, 1986 оны 11-р сар, 46).

37. “Энэ үеэс олон биш жилийн дараа дэлхий цэвэршинэ гэдгийг би гэрчилж байна. (С ба Г 76:41-ийг үз). Христ болох Есүс дайснаудаа дарж, газар дээр захиран хаанчлахын тулд, энэ удаад хүч, агуу сүр жавхлантайгаар дахин ирнэ (С ба Г 43:26–33-ыг үз). Зохих цаг үед бүх хүмүүс амилуулалтыг хүлээн авах бөгөөд эцсийн шүүлтэнд Эзэнтэй нүүр тулан уулзана (2 Нифай 9:15, 41-ийг үз). Махан биетэй байхдаа хийсэн үйлийнх нь дагуу хүн бүрд Бурхан шагналуудыг нь өгнө (Алма 5:15-ыг үз)” (In Conference Report, 1988 оны 10-р сар, 104; *Ensign*, 1988 оны 11-р сар, 87).



Уншсанаа ойлгох нь



Эзра Тафт Бенсоны сургаал ба гэрчлэл

Буруушаалт (догол мөр 12)—Зэмлэл, үл сайшаах

Дайсагнах (догол мөр 26)—
Үзэн ядах

Тэргүүлэх (догол мөр 20)—
Удирдах

Уншсанаа судлах нь



“Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон”-ыг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий

А Наамал хий

Ерөнхийлөгч Бенсоны амьдралын үед тохиосон үйл явдлуудыг төлөөлнө гэж өөрийнхөө бодсон зургуудыг догол мөр 1–10-ыг уншсанаасаа зурах буюу сэтгүүл, сонинны зургуудыг ол. Зураг бүрд гарчиг өгч, эдгээрийг нэг наамал болгон тэмдэглэлийн дэвтэртээ наах буюу үзүүлэнгийн самбар дээр тусдаа хэсгүүд болгон байрлуул.



Б Тохируулах дасгал

1. Дараах судрын эшлэлүүдийг тэмдэглэлийн дэвтэртээ нэг багананд бич:

- Алма 31:5
- Алма 41:10
- Сургаал ба Гэрээ 42:13–14
- Сургаал ба Гэрээ 84:54–57
- 3 Нифай 27:5–8
- Исаиа 64:1–3
- Алма 5:22–23
- Алма 56:47–48

- Эшлэл бүрийн хажууд догол мөрийн дугааруудыг, догол мөр 12–37-гоос хамгийн сайн тохирно гэж өөрийнхөө бодсон судар бүрийг бич. Нэгээс дээш догол мөр байж болно.
- Өөрт чинь гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн Ерөнхийлөгч Бенсоны сургаалуудаас нэгийг сонгож, энэ нь өөрт чинь ямар учир холбогдолтойг тайлбарла.

Ерөнхийлөгч Ховард В.Хантер Христийнх шиг хайрыг эзэмшсэн хүн



Ерөнхийлөгч Ховард В.Хантер: “Энэхүү нэг л зүйлийг санаж явагтун. Хэрэв бидний амьдрал, итгэл Есүс Христ болон Түүний сэргээгдсэн сайн мэдээн дээр төвлөрөх юм бол, ямар ч зүйл буруу байна гэж огт байхгүй” гэж сургажээ (“Fear Not, Little Flock,” Бригам Янгийн Их Сургууль 1988–1989 оны хичээлийн жилийн Онцгой Цугларалт болон Галын дэргэдэх ярилцлага дээр хэлсэн үг [1989], 112). Ерөнхийлөгч Хантер эл чухал зарчмыг заадаг байсан төдийгүй, бас энэ зарчмаар амьдардаг байсан юм. Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Жеймс И.Фауст: “Сүмийн Ерөнхийлөгч байсан богинохон хугацаанд тохиосон хамгийн гайхалтай үйл явдал бол бүх дэлхий даяарх Сүмийн гишүүд өөрсдийн бошиглогч, үзмэрч, илчлэгчийн хувьд түүнтэй өвөрмөц замаар хэлхээ холбоотой байсан явдал мөн. Тэд Аврагчийн өөрийнх нь харьцаа хандлагын биеллийг түүнээс олж хардаг байв. Бидний амьдралыг Христийнхтэй илүү адилхан болгох, манай ариун сүмүүдийг бидний шүтлэг бишрэлийн төв болгох тухай бошиглогчийнх нь захиасуудад тэд гайхалтай замаар хариулдаг байв” хэмээн хэлжээ (“Ховард В. Хантер: Man of God,” Ensign, 1995 оны 4-р сар, 26).

Христийнхтэй адил түүний зан чанарын нэг жишээг Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн Ахлагч Нийл А.Маквелл харуулсан байдаг. Ерөнхийлөгч Хантер бол “номхон дөлгөөн хүн юм. Нэг удаа тэр залуу байхдаа өөрт нь хэрэгтэй ажлаас татгалзсан гэнэ. Учир нь энэ ажил өөр нэг хүнийг ажлаа алдахад хүргэх байж. Тэр хүн мөн л даруу дөлгөөхөн нэгэн байжээ. Түүнтэй хамт байсан Египет дэх томилолтын зүдэргээтэй, тоосонд даруулсан нэг өдрийн дараа тэрээр харагдалгүйгээр хийхээр хичээн, гутлыг минь чимээгүйхэн гялалзтал нь өнгөлсөн байж билээ” гэж тэрээр ярьжээ (“Meek and Lowly,” Бригам Янгийн Их Сургууль, 1986–1987 оны Онцгой цугларалт болон галын дэргэдэх ярилцлага дээр хэлсэн үг [1987], 61).

ТҮҮНИЙ АМЬДРАЛ (1907–1995)

- 1907 он** Арваннэгдүгээр сарын 14-нд Айдахогийн Бойзид, Жон Виллям Хантер, Нелли Мари Расмюсен Хантер нарын гэр бүлд төрсөн
- 1919 он** 12 настайдаа, дөрөвдүгээр сарын 4-нд баптисм хүртэв (аавынхаа зөвшөөрлийг хүлээж байжээ); зургадугаар сарын 21-нд бишоп нь түүнийг диконоор томилжээ
- 1931 он** 23 настайдаа, зургадугаар сарын 10-нд (Клайре) Мей Жеффстэй гэрлэв
- 1950 он** 42 настайдаа, Калифорнид өглөө эртийн семинарыг нэвтрүүлэх хорооны дарга байв
- 1959 он** 51 нас, Ерөнхийлөгч Давид О. МакКей түүнийг Төлөөлөгчөөр томилов
- 1964–1972 он** 56–64 настайдаа, Сүмийн Угийн Бичгийн Нийгэмлэгийн ерөнхийлөгч байв
- 1970–1972 он** 62–64 настайдаа, Сүмийн түүхч байв
- 1975–1993 он** 67–85 настайдаа, Израилд олон удаа очжээ; БЯИС-ийн Иерусалимийн Төвийг онцгойлон адисалжээ
- 1983 он** 75 нас, анхны эхнэр нь нас барав
- 1988 он** 80 настайдаа, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав
- 1989 он** 81 настайдаа, дөрөвдүгээр сарын 10-нд Инис Бернис Эгантай гэрлэв
- 1994 он** 86 настайдаа, Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав
- 1995 он** 87 настайдаа, Солт Лейк хотод гуравдугаар сарын 3-нд нас барав; Сүмийн Ерөнхийлөгчөөр есөн сар үйлчилжээ



ТҮҮНИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ (1994–1995)

- 1994 он** Флоридын Орландогийн Ариун сүмийг онцгойлон адисалж, Сүмийн 2,000 дахь гадсыг зохион байгуулав
- 1995 он** Ютагийн Баунтифулын Ариун сүмийг онцгойлон адислав; Сүмийн гишүүнчлэл 9,338,859-д хүрэв

Ерөнхийлөгч Ховард В. Хантерын амьдрал

1. “1994 оны зургадугаар сарын 6-нд анхныхаа хэвлэлийн бага хурал дээр Ерөнхийлөгч Ховард В. Хантер удирдлагынхаа чухал сэдвүүдээс заримыг нь үндэслэжээ. ‘Их Эзэн Есүс Христийн амьдрал, үлгэр жишээнд, ялангуяа Түүний харуулсан хайр, найдвар, нинжин сэтгэлд хэзээ хэзээнийхээс илүү анхаарал тавьж амьдрахад Сүмийн бүх гишүүдийг би урьж байна’ гэж тэрээр хэлжээ.

2. “Бид бие биедээ илүү нинжин сэтгэлээр, улам эелдэг уриалгахан, улам даруу төлөв, тэвчээртэй, уучлалаар хандаж байхын төлөө би залбирна.’



3. “Их Эзэний ариун сүмийг гишүүнчлэлийнхээ болон хамгийн ариун нандин гэрээнүүдийнхээ тэнгэрлэг шинж чанарын агуу бэлгэдэл болгож, байгуулахыг тэрээр Сүмийн гишүүдээс хүсчээ. Сүмийн гишүүн бүр ариун сүмд орохуйц зохистой байх нь зүрх сэтгэлийн минь хамгийн гүнзгий хүсэл байх болно’

[Church News, 1994 оны зургадугаар сарын 14, 14]. Сүмийн олон мянган гишүүн эдгээр захиасуудыг амьдралдаа хэрэгжүүлж, илүү гүнзгий сүнслэг байдлаар адислагдсан билээ.

4. “Ерөнхийлөгч Хантер ажигч гярхай, оюун ухаан нь тэлэн хөгжсөн хүн байсан нь Сүмд ихэд үнэ цэнэтэй байлаа. 1970-аад оны сүүлчээр, бүх ур чадварыг нь шаардсан томилолтыг тэрээр хүлээн авсан юм. Ариун Нутаг дахь Сүмийн гол барилга—Бригам Янгийн Их Сургуулийн Ойрхи Дорнодын Судлалын Иерусалим дахь Төвийн барилгын газар олж авах хэлэлцээр хийх, барилгад хяналт тавихад тэр чухал үүрэг гүйцэтгэсэн ажээ. Энэ төв Чидуны Уулын нэг салбар Скор Уулан дээр байрладаг. Сонгогдсон энэ нутаг, эл нутгийн хүмүүс (иудейчууд, арабчууд гэхчилэн), тэрчлэн Есүс болон түүний эртний бошиглогчдын амьдарч байсан газруудын талаар гүнзгий судалгаа хийдэг оюутнуудын хувьд энэ төв оршин суух, судалгаа хийх газар нь юм. Эл төв суралцдаг хүмүүсийнхээ хувьд адислал болсоор ирсэн бөгөөд хараа булаам үзэсгэлэнт сайхан нь энд ирсэн олон хүмүүст бурханлигаар нөлөөлдөг. . . .



БЯИС-ийн Иерусалимын Төв

5. “Ерөнхийлөгч Хантер насан туршдаа олон бэрхшээлтэй тулгарч байв. Тэрээр эрүүл мэндийн ноцтой, хүнд асуудалтай итгэл, тэвчээр хатуужлаар нүүр тулан учирч, анхных нь эхнэр бие нь муудан, удаан хугацаагаар өвчилж, өөд болсон хийгээд бусад түмэн бэрхшээл, зовлонг туулсан юм. Тэрээр саад бэрхшээл, зовлонг эс хайхран, Их Эзэнд идэвхтэй үйлчилж, олон удаа аялж, Сүмийн ажил хэргийг удирдахад шаргуу ажиллаж байв. ‘Хэрэв хүүхдүүд чинь замаасаа гажиж байгаа асуудал гэр оронд чинь байгаа бол, хэрэв та санхүүгийн алдагдалд орсон бол, хэрэв гэр орон, аз жаргалд чинь заналхийлөгч сэтгэл санааны дарамттай учирсан бол, эрүүл мэндээ алдах аюул танд учирсан бол, бодгалд чинь амар амгалан байг. Бидний тэвчээр хатуужил, сэтгэлийн хат дааж чадахаас илүү хүнд сорилт бидэнд учрахгүй. Бидний тойруу зам, сэтгэлийн гунихрал бол Түүнд хүрэх

нарийн бөгөөд шулуун зам юм' гэсэн захиастай нь түүний үлгэр дуурайл дүйдэг байлаа [In Conference Report, 1987 оны 10-р сар, 71; *Ensign*, 1987 оны 11-р сар, 60].

6. "Сүмийн түүхэн дэх хөгжлийн нэг чухал үе шат болсон Сүмийн 2000 дахь гадас 1994 оны арванхоёрдугаар сарын 11-нд Мексикийн Мехико хотод байгуулагдахад Ерөнхийлөгч Хантер тэргүүлсэн юм. Цугларагсдад хандаж тэрээр: 'Их Эзэн Үйлчлэгдээрээ дамжуулан энэхүү гайхамшгийг тохиолгон авчирлаа. Энэ ажил хүч чадал, амьдрах чадвараар үргэлж урагшлах болно. Эцэг Лихай, түүний хүүхдүүдэд үр удмынх нь талаар өгөгдсөн амлалтууд Мексикт гүйцэлддээ. Цаашид ч бас гүйцэлдэх болно' гэжээ [*Church News*, 1994 оны арванхоёрдугаар сарын 17, 3]. Ерөнхийлөгч Хантер Ерөнхий эрх мэдэлтнээр үйлчилж байх үед Латин Америкт Сүм эрс түргэн өссөн юм. Түүнийг Сүмийн Ерөнхийлөгч болох үед Мексик, Бразил, Чилид 1.5 сая гаруй Хожмын Үеийн Гэгээнтэн байсан нь тэр үед Ютад оршин сууж байсан Сүмийн гишүүдээс илүү олон байлаа.

7. "Ерөнхийлөгч Хантер хэдийгээр Сүмийн Ерөнхийлөгчөөр ердөө есхөн сар үйлчилсэн ч, нинжин сэтгэл, тэсвэр хатуужил, Христийнтэй адил амьдралынх нь гаргуун үлгэр жишээ нь түүнийг дурсан санадаг Гэгээнтнүүдэд хүчтэй нөлөө үзүүлсэн юм" (*Бидний Өв*, 159-163).

8. Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байсан, Ахлагч Жеймс И.Фауст Ерөнхийлөгч Хантерын залуу үеийн тухай дараах түүхийг хуваалцжээ: "Түүний дүү Дороти Хантер Расмюссен, . . . тэр хоёр хоёул хүүхэд байсан үеийнхээ нэгэн ялдамхан явдлыг дурссан байдаг. 'Ховард үргэлж сайныг үйлдэхийг хүсдэг бас сайн байхыг хүсдэг байж. Гайхалтай сайн ахын хувьд тэр намайг харж ханддаг байсан. Тэр аав, ээж хоёртоо эелдэг уриалгахан байдаг байв. Ховард амьтанд хайртай байлаа. Тиймээс золбин амьтдыг гэртээ дандаа авчирдаг байсан. Тэрийнх нь хажууд услалтын шуудуу байдаг байж, нэг өдөр тэр хавийн хэдэн хөвгүүд шуудуу руу . . . нэг муурын зулзгыг шидсээр байв. Муурын зулзага шуудуунаас гарах гэж зүтгэхэд нь тэд энэ тоглоомноосоо залхах хүртлээ түүнийг дахин дахин ус руу шидсээр байв. 'Ховард очоод, муурын зулзгыг шуудуунаас гаргаж ирэв. Муурын зулзага бараг үхдэгийн даваан дээр байсныг тэр гэртээ авчирсан аж. Муурын зулзага үхчих нь үү гэж ээж нь айж байлаа. Гэвч тэр хоёр муурын зулзгыг хөнжлөөр хучиж, бүлээхэн пийшингийн дэргэд тавиад асарчээ. 'Муурын зулзага амь аврагдаж, тэр хоёр олон жил мууртай байв. 'Тэр бас их сайхан сэтгэлтэй хүн байлаа. Ах маань миний амьдралд ямар нэг буруу юм хийж байсныг би огт мэдэхгүй'" гэж Дороти ярьжээ ("The Way of an Eagle," *Ensign*, 1994 оны наймдугаар сар, 4, 6).



9. Далын гишүүн асан, Ахлагч Рулон Г. Крейвен дараах түүхийг хуваалцжээ: "Ерөнхийлөгч Хантер дахиад явдаг болж чадахгүй гэж нэлээд олон жилийн өмнө түүнд хэлснийг олон хүмүүс санаж байгаа. Гэвч, түүний итгэл, сэтгэлийн хат тэр үгнээс илүү хүчтэй байсан аж. Тэр сүржигнэлгүйгээр, бусдад мэдэгдэлгүйгээр, эрч хүч их шаардсан биеийн хүчний эмчилгээний дасгалыг өдөр бүр эрс

шийдэмгий, итгэлтэйгээр, дахин явж чаддаг болно гэсэн хатуу зөн билгээр хийдэг байв. Хүнд хэцүү тэдгээр саруудад Арванхоёрын Ах нар нь чуулгынхаа цулаанууд дээр, бас хувиараа түүний төлөө өдөр бүр залбирдаг байжээ.

10. "Хэдэн сарын дараа, нэг пүрэв гарагийн өглөө би Ерөнхийлөгч Хантерын албан өрөөнд орлоо . . . Тэр өглөө эрт гараад ариун сүм рүү явган явсан гэж надад хэлэв. Ингэж хэлсэнд би эргэлзэн, түүнийг замаас нь машинд суулгах гэж яаран гарав. Намайг түүн дээр хүрч очиход тэр таяг тулан алхаж явах нь тэр. . . . Ерөнхийлөгч нь [цуглааны] өрөөнд алхан орж ирэхэд Арванхоёр босч, алга ташиж эхэлжээ. . . . Ерөнхийлөгч Хантер тэдэнд талархал илэрхийлээд, 'Би дахин явдаг болно гэж бодоогүй, гэвч Их Эзэний туслалцаа, өөрийн минь шийдэмгий зан, хамгийн гол нь, Арванхоёрын Ах нарын маань итгэлээр би дахин явдаг боллоо'" гэжээ (In Conference Report, 1991 оны 4-р сар, 35-36; *Ensign*, 1991 оны 5-р сар, 28-29).

Уншсанаа ойлгох нь



Ерөнхийлөгч Ховард В.Хантерын амьдрал

Олж авах (догол мөр 4)—
Худалдаж авах

Сүржигнэх (догол мөр 9)—
Олон түмэнд мэдэгдэх,
харуулах

Ховард В.Хантерын сургаал ба гэрчлэл

11. "Аврагч бусдаас авахыг хэзээ ч хүсэн хүлээдэггүй байсан юм. Тэрээр үнэгүйгээр, хайраар өгдөг байсан. Түүний бэлгүүд хэмжээлшгүй үнэ цэнэтэй байлаа. Тэрээр хараагүйчүүдэд харааг, сонсголгүйчүүдэд чихийг, хазгаруудад холийг; цэвэр ариун бус хүмүүст цэвэр ариун сэтгэлийг, согогтойд эрүүл саруулыг, амьгүй бологсдод амьсгалыг өгч байлаа.

12. "Түүний бэлгүүд урам нь хугарагчдад боломж, дарлагчдад эрх чөлөө, наманчлагчдад уучлал, цөхрөгсдөд найдвар, харанхуйд гэрэл болж байлаа. Тэрээр хайраа, үйлчлэлээ, амь насаа бидний төлөө өгсөн юм. Бас хамгийн чухал нь, Тэр бидэнд болон бүх мөнх бус хүмүүст амилуулалт, аврал болон мөнх амьдралыг өгсөн юм.

13. "Түүний өгдөгийн нэгэн адилаар бид бусдад өгөхийг хичээх ёстой. . . . Өөрийгөө өгнө гэдэг бол ариун нандин бэлэг юм. Бид бусдад өгөхдөө Аврагчийн өгсөн бүхнийг санадаг. . . .

14. ". . . Христийн Мэндэлсний энэхүү баяр хэрүүлийг эвлэрүүлдэг. Мартагдсан найзаа эрж ол. Сэжгийг арилгаж, итгэлээр соль. Захидал бич. Эелдэг уриалгахан хариу өг. Залуучуудыг урамшуулан дэмж. Үнэнч шударга зангаа үг хэл, үйл ажлаар харуул. Амлалтаа биелүүл. Атгаг санаанаас татгалз. Дайсныг уучил. Уучлал гуйж бай. Ойлгохыг хичээ. Бусдад тавьдаг шаардлагаа шалга. Өөр хүний тухай эхлээд бод. Найрсаг бай. Эелдэг дөлгөөн бай. Ахиухан инээж бай. Талархлаа илэрхийлж бай. Танихгүй хүнтэй мэндэлж бай. Хүүхдийн зүрх сэтгэлийг баярлуулж бай. Газар дэлхийн үзэсгэлэн, гайхалтай сайханд баяс. Хайраа илэрхийлж, дахин хэлж бай. [Нэр нь үл мэдэгдэх зохиогчийн бүтээлээс хялбаршуулан авав.]" (in "To Give of Oneself Is a Holy Gift," Prophet Tells Christmas Gathering," *Church News*, 1994 оны 12-р сарын 10, 4).



15. “Бид хувь хүмүүсийн хувьд, гэр бүлийн хувьд, хамт олны хувьд, түүнчлэн улс үндэстний хувьд, бид бас Петр шиг, хараагаа Есүс дээр тогтоох юм бол, өргөжин тэлж буй итгэлгүй байдлын давалгаан дээгүүр ялгууснаар алхан гарч, өсөн нэмэгдэж буй эргэлзээний шуурган дунд айдасгүй байж болно гэдэгт миний бие бат итгэдэг билээ. Гэвч бид итгэх ёстой түүнээс хараагаа буруулах юм бол, бидэнд тусалж, биднийг аварч чадах түүний оронд, бидний эргэн тойрон дахь аймшигт, устгагч элементүүдийн хүч, уур хилэн рүү харах юм бол, уруу татагдах нь, дэлхийд ихэд уруу татагдах нь амар хялбар байх болно. Ингэх юм бол бид зөрчил сөргөлдөөн, уй гашуу, гансрал цөхрөлийн далайд зайлшгүй живнэ.

16. “Бид өөрсдийг маань живүүлэхээр заналхийлж байгаа үерийг, гүнзгий усанд шидэгдсэн итгэлийг мань залгих гэж байгааг мэдэрсэн ийм үед, шуурган дунд, харанхуйн дунд: ‘Зоригтой бай. Би байна. Бүү ай’ (Матай 14:27)” гэсэн дэлхийн Аврагчийн аятай сайхан үгсийг бид үргэлж сонсохын төлөө би залбирдаг. (In Conference Report, 1992 оны 10-р сар, 24; *Ensign*, 1992 оны 11-р сар, 19; Фредери В. Фаррар, *The Life of Christ* [1964], 313)-аас хялбаршуулан авав.

17. “Цаг хугацаа эхэлснээс хойш үе үеийнхэн юмсыг даван туулж, асуудлыг шийдвэрлэсээр ирсэн юм. Түүнээс гадна, хувь хүн бүр зөвхөн өөрт нь тулгарсан юм шиг санагдах цогц сорилттой заримдаа тулгардаг. Бид үүнийг мөнх бус байдлынхаа өмнөх оршихуйд ойлгодог байсан.

18. “Эдгээр туршлагауд биднийг даруусгаж, цэвэршүүлэн, бидэнд заах үед биднийг илүү сайн, илүү талархалтай, зовлон бэрхшээл тохиолдсон үед нь бусад хүмүүст анхааралтай ханддаг хүмүүс болгодог.

19. “Хамгийн хэцүү цаг үед, асуудал, адислалууд зөв шударга хүмүүсийг адисалж, зөв шударга байдал хомс байдаг хүмүүсийг наманчлал руу хөтлөхөөс өөр ямар нэг зорилго агуулж байгаагүй билээ” (“Why Try?” *New Era*, 1994 оны 1-р сар, 6).

20. “Есүс мутраа юун дээр ч тавилаа гэсэн тэр зүйл амилан амьдардаг. Хэрэв Есүс мутраа гэрлэлт дээр тавьсан бол, гэрлэлт амьдарна. Хэрэв тэрээр мутраа гэр бүл дээр тавихыг соёрхсон бол гэр бүл оршин тогтноно” (In Conference Report, 1979 оны 10-р сар, 93; *Ensign*, 1979 оны 11-р сар, 65).

21. “Есүс бол өнө удаан үргэлжлэгч баяр баяслын цорын ганц эх сурвалж гэдгийг, бидний энэхүү өнө удаан амар амгалан түүнд байдгийг би гэрчилж байна. Тэрбээр ‘эдүгээ бидний алдар суу’ байхыг, бидний хүн нэг бүрийн алдар суу нь хүн бүрийн эрч хүчтэй хүсэл эрмэлзэл байж, хүмүүс

болон үндэстнүүд түүнийг үргэлж дээдлэн хүндэлж байхыг би хүсдэг. Тэр бол энэ амьдралд болон үүр мөнхөд бидний шагнал юм. Бусад бүх шагнал эцэстээ үр ашиггүй болдог. Бусад бүх агуу юмс цагийн уртад элэгдэж гандан, элементүүд болон сарниж алга болдог. Христ дотор байхаас өөр жинхэнэ баяр баясгалан гэж үгүйг бид. . . төгсгөлд мэдэх болно” (In Conference Report, 1993 оны 4-р сар, 80–81; *Ensign*, 1993 оны 5-р сар, 65).

22. “Есүс Христийн нэрийг бүх дэлхийд гэрчлэхээр дуудагдаж, томилогдсон хүний хувьд, Тэрээр амьд гэдгийг Улаан Өндөгний энэ Баярын үеэр би гэрчилж байна. Тэрээр алдар сууд оршсон, үхэшгүй мөнх, яс болон махан биетэй юм. Тэр бол махан биеэр төрсөн Эцэгийн Төрсөн Ганц Хүү мөн. Тэр бол дэлхийн Аврагч, дэлхийн Гэрэл бөгөөд Амь мөн. Цовдлолт болон үхлийнхээ дараа тэрээр амилсан хүмүүн болж, Мариа, Петр, Паул, бусад олон хүмүүс дээр хүрч ирсэн билээ. Тэр өөрийгөө нифайчуудад харуулсан юм. Манай эрин үед Тэрбээр өөрийгөө бошиглогч хөвгүүн Иосеф Смит болон бусад олон хүмүүст харуулсан билээ. Энэ Сүм бол Түүний Сүм” (In Conference Report, 1988 оны 4-р сар, 19; *Ensign*, 1988 оны 5-р сар, 17).



Уншсанаа ойлгох нь



Ховард В.Хантерын сургаал ба гэрчлэл

Урам нь хугарагчид (догол мөр 12)—Зориг нь мохсон, хүсэл эрмэлзэлгүй болсон хүмүүс

Атгаг санаанаас татгалзах (догол мөр 14)—Гомдлын мэдрэмжийг уучлах

Уншсанаа судлах нь




“Ерөнхийлөгч Ховард В.Хантер”-ыг судлахдаа үйл ажиллагаа А буюу Б-г хий.

А Ерөнхийлөгч Хантерын тухай мэдэх нь

Ерөнхийлөгч Ховард В. Хантерын амьдрал ба Ерөнхийлөгчийн Зөвлөлийн талаарх схем (х.00 216), мөн догол мөр 1–10-ын унших материалыг судалж, дараах асуултуудын хариултыг ол:

1. Ерөнхийлөгч Хантер баптисм хүртэж, Сүмийн гишүүн болохдоо хэдэн настай байсан бэ?
2. Төлөөлөгчөөр томилогдохдоо тэр хэдтэй байсан бэ?
3. Хоёр дахь удаа гэрлэхдээ тэр хэдэн настай байсан бэ?
4. Ямар ариун сүмүүдийг тэр онцгойлон адисалсан бэ?

- Түүнд тулгарсан наад талын хоёр бэрхшээл юу вэ?
- Хоёр мянга дахь гадас ямар оронд байсан бэ?
- 1994 онд Латин Америкийн ямар гурван орон Ютагаас илүү олон сүмийн гишүүдтэй байсан бэ?
- Ерөнхийлөгч Хантер Сүмийн Ерөнхийлөгчөөр хэр зэрэг удаан үйлчилсэн бэ?



Б Амжилтуудыг судал

- Өөрт чинь гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн таван амжилтыг Ерөнхийлөгч Хантерын амьдралаас жагсаан бичн бич. Амжилт бүрийн дараа, уг зорилтыг хэрэгжүүлэхийн тулд хүнд хэрэгтэй зан төлвийн өөр өөр шинжүүдийг бич.
- Жагсаалт дээрх зан төлвийн ямар шинжийг өөртөө илүү ихээр хөгжүүлэхийг хүсдэгээ, түүнчлэн үүнийг хэрхэн хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаагаа товч тайлбарла.

В Залруулга хий

- Дараах нотолгоо бүрд Ерөнхийлөгч Хантерын сургаалуудын нэг буруу хувилбар байгаа. Нотолгоонуудыг зөв болгож дахин бич.
 - “Найз нарынхаа амьдрал, үлгэр дуурайлд илүү их анхаарал тавьж амьдрахад би газар бүрийн бүх хүмүүсийг уримаар байна” (догол мөр 1-ийг үз).
 - “Бид бие биендээ илүү нинжин сэтгэлээр, илүү эелдэг уриалгахан, илүү баяр баясал болон тэвчээртэйгээр бас уучлалаар хандаж байхын төлөө би залбирна. (догол мөр 2-ыг үз).
 - “Сүмийн гишүүн бүрийг номлогч байлгах нь зүрх сэтгэлийн минь хамгийн гүнзгий хүсэл байх болно” (догол мөр 3-ыг үз).
 - “Бидний тойруу зам, сэтгэлийн гунихрал бол бидний Аврагчид хүрэх зам дээрх бартаа юм” (догол мөр 5-ыг үз).
 - “Аврагч авахыг хүсэн хүлээх нь ховор байлаа. Тэрээр үнэгүйгээр, шүүлтгүйгээр өгдөг байсан бөгөөд түүний бэлгүүд дэлхийн үнэ цэнээр бага байлаа” (догол мөр 11-ийг үз).
- Дээрх нотолгоонуудын нэгийг сонгож, зөв хувилбар нь буруугаасаа яагаад дээр болохыг тайлбарла.

Г Аврагчийн тухай судалгаа

- “Ховард Б.Хантерын сургаал ба гэрчлэл” (догол мөр 11–22-ыг үз) дэх нотолгоонуудын хэд нь Аврагчийн тухай өгүүлж байна вэ?
- Ерөнхийлөгч Хантер Есүс Христийн тухай юу заасныг жагсаан бич. Жагсаалтан дахь өөрт чинь гүнзгий сэтгэгдэл төрүүлсэн санаануудыг дугуйл.
- Аврагчийн тухай юуг мэдэхийг, мөн Түүний тухай юу гэж бодохыг Ерөнхийлөгч Хантер биднээс хүсдэг байсан гэж боддогоо товч тайлбарла.

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли

“Би өөдрөг үзэлтэй хүн. Ирээдүй сайн сайхан харагдаж байна гэж би боддог.”

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли Сүмийн Ерөнхийлөгч болсныхоо эхний таван жилд Антарктикаас бусад бүх тивийн Сүмийн гишүүдэд айлчлан очжээ. “Би аялах дургүй. Гэвч итгэлтэй Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн нүүр царайг харж, гарыг нь барих дуртай.” . . гэж тэрээр 1996 оны аравдугаар сарын ерөнхий чуулган дээр хэлжээ...

“... [Хэдэн жилийн дараа тэр хэлсэн нь:] ‘Би аялах хүч чадалтай байгаа цагтаа аяллаа аль болохоор удаан үргэлжлүүлэхээр шийдлээ. Би өтөлж хөгширсөөр байна. Би зургадугаар сард 90 хүрнэ. Энэ өдөр удахгүй болно. Заримдаа би өтөлж хөгширч байгаагаа хөлөндөө мэдэрдэг. [Гэвч гишүүдийн дунд байх нь] миний эгээрэл хүсэл юм. Сүмийн хүмүүс Сүмийн ерөнхийлөгчтэйгөө уулзах боломжтой байх эрхтэй гэж би боддог” (“Looking into the Faces of Faithful Latter-day Saints,” “Church News, 2000 оны гуравдугаар сарын 4, 8, 13).

ТҮҮНИЙ АМЬДРАЛ (1910–2008)

1910 он	Зургадугаар сарын Солт Лейк хотод 23-нд Брайнт С. Хинкли, Ада Битнер Хинкли нарын гэр бүлд төржээ	
1919 он	8 настайд нь, дөрөвдүгээр сарын 28-нд Солт Лейк хотод аав нь түүнд баптисм хүртээжээ	
1930 он	20 настайд нь, ээж нь нас барав	
1933–1935 он	23–25 настайдаа, Их Британид номлолд үйлчлэв	
1935–1958 он	25–47 настайдаа, Сүмийн номлолын хороонд бүрэн цагаар ажиллаж байв, дараа нь Сүмийн газруудад бусад албан тушаалуудад ажиллаж байв	
1937 он	26 настайдаа, дөрөвдүгээр сарын 29-нд Маржори Рейтэй гэрлэв; Ням Гарагийн Сургуулийн Ерөнхий Зөвлөлд үйлчлэхээр дуудагдав	
1958 он	47 настайдаа, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад Туслагчаар томилогдов	
1961 он	51 настайдаа, Төлөөлөгчөөр томилогдов	

- 1981–1995 он** 71–84 настайдаа, Тэргүүн Зөвлөлд Ерөнхийлөгч Спенсер В. Кимбалл (1981), Эзра Тафт Бенсон (1985), Ховард В. Хантер (1994) нарын зөвлөх байв
- 1995 он** 84 настайдаа, Сүмийн Ерөнхийлөгчөөр дэмжигдэн батлагдав
- 2008 он** 97 настайдаа, Солт Лейк хотод таалал төгсөв

ТҮҮНИЙ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛ (1995–2008)

- 1995 он** Бүс нутгийн бүх төлөөлөгчид чөлөөлөгдсөнийг мөн Бүсийн Эрх мэдэлтний шинэ дуудлагыг Арванхоёр зарлав; “Тэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг” танилцуулагдав
- 1996 он** Бүх гишүүд ариун сүмд тогтмол орохоос ирдэг адислалуудыг хүртэх боломжтой байхын тулд дэлхий даяар жижиг ариун сүмүүд барих хөтөлбөр эхлэв
- 1997 он** Бүсийн эрх мэдэлтнүүдээс Далын чуулгуудыг нэмж зохион байгуулав; дэлхий даяар Далын Чуулга бүгд тав болов
- 1998 он** Африк, Европ, Ази, Хойд болон Өмнөд Америк, Австрали, Өмнөд Номхон Далай дахь Гэгээнтнүүдтэй уулзан, дэлхий даяар явав
- 1999 он** Нэлээд хэдэн телевизийн хөтөлбөрт Сүмийг төлөөлдөг болов; Наувугийн Ариун сүмийг дахин барихаар зарлав
- 2000 он** Солт Лейк хот дахь Чуулганы шинэ Төвийг онцгойлон адислав; жилийн эхээр Сүмийн гишүүнчлэл 10,752,986 байснаа-зун гэхэд 11 саяас давав

Сүмийн Ерөнхийлөгч болсны эхний таван жилд тэрээр бараг 402,336 км аялж, 58 улсад айлчилж, 2.2 сая Сүмийн гишүүд болон бусад хүмүүстэй ярилцаж 24 ариун сүмийг онцгойлон адисалжээ.



Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн амьдрал

1. “Ерөнхийлөгч Хантерыг таалал төгссөний дараа Гордон Б. Хинкли Сүмийн Ерөнхийлөгч болоход түүний Ерөнхийлөгчийн Зөвлөлийн анхаарах гол зүйл юу байхыг түүнээс асуужээ. ‘Ажлыг үргэлжлүүлэх. Тийм ээ, үнэнхүү

биширмээр, үнэнхүү итгэлтэйгээр, бас үнэнхүү сайн үйлчилж байсан бидний өмнөх залгамжлагчдын урагш ахиулсан агуу ажлыг үргэлжлүүлэх нь бидний зорилго мөн. Гэр бүлийн үнэт зүйлсийг төлөвшүүлэх, боловсролд түлхэц өгөх, газар бүрийн хүмүүсийн дунд хүлээцтэй, хүлцэнгүй зан чанарыг төлөвшүүлэх мөн Есүс Христийн сайн мэдээг тунхаглах’ гэж тэрээр хариулсан гэдэг [Church News, 1995 оны 3-р сарын 18, 10].

2. “Сүмийн удирдлагын талаарх Ерөнхийлөгч Хинклийн өргөн цар хүрээтэй туршлага түүнийг Ерөнхийлөгчийн Зөвлөлийн ажилд сайн бэлтгэсэн юм. Тэрээр Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгад 1961 онд дэмжигдэн батлагджээ. 1981 оноос эхлэн тэр Сүмийн гурван Ерөнхийлөгч-Спенсер В.Кимбалл, Эзра Тафт Бенсон, Ховард В.Хантер нарын Ерөнхийлөгчийн зөвлөлд зөвлөхөөр үйлчлэв. Энэ жилүүдэд Сүмийн эдгээр Ерөнхийлөгчид насны доройтлоор зовон шаналж байсан үед ер бусын хүнд үүрэг хариуцлагыг тэрбээр үүрч байсан юм.



3. “Залуу Гордон Б.Хинкли Англид номлолд байхдаа, хүнд хэцүү үүрэг хариуцлагын жилүүдэд, өөрт нь сайнаар нөлөөлсөн нэг зөвлөгөө хүлээн авчээ. Тэрээр ямар нэг хэмжээгээр урам нь хугарсан үед, ‘Би цаг заваа, бас

таны мөнгийг дэмий үрж байна. Би энд байгаагийнхаа утга учрыг олж харахгүй байна’ хэмээн аавдаа захидал бичжээ. Хэсэг хугацааны дараа: ‘Эрхэм Гордон. Захидлыг чинь авлаа. . . . Би ердөө ганцхан зөвлөгөө өгье. Өөрийгөө март, тэгээд ажиллахаар яв. Хайрт аав чинь’ гэсэн товчхон захидалыг тэр ааваасаа хүлээн авчээ.

4. “Ерөнхийлөгч Хинкли тэр үеийн тухай: ‘Би үүнийг тунгаан бодсон. Тэгээд маргааш өглөө нь бид судрын хичээл дээрээ: ‘Учир нь хэн өөрийн амийг аврахыг хүснэ, тэр үүнийгээ алдана, харин хэн миний төлөө, сайн мэдээний төлөө амиа алдана, тэр хүн түүнийгээ аварна’ (Марк 8:35) гэсэн Их Эзэний агуу үгсийг уншиж билээ. Эдгээр үгс надад нөлөөлсөн юм. Эдгээр үгс, энэ амлалт, аавын минь захидалтай нийлээд, намайг шатаар дээш өгсөж. . . өвдөг сөгдөн, өөрийгөө мартахыг хичээж, ажиллахаар явна хэмээн Их Эзэнтэй гэрээ хийхэд намайг өдөөв. Үүнийг би амьдралдаа чухал шийдвэр гаргасан өдөр гэж үздэг билээ. Тэр үеэс хойш надад тохиолдсон сайн сайхан бүхнийг би тэр үед гаргасан шийдвэртэйгээ холбож үздэг’ [Гордон Б. Хинкли: Man of Integrity, 15th President of the Church, видео хуурцаг (1994)].



5. “Ерөнхийлөгч Хинкли бол гандан бууршгүй өөдрөг үзэлтэй, Бурхан болон ирээдүйд итгэх итгэлээр ямагт дүүрэн байдгаараа нэрд гарсан хүн юм.” “Юмс шийдвэрлэгдэнэ. Үргэлж хичээж бай. Итгэлтэй бай. Баяртай бай. Санаагаар бүү уна. Юмс шийдвэрлэгдэнэ” гэсэн үгс нь гэр бүлдээ, найз нөхдөдөө, таньдаг хүмүүстээ Ерөнхийлөгч Хинклийн дахин дахин хэлдэг хамгийн итгэл үнэмшилтэй үгс юм” [Жеффри Р.Холланд, “Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли,” Ensign, 1995 оны 6-р сар, 5].

6. “Сүмд тулгарч байгаа хамгийн том бэрхшээлийг мэдэх гэж нэг сурвалжлагч түүнээс асуухад, тэрээр, ‘Бидэнд тулгарч байгаа хамгийн ноцтой бэрхшээл, бас хамгийн гайхалтай бэрхшээл бол өсөлтөөс үүдэлтэй бэрхшээл юм’ гэж хариулжээ. Өсөлт нэмэгдэж байгаа нь улам олон барилга байшин, түүний дотор ариун сүмүүдийн хэрэгцээг бий болгож байгааг тайлбарлан:



‘Өнөө үе бол ариун сүм барихын хувьд Сүмийн түүхэн дэх хамгийн агуу үе юм. Эдүгээ урагш ахиж байгаа ариун сүмийн барилгын ажил хэзээ ч ийм аварга цар хүрээгээр урагш ахиж байсангүй. Үйл ажиллагаа явуулж байгаа 47 ариун сүм бидэнд байна. Барилгын явцад зураг төслийг нь хэрэгжүүлж байгаа өөр 13 ариун сүм бидэнд байна. Бид ариун сүм барихаа үргэлжлүүлнэ’ [in *Church News*, 1995 оны 3-р сарын 18, 10]. Сүмийн өсөлт нэмэгдсэн нь бас Мормоны Номыг олон хэлэнд орчуулах шаардлагыг бий болголоо.

7. “Сүмийн эрчимтэй өсөлтөд Ерөнхийлөгч Хинклийн хувийн туршлага бий. Тэрээр 1967 онд Японы Осакад чуулганд оролцох үеэрээ, олон залуу хүмүүс оролцсон сонсогчдыг гүйлгэн харснаа: ‘Япон дахь Сүмийн ирээдүйг би та нарын дотор харж байна. Би бас агуу ирээдүйг харж байна. Бид дөнгөж гадаргууд хүрч байна. Гэвч энэ агуу оронд Сионы гадаснууд бий болох тэр өдөр холгүй байгааг би их эртнээс мэдэрдэг байснаа хэлье гэж бодлоо’ [“Addresses,” AV 1801; ХҮГ Сүмийн Архивт]. Нэг үеийнхний амьдралын хугацаанд Японд 100,000 Хожмын Үеийн Гэгээнтэн, олон гадас, дүүрэг, номлол, нэг ариун сүм бий болсон байлаа.



8. “1973 онд Манилд анхны гадас зохион байгуулагдсан Филиппин дэх Сүмийн өсөлтийг Ерөнхийлөгч Хинкли бас их сонирхдог байлаа. Хорин жилийн дараа түүнийг Сүмийн Ерөнхийлөгч болсон үед сайн мэдээний адислаалуудыг, түүний дотор тус орон дахь нэг ариун сүмийг Филиппиний 300,000 гаруй гишүүд хүлээж авсан билээ. Азийн бусад хэсэг, түүний дотор Солонгос, Хятад, Зүүн Өмнөд Ази дахь Сүмийн өсөлтөд Ерөнхийлөгч Хинкли асар их санаа тавьсан юм.

9. “Филиппиний нэг гадсанд шинэ ерөнхийлөгч дуудахаар томилогдсон нэг Ерөнхий эрх мэдэлтний туршлага Ази дахь олон гишүүний сүнслэг байдлын нотолгоо болсон

билээ. Нэлээд хэдэн санваартан ах нартай ярилцлага хийсний эцэст хорь гаруй насны нэг хүнийг гадасны ерөнхийлөгчөөр дуудах санаа түүнд төрж гэнэ. Тэрээр нөгөөх ахыг зэргэлдээх өрөөнд орж, зөвлөхүүдээ сонгож авахад хэсэгхэн цаг гаргана уу гэж хүсэв. 30 секундын дараа нөгөөх ах эргэж ирж гэнэ. Ерөнхий Эрх мэдэлтэн түүнийг буруу ойлгосон юм болов уу гэж бодтол, ‘Үгүй ээ. Би Их Эзэний Сүнсээр дамжуулан гадасны ерөнхийлөгч болохоо сарын өмнө мэдсэн юм. Зөвлөхүүдээ аль хэдийн сонгочихсон л доо’ гэж гадасны шинэ ерөнхийлөгч хэлсэн гэдэг.

10. “Дэлхий даяар Сүмийг байгуулахад туслахын тулд өдий ихийг хийсэн Ерөнхийлөгч Хинкли удирдлагынхаа үед: ‘Хэрэв одоогийн хандлага хэвээр үргэлжлэх юм бол, 1996 оны хоёрдугаар сарын орчим, одоогоос ердөө хэдхэн сарын дараа Нэгдсэн Улсын гадна Нэгдсэн Улсад байгаагаас илүү олон Сүмийн гишүүд байх болно гэдгийг манай статистикийн мэдээ харуулж байна. Энэ шугамыг давах нь гайхалтай ач холбогдолтой зүйл. Энэ бол агуу их ажлын үр жимс юм’ гэж хэлжээ [In Conference Report, 1995 оны 10-р сар, 92–93; *Ensign*, 1995 оны 11-р сар, 70]. . . .

11. “Гэгээнтэн бүр Ерөнхийлөгч Хинклийг хэрхэн хамгийн дээд зэргээр дэмждэгийг нэг Ерөнхий эрх мэдэлтэн тайлбарлаж: ‘Өөрийнхөө дуудагдсан—бошиглогч, үзмэрч, илчлэгч, Тэргүүлэх Дээд Санваартан, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Ерөнхийлөгчийн ариун албан тушаалыг тэрээр авсан үед . . . бидний хийж болох хамгийн сайн зүйл бол түүнийг албан тушаалд нь үргэлжлүүлэх, үргэлжлүүлэх, үргэлжлүүлэн байлгах явдал мөн!’ гэжээ [Жеффри Р.Холланд, “Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли,” 13]” (*Бидний Өв*, 163–167).

Уншсанаа ойлгох нь



Ерөнхийлөгч Гордон Б.Хинклийн амьдрал

Өөдрөг үзэл (догол мөр
5)—Итгэл найдвартай байх

Гордон Б.Хинклийн сургаал ба гэрчлэл

12. “Ойрын жилүүдийн тухай асуухад, Ерөнхийлөгч Хинкли, ‘Сүм дэх манай залуу хүмүүсийг би харж байна. Тэднээс олныг нь би харж байна. Бүхнээс илүүгээр би тэднийг харж байна. Би тэдний амьдралын чанар, хүч чадал, нинжин сэтгэл, итгэл бишрэлийн тухайд туйлын өөдрөг үзэлтэй байна. Манай залуу хүмүүсийг харахаараа би энэ Сүмийн ирээдүйн талаар төдийлөн их санаа зовдоггүй шүү. Тэд судруудыг судалдаг. Тэд семинар, институтэд явдаг. Тэд гаргах шийдвэрийнхээ талаар залбирдаг. Тэд итгэл бишрэлийн гайхалтай уур амьсгалд олон нийтийн арга хэмжээ зохион байгуулдаг. Хүчирхэг, итгэл бишрэлтэй, чадварлаг Хожмын Үеийн Гэгээнтнүүд болохыг уриалсан дуудлагыг манай залуу хүмүүс хэрэгжүүлэх зам дээрээ байна” хэмээн хэлжээ (“We Must Look After the Individual,” *Church News*, 2000 оны гуравдугаар сарын 4, 13).



13. “Бид итгэл бишрэлээ ээ харуулснаар л манай хүмүүсийн амьдрал утга учиртай болох ёстой. . . .

14. “. . . Бидний Аврагч амьд учраас, түүний үхлийн бэлгэдийг [цовдлуур] бид ашигладаггүй. Гэвч бид юуг ашиглах вэ? Тэмдэг ч, урлагийн бүтээл ч, хэлбэр дүрс ч амьд Христийн сүр жавхлан, гайхамшигийг шаардлага хангахаар илэрхийлж чадахгүй. ‘Хэрэв та нар намайг хайрладаг бол, зарлигуудыг минь сахь’ (Иохан 14:15) гэж Түүний хэлсэн үг бэлгэдэл байх ёстойг тэрээр бидэнд хэлсэн юм.

15. “Бид дагалдагчдын хувьд Түүний дүр төрхийг гутааж мэдэх муу, тааруухан эсвэл бүдүүн баараг зүйлийг хийж болохгүй. Бас бид өөрсөд дээрээ нэрийг нь хүлээн авсан Түүний бэлгэдийг өндөрт өргөн дээдлэхгүйгээр сайн сайхан, ач буянтай, өгөөмөр сэтгэлийн үйлийг үйлдэж чадахгүй.

16. “Бидний амьдрал утга учиртай бэлгэдэл, амьд Бурханы Мөнхийн Хүү, амьд Христийн тухай бидний гэрчлэлийг тунхаглах бэлгэдэл байх ёстой” (“Our One Bright Hope,” *Ensign*, 1994 оны 4-р сар, 2, 5).

17. “Тэнгэр дэх Эцэг маань та биднийг бүгдээрэнг нь дэлхийд сайн сайхныг үйлдэх үлэмж их чадвараар адисалсан билээ. Та нар өөрсдөө нэг хэсэг нь болсон нийгэмдээ үйлчлэх чадвартай байхын тулд оюун ухаанаа, гараа сурган дадлагажуул. Эелдэг уриалгахан, ухаалаг хэрсүү, бусдад тусалдаг байх чадварыг хөгжүүл. Өвлөж авсан бурханлиг шинж чанарын тань нэг хэсэг болон ирдэг нигүүлслийг дотор сэтгэлдээ улам төгөлдөржүүл. . . .

18. “Та нар хэзээ ч муу юм бодох хэрэггүй. Та нар өөрсдийгөө авьяас чадваргүй төрсөн эсвэл авьяас чадвараа харуулах боломжгүй байна гэж хэзээ ч бодох хэрэггүй. Өөртөө байгаа авьяас чадварыг хөгжүүл, тэгвэл авьяас чадвар чинь өсч хөгжин уламж сайжирч, жинхэнэ үнэ цэнийг тань бусад хүмүүс өндрөөр үнэлнэ” (“The Light within You,” *Ensign*, 1995 оны 5-р сар, 99; Залуу Эмэгтэйчүүдийн Ерөнхий Цуглаан дээр хэлсэн үгнээс).

19. “Бид гэр орноо эмх журамтай байлгах цаг болсныг би зөвлөмж болгож байна.

20. “Манай хүмүүсээс их олон нь орлогоороо дөнгөн данган амьдарч байна. Хэрэг дээрээ зарим нь өр зээл тавьж амьдарч байна. . . .

21. “Бие дааж амьдрах чадварын тухай захиасыг бид Сүм даяар хэрэгжүүлж байна. Гэр оронд ноцтой өр нүүрлэж байгаа үед бие даан амьдрах чадвартай болж чадахгүй. Хүн

бусдад өртэй байх юм бол бие дааж амьдрах чадвартай байж чадахгүй, боолчлолоос чөлөөтэй ч байж чадахгүй” (In Conference Report, 1998 оны 10-р сар, 70–71; *Ensign*, 1998 оны 11-р сар, 53).



22. “Энэ Сүмийн гишүүн байна гэдэг амаргүй хэрэг. Ихэнх тохиолдолд хүн энэ Сүмийн гишүүн болсноор хуучин зуршлаа, хуучин найз нараа, хуучин хэлхээ холбоогоо орхиж, огт өөр, шаардлага өндөртэй шинэ нийгэм рүү алхан ордог.

23. “Хөрвөгчдийн тоо байнга өсч байгаа болохоор, замаа олоход нь тэдэнд туслахын тулд бид хүч чармайлтаа үлэмж өсгөн нэмэгдүүлэх ёстой. Хөрвөгч бүрд гурван зүйл: найз нөхөр, үүрэгт ажил, ‘Бурханы сайн үгээр’ (Моронай 6:4) тэжээгдэх нь хэрэгтэй байна. Энэ гурван зүйлээр хөрвөгчдийг хангах нь бидний үүрэг мөн. Энэ бол бас бидэнд боломжтой зүйл. . . .

24. “Хөрвөгчдийн тоо хэзээ хэзээнийхээс хавьгүй олон байгаагаас шалтгаалан эдүгээ сорилт их хэмжээгээр өсөн нэмэгдэж байна. . . . Хөрвөгч бүр Бурханы хүү буюу охин юм. Хөрвөгч бүр агуу, чухал үүрэг хариуцлагатай юм” (In Conference Report, 1997 оны 10-р сар, 66–67; *Ensign*, 1997 оны 5-р сар, 47–48).

25. “[Бурхан] [бүтээгдсэн энэ дэлхийг] хараад, энэ нь сайхан байх ёстой хэмээн мэдэгдсэн билээ. Дараа нь Тэрээр өөрийн дүрх төрх, адил төстэй байдлаар хүнийг бүтээсэн юм. Тэгээд Тэрээр сүүлчийнхээ бүтээлт, Өөрийн алдар суут ажлын оргил болгож, эмэгтэй хүнийг бүтээжээ. Би Еваг өмнө нь бүтээгдсэн бүхний дараах, амрахын өмнөх Түүний сүүлчийн ажил гэж үзэх дуртай” (“Daughters of God,” *Ensign*, 1991 оны 11-р сар, 99).



26. “Иосеф Смит бол Бурханы бошиглогч байсныг надад мэдүүлснийх нь төлөө би Их Эзэнд баярлан талархаж явдаг. Арванхоёр настай хөвгүүн, шинээр томилогдсон дикон байхад надад тохиолдсон нэг явдлын тухай би өмнө нь ярьсан билээ. Би аавтайгаа хамт гадасныхаа санваартны цуглаанд очив. Аав маань гадасны ерөнхийлөгчийн зөвлөлийн гишүүн байсан болохоор

индэр дээр, харин би ариун ёслолын танхимын арын эгнээнд суув. Энэ том цугларалтад эрчүүд босч зогсон, дуулж байв [“Тэр хүнийг магтъя” дууллыг].

27. “Эл дууллыг тэд хүч, итгэл бишрэлээр дуулж байхыг сонсоход, Иосефын бурханлиг дуудлагын тухай гэрчлэл зүрх сэтгэлд минь орж ирж билээ. Тэр үеэс хойш дал гаруй жилийн туршид Их Эзэн энэ гэрчлэлийг надад хадгалж ирсний төлөө би Түүнд баярлан талархаж явдаг юм” (In Conference Report, 1993 оны 10-р сар, 70; or *Ensign*, 1993 оны 11-р сар, 51).

28. “Өнөө өглөө миний бие талархалтайгаар санасан бүх юмнаас нэг зүйл бүхнээс дээгүүр онцгой байна. Энэ бол

Бүхнийг Чадагч Бурханы Хүү, Энхийн Хунтайж, Ариун Нэгэн, Есүс Христийн тухай амьд гэрчлэл юм. . . .

29. “. . . Би Түүний Төлөөлөгч болж, хүсэл тааллыг нь хэрэгжүүлж, үгийг нь заахаар томилогдсон билээ. Би дэлхийд Түүний гэрч болсон билээ. Итгэлийн энэхүү гэрчлэлийг би та нарт бас миний дуу хоолойг сонсох бүгдэд давтан хэлж байна. . . .

30. “Есүс бол миний найз. Өөр хэн ч надад өдий ихийг өгөөгүй юм. . . .

31. “Тэр бол миний үлгэр дуурайл. . . .

32. “Тэр бол миний багш. . . .

33. “Тэр бол намайг эдгээгч. . . .

34. “Тэр бол миний удирдагч. . . .

35. “Тэр бол миний Аврагч бөгөөд миний Гэтэлгэгч. Өвдөлт, өгүүлшгүй бэрх зовлонг амсан байж, амь насаа өгснөөр Тэрбээр Бурханы бүх хөвгүүд охидыг үхлийн дараах мөнхийн ёроолгүй харанхуйгаас намайг болон бид бүгдийг өргөн гаргахаар доош бууж ирсэн билээ. . . .

36. “Тэр бол миний Бурхан бас миний Хаан. . . . Түүний сүр жавхлангийн хувьд шөнө гэж үгүй. . . .

37. “. . . Тэр бол миний мэхийн хүндэтгэдэг, түүгээр дамжуулан би Тэнгэр дэх Эцэгтээ ханддаг Бурханы Хурга юм” (In Conference Report, 2000 оны 4-р сар, 86–88; *Ensign*, 2000 оны 5-р сар, 69–71).



Уншсанаа ойлгох нь



Гордон Б. Хинклийн сургаал ба гэрчлэл

Ёроолгүй харанхуй (догол мөр 35)—Нүх

Уншсанаа судлах нь



“Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли”-г судлахдаа үйл ажиллагаа А, Б, эсвэл В болон Г-г хий

А Ерөнхийлөгч Хинклийн тухай мэдэх нь

Ерөнхийлөгч Гордон Б. Хинклийн амьдрал ба түүний Ерөнхийлөгчийн Зөвлөлийн тухай мэдээллээс дараах асуултуудад хариул:

1. Бүрэн цагийн номлолд тэр хаана үйлчилсэн бэ?
2. Номлолынхоо талаар Их Эзэнтэй гэрээ хийхэд ямар судар түүнд тусалсан бэ?
3. Сүмийн бүрэн цагийн ажилтан, мөн Ерөнхий Эрх мэдэлтэн болсноос хойш тэр Сүмийн хэдэн Ерөнхийлөгчтэй холбоотой байсан бэ?
4. Тэргүүн Зөвлөлийн Зөвлөхөөр тэр хэр зэрэг удаан үйлчилсэн бэ?
5. Бошиглогчийг бид дэмжиж болох хамгийн сайн арга гэж Ахлагч Холланд юуг хэлсэн бэ?

Б Өөдрөг үзэлтэй байх нь

1. Хүмүүс улс орондоо буюу дэлхийд оршиж байгаа нөхцөл байдлын тухайд бухимдан цухалдахад өөрсдийгөө хүргэдэг ямар гурван шалтгаан байдаг вэ?
2. Ерөнхийлөгч Хинкли өөрийгөө өөдрөг үзэлтэй хүн гэж дүрсэлсэн байдаг. Өөдрөг үзэлтэй хүн гэж ямар хүн болохыг товч тайлбарла. Догол мөр 5-ыг нэгтгэн дүгнэж, Ерөнхийлөгч Хинклийг яагаад өөдрөг үзэлтэй хүн гэж боддогоо тайлбарла.
3. Догол мөр 6–11-ийг судалж, яагаад Сүмийн гишүүн өөдрөг бодол санаатай байх ёстойн гурван шалтгааныг жагсаан бич.
4. Та өөрийгөө өөдрөг үзэлтэй гэж дүрслэх үү? Яагаад, эсвэл яагаад үгүй гэж?

В Найман нэр зохио

“Гордон Б. Хинклийн сургаал ба гэрчлэл” дэх найман нотолгоо бүрд нэр өг (догол мөр 12, 13–16, 17–18, 19–21, 22–24, 25, 26–27, 28–37). Нэр бүрийн хувьд, гол сэдэв буюу нотолгоог илэрхийлсэн нийлэмж үгийг Ерөнхийлөгч Хинклийн хэлсэн зүйлээс ашигла. Жишээ нь, догол мөр 13–16-гийн нэр нь “Бидний итгэлийн бэлгэдэл” байж болно.

Г Илүү сайныг хийхээр сонгох нь

Ерөнхийлөгч Хинкли илүү сайныг үйлдэхэд Сүмийн гишүүдийг олонтаа уриалан дууддаг. Догол мөр 12–37-гоос, өсч дэвжихийг тэрээр бидэнд зөвлөсөн арван арга замыг жагсаан бич. Дараагийн долоо хоногт ямар арга замаар өөрөө сайжрахыг хүсч байгаа нэг арга замыг жагсаан бичилтаасаа сонго. Түүний зөвлөгөөг дагахын тулд юу хийхээ товч тайлбарла.

Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг



“Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”-ийг Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли Ерөнхий Нийгмийн Халамжийн Бүлгийн цуглаан дээр 1995 оны есдүгээр сард уншихаасаа өмнө: “Өнгөлөн далдалсан зальжин ов мэхийг үнэн мэтээр өгүүлэх нь их болж, жишиг болон үнэт зүйлсийн талаар ихээр хууран мэхэлж, дэлхий буртаглагдахыг даамжруулах их шохоорхол, уруу таталт бий болсон үед, сэрэмжлүүлэх, урьдчилан анхааруула шаардлагатайг бид мэдэрч байна. Ийнхүү сэрэмжлүүлэхийн тулд энэ Сүмийн бошиглогч, үзмэрч, илчлэгчдээс Сүмийн түүхийн туршиуд дахин давтан мэдэгдсээр ирсэн, гэр бүлтэй холбоотой жишиг, сургаалууд болон практикийг Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөл эдүгээ Сүмд бас дэлхий дахинд хандсан тунхаг болгож, дахин батлан

гаргаж байна” гэж хэлжээ (“Stand Strong against the Wiles of the World” Ensign, 1995 оны 11-р сар, 100).

ГЭР БҮЛ

ДЭЛХИЙ ДАХИНАА ӨРГӨХ ТУНХАГ

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөл

Есүс Христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн тэргүүн зөвлөл ба арванхоёр төлөөлөгчийн хоорондын гэрлэлт нь Бурханыг төлөөлөх тэмдэг байхыг чин сэтгэлээс тунхаглаж байна.

Бүх хүн төрөлхтөн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг Бурхан, өөрийн дүр төрөөр бүтээсэн. Хүн бүр Тэнгэрээ Эцэс Эгийн хайртай сүнсэн охин, хүү нь бөгөөд хүн бүр бурханлаг шинж чанар, хувь тавилантай юм. Хүйс бол хувь хүний мөнх бус байдлын өмнөх, мөнх бус болон мөнхийн амьдралын тодорхойлолт ба зорилгын салшгүй шинж чанар юм.

Мөнх бус байдлын өмнөх амьдралд сүнсэн охин хөвгүүд Бурханыг Мөнхийн Эцэг хэмээн мэдэж, биширдэг. Мөнхийн амьдралын өвлөн авах тэнгэрлэг хувь заяагаа бүрэн ухааран ойлгож, төгс төгөлдөр болон хөгжин дэвшихийн тулд бие махбодтой болж энэ дэлхийг амьдрах тухай Түүний төлөвлөгөө хүлээн зөвшөөрсөн юм. Аз жаргалын тэнгэрлэг төлөвлөгөө нь насан эцэслэсний дараа ч гэр бүлийн холбоогч мөнхжүүлэх. Ариун сүмийн хэлснээр болон гэрлэлт нь мөнх хүр Бурханы оршингүйд эргэн охин, гэр бүлд үз мөнх нэгдэх боломжийг олгодог.

Бурханы Адам, Ева хоёрт өгсөн алхны зарлиг нь эхнэр нөхрийн хувьд эцэс эх болох талаар байлаа. Өдгөө бид Бурханы хүүхдүүдэд “эсөн нэгдэж, өөр өгсөн болох, газар дэлхийг дүүргэ” хэмээн зарлиг нь хүний төгөлдөр байгааг тунхаглаж байна. Түүнчлэн “үр удамаа үлдэх зориулалттай” насан хүч нь мөнх хувь ёсоор гэрлэлтэй эхнэр нөхөр болон эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой” хэмээн Бурханы зарлиг тунхаглаж байна.

Мөнх бус амьдралын арга зам нь тэнгэрлэг төлөвлөгөөнд дэх амьдралын гэрлэлт байлаа, түүний ач холбогчдын чухал бичиг багтан хэлж байна.

Эхнэр нөхөр хоёр нь бие бие болон үр хүүхдэд хайрлан халамжаа харуулж ахуулаа. “Үр хүүхдэд

бол Их Эзэний өмнө юм” (Дуулал 127:3). Эцэг эхчүүд нь хүүхдүүдэд хайр, амьдралга байхад өрсөн хүүхдүүдэд бие биед хайраа, үйлчилж, Бурханы зарлигуудыг дагаж, хаана ч амьдарсан хуульчлалын сааман иргэд байгаад аажур сургах шаардлага үүсгэж байна. Эцэг эхчүүд үүргээ хэрхэн биелүүлснээр Бурханы өмнө хариуцлага хүлээн.

Гэр бүл Бурханыг заадаг. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөвлөгөөний зайлшгүй нэг хэсэг юм. Хүүхдүүд нь гэр бүлд төрж, гэрлэлтийн тангаргаа үнэнчээр сахдаг эцэг эхээр өсүүлж эргэлт. Их Эцэс Есүс Христийн сургаал дээр үндэслэн гэр бүлээ жаргалаа хүрнэ гэдэгт итгэж болно. Аз жаргалтай гэрлэлт болон гэр бүлд нь итгэл, залбирал, наманчлал, уучлал, хүндэтгэл, хайр, өрөөч сэтгэл, ажил мэддмөр ба гэр бүлээрээ үр бүтээлтэй үйл ажиллагаа зохиож зарчмуудыг барилдан амьдрах. Тэнгэрийн загварууд энэ нь гэр бүлд хайр болон амьдралыг эргэн гэрлэлтэй ирдэг, хэрэгцээг үндэслэн нь хангаж, хамгаалах үүргийг гүйцэтгэн үүрэг бол хүүхдүүдэд хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Энэхүү насны үүргээ биелүүлэхэд эцэг эхчүүд зарлигтай бие биед хамтран үйлдэх ёстой. Хүүхдүүдэд эцэг эхчүүд болон нас нөгчих болон бусад өмнөх байдлаа зайлшгүй дасан зохицох шаардлага гарч болно. Төрөл төрөгсөдөө шаардлагатай үед туслан дэмжжээ ёстой.

Ариун явдлын гэрээгээ зөрчин, хань нэгийг үр хүүхдүүдэд зүй бусар харьцсан, гэр бүлийнхэн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж хувь хүн хожмын нэг өдөр Бурханы өмнө өгч мэдүүлэх болно бид анхааруулж байна. Түүнчлэн гэр бүлд сарниулбал эрт эдүгээгийн бошиглогчдын угтан хэлснээр хувь хүн, нийгэм, улс үндэстнүүдэд гай гамшиг авчирч гэдгийг бид сануулж байна.

Итгэл хүлээсэн иргэд, төрийн албан хаагч та бүхнийг нийгмийн үндсэн нэгж болох гэр бүлийг бэхжүүлж ач хүүхдүүдэд ач ах арга замуудыг өгч хэрэгцээг үндэслэн хэмийн уриалаа дуудаж байна.

Энэ үг олонд 1995 оны 11-р сарын 21-д Ихэнх ариун Сүмийн Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөлөөс гаргасан. Хамгаалах бусад үгсүүд Бурханыг Энгийн Гэрлэлт, Эцэг эхчүүдэд хайр, амьдралга байхад өрсөн хүүхдүүдэд бие биед хайраа, үйлчилж, Бурханы зарлигуудыг дагаж, хаана ч амьдарсан хуульчлалын сааман иргэд байгаад аажур сургах шаардлага үүсгэж байна. Эцэг эхчүүд үүргээ хэрхэн биелүүлснээр Бурханы өмнө хариуцлага хүлээн.

Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг

1. “Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Тэргүүн Зөвлөл ба Арванхоёр Төлөөлөгчийн Зөвлөлийнхөн бид, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хоорондын гэрлэлтийг Бурхан томилдог бөгөөд гэр бүл нь Түүний хүүхдүүдийн мөнхийн хувь заяаны төлөөх Бүтээгчийн төлөвлөгөөний төвд байдгийг хүндэтгэлтэйгээр тунхаглаж байна.
2. “Бурхан бүх хүн төрөлхтөн, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийг өөрийнхөө дүр төрөөр бүтээжээ. Хүн бүр тэнгэрлэг эцэг эхийн хайртай сүнсэн хүү, охин нь бөгөөд ийм учраас хүн бүр бурханлаг шинж чанар, хувь тавилантай юм. Хүйс бол хувь хүний мөнх бус байдлын өмнөх, мөнх бус байдлын болон мөнх амьдралын тодорхойлолт ба зорилгын салшгүй шинж чанар юм.
3. “Мөнх бус байдлын өмнөх амьдралд, сүнсэн хөвгүүд охинд Бурханыг Мөнхийн Эцэг хэмээн мэдэж, биширдэг байсан бөгөөд мөнх амьдралыг өвлөн авах тэнгэрлэг хувь заяагаа бүрэн дүүрэн ухааран ойлгож, төгс төгөлдөр болон хөгжин дэвшихийн тулд бие махбодтой болж, энэ дэлхийд амьдрах тухай Түүний төлөвлөгөөг хүлээн зөвшөөрсөн юм. Аз жаргалын тэнгэрлэг төлөвлөгөө нь насан эцэслэсний дараа мөнхжих боломжийг гэр бүлийн холбоонд олгодог. Ариун сүмүүдэд гүйцэтгэгддэг ариун нандин ёслол ба гэрээнд нь Бурханы оршингүйд эргэн очих боломжийг хувь хүмүүст, түүнчлэн үүрд мөнхөд нэгдэх боломжийг гэр бүлд олгодог.
4. “Адам Ева хоёрт Бурханы өгсөн анхны зарлиг нь, тэд эхнэр нөхрийн хувьд эцэг эх болж чадах боломжийн талаар

байлаа. Өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болж, газар дэлхийг дүүргэж хэмээн Өөрийн хүүхдүүдэд өгсөн Бурханы зарлиг хүчин төгөлдөр байгааг бид тунхаглаж байна. Түүнчлэн үр удмаа үлдээх энэхүү ариун нандин хүч нь зөвхөн хууль ёсоор гэрлэсэн эхнэр нөхөр болох эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн хооронд байх ёстой хэмээн Бурхан зарлиг болгосныг бид тунхаглаж байна.

5. “Мөнх бус амьдралыг бий болгох арга зам нь Тэнгэрээс тогтоогдсоныг бид тунхагладаг. Бурханы мөнхийн төлөвлөгөөн дэх амьдралын цэвэр ариун байдал болон үүний чухал ач холбогчдыг бид батлан хэлж байна.



6. “Нөхөр эхнэр хоёр бие биенээ болон үр хүүхдээ хайрлаж, халамжлах эрхэм хүндтэй үүрэг хүлээнэ. ‘Хүүхдүүд бол ЭЗЭНээс ирдэг бэлэг’ юм (Дуулал 127:3). Эцэг эхчүүд хүүхдүүдээ хайраар болон зөв шударгаар өсгөн хүмүүжүүлж, бие бялдар болон оюун санааны нь хэрэгцээг хангаж, бие биенээ хайрлан, үйлчлэхийг,

түүнчлэн Бурханы зарлигуудыг дагаж, хаана ч амьдардаг байлаа гэсэн хуулийг хүндэтгэн сахидаг иргэд байхыг зааж сургах ариун үүрэгтэй юм. Эхнэр, нөхөр, эцэг эхчүүд үүргээ хэрхэн биелүүлснээрээ Бурханы өмнө хариуцлага хүлээнэ.

7. Гэр бүл Бурханаас томилогддог. Эрэгтэй, эмэгтэй хүмүүс гэр бүл болох нь Түүний мөнхийн төлөвлөгөөний нэг зайлшгүй хэсэг юм. Хүүхэд гэр бүлийн дотор төрж, гэрлэлтийн тангаргаа үнэнчээр сахидаг эцэг эхээр өсгүүлэх эрхтэй юм. Их Эзэн Есүс Христийн сургаал дээр үндэслэгдсэн гэр бүл аз жаргалд хүрнэ гэдэгт итгэж болно. Аз жаргалтай гэрлэлт болон аз жаргалтай гэр бүлүүд итгэл, залбирал, наманчлал, уучлал, хүндэтгэл, хайр энэрэл, өрөөч сэтгэл, ажил хөдөлмөр болон гэр бүлээрээ эрүүл саруул, идэвхтэй амрах үйл ажиллагааны зарчмууд дээр оршин аж төрдөг. Бурханлиг загвараар, эцэг нь өрх гэрээ хайр, зөв шударга ёсоор тэргүүлэн удирдаж, амьдралын хэрэгцээт зүйлсээр ханган, гэр бүлээ хамгаалах үүрэгтэй. Эхийн үндсэн үүрэг бол хүүхдүүдээ хайраар өсгөн хүмүүжүүлэх явдал юм. Энэхүү ариун үүргээ биелүүлэхдээ эцэг эхчүүд харилцан бие биедээ адил тэгшээр туслах ёстой. Тахир дутуу болох, нас нөгчих болон бусад нөхцөлд хувь хүн зайлшгүй дасан зохицох шаардлага гарч болно. Төрөл төрөгсөд нь хэрэгтэй үед туслан дэмжжээл зохино.



8. “Ариун явдлын гэрээгээ зөрчин, хань ижил, үр хүүхдүүдэд зүй бусар харьцсан, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлээгүй хувь хүн хожмын нэг өдөр Бурханы өмнө өгч мэдүүлэх болно гэдгийг бид анхааруулж байна. Түүнчлэн, гэр бүлээ сарниулбал, эрт эдүгээгийн бошиглогчдын угтан хэлснээр хувь хүн, нийгэм, улс үндэстнүүдэд гай гамшиг авчирч гэдгийг бид сануулж байна.

9. “Итгэл хүлээсэн иргэд, төрийн албан хаагч та бүхнийг нийгмийн үндсэн нэгж болох гэр бүлийг бэхжүүлэн авч явах эдгээр арга замыг үргэлж хэрэгжүүлэгчтүн хэмээн бид уриалан дуудаж байна” (Ensign, 1995 оны 11-р сар, 102).

Уншсанаа ойлгох нь



Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг

Хүндэтгэлтэйгээр (догол мөр 1)—Буурь суурьтай болон хүндэтгэлтэйгээр Өсөн нэмэгдэж, өнөр өтгөн болох (догол мөр 4)—Хүүхдүүдтэй болж, газар дэлхийг бүрхэх Үр удмаа үлдээх (догол мөр 4)— Хүүхэдтэй болох чадвар

Уншсанаа судлах нь



“Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий

А Нэг догол мөрийг цээжил

Тунхаг дахь есөн догол мөрөөс аль нэгийг нь сонгож, цээжил. Хэрэв тусламж хэрэгтэй бол Тунхагийн нэг хувийг харж, уг догол мөрийг гурван удаа бичих замаар үүнийг цээжилж болно. Дараа нь гэр бүлийнхээ нэг гишүүнээр хянуулж, догол мөрийг цээжээр бич. Эсвэл үүнийг нэлээд хэдэн удаа давтан хэлэхдээ, тусламж хэрэгтэй бол тунхгийг харж болно. Дараа нь үүнийг гэр бүлийнхээ нэг гишүүнд цээжээр давтан хэл.

Б Тохируулах дасгал

Тэмдэглэлийн дэвтэртээ 1–9-ийн тоонуудыг доош нь жагсаан бичээд дараах сэдэв бүрийг “Гэр бүл: Дэлхий Дахинаа Өргөх Тунхаг”-ийн есөн догол мөрийн аль нэгтэй тохируул. Зарим догол мөр нэгээс илүү олон сэдвээрх сургаалуудыг агуулж болно.

- | | |
|---|--|
| а. Үр зулбуулалт | й. Бурханы шүүлтүүд |
| б. Гэр бүлийн үдэш | к. Нас барагсдын өмнөөс хийх ариун сүмийн ажил |
| в. Хүүхдүүдийг сахилгатай болгох | л. Бурханаас өгөгдсөн бэлгийн харилцааны хүсэл |
| г. Өвөө эмээ, ач зээ нарыг хамарсан гэр бүл | м. Хүний амь бүрэлгэхийг өршөөх |
| д. Эцэг болох | н. Төрөлтөд хяналт тавих |
| е. Ижил хүйстний гэрлэлт | о. Авралын төлөвлөгөө |
| ё. Ариун сүмийн гэрлэлт | ө. Амиа хорлох |
| ж. Гэрлэлт дэх жендерийн үүрэг | п. Төр засгийн хуулиуд |
| з. Гэр бүлээрээ шийдвэр гаргах | р. Хүүхэдтэй зүй бус харьцах |
| и. Садар самуун | с. Гэр бүл салалт |

В Бат бөх гэрлэлт бий болгон төлөвшүүлэх санаануудыг жагсаан бич

1. Аз жаргалтай гэрлэлт, аз жаргалтай гэр бүлийн хувьд чухал гэж өөрийнхөө боддог арван санааг гэр бүлийн тунхгийн догол мөр 7-гоос жагсаан бич.
2. Эдгээр санаа тус бүрийг баримтлахын тулд та юу хийх гэж байгаагаа, эсвэл юу хийхээр бодож байгаагаа товчхон дүрсэл. Жишээ нь: Залбирал-Би хувиараа бас гэр бүлтэйгээ хамт залбирдаг.

Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, зүрхний нэрд гарсан мэс засалч, Ахлагч Рассел М. Нелсон:

“1984 оны дөрөвдүгээр сард би эмнэлгийн мэс заслын өрөөг орхиж, ариун сүмийн дээд өрөөнд орсноор хүний зүрхийг сонирхох насан туршийн сонирхолд минь хүсэн хүлээж байгаагүй эргэлт гарсан юм. Би тийнхүү Их Эзэн Есүс Христийн томилогдсон Төлөөлөгч болсон билээ. Би ийм дуудлагыг эрэлхийлж байсангүй. Гэвч эдүгээ би мэс засал хийж байсан шигээ хүний зүрхийг сүнслэг байдлын хувьд засч залруулахын тулд Түүний төлөөлөгч байх энэхүү итгэл, онцгой боломжид тэнцэхээр зохистой байхыг даруухнаар хичээдэг билээ.

“Би Их Эзэнийхээ 15 тусгай гэрчийн нэгнээр дуудагдан, дэмжигдэн батлагдаж, томилогдсон хүний хувьд Мормоны Номын дараах амин чухал сэдвийг баримталдаг: ‘Бид Христийн тухай ярьж, бид Христэд баясч, бид Христийн талаар номлож, [мөн] бид Христийн тухай бошиглодог’ хэмээн бичжээ (2 Нифай 25:26)” (“Jesus the Christ : Our Master and More,” Ensign, 2000 оны 4-р сар, 4).



Амьд Христ:Төлөөлөгчдийн гэрчлэл

Дараах гэрчлэл 2000 оны нэгдүгээр сарын 1-нээр хаяглагдсан бөгөөд Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд гарын үсэг зуржээ:

1. “Хоёр мянган жилийн тэртээх Есүс Христийн төрөлтийг бид ёслон тэмдэглэхдээ, юутай ч эгнэшгүй Түүний амьдралын бодит үнэн болон Түүний агуу цагаатгагч золиослолын хязгааргүй ариун нандин чанарын тухай гэрчлэлээ бид хэлж байна. Дэлхий дээр амьдарч байсан болон ирээдүйд амьдрах бүх хүмүүст ийм гүнзгий нөлөөг өөр нэг ч хүн үзүүлээгүй билээ.

2. “Тэр бол Хуучин Гэрээний Агуу Иехова, Шинэ Гэрээний Мессиа байлаа. Тэрээр Эцэгийнхээ удирдлага дор, газар дэлхийг Бүтээгч болсон юм. Бүх юм Түүгээр бий болсон; бий болсон юмсаас Түүнгүйгэр бий болсон юм нэг ч байхгүй” (Иохан 1:3). Тэрээр нүгэлгүй байсан хэдий ч, зөвт байдлыг бүгдийг нь ном ёсоор гүйцэлдүүлэхийн тулд баптисм хүртсэн билээ. Тэрээр үүнийхээ төлөө ад шоо үзэгдсэн ч, ‘сайныг үйлдэж явсан юм’ (Үйлс 10:38). Түүний сайн мэдээ бол амар амгалангийн болон сайн санааны захиас байлаа. Тэрээр үлгэр жишээгээ дагахыг бүхнээс гуйдаг байв. Тэрээр Палестины замуудаар алхлан, өвчтэйг эдгээж, хараагүйг хардаг болгож, үхсэнийг амьдруулж явлаа. Үүрд мөнхийн үнэнүүдийг, бидний мөнх бус байдлын өмнөх оршихуйн үнэн бодитойг, дэлхий дээрх бидний амьдралын зорилгыг, түүнчлэн ирэх амьдрал дахь Бурханы хөвгүүд, охидын боломжийг Тэрээр заадаг байлаа.

3. “Тэрээр Өөрийн агуу цагаатгагч золиослолын сануулагч болгон ариун ёслолыг үндэслэн бий болгосон билээ. Тэрээр баривчлагдаж, зохиомол хэрэгт буруутгагдан, дургүйцсэн олны бахыг хангахын тулд яллагдаж, Калвариин загалмай дээр үхэхээр яллагдсан юм. Бүх хүн төрөлхтний нүглийг цагаатгахын төлөө Тэрээр амь насгаа өргөсөн билээ. Дэлхий дээр амьдарч байсан бүх хүмүүсийн төлөө тэдний өмнөөс төлсөн тэрхүү аугаа бэлгийг Тэрээр өгсөн юм.

4. “Бүх хүн төрөлхтний түүхэнд төв байрыг эзэлдэг Түүний амьдрал Бетлехемд эхлээгүй, Калвари дээр дуусаагүйг бид хүндэтгэлтэйгээр гэрчилж байна. Тэр бол Эцэгийн Ууган, махбодод Төрсөн Ганц Хүү, дэлхийн Гэтэлгэгч байлаа.

5. “Тэрээр ‘нойрсогсдоос анхны үр жимс болж’ (1 Коринт 15:20) булшнаас босч ирсэн юм. Тэрээр амилан босч ирсэн Их Эзэнийн хувьд амьдралдаа хайртай байсан хүмүүсийнхээ дунд хүрч ирсэн билээ. Тэр бас эртний Америк дахь Өөрийнхөө ‘бусад хонинуудын’ (Иохан 10:16) дунд үйлчилсэн юм. Орчин үеийн дэлхийд, Тэрээр Эцэгтэйгээ хамт Иосеф Смит хөвгүүн дээр хүрч ирэн, эрт дээр үеэс амлагдсан ‘цагийг дүүрний эрин үеийг’ (Ефес 1:10) эхлүүлсэн билээ.

6. “Амьд Христийн тухай Бошиглогч Иосеф бичсэн нь: ‘Түүний мэлхий галын дөл лүгээ адил байв. Тэргүүнийх нь үс цэвэрхэн цас лугаа адил цав цагаан байв. Нүүрнийх нь төрх байдал нарны хурц гэрлээс ч илүү гялалзан гэрэлтэж байв. Дуу хоолой нь их ус нүргэлэх лүгээ адил байв. Тийнхүү Иеховагийн дуу хоолой огулруун:

7. “Бибээр эхнийх мөн эцсийнх болой; Бибээр амьдардаг тэрээр болой, би бол алагдсан тэрбээр бөлгөө; бибээр Эцэгийн өмнө та нарын өмгөөлөгч билээ” (С ба Г 110:3–4) гэв.

8. “Түүний тухай Бошиглогч бас хэлсэн нь: ‘Мөн эдүгээ түүний талаар өгөгдсөн олон гэрчлэлийн дараа, энэ бол түүний талаар бидний өгөх, хамгийн сүүлчийн гэрчлэл бөлгөө: Тэр амьд!

9. “Учир нь бид түүнийг бүр Бурханы баруун гар талд харсан билээ; түүнчлэн тэрээр Эцэгийн Төрсөн Ганц болой хэмээн гэрчлэх дуу хоолойг бид сонссон юм

10. “Ийнхүү түүгээр, мөн түүгээр дамжин, мөн түүнээс, дэлхийнүүд бүтээгдсэн, бас бүтээгддэг ажгуу, мөн тэдгээрийн оршин суугчид нь Бурханы төрсөн хөвгүүд болон охид бөлгөө” (С ба Г 76:22–24).

11. “Түүний санваар болон Түүний Сүм дэлхий дээр сэргээгдэн-элч нар болон эш үзүүлэгчдийн суурин дээр босгогдож . . . Есүс Христ өөрөө булангийн чулуу нь болсныг” (Ефес 2:20) бид хүндэтгэлийн үгсээр тунхаглаж байна.

12. “Тэрээр нэгэн өдөр дэлхийд эргэж ирнэ гэдгийг бид гэрчилж байна. ‘Дараа нь ЭЗЭНий алдар илэрхийлэгдэж, бүх махан бие хамтдаа үзнэ’ (Исаиа 40:5). Тэрээр Хаадын Хаан болж захиран Эздийн Их Эзэн болж хаанчилна, мөн өвдөг бүхэн сөгдөж, хэл бүхэн Түүний өмнө шүтэн биширч ярих болно. Бид бүгд ажил үйлс, зүрх сэтгэлийнхээ хүслийн дагуу Түүгээр шүүгдэхээр зогсох болно.



13. “Есүс бол Амьд Христ, Бурханы үхэшгүй Хүү гэдгийг зохих ёсоор томилогдсон Түүний Төлөөлөгчдийн хувьд бид гэрчилж байна. Тэр бол өнөөдөр Эцэгийнхээ баруун гар талд зогсож байгаа аугаа Хаан Иммануел мөн. Тэр бол дэлхийн гэрэл, амь, найдвар юм. Түүний зам бол энэ амьдралд аз жаргал өөд, ирэх дэлхийд мөнх амьдрал өөд хөтөлдөг зам билээ. Түүний Хүүгийн ноутай ч зүйрлэшгүй бэлгийн төлөө Бурханд талархал өргөө” (Ensign, 2000 оны 4-р сар, 2–3).

АМЬД ХРИСТ

Төлөөлөгчдийн Гэрчлэл
Исүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм

Исүс Христ хөр минин эхний өмнө мөхсөнийг ирсэн хүнэлгээгээ бид Түүний зүйрлэлгүй амьдрал болон агуу аз палатгах золиослолын хэмжээнийг нь үзсэн болон үнэнхний гэрчилсэн. Дэлхий дээр амьдрал байсан ба амьдрал бүх хүмүүст ийн хүртэй нооноо хан ч үзүүлж байгаагүй.

Тэр бол Хуучин Гэрээний Агуу Жихова, Шинэ Гэрээний Мессиа билээ. Тэр бол Эцэгийнхээ удирдлага дор эхний бүтээсэн Бүтээгч. “Бүх юм Түүгээр бий болсон, Түүнгүйгэр бий болсон юм нэг ч үгүй” (Иохан 1:3). Нүгэлгүй ч Тэрээр бүх энэ илшлэрт өсөл гүйцэлдүүлэхээр үзэж батлуулсан. Түүнийг “иш сайныг үйлсээг”-д нь төлөө үзэж алаж байсан. Түүний арин суртал бол асар амилан ба сайн санааны зогсож байлаа. Тэр чин сэтгэлээсээ бүрхэн өргөх нь ижилжээ лугаа хүссэн билээ. Тэрээр Палестины замаар аж өвчтэй нэгтгэн алаж, сохор нэгтгэн хардагтай болж, үхсэн нэгтгэн амьдруулж байв. Тэрээр мөнх байсан, мөнх байсан өмнөх оршин болон үнэнхний, дэлхий дээр бидний амьдралын зоргодо болон ирэх амьдрал дахь Бурханы ихэнэ, хөвгүүдэн өмнө бөлмөжийн тухай элсэн.

Тэрээр Түүний агуу их палатгах золиослолын сануулагчаар ариун ёслолыг төгссөн. Түүний баривчлал гүтээгдэж алаж цугларсанг бэлч ханган илшлэж Түүнэ Калвариин загалмай дээр үхэх л өгссөн юм. Тэрээр бүх ч хүн төрөлхтний нүглийг цагаатгахын төлөө амьд өгсөн. Энэ бол хэзээд дэлхий дээр амьдрах бүх хүнч зорилго Түүний бэлч билээ.

Бүх хүн төрөлхтний түүний төв болж Батлагдсан төрөлхөөс өмнө ч, мөн Калвариин хойч ч амьдрал бүх Түүний амьдрал бид чин сэтгэлээсээ гэрчилж байна. Тэр бол Эцэгийн ууган, мөхсөний Шоран Ганц Хүү, дэлхийн Гэтэлгэгч юм.

Тэр бол “нойрсогсдоос эхний үр жимс” болохын тул үзэгдсэн амилан юм (1 Коринт.15:20). Тэрээр нэвчин өмнөх Их Эзэний хувьд амьдралын хайрцаг байсан хүмүүс дээр ирсэн. Тэрээр бас арин Америк бий бол “Есүс хониваар” (Иохан 10:16) үйлчилж үзүүлсэн. Орчин үеэс арингээ амилан “ага хууцланын бүрхэний эрин үе”-ийг

эцүүлэхээр Тэр бол Түүний Эцэг Жозеф Смит түүний өмнө гарч ирсэн юм (Ефес 1:10).

Түүний гур талын дөр мэт, толгойгоо үс нь цас мэт талын, шарай нь нарын туха мэт гэрэлтэж байв. Тэр бол анхны ба сүүлчийн, Тэр амьд, зунуулан Тэрээр Эцэгийнхээ өмнө бэлхийн өмгөөлөгч болно гэж хэлжээ Жозефынхээ хөвгүүдтэй адил Түүний хөвгүүд агуу их усны нүргэлжээр цас мөхөө мэт байсан гэж Амьд Христийн тухай бошиглогч Жозеф бичсэн (С ба Г 110:3–4 үр).

“Арагийн тухай өмнө гэрчиллийн шарай “Тэр амьд” гэсэн амьдүү гэрчил бол хамгийн сүүлчийн нь юм.” хэмээн бошиглогч бас тунхагласан.

“Учир нь бид Түүнийг Бурханы баруун гар талд байсан гэсэн ба “Тэр бол Эцэгийн Шоран Ганц Төрсөн Хүү” Тэрээр, Түүгээр замлуулсан, Түүнээс дэлхий өргөтгөж бүтээсэн бөгөөд бүтээгдэж, гэгээрийн оршин хурчид нь Бурханы төрсөн охин, хөвгүүд нь болж юм.” хэмээн гэрчилж агуу бэлч өгссөн (С ба Г 76:22–24 үр).

“Исүс Христ өөрийн биеэр түлгүүр хүмүү нь босж төлөөнийг, бэлшлэгчид . . . сүүрэн явж бариган” Сүм болон ирээний зорго нь дэлхий дээр нэвчин сэрээлсэн гэж бид чин сэтгэлийнхээ үгээр мэлжлэж байна (Ефес 2:20).

Түүнийг хэзээ нэгэн илт шалхыг асар эрхэж ирээ гэж бид гэрчилж байна.

“Шарай нь Эцэний алар илэрхийлэгчээ бүх мөхсөн хамтдаа Түүнийг үзнэ” (Исайа 40:5). Тэрээр Хаадын Хаан хүнд удирдаж Эцэгийнхээ хувьд хангалт болно. Тэрээр Түүнийг шурган “амьд бүхэл сонгож хан бүрхээр ирэх болно.” Хүү бүр Түүний өмнө хайсан эхэн хэрэг, зүрх сэтгэлээсээ агуулан хүснэгтээ агуу шургалж болно.

Бид, Түүний энэ төлөөний Төлөөлөгчдийнх нь хувьд Исүс бол амьд Христ, Бурханы үхэшгүй Хүү хэмээн гэрчилж байна. Тэр бол өнөөдөр Эцэгийнхээ баруун гар талд зогсож буй агуу Иммануел Хаан. Тэр бол дэлхийн гэрэл, амьдрал ба итгэл найвар. Түүний зам бол энэ амьдрал аз жаргал үрүү хөтлөх зам болохын дээр эринийн амилан амьдрал үрүү хөтлөх жили юм. Тэгвэлгээ Хүүгийнх нь зүйрлэлгүй бэлхийнх нь төлөө Бурханд талархал өргөө.

ТЭРҮҮНИ ЗӨВЛӨЛ

Joseph Smith
Mormon
James E. Smith

III/1, 2000

АРВАН ХОЁРНИЙ ЧУУЛГА

Brigham Young
Robert B. Taylor
Amos A. Phelps
Amos A. Phelps
Amos A. Phelps
Allen B. Derby

M. Russell Ballard
Boyd K. Packer
Richard L. Evans
John A. Tanner
Robert A. Phillips

Уншсанаа ойлгох нь

Амьд Христ : Төлөөлөгчдийн гэрчлэл

Ёслол тэмдэглэх (догол мөр 1)—Тэмдэглэх, дурсан санах

Зохиомол (догол мөр 3)—Худал хуурмаг

Хүндэтгэлтэйгээр (догол мөр 4)—Буурь суурьтай бөгөөд хүндлэлтэйгээр

Нойрсогсдын анхны үр жимс (догол мөр 5)—Хамгийн түрүүнд амилуулагдсагд

Та нарын өмгөөлөгч
(догол мөр 7)—Та нарын
өмнөөс ярьдаг хүн

Төрсөн (догол мөр 10)—
Сүнсээр дахин төрсөн

Махан бие (догол мөр 12)—
Хүмүүс

Зохих ёсоор (догол мөр
13)—Зохих журмын дагуу,
албан ёсоор

(Догол мөр 4, 9—“Төрсөн Ганц Хүү”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Жозеф Б. Вертлин: “Есүс мөнх бус байдалд төрөхөд Түүний эцэг эх нь, Бурхан Мөнхийн Эцэг (1 Нифай 11:21-ийг үз), тэнгэрлэг үзэгдэлд Нифайн харсан Мариа хоёр байлаа. . . . Тэр бол Бурханы Төрсөн Ганц Хүү, ийм эцэг эхэд газар дэлхий дээр өмнө нь төрөөгүй, дахин төрөхгүй цорын ганц хүн юм. Эхээсээ өвлөн авсан түүний мөнх бус байдлын улмаас ‘бие, сүнс хоёр салх . . . үхэх хүч болох мөнх бус байдлын хүч’ түүнд байсан юм [Брус Р. МакКонки, *The Promised Messiah*, 471]. Эцэгээсээ өвлөн авсан бурханлиг мөн чанарын улмаас ‘үүрд мөнхөд амьдрах хүч, үхэшгүй байдлын хүч; эсвэл, үхлийг сонгоод, . . . үхэшгүй байдалд дахин босч ирэх хүч түүнд байсан юм’ хэмээн сургажээ [*Promised Messiah*, 471]” (In Conference Report, 1993 оны 10-р сар, 5; *Ensign*, 1993 оны 11-р сар, 6).

(Догол мөр 5—“Цаг хугацааны бүрэн байдлын эрин үе” гэж юу вэ?

“Жозеф Фиелдинг Смитийн сургаал ба гэрчлэл” (х.00 204) догол мөр 13-ын “Уншсанаа ойлгох нь” хэсгийг үз.

Уншсанаа судлах нь

“Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл”-ийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас хоёрыг хий

А Нэрнүүд

1. “Амьд Христ: Төлөөлөгчдийн гэрчлэл”-ийг нэгтгэн дүгнэж, Есүс Христэд зориулж Төлөөлөгчдийн хэрэглэсэн наад тал нь арван нэрийг жагсаан бич.
2. Жагсаалт дахь нэр бүрийн дараа эдгээр нэр тус бүр нь Аврагчийн тухай та нарт юу зааж байгааг товч тайлбарла.
3. Нэг нэрийг сонгож, уг нэр яагаад өөрт чинь чухал болохыг тайлбарла.

Б Төлөөлөгчийн үүрэг зорилго юу вэ?

1. Сургаал ба Гэрээ 107:23-ыг уншиж, “Төлөөлөгч бол . . .” гэсэн өгүүлбэрийг тэмдэглэлийн дэвтэртээ гүйцээ.
2. “Амьд Христ”-ийн догол мөр 1, 4, 11–13-ыг нэгтгэн дүгнэж, Сургаал ба Гэрээ 107:23-т дурдсан үүрэг хариуцлагаа биелүүлж байгаа талаар Төлөөлөгчдийн хэрэглэсэн өгүүлбэрүүдийг жагсаан бич.

В Амьд Христ

1. Амьд Христийн тухай гэрчлэлээ бич.
2. Есүс бол амьд Христ гэдгийг хэрхэн мэдсэн тухайгаа тайлбарласан богинохон догол мөр бич.

Итгэлийн Тунхаг

Бид юунд итгэдэг вэ?



1842 онд Жон Вентворт хэмээх нэг сонин эрхлэгч Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн түүх болоод итгэл бишрэлийн тухай Бошиглогч Иосеф Смитээс асуужээ. “Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн өсөлт хөгжилт, мөрдлөг хавчлага болон итгэл бишрэлийг” (History of the Church,

4:535) тайлбарласан захидлыг Бошиглогч түүнд бичжээ. Сүмийн зарим сургаал болон итгэл бишрэлийн тухай арван гурван богинохон мэдэгдлийг тэрээр оруулжээ. Эдгээр мэдэгдлүүд Итгэлийн Тунхаг гэж нэрд гарсан бөгөөд 1880 оны аравдугаар сарын ерөнхий чуулганы үеэр судар хэмээн хүлээн зөвшөөрөгджээ (Агуу Үнэт Судвын Оршлыг үз).

Итгэлийн Тунхагийн тухай Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Том Перри:

“Итгэлийн тунхаг нь манай шашны зарчмуудын тухай шууд, энгийн мэдэгдлүүдийг агуулдаг бөгөөд Бошиглогч Иосеф Смитэд байсан бурханлиг сүнсний нөлөөний хүчирхэг нотолгоо болдог билээ.

“Итгэлийн Тунхаг болон үүнд агуулагдсан сургаалуудыг та нарын хүн нэг бүр судлахыг би урамшуулан дэмжиж байна. . . . Хэрэв та нар Аврагчийн сургаалыг судлахдаа уг тунхгийг шууд удирдамж болгон ашиглах юм бол, сэргээгдсэн, Их Эзэний үнэн Сүмийн тухай гэрчлэлээ илэрхийлэхэд өөрсдийгөө бэлтгэх болно. ‘Бид эдгээр зүйлүүдэд итгэдэг’ гэж та нар итгэл үнэмшилтэйгээр тунхаглах боломжтой байх болно” гэжээ (In Conference Report, 1998 оны 4-р сар, 30; *Ensign*, 1998 оны 5-р сар, 24).

Судруудыг ойлгох нь

Итгэлийн Тунхаг

Зөрчил (ш. 2)—Зарлигийг зөрчих

Ангижрал (ш. 4)—Уучлал

Бошиглол (ш. 5)—Илчлэлт

Анхны Сүм (ш. 6)—Шинэ зөрчийн үед зохион байгуулагдсан Сүм

Хамаарагдах (ш. 9)—Талаарх

Диваажингийн алдар суу (ш. 10)—Едений Цэцэрлэгийнх шиг нөхцөл

Ухамсар (ш. 11)—Зөв буруугийн тухай дотоод мэдрэмж

Итгэлийн Тунхаг 1:1—Бурхан тэргүүтэн

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн Ахлагч Даллин Х. Өүкс: “Бид Христэд итгэгчдийн үлдсэн хэсэгтэй адилхан Бурхан тэргүүтэн-Эцэг, Хүү, Ариун Сүнсэнд итгэдэг. Гэвч, Бурхан тэргүүтний эдгээр гурван гишүүн бол гурвуул тусдаа, ялгаатай хүмүүн биес гэдгийг бид гэрчилдэг. Бурхан Эцэг бол зүгээр л нэг Сүнс биш, харин Түүний амилсан Хүү, Есүс Христэй адил, бодит биетэй, сүр жавхлан төгс хүн гэдгийг бид бас гэрчилдэг” гэж хэлжээ (In Conference Report, 1995 оны 4-р сар, 112; *Ensign*, 1995 оны 5-р сар, 84; мөн С ба Г 130:22-ыг үз).

Итгэлийн Тунхаг 1:2—Адам Ева хоёрын Уналт

Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн байсан Ахлагч Жеймс И. Фауст:

“Зөрчлийнхөө улмаас, Адам Ева хоёр гэнэн цайлган байдлаа орхихоор сонгож, (2 Нифай 2:23—25-ыг үз), Бурханы оршихуйгаас таслагдсан [хөөгдсөн] юм. Энэ нь Христийн ертөнцөд Уналт буюу Адамын зөрчил хэмээн нэрлэгддэг. Адам Ева хоёр Бурханы оршихуйгаас тусгаарлагдсан учир энэ бол сүнсний үхэл юм. . . .

“Тэдний бүх үр удам бас Бурханы оршихуйгаас таслагдсан билээ (2 Нифай 2:22–26-г үз). Гэвч, Адам Ева хоёрын үр удам анхны нүгэлд [хориглосон жимснээс хүртсэн] гэм буруугүй юм. Учир нь тэд үүнд оролцоогүй билээ. Иймээс бүх хүн төрөлхтөн анхныхаа эцэг эх, Адам Ева хоёрын зөрчлийн улмаас үүрд мөнхөд зовлон эдлэх нь шударга бус юм. Энэхүү шударга бус явдлыг шийдвэрлэх шаардлагатай байсан юм. Үүнээс үүдэн Аврагч, Гэтэлгэгч Есүсийн цагаатгагч золиослолын хэрэгцээ бий болсон юм” хэмээн сургажээ (In Conference Report, 1988 оны 10-р сар, 13–14; *Ensign*, 1988 оны 11-р сар, 12; мөн Дэд Хууль 24:16-г үз).

Итгэлийн Тунхаг 1:3—Есүс Христийн Цагаатгал

Ахлагч Даллин Х. Өүкс сургасан нь:

“Бидний Аврагч Адамын нүглээс биднийг гэтэлгэсэн юм. Харин бидний өөрсдийн нүглийн тухайд яах ёстой вэ? ‘Бүгд нүгэл үйлддэг’ (Ром 3:23) учраас, сүнслэг байдлын хувьд бид бүгдээрээ үхмэл байдаг. Дахин хэлэхэд, амьдралын төлөөх бидний цорын ганц найдвар бол, ‘хуулийн шаардлагуудыг хангаж, нүглийн золиослол болгон өөрийгөө өргөснийг’ (2 Нифай 2:7) бошиглогч Лихайн заасан бидний Аврагч юм.

“Нүглийн улмаас бидэнд учирдаг сүнсний үхлийг ялгууснаар даван туулж амь насаа өргөсөн, бидний Аврагчид найдлага тавихын тулд түүний тодорхойлсон нөхцөлүүдийг бид дагах ёстой. . . .

“Итгэлийн гурав дахь тунхаг Аврагчаас бидэнд тавьдаг нөхцөлүүдийг дүрсэлдэг” (In Conference Report, 1987 оны 10-р сар, 77; *Ensign*, 1987 оны 11-р сар, 65; мөн С ба Г 19:16–19-ийг үз).

Итгэлийн Тунхаг 1:4—“Сайн мэдээний анхдагч зарчмууд ба ёслолууд”

Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Ховард В. Хантер:

“Энэ дөрөв нь [Итгэлийн Тунхаг 1:4-ийн зарчмууд ба ёслолууд] сайн мэдээний бүх зарчим болон ёслолуудын зөвхөн

анхдагч нь юм. Нифайчуудад Аврагчийн хэлсэн үгсийг авч үзвэл, энэ дөрвийг гүйцэлдүүлсний дараа Их Эзэний хуулиуд болон зарлигуудыг насан туршдаа сахиж ёстойг бид мэддэг. Учир нь, ‘. . . мөн хэрэв тэр эцсийг хүртэл тэвчих аваас, болгоогтун, би дэлхийг шүүхээр зогсох тэр өдөр Эцэгийнхээ өмнө түүний гэмгүйг үнэлэх болно’ хэмээн тэрээр хэлжээ (3 Нифай 27:16).

“Анхдагч зарчмууд дангаараа хангалтгүй юм. Хүн үүнээс хойш амьдралд үйлдсэн зүйлээрээ, сайныг эсвэл хилэнцэгийг үйлдсэнийхээ төлөө мөнхийн шүүлтэд хариуцлага хүлээх болно” хэмээн сургажээ (In Conference Report, 1973 оны 4-р сар, 175; *Ensign*, 1973, 120; мөн 2 Нифай 31:10–15-ыг үз).

Итгэлийн Тунхаг 1:5—Бид хэрхэн Бурханаас дуудагддаг вэ?



Ерөнхийлөгч Гордон Б. Хинкли: “Нэр дэвшүүлэх [гишүүдийг Сүмийн дуудлагуудад] эрх дээд тушаалын ажилтанд, бас аль ч түвшний ажилтнуудад байдаг. Гэвч энэ нь юу гэсэн үг вэ гэвэл-уг нэр дэвшүүлэлт Сүмийн гишүүнчлэлээр хүлээн зөвшөөрөгдөж, батлагдах ёстой гэсэн үг. Эл журам Их Эзэний Сүмийн хувьд өвөрмөц юм. Энд албан тушаалд шимтэн, албан тушаалын хойноос хөөцөлддөггүй, хүний давуу талыг сурталчлах кампанит ажил байдаггүй. Их Эзэний арга зам дэлхийн арга замын эсрэг юм. Их Эзэний зам нам гүм байдаг. Энэ бол амар амгалангийн зам. Энэ бол сүржин дуулиангүй буюу мөнгөөр үнэлэгддэггүй зам. Аминч үзэл, нэр төр хөөцөлдөх нь энд байдаггүй. Их Эзэний төлөвлөгөөгөөр, ажилтнуудыг сонгох хариуцлага хүлээсэн хүмүүс: ‘Их Эзэн хэнийг сонгох бол?’ гэсэн шийдвэрлэгч ганцхан асуултыг удирдлага болгодог. Энд анир чимээгүй, буурь суурьтай хэлэлцүүлэг болдог. Мөн сонголт зөв гэдгийг нотлох Ариун Сүнсний баталгааг хүлээн авахын тулд их залбирдаг” гэж хэлжээ (In Conference Report, 1994 оны 4-р сар, 73; *Ensign*, 1994 оны 5-р сар, 53; мөн Еврей 5:4-ийг үз).

Итгэлийн Тунхаг 1:6—Үнэн Сүмийн зохион байгуулалт

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Петр Б. Хейт: “Энэ Сүм бол Христийн Сэргээгдсэн Сүм гэдгийг Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм дэлхий дахинд тунхаглаж байна. Их Эзэний анхны Сүмийн суурь байсан бошиглогчид, Төлөөлөгчид алагдсан, эсвэл авагдсан учраас Сэргээлт зайлшгүй байлаа. Өнөөдөр Сүм Есүс Христ гол тулгуурын чулуу нь болсон, бошиглогчид, Төлөөлөгчдийн суурин дээр баригдаж байна. Иймээс хэрэв

шинэчлэлт, засварлалт, өөрчлөн зохион байгуулалт байгаагүй бол ердөө л нэг бүлэглэл болох байв. Энэ бол хожмын өдрүүдэд сэргээгдсэн Есүс Христийн Сүм” гэж гэрчилжээ (In Conference Report, 1986 оны 4-р сар, 7; *Ensign*, 1986 оны 5-р сар, 7; мөн Ефес 4:11–14-ийг үз).

Итгэлийн Тунхаг 1:7—Сүнсний бэлгүүд

Ахлагч Даллин Х.Өүкс сургасан нь:

“Санваарын адислалд Их Эзэний үйлчлэгч, адислагдаж байгаа хүний ашиг тусын төлөө тэнгэрийн хүчнүүдийг дуудахын тулд Ариун Сүнсээр нөлөөлөгдсөний дагуу санваарыг ашигладаг. Ийм адислалуудыг Сүмийн сүнсний бүх адислалын түлхүүрийг эзэмшдэг Мелкизедек санваартнууд өгдөг (С ба Г 107:18, 67-г үз).

“Санваарын олон төрлийн адислал байдаг. Янз бүрийн жишээг дурдъя, харин санваарын адислал хэрэгтэй байгаа бүх хүмүүст адислал хүртээмжтэй боловч, адислалыг зөвхөн хүн өөрөө хүссэн үед өгдгийг санагтун. . . .

“Чухал шийдвэр гаргахад удирдамж хүсч байгаа хүмүүс санваарын адислал хүлээн авч болно. Тохиолдсон сорилтыг даван туулахад сүнсний илүү их хүч хэрэгтэй байгаа хүмүүс адислал хүлээн авч болно. Жирэмсэн эхчүүд төрөхийнхөө өмнө адислал хүлээн авч болно. Гэрлэх гэж байгаа хүү буюу охиндоо зохистой эцэг хүн санваарын адислал өгдгийг ХҮГ олон гэр бүл санаж байгаа. Хүүхэд нь сургууль, цэрэгт орох, урт хугацааны аяллаар явах зэрэг бусад зорилгоор гэрээсээ хол явахын өмнө ааваасаа санваарын адислал хүсэх нь олонтаа тохиолддог. . . .

“Энд миний дүрсэлсэн тохиолдлуудад өгөгддөг адислалыг заримдаа тайтгарлын адислал эсвэл зөвлөгөө гэж нэрлэдэг. Эдгээр адислалыг эцэг, нөхөр эсвэл гэр бүлийн доторх бусад ахлагч нар өгдөг. Адислалыг тэмдэглэж, адислагдсан хүмүүс сүнсний удирдамжийг хувиараа авч болохын тулд гэр бүлийн цэдэгт хадгалдаг” (In Conference Report, 1987 оны 4-р сар, 44; *Ensign*, 1987 оны 5-р сар, 36; мөн С ба Г 46:11–26-г үз).

Итгэлийн Тунхаг 1:8—Судруудаас хамгийн их хүчийг бид хэрхэн авч чадах вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли: “Ариун Библийн энэхүү гайхалтай хамтрагч Мормоны Номын талаарх гэрчлэлийнхээ төлөө би Бүхнийг Чадагчид баярлан талархаж явдаг. . . . Энэ номыг уншаад үзэхэд ийм гэрчлэл төрөх болно. Би энэ номыг дахин дахин уншиж, сайхныг нь, гүн гүнзгийг нь, хүчийг нь амтлан мэдэрсэн хүний хувьд ярьж байна. Сургуульд сураагүй, ихэнхдээ Нью-Йоркийн захад хөдөө өссөн залуу хүн Иосеф Смит, ийм богинохон хугацаанд, мөн чанараараа ихэд нарийн, үй олон баатруудтай, цар хүрээгээрээ ийм өргөн, өдий том хэмжээний ботийг бүхэлд нь ийм их зохицолтойгоор хэлж бичүүлж чадах байсан уу? гэж би та нараас асууя. Дэлхий даяар сая сая хүмүүс энэ номыг уншаад, “Энэ үнэн үү?” гэж хэлэхэд хүргэдэг эл номны хэл, бодрол, сүнсний хүчтэй нөлөөг тэрээр зөвхөн өөрийнхөө чадвараар бий болгож чадах байсан уу?” хэмээн асуужээ (In Conference Report, 1993 оны 10-р сар, 71; *Ensign*, 1993 оны 11-р сар, 51–52; мөн Езекиел 37:15–17-г үз).

Итгэлийн Тунхаг 1:9—Бид илчлэлт үргэлжилж байгаад итгэдэг

Ахлагч Петр Б.Хейт хэлсэн нь:

“Сүмийн ялгарах нэг онцлог нь Их Эзэнээс илчлэлт үргэлжлүүлэн хүлээн авдагт байдаг. . . . Өнөөдөр, Их

Эзэний Сүм өмнөх эрин үеүдэд байсан, Бурхантай харилцах тийм харилцаагаар удирдуулж байгаа билээ.

“Бид ийнхүү мэдэгдэхдээ хөнгөн хуумгай ханддаггүй. Илчлэлт байгааг би мэднэ. Түүний ажлыг гүйцэтгэдэг бусад хүмүүсийн биеэр туулсан ариун зүйлсийн гэрч нь би байна.

“Ариун Сүнсээр ирдэг илчлэлтийн зарчим бол Их Эзэний Сүмийн тулгуур зарчим мөн. Энэ үйл явцаар Бурханы бошиглогчид илчлэлт хүлээн авдаг. Үнэнийг нотлохын тулд Сүмийн гишүүд бас хувиараа илчлэлт хүлээн авч болно” (In Conference Report, 1986 оны 4-р сар, 7; *Ensign*, 1986 оны 5-р сар, 7–8; мөн Амос 3:7-г үз).

Итгэлийн Тунхаг 1:10—Цуглуулагдсан Израилд Христ хаанчлах болно

Ерөнхийлөгч Спенсер В.Кимбалл сургахдаа: “Эдүгээ, Израилын цугларалт гэдэг бол үнэн Сүмд нэгдэх болон хүмүүс үнэн Бурханы тухай мэдэх явдал мөн. . . . Иймээс, сэргээгдсэн сайн мэдээг хүлээн авсан, эдүгээ Их Эзэнийг төрөлх хэлээрээ, аж төрдөг улс орныхоо Гэгээнтнүүдийн хамт шүтэн бишрэхийг эрэлхийлдэг, Израилын цугларалтын хуулийг хэрэгжүүлж байгаа хэн боловч, энхүү эцсийн өдрүүдэд Гэгээнтнүүдэд амлагдсан бүх адислалыг өвлөгч юм” гэжээ (*Teachings of Spencer W. Kimball*, 439).

Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан Ахлагч Жорж Альберт Смит: “Хэрэв бид Түүнийг дээдлэн хүндэлж, зарлигуудыг нь сахих юм бол, хэрэв бид Түүний хуулиудыг дагах юм бол, Тэр бидний талд тулалдаж, ёс бусчуудыг устгах болно. . . . Бидний аж төрдөг энэ дэлхий селестиел хаант улс болно гэдгийг Бурхан айлдсан юм” гэжээ (In Conference Report, 1942 оны 10-р сар, 49; мөн С ба Г 45:64–71-ийг үз).

Итгэлийн Тунхаг 1:11—Шүтэн бишрэх эрх чөлөө

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Брус Р. МкКонки: “Бид бүх хүмүүсийн шүтэн бишрэх эрх чөлөөнд итгэдэг. Энэ эрх чөлөөг талархан сайшааж, өндөрт өргөн, дэмжлэг үзүүлж, өмгөөлөн хамгаалдаг. Хүмүүсийн шүтэн бишрэх эрх чөлөөг нэг бол үгүйсгэдэг, эсвэл аль нэг шүтэн бишрэх тогтолцоо буюу арга замыг сонгож, тэдэнд хүчээр тулдаг аливаа засгийн газар, улс төрийн тогтолцоо, шашны бүлэглэл, сүсэг бишрэлтнүүдийн бүлэг бол Бурханых биш юм” гэж бичжээ (*A New Witness for the Articles of Faith*, 657; мөн Алма 21:22-ыг үз).

Итгэлийн Тунхаг 1:12—Улс орныхоо хуулийг дээдлэн сахих нь

“Сүмийн бүх гишүүд амьдардаг улс орныхоо хуулийг дуулгавартай сахиж, дээдлэн хүндэлдэг байх ёстой. Бид өөрсдийгөө удирддаг төр засагт дуулгавартай байдгаараа үлгэр дуурайл үзүүлэх ёстой. Сүм дэлхийн үндэстнүүдэд үйлчлэхийн тулд, Сүмийг баяртайгаар хүлээн авсан хувь хүмүүсийн амьдралд түүнчлэн материаллаг болон сүнслэг үйл хэргүүдэд нь эрүүл саруул нөлөө үзүүлдэг байх ёстой” гэж Ахлагч Л.Том Перри хэлсэн байдаг (In Conference Report, 1987 оны 10-р сар, 86; *Ensign*, 1987 оны 11-р сар, 71; мөн С ба Г 134:1, 5-ыг үз).

Итгэлийн Тунхаг 1:13—Би хэрхэн ариун журамтай байж чадах вэ?

Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли:

“Дэлхий ариун журамд хөнгөн хуумгай ханддаг цаг үед бид аж төрж байна. . . .



“Цэвэр ариун бай. Уншдаг зүйлээ хар. Порнографийн сэтгүүлд буюу ийм бусад ном хэвлэлийг уншсанаас бузар булай, мангасын хор хөнөөлтэй зүйл л ирнэ. Ийм зүйл сахилгыг чинь эсвэл өөрийг чинь зөвхөн судруулан доройтуулах бодол санааг л дотор сэтгэлд чинь өдөөх болно. Мөнгийг чинь салгаж аваад, хариуд нь зөвхөн сэтгэлийн сул дорой, донтсон хүслийг төрүүлдэг кинонд явснаас сайн юм юу ч ирэхгүй” гэж зөвлөжээ (In Conference Report, 1981 оны 10-р сар, 58–59; Ensign, 1981 оны 11-р сар, 41; мөн Филиппой 4:8-ыг үз).

Итгэлийн Тунхагийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас тавыг хий.

Судруудыг судлах нь

Итгэлийн Тунхагийг судлахдаа дараах үйл ажиллагаануудаас тавыг хий.

А Бид юунд итгэдэг тухай асуултуудад хариулах нь

Сүмийн гишүүн бус найз нар чинь өөрөөс чинь асуусан эсвэл гишүүн бус хүмүүс асууж болно гэж өөрийнхөө бодсон таван асуултыг бич. Асуулт бүрд, үүнд хариулахад ашиглаж болох Итгэлийн Тунхагийг жагсаан бич. Жишээ нь, гишүүн бус хүн, “Хожмын Үеийн Гэгээнтнүүд Есүс Христэд итгэдэг үү?” гэж асууж болно. Энэ асуултанд Итгэлийн Тунхаг 1:1, 3, 4, 6, 8, 10-аар хариулж болно.

Б Итгэлийн Тунхагийг цээжлэх нь

“Хэрэв Сүмийн гишүүн бүр Итгэлийн Тунхагийг цээжилж, тунхаг бүрд агуулагддаг зарчмуудын тухай мэддэг байвал энэ нь хэчнээн агуу адислал болохсон билээ” гэж Ахлагч Том Перри хэлжээ (In Conference Report, 1998 оны 4-р сар, 28; Ensign, 1998 оны 5-р сар, 23).

1. Итгэлийн Тунхагийг цээжлэх нь амьдралд чинь хэрхэн адислал болж чадахыг тайлбарласан товчхон нэг догол мөр бич.
2. Итгэлийн арван гурван Тунхагаас дөрвийг нь цээжилж, эдгээрийг бичих буюу гэр бүлийнхээ нэг гишүүнд давтан хэл.

В Итгэлийн Тунхагийг заах нь

Гэр бүлдээ буюу өөр нэг бүлэгт Итгэлийн Тунхагийн аль нэгнийг нь утгыг заах арван таван минутын хичээл бэлтгэ. Судрын түүхүүд, судрын эшлэл, асуулт, хувь хүний туршлага, зураг, эд юмс буюу энэ хичээлийг заахад туслах өөрийнхөө гэрчлэлийг ашигла.

Г Дууллууд ба Итгэлийн Тунхаг

Итгэлийн Тунхаг бүрд Дууллын Ном, Хүүхдийн Хэсгийн Дууны номыг ашиглан, адил үнэн буюу адил сургаалыг заадаг дор хаяж нэг дуулал эсвэл дууг жагсаан бич. Мөн судрууд дээрээ Итгэлийн холбогдох Тунхаг бүрийн хажууд дууллын дугаар эсвэл дууны нэрийг бичихийг та нар хүсч болно. (Хэрэв туслалцаа хэрэгтэй бол, Дууллын Номон дахь “Судрууд” болон “Сэдвүүдийн” индексүүд, Хүүхдийн Хэсгийн Дууны номон дахь индексийг ашигла).

Д Авралын төлөвлөгөөний хэсгүүд

Итгэлийн Тунхаг 1:1–4-ийг уншиж, энд дурдсан авралын төлөвлөгөөний бүрдүүлбэрүүдийг жагсаан бич. Эдгээр бүрдүүлбэрүүдийг оруулсан зураг зурах буюу схем хий. Үүнээс та нар гэртээ эсвэл бусад хүмүүст авралын төлөвлөгөөг зааж болно.

Е Бусад хүмүүс юунд итгэдэг вэ?

Итгэлийн Тунхаг 1:5–10-ыг нэгтгэн дүгнэж, Их Эзэний Сүмийг дүрсэлсэн үгс, өгүүлбэрүүдийг жагсаан бич. Жагсаалтан дахь санаануудын талаарх итгэлээ хуваалцахыг гишүүн биш найзаасаа хүс. (Найзынхаа итгэлд найрсаг, хүндэтгэлтэй ханд. Чи итгэл дэх ялгааны талаар маргах биш, харин мэдээлэл хүсч байгаа.) Мэдсэн зүйлийнхээ талаар нэг догол мөр бич.

Ё Хожмын Үеийн Гэгээнтний эрх, үүргүүд

1. Тэмдэглэлийн дэвтэртээ дараах нөхцөлүүдийг жагсаан бич:
 - а. Машин барьж явахдаа хурдны хязгаарыг хэтрүүлэх
 - б. Шашны хувцас өмссөнийх нь төлөө хүнийг шоолох
 - в. Номлогчийн ярилцлагуудыг сонсоход хүнийг шахаж шаардах
 - г. Улс орныхоо удирдагчдын зааврыг дагахаас татгалзах
 - д. Тусламж хэрэгтэй байгаа хүнд туслахгүй байх
 - е. Аль нэг хүн өөрийн чинь итгэлийнх биш учраас түүнд найрсаг биш байх
 - ё. Бэлгийн харилцааг харуулсан кино буюу телевизийн хөтөлбөр үзэх
 - ж. Амьдардаг орчиндоо ариун ёслолын байр барихыг эсэргүүцэх
 - з. Бүдүүлэг дохио зангаа буюу үг хэллэг хэрэглэх
 - и. Өөрийнхөөсөө бусад бүх шашны хүмүүсийг ёс бус гэж бодох
2. Итгэлийн Тунхаг 1:11–13-ыг нэгтгэн дүгнэж, нөхцөл бүрийн дараа үүнтэй нягт холбоотой итгэлийн тунхагийг жагсаан бичиж, энэ нь хэрхэн хэрэгждэгийг тайлбарла.
3. Итгэлийн Тунхаг 1:11–13 дахь сургаалын дагуу амьдрахын тулд юу хийх тухайгаа өгүүлсэн наад тал нь гурван нотолгоо бүхий хувь хүний биеэ авч явах дүрмийг бич. Нотолгоонуудаа “Би (ямар нэг зүйлийг) хийх болно” эсвэл “Би (ямар нэг зүйлийг) хийхгүй байх болно” гэж эхэл.



Сэргээгдсэн Сүмийн түүхийг судлах нь бидний өмнө амьдарч байсан хүмүүсийн итгэл, шийдвэр төгс байдлын тухай маш ихийг бидэнд өгүүлж чадна. Бошиглогч Иосеф Смитийн үеэс хойш, Сүмийн олон гишүүд жинхэнэ

Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн сүнслэг нөлөөний үлгэр жишээ болсоор байна. Гэвч газар дэлхий дээрх Бурханы хаант улсын хамгийн алдар суут өдрүүд бидний өмнө байна. Урьд өмнө амьдарч байсан итгэлтэй Гэгээнтнүүдийн нэгэн адил, өөрсдийн итгэл бишрэл, хичээл зүтгэл, золиослол, Бурхан болон Түүний бошиглогчдод үйлчлэх үйлчлэлээр дамжуулан та нар ч бас Сүмийн түүхэн дэх байраа олж болно. Эцэст нь, дэлхийн олон бүсэд Сүмийн түүх хараахан бичигдээгүй байна.

Сүмийн Түүхэн дэх та нарын орон зай

1. “Бидний хүн нэг бүр Сүмийн түүхэнд өөрийн орон зайтай юм. Зарим гишүүд хэдэн үеэрээ сайн мэдээг баяртайгаар хүлээж авсан, үр хүүхдээ Их Эзэний замаар өсгөн хүмүүжүүлсэн гэр бүлд төрсөн байдаг. Бусад нь сайн мэдээг анх удаа сонсон, баптисмын усанд орж, Бурханы хаант улсыг байгуулахад хувь нэмрээ оруулахаар ариун гэрээнүүд хийсэн байдаг. Олон гишүүд Сүмийн түүхэн дэх өөрсдийнхөө үеийг дөнгөж эхлэн, үр хүүхдийнхээ хувьд итгэлийн үрийг суулгаж байгаа бүс нутгуудад аж төрдөг. Нөхцөл байдал маань ямар ч байлаа гэсэн, бид бүгд бол Сионыг байгуулах зорилгын салшгүй хэсэг бөгөөд Аврагчийн Хоёр дахь Ирэлтэд бэлтгэж байна. Бид бол ‘цаашид харь хүмүүс болон гадны хүмүүс биш, харин ариун хүмүүсийн адил нутгийн иргэд бөгөөд Бурханы гэр бүлийнх юм’ (Ефес 2:19).



2. “Бид шинэ гишүүд байна уу, хуучин ч байна уу ялгаагүй бидний урьд өмнө аж төрж байсан хүмүүсээс итгэл, золиослолын өвийг уламжлан авсан байдаг. Бид үр хүүхдэдээ бас Есүс Христийн сайн мэдээг хараахан сонсоогүй, хүлээж аваагүй байгаа, Тэнгэрлэг Эцэгийнхээ сая сая хүүхдийн хувьд өнөө үеийн анхдагч нар билээ. Бид Их Эзэний ажлыг итгэл бишрэлтэйгээр хийснээр дэлхий дахинд хувь нэмрээ өөр өөр арга замаар оруулдаг.

3. “Эцэг эхчүүд зөв шударга ёсны зарчмуудыг үр хүүхдэдээ залбирч, зааж сургадаг. Гэрийн болон айлчлагч багш нар гачигдалтай хүмүүст анхаарал халамж тавьдаг. Сайн мэдээний захиасыг бусад хүргэхийн тулд амьдралынхаа тодорхой жилүүдийг зориулахаар сонгосон номлогчдод гэр бүлүүд баяртай гэж хэлдэг. Амь биеэ үл хайрлагч санваартны болон туслах байгууллагуудын удирдагчид үйлчлэх дуудлагыг хүлээн авч хэрэгжүүлдэг. Өвөг дээдсийнхээ нэрсийг эрж хайхад зориулагдсан тоо томшгүй олон цагийн чимээгүй үйлчлэл, ариун сүмд гүйцэтгэгддэг ариун ёслолуудаар дамжин, амьд байгаа болон нас барсан хүмүүст адислалууд өгөгддөг.

4. “Бошиглогч Иосеф Смитэд илчлэгдсэн Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн хувь тавиланг гүйцэлдүүлэхийн төлөө бид бүгд тусалдаг. 1842 онд тэрээр бошиглосон нь:

5. “Үнэний Жишиг тогтлоо. Цэвэршээгүй гар уг ажлыг өсч дэвжихээс зогсоож чадахгүй. Мөрдлөг хавчлага гаарч, танхайрагч бүлгүүд нэгдэж, цэрэг арми цугларч болно, худал хуурмаг хорон санаат явуулга, гүжир гүтгэлэг зохион байгуулагдаж болно. Гэвч Бурханы үнэн тив болгонд хүрч, орон бүрд нэвтэрч, цаг уур болгонд хүрч, чих болгонд сонсогдох хүртэл, Бурханы зорилго хэрэгжих хүртэл, уг ажил хийгдлээ гэж Аугаа Иеховаг хэлэх хүртэл зоригтойгоор, эрхэмсгээр, тусгаар байдалтайгаар урагш давших болно’ [History of the Church, 4:540].

6. “Бошиглогч Иосеф Смитийн амьдарч байсан үед Сүм хэдийгээр жижигхэн байсан ч, энэ бол Есүс Христийн сайн мэдээний үнэнүүдээр бүх дэлхийг дүүргэх хувь тавилантай, газар дээрх Бурханы хаант улс байсныг тэрээр мэдэж байсан юм. Ойрын жилүүдэд Сүм эрс түргэн өссөнийг бид харж байна. Үүрд мөнхөд орших хаант улс-Бурханы хаант улсыг байгуулахад туслахын тулд итгэл, золиослолоо өргөн барьж болох үед аж төрөх онцгой боломж бидэнд заяасан билээ” (Бидний Өв, 169–170).

Уншсанаа ойлгох нь



Сүмийн Түүхэн дэх та нарын орон зай

Өв (догол мөр 2)—
Уламжлал

Цэвэршээгүй (догол мөр
5)—Ариун бус

Уншсанаа судлах нь



“Сүмийн Түүхэн дэх бидний орон зай”-ыг судлахдаа үйл ажиллагаа А эсвэл Б-г хий

А Бурханы хаант улс дахь та нарын орон зай

Өөрийг чинь, туршлагыг чинь, Сүм дэх өөрийн чинь үүргийг дүрсэлсэн үгс, өгүүлбэрүүдийг догол мөр 1–6-гаас жагсаан бич. Тэгээд дараах асуултуудад хариул:

1. Танай хот буюу хотхонд арван жилийн өмнө ойролцоогоор Сүмийн хэчнээн гишүүн байсан бэ? Одоо хэд байгаа вэ? (Эдгээр асуултуудад тусалцаа хэрэгтэй бол эцэг эхээсээ буюу орон нутгийн Сүмийн удирдагчдаас асуу.)

2. Хоёр жилийн дараа тэнд хэчнээн гишүүн байх болно гэж та нар бодож байна? Таван жилийн дараа? Арван жилийн дараа?
3. Танай бүсэд Сүм өсөн хөгжихөд өөрийн чинь тусалж чадах таван зүйл юу вэ?
4. Ирээдүйн үеийнхний хүмүүс өөрийг чинь яаж дурсан санахыг чи хүсдэг вэ?

Б Товч түүх бич

Танай бүс дэх Сүмийн түүхийн тухай мэдэх наад тал нь хоёр хүнтэй ярилцлага хий. Зарим зураг, түүх, сэтгүүлүүд, өдрийн тэмдэглэл буюу орон нутгийн Сүмийнхээ тухай хэвлэлийн мэдээний түүхүүдийг олохыг бас хичээ. Өөрийнхөө бүс дэх Сүмийн товч түүхийг бичиж, өөрийн бүсэд Бурханы хаант улсыг байгуулахад оролцоход өөрт чинь юу сүнслэгээр нөлөөлснийг хэрхэн мэдсэнээ тайлбарла.

Сургаал ба Гэрээн дэх Хүмүүс ба нэр томъёонууд

Ерөнхийлөгч Эзра Тафт Бенсон хэлсэн нь: “Сургаал ба Гэрээ үнэн. Учир нь үүнийг зохиогч нь Есүс Христ бөгөөд Түүний захиас бүх хүмүүст зориулагдсан юм” (*Teachings of Ezra Taft Benson*, 46).

Их Эзэн манай өнөө үед өгсөн илчлэлтүүдийг Сургаал ба Гэрээ агуулдаг бөгөөд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн түүхэн дэх олон хүмүүс, газар нутаг, үйл явдлын тухай өгүүлдэг билээ. Сургаал ба Гэрээг судлахад бэлтгэхээсээ өмнө дараах мэдээллийг унш. Уг мэдээлэл илчлэлтүүдийн эргэн тойрон дахь түүх болон үйл явдлуудыг ойлгоход тань туслах болно.

Сургаал ба Гэрээн дэх хүмүүс

Дараах шастирууд бол Сургаал ба Гэрээнд та нарын унших чухал хүмүүсийн заримынх нь товч түүх юм:



Бошиглогч **Хүү Иосеф Смит**, “Энэ дэлхийд хүмүүний авралын төлөө зөвхөн Есүсийг эс тооцвол, үүн дээр амьдарч асан аль ч бусад хүнээс илүү ихийг хийсэн билээ” (С ба Г 135:3). Тэрбээр 1805 оны арванхоёрдугаар сарын 23-нд төржээ. Түүний амьдралын эхэн үеийн товч түүх, Бурхан Эцэг Есүс Христ хоёрын тухай түүний үзэгдэл, тэнгэр элч Моронайн айлчлалыг Иосеф Смит-Түүх 1:5–54-өөс үз. Иосеф Смитэд санваарыг тэнгэрлэг элчүүд олгосон бөгөөд тэрээр олон илчлэлт хүлээн авчээ. Тэрээр Мормоны Номыг орчуулж, хэвлүүлсэн бөгөөд түүгээр дамжуулан Их Эзэн Есүс Христ Өөрийн Сүмийг сэргээсэн юм. Бусад бошиглогчдын нэгэн адил, дайснууд нь түүнийг мөрдөн хавчиж, олон удаа шударга бусаар шоронд хорьж, олон гай зовлонд унагаж байлаа (С ба Г 121–123-ыг үз). Түүнийг ах Хайрумынх нь хамт Есүс Христийг гэрчилснийх нь улмаас танхайрагч бүлэг 1844 онд амь насыг нь бүрэлгэсэн юм (С ба Г 135-ыг үз).



Эмма Хейл Смит 1827 оны нэгдүгээр сард Бошиглогч Иосеф Смиттэй гэрлэсэн, тэрээр Мормоны Номыг орчуулж эхлэхэд орчуулгыг нь бичиж өгдөг байв. Эмма Смит бол Нийгмийн Халамжийн Бүлгийн анхны ерөнхийлөгч юм. Тэрээр бас Сүмийн анхны дууллын номон дахь дууллуудыг сонгожээ (С ба Г 25:1–15; мөн 132:51–56-г үз). Тэрээр олон мөрдлөг хавчлага, гай зовлонд өртсөн юм. Бага насны хэдэн хүүхэд нь нас барж, нөхөр Иосеф нь дайснуудад алагдсан билээ. Сүм Юта руу шилжин нүүхэд тэр Иллинойд үлдсэн аж. Тэрээр 1879 онд Иллинойн Наувуд нас баржээ.



Хайрум Смит бол Бошиглогч Иосеф Смитийн ах юм. Дүүг нь Бурхан бошиглогчоор дуудсаныг Хайрум Смит бүр эхнээс нь мэддэг байсан бөгөөд уг гэрчлэлдээ итгэлтэй хэвээр үлдсэн юм (С ба Г 11-р хэсгийн тойм, 6–26; 23:3; 52:8; 124:15, 124-ийг үз). Тэрээр Туслах Ерөнхийлөгч бөгөөд Тэргүүн Зөвлөлийн гишүүнээр үйлчилж байв. Бас Сүмийн Патриарх байлаа (С ба Г 124:91–95-ыг үз). Үнэн Сүм дэлхий дээр сэргээгдсэнийг гэрчилснийхээ төлөө тэрээр ахынхаа хамт Картейж шоронд амь насаа егүүтгүүлсэн билээ (С ба Г 135:1–7-г үз). Түүний хөвгүүдийн нэг, Жозеф Ф.Смит, ач хүү Жозеф Фиелдинг Смит хоёр Сүмийн Ерөнхийлөгч болсон юм.



Эцэг Иосеф Смит (Иосеф Смит-Түүх 1:48–50; С ба Г 4-ийн хэсгийн тойм; 23-ын хэсгийн тойм, 5; 90:20, 25–26; 102:3; 124:19; 137:5-ыг үз). 1771 оны долдугаар сарын 12-нд Массачусетсын Топсфилдэд төрсөн. Хорин дөрөвтэйдөө **Люси Мак Смиттэй** гэрлэж (С ба Г 137:5-ыг үз), Вермонтод суурьшсан ажээ. Удаа дараа ургац алдсан болон санхүүгийн алдагдал нь Эцэг Иосеф Смитийг Нью-Йоркийн Палмирагийн ойролцоох Кумора гүвээний зэргэлдээх нутагт гэр бүлээ шилжүүлэхэд хүргэжээ. Эцэг Иосеф Смит хүүгийнхээ Их Эзэний бошиглогчийн дуудлагыг цаг үргэлж ихэд дэмждэг байв (Иосеф Смит-Түүх 1:50-ийг үз). Сүм зохион байгуулагдсан өдөр 1830 оны дөрөвдүгээр сарын 6-нд тэр баптисм хүртжээ. Эцэг Иосеф Смит болон түүний хоёр хүү Хайрум, Самуел нар Мормоны Номын алтан ялтсуудын гэрчүүдийн дунд байсан юм (Мормоны Номын өмнөх хуудсууд дээрх “Найман гэрчийн гэрчлэл”-ийг үз). Эцэг Иосеф Смит Сүмийн анхны Патриарх бөгөөд Тэргүүн Зөвлөлийн зөвлөх байлаа. Тэрээр 1840 онд Иллинойн Наувуд нас баржээ.



Эцэг Иосеф Смит, Люси Смит хоёр арваннэгэн хүүхдийн эцэг эх байв. Тэдний анхны хүүхэд нь төрөхдөө эндсэн аж. Бусад хөвгүүд нь **Алвин** (Иосеф Смит-Түүх 1:56; С ба Г 137:5–6-г үз), **Хайрум** (дээрх “Хайрум Смит”-ийг үз), **Иосеф** (дээрх “Бага Иосеф Смит”-ийг үз), **Самуел** (С ба Г 23-ын хэсгийн тойм, 4; 61:35; 66:8; 75:13; 102:3, 34; 124:141-ийг үз), **Эфрейм** (ердөө арваннэгэн өдөр амьд байжээ), **Виллям** (Сургаал ба Гэрээний өмнөх Сургаал ба Гэрээ ном үнэн болох тухай Арванхоёр Төлөөлөгчийн гэрчлэл”; С ба Г 124:129-ийг үз), **Дон Карлос** нар байлаа. Охид нь **Софрония**, **Катерин**, **Люси** нар болно. Самуел Смит Сүмийн анхны номлогч байсан бөгөөд Наувуд бишопын зөвлөлд үйлчилж байв. Тэрээр маш их мөрдлөг хавчлагад өртсөн бөгөөд хоёр ах Иосеф, Хайрум нар нь алагдсанаас хойш сар орчмын дараа гучин зургаатайдаа нас баржээ.





Мартин Харрис Нью-Йоркийн Палмира дахь чинээлэг фермер байв. Тэрээр залуу Иосеф Смиттэй нөхөрлөж, зардлуудыг нь төлөхөд түүнд тусалж байлаа. Бошиглогч Мормоны Номыг орчуулж байх үед тэрээр богинохон хугацаанд Иосеф Смитэд орчуулгыг нь бичиж өгч байв. Хожим нь тэрээр Мормоны

Номын эхний таван мянган хувийг хэвлүүлэхийн тулд фермийнхээ нэг хэсгийг зарсан ажээ (С ба Г 3-ын хэсгийн тойм, 12-13; 5:1-15, 24-32; 10-ын хэсгийн тойм; 19-ийн хэсгийн тойм, 25-41-ийг үз). Тэрээр алтан ялтсуудын тусгай гурван гэрчийн нэг байсан бөгөөд бүх амьдралынхаа туршид уг гэрчлэлд итгэлтэй хэвээр байжээ (Мормоны Номын өмнөх "Турван гэрчийн гэрчлэл"; С ба Г 17-р хэсгийн тойм, 1-9; 58:35-39; 104:24-26; Иосеф Смит-Түүх 1:61-65-ыг үз). Мартин Харрис 1838 онд Сүмийг орхисон боловч Сүмтэй хамт байхын тулд 1870 онд Ютад ирж, дахин баптисм хүртсэн ажээ. Тэр 1875 онд нас баржээ.



Оливер Каудери 1806 онд Вермонтод төрсөн. Тэр сургуулийн багш болсон бөгөөд Бошиглогч Иосеф Смитийн тухай мэдэж, улмаар Нью-Йоркийн Палмирад Иосефын эцэг эхтэй хамт амьдарч байхдаа

Бошиглогчийн дуудлагын талаар сүнсний гэрчлэл хүлээн авчээ (С ба Г 6-р хэсгийн тойм,

14-24-р хэсгийг үз). 1829 оны дөрөвдүгээр сард Оливер Каудери Бошиглогчтой уулзахаар Пеннсилванийн Хармонид ирсэн аж. Бошиглогч Мормоны Номын алтан ялтсуудыг орчуулж байх үед тэр бичээч нь болов (С ба Г 8-ын хэсгийн тойм, 1-12; 9-ийн хэсгийн тойм, 1-14-ийг үз). Тэрээр алтан ялтсуудын тусгай гурван гэрчийн нэг байв ("Мормоны Номын өмнөх "Турван гэрчийн гэрчлэл"; С ба Г 17 хэсгийн тойм, 1-9-р хэсгийг үз). Санваарын эрх мэдэл сэргээгдэж, бусад олон илчлэлт хүлээн авагдахад тэрээр Бошиглогч Иосеф Смиттэй хамт байжээ (С ба Г 13-ын хэсгийн тойм; 18:37; 20:3-4; 21-ийн хэсгийн тойм; 27:8, 12; 28-ын хэсгийн тойм, 1-16; 47-гийн хэсгийн тойм; 69-ийн хэсгийн тойм; 104:28-30; 110-ын хэсгийн тойм, 1-16; 111-ийн хэсгийн тоймыг үз; мөн Иосеф Смит-Түүх 1:66-72-ыг үз). Тэр бас Сүмийн Туслах Ерөнхийлөгчөөр үйлчилж байв (Смит, *Doctrines of Salvation*, 1:211-ийг үз). Оливер Каудери 1838 онд Сүмийг орхисон боловч, 1848 онд эргэж ирэн дахин баптисм хүртжээ (С ба Г 124:95-ыг үз). Тэрээр Юта руу цагаачлах боломжтой болохоосоо өмнө 1850 оны гуравдугаар сарын 3-нд Миссурид нас баржээ.



Эцэг Петр Витмер түүний гэргий **Мэри** нар гурван охин, таван хүүтэй байжээ. Нэг охин Элизабет Анн нь Оливер Каудеритай гэрлэсэн (өмнөх "Оливер Каудери"-ийг үз). Хоёр дахь

охин Нанси нь ойролцоогоор дөрвөн сартай байхдаа нас барсан гэдэг. Гурав дахь охин Катерин нь Хайрам Пейжтэй гэрлэсэн байна (С ба Г 28-р хэсгийн тоймыг үз). Таван хөвгүүн нь Мормоны Номын алтан ялтсуудын гэрчүүд байв ("Мормоны Номын өмнөх "Турван гэрчийн гэрчлэл"; "Найман гэрчийн гэрчлэл"-ийг үз). **Давид Витмер** бол Сүмийг шашны нийгэмлэг болгон нэгтгэх баримт бичигт гарын үсэг зурсан зургаан хүний нэг байлаа. Хожим нь тэрээр 1838 онд Сүмийг орхих хүртлээ Миссури дэх

Сүмийн удирдагчаар үйлчилж байв (С ба Г 14-р хэсгийн тойм, 11; 17-р хэсгийн тойм, 1-9; 18-р хэсгийн тойм, 9, 37-39; 30:1-4; 52:25-ыг үз). 1829 онд Мормоны Номын орчуулгын үед Витмерийн гэр бүл Иосеф, Эмма Смит, Оливер Каудери нарт мөнгө, хоол хүнс, оршин суух газар гарган өгч байв. 1830 онд Нью-Йоркийн Фейеттед Витмерийн гэрт Сүм зохион байгуулагдсан юм (С ба Г 21-р хэсгийн тоймыг үз).



Сидней Ригдон бол Мормоны Номыг залбирч уншсаны дараа 1830 онд Сүмд нэгдсэн, Огайогийн Ментор дахь үйлчлэгч байв.

1833-1844 онуудад тэр Тэргүүн Зөвлөлийн зөвлөх байсан бөгөөд Сүмийн бусад олон албан тушаалд үйлчилж байжээ (С ба Г 35-р хэсгийн тойм, 3-6; 36:2, 5; 58:50, 57-58; 63:65-66; 71:1; 76-р хэсгийн тойм, 11-24; 82:11; 90:6, 21; 93:44, 51; 102:3; 124:125-126-г үз). Бошиглогч Иосеф Смитийн амь насыг бүрэлгэсний дараа, тэрээр Сүмийн "харгалзагч" болж, Сүмийг удирдах тухай мэдэгдлээ танилцуулсан боловч гишүүд Арванхоёр Төлөөлөгчийг дэмжин баталжээ.

Тэрээр Арванхоёрыг дэмжин баталсангүй, улмаар 1844 онд гишүүнээс хөөгджээ.

Эдвард Партриж 1830 онд Сүмд нэгдсэн бөгөөд Сүмийн анхны бишоп байв (С ба Г 35-ын хэсгийн тойм; 36-гийн хэсгийн тойм, 1-7; 41:9-11; 42:10; 50:39; 51:1-4, 18; 52:24; 57:7; 58:14-16, 24-25, 61-62; 60:10; 64:17; 82:11; 124:19-ийг үз). Бишоп Партриж Миссурид олон мөрдлөг хавчлагад өртсөн бөгөөд 1840 онд Иллинойн Наувуд дөчин долоотойдоо нас баржээ.



Эцэг Жозеф Найт 1826 онд Бошиглогч Иосеф

Смиттэй танилцаж, улмаар Сэргээлтийн ажилд туслахыг сонирхох болжээ. Тэрээр Бошиглогч Иосефоос гучин насаар ах байсан бөгөөд Мормоны Номын орчуулгыг үргэлжлүүлэхэд шаардлагатай зүйлүүдийг олон удаа-түүний дотор 1827 онд Бошиглогч эхнэртэйгээ хамт алтан ялтсуудыг Кумора гүвээнээс шөнөөр авчрахад сүйх тэрэг гаргаж өгчээ. Гэгээнтнүүд Наувугаас шилжин явсан 1847 оны нүүдлийн үед Найт ах Айовагийн нутагт Рисга өртөөн дээр нас баржээ.



Ньюел К.Витней Огайогийн Кортландад нэг дэлгүүр эзэмшдэг байв. 1830 онд тэр Сүмд нэгдэж, Бошиглогч Иосеф Смитийн дотнын найз болжээ. Бошиглогч болон түүний гэр бүл Витнейн гэрт хэсэг хугацаагаар амьдарч байх үед Сургаал ба Гэрээн дэх нэлээд хэдэн илчлэлт тэнд хүлээн авагджээ. Ньюел К. Витней Сүмийн хоёр дахь бишопор дуудагдаж, 1847 онд Сүмийн Тэргүүлэх Бишопор дуудагджээ (С ба Г 63:42-46; 72-р хэсгийн тойм, 1-8; 78:8-10; 82:11-12; 84:112; 93:50; 96-р хэсгийн тойм, 2; 104:39-42; 117:1-2, 11-ийг үз).



Тэрээр 1850 онд Ютад нас баржээ. Түүний эхнэр, **Элизабет Анн Витней** Нийгмийн Халамжийн Бүлгийн анхны Ерөнхийлөгчийн Зөвлөлд Эмма Смитийн зөвлөх байв.



Томас Б.Марш Мормоны Номын нэг хувь Е.В.Грандины хэвлэх цехээс дөнгөж гарсны дараа эхний арван зургаан хуудсыг нь уншаад, 1830 онд Сүмд нэгджээ. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын анхны Ерөнхийлөгч болсон аж (С ба Г 31-р хэсгийн тойм, 1-13; 52:22; 56:5; 112-р хэсгийн тойм, 1-19; 118:2-ыг

үз). Тэрээр Бошиглогч Иосеф Смитэд уурлаж, улмаар Миссури дэх Сүмийг мөрдөн хавчихад хүргэсэн юм. Тэр 1838 онд Сүмийг орхиж, 1839 онд гишүүнээс хөөгдсөн боловч, 1857 онд дахин баптисм хүртжээ.



Парли П.Пратт түүний ах **Оорсон Пратт** хоёр Сүмд 1830 онд нэгдэж, энэ эрин үе дэх анхны Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүд болжээ. Парли П.Пратт Сүмийн олон номлолд үйлчилсэн ажээ (С ба Г 32-р хэсгийн тойм, 1-2; 34-р хэсгийн тойм; 49:1-3; 50:37; 52:26; 97:3-5; 103-р хэсгийн тойм, 30, 37; 124:127-129-ийг үз). Тэрээр Сүмээс нийтэлсэн олон номлол, дууллыг бичиж, хэвлүүлсэн бөгөөд Ютад хүрч ирсэн эхэн үеийн анхдагч нарын нэг байлаа. Тэрээр 1857 онд Нэгдсэн Улсын өмнөд хэсэгт номлолд үйлчилж байхдаа алагджээ. Оорсон Пратт бас



Сүмийн олон номлолд үйлчилсэн байна (С ба Г 34-р хэсгийн тойм, 1-10; 52:26; 75:14; 103:40; 124:127-29; 136:13-ыг үз). Тэрээр Сүмийн Ерөнхийлөгчийн удирдлага дор ажиллан, Сургаал ба Гэрээнд хорин зургаан илчлэлт нэмж, шүлгүүд дэх өгүүлбэр, догол мөрүүдийг өөрчилж, Мормоны Ном, Сургаал ба Гэрээ, Агуу Үнэт Сувдад анхны зүүвэр тайлбаруудыг оруулжээ. Тэрээр шашин, шинжлэх ухааны сэдвээр олон ном бичсэн бөгөөд Ютад хүрч ирсэн эхэн үеийн анхдагч нарын нэг байв. Тэр 1881 онд нас барах хүртлээ дөчин таван жил гаруй Төлөөлөгч байжээ.

Сургаал ба Гэрээн дэх нэр томьёонууд

Урвалт

Шинэ Гэрээний үед Есүс Христ Өөрийн сайн мэдээг зааж, Төлөөлөгчдийг сонгон, Өөрийн Сүмийг зохион байгуулсан юм. Түүний Цагаатгал, үхэл, Амилалтын дараа хүмүүс Төлөөлөгчдийг эсэргүүцэж, сайн мэдээний сургаалуудыг өөрчилсөн билээ. Иймээс Есүс Христийн үнэн Сүм дэлхийгээс авагдсан байлаа. Үнэн Сүмээс ийнхүү “тусгаарлан салах явдлыг” (2 Тесалоник 2:3) Урвалт гэдэг.

Сэргээлт

Сайн мэдээ болон Урвалтын улмаас дэлхийгээс авагдсан Есүс Христийн үнэн Сүмийг сэргээхийн тулд (буцааж авчрах) Их Эзэн Бошиглогч Иосеф Смитийг сонгосон юм. Есүс Христийн сайн мэдээг агуулсан Мормоны Номыг Иосеф Смит Бурханы бэлэг болон хүчээр орчуулсан билээ. Их Эзэн бас санваарын эрх мэдэл, гэрээ, ёслол, Сүнсний бэлгүүд, Сүмийн зохион байгуулалт гэхчилэн Шинэ Гэрээний үед дэлхий дээр байсан зүйлүүдийг сэргээжээ (Итгэлийн Тунхаг 1:4-7, 9-ийг үз).

Израилын цугларалт

Иаковын нэрийг “Израил” (Эхлэл 32:28; 35:10-ыг үз) болгон өөрчилсөн тухай Хуучин Гэрээ өгүүлдэг. Израилын арванхоёр хөвгүүний үр удмыг “Израилын арванхоёр овог” буюу

“Израилын хүүхдүүд” гэдэг. Судруудад зарим газарт тэдний “Иаковын хүүхдүүд” (Дуулал 105:6; С ба Г 109:61-ийг үз) гэсэн байдаг ч, бас бусад газарт зүгээр л “Израил” гэсэн байдаг. Өнөөдөр Сүмийн гишүүдийг бас “Израил” ; “Израилын угсаа,” эсвэл “Израилын хүүхдүүд” гэдэг (2 Нифай 29:14; С ба Г 103:17-ыг үз).

Израилын арванхоёр овгийн ёс бус байдлын улмаас арван овгийг байлдан эзэлж, боолчлолд аваачжээ (Хаадын Дэд 17:18-23; 1 Нифай 22:3-4-ийг үз). Эдгээр овгуудыг “алдагдсан арван овог” гэдэг. Израилын овгуудын үлдсэнийг нь “Иуда” эсвэл “Иудейчүүд” гэдэг бөгөөд хожим нь тэд бас эзлэгдэж, тараагджээ (2 Нифай 6:8-11-ийг үз).

Их Эзэн Өөрийн хүмүүс Израилыг эцсийн өдрүүдэд цуглуулна гэж амлажээ (Иеремиа 16:14-15; 1 Нифай 22:24-25; 2 Нифай 9:1-2-ыг үз). Эл цугларалт Бошиглогч Иосеф Смитээр дамжуулан Есүс Христийн сайн мэдээ болон үнэн Сүмийг Сэргээснээр эхэлсэн юм. Хожим нь Их Эзэн гишүүд Огайогийн Көртландад цуглах ёстойг хэлсэн билээ (С ба Г 37:1-4-ийг үз). 1831 онд Миссури мужид Сүм цугларах газар бэлтгэхийг Их Эзэн зарим гишүүдэд зарлиг болгосон ажээ (С ба Г 57:1-2-ыг үз). Ингээд 1838 он гэхэд Сүмийн үлдсэн хэсэг тэнд цугласан байлаа. Гэвч зарим гишүүд Их Эзэний зарлигуудыг дуулгавартай дагаагүйн улмаас, бас Сүмийн дайснуудын мөрдлөг хавчлагын улмаас 1839 онд Сүм Иллинойн Науву руу шилжсэн юм. Бошиглогч Иосеф Смитийн амь насыг бүрэлгэсний дараа, гишүүдийг мөрдлөг хавчлага Иллиной мужийг орхин явахаас аргагүйд хүргэхэд, Их Эзэн Сүмийг Нэгдсэн Улсын баруун хэсэгт цугларах газар руу нь удирджээ. (Гурамсан судрын ар тал дахь газрын зургийн хэсгийг үз.)

Их Эзэн Өөрийн хүмүүсийг цуглуулах амлалтаа биелүүлсээр байгаа ч, өнөөдөр оршин суугаа газартаа Сүмийг байгуулахаар бид зарлигдуулаад байгаа билээ. Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн, Ахлагч Брус Р.МкКонкийн хэлсэнчлэн: “Газар дэлхий бүхэлдээ сайн мэдээний үр жимсээр адислагдахын тулд Израил нэг нэгээрээ, гэр бүлээрээ дэлхийн бүх хэсэгт байгуулагдсан Сионы гадаснуудад цуглах болно” (“Come: Let Israel Build Zion,” *Ensign*, 1977 оны 5-р сар, 118).

Сургаал ба Гэрээний түүх

Миссурид 1833 онд хэвлэгдсэн “дуусаагүй” Зарлигуудын Ном Их Эзэнээс Бошиглогч Иосеф Смитийн хүлээн авсан жаран таван илчлэлтийг агуулсан боловч, бас бусад зүйл орсон байжээ (С ба Г 1:6 түүнчлэн С ба Г 1; 67; 69-70-р хэсгийн тоймыг үз). Их Эзэнээс Бошиглогч Иосефын хүлээн авсан шинэ илчлэлтүүдийн хамт Зарлигуудын Ном нь Сургаал ба Гэрээ болон 1835 онд хэвлэгджээ. Сургаал ба Гэрээний энэ хэвлэл 103 хэсэгтэй (66-р хэсэг нь хоёр хэсэг байсан) байв. Тэр үеэс хойш Сүмийн Ерөнхийлөгчид олон өөр илчлэлт хүлээн авснаас зарим нь Сургаал ба Гэрээнд нэмэгдсэн юм. Тэр үед Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын гишүүн асан, Ахлагч Ховард В. Хантер, Бурхан өнөөдөр амьд бошиглогчоор дамжуулан, “Бүх хүүхдүүдээ удирдамжаар хангасаар байна” гэжээ. Тэрбээр амласныхаа дагуу үйлчлэгчдийнхээ хамт дэлхий даяарх Сүмийнхээ ажил хэргийг үргэлж удирдан чиглүүлж байдгийг бид мэдэгдэж байна” (In Conference Report, 1981 оны 4-р сар, 88; *Ensign*, 1981 оны 5-р сар, 65).

ИСО (Библийн Хаан Жеймсийн Хувилбарын Иосеф Смитийн Орчуулга)

Библийн олон чухал хэсэг алга болсон эсвэл өөрчлөгдсөн байв (1 Нифай 13:24–29-ийг үз). Библид олон залруулга хийхийг Их Эзэн Бошиглогч Иосеф Смитэд зарлиг болгожээ (С ба Г 35:20; 41:7; 45:60–61; 73:3–4; 93:53-ыг үз). Эдгээр залруулгуудыг Иосеф Смитийн Орчуулга буюу ИСО гэдэг. ИСО-ын өөрчлөлтийн зарим нь Библийн Хаан Жеймсийн Хувилбарын Сүмийн хэвлэлийн зүүвэр тайлбар болон сүүлчийн хуудсуудад байдаг. Бошиглогч Иосеф Смитийг Библийн орчуулга дээр ажиллаж байх үед, Библийн олон хэсгийг тайлбарласан илчлэлтүүдийг Их Эзэн түүнд өгчээ (С ба Г 76; 77; 86; 91; 93; 113; 132-ыг үз; мөн Мосе; Иосеф Смит-Матайг үз).

Өргөлийн хууль

Бүх юмс Их Эзэнийх байдаг. Бидэнд Түүний өгдөг юм бүхнийг хаант улсыг нь байгуулахад туслахад ашиглах ёстойг Өргөлийн хууль заадаг (С ба Г 104:11–18-ыг үз). Сүмийн эхэн үед өргөлийн хуулиар амьдрахаар сонгосон гишүүд мөнгө, өмч хөрөнгөө бишопт өгч, оронд нь хариуцах ажил үүргийг (мөнгө, өмч хөрөнгө, бусад үүрэгт ажил) хүлээн авдаг байлаа. Бишопоос хүмүүсийн хүлээн авдаг зүйлүүд өөрсдийнх нь өмч болж, хэрэгцээгээ хангахад ашигладаг байжээ. Тэд хэрэгцээнээсээ илүү үйлдвэрлэсэн юуг боловч ядуучууд, гачигдалтай хүмүүст туслахын тулд бишопт буцаан өгөх ёстой байв (С ба Г 42:30–39-ийг үз). Бардамнал, аминч үзлийг даван туулах болон селестиел хаант улсад амьдрахад нь бэлтгэхэд туслахын тулд өргөлийн хууль гишүүдэд өгөгдсөн ажээ (Мосе 7:16–20-ийг үз). Сүмийн зарим гишүүд өргөлийн хуулиар хэсэг хугацаанд амьдрах гэж оролдсон ч, тэд энэ хуулиар бүрэн амьдрах боломжгүй байлаа (С ба Г 105:1–5, 9–13-ыг үз). Өнөөдөр, аравны нэг, мацгийн өргөл, Дезерет Индастрид оруулдаг хандив, Сүмийн халамжийн хөтөлбөр, цаг зав, авъяас чадвараа зориулах болон Бурханы хаант улсыг байгуулахад бидний хийж байгаа бусад золиослол бол бүгдээрээ өргөлийн хуулийн нэг хэсэг юм (С ба Г 119-р хэсгийн тоймыг үз).

Сион

Сургаал ба Гэрээ Сион гэдэг үгийг:

- “Зүрх сэтгэлдээ цэвэр ариун” (С ба Г 97:21), бие биенээ хайрладаг, Их Эзэний зарлигуудыг сахидаг, ядуучуудад анхаарал халамж тавьдаг хүмүүс (мөн Мосе 7:18-ыг үз).
- Миссурийн Индепенденс нутгийн өөр нэг нэр (С ба Г 57:1–3-ыг үз). Сургаал ба Гэрээн дэх “Сионы нутаг” гэдэг нийлэмж үг Миссурийн энэ хэсгийг заадаг.
- Ирээдүйд Миссурид байгуулагдах хот (С ба Г 45:64–71; 84:2–4; мөн Итгэлийн Тунхаг 1:10-ыг үз). 1830-аад оны үед Сүмийн гишүүд (үүний хуулиудаар амьдрах) Сионыг байгуулах боломжгүй байсан ч, Сион ирээдүйд нэгэн цагт байгуулагдана гэдгийг Их Эзэн амлажээ (С ба Г 58:3–7; 101:16–21; 105:1–5-ыг үз).
- Бошиглогч Енохын хот (С ба Г 38:4; 45:11–14; мөн Мосе 7:16–21-ийг үз).
- Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм (С ба Г 21:7–8; 68:25–30) гэсэн утгаар хэрэглэсэн байдаг.

Сионы Хуаран

Сионы Хуаран бол 1834 онд “Сионы нутаг руу” (С ба Г 103:22; 22–35-р хэсгийн тойм болон шүлгийг үз) явах тухай Их Эзэний зарлигийг дуулгавартай дагасан хоёр зуу орчим эрэгтэйчүүд, цөөн эмэгтэйчүүд, хүүхдээс бүрдсэн бүлгийн нэр юм. Тэд Сионыг (өмнөх “Сион”-ыг үз) байгуулахын тулд, бас танхайрагч бүлгүүдээр гэр орноосоо албадуулан хөөгдсөн Сүмийн гишүүдэд туслахын тулд Огайогоос Миссури рүү 1450 км газар аялжээ. Сионы Хуаранг Миссурид ирэхэд, Сионыг байгуулахын тулд “багахан хугацаагаар хүлээ” (түр зуур) хэмээн Их Эзэн тэдэнд хэлжээ (С ба Г 105:9; хэсгийн тойм, шүлэг 1–19-ийг үз). Сионы Хуарангийн үед дуулгавартай, итгэлтэй байсан хүмүүсээс олон нь хожим Сүмийн удирдагчид болсон ажээ.

Хэсгийн тойм

Сургаал ба Гэрээний хэсгүүд нь хэсгийн тоймоор эхэлдэг. Хэсгийн тоймд тухайн илчлэлт хэзээ өгөгдсөн, хэнд чиглэгдсэн болон Их Эзэн илчлэлтийг өгсөн үе дэх Сүмийн зарим түүхийг өгүүлдэг. Хэсэг бүрийг судлахдаа хэсгийн тоймыг үргэлж унших хэрэгтэй.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ

